



ПАРЛАМЕНТАД ХҮРЭХ МЯНГАН АЛХАМ

МОНГОЛ ЭМЭГТЭЙ СОНГУУЛЬД НЭР ДЭВШСЭН НЬ

БУЯНДЭЛГЭРИЙН МАНДУХАЙ

Парламентад хүрэх мянган алхам

Парламентад хүрэх

мянган алхам

Монгол эмэгтэй сонгуульд нэр дэвшсэн нь

Буяндэлгэрийн Мандухай

Чикагогийн их сургуулийн хэвлэлийн газар
Чикаго, Лондон

The University of Chicago Press, Chicago 60637

The University of Chicago Press, Ltd., London

© 2022 by The University of Chicago

All rights reserved. No part of this book may be used or reproduced in any manner whatsoever without written permission, except in the case of brief quotations in critical articles and reviews. For more information, contact the University of Chicago Press, 1427 E. 60th St., Chicago, IL 60637.

Published 2022

Printed in the United States of America

31 30 29 28 27 26 25 24 23 22 1 2 3 4 5

isbn-13: 978-0-226-81872-6 (cloth)

isbn-13: 978-0-226-81874-0 (paper)

isbn-13: 978-0-226-81873-3 (e-book)

doi: <https://doi.org/10.7208/chicago/9780226818733.001.0001>

Library of Congress Cataloging-in-Publication Data

Names: Buyandelger, Manduhai, author.

Title: A thousand steps to parliament : constructing electable women in Mongolia / Manduhai Buyandelger.

Other titles: Constructing electable women in Mongolia

Description: Chicago ; London : The University of Chicago Press, 2022. |

Includes bibliographical references and index.

Identifiers: lccn 2022003329 | isbn 9780226818726 (cloth) |

isbn 9780226818740 (paperback) | isbn 9780226818733 (ebook)

Subjects: lsh: Women politicians—Mongolia. | Women political candidates—

Mongolia. | Political campaigns—Mongolia. | Women—Political activity—

Mongolia. | Neoliberalism—Political aspects—Mongolia. | Mongolia—

Politics and government—1992-

Classification: lcc hq1236.5.m657 b89 2022 | ddc 305.409517—dc23/eng/20220214

LC record available at <https://lccn.loc.gov/2022003329>

This paper meets the requirements of ansi/niso z39.48-1992 (Permanence of Paper).

Энэхүү номыг “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд албан ёсны эрхтэйгээр орчуулав.

Тус номын дүгнэлтүүд гагцхүү зохиогчийн байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА) болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

Орчуулсан: Дүгэрсүрэнгийн Оргил

Редактор: Бундэлгэрийн Мандухай

Гантулгын Мөнх-Эрдэнэ

isbn: 978-9919-9059-2-7

Тоонотпринт ххк-д хэвлэв.

Утас: 70187616, 99093235

И-мэйл: toonot98@yahoo.com

Улаанбаатар хот

2023 он

Охин Ээви, ээж Мэнгэтийн Буяндэлгэр болон чадварлаг, зоримог
Монгол бүсгүйчүүддээ зориулав.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт *i*
Өмнөтгөл: Хилари Клинтон Монголд *1*

Удиртгал: Сонгогдохуйц байх нь - “Эмэгтэй Бүр Өөрийнхөө Төлөө”	9
<i>Шийдвэрлэх үйл явдал</i>	9
<i>Мянган алхам</i>	14
<i>Сонгогдохуйц байх нь</i>	17
<i>Сонгуульжилт</i>	24
<i>Феминизм ба “Эмэгтэйчүүд улс төрд”</i>	27
<i>Судалгааны талаар</i>	33
<i>Онцлом хоёр сонгууль</i>	39
<i>Бүлгийн тойм</i>	41
1 Өв: Социалист төрийн үеийн Жендэр ба Феминист улс төр	44
<i>Олон нийтийн өмнө чөлөөтэй байх нь</i>	44
<i>Үл үзэгдэх мэргэжилтнүүд</i>	49
<i>Социализмаас өмнөх үеийн Монгол эмэгтэйчүүд (1921 оноос өмнө)</i>	54
<i>Биеэ даасан хэлтэстэй болсон нь (1924-32)</i>	56
<i>Стратегиа өөрчлөх нь: Суртал ухуулгаас ажиллах хүч рүү (1932-59)</i>	60
<i>Олон улс дамнасан (transnational) феминизмийн хүч (1959-70)</i>	65
<i>Эмэгтэйчүүдийн байдал дээшилж удирдлагын түвшинд ахисан түүх (1960-90)</i>	70
<i>Дүгнэлт: Хийсвэр Зарчмын хүч</i>	72
2 Сонгуульжилт: Засаглал ба ардчиллын шинэ эдийн засгийн хэлбэрүүд	79
<i>Хөөрсөн улс</i>	79
<i>Сонгуульжилтын талаарх товч түүх</i>	85
<i>Нэр дэвшигчид: суудлаас олон ялагч</i>	90
<i>Сонгогчид: Амлалт бус үр дүнг хүлээх нь</i>	93
<i>Сонгуулийн шинэ эдийн засаг: халтуурчид ба сонгуулийн мэргэжилтнүүд</i>	99
<i>Хайхрахгүй хүн: субъектив шинж байдал ба “нийтийн дуу”</i>	105
<i>Эрх мэдэл хадгалагчид ба сонгуулийн амлалт</i>	108
<i>Дүгнэлт: Улс төрийн цаг хугацааг залуурдах нь</i>	114
3 Гадаргуу: Кампанит ажил ба жендэр, улс төрийн харилцан хамаарал	120
<i>Өнөө үеийн өнгөц шинж</i>	120
<i>Хэвлэл мэдээллийн кампанит ажлын сүрреалист орчин</i>	124
<i>Хэмжээ: Яагаад ийм их байдаг вэ?</i>	131
<i>Танигдах нь: уйтгартай зураг ба, эрсдэл хүлээгчид</i>	133
<i>Гадаргын гүнд</i>	140
<i>Шударга Жендэр</i>	145
<i>Иргэний хамгаалалт</i>	147

<i>Гадаргууг өргөжүүлэх нь</i>	150
<i>Дүгнэлт: Зургийн гуравласан хэлхээ</i>	154
4 Тайзны ар тал: Кампанит ажлын өмнөх стратеги	158
<i>Шинэ нэр дэвшигч: Жендэрийн нормоос гадуур</i>	158
<i>Улс төрд оролцохын төлөө төрсөн хүн</i>	162
<i>Стратеги ба тактик</i>	165
<i>Нөлөөлөхүйц стратегиуд: Мэдлэгийн Ажил, Шөнийн ажил, Уух ажил</i>	168
<i>Бүтцийн стратеги: Тойргийн төлөөх тэмцэл</i>	172
<i>Том зургаар харах туршлага: Дэмжлэгийн суурь, үнэт зүйлээ бий болгох нь</i>	176
<i>Тактикаа өөрчлөх нь: Дотоод өрсөлдөөн, уналт</i>	179
<i>Өөр нэгний нутаг дэвсгэрт: Кампанит ажил засаглах нь</i>	180
<i>Дүгнэлт: Сонгуульжилтын хүч</i>	186
5 Оюунлаг: Эмэгтэйчүүд мөнгөний кампанит ажлын эсрэг	189
<i>Торгон Ухаан</i>	192
<i>Кампанит ажлыг сааруулсан нь</i>	196
<i>Оюунлаг харизм</i>	198
<i>Оюунлаг алдартан: Уран зохиолоороо санхүүжилт босгосон нь</i>	204
<i>Бэлгэдлийн капитал ашиглан кампанит ажил явуулах нь:</i>	
<i>Улс төр дэх шинэ Оюунлаг</i>	208
<i>Нийгмийн тойрог, ба нийгмийн сүлжээ</i>	211
<i>Цуглуулагчид, бие халаагчид, болон дагалдагчид</i>	215
<i>Санхүүжилт: Эмх замбараагүй байдлын эсрэг гарын авлага</i>	218
<i>Луйврыг нь илчилсэн 2008 оны сонгуулиас 2012 оны сонгууль хүртэл</i>	220
<i>Дүгнэлт: Оюунлаг байдал сүйрүүлэх хүч болох нь</i>	225
6 Биеэ бэлдэх нь: Нэр дэвшигчийн дотоод болон гадаад дүр төрх	228
<i>Хувиргалт</i>	228
<i>Неолиберализмын нугачаанууд</i>	229
<i>Супер нарийн бичгийн дарга ба нэр дэвшигч</i>	233
<i>Сонгогдохуйц гэдэг барьцгүй байдал</i>	234
<i>Биеэ бэлдэх нь: Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас</i>	238
<i>Хэв маягаа тодорхойлох нь: Хослол ба дээл</i>	239
<i>Харизм ба орчин цагийн Дээл</i>	246
<i>Дотоод хүнээ хөгжүүлэх нь: Нэр дэвшигч байхын төлөө</i>	249
<i>Дүгнэлт: Гоо сайхан Улс төрийн төсөл болох нь</i>	254
Дүгнэлт: Шилэн тааз томруулдаг шил болох нь	257
<i>Талархал</i>	263
<i>Ном зүй</i>	266
<i>Нэрийн хэлхээс</i>	281

Товчилсон үгийн жагсаалт

АН – Ардчилсан нам

БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ЗХУ – Зөвлөлт Холбоот Улс

МАН – Монгол Ардын Нам

МАХН – Монгол Ардын Хувьсгалт Нам

МПБ – Монголын Пионерийн Байгууллага

МСК – Мянганы Сорилтын Компакт гэрээ

МҮЭХ – Монголын Үйлдвэрчний Эвлэлуудийн Холбоо

МХЗЭ – Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл

МЭХ – Монголын Эмэгтэйчүүдийн Хороо

НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага

НҮБХХ – Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

СЕХ – Сонгуулийн Ерөнхий хороо

ТББ – Төрийн Бус Байгууллага

Өмнөтгөл: Хилари Клинтон Монголд

2012 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн дарга Хилари Клинтон Монгол Улсад айлчлав (дүрс. зураг 1). Энэ талаар Нью-Йорк Таймс сэтгүүлд “Монголын хөрш залгаа Хятад, холгүй орших Сингапур улсын удирдагчид ардчиллын үнэт зүйлс баруунд л хэрэгжих боломжтой хэмээн шууд бусаар шүүмжилдэг ч, авторитар дэглэмээс ардчилал хэрхэн бойжиж болохыг харуулсан Монголын ардчиллын загварыг Обамагийн засаг захиргаа нүдээр үзэхээр иржээ” хэмээн бичиж байлаа (Perlez 2012). Айлчлалын өмнөхөн болсон Ерөнхийлөгч асны баривчилгаа Монголын ардчиллын дүр төрхөд нөлөөлсөн байж болзошгүй ч Клинтон парламентад шинээр сонгогдсон 9 эмэгтэй гишүүнд тусгайлан баяр хүргээд буцсан юм. 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд 9 эмэгтэй гишүүн сонгогдоод байсан нь 2008 оны сонгуулиар сонгогдсон эмэгтэйчүүдээс 3 дахин, 1990 оноос хойших бүх ардчилсан сонгуулийн дундаас хамгийн олон эмэгтэйчүүд сонгогдсон сонгууль байлаа¹. Клинтон айлчлал нь “Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх олон улсын чуулга уулзалт”-тай давхацсан бөгөөд Клинтон ч парламентад сонгогдсон эмэгтэй гишүүдэд үргэлжлүүлэн баяр хүргэсээр байлаа.

Тус ном нь эмэгтэйчүүд улс төрд хэрхэн бэлдсэн, ээдрээ төвөгтэй нөхцөл байдлаас хэрхэн амжилтад хүрсэн болон тэдгээр эмэгтэйчүүдийн туршлага жендэр, улс төрийн харилцан хамаарлыг хэрхэн тодорхойлж байгаа талаар өгүүлнэ. Ардчилагдаж буй Монголын улс төр дэх эмэгтэйчүүдийн туршлагыг нарийвчлан үзвэл тэдний парламентад хүрэх зам нь дардан биш, эрх зүйн, санхүүгийн болон улс төрийн саад тотгор тэдэнд байнга учирч байсан нь тодорхой байна. Улс төрийн нам эрэгтэй нэр дэвшигчдийг түлхүү дэмждэг, сонгуулийн кампанит ажилд шаардагдах санхүүгийн зардал маш өндөр гэх зэрэг хүчин зүйлстэй эмэгтэй улс төрчид тулгарах шаардлагатай болдог төдийгүй 2008 оны сонгуулийн өмнө нэр дэвшигчийн хүйсийн квотыг хүчингүй болгосон билээ.

Тус ном нь эмэгтэйчүүд сонгогдохуйц сонгуулийн хууль бэхжүүлэх, нөөцийг цуглуулах, хуваарилах, өөрсдөө сонгогдохын тулд яаж биеэ бэлдэж амжилтад хүрэх шинэ стратеги боловсруулах гэсэн эмэгтэйчүүдийн

¹ Сонгуулийн өдрөөс хойш (2012 оны 6-р сарын 28) нөхөн сонгуулиар хоёр эмэгтэй сонгогдсоноор Парламент нийт 11 эмэгтэй гишүүнтэй болов.



Дүрс. Р1. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хилари Клинтон Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржтой ерөнхийлөгчийн өргөөнд уулзаж байна. Улаанбаатар хот, 2012 он. Брэндан Смиаловский. Getty images –аас авав.

өдөр тутмын хүчин чармайлтыг антропологийн үүднээс судалсан бүтээл юм. Монгол Улс ардчилал, неолиберализм руу шилжих цаг үед эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийнхөө шинэ дүр төрхийг бүтээхийн зэрэгцээ Монгол дахь жендэрийн байдал, олон нийтийн дунд эмэгтэйчүүдийн талаарх ойлголтыг ч өөрчлөх шаардлагатай тулгарч байсныг харуулдаг. “Сонгуульжилт” гэх ойлголтыг голчлон авч үзэв. Энэхүү нэр томъёоны улс төрийн кампанит ажлын өргөн хүрээг хамарсан шинж чанар, сонгуулийн улс төр бидний өдөр тутмын амьдралд нэвчин орж буй байдал, мөн сонгуулийн кампанит ажилтай холбоотойгоор бий болсон нийгмийн бүтэц, улс орныг удирдах төрийн болон олон нийтийн чиг үүрэгт хэрхэн нөлөөлж буйг илэрхийлнэ. Монгол Улс дэд бүтэц, төрийн болон өдөр тутмын зохион байгуулалтын чиг үүргийн хувьд сонгуулиас ихээхэн хамааралтай болж, сонгуульжилт нь засаглалыг орлох бүрэн бус хэлбэр болон хувирлаа.

Үүний зэрэгцээ, хүмүүс сонгуулийг неолиберализмын тогтворгүй байдлыг даван туулах механизм болгон ашиглах болж, сонгууль ч анхдагч зорилгоосоо давсан илүү өргөн хүрээний зүйл болон хувирсныг харуулахыг зорилоо. Хэдийгээр эмэгтэй нэр дэвшигчдийг судлахдаа 2006-2020 оны хооронд болсон сонгуулиудыг авч үзсэн боловч 2008, 2012 болон 2016 оны сонгуульд голчлон төвлөрсөн. 2008 оны сонгуулийн кампанит ажил харагдахуйц байдлаараа хамгийн түрэмгий, эмэгтэйчүүдийг нэр

дэвшүүлэх 30 хувийн квотыг гэнэт цуцалсан, сонгуулийн дараа бий болсон үймээн самуун зэрэг шинжээрээ жендэр, улс төр, дэлхийн капитализм зэрэг ойлголтын хоорондын орооцолдоог харуулсан сонгууль болсон юм. 20 хувийн квоттой шинэ загвараар зохион байгуулсан 2012 оны сонгууль эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй сайн үр дүнг үзүүлэв. 2016 онд нэр дэвшигчийн квот эмэгтэйчүүдэд ашигтай байсан боловч, эмэгтэйчүүдийн оролцоог цааш нэмэгдүүлэх үйл ажиллагаа суларчээ. Би оролцон ажиглах арга зүй ашиглан 2008, 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн туулсан замнал, түүх, улс төрийн нөхцөл байдлыг задлан харуулахыг оролдлоо.

Энэхүү антропологийн шинжилгээ нь ардчилсан сонгууль, неолиберал төслүүд хэрхэн хэрэгждэг талаарх норматив хэв загвараас Монголын жишээ яагаад ялгаатай вэ гэдгийг харуулна. Жишээлбэл, неолиберализмыг дэмжигчдийн таамаглаж байсанчлан сонгууль нь бүтээмжтэй, цомхон засгийн газрын эрин үеийг бий болгохын оронд албан тушаал эрхэлж буй хувь хүмүүсийн үзэмжид суурилсан, хүлээлтээс илүү нүсэр төрийг бий болгожээ. 1990-ээд онд неолиберал “цохилт”-той тулгарсан, өмнөх 70 жилийн туршид үйлчилж байсан (1921-1990) социалист практик зэргээс үүдэн санаатай болон санамсаргүйгээр пост-социалист Монголын улс төрийн хэв загвар нь зөрчилтэй ардчилал маягийн байдалтай байна. 1990-ээд онд Монгол Улс ардчиллын үйл явцыг өлгийдөн авснаар улс төрийн амьдралаа зохион байгуулах арга хэлбэр төдийгүй үндэсний танигдахуйгаа шинээр бий болгосон буюу Зөвлөлтийн нөлөөнөөс гарч (энд Монголын нөгөө том хөрш Хятад бас хамаарна), олон улсын тавцанд өөрийгөө төлөөлөх хаалгыг нээсэн хэрэг болсон юм. Хэдийгээр Монгол Улс социализмын төгсгөлд хуучин “коммунист” намаа (Монгол Ардын Хувьсгалт нам буюу МАХН) татан буулгаагүй ч, Зүүн болон Төв Европын улсуудын нэгэн адил “ардчилсан” улс болж, ардчилсан улсын хувиар улс төрийн, нийгэм, соёлын болон эдийн засгийн хувьд хүчирхэгжих эрмэлзэлтэй болсон².

1990-ээд онд ардчиллын үйл явцтай зэрэгцэн, Монголд чөлөөт хэвлэл, зах зээлийн эдийн засаг, иргэний нийгэм эрчимтэй хөгжиж 10 жилийн дотор харьцангуй ардчилсан улс болов. 2000-аад оны сүүл үе гэхэд уул уурхайн нөөцтэй холбоотойгоор улс төрийн хүчнүүд тэдгээр институцийг хязгаарлаж, дургүйцлээ илэрхийлж эхэллээ. Тухайлбал, 2008 оны сонгуулийн дараах жагсаалыг төр хүчээр дарсан, эрүүдэн шүүж хүний эрх зөрчсөн, үймээн самууны үеэр 5 иргэн амиа алдсан зэрэг нь ардчилал эмзэг байсныг харуулдаг. Монголчуудын дийлэнх нь албан тушаалтны авлига, төрийн хяналт шалгалт, эрх мэдлээ урвуулан ашиглах, улс төрчдийн ёс

² 1990-ээд онд, социализмын төгсгөлд МАХН-ын бүтцийг хадгалан үлдэх нь геополитикийн асуудал байв. Зөвлөлт Холбоот Улс, Хятадынхтай ижил, төстэй намыг татан буулгах нь өдөөн хатгалга мэт харагдаж болох байсан. 1989, 1990-ээд онд Монгол Улс ардчилсан шилжилт хийсний дараа Зөвлөлт Холбоот Улс Монголд хориг тавьж, орлогыг нь 30 хувиар багасгахад хүргэсэн төдийгүй газрын тосны нийлүүлэлтээ тасалснаар 1990 оны эхэнд Монголчууд хэдэн сарын туршид газрын тосгүй, зогсонги байдалд орсон юм.

зүйгүй, чадваргүй байдалд санаа зовнисоор ирэв.

Уул уурхайн салбар дах гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхайн салбараас ирээдүйд олж болох орлого зэргээс шалтгаалан 2009-2014 онуудад эдийн засаг “эрчимтэй өссөн” нь дундаж давхарга, бизнес эрхлэгчдэд урам зориг, хүлээлтийг бий болгов. Гэвч удалгүй эдийн засгийн уналт болж, дундаж болон доод давхаргынхан хумигдаж буй амьжиргаагаа залгуулахын тулд амь тэмцэж эхэллээ. Неолиберал өөрчлөлтүүдийн дийлэнхийг Ардчилсан Намын (АН) удирдлагууд санаачилсан тул, ихэнх иргэд ардчиллыг неолиберализмтай хольж хутган, улмаар ардчилалд итгэл алдарч эхэлсэн юм. Мөн популизм, үндсэрхэг үзэл, эмэгтэйчүүдийг гадуурхах үзэл цэцэглэн хөгжиж, сонгуулийн санхүүжилт ихээхэн нэмэгдсээр ирсэн бөгөөд эх үүсвэр нь одоо ч ил тод биш байна. 2021 оны байдлаар, 2016 оноос хойш засгийн эрхэнд буй Монгол Ардын Нам (МАН) КОВИД-19 цар тахалтай тэмцэхийн хажуугаар давуу байдал олж авснаар улам бүр хүчирхэгжив³.

Өнгөрсөн хүндхэн үйл явдлууд болон ардчиллын үйл явц, зарчмын хувьд ч, бодит байдалд ч, Монголын эмэгтэйчүүдийн байр суурь, жендэрийн дүр төрхөд хэрхэн нөлөөлсөн бэ? Мэдээж нээлттэй байдал, олон улсад аялах боломж, чөлөөт зах зээл маш олон эмэгтэйд ач тусгаа өгсөн. Гэхдээ Монгол Улс социалист үеэс шилжихдээ, социализмын үед эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн байдал, улс төрийн албан тушаалыг дэмждэг байсан олон хөтөлбөр, квотыг хамтад нь орхисон байдаг. Социализмын оргил үед, социалист улсууд олон улсын тавцанд эмэгтэйчүүдийнхээ амжилтыг харуулсаар иржээ. Учир нь социализмын эмэгтэйчүүдийн байр суурь нь тухайн улс хөгжлийн аль түвшинд буйг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг байв. Өөрөөр хэлбэл, Монголын удирдагчдыг үнэлэх, улмаар татаас, зээл тусламж үзүүлэх, тэр бүү хэл найрсаг харилцаатай байх эсэхийг шийддэг хүчирхэг холбоотнуудад нь маш чухал байсан нь, Монголын төр эмэгтэйчүүдийг дэмждэг шалтгааны нэг байжээ.

Социализмын дараа, эмэгтэйчүүдтэй холбоотой дэвшилтэт үзүүлэлт нь ач холбогдолгүй болсноор, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих гаднын сэдэлгүй болсон юм⁴. Капитализм нь угаас эрчүүд төвтэй систем

³ Монгол Ардын Нам (МАН) 1920 онд байгуулагдаж, 1924 онд Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) болж нэрээ өөрчилсөн юм. 2010 онд намын нэрээ “хувьсгалт” гэх үгийг авч, ууган нэрээ сэргээсэн бөгөөд, нэг фракц МАХН гэх нэрийн хадгалан тусдаа улс төрийн нам байгуулав.

⁴ Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих оролдогууд олон төрлийн хүндрэл, бэрхшээлтэй тулгарсаар ирэв. 2005 онд НҮБ-ын Мянганы Хөгжлийн Сан байгуулагдаж, Монгол Улс хэлэлцээрт нэгдэн орсон бөгөөд тус сангаас тэтгэлэг авахын тулд эмэгтэй удирдагчдын хувийг нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн юм (Undarya 2009, 147). 2006 онд Монголын парламент хэлэлцээрийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихийн тулд нэр дэвшигчийн хүйсийн квот 30%-аар тогтоосон боловч, 2007 онд тус квотыг цуцлав (Энэ талаар удиртгал хэсэгт ярилцсан). УИХ-ын намрын чуулганаар нэр дэвшигчийн хүйсийн квотыг хүчингүй болгох эсэхийг хэлэлцэж байх үеэр УИХ-ын гишүүн Эрдэнийн Бат-Үүл тус квотыг хадгалах ёстой, квотыг цуцалбал олон улсын хамтын нийгэмлэгийн нүдэнд Монгол Улс итгэл хүлээж чадахгүй гэж харагдана шүү дээ (“2007 оны УИХ-ын намрын чуулганы хуралдааны тэмдэглэл” 2008 оны 1-р сарын 10, УИХ-ын архив) гэж хэлж байлаа. Монгол Улсын Засгийн газраас 2013 онд бэлтгэсэн Мянганы Хөгжлийн Зорилгуудын хэрэгжилтийн үндэсний тав дахь илтгэлд улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг “хэрэгжих магадлал бага” буюу үнэлгээний схемийн хамгийн бага ангилалд багтаан тодорхойлжээ.

учир эмэгтэйчүүдийн байр суурьд төрөөс тавих анхаарал улам суларлаа. Эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгмийн байдлыг дэмжиж ирсэн хүүхдийн өдөр өнжүүлэх болон цэцэрлэг, ясли, улс төрийн албан тушаалд тавих хүйсийн квот зэрэг дэмжлэгүүд нь 1990 оны ардчилсан шилжилтийн эхэн үеэс эхлээд нэг хэсэгтээ бүрэн орхигджээ. Эмэгтэйчүүдийн дэмжлэгийг орхигдуулснаас хор хөнөөлтэй үр дагаврууд бий болж, улмаар эмэгтэйчүүд 2000-аад оноос эхлэн өөрсдийн эрхийг шаардан хүчтэй дуугарч эхэлсэн юм⁵. Хуучин Зүүн Европын улс орнууд болон социализмыг туулсан ихэнх улс орнуудын нэгэн адилаар Монголын парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл социализмын үед 25-30 хувь байсан бол, ардчилалд шилжсэнээр 3-8 хувь (1992-2004) болтлоо буурчээ⁶. Харин 2012 онд, нэр дэвшигчийн квотыг 20 хувь болгосноор, ардчилсан, неолиберал эрин үед, анх удаа 9 эмэгтэй (12 орчим хувь) хууль тогтоох байгууллагад сонгогдов. Социалист дэглэмээр хүрээлүүлсэн Монгол Улс орчин үеийн ололт амжилтаа харуулах үүднээс, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хилари Клинтон айлчлалын үеэр Олон Улсын Эмэгтэйчүүдийн Чуулга Уулзалтыг зохион байгуулжээ (Удиртгал хэсэгт буй дүрс 1-ийг үз).

Социалист төр эмэгтэйчүүдийг төрөл бүрийн мэргэжлээр, бүх түвшинд бэлтгэсний үр дүнд дээд боловсролтой эмэгтэйчүүд, эрчүүдтэй харьцуулахад илүү олон болж, зарим эмэгтэйчүүд олж авсан туршлага дээрээ үндэслэн чухал албан тушаалд ажиллах болсонд талархууштай. Хэдийгээр эмэгтэйчүүд зарчмын болон эрх зүйн хувьд өндөр албан тушаал хаших нь нээлттэй боловч, бодит байдалд олон бэрхшээлтэй тулгардаг юм. Эмэгтэй нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөж, кампанит ажлаа хийж эхэлсний дараа жендэрт суурилсан урьдчилж мэдэхийн аргагүй саад тотгорыг даван туулах болдог. Гэхдээ маш олон бэрхшээлээс хамгийн тодорхой нь бол санхүүгийн асуудал юм. Энэ нь бүр 1990-ээд оны өмч хувьчлалын жилүүдэд ихэнх эмэгтэйчүүд хөрөнгө хуваарилалтаар эрчүүдтэй тэгш хувь хүртээгүйгээс үүдэлтэй.

Арилжааны шинжтэй болсон, нэр дэвшигч санхүүжилтээ ихэнхдээ хувиасаа гаргадаг сонгуульд (АНУ-ын санхүүжилт босгох загвараас сууриараа гэс өөр) хувь хүний баялаг нь шийдвэрлэгч хүчин зүйл болжээ. Сонгогчдын Боловсролын Төвөөс гаргасан статистик мэдээллээр нэг нэр дэвшигчийн сонгуулийн зардал 1992 оноос 2012 оны хооронд 2295 дахин өсжээ (Oyuntuuya 2013a). Ийм нөхцөлд, ихэнх эмэгтэй нэр дэвшигчид мөнгөний хүчин зүйлд найдахаасаа илүү өөрсдийн гаргасан

⁵ Нэгдүгээр бүлэгт ярилцсанчлан, хэдийгээр социализмын үед удирдах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийг “квот” гэх үгийг ашиглаж байгаагүй боловч 1950-1960-аад оноос эхлэн удирдах албан тушаалын 25 хувиас доошгүй нь эмэгтэйчүүд байхаар хууль хэрэгжиж эхэлсэн.

⁶ Монгол Улс 1973 онд 336 суудалтай парламентад 77 эмэгтэй гишүүн; http://www.ipu.org/parline-e/reports/arc/MONGOLIA_1973_E.PDF, 1977 онд, 354 суудлын 82 нь эмэгтэй; http://www.ipu.org/parline-e/reports/arc/MONGOLIA_1977_E.PDF, 1981 онд 370 суудлын 90-ийг эмэгтэй гишүүд http://archive.ipu.org/parline-e/reports/arc/MONGOLIA_1981_E.PDF тус тус эзэлж байжээ.

амжилт (жишээлбэл, Стэнфорд, Йел гэх мэт дэлхийн нэр хүндтэй их сургуулийн диплом), үзэл санааныхаа үнэн зөв байдал, нэр хүнд, сүлжээ, ялангуяа олон улсын тавцан дахь танилын хүрээлэл зэрэг бусад илэрхийлэх үнэ цэний нөөцөд илүү найддаг. Тэд сонгогдохын тулд төгс, өө сэвгүй, оюунлаг, харизмтай, мөн үзэсгэлэнтэй байхыг хичээдэг. Дийлэнх Монголчууд харизм гэж юу болох, улс төрч эмэгтэйн зохист дүр төрх ямар байх талаарх төсөөллийг Хилари Клинтон, Ангела Меркел, арай ахмад үеийнхэн нь бол Маргарет Тэтчер зэрэг дэлхийн хүчирхэг эмэгтэй улс төрчдийн дүр төрхөөр төсөөлнө. Тиймээс, Монгол эмэгтэй нэр дэвшигчийн талаарх судалгаа уншигчийн байгаа газраас нь үл хамааран сонирхолтой байх болов уу. Ихэнх Монгол эмэгтэй нэр дэвшигч нар даяарчлалын шинжүүдийг Монгол хүнийхээ шинжүүдтэй хослуулжээ. Тэд өндөр боловсролтой, дээд давхаргын, өөрийгөө хөгжүүлсэн, улс төрд бэлтгэгдсэн Дэлхийн иргэн зэрэг улс төрч эмэгтэйчүүдийн танигдахуйд ач холбогдол өгнө. Мөн адилхан, төрсөн газар, хэл, гэрлэлтийн байдал, Монголын ирээдүйд санаа зовних гэх мэт бусад Монгол хүний танигдахуйг бас эрхэмлэжээ. Тэд Монгол хэлээрээ ярьж, Монгол Улсыг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж танилцуулахын зэрэгцээ, өөрсдийгөө дэлхийд танигдсан удирдагчдын адил тэгш харуулах шаардлагатай гэж үздэг. Дэлхийн дайтай эмэгтэй удирдагчдыг төсөөлж буй нөхцөлд Монгол эмэгтэйн чамин дүр төрхийг гаргах учир энэ нь ихээхэн сонирхолтой даалгавар билээ.

Монгол дахь Буриадуудын бөөгийн зан үйлийн талаарх “Эмгэнэлт Онгодууд” (Tragic Spirits) (Buyandelger 2013) хэмээх өмнөх номдоо би бөө мөргөл нь орчин үеийн хүлээн зөвшөөрөгдөөгүй ихэр нь болж оршиж байдаг тухай, бас сүнслэг байдал Монголын нийгэм улс төрийн амьдралд хэрхэн сүлжилдсэн байдаг тухай өгүүлсэн. Харин энэхүү номоо бичихдээ Монгол орныг алслагдсан, эртний уламжлалт орон гэсэн гадаадад зонхилох ойлголтыг хослол өмссөн, олон улсын тавцанд илтгэл тавьсан, Харвард, Йелийн их сургуульд сурсан, Хилари Клинтонтой хөөрөлдсөн, хүчирхэг, орчин үеийн эмэгтэйн дүр төрхтэй мөргөлдүүлэн хослуулах хэрэгтэй болсон юм.

Үнэн хэрэгтээ, Монгол эмэгтэйчүүд ардчиллын үед улс төрд орж идэвхтэй болсон юм биш. Социализмын үед ч гэсэн Монгол эмэгтэйчүүд аль хэдийнээ байр сууриа олсон, нийгэмд идэвхтэй оролцдог байсан тул улс төрд эмэгтэйчүүдийг байршуулах гэдэг нь жигтэй санагдаж байна. Тиймээс би антропологийн үүднээс “хөндийрөлт”-ийн аргаар зарим мэдээжийн гэж бодогдох зүйлээ “холоос харах” хэрэг гарав. Миний хувьд, 1970, 1980-аад оны Монгол Улс НҮБ-ын Эмэгтэйчүүдийг Дэмжих Арван Жилийн бодит биелэл болсон улс байлаа. Монгол Улс олон улсын эмэгтэйчүүдийн хуралд эмэгтэйчүүдийг оролцуулдаг, эмэгтэйчүүдийн төлөөллөө боловсролтой, орчин үеийн, улс төр, нийгмийн амьдралд

чухал үүрэгтэй гэдгийг байнга сурталчилдаг байлаа. НҮБ-ын Эмэгтэйчүүдийг Дэмжих Арван Жилд өрнөсөн үйл явдлын өмнө болон дараа эмэгтэйчүүдийг дэмжих төрөл бүрийн арга хэмжээ хэрэгжсэн юм. Миний ээж Мэнгэтийн Буяндэлгэр Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн (1967 онд байгуулагдсан, Монгол Телевиз гэгддэг тухайн үеийн цор ганц телевиз байв) анхны сэтгүүлчдийн нэг байсан. Би хослол, даашинз өмссөн, карьертай эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд өссөн бөгөөд одоо бодоход сэтгүүлчид, редактор, найруулагчид, инженерүүд, соёлын мэргэжилтэн, судлаачид, байгууллагын газар, хэлтсийн дарга гэх мэт нэр хүндтэй ажил эрхэлдэг хүмүүс байж. Манай хөрш айлын эгч Монголын анхны зураглаач байсан бөгөөд, миний ээж 1966 онд Никон брэндийн анхны СЛР (SLR) камер авснаар тус камерыг эзэмшдэг анхны Монголчуудын нэгд тооцогдож байлаа. Монголын Эмэгтэйчүүдийн Хорооны үндсэн сэтгүүлч, талийгаач Ишхандын Эрдэнэчимэг эгч манай гэр бүлийн найз байсан. Энэ номд өгүүлэх түүх магад эндээс эхэлсэн байх. Эрдэнэчимэг эгч Мисс Диор (Miss Dior) үнэртэй ус үнэртүүлж, чанадаг кофе авчирдаг байсан бөгөөд аль нь ч тухайн үед Монголын дэлгүүрүүдэд байдаггүй байлаа. Тиймээс энэ нь олон улсад харилцаа холбоотой, тэр нь бүр жендэрт суурилсан холбоо байсны тэмдэг юм. Тэр үед манай дээд айлын Юндэнгийн Эрдэнэтуяа эгч Монгол Телевизийн дарга болсон нь үндэсний хэмжээнд хамгийн өндөр албан тушаалын нэг байв. Би энэ мэт карьертай бүсгүйчүүдийн дунд л өсөж торнисон.

Социалист нийгмийн үед хязгаарлагдмал байдлаар ч атугай хэрэгжиж эхэлсэн жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа ардчиллын жилүүдэд ч үргэлжилж, улам сайжирна гэж би гэнэнээр бодож явжээ. Эсрэгээрээ, ардчилсан тогтолцоо нь шинэ аргуудыг шаарддаг, огт өөр боломжуудыг санал болгодог, мөн өөрийн өвөрмөц дүрэмтэй зүйл аж. Ардчиллын үед эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөр байхыг шаардав. Сонгуулийн, өдөр тутмын улс төр, эмэгтэй нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажилд анхаарал хандуулснаар тус ном нь Нью-Йорк Таймс “Дэлхийн дахинд парламент дэх эмэгтэйчүүдийн . . . хувь хэмжээг нэмэгдүүлэх нь . . . тэвчихийн арга үгүй удаан үйл явц болсон байна” (Sengupta 2015) гэж халаглахад хүргэсэн Монгол Улсын болон дэлхий дахины динамикийг өгүүлэх болно. Энэ ном нь Олон Улсын Парламентын Холбооны асуусан: “Энэ дэлхийд эмэгтэйчүүд бүгд шилэн таазанд тулчихсан уу? - гэсэн асуултад хариулж, эмэгтэйчүүдийн улс төрд оролцоход тулгамддаг бэрхшээл болон боломжуудыг нь задлан өгүүллээ.

Тус номыг бичих, судалгаа хийх он жилүүдэд, 2016 оны сонгуулиар Хилари Клинтон Доналд Трампд ялагдаж, тус сонгуулийн үр дүн дэлхий дахиныг цочирдуулж, эмэгтэйчүүдийг үзэн ядах үзэл, хүйсээр ялгаварлан гадуурхах үзэл газар авлаа. Саяхан 2021 оны ерөнхийлөгчийн

сонгуулийн өмнө Монгол Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Оюунгэрэл нэр дэвшихээ зарлахад нийгмийн сүлжээ тэр чигтээ түүнийг хүйсээр ялгаварлан гадуурхах, нэр төрийг нь гутаах гэсэн оролдлого, доромжлолоор дүүрэв. Ковид 19 цар тахлын үеэр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдэж, тэдний карьерт сөрөг нөлөөлсөн гэх мэтээс үзэхэд жендэрийн асуудлыг бүтцийн түвшинд дахин авч үзэх шаардлагатай нь илэрхий байна.

Удиртгал Сонгогдохуйц байх нь: “Эмэгтэй Бүр Өөрийнхөө Төлөө”

Шийдвэрлэх үйл явдал

“УИХ-ын сонгуульд би ялна гэж бодож байна. Учир нь би олон эрэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлыг удирдан зохион байгуулж, ялуулж байсан туршлагатай” хэмээн нэр дэвшихдээ бэлдэж байгаа Лэгцэгийн Ариунаа надад хэлж билээ¹.

Тээр жил би нэлээн хүчтэй өрсөлдөгчийн эсрэг багахан зардалтай кампанит ажил удирдсан юм. Сонгуулийн өдөр хүмүүсийг сэрээгүй байхад нь багаа эрт босгоод, тойргийнхоо бүх гудамжийг шаар, бас нэр дэвшигчийнхээ зургаар чимээд дүүргэчихлээ. Санал авах байрны үүдэнд шаарнаасаа өлгөж, бас нэр дэвшигчийг дэмжсээрэй гэсэн уриатай плакатнууд наалаа. Ёстой л олны анхаарлыг үнэхээр татаж чадсан. Бид тэр сүүлийн өдөр л саналын багахан зөрүүгээр ялчхаж байгаа юм. Надад сонгуулийн Пи-Ар [PR] яаж зохион байгуулах, нэр дэвшигчээ хэрхэн ялуулах туршилага байна. Кампанит ажлаа надаар ахлуулсан нэр дэвшигч бүр ялсан. Одоо би нэрээ дэвшүүлнэ гэж бодож байгаа.

Бид Ариунаагийн Улаанбаатар хотын төвийн дэгжин тохижилттой гэрт нь алтлаг шаргал буйдан дээр нь ярилцаж суулаа. Би түүнээс урьдах

¹ Энэ номд онцлон тэмдэглэсэнээс бусад тохиолдолд олны танил хүмүүс, эмэгтэй нэр дэвшигчдийн жинхэнэ нэрийг ашиглав. Харин олны танил болон олны танил бус хүмүүсийн хувийн нууцыг хүндэтгэх үүднээс зарим тохиолдолд нууц нэр ашиглалаа. Нууц нэр ашиглаад ч олны танил хүмүүс танигдах тохиолдолд тухайн хүний онцлогийг тодорхойлох ямар нэг шинжийг улам тодруулахаас татгалзаж ерөнхий төлөөний нэр ашигласан (жишээ нь, хэн нэгэн надад хэлсэн, судалгааны маань ярилцагч гэх мэт).

сонгуулиудад яагаад нэр дэвшээгүй талаар асуулаа. Социалист нийгэм 1990 оноос хойш задарсны дараа 2008 он гэхэд 6 дахь удаагийнхаа УИХ-ын сонгууль болж байхад тэрээр яагаад анх удаа нэр дэвших болов? гэж асуувал, “Учир нь түүнээс өмнө нэр дэвшинэ гэдэг нь эмэгтэйчүүд бидний хувьд тийм ч амар зүйл биш байв. Харин одоо улс төрийн нам бүр нийт нэр дэвшигчдийн 30 хувиас доошгүй нь эмэгтэй нэр дэвшигч байх ёстой гэсэн квот тавигдсанаар бидэнд хууль зүйн шинэ орон зай бий болж бид бас итгэлтэй, зоригтой болсон” гэж тэр хэлсэн юм.

“Та олон кампанит ажил удирдаж байсан, сонгууль хэрхэн өрнөдгийг сайтар мэдэж байсан юм чинь өмнөх сонгуулиудад нэр дэвшиж болох л байсан биз дээ?” хэмээн би тулгаж асуулаа. Ариунаа Ардчилсан Намын (АН), Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбооны (АЭХ) тэргүүлэгч байсан тул нэр дэвшигч болоход бүрэн боломжтой байсан билээ. Тэр гангар шаазанд ногоотой шөл надад аягалангаа “Огтхон ч үгүй” хэмээн илэн далангүй хариулж билээ.

Тийм зүйл байхгүй ээ. Намын эрэгтэй нөхдийнхөө тэмүүлж буй руу тэмүүлж, тэдэнтэй өрсөлдөх нь тийм амар зүйл биш. Сүүлийн сонгуулиар өрсөлдсөн ч гэсэн эрэгтэйчүүд ялах нь ойлгомжтой л байсан. Эмэгтэйчүүдэд ялах боломж тун бага байсан. Квотыг хуульчлах нь бидэнд нэр дэвших итгэлийг нэмэгдүүлээд зогсохгүй, ялах өчүүхэн ч атугай магадлал буйг, мөн бид ижил статустай хүмүүс гэдгийг эрчүүдэд ойлгуулахад чухал нөлөөтэй. Квотгүй бол эмэгтэйчүүдэд бараг л боломж байхгүй гэсэн үг. Харин квоттой тохиолдолд бид эргэлзэх хэрэггүй.

Санхүүгийн хязгаарлагдмал байдал, улс төрд гадуурхагдах, мөн, эмэгтэйчүүдийг хүйсээр нь дорд үзэх байдал гэх мэт олон төрлийн саад, бэрхшээлээс үл хамааран нэлээд олон эмэгтэй 2008 оны сонгуулийг тэсэн ядаж хүлээж байлаа. Учир нь Ариунаагийн хэлснээр олон жилийн лобби, нөлөөллийн ажлын эцэст 2006 онд Монгол Улсын Их Хурал эмэгтэй нэр дэвшигчдийн 30%-ийн квотыг баталсан юм. Тус хууль батлагдсанаар эмэгтэйчүүд парламентад сонгогдох урт хугацааны эрмэлзлээ биелүүлэх боломжтой болов.² Сонгуулийн эцсийн үр дүнг будилаантуулж болзошгүй гэдгийг эмэгтэй нэр дэвшигчид болон нэр дэвших статус горилогчид мэдэж байсан хэдий ч тэд улс төрд өөрийн гэсэн орон зай олгосон квотод найдаж байлаа.³ 2006 оны зун нэр дэвших төлөвлөгөөтэй бусад ажлаа зохицуулж байсан нэлээн хэдэн эмэгтэйтэй уулзаж билээ. Тэд

² Нэр дэвшигч, горилогч гэх нэр томьёо албан ёсны нэр дэвших үйл явцаар хязгаарлагдана. Сонгуулийн Ерөнхий Хорооноос нэр дэвшигчийн үнэмлэх аваагүй бүх хүн горилогч байна гэсэн үг.

³ Монголын сонгуульд зарим луйврын шинжтэй, будилаантай үйлдэл элбэг бөгөөд дараагийн сонгуулиар эдгээрийг шийдвэрлэхийн тулд хууль тогтоомжоо байнга шинэчилсэн талаар Баянтөрийн Гэрэлт-Од (2008) дурджээ. Гэвч, томоохон хэмжээний луйврыг зарим зөрчил, алдаанаас ялгах боломжгүй байсаар байна (Туяа 2005). Ломниц, Адлер, болон Адлер нарын (1993) өгүүлснээр, Мексикийн сонгуульд кампанит ажилд тахилгын шинжтэй зүйлүүдийг оруулдаг тул сонгуулийн будилаан, авлига уу эсвэл нийгмийн элитүүд, эмзэг бүлгийнхэнд аль алинд хамаатай тогтолцооноос ялгахад бараг л боломжгүй байдаг аж.

сонгуулийн кампанит ажлын санхүүжилтээ төлөвлөж, сонгуулиас өмнө бусад ажлаа амжуулж, гэр бүлийнхээ үүрэг хариуцлагаа гэрийнхэндээ хуваарилж, сонгуулийн хөтөлбөртөө бэлтгэж, мөн өөрсдийн гадаад төрх, ололт амжилт, нэр хүндээ дүгнэж байсан юм.

Хэдийгээр 2008 оноос өмнөх сонгуулиудаар УИХ-д маш цөөхөн эмэгтэй сонгогдсон түүхтэй ч, 2008 оны сонгуулиар олон эмэгтэйчүүд нэр дэвших шийдвэрээ гаргахад нь 30%-ийн квот батлагдсан нь чухал хөшүүрэг болжээ⁴. Энэхүү квотын ач холбогдлыг АНУ-ын Антропологич Шерри Ортнерийн онолоор илэрхийлбэл, квот нь “өөрчлөгдөж буй соёлын үзлийг дэмжин бэхжүүлэх . . . тэрний нийгэм дэх институцийнх нь суурийг өөрчлөх” боломж нь байсан юм (1974, 87). Өөрөөр хэлбэл, энэ квотыг баталсны улмаас олон эмэгтэй хүйсээр ялгаварлан гадуурхах үзэл, ялангуяа эмэгтэйчүүдийг нийтэд элэг доог болгох, гутаан доромжлох явдлыг бууруулж, эмэгтэйчүүдийг эрчүүдийн адил нухацтай авч үзэх болно гэж эмэгтэйчүүд найдаж байсныг албан ёсны болгох байлаа. Квотыг хуульчилснаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил нэр дэвших эрхтэй, тэр бүү хэл 1924 онд батлагдсан Монгол Улсын анхны үндсэн хуулиар баталгаажсан сонгох, сонгогдох эрхийг бодитоор эдлэх боломжтой болсон юм гэж үзэж байлаа.⁵ Улс төрийн намд эмэгтэйчүүд үргэлж хөшигний ард зохион байгуулалтын, нарийн бичгийн болон бусад дэмжлэгийн ажил эрхэлсээр ирсэн бол, харин одоо тэд эрчүүдийн адил ил гарч, өрсөлдөх боломжтойгоо мэдэрсэн юм.⁶ Квот батлагдсанаар эмэгтэйчүүд хүчирхэг эрэгтэй улс төрчдийн эсрэг өрсөлдөхийн тулд төрөл бүрийн арга ухаан сэдэж системийн урд хойно нь учраа олох гэж зовох шаардлагагүй болсон юм. Одоо асар их мөнгө санхүүгүй байсан ч бас эмэгтэй гэсэн эрэгтэй хүйсээс дутмаг санагдуулах хэвшмэл ойлголт нийгэмд байсан ч квоттой эрхзүйн шинэ орчинд тэдний итгэл найдвар сэргэсэн байлаа.

Квот нь сонгуулийн кампанит ажлын зардлаас бүрэн хамаарахаасаа илүү нэр дэвшигчийн хувьд бэлтгэгдсэн байдлаараа өрсөлдөх боломж олгоно гэдэгт гол нь найдаж байсан юм. Тэр үедээ шинээр боссон телевизүүдийн нэгийнх нь гүйцэтгэх захирал, Нацагийн Дуламсүрэн бас сонгуульд нэр дэвшихээр зэхэж байсан. Тэр: “Квотын буянаар улс төрийн намын удирдлагууд улс төрд бэлтгэгдсэн эмэгтэйчүүдийг хайж

⁴ 1990-2004 оны хооронд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2-10 хувийн хооронд л хэлбэлзэж байлаа.

⁵ 1924 онд батлагдсан Монгол Улсын анхны үндсэн хуульд эрэгтэй, эмэгтэй сонгох, сонгогдох тэгш эрхийг баталгаажуулсан. *Монгол Улсын Үндсэн хууль* (1-р хэсэг) (2009) үзнэ үү. Анхны үндсэн хууль батлах үеийн геополитикийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүйг Саблин, Бадагаров нарын бүтээлийг үзнэ үү.

⁶ Квот нь шинэ, бас хуучин зүйл юм. Нэр дэвшигчийн квот батлуулахаар идэвхтэй лоббидож байсан хүмүүсийн өнцгөөс үзвэл 2006 онд квот баталсан нь цэвэр ялалт байлаа. Харин урт хугацааны үр дүн талаас, том зургаар харвал эмэгтэйчүүдэд хэдийн байсан мөртөө алдсан зүйлээ буцааж авсан юм. Социализмын үед, 1960-аад онд парламентын гишүүдийн 25 хувийг эмэгтэйчүүд эзэлж байв. Гэсэн хэдий ч ардчиллын үйл явц эхэлснээр энэ байдал орвонгоороо эргэсэн бөгөөд тус квотыг батлуулж чадсан нь шинэ, чухал дэвшил байлаа.

эхэлж байна” гэж надад хэлж байж билээ. Бэлтгэгдсэн нэр дэвшигч гэж яг хэнийг хэлэх нь тодорхой биш хэдий ч нэр дэвшигч бүр өөрийнхөөрөө тайлбарлаж байлаа. Ерөнхийдөө, хараа булаам, амжилтад хүрч танигдсан, харизмтай, бэлтэй, сонгогдоход шаардлагатай бусад ур чадварыг эзэмшсэн хүнийг ойлгох бололтой. Бэлтгэгдсэн гэдэг нь сонгогдохуйц, эсвэл үгүйсгэх аргагүй нэр дэвшигчийг хэлнэ. Миний хувьд бэлтгэгдсэн гэх ерөнхий утгаас илүүтэй сонгогдохуйц хэмээн хэлэх нь тохиромжтой гэж үзлээ. Учир нь сонгогдохуйц гэдэг нь сонгуулийн кампанит ажлын агуулгатай илүү тохирохуйц, нэр дэвшихээр горилогч эмэгтэйчүүд болон сонгогчдын хүлээлтийг зэрэг илэрхийлэх ойлголт юм.

2007 оны зун буюу хойтонгийн сонгуулийн бэлтгэл ажил ид өрнөж байх үед нэр дэвшихээр горилогч эмэгтэйчүүд хангалттай бэлтгэгдээгүй, бэлтгэгдсэн горилогчид квотын тоонд хүрэхээргүй цөөн байна гэсэн яриа улс төрийн хүрээнд тарж эхлэв. Гэтэл бас улс төрийн намын эмэгтэй гишүүдийн дунд 30 хувийн квотод багтан нэр дэвшихийн төлөө өрсөлдөөн ширүүсэж буй талаарх яриа сонсогдож байлаа. Энэ зуур хэдийгээр квотод багтан нэр дэвших эсэх нь баталгаатай болоогүй ч гэсэн, эмэгтэй нэр дэвшигчдийн бэлтгэгдээгүй байдлын талаарх цуу яриаг сонссон бүсгүйчүүд сонгуулийн бэлтгэлээ улам эрчимжүүлж эхэлсэн байв.

Дараа нь 2007 оны 12 дугаар сарын сүүлээр хоёр жилийн өмнө батлаад байсан квотыг УИХ хүчингүй болгов. Хүчингүй болгох цаг хугацааг ч стратегитай сонгожээ. 2007 оны 12-р сарын эцэс бол 2008 оны сонгуулиас өмнө хууль нэмэлт, өөрчлөлт оруулж болох хамгийн сүүлийн хугацаа юм. Сонгууль хүртэл хууль өөрчилж болохгүй хуультай тул квот хүчингүй чигээрээ л үлдэнэ. Эмэгтэй гишүүдийн лобби бүлэг квотыг сэргээх чиглэлээр идэвхтэй кампанит ажил явуулан квотыг цуцалсан нэмэлт, хуулийн өөрчлөлтөд ерөнхийлөгчийн хориг хүртэл тавиулж чадсан юм.⁷ УИХ ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан хэдий ч, дараагийн өдөр нь УИХ-ын гишүүдийн олонх нь эсрэг санал өгсөн юм.⁸ Улмаар УИХ эмэгтэйчүүдийн байгууллагуудын өргөдөл, гомдлыг үл тоомсорлож, хангалттай тооны бэлтгэгдсэн

⁷ Төмөрсүхийн Ундаръяа хуулиас эш татаж (Монгол Улсын Үндсэн хууль 33-р зүйлийн 1 дэх хэсэг) хэрэв ерөнхийлөгчийн хоригийг УИХ-ын гишүүдийн гуравны нэг нь хүлээж авбал тус хориг хүчин төгөлдөр байх талаар бичжээ (УИХ хоригийг хүлээн авсан) (2009, 148). http://www.ilo.org/wcmsp5/groups/public/@ed_protect/@protrav/@ilo_aids/documents/legaldocument/wcms_117392.pdf.

⁸ 2007 оны 1-р сарын 10-ны өдрийн тэмдэглэлд УИХ-ын чуулган ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан талаар дурдсан байна. Гэсэн хэдий ч УИХ-ын нэг гишүүн (Хууль зүйн байнгын хорооны дарга, Сангажавын Баярцогт) ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ хүлээж авах нь сонгуулийн хуулийн 58-р зүйлд заасан УИХ-ын ээлжит сонгууль болохоор 6 сарын өмнө хуульд өөрчлөлт оруулж болохгүй гэсэн заалттай зөрчилдөнө гэв. УИХ 30 хувийн квотыг цуцалж болох байсан хамгийн сүүлийн хугацаа бол 2007 оны 12-р сарын 29-ний өдөр байсан. Ингээд квотыг тойрсон асуудал нь УИХ үндсэн хууль зөрчсөн эсэх асуудал болж хувирлаа. УИХ-ын зарим эрэгтэй гишүүд ерөнхийлөгчийн хоригийг дэмжиж, 2008 оны 1-р сарын 10-ны өдөр УИХ-ын чуулганаар квотыг цуцалсан нь хууль зөрчсөн үйлдэл болсон юм (“УИХ-ын 2007 оны намрын чуулганы хуралдааны тэмдэглэл”, 2008 оны 1-р сарын 10, УИХ-ын архив).

эмэгтэйчүүд байхгүй байна гэсэн цуу ярианаас илүү үндэслэлтэй тайлбар хийсэнгүй.⁹

Хожим нь миний олж мэдсэнээр эмэгтэйчүүд бэлтгэгдээгүй гэх яриа, тэдний дотоод өрсөлдөөн гэх мэт нь нэр дэвшигчийн 30 хувийн квотыг цуцлахад төдийлөн ач холбогдолтой байгаагүй билээ. Харин УИХ-д зонхилогч Ардчилсан нам, Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) дотроо олон төрлийн сонирхлын бүлэг, фракцуудтай байсан ч гэлээ УИХ-д бүрэн бүрэлдэхүүнээрээ дахин сонгогдохыг зорьж байжээ. Хоёр намын удирдлага олон улсын хөрөнгө оруулагчидтай Оюу толгойн гэрээг байгуулахыг эрмэлзэж байлаа. Удаан үргэлжилсэн хэрүүл, тэмцлийн үр дүнд засгийн газар Монголын төр 51% эзэмших саналыг гаргасан нь Айвенхоу, Рио Тинто болон Барууны бусад хөрөнгө оруулагчдын эгдүүцлийг төрүүлэв. Америкийн лоббичид АНУ-ын засаг захиргаанаас Монголын засгийн газрыг авилгаас салах, тэр бүү хэл Мянганы Сорилтын Санг зогсоохыг хүртэл шахалт үзүүлээ (Bulag 2009). Ингээд, олон нийтэд танигдсан янз бүрийн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл гадаадын хөрөнгө оруулалтад ч тэр, засгийн газарт ч тэр үл итгэх болжээ.¹⁰ Олон нийт нөлөөтэй улс төрчид, гадаадын хөрөнгө оруулагчдад эргэлзэж буй улс төрийн орчин тогтов. УИХ шинэ улс төрчид, ялангуяа байгаль орчин, хүний эрхийн төлөө ажилладаг улс төрчид болон ашигт малтмалтай холбоотой эрх зүйн орчныг шинэчлэхийн төлөө тэмцдэг хэд хэдэн эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжихгүй байх сэдэлтэй болсон юм.¹¹

Зарим улс төрийн намтай ойр хүмүүс 2008 оны сонгуулийг “уул уурхайн лоббины сонгууль” гэж нэрлэдэг. Номын 2 дугаар бүлэгт улс төрчид иргэдийн гадаадын хөрөнгө оруулалтын эсрэг хандлагыг бас улс төрчдөд эргэлзэх болсныг эргүүлэн, харин ч ирээдүйд олох уурхайн орлогоос иргэн бүрд хувь хүртээх талаар амлалт өгч иргэдийн хандлагыг өөрчилсөн тухай авч үзнэ. Улс төрийн намуудын давамгайл байдал ийм байсан учир нэр дэвшигчийн 30 хувийн квот хүчин төгс үлдсэн бол, уул уурхай ашиглах гэрээг эсэргүүцэж байсан эмэгтэй улс төрчдийг иргэд сонгох магадлалтай байсан юм.

⁹ Эмэгтэйчүүд нэр дэвшигчийн 30 хувийн квотыг унагах зорилготой хүмүүсийн хэл амны дайралтад ихээхэн өртөв. УИХ хүйсийн квотыг цуцлах нь зүйтэй гэж үзэж байсан хүмүүс, намын эрэгтэй удирдлагууд чөлөөт өрсөлдөөн, бие даасан байдал, мерит зарчим зэрэг неолиберал үзэл санааг аргумент болгон ашиглаж байлаа. Тухайлбал, Монгол мэдээллийн томоохон вэб хуудас oloo.mn, АН-ын нэрт нийтлэлч Цэнддоо (2008) эмэгтэйчүүдэд зориулж квот батлах нь, хөгжлийн бэрхшээлтэй хүнд “тааг” өгч буйтай адил хэмээн бичсэн нийтлэлийг нийтэлжээ. Цэнддоогийнхоор квотоор дэмжлэг үзүүлэх нь ердөө л доромжилж буй нэг хэлбэр гэнэ.

¹⁰ 2008 оны сонгуулийн улс төрийн үр дагаврын талаар тус сонгуульд нэр дэвшсэн Уянгын (2017) болон Ганхуягийн (2019) бичсэнийг үзнэ үү. 2008 оны сонгуулийн хамгийн гол үр дүн бол Монголын улс төрд зонхилогч хоёр нам МАН, АН-ын гол толгогчид хоорондын хамтын ажиллагаа бөгөөд МАНАН-г байгуулсан явдал юм.

¹¹ Нэр дэвшигчийн квотыг хүчингүй болгох нь УИХ-д онц эрх мэдэлтэй болоод байгаа эрэгтэй гишүүдийг сорьж чадах чадварлаг, мэдлэгтэй эмэгтэй гишүүдийн өрсөлдөх боломжийг үгүй хийж байна гэж үгүүдээ л УИХ-ын нэг эмэгтэй (2008 оны 1-р сарын 10-ны өдрийн УИХ-ын чуулганы хуралдааны үеэр УИХ-ын гишүүн Дашжамцын Арвин ийнхүү дуу хоолойгоо илэрхийлж байв) гишүүн дурдаж байлаа.

Нэр дэвшигчийн квотын нөлөөг судлах гэсэн судалгааны минь анхны зорилго квотыг цуцалсны дараа эмэгтэй нэр дэвшигчдийн стратеги, нөхцөл байдлыг судлах болж өөрчлөгдлөө. Квотыг цуцалсан нь эмэгтэйчүүдийн хувьд “шийдвэрлэх үйл явдал” болжээ. Энэ нь “аливаа дасал болсон хэв загвар нь эрс өөрчлөгдөж цоо шинэ үзэл санаа, нөхцөл бий болж эхлэхэд хувь хүн өөрийнхөө олон талт онцлогоо улам тодотгон нэгдэх байдал” юм. (Humphrey 2008, 357) Ингээд, эмэгтэйчүүд эрэгтэй улс төрчдийг эрхэмлэсэн сонгогчидтой, эрчүүд зонхилсон улс төр, хэт өндөр өртөгтэй сонгуулийн кампанит ажил зэрэгтэй ямар нэг албан ёсны орон зай болон хууль зүйн зохицуулалтгүй, “өөрсдөө” нүүр тулах болов. Тэр үеийн нэр дэвшигч Оюунгэрэл нэгэнтээ: “Квотыг цуцалснаар ердөө цорын ганц эерэг зүйл гэвэл, эмэгтэйчүүдэд кампанит ажлынхаа ур чадварыг улам хурцлах эрмэлзлийг л өгсөн. Мөн эмэгтэйчүүд бид тоглоом шоглоомоор, “Амь амиа хичээгээрэй” буюу эмэгтэй бүр өөрийнхөө төлөө гэж ярилцах болсон” хэмээн өгүүлжээ. Оюунгэрэлийн үг улс төрийн шинэ неолиберал эрин үе эхэлснийг илтгэх мэт. 2008 оны сонгуулийн кампанит ажил урьд өмнөх бүх сонгуулиас илүүтэйгээр нэр дэвшигчийн хувийн хариуцлагаас шалтгаалах болсон. Гэсэн хэдий ч урт хугацаанд кампанит ажил бол хувь хүний болон хамтын үйл ажиллагаанаас л бүрддэг билээ.

Мянган алхам

Энэ ном нь 2008, 2012, 2016 оны сонгуульд нэр дэвшсэн эмэгтэй улс төрчдийн туршлага, стратеги, нөхцөл байдалд хийсэн судалгааны ажил бөгөөд Монголчууд чөлөөт, ардчилсан сонгуулийг хэрхэн нутагшуулсан талаар өгүүлнэ. Ингэхдээ сонгуулийн үр дүнг үнэлэх (тухайлбал, сонгуулийн кампанит ажлын стратегийн аль хувилбар нь хамгийн шилдэг, эсвэл хамгийн муу, яагаад гэх мэт), эсвэл эмэгтэй улс төрчдөд парламентад сонгогдоход тохирох стратеги санал болгохыг зорьсонгүй.¹² Нийгэм-соёлын антропологичийн хувьд миний судалгааны сонирхол УИХ-д нэр дэвшсэн эмэгтэйчүүдийг сонгуулийн болон сонгуулийн өмнөх үеийн өдөр тутмын туршлагыг судлах билээ. Мөн, эмэгтэйчүүд улс төрд өрсөлдөхөд тулгардаг мөртөө тэр бүр анзаарагддаггүй саад бэрхшээлийг ил болгож, тэдгээр эмэгтэйчүүд сонгогдохуйц нэр дэвшигч болох хүртлээ урт хугацаанд ямар их хүчин чармайлт гаргадгийг тайлбарлахыг хичээсэн (Судалгааны ажил маань УИХ-д сонгогдсоныхоо дараа эмэгтэйчүүд хэрхэн ажилладаг талаар хөндөөгүй болно).

Монгол эмэгтэйчүүд Барууны хэв маягийн ардчилагдах үйл явц нь

¹² Мона Лена Крук (2009), Монике Лээнар (2004), Нэтина Тан (2016) зэрэг маш олон улс төр судлаачид сонгуулийн бүтцийг үнэлж, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих стратегиудыг санал болгосон.

жендэрийн тэгш байдлыг хангана хэмээн найдаж байсан ч, үнэн хэрэгтээ шинэ тогтолцоо эрчүүд зонхилсон улс төр, уламжлалт эцгийн эрхт ёсонд илүү таарсан систем юм. Социалист нийгмийн үед парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 20-30 хувийн хооронд байсан бол социализмын дараа тус тоо 6-8 хувь болтлоо буурчээ. Энэ нь 1990-ээд онд хуучин дэглэмийг нураах үед урьд өмнө нь байсан эмэгтэй манлайлагчдыг дэмжих чухал хөшүүргүүдийг чимээгүйхэн орхигдуулсантай зарим талаар холбогдоно. Ардчиллын он жилүүдэд ижил төрлийн хөшүүрэг, тухайлбал нэр дэвшигчийн квотыг хуульчлахын төлөөх тэмцэл хангалттай үр дүнд хүрээгүй талаар өмнөх хэсэгт тодорхой өгүүлсэн билээ.

Тийм учраас, 2008 оны сонгуулийн үеэр кампанит ажил явуулсан, нэр дэвшсэн эмэгтэйчүүд судалгааны хувьд онцгой ач холбогдолтой. Тэдгээр эмэгтэйчүүд нэр дэвшигчийн квотгүй, улс төрийн намын дэмжлэг бага, сонгогчдын тойргийн тоо нь бараг өмнөхөөсөө гурав дахин их гэх мэт гэнэт дүрмээ өөрчилсөн сонгуульд УИХ-ын суудлын төлөө өрсөлдсөн. Квотоо алдсан нь феминистүүд болон (зарим) эмэгтэй улс төрчдийн хүрэхийг зорьж байсан соёлын, сонгогчдын ухамсрын өөрчлөлтөд мэдэгдэхүйц ухралт болсон юм. Хэрвээ квоттой байсан бол, хуулиар тогтоогдсон орон зайд өрсөлдөх байсан. Түүний оронд, эмэгтэйчүүд эрчүүдийн орон зайд “тоглолт хийх” шаардлагатай болж, улмаар тэдний хүчин чармайлт эхлэхээсээ ч өмнө үр дүнгүй болж байлаа. Улс төрийн намууд (Санжаасүрэнгийн Оюун даргатай Иргэний Зориг Нам гэх жижгэвтэр намаас бусад нь) эмэгтэйчүүдийн оролцоонд ач холбогдол өгсөнгүй. Эмэгтэйчүүд УИХ-д хүрэх албан ёсны, хуульчлагдсан, хүлээн зөвшөөрөгдсөн зам квотоор тавьж байсан нь эвдэгдсэн тул 2008 оны сонгуульд эмэгтэйчүүд өөрсдөд нь боломжит ямар л нөөц байна, түүнийгээ эрэлхийлэх, ашиглах өрсөлдөөн болон хувирлаа. Эмэгтэйчүүд УИХ-д сонгогдох албан ёсны зам мөр байхгүй байгаа нь тэднийг эрчүүд зонхилсон улс төрийн хүрээнд төрөл бүрийн стратеги хэрэгжүүлэхэд хүргэжээ.

2007 онд квотыг хүчингүй болгосон нь 2008 оны УИХ-ын сонгуульд эмэгтэйчүүдийн байр сууринд ухралт болсон хэдий ч, урт хугацаандаа шинэчлэлийг эхлүүлэх феминист уриалгын эхлэл болсон. Улс төрийн нам, төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд (ТББ) дахь феминистүүд болон хувь уран бүтээлчид, идэвхтнүүд бүгдээрээ улс төрд эмэгтэйчүүд хэт цөөхөн байгаа талаар шүүмжилж эхлэв. Тэдгээр хүмүүс 2008, 2012 оны сонгуулийн хооронд гурван чиглэлээр өргөн хүрээг хамарсан нөлөөллийн ажил явуулахад төрөл бүрийн үүрэгтэй оролцов. Нөлөөллийн гурван ажил нь жендэрийн тэгш байдлын талаар хууль батлуулах, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль батлуулах, 2012 оны сонгуулийн хуулийг эмэгтэйчүүдэд ээлтэй болгох зэрэг асуудалд чиглэж

байлаа. Үүний үр дүнд олон хүмүүс хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийг дүрслэх байдлыг, бас улс төр дэх эмэгтэйчүүдийн талаарх олон нийтийн сөрөг ойлголтуудын эсрэг шүүмжлэлээ хурцатгав (Undarya 2009, 2018). Эерэг өөрчлөлтүүд харагдаж эхлэв.

Тухайлбал, УИХ 2012 оны сонгуулиас өмнө нэр дэвшигчийн хүйсийн квотыг 20 хувь болгон баталлаа. Ардчилсан намын Оюунгэрэл энэхүү судалгааны ярилцлагад тусгаснаар, эмэгтэйчүүдийг сонгох эсэх асуудлаар олон нийтийн санаа бодлын судалгаан дээр үндэслэн намынхаа удирдлагад квот батлахын ач холбогдлыг үнэмшүүлж чаджээ¹³. “Улс төрийн манлайлалд эмэгтэйчүүдийн оролцоо” (2011, 2012 онд хоёр хэсэгтэй хийгдсэн) тус судалгааны тайланд сонгогчдын 55.7–62.1 хувь нь эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжинэ гэжээ. Улс төрийн намын удирдлагууд 2012 оны сонгуульд 20 хувийн квот тогтоох шийдвэр гаргахад чухам тус судалгааны үр дүн ихээхэн нөлөөлсөн¹⁴. 20 хувийн квот хэвээр хадгалагдаж 2016, 2020 оны дараалсан сонгуулиудад тус бүр 13 эмэгтэй УИХ-д сонгогдоход чухал хөшүүрэг болсон юм.

«Улс төрийн манлайлалд эмэгтэйчүүдийн оролцоо» судалгааны тайлан 2008 оноос хойш хэлэлцэгдэж, 2011 онд батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” санаачлах, хэлэлцэх, батлагдах урт хугацааны ярвигтай ажлын чухал хэсэг байсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн арын ажлыг хянаж байсан тухайн үеийн Жендэрийн Үндэсний Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Баасанхүүгийн Энхсайхан надад тус тайланд туссан “жендэрийн тэгш байдлыг хангах” цогц ажлын талаар дэлгэрэнгүй ярьж өгөв. Энхсайхан төрийн ордонд зарим эрэгтэй УИХ-ын гишүүдийн өрөөний хаалгыг тогшиж, нэг бүрчлэн уулзаж, хуулийн ач холбогдлыг тайлбарлан лоббиджээ. Тэрээр Хууль зүйн яамыг манаж байж хуулийн төслийг гаргуулж, хуулийн төслийг эсэргүүцэж байсан хүмүүсийг эргүүлж, заримыг нь ядахдаа санал хураалтад оролцохгүй байхыг ятгажээ. Тэрээр хэвлэл мэдээллийн салбарынхны дунд жендэрийн асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, эмэгтэйчүүдийг дэмжиж, жендэрийн тэгш байдлыг сурталчилсан шилдэг телевизийн хөтөлбөр, сэтгүүл зүйн уралдаануудыг зарлаж, эрэгтэйчүүдийн ТББ-ууд руу чиглэсэн нөлөөллийн ажлууд хийсэн зэрэг бүхий л этгээдийг хэрхэн дайчилснаа ярьж өгч билээ. Энхсайханы энэ яриаг сонсож байхдаа би

¹³ Тус судалгааг Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн Үндэсний Хорооноос захиалж, Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэнгийн судлаачид хийж гүйцэтгэжээ.

¹⁴ Судалгааны үр дүн “Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, оролцоо: Олон нийтийн санаа бодлын судалгаа” нэртэй товхимол болон хэвлэгджээ (Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн Үндэсний хороо 2012). Эхний шатны судалгаа 2011 онд, хоёр дахь шатны судалгаа 2012 онд хэвлэгдэв. 2008, 2012 онд АН-аас сонгуульд нэр дэвшиж, 2012-2016 онд УИХ-ын гишүүнээр ажиллаж байсан Оюунгэрэл надад тус судалгаа жендэрийн улс төрд, болон 2012 оны сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлсөн амин чухал бичиг баримт болсон тухай надад ярьсан юм. Тэрээр тус судалгааны үр дүнг барьж, АН-ын дарга Элбэгдоржид нэр дэвшигчийн хүйсийн квот 20 хувийг батлах хэрэгтэйг үнэмшүүлдээ. Ялангуяа, тэрээр судалгаанд оролцогчдын 55.7 хувь нь эмэгтэй нэр дэвшигчийг сонгоно (2012, 38), 62.1 хувь нь чадварлаг эмэгтэйчүүд сонгогдох ёстой гэж үзсэн (2012, 10) зэрэг тоог онцгойлон ашигласан байна.

олон эмэгтэй зарим эрчүүдийн хамт жендэрийн тэгш байдал хангагдсан парламенттай болохын төлөө тоолж барамгүй олон ажил хийсээр ирсэн, хийж ч байгаа талаар эрхгүй зураглан бодох болов. Хамгийн гол нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлуулахад хийсэн цогц лобби ажлын үр дүнд эмэгтэй улс төрчдийг олон нийт хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, үй олон бэрхшээлээс үл хамааран эмэгтэй нэр дэвшигчид улс төрийн албан тушаалд өрсөлдөхөөс шантраагүй байсан юм



Дүрс. I.1. Хилари Клинтон (баруун талаас 9-рт) Монголын эмэгтэй улс төрчид, төрийн албан тушаалтнууд болон Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржтой (баруун талаас 8-рт) хамт, 2012 оны 7-р сарын 9-ний өдөр. Түүний айлчлал Улаанбаатар хотод болсон "Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх олон улсын чуулга уулзалт"-тай давхцсан юм. Зургийг Тензинг Палжор.

Би эмэгтэй нэр дэвшигчдийн туулдаг урт замыг харуулахын үүднээс, мөн эмэгтэйчүүдийг өндөрлөгт хүрэх боломжийг нэмэгдүүлэхийн төлөө бусад эмэгтэйчүүдийн хийсэн тоолж баршгүй олон алхмыг илэрхийлэхийн тул номоо Парламентад Хүрэх Мянган Алхам хэмээн гарчиглав. 11 эмэгтэй нэр дэвшигч 2012 оны УИХ-ын сонгуульд ялалт байгуулсан нь АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Хилари Клинтон анхаарлыг татсан тул тэрээр тус амжилтад Ерөнхийлөгч Элбэгдоржид баяр хүргэхээр Монголд нисэн ирсэн (дүрс I.1.). Энэхүү ном нь парламентын сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн түүх, туршлага, өвөрмөц стратегийн талаарх антропологийн судалгааны ажил билээ. Хилари Клинтон баяр хүргэсэн үйл явдалд хөтөлсөн болон дагалдсан өдөр тутмын, институцийн, соёлын болон жендэрийн улс төрийн нөхцөл болон үйл явдлыг өгүүлнэ.

Сонгогдохуйц байх нь

Сонгогдохуйц болохын тулд эмэгтэй нэр дэвшигчид биеэ бэлдэж, өөрсдийгөө хурцалж эмэгтэй хүнийхээ хувьд өөрсдийгөө дахин шинээр урлахыг хичээдэг. Биеэ бэлдэхэд үндэсний болон олон улсын улс төр,

институц, улс төрчийн имиж, болон улс төрийн практик өөрчлөгдөж буй явдал төдийгүй эмэгтэйчүүдийн өөрсдийн хүчин чармайлт, хариу үйлдэл ч ихэд нөлөөлжээ. Өөрсдийгөө сонгогдохуйц болгох гэдэг нь сонгуулийн ажилд зарцуулж чадах мөнгөндөө бус, харин өөрсдийн чадавхад тулгуурлан, сонгохгүй байхын аргагүй нэр дэвшигч болохын тулд өөрийгөө дахин бүтээх гэсэн тасралтгүй оролдлого гэж ойлгож болно. Миний судалгаанд хамрагдсан эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийнхөө амьдрал, нөөц, зам мөрөө сонгуульд нийцүүлж, улс төрд оролцох, нэр дэвших эрх олж авахын төлөө шинэ ур чадваруудыг суралцсаар байсан ч тэдгээр эмэгтэйчүүд зөвхөн сонгуулийн кампанит ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн төдий эмэгтэйчүүд биш билээ.

Өөрийгөө сонгогдохуйц болгох хүчин чармайлт нь эмэгтэйчүүдээс “жендэрийн мэргэжилтэн” байхыг давхар шаарддаг. Учир нь тэд өдөр тутам, тухайн соёлын орчинд жинхэнэ сайн эрэгтэй эсвэл жинхэнэ сайн эмэгтэй гэж хэнийг ойлгох талаар олон нийтийг байнга сэнхрүүлэх шаардлагатай болдог (Рахсон 2004, 12). Монголд улс төрөөс гадуур карьер болон хувийн амьдралаа амжилттай зохицуулж яваа эмэгтэй хүн сонгогдохуйц нэр дэвшигч болох тохиолдол бий. Гэсэн хэдий ч, ихэнхдээ улс төрийн замнал сонгосон бол “нэг бүлгийн бүх гишүүдэд нийтлэг байдаг дотоод бүтэц, ойлголт, үйлдэл, төсөөллийн схем бүхий тогтолцоо” (Bourdieu 1977, 86)-нд нийцэх дадлыг (habitus) олж авдаг. Тус дадал нь тодорхой ур чадварыг эзэмшихэд түлхэц өгч байдаг бөгөөд жендэрийн ур чадварууд заримдаа нийцээд заримдаа тэс ондоо ч байдаг байна. Ялангуяа сонгогдохуйц байх, жендэрийн ур чадвартай байхын шинж чанарууд нь тусдаа нөхцөл байдлаас шалтгаалаад тус тусдаа хувьсах талтай. Нэр дэвшигчдийн сонгогдохуйц болох хувьслыг судлахдаа би антропологийн болон түүх судлалд субъектийн формацийн онол, жендэр ба улс төр, болон неолиберализмын онолуудын хүрээнд авч үзсэн юм.

Эхлээд бид орчин үеийнхээ жендэр улс төрийн байдлыг ойлгохын тулд социалист төрийн үеийн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны уламжлалыг авч үзэх ёстой. 1990-ээд онд ардчилалд шилжиж, либерал феминизмийн нөлөө эрчимжсэн үед л Монгол эмэгтэйчүүд улс төрд идэвхтэй оролцох болсон гэх зонхилох [Барууны] ойлголтыг няцааж нэгдүгээр бүлэгт социалист төрийн үед Монголын Эмэгтэйчүүдийн Хороо эмэгтэйчүүдийг хэрхэн улс төрийн субъект болгон төлөвшүүлж, олон нийтийг дайчилж, тэдэнд нөлөөлөх ур чадварыг эзэмшүүлж улс төрд эмэгтэйчүүдийн орон зайг бий болгон ажиллаж байсан талаар түүхэн үүднээс өгүүлнэ. Үүгээрээ би эмэгтэйчүүд ба жендэрийн асуудалд социалист төрийн бодлогын нөлөөллийг эдийн засаг, нийгэм, соёлын шилжилтийн үүднээс, мөн жендэр, социализм хоорондын хамаарлыг хүйс – нөхөн үржихүйн үүднээс авч үздэг социалист төрийн био-улс төрийн бодлогын үүднээс судалсан ихэнх антропологийн судалгаанаас

(Andors 1983; Stacey 1983; Gal and Kligman 2000; Kligman 1998; Valdur 2020; Verdery 1996) ялгаатай байр суурийг санал болгож байна.

Харин эрэгтэйчүүд зонхилсон төр Эмэгтэйчүүдийн Хорооны статусыг удаа дараа сулруулж татан буулгах гэж байх үед эмэгтэйчүүд тус хороогоо авч үлдэхийн төлөө идэвхтэй тэмцэж байсан тул би эмэгтэйчүүдийг улс төрийн идэвхтэй талаас нь онцолж бичлээ. Эмэгтэйчүүд улс төрөөс ухраагүй, харин өөрсдийн байр сууриа хамгаалан хэлэлцээ хийж, нийгмийн хамгааллын тогтолцоонд нөлөөлсөөр иржээ. Эмэгтэйчүүдийн байгууллагыг авч үлдэх гэсэн олон үе дамнасан тэмцэл өргөжиж социалист цаг үеийн туршид өргөн хүрээг хамарсан, дуусашгүй төсөл болон хувирсан байдаг юм. Энэ түүхийг дэлгэснээр би Барууны зарим либерал феминистүүдийн үздэгээр социалист эмэгтэйчүүдийн байгууллага нь гагцхүү төрийн зэвсэг бөгөөд гишүүд нь “жинхэнэ” феминистүүд биш гэх үзлийг (жишээлбэл, Reuschemeyer and Wolchik 2009) няцааж байна. Кристен Годси (2019), Саба Махмуд (2005), Жоан Скотт (2009) нарын адил, либерал орчинд ч тэр, либерал бус орчинд ч тэр эрх мэдлийн харилцааны хүрээнд аливаа арга хэрэгсэл хэрхэн ажиллагдийг харуулахыг зорив. Социалист нийгмийн үед эмэгтэйчүүд төрөөс тавьсан зорилтын хүрээнд, болон төртэй хамтран хийсэн ажлуудын хамгийн тодорхой үр дүн нь улс төрд эмэгтэйчүүдийн байр суурийг хэвийн болгосон бөгөөд энэ нь өнөөгийн ардчилсан нийгэмд ч нөлөөлсөөр байна.

1950-1980-аад оны хооронд төрсөн олон эмэгтэй хойч үедээ улс төрийн болон бусад өндөр албан тушаалын төлөөх замналд хэрэг болохуйц үндсэн дадлуудыг өвлүүлсэн. Тухайлбал, төрөл бүрийн хүмүүстэй харилцах чадвар, олны өмнө сандрахгүй ярих, илтгэх ур чадвар, тав тухтай мэдрэмжийг илэрхийлэх болон Монголд олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрөгдөхийн тулд нийгмийн идэвхтэй байх зэрэг ур чадвар, дадлуудыг нэрлэж болно. Эдгээр ур чадварыг би олон нийтийн өмнө чөлөөтэй байх гэж нэрлэлээ. Тус ур чадварыг буюу олон нийтийн өмнө өөрийгөө эвтэйхэн авч явдаг хүнийг “нүүр хагарсан” хүн ч гэж хэлдэг. Нүүр хагарсан гэдэг нь ичимхий, сандрангүй гэдгийн эсрэг утга бөгөөд залуухан хүмүүс олон нийтийн өмнө соёлын болон нийгмийн тохиромжтой зан үйлийг гүйцэтгэх чадвартай болж буйг илэрхийлнэ. Хэдийгээр нүүр хагарсан гэдэг нь энэ номд өгүүлэх эмэгтэй нэр дэвшигчдийг илэрхийлэх боловч тэдний манлайллын ур чадвар, ямар ч хүнтэй эвлэгхэн харьцах, ятган үнэмшүүлэх зэрэг бусад ур чадварыг агуулахгүй. Олон нийтийн өмнө чөлөөтэй байх гэдэг нь нүүр хагарсан гэхээс илүү тохиромжтой. Учир нь олон нийтийн өмнө чөлөөтэй байх гэдэг нь үйлдэл, субъектив шинж байдал, туршлага, энэ бүхнийг төрөлхийн юм шиг харагдтал идэвхтэйгээр сурж эзэмшсэн байдлыг илэрхийлж буй.

Хувь хүн нийгмийн идэвхтэй гишүүн болж төлөвшдөгийг төр

бодлогоор зохицуулж байсан бөгөөд энэ нь хувь хүнээс гадна социалист нийгмийн хүмүүжлээс бас улбаатай юм. Хувь хүний түвшинд бол хүмүүжлийн ажлын улс төрийн агуулга нь тийм ч чухал байсангүй. Харин ч охид эмэгтэйчүүд улс төр, нийгэмд оролцох ур чадварыг эзэмшсэн нь эрчүүд хүчирхэг нийгэмд эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн оролцоог нь хэвшүүлж өгсөн юм. Тиймээс, социализмын төгсгөлд эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэсэн албан ёсны бүтэц, дүрэм журам, удирдлагын чиглэл зэрэг институцийн зүйлс орхигдсон ч эдгээрийн нөлөөлөл болох эмэгтэйчүүдийн улс төрд оролцох нь ердийн үзэгдэл, ойлголт болж үлдсэн юм.

Тухайлбал, 1980-аад оны эхээр төрсөн Сэржээ гэх бүсгүй намынхаа эгч нараас социалист хэв маягийн сонгуулийн кампанит ажлын стратегийг сурч, өөрийгөө төлөөлөх, хүчирхэгжихэд шинээр суралцсан либерал феминист мэдрэмж, арга барилтай хослуулжээ. Сэржээгийн сонгуулийн кампанит ажлын өмнө улс төрийн нам дотроо хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааг би орон зай, үйл явдлын хэв маяг, эрх мэдлийн харилцаагаар хардаг Мишел Де Сертогийн (1984) өнцгөөр харахыг хичээв. Ингэснээр, би дөрөвдүгээр бүлэгт эрчүүд зонхилсон улс төрд эмэгтэйчүүд өөрсдийн орон зайг бүтцийн хувьд хүлээн зөвшөөрүүлэх шийдэмгий тактикууд нь тэд сонгогдохуйц болохын тулд хувиараа биеэ бэлдэхтэй ач холбогдлоороо ижил болох талаар тайлбарлав.

Орчин үед УИХ-д нэр дэвшиж буй эмэгтэйчүүд олон нийтийг дайчлах, дэмжих бүлгүүдийг зохион байгуулах, улс төрийн албан ёсны бүтцийг ашигласаар ирсэн. Үүн дээр тэд өөрсдийн онцлогт нийцсэн өөрсдийн сонгуулийн кампанит ажлын стратеги хэрэглэж буй нь миний тодорхойлсноор сонгуульжилтын үйл явцад хувь нэмрээ оруулж байна. Сонгуулийн кампанит ажлаар улс орон тэр чигтээ амьсгалдаг байдлыг сонгуульжилт хэмээн тодорхойлов¹⁵. Эрчүүдийн өргөн хүрээний кампанит ажлын хүчин чармайлтыг тэнцвэржүүлэхийн зэрэгцээ улс төрд горилж буй эмэгтэйчүүд сонгогдохуйц нэр дэвшигч болохын тулд төрөл бүрийн арга хэмжээ авдаг. Тэднийг нь биеэ бэлдэх арга техник хэмээн нэрлэж болох бөгөөд үүнд “толгойгоо цэнэглэх”, оюунлаг болох, мөн үзэсгэлэнтэй, эмэгтэйлэг харагдах гэх зэргийн зүйлс орно.

Биеэ бэлдэж, хамгийн сайн чаддаг зүйлээ байнга хөгжүүлснээр сонгогдохуйц болтол өөрсдийгөө хурцлах нь неолиберал нийгэм дэх байнга хувьсаж байдаг бие хүмүүстэй төстэй. Учир нь неолиберал нийгэмд зах зээлийн, ялангуяа ажлын байрны байнга өөрчлөгдөж байдаг хэрэгцээ, тогтолцооны тодорхойгүй байдал, хурдацтай өөрчлөгдөх

¹⁵ Сонгуульжилт нь сонгуулийн сурталчилгааны цаг хугацаа, орон зайд сонгуулийн кампанит ажилдаа бэлдэхийг илэрхийлж буй нэр томъёо биш юм. Би сонгуульжилт гэх нэр томъёог ашиглан сонгуулийн сурталчилгаа өдөр тутмын амьдралд нэвчиж, сонгуулийн цаг хугацаа, орон зайнаас гадуур иргэдийн амьдралын хэв маягт нөлөөлж буй үзэгдлийг илэрхийлэв.

нийгмийн хүлээлт зэрэг орчин үеийн шаардлагад нийцэхийн тулд неолиберал нийгэмд амьдарч байгаа бие хүн, тэр хувьсмал нийгмээ гүйцэхийн тулд өөрсдийгөө байнга шинэчилж дахин бүтээж явдаг байна (Freeman 2014; Ong 2006; Rose 1999). Гэсэн ч эмэгтэй нэр дэвшигчийн хувьд эрчүүд ноёлсон тогтолцоонд хөлөө олохын тулд неолиберал бие хүн шиг өөрсдийгөө тогтолцоонд тааруулж хязгаарлаагүй юм. Эдгээр эмэгтэйн олонх нь сонгуулийн кампанит ажлын зардал тасралтгүй ихэссээр буй сонгуулийн голдирлыг дагахын оронд өөрсдийн мэргэжлийн болон боловсролын хувьд гаргасан амжилт, ёс суртахууны өндөр хэм хэмжээг онцлон өөрсдийгөө оюунлаг талаас тодруулахыг эрмэлзэж байлаа. Оюунлаг гэх ойлголтын ард мөнгөний, эд зүйлсийн араас хөөцөлдөх бус харин мэдлэг боловсрол болон ёс суртахууны дээд чанарыг эрхэмлэсэн гэсэн агуулга бий. Оюунлаг байхыг өөрсдийн үндсэн шинж чанар болгосноор, сонгогдохуйц эмэгтэйчүүд зах зээл, капитализмын материаллаг үнэт зүйлсээс зай барьж, харин тэднийг өөрчлөхийн төлөө ажилладаг. Тэдний сонгуулийн кампанит ажил нь бүтээлч үйл ажиллагаа, ялангуяа оюун санааны болон соёлын капитал зэрэг нөөцөд тулгуурласан нь онцлогтой.

Гэвч эдгээр оюунлаг эмэгтэйчүүд тактикийн нарийн ширийн зүйлсийг шаарддаг төвөгтэй нөхцөл дунд байлаа. Өнөөгийн Монголд сонгууль нь жендэрийн болон анги давхаргын шинжүүдийг илэрхийлэх орон зай болжээ. Хувцаслалт болон биеэ авч явах байдлаараа эмэгтэйлэг байдал, хамрагдах анги давхарга, үндсэрхэг үзэл зэргийнхээ тунг төрөл бүрийн сонгогчдод зориулан нийцүүлнэ. Сонгогчид нэр дэвшигчдийг юуны өмнө гадаад төрхөөр нь нарийн шинжинэ. Ялангуяа хэр их бэл бэнчинтэй байна, итгэл найдвар төрүүлж тэдний ирээдүйг дааж чадахаар байна уу гэдгийг шинжиж явдаг. Байнга өөрчлөгдөж байдаг загварын салбар эмэгтэй нэр дэвшигчдийг илүү эмзэг, шүүмжлэлд өртөмтгий байдалд хүргэх нь улс төрд эрчүүдийн давамгайл байдлыг улам л бататгах талтай.

Энэ нөхцөлд, эмэгтэй нэр дэвшигчид мисс охид болон гоо үзэмж хөөцөлдсөн эхнэр зэрэг дүр төрхөөс ялгарч олон нийтийн анхаарал, хүндлэлийг татсан эмэгтэйлэг шинжийг бүрдүүлэх шаардлагатай болно. Эдгээр эмэгтэйчүүд өөрсдийн харагдах байдал, хандлагаараа бусдаас ялгарч хэрэг гарвал шилэн ханаар тусгаарлаж бас шилэн өндөрлөг дээр гарсан мэт биеэ авч явах талтай. Тэд эмэгтэйлэг байдлаа биедээ хэрэглэж буй зүйлсийн төрлийг (жишээлбэл, даашинз уу, хослол уу гэх мэт), болон хэмжээг (жишээлбэл, нүүрэндээ хэр их будаг хэрэглэдэг гэх мэт) маш нарийн тооцож хэрэглэнэ. Түүнээс гадна биеэ хэрхэн хэлбэржүүлэх, бас хэрхэн харагдах нь ч мөн чухал ач холбогдолтой. Эмэгтэй нэр дэвшигчид ийнхүү биеэ бэлдэх үйлдлүүд нь сонгогчдын анхаарлыг татахаас гадна эмэгтэйчүүдийг зөвхөн

өөрсдийнхөө амжилтад хүрэх замд “шатны гишгүүр” төдийлөн хардаг эрэгтэй хамтрагчдадаа зориулж буй хариу үйлдэл юм.

Нэр дэвшигчид сурталчилгааны ажилдаа телевизийн нэвтрүүлгээс эхлээд социал медиа, бүх төрлийн зурагт хуудас, самбар гэх мэт олон нийтэд хүрэх бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг ашиглана. Сонгуулийн зураг нь маш нөлөөтэй “жендэрийн технологи” (de Lauretis 1987) тул улс төр дэх жендэрийн төлөөллийг авч хэлэлцэхэд онцгой ач холбогдолтой. Жоан Скоттын үзсэнээр, жендэр ч тэр, улс төр ч тэр аль аль нь тогтворгүй зүйлс боловч “тус тусын тогтворгүй байдал нь нөгөөгөөсөө тодорхой [бөгөөд тогтвортой] байдлыг эрэлхийлдэг” аж. Учир нь энэхүү тогтворгүй байдлаас шалтгаалж тодорхойг баталгаажуулахад хүйсийн жам ёсных нь байдлыг онцлох хандлага түгээмэл байна (Joan Scott 2019, 25). Скоттын психоаналитик тайлбартай зэрэгцүүлж, соёлын элемент жендэрийг илэрхийлэхэд ямар нөлөө үзүүлдэг талаар угсаатны зүйн өнцгөөс тайлбарлалаа. Улс төрчийн дүр төрхөө хэрхэн бүрдүүлэх, хэрхэн ашиглах, хэрхэн олон нийтэд түгээх зэрэг түүхүүдэд шинжилгээ хийснээр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлдөг болохыг мөн энд харуулахыг зорилоо.

Миний хийсэн жендэрийн судалгаа, ялангуяа эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог сонгуулийн өнцгөөс судалсан судалгаа маань, жендэрийг антропологийн үүднээс судлах, мөн социализмын дараах нийгмийг антропологийн үүднээс тайлбарлах танин мэдэхүйн салбарт хувь нэмэр оруулж буй бөгөөд, жендэрийг судалгааны объект (судлахуун), бас аналитик (судалгааны арга) байдлаар авч үзэв.¹⁶ Өмнөх үеийн феминист антропологичид эмэгтэйчүүдийн эрх мэдэл, гүйцэтгэх үүргийн талаар гэр бүлийн хүрээнд нэлээд судалгаа хийж хувь нэмэр оруулсан (тухайлбал, Wolf 1960; Stack 1983 гэх мэт). Дараагийн үеийн антропологичид жендэрийн асуудлыг нийтийн болон хувийн гэж хуваахыг үгүйсгэжээ (Gal and Kligman 2000). Учир нь эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа болон нөлөөлөл нь нийтийн гэж тодорхойлох орон зайнаас хальсан ч байж болох бөгөөд орон зайг нийтийн болон хувийн гэж хуваах нь эрх мэдлийн ялгаатай байдлыг дахин бий болгодог гэж үзэв (Brenner 1998; Leshkovich 2014; Ong and Peletz 1995). Эдгээр антропологичид “нийтийн”, болон “хувийн” хэрэг хэрхэн бие биедээ нөлөөлдгийг харуулсан. Тухайлбал, Катерин Бови (Katherine Bowie 2008) Тай бүсгүйчүүд сонгуульд өөрсдийн төрөл садны сүлжээгээр дамжуулан нөлөө үзүүлдэг байдлыг судалж, эмэгтэйчүүдийн өрхийн буюу “хувийн” гэж үздэг нөлөө нь тэр хүрээнээс хамаагүй давсныг

¹⁶ Чари, Вэрдэри нар (2009, 11) постсоциализмыг социализмын туулсан цаг үе, колоничлолын дараах үе, өнөө цагийн империализм, мөн одоогийн неолиберал шилжилтийн талаарх шүүмжлэлд өртдөг талуудыг нь онцлон өргөн утгаар тодорхойлжээ. Эд бүгд социализмын дараах, колоничлолын дараах үеийг нэгтгэж болох эсэх талаар сүүлийн үед гарч ирсэн мэтгэлцээнийг илүү эрчимжүүлдэг (Appiah 1991; Hladik 2011).

харуулж, үүнээс үүдээд нийтийн болон хувийн асуудлын ялгаа хэрхэн бүдгэрч байдгийг харуулсан.

Энэ ном нь албан ёсоор улс төр гэж нэрлэгддэг орон зайд эмэгтэйчүүдийн туршлагыг судлан шинжилсэн бүтээл юм. Хэдийгээр сонгуульжилт нь хувийн орон зай, амьдрал ахуй руу нэвтрэн орж сонгуулийн кампанит ажил явуулахыг шаарддаг боловч, судалгааны маань ажилд оролцож ярилцлага өгсөн хүмүүсийнхээ кампанит ажлын стратеги, туршлагын талаар өгүүлэхдээ зөвхөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэдний ойр дотно харилцаа, гэр бүл, ахуй амьдралын талаар дурдлаа. Учир нь миний судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд өөрсдийнхөө амьдралын хэв маяг, карьерын сонголт зэргээ эрчүүдээр шийдүүлэхгүй, өөрсдийгөө бие даасан шийдвэр гаргах чадвартай гэж үзэж байсан. Тэдгээр эмэгтэйчүүдийн гэр бүлийн байдал, хүүхэдтэй эсэх, ахуй амьдрал нь янз бүр байсан. Ямар нөхцөлд байснаас үл хамааран тэдгээр бүсгүйчүүд улс төрийн зорилгынхоо араас тууштай явахын тулд гэр бүлийнхээ асуудал, ахуй амьдралаа зохицуулахаар хичээж байв. Тухайлбал, Оюунгэрэлийг улс төр, ер нь нийтийн анхаарлын төвд байдаг албан тушаалаас татгалзахыг шаардсан тул, тэр хоёр дахь нөхрөөсөө салжээ. Дараа нь тэр өөрийнх нь карьерыг дэмждэг Америк эртэй гэрлэв. Энэ номд Сэржээ гэж нэрлэсэн бүсгүйн тухайд бага залуу наснаасаа улс төрд тууштай оролцож, хожим нь өөрийнх нь “үнэнч шүтэн бишрэгч” байж, улс төрийнх нь карьерыг дэмждэг гадаад нөхөртэй суужээ. Ихэнх Монгол айлууд барууны хэлдгээр “өнөр өтгөн” буюу ойрын төрөл саднууд нь хүүхэд харахаас өгсүүлээд, нэг нэгнийхээ ахуйн амьдралд ихээхэн тусалдаг тул, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд улс төрд оролцох боломжтой байдаг.

Улс төрд өрсөлдөх эмэгтэйчүүдийн энэ судалгаа Лондоны Мак Дауэлл бирж (McDowell 1997), Волл стрийтийн (Fisher 2012) уламжлалт ойлголтоор эрчүүд ноёлсон ажлын байранд эмэгтэйчүүд орж буй асуудлыг судалж байсан антропологич нарын бүтээлтэй үндсээрээ холбоотой. Эдгээр бүтээлүүд дээр тулгуурлан энэхүү ном нь эмэгтэй нэр дэвшигчдийн 1000 алхам нь жендэрийн болон эмэгтэй хүнийг үзэх уламжлалт, зонхилсон загварт хэрхэн нэвтэрч, өөрчилж буй талаар өгүүлэх юм. Ингэснээр өндөр албан тушаалтай эмэгтэйчүүд нь эмэгтэй хүний хувьд биш, харин эрчүүдийн хэлээр ярьж тэдний дүрмээр тоглож байж албан тушаал ахидаг гэх мэт урьд өмнө нь зонхилсон үзлийг халахад туслахыг зорив. Мелисса Фишер (2012), Линда МакДауэлл (1997) нар эрэгтэйчүүд давамгайлсан салбарт (санхүүгийн ертөнцөд тухайлбал, эрэгтэйчүүдэд байдаг онцгой зан байдал нь илүү ашгийн төлөө, илүү эрсдэлд ордог) ажиллахдаа эмэгтэйчүүд илүү эршүүд болох гэхээс илүүтэй харагдах байдал, асуудалд бодлоготой хандах, эрсдэлээс холуур байх гэх мэт “сонгодог эмэгтэйн дүр төрх”-ийг бий болгоход суралцдаг талаар өгүүлсэн. Фишер улмаар, эрчүүдийн ертөнцийн нэг

хэсэг болохынхоо оронд, тэдгээр эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүддээ орон зай гаргаж эхэлдэг гэж дүгнэв. Хэдийгээр барууны нийгэм дэх эмэгтэйчүүдийн туршлагад судалгааныхаа ажлыг үндэслэсэн боловч МакДауэлл, Фишер нарын дүгнэлт эрчүүд давамгайлсан Монголын парламентад өрсөлдөх эмэгтэйчүүдийг ойлгоход тустай. Энэ талаар дараагийн хэсэгт дэлгэрэнгүй өгүүлнэ.

Сонгуульжилт

Сонгогдохуйц хүмүүс гэх ойлголт нь нийгэм, улс төрийн хөгжлийн тодорхой субъект болохыг хүлээн зөвшөөрөхийн тулд, бид эхлээд Монгол дахь ардчилсан сонгуулиуд хувьсан өөрчлөгдөж,



Дүрс. 1.2. Сонгогчид шинэ нэр дэвшигчидтэйгээ уулзахаар цуглажээ. Улаанбаатар хот 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Америк-Европт ойлгогддог сонгууль гэх “анхдагч” ойлголтоос хол илүү том, бас өөр зүйл болсон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Сонгууль болон сонгуулийн кампанит ажил нь жендэрийн ойлголт, субъектив байдал зэргийг тодорхойлогч болж, Монголын өдөр тутмын амьдралын бүхий л хүрээг хамарсан маш өргөн зүйл болон хувирчээ. Сонгууль нь тодорхой цаг хугацаанд үргэлжилдэг зүйл байсан бол сонгуульжилт болон хувьсан өөрчлөгдөж, нийгмийг бүхэлд нь хэлбэржүүлдэг, тасралтгүй үргэлжлэх үйл явц болон хувирсан гэж би үзэж байна.

Сонгуульжилт гэдэг үгээр сонгуулийн кампанит ажил хүний амьдралын бүхий л хүрээнд нэвчин орж, нийтийн болон хувийн орон зай хоорондын зааг ялгааг бүдгэрүүлж, албан ёсны улс төр албан бус байдлаар

өдөр бүр тулж, эдийн засгийн болон нийгмийн нөөцийг өөрчлөхөд хүргэсэн ийм нүсэр байдлыг илэрхийлэхийг зорив. Сонгогчдын олонх нь сонгууль бол удирдагчдыг сонгох, тэднийг шинжих механизмаас гэхээс илүүтэй, нийгмийн баталгааны сүлжээ, неолиберализмаас үүдэх тодорхойгүй байдлыг багасгах боломж гэж харах болжээ. Сонгуульжилт нь бүх л төрлийн салбартаа хүмүүсийг багтаан хамарчээ. Жишээ нь нэр дэвшигчдээс гадна, богино хугацааны хөдөлмөр эрхлэгчид (халтуурчид), олон нийтийн цугларалт зохион байгуулагчид, нөөц эргэлдүүлэгчид, хэвлэл мэдээллийн, зугаа цэнгэлийн, судалгааны, зөвлөх үйлчилгээний гэх мэт нийгмийн амьдралын бүхий л хэв маягийн хүмүүс сонгуультай холбоотой болсон (дүрс I.2-ыг үз).

Монгол Улс парламентын сонгуулиас гадна, ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийг дөрвөн жил тутамд зохион байгуулдаг. 1990-2020 оны хооронд гэхэд Монголд 24 удаа сонгууль болсон бөгөөд бүгдэд нь ижил төстэй сонгуулийн кампанит ажил, нөөц ашиглах суваг, мэргэжилтнүүд болон дэмжигч хүмүүс оролцсон байж таарна. Тиймээс, сонгуульд зориулан байгуулсан институтууд нь улс орны институтчиллийн гол нэгжүүд болсон тул Монгол Улсад аливаа байгууллагын анхдагч чиг үүрэг нь сонгуулиас улам бүр хамааралтай болсоор байна. Үүнийг дагаад, сонгуулийн кампанит ажил нь сонгуулийн хугацаанаас хальж, сонгууль хоорондын дөрвөн жилийн хугацааны дийлэнхэд нь үргэлжилж засаглалыг орлох хэлбэр мэт болжээ. Нэр дэвшигчид нөөцийг нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж, онцгой үед дэмжлэг үзүүлэх гэх мэт сонгогчдын дэмжлэгийг цуглуулах ажлыг байнга гүйцэтгэх нь засгийн газрын өмнөөс ажиллаж буй мэт.¹⁷

Үр дүнд нь, сонгуульд өрсөлдөх эсэх нь сонгуульжилтыг санхүүжүүлэх эсэхээс шалтгаалдаг болжээ. Энэ нь сонгуулийн бус цагаар ч үнэмлэхээ авсан нэр дэвшигч мэт сонгогчид руугаа чиглэн ажиллана гэсэн үг, гэхдээ өөрийнхөө хөрөнгөөр. Сонгуулийн бус үеэр кампанит ажил явуулахад тулгарах санхүүгийн сорилт нь шинээр нэр дэвшигчид, эмэгтэйчүүдэд хамгийн өндөр дарамт учруулна. Учир нь сонгуулийн санхүүжилт нь бусад ардчилсан улсуудаас ялгаатай нь нэр дэвшигчийн хувийн асуудал байдаг бөгөөд тухайлбал, 2012 онд нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтийнхээ 70-88 хувийг өөрөө хариуцсан гэх (Oyuntuya 2013a) судалгаа байна. Өмнө нь өгүүлсэнээр ихэнх эмэгтэй нэр дэвшигчид сонгогдохуйц нэр дэвшигч болсноор ийм төрлийн мөнгөний сонгуулийн кампанит ажлын шаардлагыг даван туулахыг эрмэлздэг. Тэд сонгуульд бэлдэх олон жилийн хугацаандаа өөрийгөө төгөлдөржүүлэх буюу үзэсгэлэнтэй, оюунлаг, харизмтай дүр төрхөө бүтээж дотроосоо ч, гаднаасаа ч гэрэлтэхийг хичээдэг. Тэд мөн улс төрийг өөрчлөх, кампанит ажлыг хязгаарлахын төлөө ажилласан хэвээр боловч энэхүү нөхцөлөөс ангижирч чадахгүй хэвээр байна.

¹⁷Данн (2008) болон бусад судлаачид төрийн бус тоглогчид төрийн мэт аягласнаар төр улам өргөжиж байдаг талаар бичжээ.

Монгол дахь сонгуульжилт нь олон өөрчлөлт, шилжилтийн үр дагавар юм. 1990-ээд онд ардчилсан сонгуульдаа өмнөх социалист тогтолцооны засаг захиргааны нүсэр бүтцийг ашигласан. Ингэснээр сонгуулийг үр дүнтэй нутагшуулж, нийтийн амьдралд бүрэн нэвчихэд тусалсан гэж үзэж болно. Бодлогын хувьд бүтцийн өөрчлөлт хийж, халамжийг багасгах зэрэг неолиберализмын “шок эмчилгээ”-г Монголд эхлүүлж худалдаа болон үнийг чөлөөлж, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг татан буулгаснаар нийгмийг хамарсан ядуурал нүүрлэсэн билээ. Улмаар улс төрийн намууд, ТББ-ууд, орон нутгийн засаг захиргаа халамжийн төрийн төлөөлөгч мэт ядуурал, эдийн засгийн уналттай тэмцэхийн тулд хандив тарааж эхэлжээ. Сонгуулийг тойроод төрөл төрөгсдийн, нутаг нэгтнүүдийн, ижил сонирхлоороо нэгдсэн хүмүүсийн албан бус бүлгүүд бий болж эхэллээ. Сонгуулийн дүрэм, журам албан ёсны туршлага зэрэг нь сонгуулийг ялангуяа сонгуулийн кампанит ажлыг тасралтгүй үйл явц биш үйл явдал болгох ёстой хэдий ч эдгээр нь төлөвших шатандаа явж байлаа. Монголчууд барууны хэв маягийн институцийг нутагшуулсан боловч бие даасан либерал хүн, хувийн болон нийтийн орон зайн зааг ялгаа, эрх зүйт ёсонд суурилсан төр зэрэг барууны ойлголтыг нутагшуулаагүй. Харин эсрэгээрээ Монголчуудын өдөр тутмын амьдралын хэв маяг харилцаа, тэр тусмаа төрийн байгууллагуудын зарим хэсэг нь садан төрлийн харьцаа, тохироо, наймаа, болон бусад албан бус харилцаа, туслалцаа, боломж олгох гэх мэт дээр тулгуурласаар иржээ. Мөн энэ нягт холбоот соёл ч сонгуульд нэвтэрч сайнтай муутай, өвөрмөц, Монгол маягийн ардчилсан сонгууль бий боллоо.

Сонгууль нь албан ёсны санал авах үйл ажиллагаа, институт, туршлагаас гадна үл харагдах байдлаар сонгогчдын өдөр тутмын амьдралд байнга хүчтэй нөлөө үзүүлсээр байна. Үнэхээр ч сонгуулийн кампанит ажил болон бусад сонгуультай холбоотой туршлагауд нийгмийн амьдралын бүхий л хүрээнд нэвчсэн тул, Монголчууд өөрсдийн ахуй амьдралаа ч тэр, нийгмийн харилцаагаа ч тэр сонгуулиас үүдэж зохицуулж, сонгуулийн үеэр аль болох оновчтой боломжуудыг эрэлхийлсээр иржээ. Тийм учраас сонгуулийн дараа нийгэм өдөр тутмын амьдралдаа орох ёстой боловч, эсрэгээрээ сонгуулийн дараа ч гэсэн хүмүүсийн өдөр тутмын амьдралд нөлөөлсөн хэвээр байна. Сонгуулийн кампанит ажлын үр дүнд бий болсон том том бүтээн байгуулалт болон бусад үр дагаврууд нь (дэд бүтэц, сүлжээ, институт, зах зээл, харилцаа, нийгмийн шинээр бий болсон субъект болон субьектив байдал [нийгэм орчин тойрноос үүдэлтэй оюун санааны болон сэтгэл зүйн байдал]) сонгууль албан ёсоор дууссаны дараа ч оршин тогтнож үйл ажиллагаа явуулж байгаа нь сонгууль зогсохгүй буй мэт. Монголчууд неолиберализмын тодорхойгүй байдлыг даван туулахын тулд сонгуулийг ашиглах болсноор сонгууль нь хууль

тогтоох байгууллагын дараагийн төлөөлөгчдийг сонгохоос хамаагүй өргөн хүрээний үйл явдал болжээ.

Тиймээс тус ном нь эдийн засаг, зах зээлийн үр дагавраас гадна неолиберализмын улс төрд үзүүлэх нөлөөг харуулж байгаагаараа өнөөгийн эрин үеийг судлахад хувь нэмэр оруулж байна. Энэ номд ардчилсан институцуудыг хүчтэй хамгаалаагүй тохиолдолд чөлөөт зах зээлийн зарчим сонгуулийг, сонгуулийн кампанит ажлыг эзлэн авсан үр дүнг тод харуулна. Неолиберализмыг дийлэнхдээ эдийн засгийн өнцгөөр авч үздэг тул сонгуульжилт гэх нэр томьёо ашигласнаар би улс төрийг ч илүү бодитоор хамруулан авч үзэх ёстойг харуулахыг хичээлээ. Би сонгуулийн кампанит ажлыг жишээ болгон “чөлөөт” зах зээлийн эдийн засгийн өнцгөөс шинжлэн харуулахыг, мөн сонгуулийн кампанит ажил хэрхэн үндэсний хувь заяад нөлөөтэй томоохон уул уурхай ашиглах талаарх гэх мэт шийдвэр гаргахад иргэдийн зөвшөөрлийг авах хэрэгсэл болж буйг харуулав. Сонгууль арилжааны шинжтэй болсон нь өдөр тутмын амьдрал, нийгмийн харилцаа, нийгмийн болон соёлын шинэ туршлагыг бий болгож, тэдгээртэй холбогдох шинэ сэдэв, өөрчлөлт, ойлголтод ч нөлөөлж байна

Феминизм ба “Эмэгтэйчүүд улс төрд”

Энэхүү ном нь Монгол эмэгтэйчүүдийн дүр төрхийг бэлгэдлийн хувьд, мөн Монгол эмэгтэйчүүд нийгэм соёлын хүчний хувьд сонгуулийн технологи, сүлжээнд хэрхэн оролцож ирсэн талаар харуулна. Сонгогчдын оролцооны талаарх антропологийн судалгааг (Banerjee 2007; Bowie 2008; Miles 1988) өргөжүүлж нэр дэвшигчид ч мөн адил дотоод, гадаад төрөл бүрийн нөлөөлөл, нөхцөл байдлаас хамааран хувьсан өөрчлөгддөг талаар өгүүлнэ. Эмэгтэй нэр дэвшигчдийн субъектив байдал нь түүхэн болон орчин цагийн, дотоодын болон гадаадын феминист үзлийн нөлөөгөөр тодорхойлогдоно. Надтай уулзсан эмэгтэйн зарим нь өөрсдийгөө феминист гэж үзээгүй ч гэлээ, тэдний субъектив байдал нь социалист, колоничлолын дараах, мөн либерал феминизмийн нөлөөгөөр бий болсон байлаа. Эмэгтэйчүүдийн энэхүү субъектив байдал нь феминизмийн түүхийг нэгтгэж, колоничлолын дараа үеийн төдийгүй, хүйтэн дайны дараах болон, орчин үеийн өөр өөр төрлийн феминист хөдөлгөөний түүхийг нэгтгэн бичих боломжийг олгож байна.

“Феминизм” гэдэг үгийг Монгол хэлэнд ганц үгээр оновчтой буулгасан үг хэллэг байхгүй тул феминизм хэмээн галиглан буулгадаг. Хэдийгээр тус нэр томьёо өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгддэг ойлголт биш боловч, ихэнхдээ эмэгтэйчүүдийн эрхийн төлөө ажилладаг хүмүүс болон улс төрийн эрх мэдлийг эрэлхийлж буй эмэгтэйчүүдийг илэрхийлдэг. Монголд ардчиллын үйл явц эхэлснээс хойш феминизм

гэх ойлголт улс төрийн сэдэв, хувь хүний танигдахуйн тэмдэг, бас улс төрийн ухамсрын хэлбэрээр яригдсаар байна. Феминизм гэх ойлголт нь социализмын үед барууны, хөрөнгөтний нийгэмтэй холбож ойлгодог байсан тул бараг л хэрэглэгддэггүй байсан гэдэг утгаараа шинэ ойлголт юм.¹⁸ Гэвч, социализмын үед социалист феминизм (олон талаараа барууны либерал феминизмээс тэс өөр) гэх нэр томьёо шууд хэрэглэгддэггүй боловч зарчмууд нь өргөн хүрээнд тууштай хэрэгжиж байлаа.

Монголын Эмэгтэйчүүдийн Хороо гэх социализмын үеийн эмэгтэйчүүдийн байгууллагаас хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүд тэр үед үндэсний хэмжээнд жендэрийг хэлбэржүүлж байсан талаар, энэ байгууллагын хөтөлбөрүүдийн ач холбогдол анзаарагдахгүй байх мэт боловч ардчилсан тогтолцоонд шилжсэний дараа ч эмэгтэй нэр дэвшигчдийн улс төрийн амбицад чухал нөлөө үзүүлсэн талаар би онцлон харуулахыг хичээлээ. Социализмаас хойш эмэгтэйчүүдийн байгууллага өөрчлөгдөж, төвлөрсөн бус олон ургалч бүтэцтэй болж, хоорондоо ялгаатай бүлгүүд нэмэгдсэн. Монголын Эмэгтэйчүүдийн хороо үйл ажиллагааныхаа цар хүрээг эрс багасгасан боловч, капиталист шилжилтийн хүнд хэцүү үед эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, сайн сайхан байдлын төлөө манлайлан ажиллаж, шинэчлэгдсэн юм. Шинээр либерал феминистүүд, олон улс даяарх [transnational] феминистүүд бий болж, гол төлөв олон улсын байгууллагын санхүүжилтээр өөр өөрсдийн феминист ТББ-уудыг байгуулж эхлэв. Анхандаа тэд өөрсдийгөө хуучин Монголын Эмэгтэйчүүдийн Хорооны гишүүнчлэл, үзэл санаанаас тусгаарлаж байлаа.

Энэхүү 1990-ээд онд өрнөсөн Монголын ардчилсан шилжилтийн үеэр феминист үзэл өргөжин тэлж байх үед “улс төр дэх эмэгтэйчүүд” [women in politics] гэх шинэ хэлц үүсэж, өргөн хэрэглэгдэх боллоо. Гэвч, Монгол хэлэнд (зарим сэдэвчилсэн эрдэм шинжилгээний салбарт ч мөн адил) “феминизм”, “эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөн” гэх нэр томьёонууд нь “улс төр дэх эмэгтэйчүүд” эсвэл “эмэгтэйчүүдийн манлайлал” (Монголчуудын хэлэх дуртай хэлц) гэсэн нэр томьёонуудтай хамт хавсарч хэрэглэгддэг нь маш бага байдаг нь миний анхаарлыг татсан юм. (тухайлбал, Lawless and Fox 2010 үз). Удаа ч гүй би “феминизм”, “улс төр дэх эмэгтэйчүүд” гэсэн нэр томьёо, тэдгээрийн хэрэглээ нь зөвхөн Монголд төдийгүй, бусад газар ч гэсэн өөр өөр сэдэв, төсөл, ойлголттой холбоотой байдгийг анзаарсан юм.

“Улс төр дэх эмэгтэйчүүд” гэх нэр томьёо нь гол төлөв, төрийн болон төрийн бус байгууллагын чадавч бэхжүүлэх сургалт, эмэгтэйчүүдийн

¹⁸ 20-р зуунд Монголд феминизм гэх үгийн хэрэглээ нь Зөвлөлт Холбоот Улсын хөгжлийн тусгал байлаа. Зөвлөлтүүд тус үгийн хэрэглээ, үзэл санааг хязгаарлаж, үндэсний эмэгтэйчүүдийн байгууллагыг хумьж эхлэхээс өмнө 1930-аад он буюу социализмын эхэн үед хэрэглэгдэж байв. Тухайн үед феминизм гэх үг нь хөрөнгөтний үзэл сурталд тооцогддог байжээ. Гэвч, боловсролтой зарим хэсэг нь феминизмын философийн чиг хандлага, хувь хүний эрх чөлөөний илэрхийлэл, соёлын үнэт зүйл гэж үзэж байлаа.

манлайллыг дэмжих зорилготой олон улсын хөтөлбөрүүд болон тэднийг дагалдсан судалгаанд хэрэглэгддэг.¹⁹ “Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх”, “эмэгтэйчүүдийн манлайлал” зэрэг нэр томъёоны гарал үүсэл нь НҮБ-ын хөтөлбөрүүдтэй холбоотой. 1975 онд Мексикт болсон Олон Улсын Эмэгтэйчүүдийн анхдугаар чуулганаас гарсан зөвлөмжийн үр дүнд 1979 онд байгуулагдсан Эмэгтэйчүүдийн Хөгжлийг дэмжих НҮБ-ын Олон Улсын Сургалт, Судалгааны Хүрээлэнтэй (UN-IN-STRAW) холбоотой. 1980 онд болсон хоёрдугаар чуулганаас гарсан тайланд НҮБ-ын төрөлжсөн бүх байгууллагууд “эмэгтэйчүүдийн хэрэгцээний талаар сургалт, судалгаа, мэдээлэл хөтөлбөрүүдийг санаачлахад тус хүрээлэнд туслах” талаар уриалга гаргажээ (United Nations 1980, 100). Гуравдугаар чуулганаас гарсан тайланд төрийн болон төрийн бус байгууллагууд шийдвэр гаргах түвшинд болон менежерийн түвшинд эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах хөтөлбөрүүдийг дэмжих үүрэг хүлээжээ. Эцэст нь, 1995 онд Бээжинд болсон Дэлхийн Эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр чуулганаас гаргасан тунхагт “эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх”, “эрх мэдэлд хүргэх” гэх мэт хэлцүүдтэй тусгагдсан бөгөөд “шийдвэр гаргах, удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн чадавх оролцоог нэмэгдүүлэх” зэрэг зорилгын талаар ярьдаг болсон.²⁰ 1995 оны Бээжингийн чуулга, 2000 оны Бээжин +5 уулзалт, 2005 оны Бээжин +10 уулзалтын үеэр илүү хүчтэй, тодорхой нэр томъёо хэрэгтэй гэж ярилцан “шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд” гэх нэр томъёо анх үүсжээ (Krook and True 2012).²¹

1995 оны Бээжингийн уулзалтаас хойш Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) улс орнуудад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран чадавх бэхжүүлэх, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг хангах чиглэлээр олон тооны хөтөлбөрүүдийг санхүүжүүлсээр ирлээ. Мөн, жендэрийн тэнцвэрт байдлын шаардлагыг хангасан улс орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг Мянганы Хөгжлийн Хөтөлбөр мөн эхэллээ. Улс төрд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

¹⁹ Гүүгл дээр “эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр” гэсэн түлхүүр үгээр хайхад 245,000,000 илэрч гарч ирж байна (2015 оны 9-р сарын 29-ний байдлаар). 2021 оны 11-р сарын 2-ны өдөр ижил түлхүүр үгээр хайхад 3,850,000,000 илэрч гарч ирэв. Хэд хэдэн эрдэм шинжилгээний байгууллагын сургалтын хөтөлбөр хамгийн дээр нь харагдаж байна. Тухайлбал, Бостон хотын ойролцоо Нортитэртн Их сургуулийн Эмэгтэйчүүдийн манлайлал, хөгжлийн хүрээлэн, Бэнглигийн Их сургуулийн Эмэгтэйчүүдийн Гүйцэтгэх Манлайллын хөтөлбөр, болон Массачусетсийн Менежментийн сургууль гэх мэт.

²⁰ НҮБ-ын дөрвөн хурлын тайлангууд бүгд НҮБ-ын Эмэгтэйчүүд байгууллагын цахим хуудсанд бий <https://www.un.org/en/conferences/women>. Хамгийн сүүлийн Бээжингийн тунхаглалын үнэлгээнд шинэ сорилтууд гарч ирж буй, ялангуяа “шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвийг эн тэргүүнд анхааран шийдвэрлэх шаардлагатай талаар дурджээ (United Nations 2020, 8).

²¹ Антропологийн үүднээс ТББ-ын туршлагын талаар авч үзэхэд тухайн байгууллагын хүчний динамик, албан ёсны байдал, дагаж мөрддөг хэм хэмжээнд хандах хандлага, үр дүгээс байгууллагын тэлэлтийг илүүд үздэг байдал зэрэгт шүүмжлэлтэй хандах магадлалтай байдаг (Riles 2000, Coles 2007). Ийнхүү шүүмжлэлт дүн шинжилгээ нь хүчний харилцаа, дотоод динамикийг ойлгоход чухал боловч, миний бодлоор улс төрд эмэгтэйчүүдийн нөлөөлөл, жендэрийн асуудал, бодлого боловсруулах зэрэг нөлөөллийн ажил хийж буй хэл яриаг ойлгоход мөн тусалдаг.

нь Монголд тусгайлан зориулсан зорилго гэлтэй.²² Монголд хэрэгжиж буй НҮБ-ын эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх чиглэлийн хөтөлбөрүүд нь төр, төрийн бус байгууллага, улс төрийн нам зэрэг байгууллагуудтай ажиллаж ирсэн тул эмэгтэйчүүдийн хөдөлгөөний (төрд суурилсан биш бол) дээр дурдагдсан институцийн зарчмыг хэрэгжүүлэх хандлагатай (хүссэн ч, хүсээгүй ч) байдаг. Эдгээр байгууллага, хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүдийн манлайлал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, чадавх бэхжүүлэх гэх зэрэг үгс элбэг хэрэглэгддэг боловч “феминизм” гэх үг бараг хэрэглэгддэггүй.

Угтаа, “феминизм” гэх нэр томьёог улс төр, түүхийн нөхцөл байдал, феминизмтэй холбоотой хөгжил хөдөлгөөнөөс хамаараад дэлхий дахинд харилцан адилгүй ойлгодог. Ойлгомжтой болгох үүднээс АНУ дахь феминизм гэх ойлголтыг суурь болгон харьцуулж үзье. Тухайлбал, “феминизм” гэх нэр томьёо нь улс төрийн нөхцөл байдал, тус нэр томьёог анх хэрэглэсэн үеэс шалтгаалаад АНУ-д илэрхийлдэг утга нь Монголд илэрхийлэх утгаас өөр байна. АНУ-ын олон нийтийн дунд төдийгүй академик ертөнцөд “феминизм” гэх нэр томьёо төрийн болон олон улсын байгууллагууд гэхээсээ илүү, тэдний гадуур өрнөж буй бие даасан хөдөлгөөнүүд, бас зарим тохиолдолд босоо тогтолцоотой төрийн байгууллагуудын эсрэг хөдөлгөөнийг илэрхийлдэг (Jaggar 1994 and Weston 2002). Хамгийн чухал нь бие даан гадна өрнөх эдгээр хөдөлгөөнүүд Конгресс, болон бусад засгийн газрын байгууллагуудад лоббидох замаар амжилттай нөлөөлсөөр иржээ. АНУ-д феминистүүд улс төрийн намд элсэж, улс төрийн өндөр албан тушаал горилж яваа эмэгтэйчүүдийг феминист хөдөлгөөний гол хүмүүс гэж үздэггүй. Учир нь тэдгээр эмэгтэйчүүдийг феминизмд гэхээсээ илүүтэй улс төрийн намынхаа, болон өөрсдийнхөө хувийн зорилгод л илүү үнэнч гэж үздэг учраас тэр. Зүүн болон Төв Европ судлаач Кристен Годси (2014) энэ Америк феминист үзэл бодлыг буруутгадаг. Годси Барууны феминистүүд нь Зүүн болон Төв Европын хуучин коммунист/социалист үеийн [намтайгаа цуг байдаг] феминистүүдийг дорд үзэж, харин Баруун төвт [төрөөс дагнах] феминизмийн талаарх ойлголтыг нийтэд тулгаж буйг шүүмжилдэг. Түүхэн үүднээс АНУ-дүр нөлөө бүхий феминист хөдөлгөөн нь төр болон улс төрийн намуудын гадуур өрнөж байсан тул, тэдний хувьд жинхэнэ феминистүүдийг бусдаас ялгах нь чухал байжээ.

Нөгөөтээгүүр, Швед, Дани зэрэг улсуудад 1960-1970-аад онд өрнөсөн феминист хөдөлгөөнд идэвхтэй оролцсоны үр дүнд олон эмэгтэй улс төрд орсон талаар улс төр судлаач Моник Лээнар (2004, 22) тэмдэглэжээ. Тэдгээр эмэгтэйчүүд төрийн эрх мэдлийн гадна болон дотор талаас, феминист байдлаа улс төрийн намын гишүүний оролцооны байр суурьтай хослуулан бататгаж чадсан. Гэсэн хэдий ч бусад олон оронд

²² “Мянганы Хөгжлийн Зорилтуудад хүрэх нь” (Монгол Улсын Засгийн газар 2012, 69-79).

албан ёсны институтээс гадуурх хөдөлгөөнүүд зорьсон амжилтдаа гүйцэд хүрч чаддаггүй. Жишээлбэл, Монгол зэрэг хуучин социалист улсуудад эмэгтэйчүүд феминист төсөл хэрэгжүүлэхийн тулд төрийн эрх мэдэл заавал хэрэгтэй байдаг талтай.

Социализмын дараа Монгол Улс ардчилагдаж эхлэхэд “феминизм” дотроосоо биш, гадна талаас, тухайн үеийн бүтцийн эсрэг чиглэж байсан хэдий ч, “улс төр дэх эмэгтэйчүүд” намын тогтолцоо дотроо ажиллаж байсан ч, бусад улс оронтой, ялангуяа АНУ-ын туршлагатай харьцуулахад харьцангуй хуваагдал багатай байлаа. Улс төрд байгаа эмэгтэйчүүдийн дийлэнх нь иргэний нийгмийн идэвхтнүүд байсан юм.²³ Тухайн үеийн шинэ феминистүүд үзэл санаагаа АНУ, Европт өрнөсөн феминист хөдөлгөөнүүдээс болон феминизмийн нэг, хоёр, гуравдугаар давлагаанаас, мөн “улс төр дэх эмэгтэйчүүдийн” талаар өрнүүлсэн хэлэлцүүлэгт үндэслэн бүрэлдүүлэв. Тийм учраас шинэ Монголын феминизм олон янзын урсгалыг хамардаг. Ихэнх хэсэг нь доороос дээшээ чиглэсэн, тэгш хамруулсан, бэлгийн цөөнх зэрэг бусад бүлгийнхэнтэй хамтардаг, төр, улс төрийн намаас хараат бус, хүний эрх, бэлгийн дарамт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн гэх мэт маш олон шинжийг агуулсан байдаг. Социализмын үед эдгээр асуудлын алиныг нь ч чухлаар авч үздэггүй байв. Монголд “улс төр дэх эмэгтэйчүүдийн” талаарх яриа хэлэлцүүлгүүд гол төлөв эмэгтэйчүүдийн төлөөллийг хуульчлах, сонгуулийн квот, эмэгтэйчүүдийг сургах, улс төрийн өндөр албан тушаалд эмэгтэй хүнийг томилох зэрэг асуудлыг тойрон өрнөж байна. Эдгээр яриа хэлэлцүүлгүүд улс төрийн намд харьяалагдах эмэгтэйчүүдээс гадна, төрийн эрх мэдлээс гадуур буй феминист эмэгтэйчүүд зэрэг төрөл бүрийн эмэгтэйд хамаарна.

Эдгээр ялгаатай бүлгүүдийн хооронд үл ойлголцол, санал зөрөлдөөн их байхын сацуу, хамтын ажиллагаа ч чамгүй өргөн хүрээнд бий болов. Үнэхээр ч иргэний нийгэм улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоонд, эмэгтэйчүүдийн нэр дэвших байдалд ихээхэн нөлөөлсөн бол, Парламент дахь эмэгтэйчүүд нь иргэний нийгмийнхний хөөцөлдөж байсан төслийг нь боловсруулсан жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлахад чухал нөлөө үзүүлсэн юм. Тиймээс, Монголын нөхцөлд эмэгтэй нэр дэвшигчдийн байр суурь “улс төр дэх эмэгтэйчүүд” гэх зөвхөн дээд давхаргын элитүүдэд хамаарах онцгой ангилалд бус, харин ч ардчилсан эрин үед өрнөхдөө, социалист зохион байгуулалт уламжлалд суурилсан өргөн хүрээний феминист хөдөлгөөнөөс үүдэлтэй гэж болно.²⁴

²³ Монгол Улсын хуулиар УИХ-ын гишүүнээр сонгогдсон бол давхар албан тушаал хашиж болохгүй бөгөөд, ТББ-ын захирлаас татгалзах үүрэгтэй боловч олон гишүүн зөвлөх гэх тушаалд шилжин ТББ-таа хадгалан үлддэг. Эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг ацан шалааны талаар 5-р бүлэгт өгүүлэв.

²⁴ 2000-аад онд өрнөсөн феминист хөдөлгөөнийг хамгийн багадаа гурван хэсэгт авч үзэж болно. Уран зохиол, кино театраар дамжсан эмэгтэйчүүдийн урлагийн оролцоо, жендэрийн ойлголт, эмэгтэйчүүдийн асуудлын талаар ТББ-ын хийсэн судалгаа, тайлан, жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль батлуулахад чиглэсэн лобби, хэвлэл мэдээллийн хэргслийн үр нөлөө гэх мэт.

Ийнхүү, Монголд хийсэн угсаатан зүйн болон түүхийн судалгааны ажил маань нэг ижил нэр томъёо нийгмийн нөхцөл байдал, соёлын ялгаа, тэдгээр нэр томъёоны талаарх өөр өөр төсөөлөл зэргээс шалтгаалан хэрхэн ялгаатай утгаар ашиглагдаж буйг онцолсноороо феминист антропологи хувь нэмэр оруулж байна. Антропологи Ч Саба Махмуд (2005) Барууны феминистүүдийг эрх чөлөө гэсэн ойлголтыг хувь хүний боломжит байдал [agency] гэдэгтэй андуурч үздэг гэж шүүмжилдэг (тэрээр Египет дэх Исламын сэргэлтийн үеийн эмэгтэйчүүдийн оролцоог судалсан) бөгөөд энэ нь Монголын жишээн дээр ч нотлогддог. Эмэгтэйчүүдийн хэрэгцээ, хүсэл эрмэлзлийн төлөө тэмцэхийн тулд тухайн эмэгтэйчүүд хувиасаа хязгааргүй “чөлөөт хүсэлт зориг”-той байх албагүй. Төрийн эрх мэдлийн хүрээнд ажиллах нь заавал тэдний үнэт зүйлтэй харшилж, худал хуурмаг болгоно гэсэн үг биш. Улс төрийн шинжлэх ухаан, социологи, болон шинжлэх ухааны бусад салбарын эрдэмтэд дэлхий даяар улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл яагаад сул хангагдаж байгааг судалсаар ирлээ. Тухайлбал, эрдэмтэд жендэрийн квот, түүнд хүрэх зам, боловсрол, сонгуулийн загвар, болон дэлхий даяар хэрэгжиж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулах чиглэлийн кампанит ажлын менежментийн стратеги зэрэг формал болон институцийн стратегийн үр нөлөөг тойрон судалсаар ирсэн.²⁵ Антропологи шинжлэх ухааны хувьд эдгээр стратеги, тэдгээрийн үр нөлөөг соёлын, нийгмийн болон орон нутгийн онцлог хэрхэн хэлбэржүүлдгийг харуулдгаараа тус судлагдахуунд хувь нэмэр оруулдаг. Ардчилал өндөр хөгжсөн орнуудад институтууд нь нэгэнт хөгжиж, чиглэл, хандлага нь ямар нэг байдлаар урьдчилан таамаглахуйц болсон байдаг бол, институт, хууль эрх зүй, шийдвэр гаргах үйл явц зэрэг нь хөгжиж буй Монгол шиг улс оронд угсаатан зүйн судалгаа амин чухал.

Барууны ойлголт шинэ газар түгэхдээ бараг л цоо шинэ утга агуулгаар хэлбэрждэгийг харуулахад улс төрийн антропологи дахь угсаатан зүйн судалгаа чухал үүрэгтэй (Nugent and Vincent 2009; Paley 2002 and 2008). Тухайлбал, Баруунд ардчиллыг институтууд, үнэт зүйлс тэдгээрийн нийцэл гэж ойлгодог бол, Монголд ардчиллыг анхандаа шинэ боломжийг эрэлхийлэх эрх чөлөө гэж ойлгодог байлаа (Sabloff 2013). Тухайлбал, ихэнх оронд, “зам мөр” гэх ойлголтыг улс төрийн судалгаанд болон бодит амьдралд орон нутгийн түвшнээс үндэсний парламентад шат ахин нэр дэвших хүртэлх зам гэж ойлгодог. Гэтэл энэ ойлголт нь Монголын нөхцөлд ач холбогдол багатай. Тэр нь тогтворгүй улс төртэй учир, дэс дараатай зам мөрөөрөө урагшлах нь урьдчилан таамаглахын аргагүй бас баталгаагүй. Тэрний оронд, талбарт шинэ боломжийг бүтээх нь илүү үр дүнтэй. Тэр бүү хэл, соёлын онцлогийн үүднээс авч үзвэл, эмэгтэй нэр дэвшигч анхан

²⁵ Тухайлбал, АНУ-д хаалттай жагсаалт бүхий хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоо нь намын дотоод өрсөлдөөнийг хязгаарлаж, намын даргад илүү эрх мэдэл өгдөг тул, намын арга эмэгтэйчүүдийг дэмждэг, тэдний төлөө ажилладаг бол эмэгтэйчүүдэд ээлтэй тогтолцоо юм. Гэвч, намын дарга нь Монгол намын дарга нартай адил эмэгтэйчүүдийн оролцоог онц хайхардаггүй бол нээлттэй жагсаалтаас онцлох зүйлгүй, эмэгтэйчүүдэд онц ээлтэй тогтолцоо биш билээ.

шатнаас нь эхлэн эрэгтэй улс төрчдийн туслахын ажилд зүтгэж УИХ-д нэр дэвших хүртэлх урт хугацаанд дэвшин өгссөн ч анхан эрхэлж байсан ажил нь түүний нэр хүндэд сөрөг нөлөөлж болзошгүй. Эрэгтэй улс төрчийн туслахаас ажлаа эхэлж, өндөр албан тушаалд хүрсэн эмэгтэйчүүдийг хүмүүс эрэгтэй даргынхаа сүүдэрт байдаг гэж сэрдэхээс гадна, илүү өндөр албан тушаалд хүрсэн ч гэсэн түүнээс илүү эрх мэдэлтэй улс төрчтэй холбож ойлгох тул тухайн эмэгтэйд эрх мэдлээ өөрөө олж аваагүй хэмээн бусад эмэгтэйчүүдээс ч дор үзэх хандлагатай. Маш өндөр боловсролтой байлаа ч энэ нь эмэгтэйчүүдийг улс төрийн эрх мэдэлд хүргэх хөшүүрэг тэр болгон болдоггүй.²⁶

Сонгуулийн компанийн үеэр, сурах бичгийн дагуу боловсруулсан кампанит ажлын стратеги нь орон нутгийн онцлогтой тактикаас шалтгаалан нэр дэвшигчийнхээ эсрэг үйлчилж ч магадгүй. Эмэгтэйчүүдийг ялгаварладаг соёлтой, мөнгөнд суурилсан сонгуультай гэх мэт Монголын ээдрээтэй нөхцөлд эмэгтэй улс төрчид кампанит ажлаа өөр өөрсдийнхөөр зохион байгуулах арга замыг олж, түүгээр үл барам төрийн эрх мэдлийн дотор ч, гадна ч маш ойлгомжтой, шинэ төрлийн феминист оролцоог бий болгож байгаа гэж би үзэж байна.

Судалгааны талаар

Тус номд өгүүлэх судалгааны ажил үндсэндээ 3 өөр цаг үед хамаарна. Тэдгээр нь, 2005-2007 оны зун буюу сонгуулийн бус цаг үеийн талаарх урьдчилсан судалгаа, 2008, 2012 оны сонгуулийн оролцон ажиглалт, болон 2016 оны сонгуулийн үеийн судалгаа зэрэг болно. (Гэсэн хэдий ч, тус ном маань 1996-2004 оны хоорондын зааг үеийг хамарсан миний анхны судалгааны ажилд бас тулгуурласан). Эдгээр цаг үе бүр судалгааны ажилд өөр өөрийн жинг эзлэх бөгөөд өөр хоорондоо уялдаа холбоотой. Улс төрд буй эмэгтэйн тоо өдрийн од шиг цөөн байсан бол одоо харьцангуй олон болж, “соёлын нэг хэсэг” болж буйд эмэгтэй нэр дэвшигчдийг судлахын ач холбогдол оршино (Herzfeld 2000, 228).

2005, 2006, 2007 оны гурван зун урьдчилсан судалгаагаа хийж байх үедээ би Монгол Улсын Засгийн газар, ТББ-ууд, Олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцсоор явлаа. Эмэгтэй нэр дэвшигчээс олонх нь ТББ-ын тэргүүн, эсвэл ТББ-ын ертөнцтэй холбогдсон байв. Нэг талаас иргэний нийгэм ихээхэн дэмжлэг үзүүлэх бүтэц төдийгүй, нөгөө талаас улс төрийн намууд нэр дэвшигчдийнх нь иргэний нийгэм дэх нэр хүнд намд ашигтай гэж үздэг тул тэдгээр эмэгтэйчүүдийн ТББ-д эзлэх байр суурь, хамаарал

²⁶ Монголд боловсролтой эмэгтэйчүүд эрчүүдээсээ хамаагүй олон, хамаагүй илүү байдаг боловч бүх шатны улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд маш цөөн байдаг. Батмөнх, Алтанхуяг, Осоржав (2013), Шмиллен, Вайман-Сандиг (2018) нарын Монголын боловсролын тархалтын жендэрийн тоон үнэлгээг үзнэ үү.

нь сонгуульд нэр дэвшихэд ихээхэн хэрэгтэй байлаа. Гэсэн хэдий ч, олон улсын донор байгууллагууд дотоодын ТББ-ын төслүүдийг санхүүжүүлэхдээ гишүүдийг нь улс төрийн намын харьяалалгүй байхыг шаарддаг тул эмэгтэй нэр дэвшигчид ТББ-ын хамаарлыг сонгож буй бол улс төрийн намаас татгалзах шаардлага үүсдэг. Эмэгтэй нэр дэвшигчид энэ мэт ТББ-ын албан тушаалаас татгалзах үүдэлтэй сул талаа нөхөхийн тулд хэрхэн тэмцдэг талаар мөн энэ номд өгүүлнэ.²⁷

Мөн энэ цаг үед 30 хувийн нэр дэвшигчийн квот хэрэгжих сургаар эмэгтэй нэр дэвшигчид гадаад төрх, оюуны чадавхдаа ихэд анхаарч, хувь хувьдаа эрчимтэйгээр “биеэ бэлдэж” байлаа. Эмэгтэй нэр дэвшигчид өөр өөрсдийнхөө сонгосон мэргэжлийн салбарт танигдах, өөрсдийгөө илүү төгөлдөржүүлэхийн тулд ажиллаж эхэлсэн ч гэсэн сонгууль тэдэнд урьд өмнө төсөөлж ч байгаагүй шинэ босго, шаардлагууд байдгийг ойлгуулжээ. Нэр дэвшигчид, нэр дэвшихээр горилогчдын хувьд сонгуулийн “кампанит ажил” албаны уран яриа, хэвлэл мэдээллээр үе үе гарах, сонгогчидтой товлосон уулзалтуудаас хол илүү өргөн хүрээг хамрах болсон. Сонгуулийн “кампанит ажил” сонгуулиас сонгуулийн хооронд бүтэн дөрвөн жил үргэлжилж, нийтээрээ сонгуульжилт болж билээ. 2008, 2012 оны сонгуулийн өмнө бүтэн 6 сарын турш би хэд хэдэн эмэгтэй нэр дэвшигчийг өдөр шөнөгүй дагаж, сонгуулийн кампанит ажилд оролцож, сонгууль улс төрийн болон соёлын хувьд хэрхэн явагдаж, нэр дэвшигчдэд хэрхэн нөлөөлж байгаагаас гадна жендэрийг хэрхэн тодорхойлдог талаар сайтар ажиглаж билээ.

Хоёр дахь үе буюу судалгааны ажлын маань үндсэн хэсэг 2008 оны сонгуулийн өмнөх 6 сарын ажиглалт, 2012 оны сонгуулийн өмнөх 6 сарын ажиглалт гэсэн хоёр дараалсан сонгуулийн үед хамаарна. Энэ үеэр би Улаанбаатарт судалгааныхаа үлэмж мэдээллийг цуглуулсан бөгөөд, дагаж явсан эмэгтэй нэр дэвшигчдийнхээ дэвшсэн тойргуудад ажиллаж, мөн ганцаарчилсан, болон фокус бүлгийн ярилцлагаар орон нутгаас арвин их мэдээлэл цуглуулж чадсан. 2008 оны сонгуулийн үеийн судалгааны ажлын эхэн үед би хэд хэдэн кампанит ажлын хооронд гүйж, нэр дэвшигчдийн төлөвлөсөн арга хэмжээнээс сонгон оролцож байлаа. Гэвч, кампанит ажил өрнөх тусам, би нэг нэр дэвшигчтэй л илүү тулж ажиллах хэрэгтэй болсон юм. Өөрөөр хэлбэл, би нэг л нэр дэвшигчийн кампанит ажлыг түүний ажлын хуваариас үл шалтгаалан бүтэн дагаж, бусад нэр дэвшигчдийн кампанит ажлын давхцаж буй арга хэмжээг алгасахаас өөр аргагүй болсон гэсэн үг.

²⁷ Зарим эмэгтэй нэр дэвшигчид 1990-ээд оны эхэнд өрнөсөн ардчилсан шилжилтэд оролцсон боловч аажим аажмаар эрчүүд төвлөрсөн улс төрийн тойргийн гадна үлдсэнээр улс төрөөс холдсон байдаг. Олон улсын хандивлагч байгууллагууд мөн тэтгэлэг авах бол улс төрөөс ангид байх гэдэг шаардлага тавьснаар эмэгтэйчүүд улс төрөөс холдоход нөлөөлсөн юм (5-р бүлэг үз). Улс төр судлаач Валерий Сперлинг (1999) 1990-ээд оны Орос дахь эмэгтэйчүүдийн ТББ-ын талаар судлаад олон улсын хандивлагч байгууллагууд улс төрөөс ангид байх шаардлага тавьж буй нь эмэгтэй улс төрчид үндэсний өндөр дээд албан тушаалуудад хүрэхэд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ.

Ганц нэр дэвшигчийн кампанит ажилд төвлөрөх нь хангалтгүй байлаа. Сонгуулийн кампанит ажил нэг зэрэг явагддаг байдал нь антропологийн “оролцон ажиглагч” гэдэг судалгааны гол арга барилд хүндрэл учруулж байв. Тэр бүү хэл, нэг нэр дэвшигчийн кампанит ажлын арга хэмжээ хэд хэдэн газар зэрэг явагдаж, аль нэгийг нь сонгож явснаараа бусад чухал зүйлсийг орхигдуулах, мэдэхгүй өнгөрөөх зэрэг эрсдэлүүд байлаа. 20 гаруй эмэгтэй нэр дэвшигчтэйгээ сайтар танилцсаны дараа би судалгааны шаталсан тогтолцоог боловсруулж, байнга судалгаа хийж ажиллах 4 хүнийг сургаж, эмэгтэй нэр дэвшигчдийн кампанит ажилд сайн дурын ажилтнаар оруулсан юм. Түүнээс гадна би хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдах дүрс бичлэгийг хуулах, сурталчилгааны хуудас, тараах материал зэрэг мэдээ, материалууд цуглуулах нэг туслах судлаачтай байв. Судалгааны шаталсан тогтолцоо гэдгээ тайлбарлаж өгье.

Нэгдүгээр шатлалд, улс орны өнцөг булан бүрд кампанит ажлын янз бүрийн шатанд ажиллаж буй түлхүүр болох хэд хэдэн нэр дэвшигчид төвлөрөн биечлэн ажиглалт хийв. Эдгээр түлхүүр нэр дэвшигчдийн дунд, 2008 оны сонгуулийн кампанит ажлын өмнө болон дундуур буюу 5-6-р сард хэдэн долоо хоногийн турш өглөөний 9 цагаас эхлээд шөнө дунд хүртэл, дийлэнхдээ шөнийн 3 цаг хүртэл Ардчилсан намаас нэр дэвшигч, судалгааны ажлын маань оролцогчдын нэг Раднаагийн Бурмаагийн кампанит ажилд ийнхүү ажиглалтаа хийж явлаа²⁸ (Бурмаагийн сонгуулийн кампанит ажлыг дагахын өмнө буюу 4-5-р сард би Салдангийн Одонтуяаг дагаж судалгааны ажлаа гүйцэтгэж байв). Миний туслах судлаач Нэргүйн Баасанхүү Бурмаагийн сонгуулийн штабт бас байнга сууж сонгуулийн менежерийн туслахаар сайн дураар ажиллахын зэрэгцээ, өдөр бүр биечлэн ажиглалт хийж гүйцэтгэсэн. Баасанхүү бусад сайн дурынхны хамтаар нэр дэвшигчийн сонин, сэтгүүлийг тарааж, хоол бэлдэж, хүргэж өгч, уулзалт зохион байгуулж, мөн судалгааны мэдээлэл цуглуулж ажилласан юм.

Судалгааны ажлын маань хоёрдугаар шатлалд 3 туслах судлаач бэлтгэгдэж, ажилласан бөгөөд бие даан нэр дэвшигч Жүрмэдийн Занаа, Иргэний Зориг Намаас нэр дэвшигч, сэтгүүлч Чимэдийн Базар, УИХ-ын гишүүн, Иргэний Зориг Намын дарга Санжаасүрэнгийн Оюун нарын сонгуулийн штабт сайн дураар ажилласан. Туслах судлаачид маань уулзалт, арга хэмжээнд оролцох, хөрөнгө босгох болон штабын ажилтнуудын хамт зурагт хуудас, сонин сэтгүүл тараах гэх мэт өдөр тутмын ажилд оролцохоос гадна сонгуулийн өдөр санал хураах, тоолох үйл явцад ажиглагчаар оролцсон юм. Би туслах судлаачидтайгаа долоо хоног бүр уулзаж, харилцан ярилцаж, тэд маань ажигласан зүйлсээ

²⁸ 2008 оны сонгуулийн үеэр Бурмаа кампанит ажил явуулсан, 2012 оны сонгуульд тэрээр намын жагсаалтад орсон тул намын улс төрд өвөрмөц, чухал нөлөө үзүүлж чадсан.

тайлан болгож нэгтгээд сонгуулийн төгсгөлд надад хүлээлгэн өгөх байдлаар ажиллаж билээ.

Судалгааны ажлын гуравдугаар шатлалын хүрээнд би сонгуулийн кампанит ажилд бүтэн оролцож, ажиглах гэхээс илүүтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, богино хугацааны айлчлалууд хийсэн. Би олон улс төрийн намын төлөөлөл, зарим нь улс төрд ихэд танигдсан (Цэдэвдамбын Оюунгэрэл, Чимэдийн Базар, Манжаагийн Ичинноров, Шагдарын Батцэцэг, Төгсжаргалын Ганди, Нацагийн Удвал гэх мэт) хэд хэдэн нэр дэвшигч эмэгтэйтэй дэлгэрэнгүй ярилцлага хийв. Эдгээр бүсгүйчүүдтэй ярилцаж, туршлагыг нь илүү түүврийн шинжтэй, тэдний сонгосон сэдвүүдийг голчилсон. Би энэ номдоо нэр дэвшигч бүрийн түүхийг бүтнээр нь оруулаагүй ч нэр дэвшигч эмэгтэй бүр өөр өөрийнхөөрөө тэдэнд тулгардаг нийтлэг шинжийг баталгаажуулсан ч бай, эсвэл онцгой шинэ тохиолдол бүтээсэн ч бай миний дүн шинжилгээнд бүгд хувь нэмэр оруулсныг онцлон тэмдэглэе.

Надтай ярилцсан хүмүүсийн дунд хэвлэл мэдээллийнхэн, бүх төрлийн судалгаа хийдэг судлаачид, хэвлэл мэдээллийн мониторингийн компани, сонгуулийн тойрог, хэсгийн хорооны ажилчид, хараат бус зөвлөхүүд, пи-арчид зэрэг олон хүмүүс байсан бөгөөд ярилцлага өгсөн зөвлөхүүдийн дийлэнх нь нэрээ нууцлахыг хүссэн. Тэдгээрээс гадна би олон сонгогчтой дэлгэрэнгүй ярилцлага хийж бас өдөр тутам байнга ярилцаж байв. Ихэнх ярилцлагуудыг бүлгийн ярилцлага хэлбэрээр авсан бөгөөд 20 гаруй бүлгийн ярилцлага, мөн цөөнгүй ганцаарчилсан ярилцлага ч хийж гүйцэтгэв. Ихэнхдээ би ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг хослуулж хийсэн. Ярилцлага, тэмдэглэл, бусад судалгааны материал зэргээс гадна би сонгуулийн үеийн телевизийн бичлэгүүдийг цуглуулсан нь судалгааны ажилд ихээхэн хувь нэмэр болсон юм.

2008 оны сонгуулийн кампанит ажлыг би “гаднаас” нь ажиглаж судалсан гэж үзвэл, 2012 оны УИХ-ын сонгуулиар би “дотроос” нь ажиглаж, Монголын улс төрийн амьдрал, сонгууль тойрсон улс төрийн ихэнхдээ нуугдмал байдаг олон зүйлийг мэдэж авсан. Би сонгуулийн хууль хэрхэн бүтдэг, гол үйл явдлуудын ар талд ямар хүч, ямар өөрчлөлтүүд оршдог, сонгуулийн тогтолцооны нарийн ширийнийг ч сайтар судалсан. Би улс төрийн намын дотоод улс төрийг анзаарч, нөлөө бүхий улс төрчидтэй ярилцав. Ерөнхийдөө, 2005-2012 сонгуулийн тогтолцоо, сонгуулийн хуульд маш олон өөрчлөлт орж, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, эмэгтэй нэр дэвшигчид ч маш их өөрчлөгдсөн. Энэ номоо бичихдээ би үлгэр жишээ болохуйц, өвөрмөц, олон нийтийг төлөөлөхүйц эмэгтэйчүүдийн амьдралыг нарийвчлан судалж, түүнийгээ өгүүллээ.

2017 онд би 2016 оны УИХ-ын сонгуулийн талаар үргэлжлүүлэн судалсан. Тэр үед уулзсан хүмүүсулс төрийн нам, сонгуулийн кампанит ажилтай огт холбоогүй байсан ч гэлээ сонгууль нь эдийн засаг, нийгэм, соёлын амьдралыг бүхэлд нь хамарсан томоохон хүч болсон гэх өмнөх

гаргалгааг дахин нотолж билээ. Тэд 2016 оны сонгуулийн үр дүнд үндэслэн 2020 оны сонгуулийг угтан амьдралын хэв маяг, төлөвлөгөөгөө өөрчилж байв (өөр улс руу шилжин суурьших, ажлаа, мэргэжлээ солих зэрэг эрс тэс өөрчлөлт хүртэл гарч байв). Хачирхалтай нь хамгийн төлөв төвшин гэмээр, сонгуулийн үеийн халил ихтэй улс төрөөс харьцангуй хараат бус байхаар төсөөлж байсан хүмүүс хүйсээсээ үл хамааран сэтгэл хөдлөлөө барьж чадахгүй байлаа. Сонгуулийн үр дүн тэдний амьдралыг хүссэн хүсээгүй чиглүүлж байлаа. Өчнөөн их зардал гаргасан ч ялж чадаагүй, ялсан намын гишүүн биш учраас бусад намынханд доромжлуулсан гэх мэт олон хүний нулимс сонгуулийн дараа урссан юм. Тэд 2016 оны сонгуулиас хойш янз бүрийн стратеги хэрэгжүүлж, үйл явдалд шүүмжлэлтэйгээр сэтгэгдлээ хэлж, мэдрэмж, туршлага, бодлоо цааргалалгүй хуваалцаж байлаа. Сонгууль сонгуульжилт болон хувирч, улс орон даяар түгж, хувь хүн, сэдэв, аль алиныг нь хэлбэржүүлэх болжээ.

Би судалгааныхаа ажилд АН, МАХН (2010 онд МАН болж нэрээ сольсноор МАХН, МАН болж хуваагдсан) зэрэг гол хоёр намаас гадна Иргэний Зориг Нам гэх мэт зарим жижиг намын гишүүдийг хамруулсан.²⁹ 1990 онд социализмын төгсгөлд хэд хэдэн жижиг улс төрийн нам эвсэж, АН-ыг үүсгэн байгуулсан билээ. АН-ын цахим хуудаснаас үзэхэд тус намын үндсэн зарчим нь үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувь хүний итгэл үнэмшил, ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засаг, хүний эрхэд суурилсан нийгмийг бүтээх зэрэг болно гэжээ.³⁰ Харин МАХН (2010 оноос хойш МАН болсон) өөрсдийн үндсэн зарчмаа социал демократ үзэл санаа түүний үнэт зүйлс, үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, аюулгүй байдал, энх тайван хэмээн тодорхойлжээ.³¹ Хоёр намын өөрсдөө тодорхойлсон үндсэн зарчим, үнэт зүйлс нь хоорондоо тэгтлээ хол зөрүү ч гүй, хоорондоо зөрчилдөж, эсрэгцдэг ч үгүй билээ.

Гэвч, бодит байдал дээр хоёр намын гишүүд үнэт зүйлс, байр сууриараа нөгөө намын гишүүдийн эсрэг байх хандлагатай байна. Тухайлбал, миний уулзсан АН-ын гишүүд МАН-ын босоо тогтолцоо бүхий бүтэц, хэт албархуу, хаалттай хурлын дэг зэрэгт шүүмжлэлтэй хандаж, эсрэгээрээ АН-ын хурлууд хэрхэн бүх гишүүддээ нээлттэй болдог зэрэг намын дотоод ардчилал сайтай гэдгээрээ бахархана. Эсрэгээрээ, МАН/МАХН-ын гишүүд АН-ын бүтцийг зохион байгуулалт муутай хэмээн шүүмжилнэ. Миний хувийн туршлагаас АН-ын гишүүд илүү нээлттэй, энгийн мэт санагдсан. МАН-ын олон гишүүд судалгааны

²⁹ 2000-аад онд Монголд 10 орчим улс төрийн нам үйл ажиллагаа явуулж байлаа. Гол хоёр нам нь Монгол Ардын Хувьсгалт Нам (2010 онд Монгол Ардын Нам буюу МАН, МАХН болж хуваагдах хүртлээ) болон Ардчилсан нам юм. Улс төрийн гуравдагч хүчнээс Иргэний Зориг Нам хамгийн тод нь байв. МАХН-ын үргэлжлэл, хөгжил болон 1990 оноос хойш бий болсон шинэ намуудын талаар Смитийн (2020) ажлыг үзнэ үү.

³⁰ Ардчилсан нам. <http://www.demparty>.

³¹ Монгол Ардын Намын эрмэлзэж буй үнэт зүйлс. <http://www.mpp.mn>.

минь ажилд туслахыг хүсэж байсан ч, ерөнхийдөө илүү хашир, нухацтай, албан ёсны байдал баримталж байв.

Судалгааны ажилд маань архивын төрөл бүрийн баримт ихээхэн хэрэг болсон. УИХ-ын архиваас нэр дэвшигчийн квотын төлөөх тэмцлийн талаарх архивын материалуудыг сайн цуглуулж чадсан нь азтай хэрэг байлаа. Социализмын үед эмэгтэйчүүдийг хэрхэн дэмждэг байсан талаар, “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүл, тэнд нийтлэгдсэн дурсамж, намтрууд, ялангуяа Гэрэлсүрэн, Эрдэнэчимэг (2014) нарын хийсэн ярилцлага, захидал, дурсамж бүхий гурван дугаар ном нь социализмын үеийн түүхийг шинэчлэн баяжуулж орхигдсон баларсныг нь сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Би эдгээр эх сурвалжийг, ялангуяа албан ёсны түүхийн номыг эх сурвалж төдий гэж үзсэнгүй. Харин, зарим хэл яриа, мэдээллийг хүлээн зөвшөөрч, онцолж, бусдыг нь бүдгэрүүлдэг, хаадаг төрийн эрх мэдэл бүхий тодорхой дэглэмийн бүтээгдэхүүн гэж үзлээ. Цензур бүхий эдгээр бичвэрийг уншсанаар би нам төвтэй төрийн тогтолцооны үед эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх ажлыг бас бодол эрмэлзлийг нь оруулаагүй байж болохыг тэмдэглэв. Тиймээс би Анн Столер “аливааг уян хатан зохицуулах . . . эрүүл ухаан” (2009, 3) хэмээн тодорхойлсончлон төрийн хэвлэл Монголын ард түмний идэвхтэй байдал, дуу хоолой, итгэл үнэмшлийг хэрхэн харгалзахгүйгээр нийтэлж байсан талаар харуулахыг зорив. Социалист нийгэмд эмэгтэйчүүдийн туршлагын талаарх түүх бичих нь бүтэн бус эвлүүлдэг тоглоом эвлүүлж буй мэт. Учир нь албан ёсны үйл явдал, огноог аман түүх, дурсамжтай харьцуулах болдог. Миний үзэж буйгаар социалист төрийн үеийн феминизм нь дотооддоо халамжийн төрийг хэлбэржүүлэх, улс үндэстнийг цогцлоох илүү том хөтөлбөрийн нэг хэсэг, гадаад ертөнцөд дэлхий даяар өрнөж байсан феминист хөдөлгөөний аль алиных нь үр дүн юм. Мөн, түүхийн судалгааны ажил маань дан ганц энэхүү судалгааны эх сурвалжаар хязгаарлагдахгүй, Монголын эмэгтэйчүүдийн түүхэнд оруулж буй хувь нэмэр гэж үзэж байна. Би түүхэн шинжилгээнийхээ үр дүнд, социалист нийгмийн үед эмэгтэйчүүд улс төрийн хувьд бойжсон үйл явц нь орчин цагийн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, ардчилсан сонгуульд өрсөлдөхөд шийдвэрлэхүйц чухал үүрэгтэй гэж дүгнэсэн. Учир нь либерал феминизмийн нөлөөнөөс аль өмнө эмэгтэйчүүд улс төрийн албан тушаалд томилогдох боломжоор хангагдсан байсан юм. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд шинэ тогтолцоонд өөрсдийнхөө оролцоог баталгаажуулахын төлөө үй түмэн саад бэрхшээлийг өчүүхэн дэмжлэгтэйгээр л үргэлжлүүлэн даван туулж өөрсдийгөө шинэчилж буй хэрэг.

Онцлом хоёр сонгууль

2008, 2012 оны УИХ-ын хоёр сонгууль тогтолцооны хувьд ч, үр дүнгийн хувьд ч тэс өөр болов. 1992 оноос хойш Монгол УИХ 76 гишүүнтэй байсаар ирсэн. Ихэнх сонгуулиар сонгогчид нэг мандатай 76 жижиг тойргоос дэмжсэн нэр дэвшигчээ сонгодог мажоритар сонгуулийн тогтолцоо буюу хамгийн олон санал авсан нэр дэвшигч шууд сонгогддог тогтолцоогоор явуулсан. 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн бүр санал өгөх эрхтэй.

2008 оны сонгууль эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд хамгийн амаргүй сонгууль байсан. Нэгдүгээрт, сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж квотыг цуцалсан төдийгүй, нэг мандатай 76 тойргоос 76 гишүүн сонгодог байсан тогтолцоог олон мандатай (2-4 мандат) 26 сонгуулийн тойргоос 76 гишүүн сонгодог болж өөрчилсөн юм. Сонгуулийн тойрог томрох тусам кампанит ажлын зардал нэмэгдэнэ. Кампанит ажлаа биечлэн хийх боломж хязгаарлагдмал тул 2008 оны сонгуульд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах сонирхол үлэмж ихсэж, кампанит ажлын зардал тэр хэмжээгээрээ өсөж байлаа.³² Хоёрдугаарт, сонгуулийн кампанит ажлын хугацаа богиносж гурван долоо хоног болсон (өмнөх сонгуулиудад сурталчилгааны хугацаа илүү урт байсан) тул шинээр нэр дэвшиж буй хүмүүст өөрсдийгөө сонгогчдод таниулах хангалттай хугацаа байсангүй.³³ Эсрэгээрээ бүрэн эрхээ хэрэгжүүлж буй УИХ-ын гишүүд эфирээр үнэ төлбөргүй, байнга гарч байлаа. Гуравдугаарт, том тойргийн сонгогчид мандатын тоогоор санал өгөх тул албан ёсны өрсөлдөөн нам хооронд өрнөж байсан хэдий ч, албан бусаар нэг намын нэр дэвшигчид хоорондоо өрсөлдөв. Тэр бүү хэл зарим эмэгтэй нэр дэвшигчдийн хэлснээр жинхэнэ өрсөлдөөн нам хооронд суурилсангүй. Өөрөөр хэлбэл эрэгтэй нэр дэвшигчид хэдий өрсөлдөгч намуудаас нэр дэвшсэн ч гэлээ сонгуулийн кампанит ажлын үеэр яаж ийгээд холбоотон болж, намынхаа эмэгтэйчүүдийн эсрэг хоорондоо үгсэж, сонгогдсон тохиолдлууд 2008 оны сонгуульд гарсан гэнэ.

Эргээд харахад, 2008 оны сонгууль нэгэнт сонгогдсон хэсгийн эрх мэдлийг илүү баталгаажуулж, улмаар 2009 онд уул уурхайн томоохон гэрээ, хэлэлцээрийг батлахын суурь болсон сонгууль байжээ (Chaney and Stanway 2010). 2008 оны сонгуулийн дараа 7 дугаар сарын 1-ний өдөр иргэдийн тайван жагсаал үймээн самуун болон хувирсан. Мөн засгийн газраас хүчирхийлэл хэрэглэн зогсоож байсан сонгууль өмнө

³² УИХ-ын 2008 оны сонгуульд 76 суудлын төлөө 366 нэр дэвшигч өрсөлдөхөөр бүртгүүлжээ. Сонгууль бүрээр нэр өрсөлдөхөөр бүртгүүлсэн нэр дэвшигчдийн тоо харилцан адилгүй бөгөөд 293 (1992 оны сонгууль) -аас 602 (2000 оны сонгууль)-ын хооронд хэлбэлзэж байна.

³³ Миний ярилцсан хууль тогтоогчид сонгуулийн кампанит ажлын зардлыг бууруулахын тулд сурталчилгааны хугацааг богиносгосон гэж тайлбарлаж байв. Гэвч тэд богиносгосон хугацаанд зардал ихээхэн төвлөрсөн тул энэхүү өөрчлөлт нь зорилгодоо хүрээгүйг хүлээн зөвшөөрсөн. Хамгийн гол нь, шинэ нэр дэвшигчид дахин өрсөлдөж буй хүмүүстэй ижил тэгш өрсөлдөж, сонгогчдод танигдах хангалттай цаг хугацаа үгүй болсон.

нь тохиолдож байсангүй. Энэ нь ардчилсан Монголд олныг хамарсан үймээн самуун гарсан анхны тохиолдол байсан бөгөөд, 1930 оноос хойш засгийн газар нь ард иргэдийн эсрэг зэвсэг барьж зогссон мөн анхны тохиолдол юм. Номынхоо тавдугаар бүлэгт тус үймээн самуун, зүй бус үйлдлүүдийг улс төрийн гол тоглогчид хэрхэн харж байсан талаар өгүүлэх болно.

2012 онд сонгуулийн тогтолцоо 2008 оныхоос өөрчлөгдөв. Эмэгтэйчүүдийн оролцооны үүднээс харахад хуулийн болон соёлын хувьд зарим дэвшил ч гарлаа. Тухайлбал, 26 том тойрогтой байсан бол 76 жижиг тойрог руу буцаж шилжсэн. 2012 оны сонгуульд 26 тойргоос 48 нэр дэвшигч, намын жагсаалтаар 28 нэр дэвшигч сонгогдов [орч.]. Энэ нь нэр дэвшигчид тойргийнхоо сонгогчдод хүрэх, кампанит ажлаа хэвлэл мэдээллээр бус биечлэн явуулах боломж нь нэмэгдсэн гэсэн үг. 2011 оны 12-р сарын 14-ний өдөр УИХ сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, мажоритар сонгуулийн тогтолцооноос холимог тогтолцоонд шилжсэн нь эмэгтэйчүүд сонгогчдын саналаас гадна, намын жагсаалтаар сонгогдох боломжийг олголоо.³⁴

Монголын хууль тогтоогчид хоёр сонгуулийн тогтолцооны аль нь Монголд илүү тохирох вэ гэдэг дээр харилцан адилгүй байр суурьтай байдаг. Мажоритар сонгуулийн тогтолцоо (2008 оны болон бусад сонгуулиудад хэрэглэсэн) нь улс төрийн намыг (болон сонгогчдыг) туйлшруулдаг бөгөөд эмэгтэй нэр дэвшигчид өрсөлдөхөд хамгийн төвөгтэй тогтолцоо юм. Сонгуулийн холимог тогтолцоо нь эмэгтэй болон анх удаа дэвшиж буй нэр дэвшигчдэд илүү тохиромжтой тогтолцоо бөгөөд 2012 онд хэрэглэгдсэн. Гэсэн хэдий ч, энэ тогтолцоо нь нам дамжсан фракцуудыг бий болгож, улс төрийн намын эрх мэдлийн төвлөрлийг сааруулдаг. Хууль тогтоогчид, улс төрийн намуудын хооронд өрнөсөн олон мэтгэлцээний дараа 2016 оны сонгуулийн хуулиар, холимог тогтолцооноос мажоритар тогтолцоо руугаа буцаад шилжсэн юм. Ингэснээр эмэгтэйчүүд намын жагсаалтаар сонгогдох боломж хаагдав.

³⁴ Жулиан Диркес, Mongolia Today блогийн 2011 оны 12-р сарын 15-ны өдрийн “Сонгуулийн хуулийг тодруулах нь”, болон “Их Хурал Сонгуулийн шинэ хуулийг баталлаа” зэрэг бичвэрийг үзнэ үү. Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчид саналын хуудсанд дэмжиж буй нэр дэвшигч, болон дэмжиж буй нам гэсэн хоёр газар сонголт хийдэг. Нөгөө талаар улс төрийн нам авсан саналаасаа шалтгаалан нэр дэвшигчдийн жагсаалтаас суудал хуваарилна. Нийт УИХ-ын 76 гишүүдийн 48 нь сонгуулийн тойргоос, 28 нь намын жагсаалтаар буюу авсан саналаар хувь тэнцүүлсэн сонгогдсон. Энэ тогтолцоонд улс төрийн нам жагсаалтаар суудал авахын тулд нийт сонгогчдын таван хувийн саналын босго давах ёстой гэх нийтлэг шалгуур тавигддаг. http://www.loc.gov/lawweb/servlet/lloc_news?disp3_l205402958_text. 28 гишүүнийг хувь тэнцүүлсэн тогтолцоогоор суудал хуваарилж буй тохиолдолд нэг нам 10-аас дээш суудал авах магадлал маш бага. Гол хоёр намын хувьд АН 9, МАН 11 эмэгтэйг жагсаалтын 28-д багтаан нэр дэвшүүлсэн. Гэвч АН жагсаалтын 7-р байранд, харин МАН жагсаалтын 10-р байранд эмэгтэй нэр дэвшигчийг багтаасан юм. Перли Жэкоб (2012) үзнэ үү.

Бүлгийн тойм

1-р бүлэг: Өв

Нэгдүгээр бүлэгт 1990 оноос хойш ардчилал эхэлж, либерал феминизм нэвтэрснээс хойш л Монголын эмэгтэйчүүд улс төрийн идэвхтэй болсон гэх нийтлэг хандлагыг үгүйсгэнэ. Социализмын үед эмэгтэйчүүд хэрхэн өөрсдийн үүргээ эрэгтэй удирдлагадаа таниулж, эмэгтэйчүүдэд ээлтэй бодлого боловсруулахын төлөө ажиллаж байсныг эрэлхийлснээр би эмэгтэй хүн социализмын үед ч улс төрийн хувьд идэвхтэй оролцогч байсан гэж дүгнэв. Социалист нийгмээс үлдээсэн өв ардчилсан нийгэмд ч эмэгтэйчүүд улс төрийн кампанит ажил хийхэд чухал нөлөө үзүүлсэн юм.

2-р бүлэг: Сонгуульжилт

Монгол дахь сонгууль Барууны улс орнуудад болдог сонгуулиас маш өөр. Би энэ бүлэгт парламентын сонгууль тодорхой цаг хугацаанд үргэлжилдэг үйл явдал байснаа сонгуульжилт буюу байнгын зохион байгуулалттай, ялалтын төлөөх зогсолтгүй хүч болон хувирч буй талаар өгүүлэв. Сонгууль өдөр тутмын амьдралд нөлөөлөх чухал хүчин зүйл болж, гол субъектүүд, болон өдөр тутмын сэдвийг тодорхойлогч, нийгэм улс төрийн тогтоц болон хувирч байна. Ард иргэдийн хувьд сонгуулийг неолиберализмын үр дүнд бий болсон тодорхойгүй, тогтворгүй байдлаас үүсэх эрсдэлийг бууруулах, шинэ боломжийг эрэлхийлэх, бизнесээ хамгаалах аюулгүйн тор болгон хардаг болжээ. Тиймээс, сонгуулийн кампанит ажлыг санхүүжүүлнэ гэдэг нь засаглах үйл явцад түр хугацаанд оролцох гэсэн утга болсон бөгөөд тэр хэмжээгээр эмэгтэй нэр дэвшигчдэд шинэ саад тотгор учруулж байна. Учир нь эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн асуудал том сорилт төдийгүй, хувь хүн өөрөө хариуцдаг хэвээр байна.

3-р бүлэг: Гадаргуу

Гуравдугаар бүлэгт жендэр, улс төрийн хоорондын харилцааны талаар өгүүлнэ. Ингэхдээ уншигч та бүхнийг Улаанбаатар хотын гудамжинд болон телевизэд өрнөж буй сонгуулийн кампанит ажлаар аялуулах болно. Нэр дэвшигчдийн хөрөг зургийн ард ямар сэдэл байдаг, сонгуулийн кампанит ажлын ард харагдахуйц болон үл харагдах байдлаар жендэрийн ямар харилцаа бий болж байдгийг өгүүлнэ. Жоан Скотт (2019) ардчилсан тогтолцоонд удирдлагын тогтворгүй байдал нь жендэрийн тэгш бус байдлыг бий болгож байдаг гэсэн санааг дэвшүүлсэн. Энэ бүлэгт жендэрийн тэгш бус байдал хэлбэржихэд соёл хэрхэн нөлөөлдгийг харуулав. Эмэгтэйчүүд боловсрол, ур чадвар

зэрэгт илүү анхаарч соёлын үнэт зүйл бүтээдэг хэдий ч, эрэгтэй улс төрчид байгалиас заяагдсан биологийн өгөгдөхүүнийг цэвэр эр хүний тодорхойлолт болгон асуудалд хандсанаар жендэрийн тэгш бус байдлыг улам гааруулж байна.

4-р бүлэг: Тайзны ар тал

Энэ бүлэгт би улс төрийн тайзан дээрх буюу албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө кампанит ажлын өмнөх үе шатад төвлөрч уншигчдаа сонгуулийн тайзны ар талаар танилцуулна. Энд сонгуулийн өмнө өөртөө мөнгөн бус үнэ цэнийг бүтээж, улс төрийн намынхаа удирдлагуудтай нэр дэвших талаар хэлэлцээ хийж буй эмэгтэй нэр дэвшигчдийн талаар өгүүлнэ. Мишель де Сертогийн (1984) стратеги, тактикийн талаарх үзлийг илүү нарийвчилж, эрчүүд зонхилсон, хатуу бүтцийг хэрхэн уян хатан болгох, өөрчлөх арга замуудыг эрэлхийлсэн өнцгөөс энэ бүлгийг бичлээ.

5-р бүлэг: Оюунлаг

Энэ бүлэгт эмэгтэй нэр дэвшигчид оюунлаг байдлаараа улс төрийг хэрхэн өөр өнцгөөр дүрслэхийг чармайдаг талаар өгүүлнэ. Тэдний төсөөлөл заримдаа сонгуульжилтын нийгмийн хэлбэрт сорилт учруулахын сацуу, сонгуульжилтаас шалтгаалан бүрэлдэж байдаг. 4-р бүлэгт эмэгтэйчүүд нэр дэвшихийн тулд улс төрийн нам дотроо хэрхэн ажилладаг талаар өгүүлсэн бол, энэ бүлэгт улс төрийн намынхаа дотор болон гадна талд ямар стратеги хэрэгжүүлдэг талаар өгүүлнэ. Оюунлаг байх нь зарчмын хувьд өндрөөр үнэлэгдэх боловч, сонгуулийн кампанит ажил, засгийн газрын үйл ажиллагаа, буяны ажил, хувийн хэвшлийн зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарим талаар хангалттай биш байдаг нь жигтэй. Улс төрийн намууд оюунлаг эмэгтэйчүүдийг ашиглаж, намын амжилтыг ахиулахыг ихэд хүсдэг хэдий ч, тэдгээр эмэгтэйчүүдийн үл шавхагдах ур чадвар нь өөрсдийнх нь эрх мэдлийг бүдгэрүүлэх вий гэдгээс болгоомжилж, зориуд зайтай байлгадаг.

6 -р бүлэг: Биеэ бэлдэх нь

Энэ бүлэгт сонгогдохуйц, төгс нэр дэвшигчийг бүтээхийн төлөө “биеэ бэлдэх” цогц үйл ажиллагаа нь эмэгтэй нэр дэвшигчдийн талаар социализмын дараа үеийн дүр төрхийг бий болгож дүр төрх нь дэлхий дахины, болон Монгол Улс орны хүрээнд хэрхэн жендэрийн шинэ дүр төрх бий болгож байгаа талаар дэлгэрэнгүй өгүүллээ. Эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийнхөө гадаад дүр төрхийг бий болгохдоо хувцас хунараа хэрхэн шинэчилж, дуу хоолойгоо хэрхэн тохируулах, гоо

үзэмжээ хэрхэн сайжруулах талаар боломжуудыг ашиглаж, бусад алдартай эмэгтэйчүүдийн нийтлэг дүр төрхөөс ялгарах, сонгогчдын анхаарлыг хэрхэн татах талаар чармайж байдаг. Өөрсдийгөө дотор талаас нь хөгжүүлэх нь мөн адил биеэ бэлдэх үйл ажиллагааны хэсэг бөгөөд халамжтай, амьдралд ойр шийдвэр гаргах боломжтой дүр төрхөө сонгогчдод харуулах, сонгогчидтой ойрхон байхад тусалдаг. Энэ бүлэгт би сонгогчид болон, улс төрийн намын удирдлага хоорондын сонгогдохуйц байдлын талаарх зөрчилтэй ойлголтын эсрэг эмэгтэй нэр дэвшигчид биеэ хэрхэн бэлдэж буй талаар өгүүлнэ.

Дүгнэлт: Шилэн тааз томруулдаг шил болох нь

Дүгнэлт бүлэгт жендэрийн байдал, улс төрийн тогтолцоо, ардчилсан сонгуулийн бүтэц өөрчлөгдөж буй, болон тэдний давхцалын талаарх судалгааны ажлын үндсэн үр дүнг өгүүлнэ. Энд эмэгтэй улс төрчдөд тулгарч буй саад бэрхшээл, үүнээс болж нийгэмд үүсэх нөлөөг онцлохын сацуу эмэгтэйчүүд сонгуулийн кампанит ажил өрнүүлэх, эрх мэдэлд хүрэх үйл явц нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, нөлөө ихтэй, Тереза де Лауретын (1987) үгээр илэрхийлбэл, “жендэрийн технологи” болон өөрчлөгдсөн гэсэн санааг дэвшүүлэв. Тус дүгнэлт бидэнд сонгуульжилт гэх агуулгаар соёлын болон нийгмийн шинэ туршлага нь цаашид түгэн дэлгэрч, давамгайлсан хэлбэр болж болох тухайг сануулна.

Ийнхүү, Парламентад Хүрэх Мянган Алхам ном неолиберал эриний улс төр, чөлөөт, ардчилсан сонгуулийн тогтолцоо дахь эрчүүдэд төвлөрсөн улс төр, арилжааны шинжтэй кампанит ажилтай зэрэгцэн сонгогдохуйц эмэгтэй нэр дэвшигчид хэрхэн хүчин чармайлт гаргаж, өөрсдийгөө бүтээж буй талаар судалсан бүтээл юм. Эмэгтэй нэр дэвшигчдийн хүчин чармайлт нь квот, хууль тогтоомж, сонгогчдын боловсрол зэрэг гадаад нөхцөл байдлыг өөрчилж, өөрсдийн бие, оюун санаа, хувь хүний танигдахуй зэрэг дотоод нөхцөлөө сайжруулахад чиглэж байдаг. Эдгээр эмэгтэйчүүд өөрсдийн бие, оюун санаагаа хязгааргүй, уян хатан, шинэлэг байхад анхаарч, орчин үеийн арилжааны шинжтэй болсон сонгуульд эмэгтэй хүний шинэ дүр төрхийг бий болгож, сонгуульд биеэ бэлдсээр байна. Монгол эмэгтэйчүүдийн алхаж буй 1000 алхам нь дэлхий дахинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангагдах замналд чиглэж буй ч, зарим улс орнуудын хууль тогтоох байгууллагад жим нь ч гарч амжаагүй байна. Дэлхий дахинд болон үндэсний хэмжээнд ардчилал, эмэгтэйчүүдийн ололт амжилтад неолиберализм сөрөг нөлөөлж буй асуудлыг цогцоор нь улс төр, хууль зүйн хүрээнд шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ бий бөгөөд хувь хүний өөрчлөлт тус хэрэгцээг хангах боломжгүйг эдгээр эмэгтэйчүүдийн хүчин чармайлт харуулдаг.

Өв: Социалист төрийн үеийн Жендэр ба Феминист улс төр

Олон нийтийн өмнө чөлөөтэй байх нь

1925 оны 3-р сард МАХН-ын Төв хорооны хуралд эмэгтэйчүүдийн тасгийн дарга (Засгийн газрын үзэл суртлын хэлтэст харьяалагддаг) Сүхбаатарын Янжмаа айхавтар ширүүн илтгэл тавьжээ. Янжмаагийн илтгэлд дурдсанаар үндэсний эмэгтэйчүүдийн байгууллагын гол зорилго нь социалист төрийн шинэ үзэл суртлыг түгээн дэлгэрүүлэх, мөн эмэгтэйчүүдэд боловсрол олгож, хоцрогдмол байдлаас гаргах явдал гэжээ. Тус зорилгод хүрэхийн тулд эмэгтэйчүүдийн байгууллага бие даасан байх ёстой бөгөөд үзэл суртлын хэлтэст харьяалагдаж болохгүй. Мөн, Янжмаа эмэгтэйчүүдийн хэсэгт үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зориулж төсөв хуваарилж өгөхийг хүсжээ (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol 1). Энэ нь үнэмшил төрүүлэм илтгэл тавьсан хувьсгалч, феминист, хожим 1953-1954 онд Монгол Улсын төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэж байсан улс төрч бүсгүй Янжмаагийн тоо томшгүй олон ажлын ердөө нэг нь л юм.

Тус илтгэл нь эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагааны, жендэр гэх ойлголтын өөрчлөлт, болон шинэ үе ирж буйн зэрэг олон чухал зүйлийн эхлэл байлаа. Үр дүнд нь, эмэгтэйчүүдийн тасаг (Үзэл суртлын хэлтэст харьяалагддаг байсан) нь “Эмэгтэйчүүдийн хэлтэс” гэх өөрийн гэсэн төсөв, хүний нөөц бүхий бие даасан байгууллага болон өргөжлөө (Gerelsuren and Erdenechimeg 2014, voll; Nordby 1988, 98; Shirendev 1969, 16). Намын төв хорооны хурлаас Эмэгтэйчүүдийн санал (Batchuluun 1982; Gerelsuren and Erdenechimeg 2014, vol 1:8) гэх сэтгүүл гаргах

тухай тогтоол гаргаж, ЗХУ-ын Эмэгтэйчүүдийн тасгаас зөвлөх урих тухай төсөв хүртэл суулгажээ. 1925 онд Коминтерний гишүүн Вера Тарантаева Эмэгтэйчүүдийн тасгийн зөвлөхөөр Монголд ирлээ. Намын төв хороо мөн эмэгтэйчүүдийн төлөө сургууль, соёл боловсролын арга хэмжээнд зориулж төсөв баталсан юм (Gerelsuren and Erdenechime 2014, vol 1).

Янжмаа эмэгтэйчүүдийг сургууль, ажлын хэсэг, нийтийн цугларалт, болон улс төрийн байгууллага гэх мэт “нийтийн” хэрэгт оролцуулан, “чөлөөлөхийн” төлөө тууштай ажиллаж байв. Төр бол эмэгтэйчүүдийг зөвхөн Буддизмын болон империализмын үзэл суртлаас л хол байлгаж удирдахад санаа зовж, харин чадавхжуулах сонирхолгүй байсан юм. Янжмаа харин бууж өгөөгүй төрийн ажиллагаанаас илүү ихийг зорьсон юм.

Энэ бүлэгт Янжмаа болон эмэгтэйчүүдийн байгууллагын дараагийн удирдлага улс төрийн шинэ орон зайд эмэгтэйчүүдийг чөлөөтэй оролцуулах, улс төрд тэдний орон зайг бэхжүүлэхийн төлөө хэрхэн тэмцэж байсан талаар өгүүлнэ. Эдгээр эмэгтэй удирдагчийн зорилго, үйл ажиллагаа нь хойч үедээ ч уламжлагдав. Өмнөх үеийн эмэгтэй удирдагчдын үйл ажиллагааны талаар судлах нь надад орчин үед эмэгтэй нэр дэвшигчдийн олон шинж чанарыг ойлгоход нэмэр болсон. Тэр дундаа миний нэрлэснээр “олон нийтийн өмнө чөлөөтэй байх” буюу төрөл бүрийн хүмүүстэй харилцах, холбоо тогтоох, үг хэллэг, бэлгэ тэмдэг, биеийн хэлэмж, болон соёлын өвөрмөц арга хэрэгслийг ашиглан улс төрийн байр сууриа илэрхийлэх арга замыг ойлгоход тус болсон юм.

1990-ээд оноос ардчилал дэлгэрч, гадаад байгууллагуудын дэмжлэгтэйгээр улс төр дэх эмэгтэйчүүдийн “чадавхыг бэхжүүлэх” сургалтын төв, сургалт семинар зохион байгуулагдаж эхэллээ. Эдгээр семинарын дийлэнхийг НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Сан (United Nations Development Fund for Women) болон бусад Барууны санхүүжилттэй ТББ-уудын санаачилгаар, шинэ улс төрийн намууд зохион байгуулсан юм. Энд дурдагдсан гол тоглогчдын үйл ажиллагаа, болон Монголчуудын зохион байгуулсан маш олон семинарын үр дүнд эмэгтэйчүүд албан тушаал эрхлэх, үгүйдээ л бэлтгэгдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Мөн эдгээр семинарууд эмэгтэйчүүдэд хэрхэн мэргэжлийн түвшинд гарч ирэх, ярих, илтгэх чадвараа хөгжүүлэх, ялангуяа сонгогчдын анхаарлыг татахад хамгийн чухал үүрэгтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрсдийгөө таниулахад ихээхэн тус болсон нь дамжиггүй.

Гэсэн хэдий ч, дэмжигчдээ байлдан дагуулж, индэр дээрээс уран илтгэж, өөр хоорондоо өрсөлдөхийн сацуу сонгогчдоо ятган сэнхрүүлж буй эмэгтэй нэр дэвшигчийн кампанит ажлыг би ажиглаж байхдаа, эдгээр эмэгтэйчүүд нь чадавх бэхжүүлэх семинар, нэр дэвшигчийн сургалтын

бүтээгдэхүүн төдий биш, тэр бүү хэл Хилари Клинтонь маягийн кампанит ажил зохион байгуулаад зогсохгүй, тэр бүхнээс ч илүү их гүн гүнзгий ур чадвар нөөцтэйг нь анзаарсан юм. Тэдгээр эмэгтэйчүүд олон нийтийн дунд хэрхэн биеэ авч явах талаар социалист улс төрийн хүмүүжлийг орчин үеийн шинэ улс төрийн тогтолцоонд амжилттай хөрвүүлж байв. Тэд нарын ихэнх нь ангийн дарга, залуучуудын бүлгэмийн дарга, урлагийн наадмын аварга гэх мэт нийгмийн идэвх сайтай манлайлагч болж төлөвшсөн байлаа. Олон эмэгтэй намынхаа эрэгтэй нэр дэвшигчдийн сонгуульд ажиллахдаа улс төрийн тогтворгүй байдал бүхий ээдрээт орчинд кампанит ажлыг амжилттай удирдах чадварыг гаргууд эзэмшжээ. Олон улсын сургалт, семинар нь сонгуулийн кампанит ажлын сурах бичгийн агуулгыг ойлгоход тустай боловч, дэлхийн ихэнх газар хэрэгждэг эдгээр онол, дүрэм, журам нь улс төрийн соёлын онцлогоос болоод Монголын нөхцөлд тэр бүр тохирч нийцдэггүй юм.

2007 оны зун болсон семинарыг жишээ болгон авч үзье. Калифорни мужийн амбан захирагч Арнолд Шварценегерийн 2006-2007 оны сонгуулийн кампанит ажлын Стратеги хариуцсан орлогч захирал, Жон Маккэйний 2007-2008 оны ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын Стратеги хариуцсан захирлаар ажиллаж байсан Сара Симмонс гэгч Америк бүсгүй Монгол эмэгтэй нэр дэвшигчдэд кампанит ажлын стратеги заахаар Монголд ирэв. Түүний олон цаг үргэлжилсэн лекцийг дуулгавартай нь аргагүй сонсож буй эмэгтэйчүүд хоорондоо тус лекц онц сонирхолтой боловч, Монголын нөхцөлд тохирохгүй хэмээн ярилцаж байхыг би сонслоо. “Манай нөхцөл байдлыг огт мэдэхгүй байна” хэмээн нэг нь хэлэхэд, бусад нь хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлэх мэт харилцан толгой дохилцоно.

Симмонс сонгуулийн кампанит ажлын төлөвлөгөөгөө яс баримтлах талаар зааварчилж байлаа. Тэрээр дундын хуанли үүсгэж, цагийн менежментэд гол анхаарлаа хандуулж, ажилтнуудаа үүргийг нь сайтар хуваарилж, кампанит ажлын туршид хийж гүйцэтгэх зүйлдээ төсөв тогтоож, яг л анхнаасаа төлөвлөсөн цаг, санхүү, төлөвлөгөөгөө барьж ажиллахыг чухалчлав. Симмонсын энэ арга барил нь удаан хугацаанд туршигдсан, тогтвортой улс төр, эрх зүйн орчинтой улсад бол тохирох байх. Хууль хэрэгжүүлэх соёл бүрэлдэж буй Монголд ажил өөрөөр хэрэгждэг. Маш олон зөрүү, ойлгомжгүй байдал үүснэ. Эрх зүйт ёс бүхий бусад нийгмүүдтэй харьцуулахад, Монголд хууль тогтоомжийг садан төрөл, орон нутгийнхан, болон нүүр тулсан арга хэмжээгээр дамжуулж хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Сонгуулийн хууль, хэрэгжиж буй арга хэрэгсэл нь эдгээрийн нөлөөг бууруулахад чиглэвч тийм ч амар бүтэхгүй. Сара Симмонсын семинарт оролцож буй эмэгтэйчүүдийн дийлэнх нь улс төрийн маш тогтворгүй орчинд хувь хүний авхаалж самбаа, харизм,

болон “олон нийтийн өмнө чөлөөтэй” байх ур чадвар зэрэг нь амин чухал гэдгийг мэдэж байв. Нөгөөтэйгүүр, дүрэм, журмыг ягштал мөрдөх нь үгүйдээ л Монголд дандаа амжилтад хүргээд байдаггүй билээ.

Эмэгтэйчүүд өндөр албан тушаалд эрмэлздэг бас томилогддог ч, Монгол Улс социализм, ардчиллын аль ч үед өөр өөр хэлбэрээр эрчүүд ноёлсон нийгэмтэй байсаар ирсэн юм. Социализмын үед төрөөс эмэгтэйчүүдийг боловсролд дэмжиж, ажиллах хүч хэмээн бэлтгэж байсан хэдий ч удирдах түвшний дийлэнх албан тушаалыг эрчүүд л хашиж байлаа. 1950-аад оны дунд үеэс эхлэн улс төрийн товчоо ур чадвар, туршлагатай эмэгтэйчүүд байгаа боловч удирдлагын түвшинд тэдний оролцоо дутмаг байгааг цохон тэмдэглэж, Монголын Эмэгтэйчүүдийн Хорооны (МЭХ) хяналт дор эмэгтэйчүүдийг өндөр албан тушаалд томилох тухай тогтоол гаргав. МЭХ-ны байр суурь, оролцоо нь эмэгтэйчүүдэд урам зориг өгөхийн сацуу, тэднийг хүйсээр ялгаварлан гадуурхах үзлээс хамгаалах бэлэг тэмдэг болсон байлаа. Харин ардчилал эмэгтэйчүүдэд улам их итгэл найдвар өгсөн ч шинэ тогтолцоо зарим талаар социализмын үеэс ч дор гэмээр эрчүүд хэт зонхилсон нийгэм болж хувирлаа. Социализмын үед эмэгтэйчүүдийг дэмжих тухай гаргаж байсан тогтоол, шийдвэрийг 1990-ээд онд чимээгүйхэн орхигдуулсан төдийгүй шинэ, ардчилсан тогтолцоонд нэр дэвшигчийн хүйсийн квотыг дахин сэргээхэд төсөөлөө ч үгүй бэрхшээлүүд тулгарсан юм. Неолиберал капитализм руу чиглэсэн алхам бүр нь өдөр тутмын амьдралд, ялангуяа баялгийн тэгш бус хуваарилалт, орлогын ялгаа зэргээр дамжуулан жендэрийн тэгш бус байдлыг улам гааруулав¹. Бусад улс орноос ялгаатай нь, сонгуулийн кампанит ажил хаалттай, нэр дэвшигч нь санхүүгээ өөрөө даадаг болж буй нь эрчүүдэд л илүү ээлтэй орчин бүрдүүлжээ. Учир нь капиталист нийгэмд эрчүүд, эмэгтэйчүүдээс хамаагүй илүү эдийн засгийн ашиг орлого хүртдэг. Энэ мэт өөрчлөлт нь эрчүүдийн улс төрд улам бэхжих, эмэгтэйчүүд гадуурхагдахад нөлөөлсөөр ирлээ.

Эрэгтэйчүүд зонхилсон улс төрөөс үүдэлтэй түмэн бэрхшээл байсан хэдий ч, улс төрд өрсөлдөх хүсэлтэй эмэгтэйчүүд үргэлжид байсаар л ирсэн². Эмэгтэйчүүдийн нийгэмшил, ялангуяа социализмын үед олж авсан нийгэмшил нь эмэгтэйчүүд нийгэмд оролцох, цаашлаад

¹ Монгол эмэгтэйчүүд, эрчүүдээсээ илүү боловсрол эзэмшсэн бүлэгт тооцогддог (Schmillen and Weimann-Sandig 2018). Ажиллах хүчний дийлэнхийг (57%) эмэгтэйчүүд бүрдүүлдэг ч, эмэгтэйчүүд голдуу нийт бизнесийн 98 хувийг эзэлдэг жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ажилладаг бөгөөд, тэдгээрийн ДНБ-д оруулах хувь нэмэр нь ердөө 25 хувь байдаг (Монгол дахь Жижиг, дунд бизнесүүд ба, эмэгтэйчүүдийн удирдлаг Жижиг дунд бизнесүүд 2014: 7). Мөн төрийн албаны, хамгийн бага цалинтай албан тушаалууд эмэгтэйчүүд голдуу ажилладаг. Эсрэгээрээ, эрчүүд уул уурхай, барилга, нийтийн тээвэр, арилжаа, банк зэрэг томоохон хэмжээний бизнесүүдэд зонхилдог байна (Begzsuren and Aldar 2014, 24).

² Улс төр судлаач Женнифер Лоулэсс, Ричард Л. Фокс нар (2010) АНУ-ын жишээн дээр эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдөх амбиц багатайгаас болж улс төрийн карьер хөөхөөс татгалздаг хэмээн үзжээ. Маш олон асуудлын дундаас эрчүүд зонхилсон улс төр, эмэгтэйчүүд нийгмийн харилцаанд орж буй байдал зэрэг нь эмэгтэйчүүд улс төрийн амбиц хөөхөөс татгалзах шалтгаан болдог ажээ. Лоулэсс, Фокс нарын судалгаа нь эмэгтэйчүүдийн хувь хүний хувьд хийж буй сонголт дээр төвлөрсөн тул эмэгтэйчүүдийн үйл ажиллагааны цар хүрээ, том бүтцийг хангалттай шинжилж үзээгүй байна.

удирдлагын түвшинд өрсөлдөхөд ихээхэн дөхөм болсон юм. Чухамдаа, надад зарим нэр дэвшигч, горилогчид сонгуульд суудлын төлөө өрсөлдөх буюу нэрээ дэвшүүлэхэд олон нийтэд танигдах, таалагдах шаардлагатай болдог тухай ярьж байлаа. Тэд том танхимд цугласан хүмүүсээс нэр дэвшүүлэх санал гаргах, олны өмнө илтгэх, дагагчид, дэмжигчдээ удирдах, сонгогчидтой уулзах зэрэг олон зүйлд сэтгэл догдолно. Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт байсан ч гэсэн, улс төрд оролцох боломжтой, оролцдог, оролцох чадвартай байх мэдрэмж нь улс төрийн замналаар алхаж буй эмэгтэйчүүдийн улс төрийн гол субьектив шинж чанарын нэг билээ.

Субьектив шинж байдал гэх ойлголтын талаар Шерри Ортнерийн тодорхойлолт хамгийн оновчтой бөгөөд тус нэр томьёоны диалектик талыг илүү онцолдог тул энэхүү судалгааны ажлын зорилгод илүү нийцнэ гэж үзлээ. Субьектив шинж байдал нь “Нийгмийн амьдралын тоглогчдын оюун санааны төлөв байдал ба . . . тус оюун санааны төлөв байдлыг бүрдүүлдэг, хэлбэржүүлдэг, илэрхийлдэг (хэсэгчилсэн байдлаар ч атугай) соёлын хэв маяг юм” (Ortner 2005, 46). “Хүмүүс хорвоо ертөнцөд хүлцэх мөртөө, хорвоо ертөнцөд эргээд хэрхэн ханддаг болохыг ойлгоход нэн шаардлагатай үндсэн зүйл нь субьектив шинж байдал” гэх Ортнерийн санааг Монголын жишээ илүү тодруулж өгдөг. Субьектив шинж байдал нь хэрхэн идэвхжиж байдаг талаар социализмын үед эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагааны жишээгээр харуулахыг хичээлээ.

Олон нийтийн өмнө ил гарсан эмэгтэй нэр дэвшигч бол төрөл бүрийн тэмцэл, субьектив шинж байдлаас үүдэлтэй саадыг даван туулж буй, институцийн болон нийгмийн өөрчлөлтийн үр дүнд тасралтгүй хувирсаар ирсэн гэсэн үг. Эдгээр эмэгтэйн улс төрийн амбиц, олон нийтийн өмнө чөлөөтэй байх ур чадвар нь түүхэнд ямар байсан, одоо ямар байгаа вэ гэх асуултыг заавал асуух шаардлагатай. Тэдний хувьд эргэн тойронд нь буй хүйсээр ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг ад үзэх үзлийг сөрж зогсоход нийгэмшил, үзэл суртал, туршлага нь хэрхэн тусалсан бэ? Тэд хүйсийн/жендэрийн тэгш байдлын талаарх яриа хэллэгийг хэрхэн хэрэглэсэн бэ? Эдгээр асуултад оновчтой хариулт эрэх нь маш чухал. Учир нь эдгээр эмэгтэй нэр дэвшигчид өөр өөр гарал үүсэл, түүх намтартай төдийгүй олонх нь харьцангуй энгийн замналаар замнасан буюу гарал үүслээ дагаж, онцгой давуу эрх эдэлж нэр дэвшигч болчихоогүй юм. Гэвч, эдгээрийн дотроос олон эмэгтэйчүүд социализмын сүүл үеийг биеэрээ туулсан тул үлдэгдэл, өвийг нь 1990-ээд оны ардчилал эхлэх үед ч мэдэрч байлаа. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд социализмын үеэс өвлөгдсөн тэгш байдал, олон нийтийн өмнө чөлөөтэй байх, эмэгтэйчүүдийг дэмжих бодлогын үр дүнг мэдрэх боломж олдсон гэсэн үг. Эдгээр ур чадвар, урам зориг нь ардчиллын цаг үед, неолиберал капиталист нийгэмд хэрэг болж буй нь баглагдсан гэж хэлж болно.

Үл үзэгдэх мэргэжилтнүүд

Социалист нийгмийн үеийн эмэгтэй удирдагчдын үлдээсэн өвийг судлаад би энэ бүлэгт орчин цагийн эмэгтэй нэр дэвшигчдийн улс төрийн субьектив шинж байдал нь өөрсдийгөө өмгөөлөх, эрчүүдийн эрх давамгайлсан социалист нийгэмд өөрсөдөө орон зай бий болгохоор зүтгэсэн олон үе дамнасан хүчин зүтгэлийн үр дүн гэсэн аргумент дэвшүүлэв. Бүр тодруулбал, Монгол эмэгтэйчүүд социализмын үед орон зайгаа бий болгож, эрчүүд давамгайлсан улс төрийн соёлыг өөрчлөхийн тулд удаан мэрийсэн нь тэдний улс төрийн субьектив шинж байдалд чухал нөлөөлсөн төдийгүй социализмын дараа үед ч гэсэн нөлөөтэй хэвээр байгаа гэж үзэж байна³. Монголын Эмэгтэйчүүдийн Хороо (МЭХ 1924-1990) социализмын үед феминист үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байв⁴. Миний үзэж байгаагаар, МЭХ-ны хууль эрх зүйн хувьд болон институцийн хувьд бүтэцлэх гэсэн хүчин чармайлт, эмэгтэйчүүдийг мэргэжлийн хувьд өсөж, дэвших боломжийн бүтээх үзэл санааны төлөөх хүчин чармайлт нь дараа үеийн эмэгтэйчүүд удирдлагын түвшний албан тушаалд хүрэхээр зорих боломж өгчээ. МЭХ социализмын үед эмэгтэйчүүд улс төрийн хувьд идэвхтэй субьект байхад гол үүрэг гүйцэтгэсэн төдийгүй 1990 оноос хойш бэхжиж буй ардчилсан нийгмийн үед эмэгтэй улс төрчдийг төлөвшүүлэхэд чухал талбар байв⁵.

Дээрх саналаараа би барууны либерал феминистүүдийн болон олон улсын байгууллагаас дэвшүүлдэг Монгол эмэгтэйчүүд, жендэрийн улс төрийн талаарх гол хоёр таамаглалыг няцааж байна. Нэгдүгээрт, социализмын үед буюу 1924-1990 оны хооронд идэвхгүй байсан Монгол эмэгтэйчүүд 1990-ээд оноос хойш ардчилал, либерал феминизм нэвтэрснээс хойш улс төрийн идэвхтэй болсон гэх таамаглал. Хоёрдугаарт, социализмын үед эмэгтэйчүүдийн байгууллага социалист төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх төдий институц байсан ба эмэгтэйчүүдийн төлөө онцлом үр нөлөө үзүүлээгүй гэх таамаглал. Энэ бүлэгт эдгээр хоёр таамаглалыг няцааж, социализмын үед МЭХ-ны ажил нь эмэгтэйчүүдийн улс төрийн субьектив шинж байдлыг тодорхойлох, эмэгтэйчүүдийг нийгэм, улс төрийн хувьд маш идэвхтэй байхад чиглүүлсэн талаар өгүүлнэ. Эмэгтэйчүүдийг дэмжихийн тулд,

³ Миний ном Монгол эмэгтэйчүүдийн эртний түүхэн үүргийг хамраагүй болно. Диаз (2019) социализмын өмнөх эмэгтэй манлайлагчдын талаар тоймлосон.

⁴ Эмэгтэйчүүдийн байгууллага нэрээ маш олон удаа өөрчилсөн юм. 1924-1925 онд, дараа нь 1932-1947 онд Эмэгтэйчүүдийн тасаг нэртэй байсан бол, 1925-1935 онд Эмэгтэйчүүдийн хэлтэс, 1947-1958 оны хооронд Монголын Эмэгтэйчүүдийн Эвлэл, 1958-1990 он хүртэл Монголын Эмэгтэйчүүдийн Хороо нэртэй байлаа. Эдгээр нэрс тус бүрдээ байгууллагын зарцуулж байсан нөөц, эрх мэдлийн ялгааг төдийгүй албан ёсны институционал байдлыг илэрхийлнэ.

⁵ 1990-ээд онд ардчиллын үйл явц эхэлснээр хэд хэдэн, бие даасан эмэгтэйчүүдийн байгууллага бий болсон юм. МЭХ мөн адил шинэчлэгдсэн бөгөөд зах зээлийн эдийн засгийн үед бусад байгууллагуудтай хамтран эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллаж эхэлсэн юм.

социализмын үед ихэнх байгууллагын удирдлагын түвшин, тэр бүү хэл үндэсний хууль тогтоох байгууллагад 30 хувийн төлөөлөл байхыг шаардаж байсан дүрэм журам 1990 онд социализмын төгсгөлтэй хамт орхигдуулсан ч эмэгтэйчүүдийн эрмэлзэл унтарсангүй. Монголын залуу үе болон барууны феминистүүд социалист үеийн эмэгтэйчүүдийн байгууллагын ахиц дэвшлийг хоосон суртал ухуулга, эсвэл өнгөрсөн юм гэж үзэх хандлагатай байлаа. Зарим нь ардчилал социалист нийгэмтэй харьцуулахад илүү жендэрийн тэгш байдлыг хангадаг нийгэм гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл, социалист эмэгтэйчүүдийн хүрсэн ололт амжилтыг олон улсын түвшинд бүү хэл дотооддоо ч үл ойшоож байсан гэсэн үг.

Зүүн Европын угсаатан зүйч Кристен Годси (2019) барууны либерал феминистүүд нь феминизм гагцхүү төрөөс гадуур оршин тогтнох боломжтой тул социалист эмэгтэйчүүдийн байгууллага төрийнхөө гар хөл төдий гэж үзэж энэхүү байгууллагад эргэлздэг талаар тэмдэглэсэн байдаг (Funk ба Mueller 1993 бүтээлийг тус хандлагын жишээ болгон үзнэ үү). Барууны либерал феминистүүд яагаад либерал ертөнцийн гадна талд эмэгтэйчүүдийн гаргасан амжилтыг үл ойшоодог шалтгаан нь онолын үл ойлголцол, хоорондоо нийцэхгүй эсэргүүцэл зэргээс үүдэлтэй болох талаар антропологич Саба Махмуд (2005) тайлбарладаг. Тэрээр угсаатан зүйн бүтээлдээ, Исламын сүм хийдийн хөдөлгөөнд Египет эмэгтэйчүүд маш үр дүнтэй оролцдог болохыг харуулжээ. Мөн дэмжлэг, хөтөлбөр нь хүчний харилцааны гадна талд оршдог гэж таамагладаг барууны ойлголтыг хүчний харилцааны дунд оршин байж эмэгтэйчүүд эрх мэдэл олж авдаг гэх агуулгаар тайлбарласан юм. Годси, (2019), Махмуд (2004) нар үр дүнг ардчилсан бус тогтолцооноос эрэлхийлсэн бол, Жоун Скотт үр дүнг барууны ардчилсан тогтолцооноос хайсан. Тэрээр хувь хүн чөлөөт хүсэл зоригоо илэрхийлэх нь үр дүнг илэрхийлэхгүй (1991, 793), харин аливаа субъектийн “төлөөлөгдөх эрх нь тэдэнд олгосон нөхцөл байдал, статусаар бүрэлддэг” гэж үзэв. Тиймээс Скотт хүчний харилцаа бол субъект болох, үр дүнд хүрэхийн аль алиных нь урьдач нөхцөл гэжээ. “Субъект болох” гэдгийг Скотт “хүчний харилцаанд тодорхой байр суурь эзлэх (эр, эм, багш, сурагч, ажилчин, ажил олгогч гэх мэт), тэр байр сууриар дамжуулан үр дүнд хүрэхэд чиглэсэн ажиллах ёстой шинж чанар, үүрэг хариуцлагын харилцан хамаарал юм” хэмээн тайлбарлажээ.

Эдгээр судлаачдын дэвшүүлсэн санаа нь Европ, Америк төвтэй барууныхан Монгол мэт газрыг хэрхэн үзэл санааны хувьд гажуудсан гэмээр өнцгөөс хардаг гэдгийг ойлгоход тусалдаг. Европ, Америк төвтэй барууныхны төсөөллөөр, хүйтэн дайны сүүл, 1990-ээд оны үед Монгол эмэгтэйчүүд эдлэх ямар нэг улс төрийн эрхтэй байсан ч гэсэн, иргэнийхээ хувьд, жендэрийн хувьд эрхээ хэрэгжүүлэх ойлголт дутмаг байжээ. Социализмын төгсгөлөөс хойш Монголд эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагад

ажилладаг гадаадын мэргэжилтэн, ялангуяа улс орны талаар ойлголт багатайнууд нь Монгол эмэгтэйчүүдийн гаргасан амжилт, ахиц дэвшлийг гагцхүү гадна талаас олгох сургалт, үзүүлэх нөлөөгөөр тайлбарлаж, уугуул иргэдийн амжилтыг үл ойшоох хандлагатай байдаг талаар хэд хэдэн Монгол хүн надад аминчлан ярьж байлаа. Социализм, дорно дахиныг дорд үзэх үзэл, колоничлогч хандлага нь феминизмийн талаар буруу ойлголтыг гааруулж, Европ, Америкаас гаралтай зарим эрдэмтдийн судалгааны бүтээлүүдэд дурдагдсан социалист нийгмийн жендэрийн улс төрийн бүтээсэн үр дүнг үндэслэл муутай болгож байна.

Антропологич Сюзан Гал, Гэйл Клигман нар (2000) социалист феминизмийн эсрэг барууныхны хэт өрөөсгөл хандлагыг илүү тодруулсан юм. Тэд “дорнын болон өрнийн ажиглагчид социалист нийгмийн дүр төрх, бодит байдлын хоорондын ялгааг, хэлсэн зүйлс, хийсэн үйлдэл, туулсан туршлагыг нь хүртэл үндэслэл муутай, хэт зөрүүтэй ойлгож байна” (2000, 6) гэв. Капиталист нийгэмд үзэл санаа, бодит байдлын хоорондын ялгаа арилаагүй боловч олон нийтийн олон ургалч дуу хоолой, капиталист нийгмийн нийтийг хамарсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг нь тус зөрүүг бүрхэгдүүлдэг. Эсрэгээрээ социализмын үед капиталист нийгэмтэй харьцуулахад хүлээлт, бодит байдал хоорондын орон зайг дүүргэх олон ургалч дуу хоолой байхгүй тул аливаа үл холбогдсон байдал хурц санагдах нь дамжиггүй (2000, 6).

Би уран яриа, бодит байдлын хоорондын ялгааг тэгш байдлын төлөөх эмэгтэйчүүдийн хүсэл тэмүүллийн үзэл санааны орон зай гэж үзэж байна. Энэ нь идеалист санагдаж магадгүй. Гэсэн хэдий ч, барууны ойлголтоор буюу, тийм ч урам зоригтой бус ертөнцөд, тухайлбал, феминист түүхч Жоан Скотт (1996) хүйсийн тэгш байдал, эсвэл эмэгтэйчүүдийг дэмжих хийсвэр зарчим нь бодит амьдралын тусгал байх албагүй, бодит байдлаас илүү төлөөлөх учиртай гэжээ. Тэгш эрхийн хийсвэр зарчмыг хэрэгжүүлснээр “улс төрийн ямар нэг үзэл санаанаас гадна орших, улмаар эрх мэдлийг урвуулан ашиглах санаархлыг хянах боломжтой” болно. Түүхийн тодорхой хязгаарлагдмал нөхцөл болон мөнхийн нийтлэг үзэл санааны хоорондын зөрчил шийдвэрлэгдэх боломжгүй; учир нь энэ нь ёс суртахууны болон бодит хүчний талаарх ойлголт юм (Скотт 1996, 165). Зарчмын үзэл санаа нь “аливаа ойлголтын мөн чанарыг эрэлхийлэх хийсвэрлэл болон тус эрэлхийллийг хязгаарлаж байдаг түүхийн, институцийн болон улс төрийн бодит байдлын хооронд ёс суртахууны орон зайг бүрдүүлж байдаг” (1996, 177).

Скоттын дэвшүүлсэн санааг Монголын нөхцөлд буулган хэрэглэх боломжтой. Учир нь хийсвэр зарчим нь Монгол эмэгтэйчүүдэд МАХН-ын эрэгтэй удирдлагатайгаа зөвшилцөх боломжийг олгосон юм. Монгол эмэгтэйчүүдийн хэрэгцээ, байр суурийг илүү өргөн

хүрээнд ойлгуулахын тулд, эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэсэн бодлого боловсруулах, төрөөс үүдэлтэй асуудлыг шийдвэрлэх шинэлэг арга замыг эрэлхийлэх гэх мэт ёс зүйн орон зайг бий болгоход хийсвэр зарчим чухал байжээ. Эмэгтэйчүүдийг дэмжихэд төрөөс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь үзэл суртлын болон практик туршлагын аль алинд нь нэвт шингэсэн байдаг. Иргэдээ нөлөөндөө байлгахын тулд социалист төр тэднийг бодлогодоо оролцуулж, бусад аль ч газартай харьцуулахад илүү дээр гэж батлахыг эрмэлзэж байдаг. Тус эрмэлзэл нь эмэгтэйчүүдийн ололт амжилт, байр суурь нь төрийн бүтэц, нөөц, үнэ цэний тогтолцоонд хэрхэн тусгагдаж буйд ч мөн хамаарна.

Хүйсийн тэгш байдлын зарчмын үзэл санаа социализмын задралыг ч давж гарсан. Ардчилал өрнөх үед улс орны хөгжлийн шинэ чиг хандлагад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, орчин үеийн олон төслийг удирдах эмэгтэйчүүдийн чадвар зэрэг нь тэдний өөртөө итгэх итгэл, амбицыг огцом нэмэгдүүллээ. Эмэгтэйчүүд иргэний нийгэм гэх маш чухал, цоо шинэ салбарыг бий болгож, бэхжүүлснээр ардчиллыг бэхжүүлсэн юм. Энэ нь социалист төр дөнгөж төвхнөж байх үед эмэгтэйчүүдийн байгууллага ажлыг санаачилж хийх, бусад хэрэгцээг урьдчилан харж шийдвэрлэж шинэ нийгэмдээ чухал үүрэг гүйцэтгэхийг санагдуулам. Монголчууд социалист түүхэн уламжлалаасаа татгалзаж шинэ нийгэм байгуулах эрмэлзэлтэйгээс гадна, социализмаас ардчилалд шилжих шилжилт нь өнгөрсөн үеэс эрс тасрах үндэс болсон гэж үздэг ч, үнэн хэрэгтээ ардчиллын үйл явц нь социалист төрийн уламжлалаас улбаатай юм (Buyandelgeriyu 2008). Ардчиллын үйл явцаас ч өмнө Монгол эмэгтэйчүүдийн гаргасан үр дүн, хүрсэн ололт амжилтыг Барууныхан үгүйсгэдэг (эсвэл либерал феминизмтэй холбон тайлбарладаг) байдлыг илчлэх нь антропологийн болон эмэгтэйчүүдийн судалгааг үргэлжлүүлэхэд амин чухал зүйл юм.

Барууны либерал феминистүүд хийсвэр зарчмыг ч тэр, төрийн оролцоог ч тэр үл тоомсорлох хандлагатай байдаг. Тэгвэл тэд “1961 онд, ерөнхийлөгч Кеннедигийн үед Хөдөлмөрийн яамны Эмэгтэйчүүдийн товчооны дарга, Эстер Питерсоны тушаалаар Эмэгтэйчүүдийн статусыг хамгаалах хороо байгуулагдсан нь” 1960-аад онд АНУ-ын Засгийн газраас тэгш байдлын төлөөх албан ёсны амлалтаа биелүүлснийг хэмжих хамгийн чухал нотолгоо байсныг мартсан байдаг (Scott 1981, 28). 1963 он гэхэд 50 мужид тус хороо [төрөөс] байгуулагджээ. Цаашлаад, хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг, тэгш байдал албан ёсоор хангагдсан орчинд илүү радикал феминист хөдөлгөөнүүд бий болов (1981, 28). Тус хөдөлгөөн социалист/коммунист улс орнуудад байсан хөдөлгөөнүүдээс ялгаатай байсан нь олон чиглэлд хөгжиж, хоорондоо ялгаатай урсгалууд бие даан хөгжих болсон юм. Гэсэн хэдий ч, АНУ-ын феминист хөдөлгөөнүүдийн бүтээсэн амжилт 1960-

аад онд АНУ-ын засгийн газраас Эмэгтэйчүүдийн статусыг хамгаалах хороо байгуулагдсанаас үүдэлтэй гэдгээ мартсан байдаг⁶.

Кристен Годси (2019) социалист эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь АНУ-д Эмэгтэйчүүдийн Статусыг Хамгаалах Хороо байгуулагдахад нөлөөлсөн гэж үзжээ. Тэр бүү хэл АНУ-ын тус хороо нь социалист улс орнуудын үндэсний эмэгтэйчүүдийн байгууллагын феминист хөдөлгөөнүүд илүү зохион байгуулалтад орж, олон улсын феминист хөдөлгөөнийг бий болгосны хариу үр дүн юм гэж үзэв. Социалист эмэгтэйчүүдийн байгууллага эмэгтэйчүүдийн асуудлыг төр, эдийн засаг, колоничлол, ангийн давхарга, арьс өнгө зэрэг олон асуудлаас зааг ялгаагүй, тусдаа асуудал огт үгүй гэж үзэж байлаа. Учир нь социалист феминизм нь либерал феминизмээс хамаагүй радикал бөгөөд, эмэгтэйчүүд өөрсдийнхөө үүргийг нийгмийн бусад асуудлаар эрэгтэйчүүдтэй хамтран ажиллах хэмээн харж байсан ч, АНУ үүнийг хэт аюултай гэж үзэв. Тиймээс ерөнхийлөгчийн албанаас АНУ-д эмэгтэйчүүдийн хороо байгуулах нь социалист үзэл суртал хэт түгэхээс урьдчилан сэргийлэх оролдлого байлаа (Годси 2019). АНУ-д эмэгтэйчүүдийн хороо байгуулагдсан нь түүхэн үүднээс социалист феминист хөдөлгөөний нөлөөлөл байсан нь Скоттын (2009, 47) дэвшүүлсэн аливаа субъект хүчний харилцаанаас үүдэлтэй гэх саналыг бататгаж байна. Либерал феминистүүд болон түүнийг баримтлагчид аливаа ололт амжилтыг төртэй холбохгүй, гагцхүү өөрсдийн хүчин чармайлтын үр дүн гэж үзэх төдийгүй аливаа үр дүнг бий болгож буй нөлөөллийг үл ойшоох хандлагатай байдаг аж. Харин эсрэгээрээ социалист эмэгтэйчүүдийн феминист хөдөлгөөний талаар ярилцахад төрийн эрх мэдлийг л онцлохоос биш социалист эмэгтэйчүүдийн хүчин чармайлтыг үл ойшооно. Либерал феминистүүд нь капитализм, эцгийн эрхт ёс, хүйтэн дайны улс төр, болон бусад хоорондоо адилгүй эрх мэдлийн субъект гэдгийг хүлээн зөвшөөрөх аваас либерал феминистүүдийг бүхэлд нь буруутгах аргагүй билээ.

МЭХ-г болон өмнөх ижил төрлийн байгууллагын үйл ажиллагааг үргэлжлүүлэх, өргөжүүлэх үйл явцад төрийн эрэгтэй удирдагчдын өмнө эмэгтэйчүүд нийгэмд, болон улс төрд тод төлөөлөгч болон гарч ирдэг. Социалист хувьсгал ялж, түүнээс үүдэх хямралыг даван туулсан үед удирдагчид эмэгтэйчүүдийг улс төрийн орон зайгаас шахах, хавчих сонирхолтой байсан ч өөрсдийн орон зайг бий болгож чадсанаараа Монгол эмэгтэйчүүд өвөрмөц жишээ болсон юм. Бусад улс оронд хувьсгал, дайн гэх мэт томоохон үйл явдлын дараа эмэгтэйчүүдийн нөхцөл байдал ухарч, улам хүндэрч байсан бол Монгол эмэгтэйчүүд ижил төрлийн үйл явдлын дараа улс төр, нийгмийн амьдралд өөрсдийн

⁶ Жоун Скотт надад энэхүү ухаарлыг хайрласан талархаж байна (2015 оны 1-р сарын 19, хувийн харилцан яриа).

гүйцэтгэх үүргийг хадгалах, лавшруулах боломжтой байсаар иржээ⁷. Энэ нь улс орны өөрчлөгдөж буй зорилгод эмэгтэйчүүд өөрсдийнхөө онцлогийг нийцүүлж, үндэсний хөгжилтэй холбоотой олон асуудалд хариуцлага үүрч, эмэгтэйчүүдийн аливаа санаачилгыг татан оролцуулах гэх мэт МЭХ-ны хүчин чармайлтын үр дүн юм. Социалист эмэгтэйчүүдийн байгууллага гэх үндэстэн дамнасан том сүлжээний нэг хэсэг байх нь эмэгтэйчүүдийн улс төрийн зорилгыг тодорхойлох, дотоодын болон олон улсад нөлөө үзүүлэх зэрэг боломжийг олгож байсан.

Социализмаас өмнөх үеийн Монгол эмэгтэйчүүд (1921 оноос өмнө)

Монгол эмэгтэй гэж хэн бэ гэвэл гарамгай дайчин гүнж, бүрэн эрхт хатад (Weatherford 2011; Sarantuya 2012; Shuudertsetseg 2011), де факто эрх баригчид, өмчлөх эрх бүхий чөлөөт язгууртан эмэгтэйчүүд (Humphrey 1993) зэрэг нийтлэг дүр төрх давамгайлж байна⁸. Социализм ноёрхож байх үед төдийлөн мэддэггүй байсан эдгээр дүр төрх, тэр бүү хэл зарим түүхэн бодит эмэгтэйн баатарлаг төрхийг Монголчууд социализм дуусаж, ардчиллын үйл явц эхэлснээр л мэддэг болсон. Нөгөөтээгүүр, социализмын турш өмнөх үеийн эмэгтэйчүүдийг феодалын нийгмийн мөлжлөгийн золиос, нийгмийн давхаргын хамгийн доод хэсэгт үлдсэн, боловсролгүй, хоцрогдсон анги гэж үзэж байлаа⁹. Социализмын үед хэвлэгдсэн зарим гадаад хэвлэлд эдгээр нь бүхэлдээ худал биш боловч социалист нийгмийн үеийн үзэл суртлын илрэл юм гэдгийг өгүүлдэг. Тухайлбал, Виллиам Б. Баллис, Роберт А. Рупен (1956) нар социализмаас өмнөх үеийн Монголд эмэгтэйчүүд ядахдаа гэр бүлийнхээ түвшинд эдийн засгийн болон шийдвэр гаргах том эрх мэдэлтэй байсан гэжээ. Улс даяар эмэгтэйчүүд морь унах эрхтэй бөгөөд, зарим газар гэрлэсэн, гэрлээгүйгээс үл шалтгаалан бэлгийн эрх чөлөөтэй байсан төдийгүй, эцэг эх нь гэр бүл болоогүй охиныхоо хүүхдийг халуунаар угтан авдаг байв. Гэвч эмэгтэйчүүдийн энэхүү чадвартай бас чөлөөт байдал нь эрчүүдтэй тэгш байдлын үзүүлэлт биш гэдгийг Баллис, Рупен (1956, 236) нар тэмдэглэжээ.

Социализмаас өмнөх үеийн, ялангуяа Чин улсын (1691-1911) эрхшээлд байх үеийн Монгол эмэгтэйчүүдийн талаарх судалгаа бага байдаг. Энэ үед эрчүүдийг илүүд үздэг Буддизм (Ламаизм) голлох

⁷ Хямралын үед эмэгтэйчүүдийг дайчлах нь хямралын дараа эмэгтэйчүүд сайн үр дүнд хүрдэггүй талаарх судалгааны ажлын жишээг Good 1999, болон АНУ-д The Real Rose Riveter аман түүхийн төсөлд Дэлхийн хоёрдугаар дайны үед эмэгтэйчүүдийн оруулсан хувь нэмрийн талаарх жишээг үзэж болно. <https://rosie.dlib.nyu.edu/about/> [2020 оны 12-р сарын 13-нд үзсэн]. Саяхны жишээ дурдвал Майкл Нап, Анжа Флак, Эркин Аябога (2016) нар Сирийн хойд хэсэгт ардчилсан конфедерализм, жендэрийн тэгш байдалд төвлөрөн хувьсгалын болон шинэ улс төрийн тогтолцоонд эмэгтэйчүүдийн үүргийг судалжээ.

⁸ 2000-аад оноос хойш түүхэн эмэгтэйчүүдийн талаар бичих явдал эмэгтэй зохиолчдын дунд түгээмэл байна.

⁹ Эдгээр үзэл суртлын дүр төрх уран зохиол, урлаг, ялангуяа кино театр зэрэгт ихээр харагдах боловч, судалгааны ажилд маш ховор тохиолдоно.

шашин байлаа. Чин улсын үеийн архивын материалд эмэгтэйчүүд маш бага дурдагдсан байдаг нь тэдний талаарх хууль ёсны гомдол, тэдгээрийг хэрхэн шийтгэсэн материалуудаар л хязгаарлагдана (Karlonski 2014). 1911 онд Чин гүрэн задарснаас 1921 онд ардын хувьсгал ялах хүртэлх хугацаанд Монгол эмэгтэйчүүдийн нөхцөл байдал огт сайжраагүй. Хууль тогтоомжид эмэгтэйчүүдтэй холбоотой заалт нь зөвхөн бусдын эрхийг хангахын тулд тэдний эрхийг хязгаарлах, хориглох төдий зохицуулалтууд л байх аж (Karlonski 2014, 80). Тухайлбал, лам нарын зөв зан үйлийг хангахын тулд, охид, эмэгтэйчүүд Нийслэл хүрээний сүм, хийдийн хүрээнд амьдрахыг хориглоно, гэх мэт (2014, 80)¹⁰.

Эмэгтэйчүүд бусад бүх газарт амьдрах эрхтэй байсан. Хориглосон сүм, хийдийн ойролцоо “Наймаа хот” зэрэг хүн ам шигүү суурьшсан, хөл хөдөлгөөн ихтэй, Хятад, Орос, тэр бүү хэл зарим Америк (Tsolmon 1995) худалдаачдад зориулсан зугаа цэнгэл, үйлчилгээ бүхий газар ч бас амьдардаг байлаа. Тус хот нь элитүүд, урчууд, худалдаачид болон эмэгтэйчүүд цай ууж, хоол идэнгээ улс төр ярьж, шүлэг уншиж, элдэв үзүүлбэр үзэхээр цуглардаг олон нийтийн орон зай байсан юм. Гэвч, энэ нь Монголын хүн амын өчүүхэн хэсэг байсан бөгөөд, 20-р зууны үед сая хүрэхгүй нийт хүн амын дийлэнх хэсэг нь нүүдэлчид хэвээр байлаа.

Эдгээр төвөөс гадна, нүүдэлчин Монголд хүн амын суурьшил сийрэг байх тул олон хүн цуглах боломж зах зээл, сүм хийдийн хашаанд (1930-аад онд сүм хийдүүдийг нураахаас өмнө Монгол 750 орчим сүм хийдтэй байлаа), эсвэл баяр наадмын талбай л голцуу байв (Karlonski 2014). Эдгээр цугларалт, арга хэмжээнд эмэгтэйчүүд оролцох эрхтэй байсан хэдий ч малчин эмэгтэйчүүдийн хувьд малаа хариулах, хүүхдээ харах, настнаа асрахын хажуугаар эдгээр цугларалтад очих нь бараг л боломжгүй зүйл байлаа.

Ерөнхийдөө, 13-р зуунаас 19-р зуун хүртэлх хугацааны ихэнх үед нь Монголын газар нутгийн дийлэнх хэсэгт эцгийн эрхт, эцгээ хүрээлсэн, эцгээр нь баримжаалсан соёлтой байсан нь үнэн билээ. Хэдийгээр заримдаа хүүхдийнхээ романтик сонирхлыг харгалзаж үзэх боловч, гэрлэлтийг ихэнх тохиолдолд эцэг эх нь л шийддэг байлаа. Бодит ч бай, бэлгэдлийн ч бай богтлох ёс ч өргөн дэлгэрчээ. Энгийн ард иргэд нэг л эхнэр авах ёстой, харин ихэс, дээдэс олон эхнэр авах эрхтэй, заримдаа бүр үүрэгтэй байлаа. Нүүдлийн нутаг дэвсгэрт хүмүүс амьдралын хэв маяг, хөдөлмөрийн хуваарь, биеийн онцлогтой холбоотойгоор жендэрийн харилцаа нь зохицуулагдана¹¹. Эмэгтэйчүүд гол төлөв гэрийн ажил хийж, эрчүүд худалдаа, аялал, улирлын чанартай нүүдэл зэргийг

¹⁰ Карлонски 2014, Урангуа Баярсайхан 2004 нараас эш татав.

¹¹ Тухайлбал, эмэгтэйчүүд гэрийн хойморт удаан байхыг цээрлэдэг бөгөөд хоймор нь гэрийн эрчүүд болон зочлод зориулагдсан. Түүнчлэн, гэр эрчүүдийн (баруун) болон эмэгтэйчүүдийн (зүүн) жигүүрт хуваагддаг нь жендэрийн үүрэг хариуцлагатай холбоотой юм. Эмэгтэйчүүд илүү өрхийн ажил хариуцах бөгөөд эрэгтэйчүүд олж ирэх, аялах, худалдаа наймаа хийх ажлыг хариуцдаг байв.

хариуцаж, нийгмийн харилцаанд илүү оролцоно.

Эмэгтэйчүүдийн нөлөө нь бүс нутаг, гэр бүлийнх нь эдийн засгийн байдал, садан төрөлтэйгөө харилцах харилцаа зэргээс хамааран янз бүр байна. Гэвч ерөнхийдөө эмэгтэйчүүд эрх мэдэл биш юмаа гэхэд гэхэд хүүхдүүдээрээ, хөвгүүдээрээ, төрлөөрөө дамжуулан нөлөөлж өрхийн эдийн засгаа хянах бололцоотой байлаа. Харин хувьсгалаас өмнөх үед эмэгтэйчүүдийн статусын талаар шарын шашин, эцгийн эрхт ёс, гэрлэлт, ураг төрлийн харилцаа зэрэгт ихээхэн ээдрээтэй үе байсан юм.

Биеэ даасан хэлтэстэй болсон нь (1924-32)

1921 оны социалист хувьсгалаар Монгол Улс аажмаар Зөвлөлтийн нөлөөнд орж, Монгол Улс Зөвлөлт Холбоот Улсын дараа хоёр дахь социалист орон болсон юм. Монголын шинэ засгийн газар эмэгтэйчүүдийг хувьсгалд татан оролцуулах, албан боловсролд хамруулах, улс төрийн сургалтын хөтөлбөрүүдийг эхлүүлэх ажлыг яаралтай зохион байгуулжээ. Засгийн газар ард иргэдийг өмнөх гурван зуун жилийн турш улс орны оюун санааны болон нийгэм, эдийн засгийн амьдралд ноёрхож байсан Буддист нөлөөнөөс салгахыг чармайж байлаа (Kaplonski 2014, 79-80).

Засгийн газар эмэгтэйчүүдийг дэмжиж буй энэхүү үзэгдлийн цаана, маш идэвхтэй, цөөн хэдэн эмэгтэй Европ, Орос, болон Азийн зарим хэсэгт өрнөж байсан феминист хөдөлгөөнүүдэд оролцож байсны нөлөө давхар байв. Тэд 1924 онд Монгол Ардын Хувьсгалт Намын (МАХН) гишүүн болсон бөгөөд 1921 онд болсон Гуравдугаар Интернационалын хоёр дахь уулзалтад оролцож, Коминтерны эмэгтэйчүүдийн тасгийн дарга Клара Цеткин тэй уулзаж, санал солилцож явсан юм¹². Мөн Монгол эмэгтэйчүүд Коминтернд ажиллаж, олон улсын өөрчлөлтийн талаар мэдээлж байсан Зөвлөлтийн феминист идэвхтэн Г.Д.Каспароватай захидлын харилцаатай байлаа (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol.1:5).

Хамгийн анхны эмэгтэйчүүдийн байгууллага нь 1924 оны 3-р сарын 19-ний өдөр Эмэгтэйчүүдийн Тасаг нэртэйгээр байгуулагдаж МАХН-ын Төв хорооны Суртал ухуулгын хэлтэст харьяалагдаж байлаа. “Тус байгууллага эмэгтэйчүүдийн боловсрол, улс төрийн оролцоо, эмэгтэйчүүдийн ерөнхий боловсрол болон уншиж, бичих чадварыг дэмжих, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэнд, халамжийн асуудлыг хариуцах үүрэгтэй” байсан талаар Жудит Нордби тэмдэглэжээ (1988, 97).

Хэдхэн сарын дараа буюу 1924 оны 11-р сарын 26-ны өдөр анхны

¹² Эдгээр эмэгтэйчүүдийн нэг нь Цэвээн Жамсраногийн (Монголын Эрдэмтдийн Хорооны анхны дарга) эхнэр (1926 оноос), Буриад угсаатан Бадамжав Седенова байсан юм (Rupen 1956, 136; Gerelsuren and Erdenechimeg 2014,5).

Үндсэн хууль батлагдсанаар эрэгтэй эмэгтэй хүмүүс ижил тэгш эрх эдлэх (Нэгдүгээр хэсэг, 11-р зүйл) төдийгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонгох эрх, болон Улсын Их, Бага Хурал гэх мэт төлөөллийн байгууллагад сонгогдох эрх (Хоёрдугаар хэсэг, 4-р бүлэг, 34-р зүйл) ижил тэгш хангагдсан юм. Эмэгтэйчүүдийн байгууллага байгуулагдсан, Үндсэн хуулиар тэгш эрхийн зарчим баталгаажсан зэрэг нь эмэгтэйчүүд төрийн бүтцийн дотор талаас болон үзэл суртлын үүднээс бодит нөлөө үзүүлэх, улс төрийн эрхээ эдлэх бололцоог эмэгтэйчүүдэд олгосон хоёр чухал ололт болсон билээ.

1924 онд байгуулагдсан тус тасгийн анхдагч зорилго нь эмэгтэйчүүдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, бичиг үсэг сургахаас гадна нам дотор албан тушаал ахиулах, хөдөлмөрийн хүч, төрийн алба, зэвсэгт хүчин, үйлдвэрчний эвлэлд тэдний тоог нэмэгдүүлэх, биеэ үнэлэх явдлыг устгах, эрүүл мэнд, эрүүл ахуйг хангах, нярайн асаргаа, шим тэжээл, өрхийн эдийн засаг гэх мэт ойлголтыг олгох гэх мэт олон зорилготой байсан юм. МАХН эмэгтэйчүүдийн улс төрийн идэвхэд анхаарах нь зарим талаар Зөвлөлтөөс гарч буй чиг хандлагатай холбоотой байлаа. 1917 оны большевик хувьсгалаас ч өмнө Оросын Коммунист нам эмэгтэйчүүдийн дэмжлэгийг өөрсдөдөө татах, тэдний дэмжлэгийг хувьсгалыг эсэргүүцэгчдэд алдахгүй байх зорилгоор Эмэгтэйчүүдийн Тасгийг байгуулж байжээ (Wood 1997, 30).

Зөвлөлт Холбоот Улсын нэгэн адил Монголын Эмэгтэйчүүдийн Тасаг төрийн суртал ухуулгын чиг үүрэг төдийхнөөс илүү бодитой ажиллах эрмэлзэлтэй байлаа. Тус тасаг улс орон даяар эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулахын сацуу олон улсын арга хэмжээнд оролцохыг зорьж байв. “Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг 1924 оноос эхлэн тэмдэглэсэн бөгөөд төлөөлөгчид Москвад очих болжээ. 1927 онд Намын гишүүн гурван эмэгтэй Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэхээр Зөвлөлт Холбоот Улсад очиж . . . хоолны газар, хүүхдийн асрамжийн газар гэх мэт эмэгтэйчүүдэд зориулсан үйлдвэрийн байгууламжаар зочлов” (Nordby 1988, 99). Буцаж ирмэгцээ эмэгтэйчүүдийн асуудлыг Намын хөтөлбөрт тусгах талаар намын удирдлагуудаа шахаж эхлэх нь тэр. Улмаар, Эмэгтэйчүүдийн Тасаг эмэгтэйчүүдийн нөхцөл, байдлыг сайжруулах зорилгоор элдэв төлөвлөгөө, шийдэл боловсруулж, МАХН-аас зөвшөөрөл, санхүүжилт, бусад дэмжлэг хүсэж, тэдэнд чиглэсэн үйл ажиллагаагаа ихээхэн өргөжүүлэх болсон юм.

Байгууллагын чиг үүрэг зарим талаар тодорхойгүй байсан тул МАХН болон Эмэгтэйчүүдийн Тасгийн хоорондын харилцаа дандаа хялбар байсангүй. Тухайлбал, Эмэгтэйчүүдийн Тасгийн анхны дарга Дамдины Пагмадулам (1924-25), Баруун Европт боловсрол эзэмшсэн феминист үзэлтэн бөгөөд богтлох ёсоор гэрлэх, биеэ үнэлэлт, эмэгтэй хүн намын

гишүүн байх зэрэг чухал асуудлаар илэн далангүй ярьдаг байжээ. Тэрээр ганц жилийн дотор удирдлагын албан тушаалыг орхих болсон юм¹³. Өмнө нь танилцуулсан эмэгтэйчүүдийн тасгийн дараагийн дарга Сүхбаатарын Янжмаа (1925-27) ч мөн адил радикал үзэлтэн байсан. Гэвч хувьсгалын удирдагч Дамдины Сүхбаатарын бэлэвсэн эхнэр тул тэрээр албан тушаалаасаа тийм ч амархан буусангүй.

Энэ бүлгийн эхэн хэсэгт дурдсанчлан 1925 онд Янжмаа Суртал Ухуулгын дэргэд байсан Эмэгтэйчүүдийн Тасгийг өөрийн гэсэн төсөв, орон тоотой бие даасан байгууллага болгосон юм. Тэгсэн ч гэсэн Янжмаа болон бусад эмэгтэйчүүдийн бий болгосон өөрчлөлт нь шинэ, хүссэнээ хийхэд хэцүүхэн, байгууллага нь ч жижиг байлаа. Эхэн үедээ эмэгтэйчүүд намд элсэх нь маш бага буюу 1924 онд нам ердөө 24 эмэгтэй гишүүнтэй байсан бол 1928 он гэхэд нийт 11400 орчим намын гишүүнээс 1000 гаруйг нь эмэгтэйчүүд эзэлж байв (Nordby 1988, 97-99, 185). Улс даяар зохион байгуулсан түр сургуульд 1924 онд ердөө 20 эмэгтэй хамрагдаж байсан бол 1931 он гэхэд 2000 гаруй болж нэмэгджээ. Хэдийгээр намд элсэх болсон ч, “эмэгтэйчүүд бичиг үсэгтэй, боловсролтой, олон нийтийн амьдралд хувь нэмэр оруулах боломж, чадвартай гэдгийг эрчүүд хүлээн зөвшөөрөхөд багагүй хугацаа шаарддаг тул эмэгтэйчүүдийн оршихуйг үл ойшоодог” (Nordby 1988, 98). Олон эмэгтэй уламжлалт хэрэгцээгээ хангаж, гэр орны ажил ахуйд дарагдах, эсвэл шинэ социалист засгийн газрын суртал ухуулгад татагдаж, МАХН-д болон Хувьсгалт Залуучуудын Эвлэлд нэгдэж, нийгмийн амьдралд оролцох гэсэн ацан шалааны дунд гацжээ.¹⁴

Гэсэн хэдий ч, Янжмаа (болон бусад удирдагчид) эмэгтэйчүүдийг урамшуулж, эмэгтэйчүүдийн улс төрийн шинж байдлыг шинээр тодорхойлж байсан юм. Тухайлбал, 1974 онд Гэрэлсүрэн, Эрдэнэчимэг нарын дахин хэвлүүлсэн “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүлд Жаргалын Сосор 1925 онд 10 настай жаахан охин байхдаа оролцсон анхны уулзалтынхаа талаар дурсамж яриа нийтлэгдэв. Тус уулзалтад Янжмаа модон тайзан дээр гарч ирээд тод дуугаар доорх зүйлийг өгүүлж гэнэ.

Тиймээс нөхөд өө, . . . зуун зууны туршид эмэгтэйчүүд бид эрчүүдийн боол, гэрийнхээ зарч нь байсаар ирсэн. Ардын Нам, Ардын хувьсгалын ачаар бид одоо эрчүүдийн адил, эрх чөлөөтэй боллоо. Одоо л сурч боловсрох ёстой цаг шүү.

¹³ Падамдулам “цаг үеэсээ түрүүлсэн”, хэт радикал, хэт мэдлэгтэй тул МАХН-ын эрх мэдэлд аюул учруулдаг байсан гэж Долгорын Нямаа (2009) үздэг.

¹⁴ Каплонски (2014) эмэгтэйчүүд олон нийтийн өмнө гаргадаг зан байдал, ёс суртахууны болон улс төрийн хувьд хийж буй сонголт нь маргаан дагуулсан асуудал байдаг талаар бичжээ. Мөн эмэгтэйчүүдийн үсний засалт, хувцаслалт, боловсрол, суурин газар болон эзгүй талд биеэ авч явах байдал, нийгмийн харилцаа зэргийг тойрон байнга маргаан өргөн байдаг бөгөөд ихэнхдээ гэр бүлийнхнээс нь гардаг гэжээ.

Янжмаагийн ярианаас урам авсан Сосор 1931 онд аймгийнхаа эмэгтэйчүүдийн сургуульд элсэн оржээ. Тэнд тэрээр МАХН-ын хорооны эмэгтэйчүүдийн асуудлыг хянан, хариуцдаг хоёр эмэгтэйтэй танилцав. 1938 он гэхэд Сосор аймгийнхаа МАХН-ын зохицуулагч, эмэгтэйчүүдийн байгууллагынхаа дэд тэргүүн болсон байлаа. Энэ үед МАХН-ын Төв хорооноос аймаг болгоноос эмэгтэйчүүдийн төлөөлөл сонгох тухай тогтоол багалжээ. Сосорт хамгийн алслагдсан нутгийнхныг “хоцрогдлоос гаргахын тулд” төлөөлөх эмэгтэйчүүдийг олж сонгох даалгавар ноогджээ (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol. 3:17). Сосорын хэлснээр, 1930 он гэхэд төрийн бодлого эмэгтэйчүүд үйлчилгээ хүртэгч төдий биш, харин идэвхтэй оролцогч болгон төлөвшүүлэхэд чиглээд байсан аж (2014, vol. 3:17). Сосорын урам зориг нь тухай үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн агуулгатай яв цав нийцэж байсан гэнэ. 1931 онд “Ажилчин эмэгтэйчүүд” (өмнө нь Эмэгтэйчүүдийн санал нэртэй байсан) гэх нэртэй эмэгтэйчүүдийн сэтгүүлд Дарьзав гэх бүсгүй “Эмэгтэйчүүд үндэсний удирдагч болох ёстой” гэх өгүүлэл нийтлүүлжээ. Тэрээр эмэгтэйчүүд удирдах албан тушаалын 20 хувийг, захиргааны байгууллагын 50 хувийг эзлэх ёстой гэх асуудал дэвшүүлсэн байна (Ажилчин эмэгтэйчүүд 1931, vol. 21, no. 1:3-5 Батчулуун эш татсан нь 1982, 99).

Тухайн үед Эмэгтэйчүүдийн Хэлтсийн хийж хэрэгжүүлсэн ажлын хэмжээг үнэлж баршгүй. МАХН, Хувьсгалт Залуучуудын Эвлэл (ХЗЭ)-тэй хамтран Эмэгтэйчүүдийн Хэлтсийн салбар нэгжийг улс орон даяар, тэр бүү хэл төрийн аж ахуйн нэгж, хамтрал, үйлдвэрийн газруудад хүртэл байгуулаад байлаа. Тус хэлтэс жил тутмын их хурлаараа (гишүүддээ болон гишүүн биш хүмүүст ч нээлттэй) байгууллагынхаа зорилго, зорилтыг танилцуулж, бичиг үсэг заах кампанит ажил, сургуулийн талаар мэдээлэл түгээж байв (Nordby 1988, 98). Эмэгтэйчүүдийн хэлтсийн 1925 оны ажлын төлөвлөгөөнд дараах жагсаалт багтжээ:

Олон эмэгтэйг бичиг үсэгтэй болгох

МАХН, ХЗЭ, Монгол Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо¹⁵, Нэгдлийн гишүүдэд эмэгтэйчүүдийг элсүүлэх, бүх шатны сонгуульд эмэгтэйчүүдийг өрсөлдүүлэх

Эмэгтэйчүүдийн Хэлтсийн орон нутгийн салбар хороодыг хянах

Цаашидын ажлын төлөвлөгөө боловсруулах

Төлөөлөгчдийг сонгох, илгээх (бүсийн салбар хороод руу)

Уулзалт зохион байгуулах (бүсийн)

Удирдлага, менежерийн түвшний уулзалтууд зохион байгуулах

Эмэгтэйчүүдийн сонирхолд нийцэх, хүүхэдтэй холбоотой ажил зохион байгуулах

Эмнэлэг, төрөх газар, нялхас, хүүхдийн асрамжийн газар байгуулах

¹⁵ Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв зөвлөл нэртэйгээр 1927 онд байгуулагджээ

*Эмэгтэйчүүдийн дунд ухуулга хийхэд хэвлэл мэдээлэл ашиглах
Эмэгтэйчүүдийг сургуульд сургах (мэргэжлийн сургуулиудыг хэлж байгаа байх)
Үйлдвэрт эмэгтэйчүүдийг ажилд авах
Бичиг үсэг заах сургуулиудыг зохион байгуулах
Асрамжийн газар (бусад байгууллагатай хамтран) байгуулах (Gerelsuren
and Erdenechimeg 2014, vol. 1:8).*

Бүлгийн удирдагчид орон нутгийн эгэл жирийн эмэгтэйчүүдтэй нягт хамтран ажиллаж байлаа. Эдгээр удирдагчид зориулсан заавар товхимолд, тэд орон нутгийн эмэгтэйчүүдэд тогтмол хэвлэлд гарсан нийтлэлийг уншиж тайлбарлах, илтгэл тавих, бичиг үсэг заах, тэднийг ахисан түвшний сургуульд элсэхэд нь туслах, зурагт хуудас хийх, нэхмэл, сүлжмэлийн бүлэг байгуулах, хамгийн идэвхтэй эмэгтэйчүүдийг татан оролцуулахыг шаардаж байлаа (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol. 1:9). Эмэгтэйчүүдийн хэлтэс нь төрийн байгууллага хэдий ч, тэдэнд чиглэсэн төрийн дэмжлэгийг нэхэж байсан юм. Бараг бүх дарга эрчүүд байсан тул эмэгтэйчүүдийн асуудалд хандуулах анхаарал төдий чинээ сул байж. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хамгийн чухал нь төрийн бодлого, төрийн бүтцэд тэднийг оролцуулахад тус хэлтэс чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Социализмын эхэн үеэс шинээр бий болж буй улс төрийн орчинд эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулах замаар ард иргэдийг үзэл суртлынхаа хүрээнд оруулах гэсэн төрийн сонирхлыг тус хэлтэс гарамгай, үр ашигтай ажиглажээ. Энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн субьектив шинж байдлыг боловсруулах, эмэгтэй хүн төрийн хүн байж болох үзэл санааг төлөвшүүлэхэд зайлшгүй шаардлагатай эхлэл байсан төдийгүй тус үзэл социализмаас ч урт удаан хугацаанд орших боломжтой байжээ.

Стратегиа өөрчлөх нь: Суртал ухуулгаас ажиллах хүч рүү (1932-59)

Эмэгтэйчүүдийн хэлтсийн ололт амжилт үлэмж байсан хэдий ч, 1932 онд МАХН Эмэгтэйчүүдийн хэлтсийн статусыг бууруулж урьдын адил Суртал Ухуулгын хэлтсийн дэргэдэх Эмэгтэйчүүдийн тасаг болгон зохион байгуулсан юм (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol:12). Тус байгууллагын статусыг бууруулах үндсэн шалтгаан нь Зөвлөлт Холбоот Улсад большевикууд феминизм бол хөрөнгөтний үзэл суртал хэмээх шүүмжлэл гарсныг (Wood 1997, 30)МАХН өлгөн авсан байж болзошгүй. Түүнчлэн, 1930 онд Москвад Зөвлөлт Холбоот Улсын эмэгтэйчүүд улс төрийн болон иргэний эрхийн хувьд өндөр чадвартай, мэргэжлийн түвшинд хүрсэн тул энэ төрлийн байгууллага цаашид шаардлагагүй гэх мэдэгдлийг Коммунист нам гаргасантай (1997, 212) холбоотой ч байж мэднэ.

Хувьсгалт засгийн газрын тогтвортой байдалд эмэгтэйчүүд сөрөг

нөлөө үзүүлэх, заналхийлэх айдасгүй болсон тул МАХН-ын хувьд хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхийг хангах асуудалд тэргүүлэх ач холбогдол өгөхөө больжээ. Крис Каплонскигийн (2014, 83) бичсэнээр, эмэгтэйчүүд олноороо ажиллах, улс төрийн амьдралд бүрэн оролцохыг дэмжих зорилгоор асрамжийн газар болон төстэй үйлдвэрийн газруудыг байгуулах амлалт байсан ч гэсэн 1940-өөд он гэхэд улсын хэмжээнд ердөө 6 цэцэрлэгтэй байлаа. Эмэгтэйчүүдийн Хэлтсийн статусыг бууруулсны өөр нэг шалтгаан нь хамтрал, өмч хөрөнгө хураах, шашныг устгах зэрэг бодлогыг эсэргүүцсэн 1932 оны иргэний дайны хариуд зүүний (хэт социалист) суртлыг сулруулах зорилготой байсан байж болзошгүй¹⁶. Улс Эмэгтэйчүүдийн Хэлтсийг суртал ухуулгын зорилгоор ашиглах шаардлагагүй болсон тул энэ асуудлын тухайд ухрах араандаа хийх хэрэгтэй болжээ. Эдгээр өөрчлөлтүүдээс үзэхэд намын эрх ашиг, намын эрэгтэй удирдлагын харах өнцгөөс эмэгтэйчүүдийн асуудал МАХН-ын хувьд хэзээ ч чухал байгаагүй болох нь харагддаг.

Статус нь буурсан ч гэсэн Эмэгтэйчүүдийн тасаг МАХН-ын дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд элдэв санаачилга дэвшүүлж, хичээж ажиллаж байлаа (Gerelsuren and Erdenechimeg 2014). 1930-аад он гэхэд Зөвлөлт маягийн үйлдвэржилтийг эхлүүлж байсан боловч ажиллах хүчний томхон хомсдолтой тулгарсан юм. Гэрэлсүрэн, Эрдэнэчимэг (2014) нарын хийсэн эмэгтэйчүүдийн дурсамж ярилцлагуудаас ялгаатай нь социализмын үед хэвлэгдсэн албан ёсны, түүхэн ном, сурах бичгүүдэд (Bira 1984; Lhamsuren 1985) ажиллах хүчний хомсдолын талаар ч тэр, эмэгтэйчүүдийн оруулсан хувь нэмрийн талаар ч тэр огт дурдсангүй. Харин, аж үйлдвэржилтийн хөгжил ихээхэн өргөжиж, чадварлаг ажилчдын тоо 1934 онд 3000 байсан бол 1939 онд 10000 болон өссөн талаар сурах бичгүүдэд тэмдэглэгджээ (Lhamsuren 1985, 196). Гэрэлсүрэн, Эрдэнэчимэг нарын (2014) ярилцлагаас 1932 онд статусыг нь бууруулсны дараа Эмэгтэйчүүдийн Тасаг эмэгтэйчүүдэд улс төрийн боловсрол олгох чиг үүргээ өөрчилж тэднийг сургаж, ажиллах хүчин болгон бэлдэх чиглэл рүү хэрхэн хөрвүүлсэн талаар мэдэж авч болно. Учир нь аж үйлдвэржих үйл явц чадварлаг ажилчин, мэргэжлийн боловсон хүчин шаарддаг билээ. Учир нь аж үйлдвэржих үйл явц чадварлаг ажилчид, мэргэжлийн боловсон хүчнийг шаарддаг билээ¹⁷. Тиймээс, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг 800,000 орчим нүүдэлчин Монголчуудын үлэмж хэсэг нь үйлдвэрийн ажилчин анги болох хэрэгтэй

¹⁶ Жишээлбэл Б.Лхасүрэн нар (1985, 154-60) зүүний улс төр суларч буй талаар бичсэнийг үзэж болно.

¹⁷ Тус эдийн засгийн хөгжил нь энгийн үйлдвэрлэлийн түвшин байсангүй. Марксист-Ленинист үзлээр, Монгол Улс феодализмаас социализм руу шууд үсэрсэн бөгөөд, капитализм гэх бүхэл бүтэн нийгэм, эдийн засгийн нэг үеийг алгасан гэж үздэг. Ленин, “Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг Монголын ард түмэн пролетарийн масс болоход Монгол хувьсгалчдын өмнө улс төр, эдийн засаг, соёлын хувьд хийх ажил маш их байна” гэжээ. Ленин Зөвлөлт Орос мэт илүү аж үйлдвэржсэн орны хангалттай тусламжтайгаар “Монголын ард түмэн ард түмэн капиталист бус, эдийн засгийн тогтолцоог шинээр бий болгож чадна” гэх шинэ онол дэвшүүлжээ (Eudin and Fisher 1957, 207).

болов.

Ажиллах хүчний хомсдол нь тухайн үед байсан хүчирхийллээс болж улам даамжирсан асуудал болсон байх. Шинэ засгийн газар 1929 онд барууны (капитализмыг дэмждэг) үзэлтнүүдийг шахан гаргав. Дараа нь 1932 онд хэт зүүний үзэлтнүүд социалист бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхээр оролдсон нь иргэний дайнд хүргэлээ. Энэ нь 1930-аад оны сүүлээр Буддын шашны лам нар, язгууртнууд, сэхээтнүүд, үндэсний цөөнх, коммунизмыг эсэргүүцэгчдийг цэвэрлэх байдлаар илрэв (Karlon-ski 2014). Үр дүнд нь бараг 40000 орчим хүн (нийт хүн амын 5 орчим хувь) хороогджээ (Atwood 2004, 68). Зарим сууринд (Буриад зэрэг ястны) эрчүүд нь бараг л тэр чигтээ хэлмэгдсэн тул эмэгтэйчүүд төрийн өмчийн, нэгдлийн аж ахуйд ажиллахаас өөр аргагүйд хүрсэн гэдэг (Buyandelger 2013). Хэдэн арваны турш цуст хүчирхийлэл үргэлжилж, газар нутаг эзгүйрч байсан хэдий ч, төр бүтээн байгуулалтын төслүүдээ өргөжүүлсээр байлаа (Shirendev 1969 үз). Улмаар эмэгтэйчүүдийг чадавхжуулах гэхээс илүүтэй, үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эмэгтэй ажиллах хүчний тоо ихээхэн нэмэгдэв.

1938 онд Эмэгтэйчүүдийн тасгийг дахин Эмэгтэйчүүдийн хэлтэс болгон өөрчилж, 13 аймагт байх салбар хороодыг ч мөн сэргээжээ (Gerelsuren and Erdenechimeg 2014). ХЗЭ, МҮЭХ-ны болон намын дэргэд байсан салбарууд ч мөн өргөжин бэхжив (Shirendev 1969, 359-60). Ажиллах хүчний эрэлт ихэссэн нь Эмэгтэйчүүдийн Хэлтэст завшаан болохын сацуу, тус байгууллага дараах шинэ төсөл санаачилгуудыг дэвшүүлэх боллоо:

Эмэгтэйчүүдийг сургах (мэргэжлийн боловсрол)

Үйлдвэр болон бусад аж ахуйн нэгжүүдэд ажлын байранд зуучлах

Ажилчин эмэгтэйчүүдийн нийгмийн халамжийг сайжруулах

Төрийн бодлогын хэрэгжилтэд эмэгтэйчүүдийг оролцуулах

Чөлөөт цагаар нийгэм, соёлын арга хэмжээ зохион байгуулах

Оройн цагаар бичиг үсэг заах, сургууль төгссөн хүмүүсийн дундаас багш авч ажиллуулах (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol.1:11)

1923 онд үйлдвэрийн газар, төрийн албанд цалинтай ажил эрхэлдэг долоохон эмэгтэй байсан бол 1940 он гэхэд 2697 болж өсжээ (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol. 1:11). Ажиллах хүчинд эмэгтэйчүүдийг идэвхтэй хамруулснаар Эмэгтэйчүүдийн Хэлтэс үнэ цэнтэй, төрийн чухал аппарат болон бэхжив. Учир нь тус хэлтэс өөрсдийнхөө хүсэл эрмэлзэл, хүч хөдөлмөрөөр үндэсний хэрэгцээг хангаж байсан юм.

Барууны маш олон феминистүүд тоталитар дэглэмтэй улс оронд ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн оролцоо өсөж буй нь тэдний өөрсдийнх нь сонголт биш, харин төрийн дарангуйллын хэлбэр хэмээн үздэг (энэ талаар Gal and Kligman 2000-аас дэлгэрүүлж үзээрэй). Энэ хандлагаар

үзвэл, тус хэлтэс эмэгтэйчүүдийг ажиллах хүчин болгон бэлдэж буй нь феминист бус үйлдэл болж таарч байна¹⁸. Гэвч хүчирхийлэлтэй тоталитар дэглэмд, аливаа гажуудлыг цэвэрлэж болдог. Тодруулбал, бид өмнө нь Эмэгтэйчүүдийн Тасгийн анхны дарга, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тууштай тэмцэгч Пагмадулам гуай албан тушаалаасаа хөөгдөж, үлдсэн амьдралаа хавчлагаас нуугдаж өнгөрүүлсэн талаар дурдсан билээ (Nima 2009). 1925-1932 оны хооронд Эмэгтэйчүүдийн Хэлтсийн даргын ажлыг өөр 6 эмэгтэй ээлжлэн хашжээ. Удирдлага ийм хурдан солигдох нь байгууллагын хувьд тогтворгүй байдлыг л бий болгодог.

Тиймээс, би социализмын үеийн эмэгтэйчүүдийн байгууллага нь социалист төрийнхөө гар хөл байдаг гэх Барууны феминистүүдийн үзлийг няцааж, Монголд эмэгтэйчүүдийн байгууллага нь эрчүүд зонхилсон намын удирдлагатайгаа зохицохын тулд хичээсэн, багагүй бэхэжсэн байгууллага байсан гэж үзэж байна. Тус байгууллага нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хангах орон зай байлгахын төлөө удирдлагатайгаа өрнүүлсэн эмэгтэйчүүдийн тэмцлийн үр дүн бөгөөд улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог энгийн үзэгдэл болгож, хойч үеийн эмэгтэй улс төрчдөд үлдээсэн өв юм. Эмэгтэйчүүдийн хэлтэс нь эмэгтэйчүүдийг ажиллах хүчин болохыг уриалахын сацуу, төрд тэдний үнэ цэнийг ойлгох, урамшуулах, дэмжих шаардлагыг тулгаж чадаж байсан юм. Тус хэлтэс эмэгтэйчүүдийг ажил, хөдөлмөрт оролцуулах замаар төр ч тэр, эмэгтэйчүүд өөрсдөө ч тэр үр ашиг хүртэж байсан тул уг оролцоо нь чухал ач холбогдолтойд тооцогдоно. Түүгээр үл барам, шинэ ажил санаачилж, түүнийгээ төрөөр батлуулж өөрсдийнхөө хэрэгцээг төрд ойлгуулснаар буураад байсан байр сууриа ч сэргээж чадсан байна. Санаачилга нь төрийн хүлээлтэд нийцэж, хяналт дор хэрэгжиж байсан ч гэсэн өөрсдийнхөө идэвх хүчин чармайлтын үр дүнд Эмэгтэйчүүдийн хэлтэс нь социализмын үед жендэрийн улс төр хийх өргөн хүрээний байгууллага болон бэхжиж чаджээ.

Дэлхийн хоёрдугаар дайны үед Эмэгтэйчүүдийн Хэлтэс Зөвлөлтийн армид хүнс, хувцас хунар, мөнгө, мал, морь, эм тариа хүргүүлэх ажлыг зохион байгуулав¹⁹. Арван наймхан настайдаа Монголын өмнөд хэсгийн Дундговь аймгаас ЗХУ-ын Свердловск (Екатеринбург) хүртэл аялсан Цэгмид гэх малчин бүсгүй дараах зүйлийг өгүүлжээ:²⁰

Аймгаас намайг авахаар сайдын машин ирлээ. Хотод ирсний дараа бид нийлж аваад машинаар Наушк хүртэл явж, цаашаа Москва хүртэл галт

¹⁸ Годси (2019) ч мөн Барууны либерал феминист өнцгөөс, феминизм төрөөс гадуур байх ёстой, социалист нийгэмд эмэгтэйчүүд төртэй хамтран ажиллах нь феминизм биш харин ч эсрэгээрээ гэх мэт бичиж байлаа.

¹⁹ Халх голын байлдаан буюу Дэлхийн хоёрдугаар дайн эхлэхээс өмнөхөн 1939 онд Зөвлөлт Холбоот Улс, Японтой хийсэн дайн Монголын нутагт 1939 онд байлдахад Зөвлөлтийн болон Монгол цэргүүдэд туслахаар эмэгтэйчүүд олноороо дайчлагдаж байлаа.

²⁰ Монголын Дундговь аймгаас Зөвлөлт Холбоот Улсын Свердловск (Екатеринбург) хүртэл ойролцоогоор 4500 км зайтай.

тэргээр 9 хоног явсан. Москвад хүрсний дараа бид хэд өөр өөр фронт руу хуваагдан явах боллоо. Би Төв хорооны Сүрэнжав даргын хамт Свердловск дахь тулааны талбарт хурч очлоо. Одоо бодоход би хүүхдээрээ байсан тул хаашаа, юу руу явж байгаа талаараа мэдэхгүй шахуу байжээ. Бид иүүд л дайны талбарт хурч очоод авч явсан бэлгээ тарааж эхлэв. Бидний дээгүүр байлдааны онгоц нисэж, их буугаар буудах чимээ эргэн тойронд сонсогдоно. Үнэхээр аймшигтай. Бид нийт 217 вагон тусламжийн бараа сэлт цэргүүдэд тараасан юм (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol. 1).

Дэлхийн хоёрдугаар дайны гарз хохирлыг үнэлж барамгүй, хамгийн харамсалтай нь хүний капиталын хямралд хүргэсэн²¹. Дайны хөлд нэрвэгдсэн Зөвлөлт Холбоот Улсад мал аж ахуйн бүтээгдэхүүн ихээхэн хэрэгтэй байлаа. Улмаар тав таван жилээр төлөвлөдөг хөгжлийн схем бий болов. Монголын анхдугаар таван жилийн төлөвлөгөө 1948-1952 оныг хамрах бөгөөд малын тоо толгойг 50 хувиар нэмэгдүүлэхээр зорьсон биелэх боломжгүй шахуу төлөвлөгөө байсан юм. Малын тоо толгой өсгөх зорилго нь бэлчээрийн менежмент, дэд бүтэц, мал эмнэлэг, малын тусламж үйлчилгээ, малын шинэ үүлдэр бий болгох зэрэг бусад үйлдвэрийн хөгжлийг шаардана (Shirendev 1969,524). Монгол Улс тээврээ өргөжүүлэх, зам барих, шинэ технологи нэвтрүүлэх, радио, телефон станц, дараа нь телевизийн станц (1960-аад оноос) байгуулж, харилцаа холбооны сүлжээг өргөжүүлэх шаардлагатай тулгарах нь тэр. Шинэ тосгон суурин, нэгдлийн төв, аж үйлдвэрийн цогцолборыг тойрон байгуулагдаж эхэллээ. Эр эмгүй ажилчин, инженер, техникч, нягтлан бодогч, сэтгүүлч, эрдэмтэн, эмч, сувилагч, багш, жүжигчин, уран барилгач болон бусад мэргэжлээр бэлтгэгдэн ажиллаж, эдгээр сууринд суурьшиж эхлэв. 1946 онд нийт ажилчдын 26 хувийг эзэлж байсан эмэгтэйчүүд 1952 он гэхэд 40 хувийг эзлэх (Ballis and Rupen 1956, 389) болжээ²². Тэд бүхий л мэргэжлээр тэр тусмаа хүнд машин механизм, нийтийн тээвэр, уул уурхай зэрэг эрчүүд давамгайлдаг уламжлалтай мэргэжлийн салбарт хүртэл удирдах алба хашиж эхэлсэн нь ч аргагүй биз.

Төрийн анхдагч сонирхол нь улс даяар ажиллах хүч бүрдүүлэх байсан ч гэлээ, маш олон эмэгтэй ажил эрхлэлтгээрээ дамжуулан эдийн засаг, нийгмийн хувьд ихээхэн хүчирхэгжихийн сацуу ажлын байр, МҮЭХ, эмэгтэйчүүдийн байгууллага гэх мэт албан болон албан бус дэмжлэгийн сүлжээг бэхжүүлж чаджээ.²³ Эмэгтэй манлайлагчид өөрсдийн ахиц дэвшлийн төлөө тэмцэх, зорилгоо төрийн зорилготой нийцүүлж, байр

²¹ Дэлхийн хоёрдугаар дайнд Монголд амиа алдсан хүний тоо тодорхойгүй ч, Халх голын байлдаанд 20000 гаруй хүн амиа алджээ.

²² 1950-аад онд гар урчуудын жижиг цехээс улсын томоохон үйлдвэр болгон хөгжүүлэх шилжилтийн үр дагавар тул энэхүү өсөлт нь ихээхэн далайцтай бөгөөд тэмдэглэхүйц өсөлт байв.

²³ Гал, Клигман (2000) нар гэр бүл нь хэврэг, эрчүүд нь сул дорой мэт мэдэрдэг нь нөхцөл байдлын эсрэг тал гэж үзжээ.

сууриа бэхжүүлэх, түүндээ хүрэхийн тулд шинэ санаачилга дэвшүүлэх зэрэг чадварт суралцав. Энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн субъектив шинж байдлын хөгжлийг тодорхойлох үндэс сууриудын нэг билээ. Номын энэ хэсэгт 1930-аад онд үзэл суртлын ажил хэрэгцээгүй болж Эмэгтэйчүүдийн Хэлтсийн статусыг бууруулсан тухай, эмэгтэй манлайлагчид Дэлхийн хоёрдугаар дайн, болон аж үйлдвэржилттэй холбоотойгоор үндэсний хэмжээнд тулгараад байсан ажиллах хүчний хомсдолтой нийцүүлж байгууллагынхаа хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан талаар өгүүллээ. Энэхүү үйл явцад Эмэгтэйчүүдийн хэлтэс үндэсний хэмжээнд бий болсон байсан орон нутаг дахь салбаруудаараа дамжуулан эмэгтэйчүүд эрхээ хамгаалах, санаачлах, манлайлах болон бусдыгаа энэ ажилд амжилттай татан оруулах зэрэг гүйцэтгэсэн юм.

Олон улс дамнасан (transnational) феминизмийн хүч (1959-70)

1947 онд, МАХН-ын улс төрийн товчоо Эмэгтэйчүүдийн Хэлтсийн бүх салбар хороог дагалдах орон тооны хамт татан буулгав. Эмэгтэйчүүд ажиллах хүчин дэх орон зайгаа бат эзэлсэн, дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас гадна улс орон хямралын хүнд хэцүү үеийнхтэй адил Эмэгтэйчүүдийн Хэлтэс хэрэггүй гэж МАХН үзжээ. Эмэгтэйчүүдийн байгууллага улс төрийн байгууллага биш, боловсрол, соёлын байгууллага байхаас гадна МАХН-аас санхүүжүүлэхгүй, харин орон нутгийн захиргаа, үйлдвэрийн газруудаас санхүүжилтээ бүрдүүлж байхаар шийдвэрлэв. Ингээд, 1950 онд Эмэгтэйчүүдийн Хэлтэс МҮЭХ-ны дэргэд очиж, улс даяар 5125 салбар нэгжээ сэргээн байгуулсан боловч ганцхан жилийн дараа Энхтайван Найрамдлын байгууллагын дэргэд очиж, бүх салбар нэгж нь дахин татан буугдлаа (Siilegmaa 2004). Энхтайван Найрамдлын байгууллагын бүтцэд багтсан тул 1958 онд эмэгтэйчүүдийн байгууллага нэрээ өөрчилж Монголын Эмэгтэйчүүдийн Хороо (МЭХ) болов. Үүнийг дагаж үүрэг хариуцлага нь ч багасаж, Монголын эмэгтэйчүүдийн эрхийн төлөө ажилладаг байсан бол олон улсын харилцаатай холбоотой л үйл ажиллагаа явуулах болов. Эмэгтэйчүүдийн байгууллагын бүтцийг цомхотгож, үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн эдгээр шийдвэрээс үзвэл, МАХН улс төр, нийгмийн үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн байгууллага цаашид огт хэрэггүй гэж үзсэн бололтой. Үүний оронд эмэгтэйчүүдийн байгууллага улс орны нүүр царайг олон улсад харуулах хэрэгсэл болжээ.

Эдгээр өөрчлөлтийн хариуд МЭХ-ны удирдлагууд байгууллагынхаа статусыг дахин сэргээхийн тулд олон улсын сүлжээг ашиглах боломжийг эрэлхийлж эхэлжээ. Зөвлөлт Холбоот Улсаас гадна өөр шинээр социалист улсууд бий болж, 1945 онд Парист Эмэгтэйчүүдийн Олон

Улсын Ардчилсан Холбоо (ЭОУАХ – Women’s International Democratic Federation) байгуулагдсан зэрэг үйл явдлын нөлөөгөөр МЭХ-ны гадаад харилцаа ихэд өргөжив.²⁴ МЭХ-ны өмнөх бүтэц буюу Эмэгтэйчүүдийн Хэлтэс 1946 онд ЭОУАХ-нд элсэж, ЭОУАХ-ны хоёрдугаар их хурлаас (1948) зургаадугаар их хурал (1969) хүртэл байнга оролцож, 1970-аад оноос эхлээд ЭОУАХ-ны төвд байнгын гишүүн суулгах болжээ. МЭХ 1980-аад оны сүүл хүртэл олон уулзалт, хурлуудад идэвхтэй оролцсоор ирсэн.²⁵ МЭХ эдгээр олон улсын хурал, уулзалтад оролцсоноор гадаад ертөнцөд, бусад улс оронд өрнөж буй үйл явдлын талаар мэдээлэлтэй болжээ. Олон улсын сүлжээ нь МЭХ-г сэргээн байгуулахад гол түлхүүр болсон юм.

Гэрэлсүрэн, Эрдэнэчимэг (2014), болон Сийлэгмаа (2004) нарын өгүүлснээр, МЭХ-ны шинэ дарга Цэрэнпилийн Сийлэгмаа 1959 онд Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг Шведийн Малмо хотод тэмдэглэсэн үйл явдлыг статус нь буураад байсан эмэгтэйчүүдийн байгууллагыг Монголд дахин сэргээх завшаан болгон ашиглахаар шийджээ. Тэрээр гуравдугаар сарын 8-ны өдрийг эмэгтэйчүүдийн баяр болгон улс даяар тэмдэглэх талаарх саналыг МАХН-ын төв хороонд хүргүүлэв. Тус санал нь батлагдмагц МЭХ-ноос улс орон даяар өмнө нь байсан ч татан буугдаад байсан салбар нэгжүүд рүү тус өдрийг хамтдаа тэмдэглэхийг урин захидал илгээжээ.

Сургууль, засаг захиргааны нэгж, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрийн газрууд гэх мэт бараг бүх л байгууллага концерт, тэмцээн, хурал, цугларалт зохион байгуулж тус өдрийг тэмдэглэжээ. Улс даяар уриа үг, зурагт хуудас, танилцуулга, товхимол, зэрэг баярын уур амьсгал бүхий материал хэвлэгдлээ. Томоохон театр, соёлын төвүүдэд (Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Залуу пионерын ордон гэх мэт) тайзны бүтээл тавигдаж, гадаад улсуудаас (ЗХУ, БНХАУ, Энэтхэг, Болгар гэх мэт) зочид, төлөөлөгч уригдан ирлээ. МЭХ нь улс даяар, тосгон, суурин бүрээс өөрсдийнхөө цаг, эрч хүчийг өдөр шөнөгүй, хагас бүтэн сайнгүй зориулж чадах маш олон тооны идэвхтэн, сонгуультан эмэгтэйг дайчлах боломжтой байсан нь энэ нүсэр ажлыг амжилттай зохион байгуулахад хүргэсэн юм.²⁶

1959 онд Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэсэн нь эмэгтэйчүүдийн ололт амжилт, улс орондоо оруулсан хувь нэмрийг тод томруун харуулсан юм. Тус өдрийг улс даяар, сүр дуулиантай тэмдэглэснээр МЭХ татан буугдаад байсан салбар нэгжүүдээ сэргээхээс гадна чухал хэрэгтэй байгууллага гэдгээ МАХН-д дахин баталсан байна. МЭХ шинэ бүтцээр ажиллах болов. Ерөнхийлөгчөөс

²⁴ Эмэгтэйчүүдийн Олон Улсын Ардчилсан Холбооны талаар дэлгэрэнгүйг Гэрэлсүрэн, Эрдэнэчимэг нар 2014, де Хаан 2012, Годси 2019-өөс үзэж болно.

²⁵ Тухайлбал, 1958 оны Дэлхийн Эжүүдийн Конгресс, НҮБ-ын эмэгтэйчүүдийн Чуулган, 1987 онд Москвад болсон Дэлхийн Эмэгтэйчүүдийн Чуулган зэрэг хурлууд багтана. Мөн МЭХ 1969 онд Вьетнам

²⁶ Социализмын үед Бямба гарагт хагас өдөр ажилладаг байлаа.

(цалингүй) гадна цалин авдаг байнгын дөрвөн орон тоо батлуулсан нь дэд ерөнхийлөгч, гадаад харилцааны мэргэжилтэн, боловсрол, соёлын арга хэмжээний зохицуулагч, эмэгтэйчүүдийн сэтгүүлийн редактор зэрэг болно (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol. 1:19). Ингээд, 1960 он гэхэд МЭХ-ны хэврэг байр суурь илүү бат боллоо. МЭХ-г улсын төсвөөс санхүүжүүлж, тус байгууллага ч социализм унасан 1990 он хүртэл үйл ажиллагаагаа өргөжүүлж, нэр хүндээ бэхжүүлсээр байсан юм.²⁷

МЭХ улс оронд томоохон байр суурьтай болж, орон нутаг дахь төрийн бүтцээр дамжуулан салбар нэгжүүдээ байгуулах замаар эмэгтэйчүүдийг дайчилж, МАХН-ын эрх мэдлийн сүлжээгээр дамжуулан орон нутгийн идэвхтнүүдтэй хамтран ажиллаж чадаж байлаа. Түүгээр үл барам, МЭХ бараг л сургууль бүр, байгууллага бүрд нөлөөлж, МҮЭХ, ХЗЭ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах бололцоотой байсан тул өөрөө зогсонги байдалтай байсан ч гэсэн улс орон даяар эмэгтэйчүүдийг дэмжих ажлын үрийг тарьж чадаж байсан юм.

Олон улсад болон дэлхийн өрнөж буй үйл явц нь МЭХ өөрийн байр суурийг улам бэхжүүлэх, амжилтаа бататгахад нь тус болж байв. Хүйтэн дайн, Гуравдагч Ертөнцийн орнуудад өрнөх колоничлолоос салах хөдөлгөөний үед олон улсын сүлжээг нь ашиглахын тулд Монголын төр МЭХ-г дэмжиж байсан юм. Тухайлбал, 1964 онд болсон Монголын эмэгтэйчүүдийн 4-р чуулганы үеэр ЭОУАХ-ны нарийн бичгийн дарга Изабелла Домингезийг илтгэл тавьж өгөхийг хүсэж, бусад гадаадын төлөөлөгчийн хамт Монголд урив (The Mongolian Women 1964, no. 3:12-15 үз). Энэ үе нь Ази, Африкт шинээр тусгаар тогтносон улс орнуудад нөлөөлөхөөр социалист болон капиталист улс орнууд ид өрсөлдөж байсан цаг (Ghodsee 2019 үз) юм. Социалист улс орнуудын эмэгтэйчүүд АНУ болон бусад барууны орны эсрэг Гуравдагч ертөнцөөс холбоотон хайж байлаа. ЗХУ-ын холбоотны хувиар Монгол Улс ч гэсэн социалист тогтолцооны үр ашгийг гадагшаа сурталчлах ажилд хувь нэмрээ оруулж байв. Хурлын үеэр тавьсан илтгэлдээ, МЭХ-ны удирдлагууд манай нийгэмд эмэгтэйчүүдийн байр суурь, тэгш эрхийн хувьд гаргасан ололт амжилтыг удаа дараа дурдаж байлаа (Gerelsuren and Erdenechimeg 2014). Энэхүү нөлөөллийн гэмээр ажил нь тусгаар тогтнолоо дэлхий дахинд таниулах, хүлээн зөвшөөрүүлэхийг эрмэлзэж байсан Монгол улс Хятад, ЗХУ-ын аль алины хэсэг биш гэдгээ харуулах томоохон завшаан болжээ. 1965 онд НҮБ Монгол Улсын засгийн газартай хамтран Нийгмийн амьдралд Эмэгтэйчүүдийн Оролцоо гэх олон улсын семинар зохион байгуулав. Камбож, Шинэ Зеланд, Баруун Самоа зэрэг дэлхийн

²⁷ МЭХ-нд тулгарч байсан санхүүгийн болон бусад олон төрлийн хүндрэлийг тоочиж болно. Заримдаа МАХН-ын төв хороо МЭХ-ны үйл ажиллагаанд зориулж томилогдсон идэвхтнүүдэд урамшуулал олгох гэх мэт үйл ажиллагааны төсвийг баталж өгнө, заримдаа өгөхгүй. 1973 онд МЭХ Төв Хороотой амжилттай хэлэлцээ хийж, 18 аймагт буй салбар хорооны удирдлагуудын цалин, болон хамгийн үр дүнтэй ажилласан идэвхтнүүддээ урамшуулал олгох төсөв батлуулж чадсан юм (урамшуулал нь гол төлөв амралтын багц, олон улсын аялал гэх мэтээр хэрэгжинэ) (Gerelsuren and Erdenechimeg 2014).

өнцөг булан бүрээс төлөөлөгч ирж, Зөвлөлт Холбоот Улс, Их Британиас ажиглагчид ирж оролцсон байна. Семинарын үеэр эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах стратегийн талаар ярилцаж, тэднийг удирдах албан тушаалд дэвшүүлэхэд эрх зүйн, эдийн засгийн, боловсролын болон тулгараад буй бусад сорилтын талаар хэлэлцжээ (United Nations 1966). 1966 онд Улс төрийн товчоо эмэгтэй удирдагчдыг дэмжих талаар тогтоол баталснаас үзэхэд тус семинар Монголын эмэгтэйчүүдэд амин чухал алхам болжээ.

НҮБ-аас зарласан Эмэгтэйчүүдийг дэмжих 10 жилийн хугацаанд (1975-85) МЭХ улам нэр хүндтэй байгууллага болж чадсан байна.²⁸ НҮБ болон бусад социалист байгууллагуудаас зохион байгуулах олон улсын хуралд Монголын засгийн газар эмэгтэй төлөөлөгчдөө илгээх ажлыг дэмжиж байлаа. Төлөөлөгчөө илгээсэн олон улсын хурлыг жагсаавал, 1975 онд Мехико хотод болсон Эмэгтэйчүүдийн асуудлаарх НҮБ-ын анхдугаар чуулган, 1975 онд Берлинд болсон ЭОУАХ-ны хурал, 1979 онд Москвад болсон Олон Улсын Хүүхэд хамгаалах жилд зориулсан олон улсын бага хурал, Зөвлөлт, Монголын Эмэгтэйчүүдийн хороодын уулзалт, Социалист системийн орнуудын эмэгтэйчүүдийн байгууллагын удирдлагын уулзалт, цуглаанууд (Gerelsuren and Erdenechimeg 2014, vol. 3:41-43), болон 1961 онд Каир хотод болсон Ази-Африкийн Эмэгтэйчүүдийн Чуулган (Prashad 2007) гэх мэт хөвөрнө. Үүнээс гадна, МЭХ-ны төлөөлөл Нороврэнцэнгийн Хандбалжир ЭОУАХ-ны төвд Азийн хэсэгт алба хашиж байлаа.

Эдгээр олон улсын хурал, уулзалтуудад оролцсоноор эмэгтэйчүүд шинэ хүмүүстэй танилцах, олон нийтийн өмнө илтгэх, нөлөөлөх, өөрсдийнхөө мэргэжлийн нэр хүндийг илэрхийлэх гэх мэт манлайллын олон ур чадвараа хөгжүүлсэн нь гарцаагүй. Дэгжин загварлаг хувцас, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг нь Монголд маш ховор байсан тул гадаад томилолтоор явсан хүмүүс л очсон газраасаа авах боломжтой байж. Эдгээр хэрэгсэл нь эх орондоо буцаж очиход эмэгтэйчүүдийн байр суурийн илэрхийлэл болж, эмэгтэй манлайлагчдыг бусад иргэдээс онцгой харагдуулна. МЭХ-ны ажилтнуудтай зөрөөд өнгөрөх төдийд хүмүүс ховор хувцас, чамин сүрчгийг нь магтаж, харагдах байдал нь “гоо сарнай” мэт хэмээн ярина (Gerelsuren and Erdenechimeg 2014; Batchuluun 1982). МЭХ-ны ерөнхийлөгч Сономын Удвалтай (1962-82) уулзсан хүмүүс түүний мэргэжлийн дүр төрх, өөгүй байдлыг нь шагшин магтдаг байв. Удвалын найзууд, болон гэр бүлийнхний ярьж буйгаар тэрээр гоо сайхны бүтээгдэхүүн, хувцас хунарынхаа хэрэглээний талаар нээлттэй ярилцаж, гадаад томилолтоор явахдаа бусдад авчирч тусалдаг нэгэн байжээ.

Олон улсын хуралд оролцохдоо гол төлөв колоничлол, арьс өнгөний

²⁸ НҮБ-ын Эмэгтэйчүүдийн арван жилийн талаар Годси 2012-оос үзэн үү.

үзэл, дарангуйлал, дайныг болон зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг эсэргүүцэх гэх мэт дотоодын болон олон улсын асуудлаар эгч дүү байгууллагуудтай яриа хэлэлцүүлэг өрнүүлнэ. Тэд хамтдаа үндэсний хөгжилд нийгмийн төлөөллийг тэгш хамруулах асуудалд өөр өөрсдийн засгийн газрын анхаарлыг хандуулах талаар нарийн төлөвлөгөө, уран саналыг боловсруулаж чадна. Годсигийн (2019) үзэж буйгаар, социалист улсууд, хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүдийн байгууллагууд феминизмийн талаарх Барууны ойлголт, байр суурийг баримталдаггүй аж. Учир нь тэд хүйсийн тэгш байдалд хүрэхэд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн юунаас ч хараат бус байх ёстой гэдэгт итгэдэггүй. Харин ч социалист эмэгтэйчүүдийн байгууллага эмэгтэйчүүдийнхээ нөхцөл байдлыг сайжруулахын тулд төрд дотроос нь нөлөөлөхийг эрмэлзэж байсан юм.

МЭХ-ны удирдлагууд өөрсдийн санаачилгаа хэрэгжүүлэх, эрэгтэй удирдагчдадаа нөлөөлөхийн тулд төрийн эрх мэдлийн нэг хэсэг байхын ач холбогдлыг сайтар ойлгож байсан. Тийм ч учраас тэд төрд эрх мэдэл, байр сууриа бэхжүүлэх, байгууллагаа өргөжүүлэх, хүлээн зөвшөөрүүлэхэд, төрийн үг хэллэгийг ашиглаж чаддаг байв. МЭХ-ны ерөнхийлөгч Удвал гуай (1949-54, 1962-82) олон бүтээл туурвисан зохиолч төдийгүй, 1990 онд социализм унах хүртэлх үеийн Монголын хамгийн алдартай эмэгтэйчүүдийн нэг байсан юм. МЭХ-г даргалахын хажуугаар, тэрээр Монголын Зохиолчдын Эвлэлийн дарга, Ардын Их Хурал буюу Парламентын гишүүний албыг хашиж байв. Удвал гуайн хашиж байсан олон чухал алба нь МЭХ-ны байр суурийг өргөжүүлэх, үйл ажиллагааны хүрээгээ тэлэхэд ихээхэн хувь нэмэр болсон. МЭХ эмэгтэйчүүдээ дэмжих, гаргасан амжилтыг намд байнга мэдэгдэхийг эрмэлзэж байсан юм. Жишээ татахад, 1964 онд болсон Монголын эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр чуулганаар МАХН-ын Төв хороонд хандан мал аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, боловсрол, анагаах ухаан зэрэг салбарт эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмрийг тодорхой дурдсан захидал илгээж байлаа. Захидлын агуулга нь улс үндэстэн эмэгтэйчүүдгүйгээр тогтвортой орших, хөгжих боломжгүй гэдгийг тодорхой илэрхийлнэ. Үнэхээр ч үнээ саах зэрэг өдөр тутмын ажлаас өгсүүлээд, эмнэлэг ажиллуулах гэх мэт олон салбарт эмэгтэйчүүд гол тоглогч байсан юм (The Mongolian Women 1964, no. 3:16-17 үз). Эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулах, чуулганд оролцох олон улсын зочид, төлөөлөгчдийг урих, Улс төрийн товчоонд захидал илгээх зэрэг нь улс орны хөгжилд эмэгтэйчүүдийн оролцооны ач холбогдлыг МАХН-д ойлгуулахын тулд МЭХ-ноос авч хэрэгжүүлсэн үй олон арга хэмжээний багахан хэсэг нь байлаа.

Эргээд бодоход, социализмын үед эмэгтэйчүүд өөрсдийгөө зөвхөн “эмэгтэйчүүдийн асуудлаар” хязгаарлалгүйгээр, нийгмийн амьдралын бүхий л салбарт үндэсний шийдвэр гаргах түвшинд оролцдог байсан

нь ардчиллын үед ч эмэгтэй нэр дэвшигчид “эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэе” гэх мэт уриатай сонгуульд оролцдоггүйг тайлбарлах шиг. Эмэгтэй сонгогчидтой ярилцах үеэр тэд маань эмэгтэй нэр дэвшигчдийг зөвхөн эмэгтэйчүүдийн асуудлаар л хязгаарлах ёсгүй гэж үзэж байсантай ч холбогдох мэт. Нэгэн ярилцлагын үеэр Төв аймгийн хөдөө амьдрах дунд эргэм насны эмэгтэй надад “Эмэгтэй нэр дэвшигчид эрэгтэй улс төрчдийн адилаар үндэсний хэмжээний бүхий л асуудалд шийдэл эрэлхийлэхэд оролцох ёстой. Эмэгтэйчүүд зөвхөн эмэгтэйчүүдийн гэгдэх асуудлаар өөрсдийгөө хязгаарлах ёсгүй” гэж үзэж буй талаараа хэлсэн юм. Маш олон эмэгтэй сонгогчийн хувьд, эмэгтэй нэр дэвшигчид гагцхүү “эмэгтэйчүүдийн асуудал” гэж суулгүй, төрийн ажилд оролцох ёстой гэж үзэж байв. Энэ үзэл бодол нь үнэн хэрэгтээ, социализмын үеийн МЭХ-ны хүчин чармайлтын үр дүнд олон шат дамжлагыг туулж, эцэст нь МАХН-ын Төв хорооноос гарсан албан ёсны тогтоолоор дамжиж олон нийтийн дунд төлөвшсөн байна.

Эмэгтэйчүүдийн байдал дээшилж удирдлагын түвшинд ахисан түүх (1960-1990)

Нийгмийн халамжийн болон хүний эрхийн зохицуулалт, эмэгтэйчүүдийн бодлогын дэмжлэг зэрэг хүчин зүйлээс шалтгаалан Монгол Улс хүйсийн тэгш байдлыг хангахад ахиц дэвшил гаргасан улс орон хэмээн албан ёсоор тооцогдох болжээ. Гэвч заримдаа албан ёсны тогтоол, эрх зүйн хувьд хүчин чадалтай хэдий ч хийсвэр үлдэж (социалист үзэл суртлын адил), энгийн эмэгтэйчүүдийн амьдралд сорилт учирсан хэвээр байх тохиолдол бишгүй бий. МЭХ-ны удирдлагууд болон албан хаагчид ангайсан хайч мэт энэхүү зөрүүтэй байдлыг мэдэж байсан төдийгүй, эмэгтэйчүүдийн сайн сайхан байдлыг хангахын төлөө санал санаачилгууд дэвшүүлсээр байсан юм. Эмэгтэйчүүдийн хүнд хэцүү нөхцөл байдалд Зөвлөлт ноёлсон Монголын эдийн засгийн байдал тодорхой нөлөөлж байсан. Гэвч МЭХ эгэл жирийн эмэгтэйчүүдийн амьдралын болон ажлын нөхцөлийг сайжруулах, тэдний байдлыг олон нийтэд ойлгуулах, удирдлагын албан тушаалд дэвшүүлэх, эхчүүдийн эрүүл мэндийг хамгаалах механизмуудыг санал болгожээ.

Улс даяар томилсон идэвхтнүүдээр дамжуулан МЭХ орон нутгийн эмэгтэйчүүд заавал болон сайн дурын үндсэн дээр хамрагдах төрөл бүрийн клубийг үүсгэж байгуулжээ. Тухайлбал, Ази, Африкт өрнөж буй колоничлолын эсрэг хөдөлгөөн, АНУ дахь арьс өнгөний үзэл, мөлжлөг, бусад капиталист улсын империалист бодлого зэргийн талаар сурч мэдэх боломжтой улс төрийн клубүүдэд заавал элсэх шаардлагатай байлаа. Мөн орчин үеийн өрхийн аж ахуй эрхлэх, хүүхэд асрах, өөрсдөө сурч хэрэгжүүлэх боломжтой төслүүд, хүүхэд хөгжил, шим тэжээлийн талаар мэдээлэл түгээх зорилготой клуб ч байгуулагдав. Учир нь ихэнх

эмэгтэй бүтэн цагийн ажилтай тул заавал оролцох ёстой эдгээр клуб тэдгээр эмэгтэйн цагийн хуваарьт төдийгүй гэр бүлийн уур амьсгал, хувийн амьдралд дарамт учруулж байна гэж үзэх бүсгүйчүүд цөөнгүй байлаа. Гэсэн хэдий ч клубийн хэлбэр агуулгаас харвал, нийгэмшүүлэх, оролцуулах, арга хэмжээ, уулзалт зохион байгуулах, мэдээлэл солилцох, нөлөөлөх, заах, залуу бүсгүйчүүдийг урамшуулахад чиглэсэн эдгээр үйл ажиллагаа нь ерөнхийдөө эмэгтэйчүүдийг манлайлах, бусдад туслах, үйлчлэх боломжийг олгосноор эмэгтэй хүн нийгмийн болон улс төрийн оролцогч болон төлөвшихөд ач тусаа өгсөн байна.

МЭХ нь улс даяар нэгдлийн аж ахуй, үйлдвэрийн газар, засаг захиргааны нэгж, төрийн байгууллага бүрд “соёлын төв” байгуулжээ. Эдгээр соёлын төвүүдэд эрүүл мэнд, өрхийн эдийн засаг, өрхийн технологи, хүүхэд асрах, өөрийгөө арчлах, гоо сайхны бүтээгдэхүүн болон шим гэжээл зэрэг олон төрлийн мэдээлэл агуулсан товхимлуудыг байршуулав. Соёлын төв нь эмэгтэй хүн өөрийгөө хайралдаг, орчин үеийн, шинэлэг, соёлтой амьдралын хэв маяг бүхий хүн гэдгийг ойлгуулах, мэдрүүлэх зорилготой аж.

Төрөөс төрөлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж эхлэхэд (1974-90) МЭХ байгууллагынхаа байр суурь, хувь гишүүдийнхээ амьжиргааг эрсдэлд оруулахыг хүсээгүй тул тус бодлогыг шууд шүүмжилж чадсангүй²⁹. МЭХ эмэгтэйчүүдийн сайн сайхан байдал, амьдралын нөхцөлийг сайжруулахын тулд төрийн зорилгын хүрээнд л ажиллажээ. Олон жил хөөцөлдсөний үр дүнд, 1980 онд дөрөв буюу түүнээс олон хүүхэдтэй эхчүүд үр хөндүүлж болох хуулийг батлуулж чадсан юм. Тухайн ажилд оролцож явсан идэвхтэн Жигжиддоржийн Ариунцэцэг ярилцлагынхаа үеэр хууль бус үр хөндүүлж амь биеэрээ хохирдог эмэгтэйчүүдийн тоог онцлон харуулж байж тус хуулийг Улс төрийн товчоогоор батлуулж чадсан талаар дурсан өгүүлжээ. МЭХ орон нутагт төрөхийн өмнөх өрөөнүүдийг байгуулснаар төрөх дөхсөн эмэгтэйчүүд эмнэлгийн ойрхавьд байх боломжтой болжээ. Дийлэнх эмэгтэй эмнэлгийн үйлчилгээ авахаар хол зам туулдаг тул энэ нь жирэмсэн эмэгтэйчүүдэд тун хэрэгтэй шийдвэр байв. МЭХ төрөх эмнэлэг, хүүхдийн эмч нарын хүрэлцээг хянаж, нярайн мэргэжлийн эмч бэлдэхийг шаардсаар байсан юм. Румын болон бусад газар байдаг жишгээр олон хүүхэд төрүүлсэн эмэгтэйн “эх орондоо оруулсан хувь нэмрийг” алдаршуулахын сацуу мөнгөн дэмжлэг олгох зохицуулалтыг идэвхтэй зүтгүүлсээр байсан билээ (cf. Kligman 1998; Paxson 2004; Kanaaneh 2002).

Социализмын сүүлийн жилүүдэд төрөлтийг дэмжих бодлого, хүүхэд, залуусын орчин нөхцөл ч мэдэгдэхүйц сайжирлаа. 44 жилийн турш улс удирдсан Намын Ерөнхий Нарийн Бичгийн дарга (ерөнхийлөгч)

²⁹ Өргөн уудам нутагтаа хүн амын өсөлтийг дэмжихийн тулд төрөөс үр зулбуулах гэх мэт төрөлтөөс хамгаалах бүх төрлийн арга хэрэгслийг хуулиар хориглож байв. 1970 онд нэг сая байсан нийт хүн ам 20 жилийн дотор хоёр сая болон өслөө. Төрөхтэй холбоотой бодлогын хэрэгжилт, нөхцөл байдал, янз бүрийн үзэл бодлын талаар Төрмөнх Одонтуяа 2016-аас үзнэ үү.

Юмжаагийн Цэдэнбал Анастасиа Филатова гэх Орос бүсгүйтэй гэрлэжээ. Олон Монгол хүн Филатовагийн нөхөртөө үзүүлсэн нөлөөг далдуур шүүмжилж, түүнийг Зөвлөлтийн ноёрхлын төлөөлөгч хэмээн эсэргүүцдэг хэдий ч хүүхдийн хүмүүжил, залуучуудын боловсролыг тууштай дэмжиж, эмэгтэйчүүдийн сайн сайхан байдлыг хангах, тэднийг эрх мэдэлжүүлэхэд оруулсан хувь нэмэрт талархдаг Монголчууд ч цөөнгүй.

МЭХ-ны салбар нэгжийн манлайлагчаас өөр бусад удирдлагын түвшинд хангалттай олон эмэгтэй байхгүйг мэдэж байсан МЭХ-ны ерөнхийлөгч Удвал эмэгтэйчүүдийг удирдлагын түвшинд томилох санаачилгыг зүтгүүлж байлаа. Эмэгтэйчүүд олноороо ажиллах хүч болж байсан хэдий ч тэр хэмжээнд талархал, шагнал хүртэхгүй байгааг МЭХ ажиглав. Харин ч орон нутгийн засаг захиргаа, үйлдвэрийн газрын эрэгтэй голдуу дарга нар эмэгтэйчүүдийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг МАХН-д танилцуулж, оноо авна. Тийм учраас, МЭХ хийсэн ажлынх нь төлөө эмэгтэйчүүдийг шагнах боломжийг эрэлхийлж байлаа.

МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн 1966 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338-р тогтоолоор нам, төр, болон бусад байгууллагын удирдлагад эмэгтэйчүүдийг дэвшүүлэхээр шийдвэрлэв. Тус тогтоолд Ардын Их Хурлын гишүүдийн 21.6 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг мөртөө, нам, төр, үйлдвэрийн газар болон бусад байгууллагын удирдах албан тушаал хашихгүй байгааг онцолжээ. Тухайн үед төрөл бүрийн байгууллагыг төвөггүй удирдаад явах чадвартай эмэгтэйчүүд хангалттай олон байсан боловч тогтоолын хүрээнд эмэгтэйчүүд тушаал ахисангүй. 1967 оны өвөл эмэгтэйчүүдийг албан тушаал ахиулах арга зам, бололцоог эрэлхийлэх судалгааны үр дүн гарч, бүх яамдад (Үйлдвэр Худалдааны яам, Соёлын яам гэх мэт) эмэгтэйчүүдийг удирдах албан тушаал хаших бололцоог хангах төлөвлөгөө боловсруулах үүрэг өгчээ. Тус тушаалд эмэгтэйчүүдийг удирдлагын түвшинд байршуулах нарийвчилсан зааварчилгааг хавсаргав. Тухайлбал, хавсралтын нэгдүгээр зүйлд бүх яамд, засгийн газрын агентлаг, газар, хэлтсийн дарга, эсвэл дэд даргын аль нэг нь эмэгтэй хүн байхаар заасан байна. Мөн, хүүхдийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, болон нийт ажилчдынх нь олонхыг эмэгтэйчүүд бүрдүүлдэг аливаа байгууллагын удирдлага нь эмэгтэй хүн байх ёстой гэх мэтчилэн үргэлжлэв. Тус тушаалын мөрөөр МЭХ өндөр албан тушаал хаших боломжтой эмэгтэйчүүдээ тодорхойлж, дэвшүүлж, томилох ажлыг гүйцэтгэж эхэлсэн юм.

Дүгнэлт: Хийсвэр Зарчмын хүч

Энэ бүлэгт эмэгтэйчүүд төрийн зорилго, зорилтын хүрээнд өөрсдийн хязгаарлагдмал бололцоондоо тохируулан жендэрийн байдлыг өөрчилж байсан стратегийг онцоллоо. Эрэгтэй удирдагчдын зүгээс хязгаарлаж,

хянаж байсан хэдий ч МЭХ үйл ажиллагаа хадгалах, өргөжүүлэх үйл явцдаа эмэгтэй хүнийг улс төрийн болон нийгмийн субъектийг төлөвшүүлжээ.

Би Монголын социализмын үеийн он жилүүдэд (1924-90) төрөл бүрийн үр дагаварт хүргэж байсан ч жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлд маш олон бодлогыг өдөр бүр хэрэгжүүлж байсан гэсэн санааг энэ бүлэгт дэвшүүллээ. Эдгээр бодлогод охид, хөвгүүдийг улсын сургуульд үнэ төлбөргүй заавал сургах, аль аль хүйсийг улс төрийн орчинд боловсруулж, нийгэмшүүлэх, бүхий л мэргэжлээр бүх түвшинд эмэгтэйчүүдийг бэлдэх, оролцуулах гэх зэрэг багтана. Бодит байдалд ажил мэргэжлийг хүйсийн онцлогоор хуваарилж, эмэгтэйчүүд удирдлагын түвшинд хүрч ажиллах зам нь дардан байгаагүй ч тэгш байдлын зарчим эмэгтэй хүн улс төрийн субъект байх, нийгэмд өөрсдийн байр сууриа бэхжүүлэхэд нөлөөгөө үзүүлсэн юм. Илүү боловсрол, өндөр байр суурь, нийгэмд илүү идэвхтэй оролцох хүсэл эрмэлзэл нь өдөр тутам бэрхшээлтэй тулгарч байсан ч төрөөс “дээрээс” зарчмын хувьд дэмжигдэж, эмэгтэйчүүд ч идэвхтэй ажиллаж чадсан юм. Монгол дахь жендэрийн хувьд эрэгтэйчүүд илүү хүчтэй боловч тэгш байдлын төлөөх сургал ухуулга нь эмэгтэйчүүд өөрсдийнхөө орон зайг бүтээх, жендэрийн тэнцвэргүй байдлыг өөрчлөх бололцоог нээсэн гэж үзэж байна.

Эмэгтэйчүүдийн социализмаасаа өвлөсөн улс төрийн субъектив шинж байдал 21-р зууны ардчилсан системд шинэ төрлийн эдийн засаг, хууль, соёлын бүтэц, тогтолцоонд нийцэн шинэчлэгдэхэд чухал байлаа. Монгол Улс ардчиллын зарчмуудыг идэвхтэй дагаж, зах зээлийн эдийн засагт амжилттай шилжсэн нь Зөвлөлт Холбоот Улс, Хятад гэх хоёр хөршөөсөө хараат бусаар социализмын дараа өөрсдийн онцлогийг тодруулах гэсэн хүсэл эрмэлзлээс үүдэлтэй. Харин 1990-ээд оноос хойш ардчилал гэх ойлголт хувь хүний болон улс үндэсний тусгаар тогтнолын ойлголтын хамт Монголын улс төр, төрийн бодлогыг тодорхойлох болсон юм.

Социализмын эсрэг байр суурьтай Барууны улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллагууд социалист төр бол нэгэн цул байгууллага бөгөөд эмэгтэйчүүд социализмаас тусдаа бодолтой байх боломжгүй гэх өрөөсгөл таамаглалд үндэслэн үйл ажиллагаа явуулах хандлагатай байдаг. Энэ буруу ойлголт нь барууны либерал феминистүүд өөрсдийн эрх чөлөөний талаарх үзэл баримлалд төдийгүй, төрийн бус тоглогчид, аливаа хөдөлгөөний үр дүнг анзаарахгүй, харалган болгож байна. Монголын эмэгтэйчүүдийн байгууллагад намаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагуудтай эв санааны хувьд нэгдэж, нэгдмэл зорилгынхоо төлөө МАХН-тай зөвшилцөхөөс өөр сонголт байсангүй.

Социализмын үеийн, ялангуяа 1950-аад оноос хойш эмэгтэйчүүдийн

төлөө хэрэгжүүлсэн “төрийн бодлого” нь эмэгтэйчүүдийн байгууллагын удирдлага нэг талаар намын албан тушаалтны хувьд үүргээ биелүүлэх, нөгөө талаар үндэсний хэмжээний эмэгтэйчүүдийг төлөөлөх зэрэг эрс тэс хоёр чиг үүргээ амжилттай хослуульж, эрэгтэй удирдлагатай нийцтэй хамтарч ажилласны үр дүн билээ. Хотын ажилчин эмэгтэйчүүдийн асуудал, хэрэгцээ нь алслагдсан, хөдөөгийн малчин нэгнээс ялгаатай байх тул тэднийг бүхэлд нь хамруулан ажиллах боломж хязгаарлагдмал байжээ.

МЭХ нь эмэгтэйчүүдийн нийгмийн болон, байр суурийн талаарх асуудлыг шийдвэрлэснээр төрийн бодлогыг өргөжүүлж, бодлогод нь амжилттай нөлөөлж чадсан юм. Энэ нь зарим эмэгтэй удирдагч тэгш эрхийн зарчим болон шинэчлэл, хөгжлийн талаарх ойлголтыг шинэлэг арга барилаар нэвтрүүлсний үр дүн байлаа. Нөгөөтгээгүүр, эрчүүдийн дийлэнх нь эмэгтэйчүүдийн байр суурь ямар байх ёстой талаарх ойлголт хомс байлаа. Тухайлбал, эрэгтэй удирдагчид төрөлтийг дэмжих бодлогыг санаачилсан хэдий ч эмэгтэйчүүдийн байгууллага л алс холоос төрөхөөр ирэх жирэмсэн эмэгтэйд төрөхийн өмнөх өрөөгөөр үйлчлэх, алдарт эхийн одон медаль гардуулах гэх мэт хэрэгцээтэй үйлчилгээ, урамшууллыг санаачилж, ажил хэрэг болгосон юм.

Энэ төрлийн “төрийн бодлого”-ын үр шимийг сонгомол цөөхөн эмэгтэй хүртэж (жишээ нь алдарт эх одон, хөдөлмөрийн одон медаль, мянгат малчин хэмээх цол, гэх мэт) нийгмээс хүлээн зөвшөөрөгдсөнөөр хязгаарлагдаагүй. Жирийн бүсгүйчүүд ч эмэгтэйчүүдийн байгууллагын орон нутгийн салбар нэгжид хувь хүнийхээ хувьд ч, жижиг бүлгийн гишүүний хувьд ч идэвхтэй оролцож жирийн ээжүүд, ажилчин, малчин гэх танигдахуйгаас давж нийгмийн, нийтийн статустай болсон юм. Ийм чимхлүүр зохицуулалт төрийг илүү хүртээмжтэй, эрэгтэй шинж нь хэт давамгайлаагүй, дээрээс доош чиглэсэн босоо чиглэлтэй биш байлгахын сацуу эмэгтэйчүүд төрийн доторх төлөөлөгч гэдгийг ойлгоход тусална. “Төрийн бодлого”-ыг задлан үзвээс, эмэгтэй хүн нийгмийн харилцааны идэвхтэй субъект гэдэг нь илэрхий болж байна. Ийм идэвхтэй субъект байх нь орчин цагийн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд ч өв болж нөлөөгөө үзүүлж буй нь харагддаг.

Эмэгтэйчүүдийг дэмжих бүхий л хүчин чармайлтад тэгш байдлын зарчмыг яв цав баримталж, өдөр тутмын амьдралд нутагшуулсан нь удаан хугацаагаар үр нөлөөтэй байжээ. Улаанбаатар хотын төв, Сүхбаатарын талбайн ойролцоо, Төрийн ордны дэргэд “Монгол Орноо Мандууль” гэсэн бичигтэй байшин бий. Төрөлтийн бодлогыг дэмжиж байсан социализмын үед Сүхбаатарын талбай дагуух төв гудамжинд (Энх тайвны өргөн чөлөө) “Бүхнийг Хүүхдийн Төлөө” гэх хаягтай байшин байдаг байлаа. Эмэгтэйчүүдийг дэмжихэд холбоотой зарчмыг хэзээ ч ингэж илэн далангүй илэрхийлж байсангүй. Улсын төв талбайн ойролцоо “Эмэгтэйчүүд Тэгш Эрхтэй” гэх ч юм уу, эсвэл “Эмэгтэйчүүдээ

Дэмжицгээе” гэх уриа, мессежийг байшингийн хананд сийлсэнгүй. Гэвч, Монгол Улсын нийслэлд өсөж торнисон хүний хувьд би өдөр бүр биш юм гэхэд долоо хоног бүр эдгээр самбарын хажуугаар өнгөрөхдөө хэзээ ч бичигдээгүй ч гэсэн, эмэгтэйчүүдийг дэмжицгээе гэсэн бичгийг дотроо төсөөлдөг байлаа.

Би яагаад феминист шинж тэмдгийг төрийн бусад уриа үгстэй хамт оруулсан гэж бодож байна? Магадгүй би өсөж том болох үедээ (НҮБ-ын Эмэгтэйчүүдийг дэмжих 10 жилийн хугацаанд ч юм уу) хэвлэл, зурагт хуудас, телевизийн мэдээгээр ижил төстэй уриа үг харсан байх. Уриа үгсийг оновчтой орчуулсан эсвэл байршуулсан эсэх нь бус, харин миний төсөөлөлд хоногшсон байдал нь сонирхлыг минь ихэд татлаа. Яагаад эх оронч, эсвэл төрөлтийг дэмжсэн уриа үгийг хармагц эдний дунд феминист уриа байдаг, эсвэл байх ёстой мэт мэдрэмж надад төрөв? Зургийн онолч В.Ж.Т Митчелл бодитоор дүрсэлсэн болон оюун санааны төсөөллийн ялгааг судлаад, бидний төсөөлөл шинэ дүрс хармагц оюун санаанд нөлөөлж байдаг тул хийсвэр төсөөлөл хэзээ ч огт хий хоосон зүйл байдаггүй гэжээ. Бодитоор дүрсэлсэн болон оюун санааны төсөөлөл нь харилцан хамааралтай (1984, 509) байх бөгөөд “бид аман яриа, дүрсэн илэрхийллээс өөрсдийнхөө ертөнцийг бүтээж байдаг” (531) аж. Митчеллийн зургийн онолоор бол эмэгтэйчүүдийн тэгш эрхийг дэмжихийг “хүссэн” нь миний оюун санаанд бий болсон төсөөлөл бололтой. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах нь мэдлэгийн үр дүн биш төдийгүй тус мэдлэг гээч зүйлийг “жам ёсны төлөөллийн ямар нэг тодорхой өмчийн хэлбэр огтоос биш, харин нийгмийн туршлага, зөрчил, нийгмийн гэрээ зэргийн үүднээс ойлговол зохино” (520).

Байшингийн дээр уриа үг хэлбэрээр дүрслэгдээгүй боловч эмэгтэйчүүдийг дэмжих талаарх мессеж МЭХ-ноос зохион байгуулдаг үндэсний шилдэг эмэгтэй ажилчин шалгаруулах, эмэгтэйчүүдийн уулзалт, хурал зохион байгуулах, Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг жил бүр тэмдэглэх, феминист сэдэвтэй уран зохиол, кино, дэлгэцийн бүтээл үйлдвэрлэх зэрэгт нэвт шингэн кодлогджээ.³⁰ 1924 оны Үндсэн хуульд хүйсийн/жэндэрийн тэгш байдлыг баталгаажуулснаар, эмэгтэйчүүд тэгш эрхийн зарчмын төлөө ажиллах төрөл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх боломжоор хангагдсан юм.

Үндсэн хуулиар баталгаажсан хүйсийн тэгш эрхийн зарчим нь хэд хэдэн талаараа хийсвэр байсан. Социализмын үеийн олон үзэл суртлын нэгэн адил эрхэмлэвэл зохих хийсвэр үзэл санаа байсан бөгөөд өдөр тутмын амьдралаас хол зарчим байсан гэж болно. Зарчмын хийсвэрлэл ихэнхдээ бидний дээр өгүүлсэн хоёр уриа үгийн адил бодит дүрсэлсэн мессежинд л хадгалагдаж байдаг. Гэвч хүйсийн/жэндэрийн тэгш эрхийн зарчим нь үгээр дүрслэн тунхаглаагүй бусад хийсвэр зарчмаас

³⁰ Түвдэнгийн Бор, Талын Цуурай, Энэ Хүүхнүүд үү, Манай Аялгуу, Сэрэлт гэх мэт кино хамаарна. Их Хувь Заяа, Олгэрэл, Цаг Төрийн Үймээн зэрэг роман, болон Газар Шороо, Тунгалаг Тамир зэрэг цуврал кино хамаарна.

өвөрмөц байлаа. Учир нь төр эмэгтэйчүүдийг бүх салбарт, ялангуяа дээд удирдлагын түвшинд ижил оролцуулах сонирхолгүй байсан (Karplonski 2014). Гэхдээ төрд эмэгтэйчүүдийн хувь нэмэр хэрэгтэй байлаа. Хүйсийн тэгш эрхийн зарчмыг эмэгтэйчүүд шууд утгаар нь бодит үгээр дүрслэн илэрхийлсэн бол эрэгтэй-төвтэй удирдлага сайшаахгүй байсан нь тодорхой. Улмаар эмзэг байсан МЭХ-ны хувь заяаг эрсдэлд оруулж ч болох байлаа. Тиймээс МАХН-ын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага (Эмэгтэйчүүдийн тасаг, МЭХ зэрэг нэртэй байсан) маш ухаалаг, нарийн тойруу арга барилаар ажиллаж байв. Эмэгтэйчүүдийн ажлын болон амьдралын орчныг сайжруулахад чиглэсэн ажил нь намын эрэгтэй удирдлага санаагаа чилээгээд байх асуудал биш байсан тул МЭХ хүйсийн тэгш эрхийн зарчим сурталчлах, зарлан тунхаглах гэхээс илүүтэй бодитоор хэрэгжүүлэхэд илүү анхаарсан юм.

Үгээр илэрхийлээгүй байснаар, “хүйс хоорондын тэгш байдал”-ын зарчим илүү хийсвэр, илүү тодорхойгүй байв. Энэ тодорхойгүй байдал нь зарим талаар эмэгтэйчүүдийн байгууллага тодорхой төслүүд (МАХН ажлынх нь үр дүнг өөртөө шингээж, харин эмэгтэйчүүдийн байгууллага сүүдэрт үлдсэн ч гэсэн) хэрэгжүүлэхэд амар байсан юм. Өөрөөр хэлбэл, МЭХ хэн нэгэн тэдэнд халдаж, төслүүдийг нь хазаарлахаас сэргийлэхдээ, өөрсдийнхөө ажлыг сурталчлах бодит мессежийг ашигласангүй. Магадгүй ажлаа сурталчлахад илүү анхаарсан бол эмэгтэйчүүдийн хүсэл эрмэлзэл нь тодорхой боловч МЭХ-ны төслүүд болон байгууллага эмзэг болох байсан. Харин эмэгтэйчүүдийн үйлдэл нь төрийн аппаратаар дамжин, гол төлөв далд байдлаар зарчмаа тууштай илэрхийлэхэд дөхөм болж байсан юм.³¹

Яваандаа манлайллаа сурталчлахгүй, даруу байхын сул тал илэрч эхлэв. Зарчмын хийсвэрлэх байдал, төсөл, хөтөлбөрүүдийг дээрээс доош чиглэсэн байдлаар хэрэгжүүлэх нь эмэгтэйчүүдийн байгууллагад шууд хамаарахгүй эгэл жирийн маш олон бүсгүй эдгээр төсөл хөтөлбөрийг эмэгтэйчүүдийн байгууллага, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө гаргаж буй хүчин чармайлт гэж үзэхээс илүүтэй төрийн халамжийн бодлогын үр дүн гэж ойлгож байлаа. Боловсрол, ажлын байр болон бусад нөөцийн тэгш хүртээмж, жирэмсний тэтгэмж, хүүхдийн халамжийн мөнгө зэрэг томоохон амжилт нь байх ёстой л мэт ойлгогдож, тэр бүү хэл социализм нуран унасны дараа хүртэл олгогдох ёстой мэт иргэд ойлгожээ. МЭХ-ны ажил аль хэдийнээ бэхэжсэн байгууллагуудаар дамжин нийтэд хүрч байлаа. Тухайлбал, дунд сургууль (8-18 насны, 1-10 дугаар ангийн сурагчид), Хувьсгалт Залуучуудын Эвлэл, Залуу Пионерын Байгууллага зэрэг нь охид, хөвгүүдэд сурч боловсрох, зохион байгуулах болон

³¹ Либерал феминизм болон бусад олон төрлийн феминизм үзэл санаагаа түгээн дэлгэрүүлэх нь үндсэн зорилго байдаг тул энэ мэт үл харагдах үйлдлийг хүлээн зөвшөөрдөггүй. Гэсэн хэдий ч, Монголд болон бусад газар социалист эмэгтэйчүүдийн байгууллагын хувьд төрийн бодлогын хүрээнд эмэгтэйчүүдийнхээ амьдралын чанарын дээшлүүлэх нь гол зорилго байсан юм.

³² Хувьсгалт Залуучуудын Эвлэл 1921 онд, Залуу Пионерын Байгууллага 1925 онд байгуулагджээ.

манлайллын ур чадвараа хөгжүүлэх боломж олгож байв³². Сургууль болон бусад байгууллагад охид хөвгүүдийг тэгш эрхийн үндсэн дээр удирдлагын болон бусад албан тушаалд хуваарилах сонирхол байсан юм. Тухайлбал, пионерын удирдагч залуучууд болон концерт хөтлөгчид дандаа хосоороо байдаг байжээ.

Миний мэдэх зарим эмэгтэй улс төрч өмнө нь Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн, Залуу Пионерын Байгууллагын дарга, эсвэл ангийн дарга, үлгэр жишээ сурагч байсан байдаг.³³ Хүүхэд байхдаа залуучуудын, пионерын үйл ажиллагаанд оролцсоноор тэд олон нийтийн өмнө ярих, ятган үнэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, хүнтэй танилцах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах гэх мэт манлайллын ур чадварт суралцжээ. Эдгээр ур чадвар нь тэдэнд эргээд улс төрийн карьерт нь чухал байв. Эмэгтэйчүүд олон нийтийн өмнө биеэ авч явах, итгэл төгс сонгуулийн кампанит ажил явуулах, тайзан дээрээс үг хэлэх, сонгогчидтой болон өндөр тушаалын удирдагуудтай уулзаж танилцах зэрэг Монголчууд огтхон ч эргэлзэдэггүй эмэгтэй улс төрчдийн эзэмшсэн ур чадвар нь ч мөн социализмаас улбаатай. Эмэгтэйчүүд олон нийтийн дунд нэвтэрч орох, тэдний гаргасан амжилтыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, эрчүүдийн адил ажил хөдөлмөр эрхлэх, дээд боловсрол эзэмших, эмэгтэйчүүдийг тодорхой түвшинд анхаарах, эрх мэдэлд хүрэх зэрэг нь ердийн хэм хэмжээ болсон нь социализмын үед бий болсон нийгмийн амьдралын томоохон өөрчлөлт юм.

Монголд тэгш эрхийн зарчим нь хийсвэр сонсогдох гэлээ ч эмэгтэйчүүд улс үндэстний чухал хэсэг тул нийгмийн болон мэргэжлийн бүхий л түвшинд ижил оролцох ёстой гэх ойлголтыг нутагшуулах, хүлээн зөвшөөрөх, хэлэлцэхэд ач тусаа өгсөн юм. Тэгш байдлын талаарх үг яриа нь эмэгтэйчүүд нийгмийн харилцаанд орох, социализмын үед феминист субъект болж төлөвшихөд үзэл санааны болон эрх зүйн үндэс суурийг бий болгосон. МЭХ-ны үе үеийн удирдагчид энэ байгууллагыг авч үлдэхийн төлөө тэмцэж, үндэсний хэмжээний эрэгтэй удирдагчдадаа эмэгтэйчүүдийн ач холбогдлыг таниулах, тэднийг бодлогоор дэмжих ёстой гэдгийг ойлгуулах, үнэмшүүлэх ажлыг хийсээр байсан юм. Монгол эмэгтэйн улс төрийн субьектив шинж байдал нь нэг талаас МЭХ-г татан буулгах гэсэн байнгын оролдлого нөгөө талаас байгууллага хадгалах, хамгаалах гэсэн эмэгтэйчүүдийн цуцашгүй тэмцлийн үр дүн юм. МЭХ-ны ажилтан, идэвхтэн нар эмэгтэйчүүдийн эрхийг сурталчлах, лоббидох, аливаа санал боловсруулах, удирдлагаа ятгахад оролцож байсан тул дийлэнх нь яваандаа улс төрд идэвхтэй оролцох болжээ.

Эмэгтэйчүүд улс төрийн субьект бий болж төлөвшихөд төрийн бүтэц,

³³ Тухайлбал, Дашжамцын Арвин 2000-2012 оны хооронд УИХ-ын гишүүний алба хашиж байсан бөгөөд улс төрийн карьераа Ардын армийн 231-р хэсгийн Залуучуудын Эвлэлийн дарга, дараа нь Улаанбаатарын Залуучуудын Эвлэлийн гишүүнээс эхлүүлсэн юм. Төгсжаргалын Ганди 1992-2008 оны хооронд УИХ-ын гишүүний алба хашсан бөгөөд Улаанбаатар хотын Залуучуудын Эвлэлийн дарга байсан юм (Gerelsuren and Altai 2008, 24 and 52). УИХ-ын гишүүн асан (2000-2004) Норловын Болормаа Монголын Пионерын байгууллагын тэргүүн байсан юм (Gerelsuren and Altai 2008, 40).

зохион байгуулалт, цаг хугацаа, орон зай, улс төрөөс гадна жендэрийн тэгш байдлын зарчмыг бодит үйлдлээр, тухайлбал, нийтийн орон зайд хамруулснаар маш ач холбогдолтой байжээ. Магадгүй улсын удирдагчдаас ирэх үл тоомсорлол, эсэргүүцлийг аргалан тэгш байдлын зарчмыг өдөр тутмын ажил үйлдэлд шингээсэн нь чухал. Тэгш байдлын зарчмыг сургуулийн арга хэмжээний үеэр, пионерийн уулзалт, жагсаалын үеэр, эмэгтэй хүн ажлын байр, байгууллагадаа ажил хөдөлмөрөө үнэлүүлж, шагнал хүртэх үеэр төдийгүй, эмэгтэйчүүдийн баярын өдрийн арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүдэд төрөл бүрийн хэлбэрээр төрийн албан ёсны үг хэллэгт суурилан илэрхийлж нийтэд хоногшуулж байжээ.

Ардчиллын эрин үеийн эмэгтэй улс төрчид өөгүй дүр төрх, төгс бэлтгэсэн үг яриа, хүчирхэг хувцаслалтаараа сонгогдохуйц болох гэж хичээж буй нь Маргарет Тэтчер, Хилари Клинтон, Сара Палин зэрэг барууны эмэгтэй удирдагчдыг санагдуулах төдийгүй неолиберал, ардчилсан, шинэ Монголын нүүр царай гэлтэй. Тэдний социализмын үед олж авсан хүмүүжил нь залуу үеийнхэнд өөрийгөө таних, илэрхийлэх, болон кампанит ажил зохион байгуулах ур чадварт нөлөөлжээ. Эдгээр эмэгтэйчүүдийн субьектив шинж байдал нь социализм болон сүүлийн үеийн ардчиллын үйл явц, түүнийг дагалдах олон улсын хэм хэмжээ, олон улсын төрийн бус байгууллагуудын дэмжлэг тусламжаар тодорхойлогддог. Монголын ардчилсан сонгуульд эмэгтэйчүүд оролцож ирсэн туршлагыг судлахын тулд, эмэгтэйчүүд рүү чиглэсэн бодлогын хэрэгжилт эмэгтэй хүний субьектив шинж байдалд хэрхэн нөлөөлж буйг онцлон авч үзлээ. Дэлхийн хоёрдугаар дайны үед цэргүүдэд тусламж хүргэхээр Новосибирск МЭХ-ны орон нутагт дахь салбар нэгжийн идэвхтний айл хотлын эмэгтэйчүүдэд тэгш эрхийн зарчмыг дамжуулан ярьж байсан ярианаас, хамрах хүрээ нь цөөн тооны онцгой мэргэжилтнүүдээс хол илүү давсан МЭХ-ны үйл ажиллагаанаас, мөн феминист удирдагч Янжмаа гуайн ярианаас залуу Сосор урам зориг авч боловсрол эзэмшихээр шийдсэн билээ. Тиймээс, үндэсний социалист эмэгтэйчүүдийн байгууллагын өргөн цар хүрээтэй боловч, шууд бус сургал ухуулгаар дамжуулан эмэгтэйчүүдийг дэмжих ажил нь одоо бодоход, тэдний нийгэмд эзлэх, ялангуяа төрийн өндөр албан тушаалд хүрч болох урт удаан аяллын төлөө тасралтгүй хэрэгжүүлж байсан кампанит ажлын нэг хэсэг байжээ.

Сонгуульжилт: Засаглал ба ардчиллын шинэ эдийн засгийн хэлбэрүүд

Хөөрсөн улс

2008 оны 5-р сар буюу УИХ-ын сонгууль болохоос ганцхан сарын өмнө би судалгааныхаа гол оролцогчийн нэг Сэржээгийн орон нутагт өрнүүлсэн кампанит ажлыг (дэлгэрэнгүйг 4-р бүлгээс) ажиглаад буцаж явлаа. Энэ номд Хангай, Нараа гэж нэрлэх хосууд шинэхэн авсан Тоёота Ланд Круйзерээр хүргэж өгье хэмээн найрсаг урилаа.¹ Тэд бол бидний хэлж заншсанаар пи-арчид (PR гэх үгээс гаралтай) буюу хэд хэдэн нэр дэвшигчидтэй ажиллаж байсан улс төрийн зөвлөхүүд юм. Буцах замдаа бид бензин авах, хоол унд идэх, хөнгөн зууш, ус зэргийг авахаар жижигхэн сууринд саатлаа. Хаа ч явсан ирж буй сонгууль, нэр дэвшигчдийн талаарх хүмүүсийн яриа сонсогдоно. Хүмүүсийн эдгээр яриа зарим нь төвийг сахисан шинжтэй, гэтэл заримдаа бүр маш ширүүн өрнөнө. Сэдэв нь улс төрчдийг өмссөн, зүүснээр нь шоглох маягтай.

Дараа нь зам зуур зогсож саатахдаа би хүн бүр сонгуулийн кампанит ажил, түүний эргэн тойронд болж буй үйл явдлыг, тэгэх тусмаа улсын өнцөг булан бүрд, хамгийн алс нутагт хүртэл зөвхөн сонгуулиар амьсгалж, сонгууль л ярьж буйг хараад гайхсанаа хэлэв. Хангай хариулсан нь:

Харин тийм ээ, солиотой байгаа биз? АНУ болон бусад ихэнх улс орнууд бидэн шиг сонгуульждаггүй байх л даа. Хүн бүр нь ингэглээ сонгуульжилгүй, өдөр тутмынхаа ажлаа мөр мөрөөрөө хийгээд, сонгууль

¹ Аль алиных нь нэрийг нууцалж, хуурамч нэр ашиглав.

нь ч хэрхэн болох ёстой, тэр хэрээрээ л болдог байлгүй. Харин бид улс даяараа сонгуульжаад л.

Хангай хэлсэн сонгуульжаад гэх үгийн сүүлийн хэсэгт “аа” хэмээх урт эгшгээ бүр онцлон хэлсэн нь инээдтэй сонсогдовч, тэрээр шинээр зохиосон нэр томъёондоо сэтгэл хангалуун байгааг илэрхийлэх мэт. Миний бодлоор сонгуульжих гэх үг нь улс орны өнөөгийн байдлыг маш оновчтой илэрхийлж байлаа. Улс төрийн зөвлөх хүн өөрөө сонгуульжуулах ажилд гар бие оролцож буй мөртөө тус үгийг хэлсэн нь егөөтэй. Түүний мэдэл, нөлөөнөөс хол илүү өргөн хүрээтэй улс орныг бүрхсэн сонгуулийн хүчийг тодорхойлохын тулд тэрээр сонгуульжих гэдэг үг ашигласан ч байж болох.

Хуулиар тогтоосон “сонгуулийн сурталчилгааны хугацаа”-нд төдийгүй, сурталчилгааны бус хугацаанд далд байдлаар сонгуулийн кампанит ажил өрнөсөөр тэр нь сонгуулиас сонгуулийн хооронд бат бөх оршсоор байдаг Монголын нөхцөл байдлыг ойлгуулах зорилгоор “сонгуульжилт” гэх үгийг энэ номд ашиглалаа. Сонгуулийн санал авах өдөр хүртэлх 21 хоногийн сурталчилгааны хугацаанд улс орон даяар нэр дэвшигчид сонгогчидтой хийх уулзалт, жагсаал болон зураг, дүрс, дуу чимээ, улс орон тэр чигээрээ сонгуулиар амьсгална. Өнгөн талдаа дараагийн сонгууль хүртэлх дөрвөн жилийн хугацаанд (мэдээж сурталчилгааны 21 хоногийг оруулахгүй) сурталчилгаа явуулах нь хуулиар хориотой тул хэвийн амьдрал үргэлжилнэ. Гэвч, хандивын болон тэмдэглэлт үйл ажиллагаа, баяр ёслол ивээн тэтгэх, орон нутгийн үйлчилгээ, тэр бүү хэл гамшгаас аврах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэг ил тод биш хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа өрнөж, сонгууль дөхөх тусам цаад зорилго нь улам тодорно. Сонгуулийн бус үеийн эдгээр үйл ажиллагааны ард сонгуультай холбоотой санаархал буйг бараг бүгд мэддэг боловч, ихэнх хүмүүс идэвхтэй оролцдог. Далд сурталчилгааны эдгээр арга хэмжээнүүд төрийн, бүр заримдаа хувийн хэвшлийн өдөр тутмын үйлчилгээ хүргэх бүтцийг ашиглах бөгөөд, шүдний эмнэлгээр төлбөргүй үйлчлэх, гадаад хэлний үнэгүй дамжаа нээх, гадаадын их дээд сургуулиудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөрийн өрсөлдөөн зэрэг байдлаар илэрнэ. Ингэснээр шинээр цугларалт, соёлын хэм хэмжээ, нийгмийн давхарга, субъектив шинж байдлыг бий болгож байдаг.

Сонгуульжилт бол нийгмийн халамжаар амьдардаг ард иргэдээс өгсүүлээд хамгийн баян хүмүүсийн амьдралд хүртэл нөлөөлсөөр байдаг, тасралтгүй үргэлжлэх, албан ёсны сонгуулийн сурталчилгааны үеийн хөөрлөөс хавьгүй гүн гүнзгий үйл явц юм. Сонгуульжилт гэх ойлголтоор би сонгууль бол одоогийн болон ирээдүйн элитүүдийг улс төрийн эрх мэдэлд хүргэх үйл явц төдийгүй социализмын дараах Монголын нийгмийн амьдралыг тодорхойлогч гэдгийг харуулахыг

хүслээ. Энэ бүлэгт, би сонгуульжилт нь сонгуулийн хооронд бүтэн дөрвөн жилийн турш шахуу үргэлжлэхдээ шинэ технологи, нийгмийн сүлжээгээр дамжин ард түмний амьдралын хамгийн хувийн орон зайд хүртэл нэвчсээр байдаг, тасралтгүй үргэлжлэх кампанит ажил болох талаар өгүүлнэ. Сонгуульжилт нь хүмүүсийн санаа бодол, цаг хугацаа, мөнгө, амьдралын хэв маягийг өөрчилж, сэдэв, субъектив шинж байдлыг тодорхойлж, ертөнцийг үзэх үзлийг бүтэцлэж, шинэ анги, шинэ нийгмийн хэм хэмжээ, танигдахуйг бүтээж байдаг. Сонгуульжилт тогтвортой үргэлжлэх нь гажуудал ч гэмээр болсон төдийгүй, оршин буй харилцааны гүнд, тэр бүү хэл төр ард түмнээ засаглах туршлагад хүртэл гүн нэвчин орж, ялагчдад төдийгүй бараг нийгмийн амьдралын бүхий л оролцогчдод шинэ туршлага, түүнээс үүдэлтэй үр дагавруудыг тулгах болжээ. Сонгуульжилт нь социализмын дараах улс төрийн хэлбэрийг тодорхойлж буй шинэ төрлийн засаглалын механизм болж хувирсан гэхэд хилсдэхгүй.

Гэсэн ч, сонгуульжилт нь эмэгтэй нэр дэвшигчдэд үзүүлэх нөлөө нь эрс тэс байна. Улс үндэсний хамгийн том үйл явдал ч гэж хэлмээр олныг хамруулсан хөөсрөлт эмэгтэй нэр дэвшигчдэд ч орон зайг нээж өгчээ. Сонгуулийн өргөн далайц нь нэгэнт эмэгтэй нэр дэвшигчид ч өрсөлдөх боломжтой гэх хэм хэмжээг бий болгов. Гадна талаас нь харвал сонгууль хэн бүхэнд зориулсан мэт. Харин дотор талаас нь ажихад, кампанит ажлын өргөн далайц, сүр жавхлан нь эмэгтэй нэр дэвшигчдэд саад учруулна. Учир нь сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр сонгогчдын сонирхлыг татахын тулд сонгуулийн кампанит ажлын хэлбэр, хэмжээ, цар хүрээ нь жинхэнэ засгийн газар, жинхэнэ төрийн албан тушаалтнууд мэт ажиллахыг шаарддаг. Нэр дэвшигчид сонгогчдын дунд өөрсдийгөө таниулах, нам дотроо ч нэр хүндээ бэхжүүлэхийн тулд элдэв буяны, болон хандивын арга хэмжээ, бүлгийн уулзалт зэргээр дамжуулан сонгуулийн бус цаг үед ч (ил тод сурталчилгааг хуулиар хориглосон үед) гэсэн далд сурталчилгаа хийх хэрэгтэй болно. Сонгогдсон гишүүд нь өөрсдийн тойрогт төсөв (элдэв сангийн мөнгөн дээр нэмж) хуваарилахад, сонгогдохоор горилж буй нь хувийнхаа хөрөнгийг зарцуулна. Бусад улсын туршлагаас ялгаатай нь олон нийтээс сонгуулийн санхүүжилт босгодоггүй, нэр дэвшигч сонгуулийнхаа зардлыг өөрөө л хариуцах тул парламентын суудал горилох нь, хувийн зардлаараа дүүрэг удирдахтай адил. Энэ тогтолцоо нь сонгогдсон төлөөлөгчид болон маш их мөнгөтэй хүмүүст ээлтэй. Хамгийн ашигтай, том бизнес эрхлэгчид нь голдуу улс төрийн өндөр албан тушаал хашдаг, эсвэл өндөр албан тушаалтнуудтай түншийн холбоотой эрчүүд байх тул тэдний давамгайлсан улс төр, сонгуулийн тогтолцоо нь аль хэдийнээ гадуурхагдаж буй эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүгийн дарамт л нэмнэ.

Энэ бүлэгт нэр дэвшигч, сонгогчдоос өгсүүлээд, сонгуульд саналаа

өгдөггүй хүмүүс гэх мэт олон төрлийн тоглогч хэрхэн сонгуулийн кампанит ажлын хэмжээ, хамрах хүрээ, байнгын үргэлжлэх шинж чанарыг бүтээлцэж, өдөр тутмын амьдралд нэвчин ороход нөлөөлдөг талаар харуулна. Тиймээс эхлээд би сонгуульд өрсөлдөж буй эмэгтэй нэр дэвшигчдийн нөхцөл байдал, сонгуулийн амлалтаас илүүтэй бодит үр дүн хүлээх болсон сонгогчдын хүлээлтийн талаар тоймлон өгүүлнэ. Ингэснээр, Монголын сонгуульд эмэгтэй нэр дэвшигчид өрсөлдөхөд юу нь, яагаад тийм хэцүү байдаг талаар хариулт өгөх юм. Нэгдүгээр бүлэгт, 20-р зууны хоёрдугаар хагаст эмэгтэйчүүдийн нийгмийн болон улс төрийн оролцоо хүлээн зөвшөөрөгдсөн талаар, болон МЭХ-ны эмэгтэйчүүд хойч үеэ улс төрийн идэвхтэй субъект болгохын тулд хүчин чармайлт гаргаж байсан талаар өгүүлсэн. Харин энэ бүлэгт ардчилалтай зэрэгцэн бий болсон шинэ нөхцөл байдал, сонгуулийн кампанит ажлын албан болон албан бус үйл ажиллагаанууд, сонгуулийн кампанит ажил сонгуульжилт болж өргөжсөн зэрэг нь эмэгтэйчүүдэд хэрхэн шинэ хүлээлт, сорилт үүсгэж буй талаар өгүүлнэ. Эмэгтэй нэр дэвшигчид хэр их бэрхшээлийг даван туулж буйг ойлгохын тулд сонгуульжилт гэдэг үг ямар өргөн хүрээтэй болохыг уншигчид маань ойлгоосой гэж хүсэж байна. Энэ талаар дараагийн бүлгүүдэд мөн ярилцах болно.

Сонгуулийн кампанит ажил, институтууд байнгын бүтэц болохын зэрэгцээ, сонгууль ч өнөөгийн институтуудад нэвчин оржээ. 21-р зууны эхэн үеийн Монголд сонгууль, түүнийг дагалдах кампанит ажлаар тэтгэгддэг, түүнээс хамаарал бүхий улс төрийн шинэ тогтоц үүсэж бүрэлдсэн гэж би үздэг. Нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд неолиберализм, ардчилал, социализм, болон бусад ойлголтын талаар өнөөг хүртэл удаан хугацаанд судалж буйтай харьцуулахад энэхүү аргумент маань гэнэтийн байж болох. Өнгөрсөн хугацаанд, улс төрийн тогтоц гэх ойлголт нь хатуу удирдлагаас салахын тулд үгүй ядахдаа алсын хараа бүхий философичдын чиглэл дор хийсэн хувьсгалын үр дүнд бий болдог байсан билээ.

Улс төрийн тогтоц бий болох талаар Доминик Боер “Арван ес, хорьдугаар зууны үеийн гол улс төрийн хөдөлгөөноос (анархизм, фашизм, либерализм, популизм, социализм гэх мэт) хэлбэрийн хувьд заавал онцлом ялгаатай байх шаардлагагүй. . . ардчиллын шинэ хэлбэрийг эрэлхийлэх явцад анархи ч бай, либерал ч бай, эсвэл бүр социалист ч бай хэлбэрийн ардчилал бий болох нь хүний санаанд оромгүй зүйл байхаа больсон шүү” (2013, 284-85) гэжээ. Боер 2010-аад оны эхэн үед өрнөсөн үйл явдлуудад (Арабын хавар, Эрхшээх хөдөлгөөн, нео-Боливарианизм болон бусад) үндэслэн тус аргументаа дэвшүүлсэн нь Монголын хөрсөнд ч нийцдэг. Социализмын дараах улс төрийн тогтоц нь түр зуурын шинжтэй сонгуулийн практик, сонгуулийн кампанит ажлаар тодорхойлогдож байна. Сонгууль нь анхныхаа зорилгоос ихээхэн өргөсөж, байнгын шинжтэй үйл явц болж буй бөгөөд (2000-аад

онд хуулиар зөвшөөрсөн 21 хоногийн сурталчилгаанаас хол давсан), үр дүн нь ч илүү удаан хадгалагдахын сацуу нийгмийн амьдралын бүхий л салбарт нөлөөлж буйг би энэ бүлэгт үзүүлэхийг зорилоо. Монголын эдийн засаг улс төрөөс, ялангуяа сонгууль угтсан улс төрөөс маш их хамаардаг. Сонгуулиар материаллаг зүйлс үйлдвэрлэх, эдийн засгийн болон засаглах чиг үүргийг сонгууль руу чиглүүлснээр сонгууль нь сонгуульжилт гэх үйл явц болж хувирав. Сонгуульжилт нь одоогийн улс төрийн бүтцээс завсарлага авах хэрэгсэл биш. Харин сонгуульжилт нь өнөөгийн нийгэм, соёл, эдийн засгийн зохицуулалт, тэдгээрийг дагалдах субъектив шинж байдлын үр дүнд бий болсон төлөвлөгөөгүй явцаас урган гарсан улс төрийн тогтоц билээ.

Дан ганц УИХ-ын сонгуулиас болж сонгуульжих үйл явц байнгын өрнөх болсон уу гэвэл бас тийм биш. Орон нутгийн болон ерөнхийлөгчийн сонгууль мөн адил дөрвөн жил тутамд болдог нь сонгуулийн кампанит ажилтай холбоотой бүтэц, институтийг улам бэхжүүлдэг.² Тиймээс, эдгээр сонгуулийн давтамж, тасралтгүй үргэлжлэх байдал нь энэхүү шинэ тогтцын үндсийг бэхжүүлсээр байна. 1990 онд социализм нуран унаснаас хойших 30 жилийн хугацаанд Монголд УИХ-ын 9 (1990-2020), Ерөнхийлөгчийн 7 (1993-2017), орон нутгийн 8 (1990-2020) нийт 24 удаагийн сонгууль болжээ. Хэд хэдэн тойрогт сонгуулийн үр дүнгийн маргаанаас болж дахин сонгууль явуулж байлаа. Энэ номд гагцхүү УИХ-ын сонгуулийн талаар судалсан боловч, УИХ-ын сонгуультай ижил хэмжээний өрсөлдөөнтэй болж, мэргэжилтэн, тэдний ашиглах техник, технологиуд нь улам боловсронгуй болсоор, илүү ухаалаг баг ажиллаж, УИХ-ын сонгуулийн кампанит ажилд нөлөөлсөөр ирсэн тул энд ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийг зориуд дурдлаа. Эдгээр гурван төрлийн сонгуулийн кампанит ажил албан ёсны сонгуулийн сурталчилгааны үеэр ч, сонгуулийн бус үед далд хэлбэрээр ч өмнөхөөсөө илүү нүсэр болсоор ирсэн гэдгийг тэмдэглэе.

Сонгууль нь зүгээр ч нэг дуу чимээ ихтэйгээр үргэлжилсээр байдаг үйл явдал биш. Сонгууль маш олон хүний амьдралд төрөл бүрийн хэлбэрээр гүн бат нөлөөлсөөр байдаг. Гүн бат нөлөөлдөг гэснийг тайлбарлахын тулд Хангай, Нараа хоёрын амьдралын хэв маяг, орлого, субъектив шинж байдал нь хэрхэн өөрчлөгдөж ирсэн талаар ярьж өгье. Нараа, Хангай хоёртой би анх 2005 онд танилцсан юм. Сонгууль болгоны дараа эднийх гэх айл байр суурийн хувьд ч, материаллаг хэрэгцээний хувьд ч үргэлж ахисаар иржээ. 2005 онд тэд хотын захын, нэг өрөө хуучны байрнаас дөнгөж хотын төвийн, Зөвлөлтийн үед баригдсан хоёр өрөө байранд нүүж ирээд байлаа. Тэд 1990 оноос хойш Монголын улс төрчдөд зөвлөсөөр ирсэн бөгөөд 2004 оны сонгууль тэдний хувьд онцгой

² Орон нутгийн сонгууль УИХ-ын сонгуулийн жилийн намар нь, харин ерөнхийлөгчийн сонгууль дараа жил нь болдог. Гэвч 2016 оны сонгуульд аймаг, нийслэлийн сонгууль УИХ-ын сонгуультай хамт, сум, дүүргийн сонгууль нь намар болсон юм.

үр өгөөжтэй байжээ. Нараа жолоо барьдаггүй тул ойр зуур зорчихын тулд такси барина. Тэрээр сэтгүүлчээр ажиллах сонирхолгүй болсон тул нэг бол УИХ-ын сонгуульд нэр дэвших, үгүй бол уран зөгнөлт зохиол бичих талаар бодож эхэлсэн байлаа. 2005 оны ерөнхийлөгчийн сонгуулийн дараа, 2008 оны УИХ-ын сонгуулийн өмнөхөн тэднийх хоёр өрөө байрнаасаа цоо шинэ баригдсан, Улаанбаатар хотын төвд ойр байрлах хамгийн үнэтэй хороололд таван өрөө байранд нүүж оржээ. Бүтэн цагийн жолооч авсан төдийгүй, охиноо ч Зүүн Азийн нэгэн улсад их сургуульд сургах болж. 2012 оны УИХ-ын сонгуулийн дараа охиноо Баруун Европт сургахаар шилжүүлжээ. Харин 2016 оны сонгуулийн дараа уулзахад тэднийх Улаанбаатар хотын ойролцоо томоохон газар худалдан авч шинэ байшин барьж байсан юм. Хангай цоо шинэ, хар өнгийн Жийп Вранглер машинаараа бидэнд үйлчиллээ. Тэрээр “Манай эхнэрийнх (Жийп машин хэлж байна) цагаан өнгөтэй, гэхдээ ноднингийн загвар л даа” гэж хэлээд инээмсэглэв.

Жилийн 2000 доллар хүрэхгүй шахуу цалинтай (1990-ээд оны сүүлээр) хоёр сэтгүүлчийн гэр бүл 12 жилийн дотор дээд зиндааны айл болон хувирлаа. Дан ганц эдийн засгийн хувьд ч биш, амьдралыг таашаах мэдрэмж, амьдралын хэв маяг нь хүртэл дэлхийн хамаг л үнэтэй газрууд руу амрахаар явж, өдөр бүр дасгал хийх, массаж, сувиллаар үйлчлүүлэхээс өгсүүлээд бүрэн өөрчлөгдөв. Баруун Европт их сургуулийн боловсрол эзэмшиж, Европ найз залуутайгаа тэндээ тааваараа амьдарч байгаа охин, дуртай ажлаа тааллаараа хийн амьдарч байгаа эхнэр, Улаанбаатарт хувийн олон улсын сургуульд сурах бага охиноо бодож, Монголын нийгмийн хамгийн чинээлэг хэсэгт байр сууриа эзэлснээрээ Хангай үргэлж бахархдаг байлаа.

Айл өрхийн энэ зэргийн өсөлт, дэвшил нь эдийн засгийн өндөр хөгжилтэй, хөгжилгүй байлаа ч эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн зам нь тогтвортой, ил тод байдаг улс орнуудад хэвийн үзэгдэл байх. Хувийн бизнес өндөр хөгжсөн, тогтсон хэм хэмжээнээс гадуурх боломж ихтэй, тус боломж хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг газарт ч айл өрх өсөн дэвших нь тийм ч хачирхалтай үзэгдэл биш биз. Хангай, Нараа хоёрын өсөлтөд хүрсэн зам нь яагаад онцлог байна гэхээр тэднийх ардчиллын үйл явц эхлэхтэй зэрэгцээд тэд (болон бусад улс төрийн зөвлөх, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, судалгааны болон зөвлөх багийнхан хамаарна) өөрсдийнхөө хөрөнгийг бараг л зөвхөн сонгуулийн кампанит ажлаар л цуглуулж чадсан юм. 2000-аад оноос хойш сэтгүүлчийн цалин өсөж базаасангүй. 2018 он гэхэд дийлэнх сэтгүүлч бүтэн цагаар ажиллаад жилдээ 3000-6000 доллар л олдог байв. Хамгийн чухал нь Хангай шиг сонгуулийг боломж болгосон хүмүүст үйлдвэр, худалдааны салбарт ч гэсэн мөнгө олох асар олон боломж нээгддэг. ДНБ цойлж өссөн 2011 онд ч, зогсонги байдалд орсон 2015 онд ч, өөрөөр хэлбэл эдийн засгийн савлагаанаас үл хамааран

сонгууль хамгийн ашигтай салбар хэвээр буй нь үл үзэгдэх хүч байгааг илтгэнэ. Сонгуулийн ажил бусад салбартай харьцуулахад олох мөнгө нь баталгаатай. Энэ нь УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хувьд сонгуулийн кампанит ажлаа тогтвортой явуулахын тулд мөнгөний тогтмол урсгалтай байх наад захын шаардлагаас гадна боломжтой бол Хангай, Нараа шиг чадварлаг зөвлөхийг ажиллуулах болон бусад тоолж барамгүй олон арга хэмжээг санхүүжүүлэх шаардлагатай болно. Ийм байдал нь шинэ болон эмэгтэй нэр дэвшигчдэд том сорилт болдог нь харамсалтай.

Пи-арчдын цалин хөлсний талаар албан ёсны мэдээлэл байхгүй боловч, тэд 2008 онд нэг сонгуулийн кампанит ажилд дунджаар 10-30 мянган ам.долларын цалин авч байсан гэх мэдээ бий (харьцуулахад, дээд боловсрол эзэмшсэн Монгол хүний жилийн дундаж орлого 3000 ам.доллар орчим байлаа). Сонгуулийн эдийн засгийн пирамидын оройд нь сонгуулийн зөвлөхүүд заларна. Сонгуулийн пи-арчинтай зэрэгцээд кампанит ажлын менежер, имижмейкэр, хувийн туслах, хэвлэл мэдээллийн ажилтан, ухуулагчид, судлаачид, болон пи-артай холбоотой, холбоогүй “мөлхөө ухуулга” (нэр дэвшигчийнхээ талаар энгийн яриа хөөрөө өрнүүлж явдаг хүмүүс) хийх, сонгогчдоо бүртгэх, нягтлах гэх мэт олон төрлийн ажлын байр бий болжээ. Энд сонгуулийн үеэр нэмэлт орлого олох боломжтой олон төрлийн ажлаас хэсэгчлэн жагсаасан болно. Шатахуун түгээх станц, орон нутгийн зочид буудал, хэвлэлийн компани зэрэг олон бизнесүүд сонгуулиас үл хамааран оршин тогтнох боловч сонгуулийн үеэр орлого нь олон дахин нэмэгдэнэ. 20-р зууны эхээр үндэстнийхээ хувьд тусгаар тогтнолоо сэргээж, орчин үетэй хөл нийлүүлэх боломж тавигдсан цагаасаа эдийн засаг, дэд бүтцээ хөгжүүлэхээр чармайсаар ирсэн Монгол Улсад сонгууль эдийн засгийн шинэ салбар болон хувирсан юм.

Сонгуульжилтын талаарх товч түүх

Сонгуульжилт бол орон нутгийн, геополитикийн, дэлхий дахины байдал, үйл явцын илэрхийлэл юм. Сонгуульжилтыг барууны маягийн ардчилал, чөлөөт сонгууль, неолиберализмыг суурьшуулсны үр дүн төдийгөөр хязгаарлаж ойлгох нь өрөөсгөл. Саяхны болон тэртээд өнгөрсөн цаг үеийн соёлын туршлага, үзэл бодлын олон талт байдал, сонгуулийн хуулийн нэмэлт өөрчлөлт, сайжруулалт, ТББ, иргэдийн бүлэг, улс төрийн намын дэвшүүлсэн яриа, хэлэлцүүлэг бүгд нийлээд сонгуулийн туршлагыг хэлбэржүүлж, өнөөгийн бидний өдөр тутмын амьдралын нэг хэсэг болоход нөлөөлсөн юм.

1990-ээд онд Монголд үндэсний тусгаар тогтнолд санаа зовох, ардчиллыг неолиберализмтай хоршуулах, социализмаас илүү дээр тогтолцоо руу шилжих гэсэн итгэл үнэмшлийн үндсэн дээр ардчилал

эхэлсэн.³ Ардчилагдах үйлэвц Монгол орон улс төрийн илүү тохиромжтой тогтолцоонд шилжихээс гадна олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, шинэ холбоотон татах боломж байсан юм. Олон улсад холбоо, сүлжээгээ өргөтгөх нь Хятад, Оросоос хараат бус байх замыг баталгаажуулна гэж олон хүн итгэж байлаа.⁴ Сонгууль нь ардчиллын үндсэн элементийн нэг байдаг тул, ардчилсан замаар сонгогдсон Монголын шинэ удирдагчид чөлөөт сонгуулийг амжилттай нутагшуулсан туршлагаа барууны хэвлэл мэдээллээр харуулах сонирхолтой байв. 1990 онд ардчилалд шилжсэнээр Монголчуудыг ямар тавилан хүлээж буйг мэдэхгүй шахуу байсан ч гэсэн, ардчилалд тэмүүлэх нь Зөвлөлт Холбоот Улсын нөлөөг багасгахад чиглэж байсан тул ард түмэн чин сэтгэлээсээ дэмжиж байсан юм.

Неолиберализм ардчилалд тодорхойгоор нөлөөлсөн. Бусад посткоммунист орнуудын нэгэн адил Монгол Улс тусламж, дэмжлэг авахад тавигдах шаардлага хангахын тулд бүтцийн өөрчлөлтийн бодлого буюу Вашингтоны Зөвшилцлөөр тохирсон шинэчлэл явуулахыг хичээж эхлэв. 1990-ээд онд Зөвлөлт Холбоот Улс газрын тос, бусад татаасанд хориг тавьсан учир Монгол үндэстэн тэсэж үлдэхийн тулд эдийн засгийн тусламж амин чухал байсан юм.⁵ Чөлөөт худалдаа бий болгох, үнийг чөлөөлөх, төрийн өмчийг хувьчлах зэрэг шинэчлэлийг дээрээс доош чиглэлд, үндэслэл багатай, тайлбаргүй шахуу, ил тод бус, хэт яарч хийв. Иргэд бүхэл бүтэн дүүрэг, сууриныг хамарсан, томоохон хэмжээний ядуурлыг урьдчилан харж чадахгүй байсан тул ямар нэг эсэргүүцэл гарсангүй. Нэгдүгээрт, иргэд тухайн үеийн хямрал түр зуурынх гэж бодож байсан ч, зарим утгаараа “шилжилт” дуусаагүй билээ (Buyandelger 2013; Buyandelgeriyn 2008; Pederson 2011; Rossabi 2005). Хоёрдугаарт, эрх чөлөө, өөрийнхөө хэрэгцээг өөрөө хангах, өмчлөх эрх зэрэг неолиберал санаачилга нь 1990-ээд онд социализмыг нуран унагахад хөтөлсөн иргэдийг хэт хараат, сул дорой, бэлэнчлэх сэтгэлгээтэй гэсэн шүүмжтэй сайхан авцалдав. Социализмыг дэмжих

³ Би 1989 оны 11-р сард Монгол Улсын Их Сургуулийн оюутан байхдаа Залуу Уран Бүтээлчдийн Улсын Хоёрдугаар Чуулганд оролцох үед чуулганы оролцогчид Монгол Улсын улс төр, эдийн засгийн байдал, Зөвлөлт Холбоот Улс, Хятадтай харилцах харилцааны талаар хэлэлцэж байлаа. Чуулганы үеэр хэд хэдэн эвсэл байгуулагдав. Үүнээс хэдхэн долоо хоногийн дараа нэг намын засаглалыг эсэргүүцэх, ардчиллыг дэмжигч хэд хэдэн бүлгүүд бий болсон юм.

⁴ Дуламын Бум-Очир (2018, 2019) Монгол Улс зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх гэхээс илүүтэй тусгаар тогтнолоо баталгаажуулах улс төрийн шалтгаанаар капитализмыг хүлээн авсан гэжээ. Гэвч уул уурхай хөгжихийн хэрээр нэг талаар, барууны ардчилсан орнуудтай хөгжүүлэх улс төрийн харилцаа эдийн засгийн нарийн төвөгтэй үр дагавруудыг бий болгов. Нөгөө талаар Оросууд бүрэн алга болоогүй төдийгүй нөлөөтэй хэвээр байна. 1990-ээд оны эхээр Монголоос цэргээ гаргасны дараа үеэс 2000-аад он хүртэл Монгол дахь Оросын оролцоо хязгаарлагдмал байсан ч, худалдаа, цэргийн сургуулилт, болон бусад талбарт үргэлжилсээр байсан юм. Монголын уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор Оросын Засгийн газар Монголд улс төр, эдийн засгийн сонирхлоо нээлттэй илэрхийлж “Хятадтай хамтран Монголын төмөр замын маршрутыг Хятадтай хамтран хянах шинэ Их Тоглоомыг эхлүүлэв” (Bulag 2009, 99-103).

⁵ Хилари Аппел, Митчел А. Орсенстэйн (2018) нар посткоммунист улс орнууд Барууны тусламжийн мөнгийг авах, олон улсын эдийн засгийн интеграцид оролцохын тулд ямар нэг эргэлзээгүйгээр неолиберал шинэчлэлийг хийдэг гэжээ. Харин Монголд Зөвлөлт Холбоот Улсаас тавьсан хориг нь бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүргэсэн (Bum-Ochir 2020).

Капиталист мөлжлөгийн талаарх Марксист онол хурдан мартагдав. Марксизмын оронд чөлөөт зах зээлийн талаарх Милтон Фридманы онол гол зарчим болох нь тэр.⁶ Гуравдугаарт, колоничлолын эсрэг хүчин чармайлтын хүрээнд Монгол Улс геополитикийн сул талаа бэхжүүлэхийн тулд АНУ гэх мэт хүчирхэг улстай ардчилал, зах зээлийн харилцаа хөгжүүлэхээр эрмэлзэж байв. Тийм ч учраас Монгол Улс хүндрэлийг үл ажран, хүлээлтээ биелүүлэхээр шийджээ.⁷

Хүн амын дийлэнхийн, ялангуяа ажилчин ангийн хувьд төрийн өмчийг яаралтай хувьчлах нь улсын үйлдвэрүүдийн төгсгөл болж, тэр хэмжээгээрээ маш олон ажлын байр үгүй болж, амьжиргаанд нь нөлөөлжээ (Hann 2006). Энэ талаар Лхамсүрэнгийн Мөнх-Эрдэнэ (2012) тогтвортой байдал, эрх зүйн сүлжээгээ устгаж, ялангуяа аж үйлдвэрийн төвүүдээ татан буулгаснаар Монголчууд Зөвлөлтөөс хараат байдлаа, барууны капитализмаас хараат байдал болгож өөрчилсөн гэжээ. Эр, эм гэлтгүй нийт иргэдийн амьдрал эрс өөрчлөгдөв. 1990-ээд оны үед хувийн хэвшилд ажиллах нөхөн үржихүйн насны ээжүүд баталгаатай ажлын байргүй байсан тул эрчүүдийнхтэй харьцуулахад амьдрал нь илүү дорджээ (Robinson and Solongo 2000). Ядууралд хамгийн их нэрвэгдсэн хүн амын дийлэнх хувийг өрх толгойлсон эх, хүчээр тэтгэвэрт гарсан 35-55 насны эмэгтэйчүүд эзэлж байлаа (Burn and Oyuntsetseg 2001). Эмэгтэйчүүд гол төлөв хүүхэд харах гэх мэт гэр орны үүрэг хүлээх тул эрсдэл хүлээх шинэ соёл, тодорхойгүй байдлаар дүүрэн капитализм эрэгтэй бизнес эрхлэгчдэд илүү таатай байсан юм. Төрийн үйлдвэрлэл хувьд шилжсэнээр эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд тусалж байсан төрд суурилсан тэднийг дэмжих тогтолцоо үгүй болжээ. Социализмын үед эрэгтэй, эмэгтэй аль аль нь цалин авдаг байсантай харьцуулахад өрхийн эдийн засаг, хөдөлмөрийн хуваарь, нөөцөө хянах зэрэг гэрийн асуудалд эрчүүд илүү давамгайлж эхлэв. Маш олон эмэгтэй ажилгүй болсон тул ажлын байранд суурилж байсан хүрээлэл, хамт олноо ч алджээ. Харин байдал дээрдэж бизнесийн шинэ салбарууд бий болох үед, ялангуяа 2009-2014 оны хооронд эдийн засаг үсрэнгүй хөгжсөн жилүүдэд эмэгтэйчүүдэд ч олон боломж гарч ирсэн (Empson 2020). Хэдийгээр олон хүний амьдрал өөдөлсөн боловч, эдийн засгийн үсрэнгүй өсөлт нь баялгийн хүртээмжийн тэгш бус байдал, ялангуяа жендэрт суурилсан баялгийн тэгш бус хуваарилалтыг сүйдтэй өөрчилж чадсангүй.

1990-ээд онд эхэлсэн нийгмийг хамарсан ядуурал нь улс төрийн намууд, нэр дэвшигчдэд өмнө нь социализмын үед төрөөс олгож байсан зарим үйлчилгээг санал болгох бололцоог нээж өглөө. Тэд ч дэмжигчдийн

⁶ Милтон Фридманы Хувь заяагаа сонгох нь (1980) ном неолиберал бодлогууд хэрэгжиж эхлэх үед Монгол хэлэнд (Friedman 2001) орчуулагдсан юм.

⁷ 1990-ээд онд ардчиллын үйл явц эхлэх үеэр зарим ардчилсан удирдагчид Скандинавын орнуудын улс төр, нийгмийн загварын дагуу ардчилсан социалист нийгэм байгуулахыг оролдож байсан ч, АНУ-ын неолиберал загварыг чиглэн өөрчлөгджээ.

сүлжээг амжилттай босгож, үнэнчээр дэмжих сонгогчдыг татаж чадсан. Улс төрийн намууд бизнес эрхлэгчдийг намдаа элсүүлж, нэр дэвшүүлэх замаар дараагийн сонгуулийг нь санхүүжүүлэх бизнес эрхлэгчдийн нөөцийг бүрдүүлж эхэлжээ.⁸

Шинээр гарч ирсэн улс төрчид нүүдэлчид, малчидтай ойр ажиллаж, улс төрийн зорилгоор ураг төрөл, угсаатны бүлэг, нутгийн иргэдийн сүлжээг босгох болов (Sneath 2010; 2018, 123). Зарим улс төрчид сонгогчдыг татахын тулд ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хандив, бэлэг хүртэл тараана. 1990-ээд онд банк, зээлийн тогтолцоо, дэд бүтэц, мэдлэг нь хангалттай байгаагүй тул ажилчин анги бизнес эрхлэх боломж туйлын хязгаарлагдмал, бараг л боломжгүй байсан бөгөөд эдгээр тогтолцоо аажмаар бүрдсэн юм. Тийм учраас, татаас, тусламж, намын шугамаар хүрэх хандив, тэр бүү хэл ажилд оруулах амлалт хүртэл орон нутгийн ихэнх сонгогчдод таалагдана.⁹

Ардчиллын үеийн сонгуулийн ач холбогдолтой болоход социализмын үеийн сонгуулийн уламжлал ихээхэн нөлөөлжээ. Социализмын үеийн сонгууль нь, Монголоос бусад олон газар судалгаа хийсэн антропологичдын үздэгээр төрөө дээдлэх иргэний улс төрийн зан үйл бөгөөд үндэсний бэлгэ тэмдэг, төрийн байгууламж, нийт нийгмийн эв санааны нэгдэл зэргийг хослуулах талбар байсан юм (Abeles 1988; Brink-Danan 2009; Lomnitz, Adler, and Adler 1993; McLeod 1999; Moore and Meyerhoff 1977, 14). Монголд зарим ахмадууд Сонгуулийн Өдөр хамгийн сайхан дээл, хувцсаа өмсөөд баяр хөөртэйгөөр оролцдог нийгмийн чухал тэмдэглэлт өдөр байсан талаараа дурсана. Хөдөө орон нутагт иргэд уран дарханы хийсэн үнэтэй эмээл, хазаараа гайхуулахаар хамгийн сайн хүлгээ унана. Социализмын үед тэмдэглэлт баяр ёслолын шинжтэй байснаа ардчиллын үед өрсөлдөөнтэй, динамик үйл явдал болж өөрчлөгдсөн ч гэлээ Монголчууд сонгуулийн туршлагатай байсан. Өөрөөр хэлбэл, ихэнх улс оронд ардчилсан сонгуулийг нутагшуулахад сонгох, сонгогдох эрхийг, сонгуульд яагаад бүх нийт оролцох ёстойг, арай бага боловсролтой иргэддээ сонгогчийн боловсрол олгохыг эрхэмлэдэг бол Монголд энэ бүхэн аль хэдийнээ бий болсон байлаа.

Социализмын үеэс уламжлагдсан төрийн захиргааны иж бүрэн, динамик бүтцийг ашиглан Монголд сонгогчдыг бүртгэх, сонгогчдын бүртгэлийг хянах, шинэчлэх тогтолцоо нь санал хураах үйл явцад хувь нэмрээ үзүүлжээ. 18 буюу түүнээс дээш насны иргэн бүр (Иргэний улсын бүртгэл хариуцсан байгууллага бүртгэнэ) автоматаар

⁸ Микал Клима (2019) Зүүн болон Төв Европын зарим газарт хурдацтай хөгжиж буй неолиберализм, түүнээс үүдэлтэй ядуурал нь шинээр бий болсон улс төрийн намууд үнэнч дагагчидтай болох, бэхжүүлэх боломжийг нээж өгчээ.

⁹ Элиса Кол-Гаррити (2019, 125) бэлэг өгөх замаар ивээн тэтгэх үзэгдлийг түүхчлэн тайлбарлажээ. Чин улсын засгийн газар шаталсан зэрэг бүхий үнэнч байдалд суурилсан, эзэн эзэндээ үнэнч байх тогтолцоог бэлэг, хүндэтгэлээр дамжуулан институцилжээ. “Бэлэг сэлт, санхүүгийн дэмжлэг хэлбэрээр Чин улсын хаан, эсвэл Монгол ноёд биесээ хүндэлж буйг илэрхийлэх бөгөөд хүндэтгэлээ илэрхийлэх илгээмж нь цаашлаад хүү, охидоо хооронд нь суулгах байдлаар үргэлжилнэ.

сонгогчдын жагсаалтад бүртгэгдэнэ. Би сонгогчдын нэрийн жагсаалтыг боловсруулахаар сонгуулийн тойрогт ажиллаж байсан хэд хэдэн хүнтэй гүнзгий ярилцлага хийсэн юм. 1990-ээд оны эхээр буюу цахим өгөгдлийн санг ашиглах тухай төсөөлж ч байгаагүй үед эдгээр ажилтан айл айлын хаалга тогшиж, оршин суугчдыг хаяг дээрээ амьдарч буй эсэхийг шалгаж, хувийн мэдээллийг нь холбогдох маягтай тулгах замаар сонгогчдын нэрсийн жагсаалтыг шинэчилдэг байжээ. Эдгээр ажилтан нь сонгуулийн бус үеэр ч тухайн дүүрэг, хороонд ажиллаж, амьдардаг, бүртгэж буй оршин суугчдынхаа талаар мэддэг байсан тулдаа бүртгэлээ амжилттай хөтөлдөг байжээ. Сонгогчдын бүртгэл үнэн зөв эсэхийг ахин дахин нягтлах эдгээр ажилтан санал хураах үйл явцыг иргэдийн амьдралд ойртуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.¹⁰ Тиймээс, сонгуульжилт нь орон нутгийн болон дэлхий дахины үйл явц төдийгүй, социалист уламжлалтай ч, орчин үеийн ардчиллын түүхтэй ч үндсээрээ холбогддог. Сонгуульжилт нь ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих хүндхэн шилжилтийн үеийн төдийгүй, иргэд өөрсдөө сонгуулийг өдөр тутмын амьдралынхаа нэг хэсэг болгосны аль алины нь үр дүн мөн билээ. Өмнө нь дурдсанчлан энэ бүгд эмэгтэй нэр дэвшигчдийн оролцоонд хүндрэл учруулж буй нь мэдээж. Өөрөөр хэлбэл, сонгогчдын субъектив шинж байдалд сонгууль илүү гүн нөлөө үзүүлж буй нь төрийн тогтолцооноос хальсан, сонгууль дагасан, түр зуурын шинжтэй удирдлагын хэв шинж бүрэлдээд байна.

Улс төрийн кампанит ажлын санхүүжилт бол Монгол УИХ-ын сонгуулийн хамгийн булингартай хэсэг юм. Олон улсын шинжээчид төдийгүй маш олон Монголчууд зохицуулалтгүй цугтах мөнгөний урсгал, авлигатай холбоотой дуулиан шуугиан нь ардчилалд бодит занал учруулж байна гэж үздэг (Burcher and Bertoa 2018).¹¹ Олон нийтээс хөрөнгө босгох механизм хязгаарлагдмал, хууль эрх зүйн зохицуулалт нь олон цоорхойтойгоос гадна хэрэгжилт сул нөхцөлд сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг мөшгөх аргагүй. Шинэ нэр дэвшигчид, хэдийн сонгогдсон гишүүдийн өрсөлдөөнийг тэнцвэржүүлэх зорилгоор сурталчилгааны хугацааг багасгаж, хэвлэх зурагт хуудасны тоог хязгаарлах гэх мэт хуулийн зохицуулалтууд хүссэн үр дүнд хүргэсэнгүй.

Тухайлбал, 2008, 2012, 2016 оны сонгуулиудад албан ёсоор сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа сонгуулийн өмнөх 21 өдөр гэж

¹⁰ 1990-ээд онд засаг захиргааны нэгжүүд (дүүрэг, хороо, хэсэг) сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах үүрэгтэй байлаа. Эдгээр нэгжийн ажилчид тухайн хэсэгтээ амьдрах бөгөөд айл бүрийн хаалга тогшиж сонгогчдын нэрс цуглуулж нэгтгэдэг байжээ. 2007 оноос хойш Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) гэх хараат бус байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтыг хариуцах болов (Chimidi 2008, 100-110). Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар эхний жагсаалтыг гаргаж СЕХ нягтлан шинэчлэх ёстой. Гэвч, СЕХ сонгогчдын нэрсийг нягтлан шинэчлэхэд засаг захиргааны анхан шатны нэгжийн тусламжийг авахаас өөр аргагүй.

¹¹ 2010 оноос хойш өндөр түвшний улс төрчид авлигын хэрэгт холбогдсон тохиолдлууд хэд хэдэн удаа олон нийтийн дунд шуугиан тарьсан. <https://country.eiu.com/article.aspx?articleid=617373245&Country=Mongolia&topic=Politics>. 2020 оны 1-р сарын 1-нд үзсэн.

Авлигын эсрэг олон жагсаал болдог ч 2018 оны 12-р сарын 27-нд томоохон жагсаал болов. “Энхболд болон бусад улс төрчид 60 тэрбум төгрөг (23 сая ам.доллар) босгохын тулд төрийн албан тушаалуудыг худалдахыг санаархсан гэх хэргийн талаар иргэдийн бухимдал олон жилийн тур нэмэгдсээр байна” (Munkhchimeg 2018).

хуульчилсан боловч албан бус, далд сурталчилгаа сонгууль хоорондын дөрвөн жилийн хугацаанд үргэлжилсэн юм. Дөрвөн жилийн хугацаанд улс төрийн намууд нэр дэвшигчдээ аль хэдийнээ албан бусаар урьдчилан сонгоно. Урьдчилсан сонгон шалгаруулалтыг ротацид орох хэмээнэ. Ротацид орж чадсан гориллогчид нь албан бусаар урьдчилсан кампани т ажил өрнүүлнэ. Энэ үед нэр дэвших эсэх нь, нэр дэвших тойрог нь ч гэсэн албан ёсны сонгууль хүртэл баталгаатай гэсэн үг биш. Тиймээс, нэр дэвшихээр гориллогчид нь өөрийнхөө нэрийг сонгуулийн саналын хуудаст бичигдэх хүртэл буюу нэр дэвшигчдийг албан ёсоор тодруулах хүртэл өрсөлдсөөр байх тул урьдчилсан кампанит ажил ч мөн өрнөсөөр байдаг. Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэх хүртэл, урьдчилсан кампанит ажлын баг, бүтэц нь аль хэдийнээ байрлалаа эзлэн, бэлдэнэ. Кампанит ажил нь нэр дэвшигчээсээ шууд хамааралтай тул эмэгтэй нэр дэвшигчдэд илүү төвөгтэй байдал бий болгодог. Ялангуяа сонгуулийн кампанит ажил нь төрийн зарим үүргийг давхар гүйцэтгэж эхлэхэд, албан тушаалгүй шинэ нэр дэвшигчид болон эмэгтэй нэр дэвшигчид хоцорч үлдэх магадлалтай. Иймээс л сонгуульжилт эмэгтэйчүүдийг нэг талаар нээлттэй байдлаар дэмжиж байгаа мэт боловч, маш их бэрхшээл үүсгэдгийг харуулсаар байна.

Сонгуулийн бус үеийн урьдчилсан сурталчилгаа, сонгуулийн үеийн албан ёсны сурталчилгаа товхимол тараах, телевизийн сурталчилгаа хийх гэх мэт маш олон ажлын байр, нэмэлт орлого олох боломжийг бий болгодог. 1990-ээд оноос хойш сонгуулийн зохицуулалт, сонгуулийн үйл явцыг хянах тогтолцоог бий болгох гэсэн урт удаан хугацаанд сонгуулийн кампанит ажил бизнес болон хувирчээ. Сонгуулийн кампанит ажил нь олон нийтийн төдийгүй хувийг амьдралыг эзэрхийлж, нийгэм, улс төрийн амьдралын хамгийн гол үйл явдал болсон нь анхны зорилгоосоо хол хөндийрчээ.¹² Уул нь улс орон сонгуулиа удирдан зохион байгуулдаг бол, сонгуульжилт нь эрчимжиж Монгол Улсыг удирдан залахад хүрчээ. Сонгуульжилт нь засаглалын хийсвэр хэлбэр биш, харин эрх мэдэлд хүрэх, хүсэх, шаардах, чиглүүлэх, эсэргүүцэх хувь хүмүүсийн нөлөөгөөр хэлбэржиж байдаг, түр зуурын гажуудсан байдал юм. Улс орны, дэлхийн болон геополитикийн хүч сонгуульжилтыг дэвэргэж байдаг бөгөөд би дараагийн хэсгүүдэд төрөл бүрийн гол тоглогчид хэрхэн сонгуулийн кампанит ажлыг өөрсдөө ч мэдэлгүй өргөсгөж, гүнзгийрүүлж байдаг талаар өгүүлнэ.

Нэр дэвшигчид: суудлаас олон ялагч

Үр дүнд нь хүчирхийлэлд хүргэдэггүй сонгуулийг амжилттай сонгууль гэнэ, хэмээн Антропологич Жон Борнеман (2011) тодорхойлжээ. Тэр, сонгуульд

¹² Хэдийгээр улс төрийн намууд сонгуулийн санхүүгийн тайлангаа Сонгуулийн Ерөнхий Хороонд (СЕХ) өгдөг боловч, СЕХ-ны албан хаагчид болон сонгуульд хяналт тавьдаг ТББ-ын гишүүд улс төрийн намын тайланд итгэхийн аргагүй гэдгийг надад хэдэнтээ дурдаж байсан юм. Ерөнхийдөө сонгуулийн санхүүжилт судлахад маш хэцүү, хаалттай сэдэв хэвээр байна.

“ялагдагч” нь “хохирсон” мэдрэмжгүй, харин ч сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрч, ялагчдаа баяр хүргэж байвал сонгууль амжилттайд тооцно гэжээ. Улс төрийн шинжлэх ухаан, Америкийн улс төр зэрэг салбар ухааныг судалсны үндсэн дээр Борнеман (2011) сонгууль бол ялагчдад төдийгүй, ялагдагчдад кампанит ажил, үр дүнг хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэх ёстой гэж үзжээ. Сонгуулиар ялалт байгуулж чадаагүй нэр дэвшигчид дуулиан дэгдээж, гомдол мэдүүлж, сонгуулийн тогтолцоонд итгэл алдрахаас сэргийлэхийн тулд сонгогчдын нэрийн жагсаалт, санал тоолох, кампанит ажил явуулах зэрэг бүхий л үйл ажиллагаа нь шинэ технологи ашигладаг, сонгууль бүхэлдээ шударга, сайн зохион байгуулагдах ёстой.

Борнеман (2011) “ялагдагчдад” анхаарал хандуулж буй нь Монголын сонгуулийн кампанит ажлыг бид өөр өнцгөөс харах ёстойг сануулна. Монголд сонгуульд ялагдсан маш олон хүн “золиослогдсон” бус, харин өөрсдийнхөө хэмжээнд өөр хэлбэрээр ялсан мэдрэмжтэй хоцрох тохиолдол бий. Сонгуулийн үеэр албан ёсны 21 хоногийн сурталчилгаанаас гадна, бараг л бүтэн дөрвөн жилийн турш үргэлжлэх урьдчилсан кампанит ажил бүхий Монголын нөхцөлд ялалт байгуулна гэдэг нь хожих магадлал багатай бооцоот тоглоом мэт. Ялагдсан нэр дэвшигч хувийн хөрөнгө, нөөцөө кампанит ажилд зарцуулсан тул санхүүгийн ихээхэн хохирол амсана.

Сонгуульд ялах нь эцсийн зорилго хэдий ч олон хүн гарцаагүй ялна гэсэн гэнэн дэврүүн улс биш юм. Монголд сонгууль гагцхүү сонгогчид руу чиглэсэн, бие даасан үйл явдал байхаа нэгэнт больсон. Харин сонгууль нь улиран сонгогдохоор өрсөлдөж буй гишүүний хувьд ч шинээр өрсөлдөх нэр дэвшигчийн хувьд ч маш олон үр дагавар, боломжийг бий болгодог. Би сонгуульд ялагдагч гэж байхгүй, суудлын төлөө өрсөлдсөн бүх хүмүүс хождог гэх гэсэнгүй. Ялагч, ялагдагчийн ялгаа нь хар цагаан гэдэг шиг эрс тэс байдаггүйг л харуулах гэсэн юм. “Ялагч” гэж зөвхөн суудал авсан хүнийг хэлэхгүй. Олон нэр дэвшигч Парламентад суудал аваагүй байвч, суудлаас огт өөрөөр бас “хождог” юм. Тухайлбал, горилогч өөрийн тойрогтоо шинэ байшин барьж байна гэж төсөөлье. Тэрээр хэрвээ өөрийг нь сонгох юм бол барилгаа эмнэлгийн зориулалтаар ашиглаж, тойргийнхон нь ашиг хүртэх талаар сонгогчдодоо хэлнэ. Хэрэв өөрөө сонгогдохгүй бол барилгаа худалдааны төвийн ч юм уу зориулалтаар ашиглаж, барилгын эзэн нь ашиг хүртэнэ. Өөрөөр хэлбэл, суудал аваагүй байсан ч гэсэн нэр дэвшигч бүрэн ялагдсан гэсэн үг биш, харин сонгуулийн талбарыг ашиглан сонгогчдынхоо анхаарлыг ямар нэг байдлаар татсан гэсэн үг. Энэ мэтчилэн хүмүүс сонгууль, тэр дундаа сонгуулийн сурталчилгааг санал хураах үйл явц, өрсөлдөөнөөс гадуурх боломж болгон ашиглаж, сонгуулийн агуулгыг өргөжүүлсээр байна.

Зарим өөр жишээ дурдахад, сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигч бүр ялалт байгуулж суудал авах зорилгогүйгээр кампанит ажил эхлүүлдэг. Тэд ихэвчлэн сонгогчдын анхаарлыг сарниулах, өөр нэр дэвшигчийг довтолгооноос халхавчлах, эсвэл ялах магадлалтай нэр дэвшигчийн

саналыг хуваах зорилгоор нэр дэвшинэ. Тэд санал аваагүй гэдэг утгаараа сонгуульд ялагдана. Гэвч, иймэрхүү нэр дэвшигчид санал хуваах, сонгогчдын анхаарлыг сарниулах л үүрэгтэй оролцсоны төлөө захиалагчаасаа төлбөр авдаг тул “ялсанд” тооцож болох. Түүнчлэн, суудал авахаар өрсөлдөж буй нэр дэвшигчид албан ёсны сурталчилгааны үеэр өөрийн бие даасан байдал, өөрийнхөө гүйцэтгэлийг хянаж буй мэт сэтгэгдэл төрүүлнэ. Энэ тодорхойлолтод нийцэх нэр дэвшигч зөндөө бий. Гэвч, хамгийн чухал хэсэг нь гол улс төрийн намаас өрсөлдөх нэр дэвшигч нь сонгуулийн багийнхаа нүүр царай л болдог. Бусад дийлэнх ажлыг төвлөрсөн найруулгын дагуу шаталсан бүтэц нь хийж гүйцэтгэнэ. Нэр дэвшигчийн өрсөлдөх тойрог, тойрогтоо нийцэх байдал, нам доторх өрсөлдөөн, хэлхээ сүлжээ, нэр дэвшигчийн соёлын болон санхүүгийн байдлыг хүртэл нарийн тооцож, нөлөө бүхий хүмүүс шийдвэрлэнэ. Тийм ч учраас ялах эсвэл ялагдах нь нэр дэвшигчийн хувьд 100% гэнэтийн үр дүн байдаггүй. Жишээ дурдахад, улс төрч Оюунгэрэл, бие даасан үзэл бодолтой дуу хоолой ихтэй эмэгтэйг намын удирдлагаас “өөрт нь зохицохгүй” алслагдсан тойрогт цөлөх нь сонгуульд өрсөлдөөд ялагдаад ир гэж буйтай ижил хэмээн ярьсан юм.

Тэр бүү хэл ялах өндөр магадлалтай мөртөө ялалт байгуулж чадаагүй нэр дэвшигчид ч гэсэн дараагийн сонгуульд өрсөлдөхөд сонгогчдоо танигдах, төрийн болон хувийн өндөр албан тушаалд томилогдох, сонгуулийн кампанит ажлын мэдлэг, туршлага олж авах, хувийн сүлжээгээ сайжруулах гэх мэт давуу талуудыг олж авах боломжтой. Ялалт байгуулаагүй нэр дэвшигчдээс ирээдүйд албан тушаалд томилогдох магадлалаа нэмэгдүүлэх гэх мэт ашигтай боломжуудыг бий болгох тохиолдол байдаг. Өөр хувилбар гэж бараг байхгүй.

Намайг судалгаа хийж байх үеэр сонгуульд ялсан нэр дэвшигч өөрийн гар утсанд ирсэн зурвасыг надад харуулсан юм. Тус зурвасаас үзэхэд сонгууль бол ердөө суудал авахын төлөөх өрсөлдөөн биш харин төрийн бүх эрх мэдэл, нөөцөд хүрэхийн төлөөх тэмцэл аж. Тус зурвас УИХ-ын гишүүн байж байгаад, 2012 онд ялагдсан нэр дэвшигчээс, дөнгөж ялалт байгуулаад байсан өөр нэр дэвшигчид (нэг тойрогт хоорондоо өрсөлдөөгүй бөгөөд нэг намаас нэр дэвшсэн улс төрчид байв) ирсэн зурвас байв. “Надад нэг яам өгөх арга байна уу? Би А юм уу Б яамыг авмаар байна” гэсэн зурвас байлаа. “Хэрэв эдгээр яамдын сайд нар тодорхой болсон бол надад шинээр яам байгуулж өгч болох уу? В, Г, эсвэл Д яамны аль нэгийг, эсвэл Г, Д хоёр яамыг нийлүүлж нэг яам болгоод авмаар байна. Өөр ямар яам, агентлагууд даргагүй байгаа билээ?” гэх зэргээр үргэлжилнэ. Ялсан нэр дэвшигч маань эдгээр зурвасыг надад чангаар уншиж өгөнгөө хүн бүхэн л надаас ямар нэг юм хүсэж, шаардах боллоо хэмээн гомдоллов. Хэдийгээр зурвас илгээсэн нэр дэвшигч УИХ-ын гишүүний болон сайдын суудал аваагүй ч түүний бизнесийн карьер үндэсний болон олон улсад нөлөөлөхүйц өргөжин цэцэглэсэн юм. Бизнесийн энэхүү боломж нь түүний улс төрийн карьераас шалтгаалсан эсэхийг таамаглах боломжгүй ч, нас нь ахиж байсан тус нэр

дэвшигч, сонгуульд суудал авснаар улс төрд нөлөөлөхүйц байх нь бас л тодорхойгүй байсан юм.

Сонгуулийг хувьдаа ашиглан, сонгуулийн далимаар хувийн боломжуудыг үүсгэж буй нь сонгуулийг анхны улс төрийн зорилгоос хэрхэн холдуулж байгаа гэдгээр жишээнүүдээс харж болно. Тиймээс, орчин үед дэлхий даяар сонгууль маш түгээмэл болсон нь ялагдагчдаа анхаарч хүчирхийлэлгүй, техникийн дэвшлийг ашиглаж амжилттай явагдаж байна гэх Борнеманы (2011) дэвшүүлсэн аргументтай санал нэгдэж буйн зэрэгцээ сонгуулийн үр өгөөж нь гишүүний суудал авахаас хол давсан учраас сонгууль ийм өргөн шинжтэй байгаа гэж би үзэж байна. Гэвч нэр дэвшигч сонгуулиас юу ч хожихгүй байх ч бий. Нэр дэвшигч суудал авахгүй, өөрийгөө таниулахгүй, дараагийн сонгуулийн алхмаа бэлдээгүй ч байж болно. Гэсэн хэдий ч, энэ тохиолдолд сонгуульд өрсөлдөхийг мөрийтэй тоглоом тоглохтой зүйрлэж болох бөгөөд үүнийг тоглох сонголт хийснээрээ сонгуульжих үзэгдлийг бэхжүүлж байдаг. Нэр дэвшигчдийн туршлагын талаар номын энэ бүлгийн эрх мэдлээ хадгалагчдын талаар өгүүлсэн хэсэгт илүү дэлгэрэнгүй өгүүлнэ.

Сонгогчид: Амлалт бус үр дүнг хүлээх нь

Сонгогчдын оролцоогүйгээр сонгуульжих боломжгүй. Монголын сонгууль сонгогчдынхоо оролцооны хувиар дэлхийд дээгүүрт ордог. 2000-аад оноос хойш сонгуулийн ирц буурсаар буй хэдий ч дунджаар 70 орчим хувь байна.¹³ Тус үзүүлэлт нь өндөр түвшний улс төрчдөд сонгогчид итгэл алдарсан, авлигын томоохон дуулиантай, сонгуулийн луйврын хардалтаар дүүрэн Монголын нөхцөлд гайхам өндөрт тооцогдоно. Сонгогчдын дийлэнх нь сонгуулийг хайхрахгүй орхих бус харин ч идэвхтэй оролцож байна.¹⁴ 2008 оны сонгуулийн дараа зохион байгуулалттай эсэргүүцлийн жагсаалыг төрийн хүч хэрэглэн зогсоосон явдал Монголчууд гудамжинд гарч жагсах, нийгмийн сүлжээгээр дамжуулан улс төрийн оролцоогоо илэрхийлэх байдлыг зогсоосонгүй.

¹³ Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороо. 2017 он. <https://www.gec.gov.mn/>. 2021 оны 3-р сарын 8-нд үзсэн.

¹⁴ 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа Улаанбаатар хотын төвд болсон жагсаал цуглаан, үймээн нь сонгуулийн үр дүнг луйвардсан гэх буруутгалаас үүдэн сэтгэл дундуур сонгогчдын хамгийн ноцтой жишээ юм (Branigan 2008; Delaplace, Kaplonski, Sneath 2008).



Дүрс 2.1 Нэр дэвшигч уулзалтаа эхлүүлэхийг хүлээж буй сонгогчид. Улаанбаатар хот. 2008 он. Зургийг Нэргүйн Баасанхүү.

Сонгуулийн механизмын шударга байдал, сонгогдсон удирдагчдаа итгэл алдарсаар байгаа хэр нь хүмүүс яагаад саналаа өгсөөр байна вэ? Антропологич Мукулика Банерже (2014) Энэтхэгт улс төрчдөдөө итгэл алдарсан хэдий ч сонгуулийн ирц өндөр буй үзэгдлийг сонирхон судалжээ. Банерже (2011, 81) сонгууль бол шинэ улс төрчдийг оруулж ирэх үүд хаалга байдаг гэх мэт сонгуулийн эерэг талыг мэддэг тул Энэтхэгийн сонгогчид сонгуульдаа идэвхтэй оролцдог хэмээн тайлбарласан. Түүнээс гадна, Энэтхэгийн олон нийгэд сонгууль ариун байр суурь эзэлдэг аж (Banerjee 2007). Энэтхэгийн сонгуулийн өдөр бол “цаг хугацааг түр зогсоож шинэ цагийг бүтээдэг, өдөр тутмын амьдралд бодитоор оршин байдаг шударга бус тэгш бус байдлыг түр ч болтугай умартаж, нийт үндэстнээрээ бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ багт наадам хийж тэмдэглэдэг” (Banerjee 2014,3) ер бусын үйл явдалд тооцогддог. Судлаач Скотт Саймон (2010), Мишель Обейд (2011) нар сонгууль бол гадуурхагдсан буюу угсаатны бүлгүүд төртэй яриа хэлэлцээ өрнүүлэх, өөрчлөлтийг бий болгох боломжтой үйл явдал хэмээн үздэг гэх санааг дэвшүүлсэн. Эдгээр бүхий л үзэл санаа Монголд ч хамаарна. Сонгогчдын саналыг л татах зорилготой сонгуулийн кампанит ажил улс орны өнцөг булан бүрийг хэрж, иргэн нэг бүрд шахуу хүрдэг тул хөдөөгийн иргэдийн дийлэнх нь өмнөх шигээ шинэчлэлээс хоцрогдсон мэт мэдрэмж авдаггүй (дүрс 2.1). Кампанит ажлаар дүүрэн “сонгуулийн үе” нь заримдаа Дюркхеймийн тодорхойлсон хамтын эрмүүн дэврүүн байдлыг бий болгодог (1995, 212-17).

Сонгуулийн кампанит ажил сонгогчдыг санал өгөхөд нь түлхэц өгөх хүч болохоос гадна, бэлэг, хандив өгөх, улс төрийн үйл ажиллагаанд оролцуулах хэлбэрээр хийсвэр болон бодит боломжийг бий болгож байдаг. “Санал худалдаж авах”, “Сонгуулийн авлига”, эсвэл “ивээн тэтгэлэг” гэх мэтээр нэрлэгдэх эдгээр үзэгдэл нь олон бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд олон төрлөөр илэрнэ. Тухайлбал, хандиваар дамжсан авлигын хэлбэр нь ардчиллыг элээж буй үзэгдэл давтагдсаар байна, гэх мэт Азийн сан болон бусад Барууны институтүүдийн шүүмжлэлийг ардчиллын төлөөх бүлгүүд, хувь хүмүүс нь ихэнхдээ дэмжин дуурайсаар ирсэн (Ledeneva 2006; Туяа 2012 зэрэг бүтээлээс энэхүү шүүмжлэлийн жишээг харж болно). Улс төрийн нөхцөл байдал, эрх зүйн сул зохицуулалтаас шалтгаалдаг ч гэсэн хэрхэн төрөл бүрийн үйл ажиллагаа нь авлигад тооцогдож болох тухай, авлига гээч зүйл ямар ээдрээ, төвөгтэй ойлголт болох талаар судлаачид тэмдэглэжээ.

Тухайлбал, улс төрийн намууд Монголд авлигаас урьдчилан сэргийлэх бүтэц байхгүй, зохицуулалт сул төдийгүй чухам ямар үйлдлүүдийг авлигын төрөлд тооцох тухай хангалттай зохицуулалт байхгүй байна гэж үзэж байх үеийн 2004 оны сонгуулиар авлигын тохиолдлууд гарсаар байв (Bayantur 2008; Туяа 2005). Заримдаа хөрөнгө өвлүүлэхгэхмэтхарьцангуйшударгасанагдахуйцүйлдэлхүртэлхэдийгээр авлига гэх ангилалд хамаарахгүй боловч авлигын хэлбэр байх боломжтой (Herzfeld 2015). Улс төрийн хамгийн эрх мэдэл бүхий хүрээлэлд хандив өргөх нь сонгуулийн кампанит ажлын үеэр сонгогчдодоо бэлэг тараахтай адилгүй бөгөөд илүү үнэнч байдлыг илэрхийлнэ. Харин сонгогчдод бэлэг сэлт өгөхөд өргөн холбоос хэрэгтэй төдийгүй, эргээд сонгогчид шууд үүрэг хүлээх байдал ч мөн үүсдэггүй. Түүнчлэн, сонгуулийн санхүүжилттэй холбоотой авлигын хэргүүд тэс өөр ангилалд хамаарна.

Энэ хэсэгт гарын бэлэг, хүнсний бүтээгдэхүүн, цаг, хуанли, аяга, ном гэх мэт сонгуулийн сурталчилгааны үеэр элбэг тараагддаг зүйлсийн талаар авч үзье. Гарын бэлэг, хандив авсан сонгогчид нь үнэхээр бэлэг өгсөн хүндээ үнэнч байж, саналаа өгдөг талаар ямар нэг нотолгоо байхгүй ч Монголчууд эдгээр бэлэг, хандивыг “санал худалдан авах” гэсэн зүйл хэмээн шүүмжилдэг. Эндээс нийгмийн арай өндөр боловсролтой хэсэг авлигын талаар нийгмийн болон цаг хугацааны хил хязгаарыг тогтоодог нь харагдаж байна. Тодруулбал, тэд ардчилсан институтийн хууль, дүрэм журмыг дагах бөгөөд бэлэг сэлт өгөх нь феодалын үеийн, хоцрогдсон, ичгүүртэй үйлдэл гэж үздэг. Нийгмийн илүү боловсролтой хэсэг бэлэг авч буй сонгогчдыг ч нэгд сул дорой, хоёрт шударга сонгуулийн төлөөх бусдаасаа урваж буй хэмээн шүүмжилнэ. Майкл Херцфэлд (2018: 54-55) Грек, Италийн туршлагыг судлаад авлигын түр зуурын шинж байдлыг харилцан адилгүй ойлгосноос ямар үйлдлийг авлига гэж үзэх, үзэхгүй талаарх маргаан үүсдэг талаар тайлбарлажээ. Хандивлагчдаа үнэнч байхыг илүүд үздэг хүмүүс хандив нь хууль бус үйлдэл биш, үгүй

ядахдаа хөнөөл багатай гэж үзнэ. Энэ хандлага нь гэм нүглийн талаарх номлолыг сарниулж байдаг. Харин бусад хүмүүс “ёс суртахууны хууль ёсны ойлголтыг дагаж . . . аливааг ёс суртахууны болон эрх зүйн үүднээс шүүн тунгаах нь төрийн чадамжаас хамаарна” (2018, 54-55) гэж үздэг. Монголын залуучууд цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж буй нь тэд хууль ёсны байдлыг дээдлэх, үндэсний бахархлаа олон улсын агуулгаар ойлгож, өрсөлдөөнт нийгмийг бүтээх эрмэлзэл зэргээс нь мэдрэгддэг.

Залуус сонгуулийн сурталчилгааны хүрээнд бэлэг тараахын эсрэг тэмцэж буйн нэг тод жишээ бол 2019 онд Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн оюутнууд, Нийгэм, Улс төрийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулсан “Улс төрчдийн гарын бэлэг” хэмээх үзэсгэлэн юм (Namuun 2019). Биечлэн болон гэрэл зургийн үзэсгэлэн хэлбэрээр зохион байгуулагдсан тус арга хэмжээнд хоолны аяга, кофены аяга, цаг, хуанли, хүнсний бүтээгдэхүүн зэрэг зүйлсийг цуглуулан үзүүлжээ. Үзэсгэлэнгийн дараах мэдээний доор “саналаа худалддаг” хүмүүсийг жигшихийн зэрэгцээ хүмүүс яагаад ийм өчүүхэн зүйлсээс болж саналаа худалддагийг гайхсан сэтгэгдэл голцуу үлдээсэн байлаа. Үзэсгэлэнг тайлбарлагчид голчлон “санал худалдан авах”-ыг оролдох нэр дэвшигчдийг буруушаах бөгөөд, харин сонгогчдыг аяга, цаг гэх мэт өчүүхэн зүйлсээр саналаа худалддаггүй байлгүй гэж таамаглана. Гэвч, тэд сонгуулийн механизмыг сайжруулах илүү чухал зорилгын төлөө энэ мэт гарын бэлэг тараах үйл явцыг бүхэлд нь зогсоох зорилготой аж.

Улс төрчид, Барууны ажиглагчид, жуулчид, ТББ-ын гишүүд зэрэг зарим хүн хэрэв өөр үр дүнтэй суваг байхгүй нөхцөлд “бэлэг өгөх” замаар нөөцийг хуваарилах нь тийм ч муу хувилбар биш гэж үзнэ. Олон Монгол хүн, тэр бүү хэл гарын бэлэг, хандив зэргийг дуртай авдаг хүмүүс ч хүртэл сонгуулийн хүрээнээс гадуур, илүү албан ёсны, ил тод үйлчилгээний бүтцийг илүүд үздэг. Марисса Смит (2018) улс төрийн кампанит ажлын агуулгаар сонгогчдоо “тэжээх” нь улс төрийн эрх мэдэлд хүрэхэд шаардлагатай үйлдэл биш гэжээ. Олон нийтийн төсөөллийн судалгаанаас үзэхэд улс төрчдийг үндсэндээ ёс суртахуунгүй гэж үзэх бөгөөд тэднийг Хятад худалдаачны хувилсан дүр мэтээр зүйрлэж (Abrahms-Kavunenko 2018, 35) үндэсний ёс суртахууны гадуур байдаг хүмүүс, эсвэл муу үйлийн үрийг тээгч зэргээр үздэг байна.

Өөрөөр хэлбэл, ялангуяа залуу үеийнхэнд сонгууль бусад үйлчилгээний институтийн үүрэг гүйцэтгэдэг машин болох вий гэдгээс урьдчилан сэргийлэх хүсэл байсаар байна. Энэ нь бүтцийн тэнцвэргүй байдал, тогтолцооны гажуудал, тэгш бус хүртээмжийг бий болгохоос урьдчилан сэргийлэх хүсэл юм. Хандивын уламжлал өндөрт тогтсон Энэтхэг (Piliavsky 2014), Казакстан (Werner 2002), Киргизстан (Ismaibekova 2017) зэрэг улсад тус хандивын механизм нь нийгмийн хамгааллын үүрэг гүйцэтгэдэг. Эдгээртэй төстэй нь Монголд харьцангуй шинэ үзэгдэл боловч хандив өгөх, гарын бэлэг сэлт өгөх нь

[неолиберал капитализмын] тодорхойгүй байдлын эсрэг хамгаалалтын тор болж байна. Төрийн үйлчилгээний хангалтгүй байдал нь (ялангуяа неолиберализмаас болж төрийн халамж буурч буй нь) бүтцийн гажуудлыг үүсгэх боловч үүнийг сонгуулийн тогтолцоо орлож эхлэх нь хүсэх зүйл биш. Бэлэг сэлтээр сонгогчдын амьжиргааг бүрэн шийдэх боломжгүй бөгөөд хандивлагч-хүлээн авагчийн харилцаа нь бүтцийн томоохон гажуудлыг халхалж, тэгш бус байдал зарим тохиолдолд ялангуяа орон нутагт гажуудлыг улам даамжруулж байна. Өөрөөр хэлбэл, бэлэг сэлт өгөх асуудал улам бүр гаарч буй нь илэрхий ч иргэдийн амьжиргааны эх үүсвэрийн хувьд найдаж болох тогтолцоо биш билээ.

Бэлэг сэлт өгөх нь материаллаг нөөц тараах төдий бус нийгмийн харилцааг бий болгож байдаг. Ларс Хөөр (2019) нийгмийн харилцаа нь харилцан үйлдэл үзүүлэх дээр тогтох бөгөөд, хэрэв харилцан үйлдэл үзүүлэхээс татгалзвал зэвүүрхэл, гадуурхалд хөтөлдөг гэжээ. Тиймээс, бэлэг сэлт авах нь сонгуулийн кампанит ажлын үеэр эдийн засгийн харилцаанд орж буй хэрэг төдий бус, нийгмийн харилцаанд орж буй үйлдэл юм. Нийгмийн харилцаанд орох нь Монголд амьдрахад зайлшгүй шаардлагатай хэрэгцээ бөгөөд үүнээс татгалзвал ирээдүйд танил талгүй, эдийн засгийн хувьд бэрхшээлтэй тулгарна (Buyandelger 2018). Сонгуулийн агуулгаар, нийгмийн харилцаа нь нэр дэвшигчийг дэмжих төдийгүй, хүлээлт, хэрэгцээг үүсгэдэг дэмжлэгийн сүлжээний хэлбэрээр хэрэгжинэ. Тиймээс бэлэг сэлт өгөх үйлдэл нь сүлжээнийхээ цар хүрэнээс хамаараад нээлттэй хүлээлтийг бий болгодог. Улс төрчид сонгогчдын анхаарлыг татахын тулд хэд хэдэн төрлийн, хоорондоо харилцаа хамаарал бүхий, шаталсан шинж чанартай улс төрчдийн, орон нутгийн эрх баригчдын, сонгогчдын гэх сүлжээнүүдийг үүсгэж, бэхжүүлж байдаг нь сонгуулийн кампанит ажлын үеэр бий болж буй шинэ үр дагавар юм. Маш олон сонгогчид неолиберализмаас үүдэлтэй урьдчилж хэлэх аргагүй нөхцөл байдалд нийцэх, нийгмийн шинэ орон зайг өөртөө бий болгох үүднээс эдгээр сүлжээнд идэвхтэй оролцдог. Тийм учраас сонгогчид сонгуулийн үеэр дэмжиж буй төлөөлөгчөө сонгох сонгуулийн анхдагч зорилгоос цааш нийгмийн, улс төрийн, эдийн засгийн туршлага болгон өргөжүүлэхэд оролцож байдаг.

Гэвч сонгуулийн зорилгоор бэлэг сэлт тараадаг нь мэдээж. Лаурен Бонилла, Шагдарын Туяа нарын (2018) үзэж буйгаар сонгуулийн гарын бэлэг тараах нь нэг талаас сонгогчид нэр дэвшигчдийнхээ ёс зүйн, болон мэргэжлийн байдлыг үнэлэх боломжийг олгох, нөгөө талаас нэр дэвшигчид ур чадвар, баялгийн хэмжээгээ илэрхийлэх механизм юм. Бэлэг сэлт өгөх туршлага нь улс төрчдийн хувьд заавал хийх соёлын үүрэг биш бөгөөд илүү боловсролтой дундаж давхарга төдийгүй хүн амын дийлэнх нь “санал худалдаж авах” оролдлого гэж тооцож, маш их шүүмжилдэг. Лаурен Бонилла, Шагдарын Туяа нар цаашлаад, сонгогчдыг хараат бус, бие даасан, нөлөөлөлд өртөөгүй хувийн

дүгнэлт өгдөг гэх Барууны сонгодог онол буруу болохыг батлав. Учир нь сонгуулийн кампанит ажил маш идэвхтэй, өргөн хүрээг хамардаг ба сонгогчид үзэл суртал, прагматик хэлбэрийн амлалтаас өгсүүлээд бэлэг сэлт хүртэлх бүхий л төрлийн нөлөөнд автамтгай байдаг. Хувь хүмүүс бүхэл нийгмийнхээ хэсэг байдаг бөгөөд, тэдний сонголт нь аль хэдийнээ өөр хувь хүний сонголтод нөлөөлсөн байдаг. Харин Лаурен Бонилла, Шагдарын Туяа нар Барууны сонгодог онол нь хувь хүн нийгмээс тусгаар зөвхөн өөрийн сонголтоороо бусдаас хамаарахгүй байдаг гэсэн явцуу ойлголтоос Монголын байдал тэс өөр гэдгийг харуулав. Сонгуулийн кампанит ажил бэлэг авсан бол, ямар нэг хариу өгөх ёстой гэх мэдрэмжийг бий болгохыг хичээх боловч, сонгогчид бусад олон хүчин зүйлд суурилан өөрийнхөө шийдвэрийг гаргадаг.

Сонгуулийн сурталчилгааны хүрээнд бэлэг сэлт өгөх нь засаглалын бүтцийн динамик шинж, улам хамааралтай болж буй сонгуулийн кампанит ажлын аль алинтай нь холбогдоно. Монголын сонгууль санал солилцох зүй тогтлын логикийг өөрчилсөн гэж Элизабет Фокс (2017) үзжээ. Энэ нь дийлэнх ардчилсан улс оронд нэр дэвшигчид амлалт дэвшүүлж сонгогдоно, харин сонгогдсоныхоо дараа амлалтаа биелүүлэхийг хичээх зүй тогтлыг хэлдэг. Монголд харин эсрэгээрээ, сонгогчид өгч буй бэлэг болон сонгуулийн өмнөх бусад улс төрийн үйл ажиллагаа болон үйлчилгээнд үндэслэн нэр дэвшигчдээ үнэлнэ. Түүнчлэн, ихэнх хүмүүс улс төр болсонгогчдыг татахын төлөө өрсөлдөөн гэдгийг мэдэх тул нэр дэвшигчдийг шударга эсэхээс нь гадна өнөөгийн улс төрийн тогтолцоонд хэрхэн өрсөлдөх чадвартайгаар нь үнэлдэг.

Гарын бэлэг, хандив өгөх нь маш олон хүмүүсийн эсэргүүцэлтэй тулгардаг, барууны ардчиллын суурь зарчимтай зөрчилдөх хэдий ч, энэ үзэгдэл албан болон албан бус сувгуудаар дамжин, шүүмжлэлээс үл шалтгаалан өргөжсөөр байна. Энэ гажуудал нь ичгүүр сонжуурыг ч давжээ. Майкл Херцфэлд (2015, 351) энэ төрлийн гажуудал нь үндэстэн улсын үндсэн шинжүүдийн нэг гэж үзсэн. “Үндэстэн улсууд төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа албан ёсных нь үзэл суртал, төрийн өөрийнх нь ёс суртахуунтай зөрчилдөх үед үндэстэн улс оршин тогтнох, тэсэн үлдэх хамгийн сайн боломжоо олж авдаг” (Herzfeld 2005). Монголчууд ардчилсан сонгуульд Барууны жишигт үл нийцэх ардчилсан бус аргаар оролцож байна. Ингэснээрээ, монголчууд том, жижиг гэлтгүй хамрагдах бүлэгтээ үнэнч байх соёлыг бүтээж байна. Энэ нь Монголчуудад эрх зүйт ёсыг эрхэмлэдэг, “бие даасан” хувь хүмүүсээс бүрдэх барууны маягийн нийгмийг бүтээх бус харин нутаг дэвсгэр, ураг төрөлд суурилсан нягт холбоо сүлбээтэй бүлгийн нэг хэсэг байх боломжийг олгодог.

Цаашилбал, бэлэг өгөх, санал худалдан авах хоёрын хооронд томоохон ялгаа бий. Анастасиа Пилиавский (2014) бэлэг өгөх нь зориуд, олон нийтийн өмнө, бахархал, дуулиантайгаар хийдэг үйл ажиллагаа бол санал худалдан авах гэдэг нь шөнийн цагаар, нууцаар,

бэлэг сэлт бус бэлэн мөнгө өгөх замаар явагддаг үйл ажиллагаа хэмээн ялгааг нь нарийн тодорхойлжээ. Снит (2006) Монголд бэлэг сэлт өгөх нь үүрэг, хариуцлагын хоорондын харилцааг илэрхийлэхээс гадна нийгмийн үүрэг гүйцэтгэж буйн илрэл гэжээ. Бонила, Шагдар (2018) нар гарын бэлэг нь бэлэглэж буй хүнийх нь онцлогийг (гоймон, хуанли гэх мэт) илэрхийлэх бөгөөд бизнесийнх нь үйл ажиллагааны амжилтаас гадна цаг хугацааны байдлыг (шидрүүн өвлийг давсны дараахан гэх мэт) илэрхийлнэ гэжээ. Нэмж өгүүлэхэд, бэлэг сэлт тараах үйл ажиллагаа нь телевизийн сурталчилгаа, цахим хэвлэлээс ялгаатай нь сонгогчдынхоо гэрийн хаалгыг тогших, зэрэг илүү нүүр тулсан ажиллагааг шаарддаг. Сонгуулийн сурталчилгааны үеэр, олон нийтийн өмнө бэлэг өгөх нь хүлээн авагчдаа хүрч буйг илэрхийлнэ.

Сонгуулийн ил тод сурталчилгаа санал авах өдрөөс наана дуусаж нүргээн нь дарагдсаны дараа сурталчилгаа нам гүмээр, өдөр тутмын амьдралд аажмаар сэргэнэ. Нүргээн ихтэй сонгуулийн сурталчилгаа сонгогчдыг соронз мэт татахын сацуу нам гүм орчинд явагдах компани ажлын үйл ажиллагаа нь ч ач холбогдол өндөртэй. Эдгээр сонгуулийн кампанит ажил нь голцуу хүүхдүүдэд зориулсан Шинэ жилийн баярын цэнгүүн, ахмадуудад зориулсан Цагаан сарын хүлээн авалт зэрэг үйл ажиллагааг ивээн тэтгэхээс өгсүүлээд гадаад хэл заах үнэгүй дугуйлан ажиллуулах, тусламжийн багц тараах, тэр бүү хэл тойрогтоо усан бассейн барих зардлыг төсөв суулгаснаасаа хүртэл оноо авахыг оролдох байдлаар үргэлжилнэ. Сонгуулийн кампанит ажлын бэлэг авах, улс төрийн үйл ажиллагаануудад оролцох зэргээр сонгуулийг сонгуульжилт болгоход сонгогчид ч хувь нэмрээ оруулдаг. Энэ нөхцөл нь баян чинээлэг, эсвэл аль хэдийнээ сонгогдсон улс төрчдөд эрх мэдлээ хадгалах илүү боломжийг олгохын зэрэгцээ шинэ нэр дэвшигчид, эрчүүдтэй харьцуулахад нөөц баялаг багатай эмэгтэй улс төрчдийг шахах хандлагатай. Гэсэн хэдий боловч, зарим хүний амьдрал сонгуулийн кампанит ажлын үеэр санал болгож буй шүдний эмчилгээг үнэ төлбөргүй авах, шинэ нэр дэвшигчээс сургалтын төлбөр хүсэх зэрэг амьдралын чухал зүйлс нь улс төрчдөөс хамааралтай болжээ.

Сонгуулийн шинэ эдийн засаг: халтуурчид ба сонгуулийн мэргэжилтнүүд

Сонгуулийн кампанит ажлын хэсэг болон хөгжсөөр буй эдийн засаг нь иргэд улс төрийн удирдлагад дургүйцэх, үл тоомсорлох, тэр бүү хэл сонгуулийн механизмын шударга бус байдлыг нэмэгдүүлж буй ч гэсэн сонгууль хэрхэн, яаж өргөжин тэлсээр буйг ойлгоход тусалдаг. Энэ хэсэгт сонгууль хэрхэн хүмүүсийн эдийн засгийн амьдралд төрөл бүрээр нөлөөлж, нийгэм, эдийн засгийн оршин буй давхаргыг бэхжүүлэхийн сацуу шинэ давхарга үүсгэж, шинэ ажил

мэргэжил, шинэ харилцааг төдийгүй итгэл найдвар, эсэргүүцлийг бүтээж буй талаар авч үзнэ. Бодит үр дүнгээс гадна, хувь хүний болон үндэстний хувьд шинэ мөрөөдөл, итгэл найдвар бий болгож буй нь сонгуульжилтын үйл явцын амин чухал шинж юм. Энэ хэсэгт сонгууль хэрхэн чинээлэг хүмүүсийг бий болгодог төдийгүй, тэдгээр хүмүүс нь буурай нэгнийхээ амьдралд яаж нөлөөлж буй талаар өгүүлье. Дор өгүүлэх эдийн засгийн ялгааг тайлбарлахад дэлхийн ихэнх улс оронд байдаг л, бүр байх ёстой мэт санагдаж болох ч Монголын хувьд шинээр бий болсон үзэгдэл юм. Сонгууль хэдий чинээ сонгуульжилт болж хувирна тэр хэмжээгээр нийгмийг давхаргажуулах хэрэгсэл, засгийн эрх барьж буй бүлгийг улам бэхжүүлэх механизм болон хувирч байна.

Гудамжинд ажиллаж буй ухуулагчдаас зөвлөхүүд хүртэлх төрөл бүрийн түвшинд амьжиргаагаа залгуулахын тулд нэмэлтээр сонгуулийн ажил хийж буй хүмүүс неолиберал эдийн засгийн тогтолцооны тусгал мэт. Тухайлбал, миний судалгааны гол ярилцагчдын нэг Раднаагийн Бурмаагийн намын орон нутгийн кампанит ажлын штаб сонгогчидтой хийх уулзалт хөтлөх хүн ажилд авлаа. Хөтлөгч уран яруу, утга зохиолын хэл ашиглаж сонгогчдыг уухайлуулж байв. Хэдхэн удаагийн уулзалтын дараа тэрээр гэнэт алга болов. Өөр нэг штаб түүнийг хөлсөлж авсан сураг дуулдлаа. Ур чадвар сайтай өөр нэг оюутныг Бурмаагийн кампанит ажилд зохион байгуулагч ажилтнаар авлаа. Гэтэл бас л өөр нэг нэр дэвшигчээс ажлын санал авсан бөгөөд өнөөх маань хоёр ажлыг хослуулах байдлаар ажилласан юм. Өдрийн цагаар хаа сайгүй үзэгдэх үй олон зурагт хуудас, далбаа, LCD дэлгэц, штабын оффис, тараах материал, танилцуулга, телевизийн сурталчилгаа зэрэг нь ажилгүй хүмүүст ажил эрхлэх боломжийг, тогтсон бизнесүүдэд орлогоо нэмэгдүүлэх боломж олгоно.

Сонгуулийн халтуур хийх хүмүүсээс гадна сонгуулийн штабт тодорхой тооны бүтэн цагийн ажилтнууд ажиллана. СЕХ-нд 2008 онд 20174, 2012 онд 15549, 2016 онд 20000 гаруй хүн ажиллаж байлаа.¹⁵ Түүнээс гадна, намын болон бие даан нэр дэвшигчдийн кампанит ажилд нягтлан бодогч, жолооч гэх мэт маш олон хүн ажиллаж байсан. СЕХ, нам, нэр дэвшигч гэх гурван төрлийн этгээд тус бүртээ өөрсдийн ажилчин, кампанит ажлын менежер, дэмжигч болон бусад хүнийг ажиллуулна. Түүнээс гадна нам, хувь нэр дэвшигч нарт судалгаа, хэвлэл мэдээллийн, ухуулга хийх ажилчид, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, хандивын арга хэмжээ зохион байгуулахад маш олон тооны хүн хүч хэрэгтэй болно. Хагас цагийн болон бүтэн цагийн ажлын байрны боломж сонгуулийн үеэр ихэсдэг нь неолиберализмын шилжилтийн үеэр эдийн засгийн бүтэц өөрчлөгдөхөд хамгийн их хохирч хамгийн бага цалинтай ажил эрхэлж буй үеийнхэнд маш том боломж олгож байгаа нь мэдээж. Хагас цагийн болон бүтэн цагийн ажлын байр

¹⁵ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Дүн (2017). <https://www.gec.gov.mn/>. 2021 оны 3-р сарын 15-нд үзсэн.

сонгуулийн кампанит ажлын үеэр бий болгох энэхүү жишиг нь шинэ нэр дэвшигчид болон эмэгтэй нэр дэвшигчдэд жинхэнэ санхүүгийн дарамт болно. Нэр дэвшигчийн үндсэн бизнес буюу байгууллагад нь бүтэн цагаар ажиллаж буй хүмүүс, бизнесүүд болон ТББ-ууд нь нэр дэвшигчийнх нь амжилт өөрсдийнх нь ажил амьжиргаанд нөлөөлөх тул хамгийн үнэнч хүмүүс байдаг. Тиймээс, хамгийн том бааз суурьтай (бизнестэй, ТББ-тай, социал медиад дагагч олонтой гэх мэт) нэр дэвшигч хамгийн том сонгуулийн кампанит ажил явуулна. Үүний улмаас зарим улс төрч нэр дэвших боломжоо нэмэгдүүлэхийн тулд ТББ (хэвлэл мэдээллийн болон судалгааны) байгуулах тохиолдол ч гардаг.

Хэдийгээр улс төрийн өндөр түвшинд хандив өгөх нь хүчтэй фракцыг бий болгож байдаг тул авторитар дэглэм тогтохоос сэргийлдэг хэдий ч, энэ нь өөр газар, өөр хүрээлэлд харилцан адилгүй байна (Radchenko and Jargalsaikhan 2017, 1035). Энэтхэг, Латин Америк дахь улс төрийн өндөр түвшний хүрээллээс ялгаатай нь Монголд дээд түвшний хандивын тогтолцоо найдвартай бүтэц бүхий аль хэдийнээ бэхэжсэн тогтвортой институт болж төлөвшөөгүй байна. Ерөнхийдөө хандивын энэ тогтолцоо бүрдлээ гэж төсөөлбөл энгийн хүмүүст, ялангуяа алслагдсан жижиг тосгон, сууринд амьдардаг, улс төрийн намын харьяалал байхгүй хүмүүст ихээхэн хохиролтой. Сонгууль болгоны дараа улс төрийн эрх мэдэл нэг намаас нөгөө намд шилжихэд энгийн ард иргэдэд ажлын байрны боломж бий болгох төдийгүй ялагдсан намын гишүүд дэмжигчид, ялсан нам руу шилжих хөдөлгөөн өрнөдөг. Зарим хүний хувьд ажлын байр болон бусад нөөцөд хүрэх боломж нь “хандив хүртэгчийнх” (сонгогдсон парламентчийг хэлж байна) нь эрх мэдэлтэй холбоотой байх тул, тэдгээр хүмүүс нэр дэвшигчдээ идэвхийлэн дэмжих хандлагатай байдаг. Нөгөө талаар нэр дэвшигчийн эсвэл улс төрийн намынх нь ялалт баталгаатай биш тул сонгогчид сонгуулийн кампанит ажлаас чадах чинээгээрээ ашиг хүртэхийг эрмэлзэнэ. Энэхүү хамаарал нь сайн ч бай, муу ч бай сонгуульжилтыг улам бататгаж, улс төрийн нам нь өмнөх социалист нам-төрийн тогтолцооны адил ажлын байр хуваарилагч болоход хүргэдэг.

Нөгөө талаар иргэд неолиберализмаас үүдэлтэй улс төрийн тогтворгүй байдлыг, ялангуяа сонгуульд ялсан нам хүмүүсийг ажлаас нь халж, өөр хүнийг ажилд авдаг дөрвөн жилийн циклийг тогтворжуулахын тулд сонгуулийг ашиглаж байна. Тухайлбал, сөрөг хүчний нам сонгуульд ялснаар ажлаа алдаж ч мэдэх тул, зарим айл аль нэг намыг үнэнчээр дэмжихийн оронд гол хоёр намд нэг нэгээрээ элсэх болжээ (жишээлбэл, нөхөр нь АН-д эхнэр нь МАН-д элсэх гэх мэт)



Дүрс 2.2. Сонгуулийн кампанит ажлын ухуулагчид. 2008 он, Улаанбаатар хот. Зохиогчийн дарсан зураг.

Ингэснээр, ялсан нам эсрэг намынхаа дэмжигчдийг ажилд авах, дэмжихээс татгалзах эрсдэлээс тухайн айл дараагийн дөрвөн жилийн хугацаанд бага боловч сэргийлж чадна. Намууд улс төрийн эрх мэдлээ, нөөц хуваарилах боломжуудтай нэгтгэн хүн амын үлэмж хэсгийг хамарсан өөрсдийг нь дэмжих сууриа бэхжүүлдэг. Тиймээс нам иргэдийг өөрсдөөсөө хамааралтай байлгах неолиберал улс төр хийхийн сацуу, сонгуулиас сонгуулийн хооронд улам өндөр эрх мэдэл, нөлөөг олж авсаар байна. Сонгууль нь улс төрийн үйл явдал төдий бус маш олон хүний өдөр тутмын амьдралыг шийдвэрлэгч хүч болон хувирсан юм.

Сонгуулийн кампанит ажилд янз бүрийн байдлаар нэмэлт орлого олох боломж хэвийн үзэгдэл болж төлөвшив. Сонгуулийн кампанит ажлын, ялангуяа нэр дэвшигчийн хувийн кампанит ажилд оролцох хүмүүсийн дийлэнхийг нэг талаас нэмэлт орлого олох гэсэн хүсэл, нөгөө талаас нийгмийн харилцаанд оролцох, төгссөний дараа ажлын байраа баталгаажуулах эрмэлзлээр дүүрэн оюутнууд эзэлнэ. Оюутнуудаас гадна бага орлоготой, гол төлөв Улаанбаатар хотын захын оршин суугчид байх бөгөөд амьжиргаагаа сайжруулахын тулд баталгаажуулахгүй, бүдэгхэн харагдах боломжийн төлөө сонгуулийн ажлаас улам ч хараат болжээ (дүрс 2.2). АНУ-д хийсэн судалгаанаас үзэхэд хамтын эдийн засаг буюу нэмэлт орлого олох эдийн засгийн үр ашгийг бага орлоготой хүмүүсээс илүүтэй ур чадвар бүхий дундаж давхарга хамгийн ихээр хүртдэг (Heller 2017) байна. Урьдчилан таамаглах аргагүйгээр өөрчлөгддөг,

түр зуурын шинжтэй сонгуулийн үеийн нэмэлт ажлын байр нь ажил эрхлэх хэрэгцээ хамгийн их байдаг хүмүүсийн байнгын ажил эрхлэх хэрэгцээг хангах боломжгүй. Ребекка Эмпсон, Лорен Бонилла (2019) нарын тодорхойлсноор “Түр зуурын байдал өргөн тархах нь . . . шинэ төрлийн капитализмын суурь шинж юм”. Энэ өгүүлбэрт сонгуулийн үеэр нэмэлт орлого олох боломж нь байнгын үйл ажиллагаа явуулдаггүй хувийн бизнесийн түр зуур орших шинжийг баталгаажуулсаар байгааг өгүүлжээ. Сонгуулийн кампанит ажил капитализмын зарим үүргийг нөхөхгүй боловч капитализмын тод томруун орон зайг бий болгож байна. Тиймээс, сонгуулийн үеийн нэмэлт ажлын байр, сонгуулийн үеэр тараагдах гарын бэлэг өдөр тутмын амьдралд байр сууриа эзэлж, сонгууль гэх улс төрийн арга хэмжээг, сонгуульжилт гэх илүү байнгын тогтолцоо бүхий хүч болгон өөрчлөхөд хувь нэмэр оруулсаар.

Орлого багатай сонгуулийн ухуулагчид хотын захын тоостой гудамжаар, халуун нарыг үл ажран хэвлэмэл сэтгүүл, тараах материалуудыг барин бүтэн өдрийн турш зарим сонгогчдод шоглуулан, заримдаа бүр нохойд туугдан барин ажиллах шалтгаан нь шалихгүй хэдхэн төгрөгийн цалин байх нь тэр. Намууд оршин суугчидтай тулж ажиллах ухуулагчдыг илүүд үздэгийн учир нь тэдгээр ухуулагчид сонгогчид, тойргийнхоо талаар чухал мэдээллийг өгөхөөс гадна зарим хөршийнхөө сонголтод ч нөлөөлж чаддагт оршино. Тиймээс, нэр дэвшигчид ч тэр, сонгуулийн кампанит ажилд оролцож буй ажилчид ч тэр олж чадах нь баталгаагүй боловч өрсөлдөгчийнхөө эсрэг ашиглаж болохуйц боломжийн эрэлд хамтдаа гарна. Сонгуулийн кампанит ажилд оролцож буй ажилчдын хувьд албан ёсны багахан орлого бүхий ажил нь заримдаа илүү том боломжид хүрэх хаалга болдог. Сонгуультай шууд холбогдохгүй ч, сонгуулийн үеэр дүүрэг, хорооныхоо засаг дарга болон орон нутагт эрх мэдэл хэрэгжүүлж буй бусад хүмүүстэй тогтоосон холбоо харилцаа гэх мэт боломжууд хожим хэрэг болох нь бий. Тиймээс, багахан цалингаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ажиллаж, хэвлэмэл материал тараах нь нэг ёсондоо дараагийн боломжуудыг бий болгохын төлөөх сэдэлтэй гэж үзэж болно. Тийм учраас сонгуулийн кампанит ажилд оролцож буй ажилчид өөрийнхөө даалгаврыг гүйцэтгэхдээ “хэл амаа билүүдэж” шаардлагатай бол гардан тулаанд бэлдэж ханцуйгаа ч шууна. Нэг нэгээрээ, эсвэл багаараа нийлэн сонгуулийн ажилд ханцуй шамлан зүтгэдэг нь (сонгуулийн бэлтгэл ажилд оролцсоноос хэдэн сар, жилийн дарааг хүртэл) сонгууль нэгэнт өөрийн гэсэн эрчээрээ тэлж, дотроосоо дэврэн тэлж арга хэмжээ болсныг илэрхийлэх мэт.

Сонгуулийн кампанит ажлаар гаргасан зүтгэл, тавьсан итгэлийнхээ хариуг тэр дорхноо хүртэнэ. Сонгуулийн кампанит ажилд оролцсон оршин суугчид төрөөс олгох үйлчилгээ, нийгмийн халамж зэрэг нэр дэвшигчийнхээ улс төрийн үйл ажиллагааг хамгийн түрүүнд хүртэх

боломжтой. Учир нь заримдаа кампанит ажил мэдэгдэхүйц бөгөөд шууд удирдлагатай байдаг тул сонгогчид цалин авах, тэр бүү хэл үнэгүй өдрийн хоол идэх гэх мэт өчүүхэн ч гэсэн үр шим хүртэх сонирхолтой байдаг.¹⁶ Жишээлбэл, 2008 оны сонгуулийн албан ёсны сурталчилгаа дуусах үед АН кампанит ажилдаа оролцож ажилласан бүх ажилчдадаа оройн хоолтой хүлээн авалт зохион байгуулсан. Би АН-аас нэр дэвшигч Бурмаагийн кампанит ажлыг дагаж судалгаа хийж байсан тул тэдний штабын ажилчдын хамт хүлээн авалтад оролцлоо.



Дүрс 2.3. Гэрлийн бүрхүүлийн доор болж буй АН-ын гишүүд дэмжигчдийн хүлээн авалт. 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Улсын хэмжээнд хамгийн тансагт тооцох хүлээн авалтын танхим бүхий ресторанд ормогцоо бид бие биесээсээ төөрч орхив. Цугласан хүмүүс чимээ шуугиан ихтэй, багтаж ядан байлаа. Шарсан мах, зайдасны үнэр ханхалж, лааз хавиралдах чимээ сонсогдовч сайн чанарын даавуун бүтээлэгтэй хүлээн авалтын ширээнүүд хоосон байх нь харагдав. Хоол унд ч олж харсангүй, хоол идэж, юм ууж байгаа хүн ч харагдсангүй. Улмаар ус, ундаа бүхий тавцан барьсан зөөгч нар орж ирж буй нь зэрвэс анзаарагдлаа. Эргэн тойронд буй хүмүүс өмнөхөөсөө ч илүү шахалдах үед зөөгч үзэгдэхээ болив. Дахин хармагц зөөгчийн барьсан тавцан хов хоосон болсон байх нь тэр. Шахалдаан дунд яван явсаар АН-ын удирдагчдын аварга том хөрөг зургийн хажууханд, тайзны ойролцоо Бурмааг болон түүний ажилчдыг олж очлоо. Би тайзан дээр гарвал болор гэрлийн бүрхүүлийн дор багтаж ядсан олон хүн хүлээн авалтын том танхимын хаа сайгүй зайдас авахын төлөө зүтгэх бөгөөд индрийн ард намын удирдлагууд олны анхааралд гарч ирэх мөчид цугласан олны үймээн түр зуур саатна (дүрс 2.3). Хоол хүнс хаашаа

¹⁶ Зарим сонгогчид УИХ бол хууль тогтоох байгууллага гэх үндсэн зорилгыг нь үл ойшоож, УИХ-ын гишүүд орон нутагт нь хийсэн ажилд илүү төвлөрөх хандлагатай байдаг. Гэвч сонгогчид УИХ-ын хийх ажлыг мэдэж байсан ч гэсэн сонгуулийн сурталчилгааны үеэр орон нутгийн засаг захиргааны ажлыг хийж, үйлчилгээ зүүлэх нь эрс нэмэгддэг.

явсан, ямар хэмжээтэй байсныг мэдэж чадсангүй. Маргааш өглөө нь кампанит ажлын багийнхнаас хүлээн авалтын үеэр хүмүүс зайдас болон бусад хоол хүнсийг, лаазтай ундааны хамт гар цүнхэндээ, уугандаа бүр малгайдаа хийж аваад гэртээ харьсан талаар олж сонсов. АН-ын дарга хүртэл өлсгөлөнд нэрвэгдсэн мэт аяглах хүмүүсийг хараад цочирдсон талаар би дараа нь сонссон.

Нөөц хуваарилах, эсвэл гадаад хэл үнэгүй заах дамжаа гэх мэт далд сонгуулийн кампанит ажил шинэ боломж, орон зай, сүлжээг бий болгож, заримдаа бүр саналаа өгөх шаардлага, дарамтыг ч бий болгодог. Өөрөөр хэлбэл, сонгуулийн кампанит ажил нь сонгуулийг сонгуульжилт болгон хувиргахад нөлөөгөө тасралтгүй үзүүлсээр байна.

Хайхрахгүй хүн: субъектив шинж байдал ба “нийтийн дуу”

Социологич Чуа Бенг Хуат сонгуулийн тэлэлтийг дараах байдлаар тайлбарлажээ.

Ази даяар сонгууль нь орон нутгийн иргэдийн өдөр тутмын амьдралд тасралтгүй өрнөж байдаг онцлогтой соёлын “арга хэмжээ” юм. . . Хэрэв нэр дэвшигч сонгогчдын саналыг авахыг хүсэж байгаа бол түүний кампанит ажил “нийтийн” соёлын элементүүдийг агуулсан, нийт ард түмний соёлын туршлагатай нийцсэн байх ёстойгоос гадна сонгогчдын сэтгэл хөдлөлийг байлдан дагуулж чадахуйц бас бодол санаатай нь давхцаж байх шаардлагатай гэжээ (2007, xii).

Сонгууль яагаад өргөжсөөр байдгийг Чуа Бенг Хуат илүү соёлын үүднээс тайлбарлажээ. Сонгууль соёлыг зөвхөн ашиглаад зогсдоггүй. Харин сонгууль соёлыг, түүгээр дамжуулж ард түмний субъектив үзлийг өөрчилж байдаг. Монгол дахь сонгуулийн кампанит ажил олон нийтийн соёлын хандлагад нөлөөлж, түүчээлсний жишээ нь “нийтийн дууны” төрөл юм. Хангай, Нараа хоёрын хамт өөр сонгуулийн тойрог руу машинд ярилцаж явах үеэр миний анхаарлыг татсан өөр нэг түүх хуваалцъя.

Бид алслагдсан, хүн ам маш цөөтэй газар руу явж байлаа. Зөрж өнгөрөх ачааны болон суудлын машинууд сонгуулийн сурталчилгааг шингээжээ. Жолоо барьж явсан Хангай гэнэт машиныхаа радиог асаах нь тэр. Монгол дуу хөгжмийн уламжлал дахь зөөлөн поп хэмээн ангилж болох “нийтийн дуу”-ны салбарт түргэн нэрд гарсан, дуучин Жавхлангийн дуу явж байв. Хангай “энэ сонгуулиар Жавхлан ч сонгуулийн кампанит ажилд тасралтгүй ажиллаж (дуулж) байх шив” гэж хэлээд, машинд нь сууж яваа зорчигчид дуу сонсохоос илүүтэй хоорондоо яриа өрнүүлэхийг хүсэж буй мэдсэн мэт хөгжмөө унтраав. Хаа нэгтээ, хамгийн алслагдсан орон нутагт хүртэл бид сонгуульжилтаас зугтаж чадахгүй аж. Нийтийн дуу 1960, 1970-аад оны үед алдартай байсан бөгөөд одоо дахин олон нийтэд түгж

байлаа. Зохиолын дуу гэж анхандаа нэрлэгддэг байсан бол ардын эсвэл поп дуутай төстэй байснаас тэр үү нийтийн дуу гэж олон нийтэд хоногшжээ. Зохиолын дуу гэх нэр томъёо нь илүү зөв мэт санагдавч, нийтийн дуу нь өрнөж буй үзэгдэлтэй илүү зохицох мэт.

2008 оны хаврын нэг өдөр 21 настай үеэл маань нийтийн дууны шүтэн бишрэгч болсноос эхлээд нийтийн дуу гэх зүйл анхаарлыг минь татсан юм. Үеэлийн яриа их сонин санагдав. Наддаа л хип хоп хөгжим сонсдогт тооцогдох үеэл маань “нийтийн дуутай” зохицохгүй мэт санагдана. Би нийтийн дууг арай ахмад хүмүүс, үгүйдээ л 30 гарсан хойноо сонсдогийг анзаарсан. Нийтийн дуунууд намуухан, тайвшралын аястай бөгөөд уламжлалыг хадгалах мэт, заримдаа дуучид нь уламжлалт хувцас өмсөж дуулдаг. Дууны хэмнэл, аялгуу нь зөөлөн намуухан бөгөөд дуучин нь найрсаг инээмсэглэл, нухацтай байдал, эрхэмсэг харц, уян зөөлөн хөдөлгөөнтэйгөөр дуугаа дуулна. Нийтийн дууны агуулга нь эх орноо, эцэг эхээ, эсвэл эргэн тойрныхоо гоо үзэсгэлэнг хайрлах агуулгатай тул ёс суртахууны зөв байдалд уриалдаг. Харин миний л мэдэхээр үеэл маань нийтийн дуунаас тэс ондоо, томоогүй, хурц, хип хоп төрлийн болон Солонгос поп, Мадонна, Женнифер Лопез зэрэг диско, бүжгийн хэмнэлтэй л хөгжим сонсдог билээ. Тэр хавар үеэл маань надад АНУ-аас J. Lo брэндийн үнэртэй ус, тэрний өмнө жил Nike брэндийн сүүлийн үеийн пүүз захиж байв. Нийтийн дуу гүн гүнзгий, уянгалаг тул хүмүүс нийлж хоол идэж, хэсэг уусныхаа дараа хамтдаа дуулах нь түгээмэл. Гэвч жинс л өмсдөг (тэрээр өвдгөө давсан банзал зөвхөн “эмээ нарт” зориулсан хэмээн балет үзэхдээ өмсөхөөс татгалзаж байсан) үеэл маань “нийтийн дуунд” уярч буйгаас үзэхэд сонгуулийн кампанит ажил хэрхэн хүн бүрийн субъектив үзэлд үр дүнтэйгээр нөлөөлж буйг харуулна.

Нийтийн дуу сонгуулийн сонголт хийхэд хэрхэн нөлөөлж буй нь тийм ч чухал биш. Монголд сонгууль хийх огт шаардлагагүй гэж үзэх тул саналаа өгдөггүй олон хүн бий. Гадаадад амьдрах гэр бүлийнх нь гишүүд тогтмол мөнгө явуулах тул тэдний зарим нь санхүүгийн хувьд бие даасан байх нь ч бий.¹⁷ Харин нөгөө хэсэг нь итгэл алдарсан тул хаашаа ч юм цагаачилж ирээдүйгээ өөр газар л өнгөрүүлэхийг хүснэ. Гэвч эдгээр хүмүүс сонгуулийн кампанит ажил, түүний нөлөөнөөс зугтаж чадахгүй. Тус нөлөө нь улс төрийн бус байж ч болно. Миний үеэлийн хувьд хэн сонгуульд ялах нь тийм чухал биш боловч тэрээр кампанит ажилтай холбоотой онигоо болон цуу ярианд дуртай нэгэн. Түүний хувьд урьд нь сурталчилгааны нэг хэсэг байсан гадаа тоглох урлагийн тоглолт, концертуудад найзуудтайгаа хөгжилдөх нь сонгуулиас ч илүү үнэ цэнтэй байсан юм. Гэхдээ л эдгээр

¹⁷ Монголын эзсийн уурхайн компани Эрдэнэт үйлдвэрийг судалдаг антропологич Марисса Смит уул уурхайн салбарын маш олон мэргэжилтнүүд өөрсдийгөө улс төрөөс ангид гэж үздэг боловч, дэмжиж буй нэр дэвшигч нь сонгуульд ялаагүй тохиолдолд сэтгэл дундуур үлддэг гэжээ (Хувийн харилцаа, ярилцлага 2021 оны 1-р сар).

тоглолт, концертууд залуу үеийнхний субъектив үзэлд нөлөөлдөг.

2000-аад оны үеэр нийтийн дуу улс даяар өндөр эрэлт хэрэгцээтэй байлаа. Аливаа тэмдэглэлт өдөр, төгсөлтийн баяр, байгууллагын зугаалгын үеэр хөгшин залуугүй нийтийн дуу сонсолгүй, эсвэл дуулалгүй өнгөрөх нь бараг л үгүй. Нийтийн дуу ийм олны хүртээл болсон байсан тул, нэгэн цуу яриагаар бол, УИХ-ын сонгуульд нэр дэвшигч нэгэн тойргийнхоо сонгогчдод танигдахын тулд дуучин Жавхлангийн тоглолтыг 100 мянган доллароор ивээн тэтгэсэн нь тухайн үеийн жишгээс хэт өндөр үнэ гэгдэж байв. 2004 (орч.) оноос хойш сонгуулийн кампанит ажлын үеэр урлагийн тоглолт зохион байгуулахыг хуулиар хориглосон юм. Гэвч сонгуулийн кампанит ажил хуулийн хязгаарлалтыг тойрох тохиолдлууд бий. Нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлынхаа хүрээнд тус тоглолтыг зохион байгуулахын оронд тухайн нэр дэвшигчийг дэмжиж буй хүмүүс нь түүний бусад нэр дэвшигчдэд (дэмжигчдээс дэмжигчдэд) бэлэг болгох маягаар зохион байгуулав. Уран бүтээлчид ч гэсэн дэмжигчдэд зориулж ая дуугаараа бэлэг барина. 2008, ялангуяа 2012 оны сонгуулиар “сонгууль ажиглагч” иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн кампанит ажлыг урлагийн тоглолттой холихыг хориглосон заалтын хэрэгжилтийг хянах болсон ч зарим нэр дэвшигчид, дэмжигчид хуулийн энэ хязгаарлалтыг тойрч гарсаар л байна.

Сонгууль бол хүмүүсийн сэтгэл хөдлөл, оюун санааг татах ёстой соёлын арга хэмжээ гэж үзсэн Чуа Бен Хуатын санааг батлах мэт дуучин Жавхлан 2016 оны сонгуульд нэр дэвшиж, УИХ-ын гишүүнээр сонгогдов. Зугаа цэнгэл, үзэл санааны хувьд Жавхлангийн кампанит ажил маш өвөрмөц байлаа. Гар хийцийн гутал, энгийн малчны малгай зэрэг Монгол үндэсний хувцас өмсөж (энэхүү хувцсаа тэрээр дуу дуулахдаа ч байнга өмсдөг), урт ургуулсан үсээ намируулсаар нэр дэвшигч Жавхлан тойргийнхоо сонгогчидтой уулзалт хийхээр тэмээн цуваа хөтлөн алхаж явав.

Жавхлангийн үзэл санааг хөгжил, шинэчлэлийн эсрэг, хоцрогдож үлдсэн өнгөрсөн үе рүүгээ буцахыг уриалан дуудагч хэмээн шүүмжлэх хүмүүс олон байсан хэдий ч, талархууштай хандах дэмжигчид нь ч мөн цөөнгүй байсан юм. Жавхлан уламжлалт амьдралын хэв маягийг сурталчлах нь уламжлалт өв соёлоо дээдлэх Монголчуудын үндсэрхэг үзлийг сэргээж байсан үетэй давхцаж байсан бөгөөд энэ нь гадаадаас явуулж буй уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцдэгтэй мөн холбоотой. Газар доорх баялгаа гадаадуудад алдахаас айх айдас, зовнилоос үүдэлтэй үндэснийхээ газар нутагт буй байгалийн баялагтаа өөрсдөө хяналтаа тогтоох ёстой гэж үздэг баялгийн национализм нь 2013 оноос хойших эдийн засгийн уналттай үед эрчимжээд байсан үндсэрхэг үзлийг улам их өрдөж өглөө. Тус жишээ сонгууль нь сонгогчдын төдийгүй, нэр дэвшигчийн ч субъектив шинжбайдалд нөлөөлдөг гэдгийг харуулж байна.

Жавхлангийн өвөрмөц найруулга бүхий кампанит ажил нь үндсэрхэг бөгөөд эрэгтэйлэг шинж чанарыг агуулсан нь ихээхэн амжилт олсон бөгөөд орчин үеийн, баруунжсан ч гэж тооцогддог дийлэнх эмэгтэй нэр дэвшигчдийн кампанит ажлын онцлогтой харьцуулахад тэс өөр байсан юм. 5, 6-р бүлэгт сонгогчид эмэгтэй нэр дэвшигчдийн онцлогийг тойрон хэрхэн маргалддаг талаар дэлгэрэнгүй ярилцана. Эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд өөрийгөө хэрхэн илэрхийлэх талаарх сонголт нь үргэлж л мөрийтэй тоглоом мэт байдаг. Эмэгтэй нэр дэвшигчид сонгогчдодоо үргэлжид хэт эмэгтэйлэг эсвэл хангалттай эмэгтэйлэг бус, хэт хөгшин эсвэл хэт залуу, хэт түрэмгий эсвэл хэт зөөлөн гэсэн мэдрэмж төрүүлдэг. Нийтийн дуу болон Жавхлангийн УИХ-д сонгогдтолоо цойлсон жишээ нь сонгуулийн нөлөө, соёлын туршлага, олон төрлийн субъектив шинж байдал зэрэгтэй харилцан холбогдсон бөгөөд бидэнд жендэрийн зарим хандлага сонгуулийн сонголт хийхэд ямар чухлаар нөлөөлж болдог гэдгийг тодорхой харуулж байна. Энэ талаар 3-р бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ. Мөн нийгмийн бухимдалтай, тодорхойгүй байдал үүсээд буй үед жендэрийн шинж чанарыг тодорхойлох хандлага бий болдог талаар ч дэлгэрэнгүй ярилцана.

Эрх мэдэл хадгалагчид ба сонгуулийн амлалт

2008 оны сонгуулийн үеэр эрх мэдэл хадгалагчид (эрх мэдэлд буй хүмүүс болон нөлөө бүхий өрсөлдөгчид) сонгуулийг үндэсний оюун санааг өөрчлөгч болгон ашиглаж буйг дараахаас харж болно. Уул уурхайг (үндсэндээ алт, нүүрс болон бусад эрдэс баялаг) иргэд эсэргүүцэж байсан үед эрх баригчид сонгуулийн кампанит ажлыг тэдгээр иргэдийг тайтгаруулах арга хэрэгсэл болгон ашигласан тул иргэд ирээдүйн ашгийн төлөө уул уурхайг хүлээн зөвшөөрөх болсон юм. Энд сонгууль гэх талбарыг ашиглаж үндэсний оюун санааг (улс төрийн эрх мэдэлд хүрэх замаар хязгаарлагдахгүй) өөрчилж буй үйл явдлаас сонгууль ямар хүчтэй болохыг харж болно.

Монголд уул уурхайгаас хүлээх догдлол 1990-ээд онд эхэлж, 2000-аад оны эхэн үед оргилдоо хүрч, түүнээс хойш шүүмжлэл, гадаадын хөрөнгө оруулалтыг эсэргүүцэх үзэл, хүрээлэн буй орчныг хамгаалах хөдөлгөөнүүд, үндэсний баялгийг зохион байгуулахад засгийн газрынхаа чадамжид эргэлзэх санаа зовнил зэргийг хамарсан ээдрээтэй асуудал болж хувирав.

Энэ хэсэгт сонгууль, уул уурхай гэх хоёр чухал зүйл хэрхэн хоорондоо хамааралтай болох талаар, мөн 2008 оноос хойших байгалийн баялгаа ашигласнаар амьжиргаа нь дээшлэх боломжтой гэж найдсан Монголчуудын хүсэл мөрөөдөл, уур бухимдалтай хэрхэн холбогдож буй талаар өгүүлнэ. 2008 оны сонгуулийн үеэр Монголын улс төрд голлох хоёр нам болох АН, МАХН уул уурхайгаас олох орлогоос иргэн

бүрд болзолгүйгээр мөнгө тараах тухай сонгуулийн амлалт өгсөн юм (дүрс 2.4, 2.5). МАХН “Эх орны хишиг” болох 1 сая 500 мянган төгрөг (ойролцоогоор 1270 ам. доллар), АН “Эрдэнийн хувь” болох 1 сая төгрөгийг (ойролцоогоор 847 ам. доллар) иргэн бүрд өгөхөөр амлав.¹⁸ Сонгуулийн амлалт үр дүнгээ өгч, арай илүү мөнгө өгөхөөр амласан МАХН сонгуульд яллаа. Энэ нь халамжийн төрийн шинж чанарыг агуулсан, халамжийн бодлогыг сонгуулийн кампанит ажилд ашигласан хамгийн тод жишээнүүдийн нэг мөн. Сонгуульд ялах нь энэхүү амлалтын цор ганц зорилго байсангүй. Энэ амлалт нь уул уурхайн томоохон гэрээ хэлэлцээрүүдийг урагшлуулахыг иргэдэд ойлгуулах арга зам байсныг би хожим нь олж мэдсэн юм.

Парламентын сонгууль судалдаг антропологич хүний өнцгөөс үзэхэд, улс төрчид мөнгө амлах нь өөрсдийгөө нэр хүндтэй удирдагч хэмээн харагдуулах төдийгүй сонгогчдын саналыг татах зорилготой байдаг. 2008 оны сонгууль бол улс төрийн өндөр албан тушаалд байж, уул уурхайтай холбоотой бүхий л зүйлд хөшүүрэг ашиглан үр ашиг хүртэхэд хамгийн чухал цаг үе байсан юм. Уул уурхай нь аль хэдийнээ улс төртэй салшгүй холбогдсон байлаа. Тухайлбал, Таван Толгой Транс гэх Монголын нүүрс тээврийн хамгийн том компаниудын 90 хувийг АН-ыг төлөөлж УИХ-д суух Д.Бат-Эрдэнэ гишүүн эзэмшиж байв (Naughton and Ullman 2008). Олон улс төрчид уул уурхайн бизнесүүдэд шууд хувь эзэмшдэггүй юм гэхэд лиценз, бүтээгдэхүүн зэргээр дамжуулж ямар нэг байдлаар холбоотой байсан юм. Түүнээс гадна би олон хүнээс уул уурхайгаас орж ирсэн мөнгө сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн үлэмж хувийг эзэлдэг талаар сонссон. Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн дийлэнх хэсэг нь нууц байдаг тул энэ таамаглалыг батлах тодорхой жишээ олох боломжгүй. Бусад газруудын жишгээр, Монгол дахь уул уурхайн салбар бол улс орны эрх зүй, улс төр, эдийн засгийн дэд бүтцийг, ялангуяа гадаадын аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх иргэдийн хариу үйлдэл, үндэсний удирдагчдын алсын хараа зэрэг маш олон хүчин зүйлээс шалтгаалсан, маргаан дагуулсан, ээдрээ төвөгтэй сэдэв билээ.

¹⁸ 2008 оны ханшаар 1 ам.доллар ойролцоогоор 1200 төгрөгтэй тэнцэж байлаа.



Дүрс 2.4. МАХН-ын “Эх орны хишиг” сонгуулийн сурталчилгааны материалын ар, өвөр тал. Тус материал нь сонгогчдод сонгуулийн сурталчилгааны материал болж тараагдсан юм.

Ерөнхийдөө, намууд сонгуульд ялалт байгуулахын тулд шинэлэг аргаар, сонгогчдын ирээдүйг гэрэл гэгээтэй мэтээр харуулж, тэдний дэмжлэгийг соронз мэт татахад уул уурхайг ашиглав. Товчхондоо уул уурхай сонгуулийг улам идэвхжүүлэв.

“Харин ч эсрэгээрээ шүү” гэж нийгмийн газар зүйч Лаурен Бонилла надад хэлэв. Тэрээр 2002 оноос хойш Монголын уул уурхай нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг судалж байгаа юм. Бонилла өргөтгөсөн судалгааныхаа ажилд (2017) засгийн газар сонгуулийг 1990, 2000-аад онд уул уурхайтай холбоотой хүлээж байсан ирээдүйн талаарх бөхсөн итгэл найдварыг сэргээх талбар болгон ашигласан гэжээ. Өөрөөр хэлбэл, сонгуулийн кампанит ажлыг үндэсний удирдагчид нь зөв менежмент хийх чадвартай гэдэгт иргэдийн итгэлийг сэргээх талбар болгон ашигласан гэсэн үг. 2000-аад оны дунд үеэс эхлэн гадаадын хөрөнгө оруулалтад ээлтэй эрх зүйн орчин, уул уурхай ашиглах гэрээнд Монголчуудын эзлэх хувь хэмжээний талаар улс даяар маргаан,

мэтгэлцээн эрчимтэй өрнөж байсан тул ийнхүү иргэдийн зөвшөөрлийг эрэлхийлэх шаардлага зайлшгүй тулгарсан юм (Bonilla 2017, 155-56). Тухайн үед уул уурхай ашиглахтай холбоотой суурь ажлуудыг үргэлжлүүлэх, яваандаа хамгийн том уул уурхайн ордуудыг ашиглаж эхлэхээр Монгол Улсын засгийн газар болон гадаадын компаниуд гарын үсэг зурж баталгаажуулах хэд хэдэн гэрээ, хэлэлцээр хүлээгдэж байлаа.

Иргэд хуульд өөрчлөлт оруулахыг шаардаж, уул уурхай ашиглахыг эсэргүүцэж байсан тул эдгээр гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах ажил түр хойшлов. Ингээд улс төрчид “Газрын хэвлийн баялгийн талаарх соёлын болон эдийн засгийн үнэ цэнийг ойлгох үндэсний шинэ ухамсар”-ыг бий болгохоор ажиллаж байлаа (Bonilla 2017, 155). Айвенхоу Майнзийн ерөнхийлөгч Роберт Фридланд Оюу толгойн ордыг илрүүлмэгцээ уул уурхайг Монголчуудад сурталчилж, Монгол Улс дараагийн Саудын Араб болох тухай мөрөөдлийг бадраасан нь иргэдийн ухамсар сэргэсний гол шалтгаануудын нэг юм.



Дүрс 2.5. АН-ын “Эрдэнийн хувь” сонгуулийн сурталчилгааны материал. Тус материал нь сонгогчдод сонгуулийн сурталчилгааны материал болж тараагдсан юм.

Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчдыг татахаар Монгол Улсыг гадаадад сурталчлах ажлын гутаасан, доромжилсон өнгө аяс нь Монголчуудын дургүйцлийг төрүүлжээ. Роберт Фридланд (2005) Монгол бол татварын таатай орчинтой, уул уурхайг эсэргүүцэх ТББ-гүй, хүрээлэн буй орчны доройтлыг бараг л анхаардаггүй эрдэнэсийн авдар юм гэж сүржин мэдэгдэв. Хэдийгээр уул уурхай ашиглахыг болон гадаадын

хөрөнгө оруулалтыг эсэргүүцэх эсэргүүцэл эрчимжиж, засгийн газар ч гэсэн тусгай зөвшөөрлийг илүү сайн хянаж, гэнэтийн орлого, ашиглалтын зардлыг барьж, гадаадын компаниудыг зохицуулах гэх мэт өөрчлөлтүүдийг хийсэн боловч гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн неолиберал орчныг хадгалах байр сууриа тууштай баримталж байлаа (Bonilla 2017; Hatcher 2014). Төр уул уурхайг дэмжихдээ ус, ойн нөөцийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын эсрэг эсэргүүцлийн хөдөлгөөний тэргүүнийг терроризмд буруутган баривчлав (Bum-Ochir 2019).

Үүний зэрэгцээ, Бонилла (2017, 157) төр ард түмнийг тайвшруулж “нөөц баялгаа гадаадынханд юу ч үгүй цөллүүлэх вий гэх иргэдийнхээ санаа зовнилыг дарах” шаардлагатай байсан гэжээ. Ямартай ч 2000-аад оны Монгол дахь уул уурхайн улс төрийн талаарх Бониллагийн дэвшүүлсэн аргумент нь сонгуулийн кампанит ажлын далайцтай байдлыг төдийгүй, сонгогчидтой хийх уулзалтын үеэр нэр дэвшигчдийн ярих зүйлсийн агуулгыг тайлбарлахад тусалдаг. Сонгуулийн үеэр нэр дэвшигчид ирээдүйд мөнгө авах тасалбар тараахын сацуу хэрхэн мөнгийг өгөх тухай харилцан адилгүй хувилбаруудыг танилцуулж байлаа.

Иргэдэд мөнгө тараах нь хүний хөгжилд гол хөшүүрэг болох бөгөөд энэ нь улс үндэстний хөгжилд зайлшгүй шаардлагатай гэсэн үзэл санааны хүрээнд ажлыг хэрэгжүүлэх арга сэджээ. Тиймээс Засгийн газар Хүний Хөгжлийн Санг үүсгэн байгуулав. Түүхэн үүднээс төрийг шүүмжлэхийн сацуу чөлөөт зах зээлийг сурталчилж байсан либерал, неолиберал зөвлөхүүд иргэдэд мөнгө тараах ажлыг төрд болон бусад аль нэг этгээдэд баялгийн хэт төвлөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам гэж үзжээ. Үүнийг зарлагыг ардчилах, орлогыг тэгшитгэх оролдлого гэж ойлгож дэмжжээ.

Ямартай ч бэлэн мөнгө тараах амлалтын цаана илүү нарийн ширийн зүйлс байсан юм. Бэлэн мөнгө тараах сонгуулийн амлалт нь АНУ-ын засгийн газрын неолиберал бодлоготой шууд холбогддог. Уул уурхайн орлого нь сонгуулийн амлалт болохоос ч өмнө 2007 онд Монгол Улсын засгийн газар “Мянганы Сорилтын Компакт гэрээ” (МСК) гэх АНУ-ын гадаад тусламжийн хөтөлбөрийн хүрээнд 284.9 сая ам.долларын хэлэлцээ хийж байлаа. МСК нь эдийн засгийн өсөлтөөр дамжуулж дэлхий дахинд ядуурлыг бууруулах зорилготой хөтөлбөр юм (МСС 2008). Тус сангийн санхүүжилтийг хүртэхийн тулд Монгол Улс сайн засаглал, эдийн засгийн эрх чөлөө, иргэддээ хөрөнгө оруулах гэх гурван төрлийн шалгуур үзүүлэлтийн төлөө тууштай байх үүрэг амлалт хүлээв. МСС-тай зэрэгцээд, Монгол Улс НҮБ-ын Мянганы Хөгжлийн Зорилтуудыг (МХЗ) хэрэгжүүлж эхлэх гэж байлаа. 2008 оны эхээр Мянганы Хөгжлийн Компакт гэрээнд гарын үсэг зурсны дараа Засгийн газар Хүний Хөгжлийн Санд хуримтлуулсан уул уурхайн орлогыг Эх

Орны Хишиг болгох хуваарилах үүрэг амлалтаа зарласан юм. Үүний дараахан Засгийн газрын төлөөлөгчид нүүрстөрөгчөөс олох орлогыг иргэддээ жил бүр чек хэлбэрээр олгодог Аляскын Байнгын Сангийн үйл ажиллагааг судлахаар явав. Өөрөөр хэлбэл, бэлэн мөнгө амлах кампанит ажил нь өргөн утгаараа социалист, либерал, неолиберал бодлогын схем, үнэт зүйлсийг зохион байгуулах (зарим нь түүхэн нөхцөлтэй, зарим нь саяхнаас хэрэгжсэн) том агуулгын ердөө нэг хэсэг нь байжээ. Сонгууль судлалын өнцгөөр харвал, бэлэн мөнгө амлах кампанит ажлаас эрх мэдлээ хадгалах, иргэдийг тайвшруулах, улс төрийн өрсөлдөгч, шинэ улс төрийн хүчнүүдийг шахах гэсэн зорилго ч мөн ажиглагддаг. Бэлэн мөнгөний амлалт нь эрх мэдлээ улам баталгаажуулахын тулд сонгуулийг төрөл бүрийн аргаар ашигладаг эрх барьж буй элитүүд буюу Амел Ахмедын нэрлэсэнээр “тусгай хамгаалалт” (2013) гэх нэр томъёоны Монгол хувилбарыг санагдуулна. Энэ тохиолдолд, сонгууль нь уул уурхай, улс орны ирээдүй зэрэг асуудалд олон нийтийн ойлголтыг чиглүүлэх зорилгоор эрх мэдэл хадгалагчдын найруулсан тайз байсан болж таарч байна.¹⁹

Гэвч тараах бэлэн мөнгө байсангүй. “Сонгуулийн амлалт нь хэрэгжиж буй уул уурхайн төслүүдээс улсын санд төвлөрүүлж буй орлогыг нарийн тооцсоны үндсэн дээр өгсөн амлалт биш, харин байгалийн баялгаас олох орлогыг ерөнхийлсөн хүлээлт дээр суурилсан амлалт юм” (Bonilla 2017, 320). Төрийн мэдлийн (Таван толгой) болон гадаадын хөрөнгө оруулалт бүхий (Оюу толгой) хамгийн ашигтайд тооцогдох том хоёр уурхай аль аль нь үйлдвэрлэлийн шатанд хүрээгүй, ердөө бүтээн байгуулалтын болон хөгжүүлэлтийн шатандаа л байлаа. Хүний Хөгжлийн Санг санхүүжүүлэхийн тулд засгийн газар удаан хүлээгдээд байсан гэрээний талаар 2009 онд Айвенхоу Майнзтай хэлэлцээг үргэлжлүүлэв. Тус хэлэлцээрт 2008 оны сонгуулийн 1-1,5 сая төгрөгийн бэлэн мөнгийг иргэдэд өгөх тусгай зорилгоор, ирээдүйн уул уурхай ашигласны төлбөрөөс буцаан төлөгдөх нөхцөлтэй 250 сая ам. долларыг Монгол Улсын Засгийн газарт шилжүүлэх тухай багтжээ. 250 сая ам. долларыг Засгийн газар татварын урьдчилгаа гэж зарласан ч, үнэндээ энэ мөнгө нь 2014, 2016 онд Айвенхоу Майнз/Рио Тинтод 24 сая ам. долларын хүүгийн төлбөрийн хамт төлөх зээл байсан юм (Kohn and Number 2013).

Айвенхоу Майнзаас авсан мөнгө Монголын 2,7 сая хүнд амласан мөнгөө тараахад яагаад ч хүрэлцэхээргүй байлаа. Иргэд бага хэмжээний төлбөр авч, илүү ихийг хүлээж эхлэв. Энэ зуур томоохон уул уурхайн төслүүд хойшлох нь тэр. Хүний Хөгжлийн Санг үргэлжлүүлэн санхүүжүүлэхийн тулд 2011 онд төрийн өмчит нүүрсний компани,

¹⁹ Бенедикт Андерсон (1998, 266-67) колоничлолын дараа Өмнөд Ази дахь сонгууль элитүүдийн гарт орж, ажил хаялт, жагсаалт цуглаан зэрэг иргэдийн оролцооны хурц хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор л нутагшуулсан хэлбэр төдий зүйл болсон гэж үзжээ. Харин Монгол иргэд сонгуульд ч оролцдог, бусад төрлийн оролцооны хэлбэрийг ч ашигладаг.

Чалко гэх Хятадын компанитай хэлэлцээр байгуулжээ. Чалко Таван толгойн ордоос авах 4 сая тонн нүүрсний урьдчилгаа болгож 250 сая долларыг Монголын уул уурхайн компанид шилжүүлэхийг зөвшөөрөв (Kohn 2013). Байгуулсан гэрээ нь маш ойлгомжгүй. Чалко тус урьдчилгаа мөнгөөр Монголын төрийн өмчит компани хөгжлийн бүтээн байгуулалт санхүүжүүлнэ гэж таамагласан ч Засгийн газар 200 сая ам. долларыг Хүний Хөгжлийн Санд төвлөрүүлжээ.

Айвенхоу Майнз ч тэр, Эрдэнэс Таван Толгой компани ч тэр бүтээн байгуулалтаа зогсоож, ажилчдаа цомхотгохоос аргагүйд хүрсэн нь Монголын эдийн засагт үлэмж хүндрэл учруулав. Нүүрсний компаниуд цалингаа хасаж, цагтаа тавьж чадахгүйд хүрэхээс гадна байгаль орчны, болон олон нийттэй харилцах хөтөлбөрүүдээ санхүүжүүлж чадахгүй байдалд хүрлээ. Үйл ажиллагаагаа явуулах боломжгүйгээс гадна ихээхэн өрөнд оров. Иргэдэд тараах мөнгийг Хүний Хөгжлийн Санд төвлөрүүлж болох гуравдагч эх үүсвэр нь Зөвлөлтүүдтэй хамтран байгуулсан, 20-р зууны хоёрдугаар хагаст үндэсний нийт орлогыг бараг дангаараа бүрдүүлж байсан Эрдэнэт хэмээх төрийн өмчит зэсийн уурхай байлаа. Сангийн яам Эрдэнэт үйлдвэрээс 28 сая ам. долларын ногдол ашгаас гадна ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт ч мөнгө нэхэмжлэв. Энэ нь тус үйлдвэрийг санхүүгийн хувьд маш эмзэг байдалд оруулжээ. Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Таван Толгой нүүрсний компани аль аль нь төлбөр төлөхөөс бултсан талаар олон улсад шуугиан дэгдээж, гадаадын хэвлэлд сөрөг мэдээнүүд тавигдсанаар олон улсын хөрөнгө оруулагчид, банк, зээлдэгч, хандивлагчдын дунд Монголын нэр хүндэд сөрөг нөлөөлөв (Choi 2010; Kohn 2013).

Сонгуулийн амлалт, мөнгө тараах нь улс орны эдийн засгийг сүйрүүлсэн юм. Хүмүүс тодорхой хэмжээний мөнгө авсан (амласан хэмжээнээс арай бага) боловч ойрын хэдэн жилдээ улс орон үлэмж их өрийг төлөх ёстой үлдсэнээс гадна, олон улсын хөрөнгө оруулагчдаа төдийгүй сүйрч буй эдийн засгаа ойрын ирээдүйд сэргээх итгэл найдвар нь ч алдагдлаа. Үүнийг улс үндэстэн сонгууль явуулах бус, харин сонгууль нь улс орныг удирдсан (удирдахдаа бүр дампууруулах шахсан) тохиолдол гэж хэлбэл илүү зохино.

Дүгнэлт: Улс төрийн цаг хугацааг залуурдах нь

Энэ бүлэгт сонгуулийн кампанит ажил нийгмийн үйл явц, хүний хувийн амьдралыг эзэлж, субъектив үзэлд нөлөөлж, эдийн засаг, амьжиргааг удирдан чиглүүлж буй үзэгдлийг сонгуульжилт гэх үгээр тодорхойлов. Сонгуульжилт нь гудамжаар дүүрэн харагдах үрэлгэн кампанит ажлаас өгсүүлээд субъектив шинж байдалд нөлөөлөхүйц соёлын хүч хүртэл олон янзаар илэрнэ. Би сонгогчид, нэр дэвшигчид, мэргэжилтнүүд,

ажилчид, улс төрийн биш юм аа гэхэд соёлын нөлөөнд автсан хүмүүс гэх мэт гол бүлгүүдийн туршлагаас онцолж чадсан гэж бодож байна.

Сонгуулийн кампанит ажлын хүч нь иргэдийн амьдралыг хот, хөдөө гэлтгүй тасралтгүй үргэлжлэх улс төрийн цаг хугацаанд чиглүүлж, дуу хөгжмөөр дамжуулж хүний субъектив үзлийг өөрчилж, амьдралыг харах мэдрэмжээр анги давхарга үүсгэж, нэмэлт орлогын, буюу бэлэг, сэлтийн эдийн засаг улам хөгжиж, уул уурхайн орлогоос нийт ард түмэнд бэлэн мөнгө тараах сонгуулийн амлалтаас эдийн засгийн сүйрэл үүсэж болдгийг харлаа. Сонгуулийн кампанит ажлаас сонгуульжилтад оролцохын тулд нэр дэвшигч аль хэдийнээ УИХ-ын гишүүн болохоосоо өмнө тойргийнхоо сонгогчдыг удирдаж, хууль тогтоогчийн ажил хийх болжээ. Хэмжээлшгүй зардал гаргах, үрэлгэн кампанит ажил нь ардчиллын шинж тэмдэг болох нээлттэй, чөлөөт өрсөлдөөн мэт харагдана. Гэвч, сонгуулийн кампанит ажил нэр дэвшигчийнхээ хөрөнгө чинээнээс хамаардаг, санхүүжилтийн тогтолцоо нь болхи зэрэг байдлаас шалтгаалан эмэгтэй нэр дэвшигч болон шинээр улс төрд орохыг эрмэлзэгчдэд кампанит ажил явуулах бололцоо олгодоггүй. Сонгууль яагаад нэр хүндтэй хэвээр, сонгуулийн кампанит ажил ард иргэдийн нийгэм, улс төрийн амьдралыг эзэлдгийн хариуг эрэлхийлэхдээ би судалгаандаа нарийн ширийн зүйлсийг тодруулахын зэрэгцээ төрөл бүрийн судлаачдын бүтээлээс энэхүү асуудлыг онолчлоход санаа авсан юм. Тэдний судалгааны ажил Монголын нөхцөл байдлыг ойлгох, задлан шинжлэхэд маш тустай, үзэл санааны арга хэрэгсэл болж байна.

Монголын эдийн засаг неолибералчлагдаж байгаа агуулгаараа бол Монголчууд ардчилсан сонгуулийг нөөц бүрдүүлэх, ашигтай гүйлгээ хийх талбар болгон хувиргав. Тиймээс, сонгууль нь төрөл бүрийн үйлдвэрлэл явуулахаас өгсүүлээд бусад боломжуудтай учир суудлынхаа тооноос олон ялагчтай цогцолбор болон хувирчээ. Хууль тогтоох байгууллагын гишүүн болох нь нэр дэвшигчийн үндсэн зорилго боловч олон шатлал бүхий, өргөн хүрээнд өрнөх сонгуулийн үйл явц жижигхэн ашиг хайх хүмүүст ч мөн боломж олгоно. Өмнөх социалист төрөөс улбаатай сонгогчдыг (зарим талаар сонгогчид ч гэлтгүй нийт иргэдийг) дайчлах, бүртгэх, мөшгөх далд үүрэг бүхий бүтэц нь сонгуульжилтын үйл явцад чухал үүрэг гүйцэтгэсэн. Тийм учир, ардчилсан сонгуулийн үндэс болсон сонгогчдын ирц өндөр байх нь тоталитар тогтолцооны өв уламжлалтай холбоотой.

Сонгууль яагаад ийм өргөн дэлгэр болдог, ард иргэд яагаад сонгуульд оролцож саналаа өгсөөр байдаг вэ гэсэн асуултын хариу нь Борнеманы (2011) үзсэнээр сонгуулийг ялагдсан хүмүүсийг тайтгаруулаад зогсохгүй, харин сонгууль нь маш олон төрлийн боломж, амлалт, төрөл бүрийн итгэл найдвар төрүүлэх орон зай болсонтой холбоотой гэсэн илүү тэлсэн аргумент дэвшүүлсэн билээ. Мөн сонгууль нь баяр

ёслолын шинжтэй үйл явдал төдийгүй цаг хугацаа, нийгэм, дэд бүтцэд оршин байх өдөр тутмын амьдралын нэг хэсэг болжээ. Ардчилагдах үйл явц, түүний зэрэгцээ неолиберал шинэчлэлийн түүхийг дэлгэснээр би социализмын дараа ядууралд нэрвэгдсэн ажилчин ангид хийсэн “шок эмчилгээ”-ний сөрөг нөлөөнөөс гадна, нэр дэвшигчид, сонгогчид хэрхэн сонгуулийн анхдагч зориулалтыг өөрсөдөө тохируулж сонгуулийн өрсөлдөөнийг хэрхэн хөгжүүлсэн талаар харууллаа. Сонгуулийн кампанит ажил хэдий чинээ сүр дуулиантай, далд сурталчилгаа нь хэдий чинээ удаан үргэлжилнэ, эмэгтэй нэр дэвшигчдийн ур чадвар, бүтээлч байдлаас үл хамаараад тэдэнд төдий чинээ өрсөлдөхөд хэцүү байдлыг үүсгэнэ. Сонгууль нь цаг хугацааны зохицуулалттай үйл явдлаас өөрчлөгдөж, далд байдлаар байнга үргэлжлэх болсон нь эмэгтэй нэр дэвшигчид өрсөлдөхөд хүндрэл учруулсаар байна.

Эцэст нь, нийгэм-улс төрийн тогтоц болохын хувьд сонгууль нь үндэсний хэмжээнд нэгэн төрлийн улс төрийн цаг хугацааны мөчлөгийг бий болгожээ. Хотын захад, эсвэл орон нутагт амьдрах иргэдэд үргэлж шинэчлэл, хөгжил, интеграцчлалаас гадна үлдэж, хоцрогдсон гэх мэдрэмж төрж байдаг (Plueckhahn 2020; Smith 2020). Эдгээр хүмүүс өөр цаг хугацаа, түүхэн болон хөгжлийн өөр үеийг эзэлдэг гэж боддог. Энэхүү цаг хугацааны зүү нь дэлхийн хөгжил, шинэчлэлтэй хамгийн ойр орших улсын нийслэл Улаанбаатар хотод түрүүлж эргэх бөгөөд, дараа нь улс орны бусад хэсэгт, өөр өөр цагийн зүү цохилно.

Нэмж дурдахад, аж үйлдвэржилтийн өмнөх үе гэгддэг нийгмийн адилаар Монголд өөр өөр нийгмийн бүлэг жигд эргэх цагийн зүүнээс үл хамааран улирлын шинжтэй, цаг агаарын нөхцөлд суурилсан, мал хариулах гэх мэт цаг хугацааны онцлог бүхий янз бүрийн амьдралын хэв маягаар амьдарна. Харин энэ цаг хугацаа нь ойлголтын хувьд нэгэн жигд үргэлжилж, өмнө өгүүлсэн шиг цагийн зүү нь ээлжлэн цохино. Жишээлбэл, цаг агаарын өөрчлөлт нь Монгол орны хаа сайгүй орших нүүдлийн мал аж ахуй эрхлэх малчин иргэдийн нүүдэллэх төлөвлөгөө, хугацаанд нөлөөлнө. Тиймээс, улсын өмнөд хэсэгт амьдардаг малчид, магадгүй хойд хэсэгт амьдрах малчдаас арай хожуу өвөлжөө рүүгээ нүүнэ. Нутаг дэвсгэрийн байршил, түүнд зонхилох малын төрөл, малчдын хийдэг цагаан идээ, нүүдэллэх цаг хугацаа зэргээс шалтгаалж, өдөр тутам, болон улирлын чанартай үйл ажиллагаанууд харилцан адилгүй. Энэ бол байгалийн жам ёсны цагийг дагаж байгаа нь.

Улс төрийн цаг гэдэг нь харин хүний нийгмээс зохиож улс орны үйл явдлыг товлох цаг. 9-р сарын 1-ний өдөр эхлэх хичээлийн шинэ жил, түүнээс хоёр долоо хоногийн өмнө үндэстэн даяараа хичээлийн шинэ жилд бэлддэгийн адил улс төрийн байнга давтагддаг үйл явдлын адил сонгуульжилт улс орныг бүхэлд нь зэрэгцээ горимд оруулна. Өмнө өгүүлсэнчлэн, Монголд төрөл бүрийн цаг хугацаанд амьдрах янз бүрийн

нийгмийн бүлгүүдэд нэгэн төрлийн улс төрийн цаг хугацаа нэмэгджээ. Тэр нь сонгуулийн цаг хугацаа юм. Зурагт хуудас, хэвлэл мэдээлэл, сонгогчидтой хийх нэр дэвшигчийн уулзалт, сонгогчдын талаар ам уралдан хэлэлцэх сонгогчид зэргийг шингээсэн сонгуулийн кампанит ажил нь улс үндэстнийг бүхэлд нь улс төрийн нэг агшинд цуглуулах бөгөөд төвөөс зах руу, хотоос хөдөө рүү хөврөх мэдээллийн урсгал нь улс төрийн цагийн зөрүүг арилгана. Алслагдсан бүсийн иргэд мэдээлэл болон бараа бүтээгдэхүүнд бусдаасаа хожимдож хүрэх нь орон нутгийнхны санаа зовнил, хоцрогдсон мэдрэмжийг төрүүлсээр ирсэн. Энэ агуулгаар, сонгуулийн сурталчилгааны үеэр түр зуур ч атугай мэдээлэл, нөөц, тэр бүү хэл нэр дэвшигчидтэйгээ уулзах уулзалт нь улс орон даяар зэрэг өрнөх тул алс нутгийн маш олон иргэдэд хоцрогдож үлдсэн гэх мэдрэмжийг нь үргээнэ. Нэр дэвшигч Чимэдийн Базарын сурталчилгааны самбар дээр харагдаж байгаачлан (дүрс 2.6) хүнээ дээдлэх сайн цагийг бид авчирна гэсэн улс төрийн мессежийг Иргэний Зориг Нам дэвшүүлжээ.



Дүрс 2.6. Хүнээ дээдлэх сайн цагийг бид авчирна гэсэн уриа бүхий Иргэний Зориг намын сурталчилгааны самбар. Улаанбаатар, 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Карол Грийнхаусын томьёолсноор “Марксын цаг үе түүх мэт” (1996, 2) гэдгийн адил сонгуулийн бус үеийн цаг хугацаа шугаман байдлаар үргэлжилнэ. Энэ үед сонгуулийн кампанит ажил албан ёсоор өрнөхгүй, үгүйдээ л маш чимээ багатай байх боловч сонгуулийн үеэр баригдсан дэд бүтэц, баялаг, хэвлэл мэдээллийн сувгаар нийгмийн нэгдэл, сүлжээ болон улс төрийн намын орон нутаг дахь салбар хороо нь сонгогчдод дараагийн сонгууль болохыг харуулсаар байдаг. Хамгийн чухал нь энэ улс төрийн цаг хугацаа ард түмний субъектив шинж байдалд нөлөөлөх хүчтэй байдаг тул ард иргэд ч амьдралынхаа мөчлөгт сонгуулийн цаг хугацааг заавал төлөвлөдөг болсон. Учир нь аль улс төрийн нам

сонгуульд ялснаас шалтгаалан төр засгийн удирдлага солигдож, төрийн албан тушаал, нийгмийн зарим зохицуулалтууд ялсан намын гишүүд рүү шилжих дөрвөн жилийн цикл нь хүмүүсийн амьдралд чичирхийлэл өгөх мэт мэдрэгддэг тул арга ч үгүй юм.

Нөгөө талаар Монголд сонгуулийн кампанит ажлын үеэр нийгмийн туршлагыг илэрхийлэх, ямар нэг зөвшилцөлгүйгээр нийгмийн эв нэгдлийн хүрээг бий болгож байдаг хэмнэл, мөчлөгөөр тодорхойлогддог нь Дюркхеймийн хэлсэнчлэн, “хамтын эрмүүн дэврүүн байдал” нийгэмд үүсгэнэ (Durkheim 1995, 212-17). Явцуу утгаараа Монгол дахь сонгуулийн кампанит ажил нь төрөл бүрийн нийгмийн бүлэг, тоглогчид, газар нутгийг түр хугацаанд нэг түвшинд авчирдаг хамтын төлөөллийн хэлбэр гэж ойлгож болно. Нийгмийн цаг хугацаа гэдэг нь хамтын хүчин зүтгэлийн илэрхийлэл гэж хэлсэн Дюркхеймийн ойлголт нь неолиберал, постсоциалист шугаман цаг хугацааг хөнгөвчлөх сонгуульжилтын чухал шинж чанар юм. Чухамдаа энд өгүүлж буй нийгмийн цаг хугацааг ард иргэд, нэн ялангуяа энэхүү номын гол цөм болсон эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн үр дүн, бодит агуулгыг хамгийн ихээр мэдрч байгаа билээ.

“Бодит хувь хүнээс нийгэм бүтэх бөгөөд . . . ийнхүү нийгмүүд нь тэлж хөгжиж байдаг” (Greenhouse 1996, 3) буюу улс төрийн цаг хугацаа нь сонгуулийн кампанит ажил, сонгогчдын оролцоо хоорондын холбоосоор бүтэж байдаг юм. Хамгийн энгийнээр ойлгоход, нийгмийн харилцаа, эдийн засгийн үйлдвэрлэл, дайчилгаа, нийгэмд өрнөх яриа, хэлэлцүүлэг нь нэр дэвшигчийг сонгогчидтой нь холбож байдаг гэсэн үг. Зурагт хуудас, өргөн нэвтрүүлгээр нэр дэвшигчийн үндэс угсаа, орон нутгийн онцлог дүр төрхийг засаж янзлахын сацуу (Smith 2020), нэгэн төрлийн дээд давхаргын Монгол хүний танигдахуйг сурталчлах төлөвтэй. Төрийн болон албан ёсны арга хэмжээний үеэр ихэнх нэр дэвшигч болон идэвхтнүүд үндэсний албан ёсны Халх аялгаар ярьж эр, эм ялгаагүй ажил хэрэгч хослол өмсөх бөгөөд харин кампанит ажлынхан нь футболк өмсөж буй нь сонгуулийн үйл ажиллагааны албан ёсны байдлыг нэмэгдүүлнэ. Зөвхөн сонгогчид л дуртай хувцсаа өмсөж, дуртай аялгаараа ярьж, дуртай эд зүйлсээ хэрэглэдэг нь олон янз байдлыг өөрсдөөрөө илэрхийлэх мэт.

2008 оны сонгуулийн дараа болсон үймээн самуун, хүчирхийллээс үзэхэд сонгуульжилт нь “улирлын”, хагас хувьсгалын шинжтэй болох нь харагддаг. (2008 оны үймээнийг Засгийн газар хүчээр дарснаас болж иймэрхүү төрлийн цуглаанууд зогссон. Дараа нь нийгмийн сүлжээний хэрэглээний өсөлттэй холбоотойгоор энэ цугларалтууд цахимд шилжив). 1990, 2000-аад оны турш хавар бүр, цагаан сарын дараа, нийслэл хотод, хүйтэн өвөл өнгөрмөгц улс төрийн амьдрал сэргэж эхэлдэг байв. Хаврын синдром гэгдэх энэ үеэр шинэ улс төрийн намууд, нийгмийн хөдөлгөөнүүд, болон хувь хүмүүс нийслэл хотын төв талбайд жагсаал, цуглаан зарлаж олон нийтийг урьж улс төрчдийг эсэргүүцэж,

шүүмжилнэ.²⁰ Жил бүр тохиолдох тус “синдром” нь ямар нэг байдлаар 1990 оны хаврын хувьсгалын эхний өдрүүдийг санагдуулахын учир нь 1990 оны хувьсгал ч мөн адил тус синдромын ихэнх шинжийг хадгалж байсных. Сонгуулийн өрсөлдөөний үеэр, улс төрийн бэлгэдлийн шинж тэмдэг хувьсгалт өнгөрсөн үеийн догдлолыг дахин бий болгож, ирэх сонгуульд бэлдэж буй хүмүүс, жил бүр болох хаврын улс төр хувьсгалын дурсамжийг санагдуулах нь улс төрөөс ангид байх иргэдийг ч уур амьсгалдаа татан оролцуулна. Эдгээр үйл явдлын дийлэнх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа мэдээгээр сайн түгээгддэг тул үзэж буй хүмүүс үндэсний хэлхээ холбоо, эв нэгдлийн холбоог эрчимжүүлж, өмнөх цуглаантай холбоотой дурсамжийг нь сэргээж, “мөнхийн хувьсгал”-ын мэдрэмжийг бий болгоно.²¹

²⁰ 2007 онд албан ёсоор бүртгэгдсэн Иргэний Хөдөлгөөний нам сайн жишээнд тооцогдоно. Улс төрийн нам болохоос өмнө, Гүржийн Цэцгийн хувьсгал, Украйны Улбар шар хувьсгал, Киргизстаны Алтанзул цэцгийн буюу ягаан хувьсгал болон Беларусын хувьсгал зэрэг Төв Азид болсон өнгөт хувьсгалуудаас урам авсан иргэний хөдөлгөөн байсан юм. Гудамжинд өрнөж байсан улс төрийн цуглаануудаас Батзандан (Иргэний Хөдөлгөөний удирдагч асан) гэх мэт Монгол УИХ-ын олон гишүүн төрсөн билээ.

²¹ Телевиз нь мэдээгээр дамжуулж өнгөрсөн үеийн дурсамжийг сэргээхийн зэрэгцээ үндэстнийг тэр чигт нь хамарсан нандин холбоос үүсгэх хүчтэй хэрэгсэл болж чаддаг талаар Мэри Стидли (2000) үзнэ үү.

Гадаргуу: Кампанит ажил ба жендэр, улс төрийн харилцан хамаарал

Өнөө үеийн өнгөц шинж

Социалист төрийн үзэл суртал ч, капиталист зах зээл ч эмэгтэй хүний дүр төрхийг өөрсдийн үзэл баримтлалаа бататгахын тулд түгээмлээр ашигласаар иржээ. Хоёр тогтолцоо өөрсдийн өвөрмөц дүр төрхийн дэглэмийг тогтоож, тэр дэглэм нь зөрчилтэй дүр төрх санаануудыг тууштай үгүйсгэдэг бөлгөө. Социалист төр иргэдийнхээ танигдахуй, мөн иргэдийн нийгэмд гүйцэтгэх үүргийг үзэл суртлаар чиглүүлэхдээ эмэгтэй хүнийг хувьсгалч, хөдөлмөрч, эх хүн гэх шинжийг илүү тодруулна (дүрс 3.1). Ийнхүү дүрслэхэд материаллаг, биеийн, болон оюун санааны хүсэл эрмэлзлийг нь огт ойшоохгүй. Эсрэгээрээ орчин цагийн зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд эмэгтэй хүний танигдахуйг бараа, бүтээгдэхүүнтэй хамт ойлгож, хэрэглээг дэмжихэд эмэгтэйчүүдийг ашиглах хандлагатай байдаг. Бараг 100 шахам шил үргэлжилсэн тэгш байдлын төлөөх тэмцлийн дараа бид Виржиниа Вүлфийн (2019 (1929)) тэмдэглэснээр, эмэгтэйчүүдийн бодит байдалд тулгарах хүндрэл бэрхшээлийг нь бус, тэдний гоо үзэсгэлэнг нь онцолсон дүр төрх төдийхнөөр ойлгож буй нь харамсалтай. Социалист төр ч тэр, зах зээлийн сурталчилгаач тэр эмэгтэйчүүдийн дүр төрхийг зөвхөн өөрсдийнхөө зорилгод хүрэхийн төлөө ашиглах бөгөөд эмэгтэйчүүдийн бодит амьдрал дахь асуудалд хангалттай анхаарахгүй иржээ.

Социалист суртал ухуулга, зах зээлийн сурталчилгаа эмэгтэйчүүдийн дүр төрхийг хаа сайгүй ашиглах хэдий ч сонгуулийн кампанит ажлын

зурагт самбарт эмэгтэйчүүд цөөн харагдах нь өнөөгийн улс төрд эмэгтэйчүүд ховор байгаагийн толин тусгал гэлтэй. 2008 оны 5-р сард би судалгааныхаа мэдээллийг цуглуулахаар сонгуулийн кампанит ажлын хэсэг хүмүүстэй орон нутгаар явж байлаа. Ингэж явахад эрэгтэй нэр дэвшигчдийн зурагт самбар, хөрөг зураг байшингийн хана, дэлгүүр, худалдааны төвийн үүд, зах руу орох хаалга гээд хаа сайгүй харагдана. Хот хоорондын замд явахад энгийн үедээ хийжүүлсэн ундаа, гоо сайхны бүтээгдэхүүн, тансаг загварын машины сурталчилгаа байрлах самбаруудыг сонгуулийн үеэр хар хослолтой, үсээ дэгжин засуулсан эрэгтэй улс төрчдийн гэрэл зургууд эзэлсэн байхтай таарав. Миний судалгаанд оролцогчдын, тэр тусмаа тухайн тойрогт нэр дэвшиж буй эмэгтэй нэр дэвшигчийн нэг ширхэг ч томоохон самбартай тааралдсангүй. Тухайн тойрогт нэр дэвшин сонгогдохоор хүчин чармайлт гаргаж буй бүсгүйн зурагт хуудас аймгийн төвд ч, аймаг руу хүрэх зам дагуу ч харагдсангүй. Эмэгтэйчүүд хотын тойрогт сонгогдох арай илүү магадлалтай гэх, тэр нь ч үнэн байх. Гэвч тэдгээр эмэгтэйчүүд илүү хүчирхэг эрэгтэй өрсөлдөгчид, өндөр зардал бүхий кампанит ажил, зурагт хуудсаа байрлуулах боломж хязгаарлагдмал орон зай зэрэгтэй нүүр тулах болно. Хүн ам ихтэй хотын тойргууд нь илүү хүчирхэг нэр дэвшигчидтэй байх төдийгүй кампанит ажлынх нь гадаргуу ч нэр дэвшигчдээр пиг дүүрэн байх аж.

Сонгуулийн кампанит ажил нь сонгогчдод илүү хүрэхийн тулд гадаргуугийн төлөөх өрсөлдөөн билээ. Дэлхийн хоёрдугаар дайны өмнө Ваймарын Бүгд найрамдах улсын үеийн соёлын томоохон шилжилт, түүний хувьслын гэрч болсон Германы нийгмийн философич Зигфрид Кракауэр, “гадаргуу нь нийгмийн хамгийн бодит байдлыг илэрхийлэгч” гэж тэмдэглэжээ. Тэрээр “Түмний гоёл” (The Mass Ornament 1995) хэмээх өөрийн үндсэн бүтээлдээ дараах зүйлийг өгүүлсэн.

Аливаа цаг үе хэрхэн бий болсон түүхэн үйл явцыг ойлгоход тухайн цаг үеийн талаарх хүмүүсийнх нь санал бодлоос илүүтэй хамгийн ердийн үл анзаарагдам гадаргууг шинжлэх нь илүү тустай байж болох. Бусдын санаа бодол нь тухайн цаг үеийн талаарх аливаа нэгэн үзэл бодлын илэрхийлэл байх тул тухайн цаг үеийнхээ ерөнхий агуулга, тодорхой нотолгоог бүрнээр нь агуулдаггүй. Гадаад талбарын илэрхийлэл нь ухамсаргүй төлөв байдлаараа аливаа юмсын мөн чанарыг ямар нэг ялгамжгүйгээр ойлгох боломжийг олгоно. Эсрэгээрээ, аливаа юмсын талаарх мэдлэг нь тухайн гадаргуугийн талаарх илэрхийллийг хэрхэн тайлбарлахаас шалтгаална. Аливаа түүхэн мөчийн суурь мөн чанар, түүний илэн далангүй илэрхийлэл хоёр бие биеэ тодотгож байдаг(1995, 75).



Дүрс 3.1. 1993 оны Улаанбаатар хотын орон сууцны барилга дээрх социалист маягийн ханын зураг. Кристофер Капланскийгийн дарсан гэрэл зураг.

Би Кракауэрын энэ ойлголтыг ашиглан сонгуулийн кампанит ажлын талбар, тэдний материаллаг байдал, мэдрэхүйг тайлбарлах нь оновчтой гэж үзлээ. Тэрээр өөрийн үзэл санаагаа Ваймарын Бүгд Найрамдах Улсын үед түгээмэл байсан бүжигчин охидын цэнгээнт үзүүлбэр дэх синхрон хөдөлгөөнийг судалж, тэрхүү бүтээлийн илэрхийлж буй

тодорхойгүй байдлыг тодотгосон нь, гадаргууг анхаарах нь чухал гэх санааг постсоциалист Монголын нөхцөлд хэрэглэхэд яг тохирно. Кракауэрийн онолоор бол бүжигчин охидын биеэрээ дэглэн бүтээж буй олон төрлийн хээ угалзны ард ямар нэг бодит зүйл агуулсан санаа байхгүй гэжээ. Тэр бүжигчид бол бүжгийн хээ угалз мэт элементийг бүрдүүлээд бүжиг бол болоод л дуусна. Харин бүжигчид нь дэглүүлж дасгалжуулсан бие махбод сэтгэхүйтэй үлдэнэ. Монголын сонгуулийн кампанит ажлын хэвлэл мэдээллийн урсгал, гудамж дүүрэн зурагт хуудаснууд сонгогчдын анхаарлыг л татах зорилготой байсан боловч цаг үеийн улс төрийн нөлөөгөөр жендэрийн ойлголтыг хэвшүүлсээр байна. Өөрөөр хэлбэл, зурагт хуудасны цаад зорилго нь маш тодорхой боловч, зорилгоосоо илүү уршигт үр дагавар тарьж байгаа энэхүү санамсаргүй гадаргуу нь тухайн үеийн мөн чанарыг дээр Кракауэрийн хэлснээр ямар нэг ялгамжгүйгээр ойлгох боломжийг олгоно.

Энэ бүлэгт би улс төр, жендэр хоёр хэрхэн биеэсээ харилцан хамааралтай байдгийг зурагт хуудасны жишгээр тайлбарлана. Ингэхдээ сонгуулийн сурталчилгааны зурагт хуудасны улиг болсон агуулга, эдгээр зурагт хуудас хэрхэн хаа сайгүй ашиглагдах болсны шалтгааны эрэлхийлэхийг хичээнэ. Зурагт хуудас нь сонгуулийн кампанит ажлын маш том орон зай дахь олон төрлийн зүйлсийн ердөө нэг хэсэг гэдгийг ойлгох хэрэгтэй. Тиймээс, энэ бүлгийн эхэнд би уншигчдаа Улаанбаатар хотын гудамжаар дагуулан алхуулах болно. Үүний зорилго нь 2008 болон 2012, 2016 оны сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн кампанит ажил, ялангуяа зурагт хуудас хэрхэн нийтэд гүн нэвчсэн, заримдаа сүрреалист, бас заримдаа инээдтэй ч гэмээр хэтэрсэн байдлыг уншигчдаа мэдрүүлэхэд оршино.¹ Монголын сонгуульд (мэдээж бусад олон улсад байдгийн адил) зурагт хуудас яагаад ийм өргөн дэлгэр ашиглагдах болов гэж асууя. Сонгуулийн ямар хэв загвар, нөхцөл байдал хэрхэн 2008 оны сонгууль зурагт хуудсаар дүүрэхэд нөлөөлөв? Бид эдгээр зурагт хуудасны хэлбэр, агуулгаас улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо жендэрийн төлөөлөл хоорондын холбоос, бодит туршлагын талаар юуг мэдэж болох вэ? Сонгуулийн сурталчилгааны зурагт хуудаснууд нь жендэрийн төлөөллийг хэрхэн илэрхийлж, тэр бүү хэл хэлбэржүүлж байдаг вэ?

Эдгээр асуултад хариулт эрэлхийлэх явцад ардчиллын хамгийн үнэт туршлага болсон чөлөөт сонгууль хэрхэн жендэрийн тэгш бус байдлын талаарх зовнилын үндэс болсныг ойлгох түлхүүр болсон юм. Жоан Скотт (2018), Клод Лэфорт (1988) нарын үзэл санаанд тулгуурласнаар, би жендэрийн талаарх ойлголтууд нь хэрхэн өөрчлөгдөж бас хэрхэн тогтворжиж байгааг ойлгож мэдлээ. Сонгуулийн сурталчилгааны

¹ Зурагт хуудас маягийн нэр дэвшигчийн сурталчилгаа 2012, 2016 оны сонгуулиудад арай багассан нь сонгуулийн дизайн, эдийн засгийн өөрчлөлтөөс гадна социал медиаг өргөнөөр ашиглах болсонтой холбоотой юм.

зурагт хуудаснууд сонгуульжилтыг өнөөгийн нийгмийн агуулга, үнэт зүйлс дээр тулгуурласан нийгэм улс төрийн тогтоц болгон бэхжүүлж, шинээр автоматаар бий болгож буй дүр төрхтэй хоршиж байна гэж би үзлээ. Хэдийгээр зурагт хуудас нь аюулгүй, дотно санагдам, эрсдэл багатай контенттой боловч хэт олныг үйлдвэрлэснээр улиг болж түүгээрээ орон зайг эзэгнэдэг. Эрсдэлгүй контент нь улс төрийн орон зайд хэт болгоомжилсон, айдастай буйг, хаа сайгүй харагдах байдал нь сандарч буйг илэрхийлнэ. Тэгэхээр эелдэг гэмээр дүр төрхтэй зурагт хуудас ч сонгуульжилтын зохион байгуулалттай, нөлөө бүхий хүчийг илэрхийлнэ. Учир нь сурталчилгааны зурагт хуудасны ард улс төрийн намуудын болон бие даан нэр дэвшигчдийн үл үзэгдэх өрсөлдөөн оршдог. Ихэнх хүмүүс зурагт хуудсанд ая илэрхийлэх жендэрийн зохист хэм хэмжээний талаар бүрхэгдүү хандлагатай байх бөгөөд тэдний сонголтууд нь тэдний технологийн болон эдийн засгийн боломжоос бас их хамаарсан байдаг. Сонгож оруулсан зургуудын ард болсон үйл явдалд угсаатан зүйн шинжилгээ хийснээр жендэр, улс төр хоёр хэрхэн холбоотойгоор хувьсдагийг харуулж, бас хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн кампанит ажлын үеэр жендэрийн ялгааг хэрхэн илчилж, эсвэл нууж байдгийг харуулахыг хичээлээ.

Хэвлэл мэдээллийн кампанит ажлын сүрреалист орчин

Эрэгтэй нэр дэвшигчдийн зурагт хуудас хамгийн алслагдсан газарт ч бас байршжээ. Улаанбаатар хот хүртэл 10 цаг явах замынхаа тал хавьд бид хоол идэхээр хаа нэгтээ зам дагуу хоолны газарт зогслоо. Нэр дэвшигчийн аварга том хөрөг зураг хоолны газрын үүдийг бүхэлд нь халхалжээ. Бид цуйван, гурилтай шөл, хуушуураа идэх зуураа хананд суурилуулсан хавтгай зурагтаар сонгуулийн сурталчилгааны видео үзэж суув. Хоолны газар биднээс өөр хүнгүй боловч, хана дүүрэн нэр дэвшигчдийн хөрөг зургуудыг өлгөжээ. Тэдгээр нь ердөө зураг боловч хоромхон зуур биднийг харж байгаа мэт жигтэй санагдана. Хоолны газрын эзнийх бололтой хажуугийн ганц гэрийн гадна нэр дэвшигчдийн хөрөг зургуудыг байрлуулсан нь дандаа эрчүүд байх аж. Сонгуулийн зөвлөхүүдийн машинд бид сонгуулийн сурталчилгааны тухай ярилцаж, сурталчилгаанд зориулсан нийтийн дуунууд сонсож явлаа. Монголын өргөн уудам, хоосон талд хүртэл бид сонгуулийн сурталчилгаа нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохоос зайлах аргагүй аж.

Шөнө дунд болсон хойно Улаанбаатарт ирэхэд хов хоосон байдаг хотын гудамжнууд зурагт самбараар дүүрчээ. Аварга том зурагт хуудаснуудыг дээрээс нь доош хөшиг мэт тал бүрдээ өлгөсөн Бөхийн өргөөний дугуй барилгын гадаа зогсоход тэр том зурагт хуудаснууд салхинд сэвэлзэх нь амь орж байгаа мэт санагдана. Жихүүцмээр. Бусад

гудамжнууд руу харлаа. Хотын сонгогчид хөдөөгийн сонгогчидтой харьцуулахад эмэгтэй нэр дэвшигчдэд нөхөрсөг ханддаг гэгддэг бөгөөд тоймгүй олон зурагт хуудасны дундаас эмэгтэй нэр дэвшигчийнх ганц нэг үзэгдэж байв. Сонгуулийн сурталчилгааны материалууд хаа сайгүй. Гэртээ орохоор лифтэнд суусан ч зурагт хуудас өлгөөтэй. Манай тойрогт өрсөлдөж буй 22 нэр дэвшигчийн сэтгүүл, танилцуулга, хуанли, нэрийн хуудас, сонин, ил захидал гээд тоймгүй олон материал хоолны ширээн дээр ч, хайрцаг дотор ч хөглөрнө. Сурталчилгааны материалууд төрөл бүрийн байх бөгөөд зарим нь их бүтээлч ханджээ. Тоглоом, хөлөгт тоглоом, хүнсний бүтээгдэхүүн, ханын цаг, кофены аяга, нэр дэвшигчийн нэр бүхий нойлын цаас. Гэвч энэ номд зурагт хуудасны талаар л өгүүлье.

Маргааш өглөө нь босоод би гудамжаар алхлаа. Хоёр долоо хоног эзгүй байх зуур хотын гудамж театрын тайз мэт болжээ. Хотын төв гудамж дагуух 20-р зууны дунд үед баригдсан 3-5 давхар барилгууд бүхэлдээ улс төрийн намын, болон бие даан нэр дэвшигчид сурталчилгаагаа өлгөх орон зай болон хувирсан байв. Байшингийн орой, хана, хаалганууд хүртэл нэр дэвшигчдийн зургаар халхлагджээ. Гэрлийн шон, байшингийн дээвэр гээд эргэн тойрон бүхэлдээ зарын самбар болсон байна. Цонхноос бусад зай бүр зурагт хуудсаар дүүрсэн тул зөвлөх үйлчилгээний Максима Консалтинг ХХК дүрс 3.2-т үзүүлсэн газарт байрлуулах самбарыг [2008 онд] бүтээжээ. 2016, 2020 оны сонгуульд харин барилгын хананд зарын самбар байрлуулахыг хуулиар хориглов. Оронд нь замын хажууд, тодорхой байршилд самбар байрлуулахыг зөвшөөрсөн тул зурагт хуудас, самбарууд хөндлөн гулд байршиж бас нэмээд зурагт хуудас биедээ үүрсэн хүн-плакатууд хүртэл энд тэндгүй зогсож байлаа (дүрс 3.3).



Дүрс. 3.2. Максима консалтинг ХХК-ийн бүтээсэн Бүдээгийн Мөнхтуяагийн сурталчилгааны самбар. 2008 он. Нэргүйн Баасанхүүгийн дарсан зураг.



Дүрс 3.3. Арилжааны сурталчилгааны самбарын оронд болон байшингийн хананд сонгуулийн нэр дэвшигчийн самбар байрлуулахыг хориглосноор бий болсон сурталчилгааны самбарууд. Улаанбаатар хот, 2020 он. Ядамсүрэнгийн Хишигсүрэн гийн дарсан зураг

Кампанит ажил сонгогчдыг татахын тулд хэвлэл мэдээллийн болон технологийн боломжит бүх стратегийг ашиглана. Маш олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуультай зэрэгцэн үүссэн бөгөөд тэдний 74 хувь нь ямар нэг байдлаар улс төрийн харьяалалтай байдаг (Gruska, Dreyer, Renzhenbrink 2016). Тухайлбал, 1980-аад оны сүүл үед улсын хэмжээнд ганцхан телевизийн суваг байсан бол 2020 онд орон нутгийн телевизүүдийг оруулалгүйгээр 131 телевизийн сувагтай болжээ. Телевизийн нэгэн адил, Монголын хэвлэл мэдээллийн орчин төрөлжиж, боломжит бүх салбарт өргөжин тэлсээр байна. Сонгуулийн кампанит ажилд ашиглах техник хэрэгсэл ч мөн адил сонгогчидтой уулзах уулзалтын үед хэрэглэх чанга яригч, байшингуудын голын талбайд Монгол гэр барьж сонгуульд ашиглах, LCD дэлгэц суурилуулсан ачааны машин, такси доторх зорчигчдод зориулсан LCD дэлгэц, гар утасны харилцаа холбоо, радио, зөөврийн хөгжим, ханын хуанли, кофены аяга зэрэг бэлэг сэлт, сурталчилгааны материал гэх мэтээр үлэмж төрөлжжээ. Мөн телевиз, радио хөтөлбөрүүд, сонин, сэтгүүл, ил захидал, Фейсбүүк, Твиттер (2016 оны сонгуулийн үеэс эхлэн онцгой ач холбогдолтой болсон) гэх мэт нийгмийн сүлжээг ч мөн оруулна.

Дуу хураагуураар урьдчилан бичсэн кампанит ажлын сурталчилгааг чанга яригчаар цацах хүнсний дэлгүүрийн хажуугаар алхаж явахад сонгуулийн сурталчилгаа үзэгдэх байдлаас хальж, сонсогдох байдал руу өргөжин тэлж буй нь надад мэдрэгдэв. Хотын өнцөг булан бүрд чанга яригчаар сонгогчидтой хийх нэр дэвшигчдийн уулзалтын зар хүргэж, сонгогчдоо уулзалтад урина. Нэг уулзалтын үеэр нэр дэвшигчийн яриа

микрофоноор дамжин хотын төвийн гудамж даяар цуурайтан сонстлоо. Оройдоо хотын томоохонд тооцогдох олон нийгийн талбайд үнэ төлбөргүй концерт тоглох нь онцгой.

Тэр өдөр би Улаанбаатар хотын төвөөс баруун жигүүрт орших Баянгол дүүрэг руу явж байлаа. Хоёр дүүргийн сурталчилгааны хуудаснууд ажиглахаас гадна зарим ажил амжуулахаар гарч байгаа нь тэр. Гараа даллаж таксинд суувал жолоочийн суудлын ард зорчигчдод зориулсан жижиг дэлгэцээр сонгуулийн сурталчилгаа явж байх нь тэр. Би Монголд анх удаа ийм өндөр технологийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахтай таарсан минь энэ байлаа. Жижиг дэлгэцийн талаар жолоочоос асуувал тэрээр энэ дэлгэцийг саяхан шинээр суулгасан бөгөөд бүх таксинд байгаа талаар хэлэв. Би хэдэн хормын турш нэр дэвшигчийн сурталчилгааг тоглуулах тэрхүү жижиг дэлгэц рүү гөлөрч орхилоо. Тэрхүү дэлгэцээс хараагаа салгаж таксины цонхоор гудамж харвал “Бид . . . -нд итгэж байна”, “Бид . . . -ыг дэмжиж байна”, “. . . -ны төлөө саналаа өгцгөөе” гэсэн үгсийг нэр дэвшигчийн бодит хэмжээтэй зургийн хамт байрлуулсан ачааны машин харагдав. Эцэст нь ачааны машины ард суурилуулсан аварга том LCD дэлгэцээр сонгуулийн сурталчилгааг цацаж буй нь Монголын хэвлэл мэдээллийн салбар шинэчлэгдэж өндөр технологийг ашиглаж буйн дохио мэт (дүрс 3.4).



Дүрс 3.4. LCD дэлгэц бүхий “Явуулын сонгуулийн штаб”. Улаанбаатар хот, 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Хаа сайгүй тархсан, хөдөлгөөнт кампанит ажил нь боломжит, сул орон зай бүрийг дүүргэсэн, хэлбэрт баригдашгүй зүйл мэт сэтгэгдэл төрүүлнэ. Үүн дээр нэмээд нэр дэвшигчдийн сонгуулийн штаб тоосгон, бетонон

барилгаас өгсүүлээд монгол гэр хүртэл хаа сайгүй суурин хэлбэрээр ч бас байлаа. Сонгуулийн кампанит ажил нь хоорондоо холбоотой хэд хэдэн шатлалтай бөгөөд шат болгон нь захиргааны байгууллагатай. Нэгдүгээрт, албан ёсны сонгууль хариуцсан төв байгууллага нь Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) бөгөөд дүүргийн хороо, тойргийн хороо, хэсгийн хороо гэх гурван шатлалтай. Эдгээр засаг захиргааны бүтэц сонгуулийн санал авах байрыг зохион байгуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг цэгцэлж, сонгуульд оролцохыг уриалах нөлөөллийн ажлыг хариуцна. Хоёрдугаарт, улс төрийн намын сонгуулийн төв штаб гол төлөв намын төв байранд байрлах бөгөөд намын дарга удирдана. Улс төрийн намын сонгуулийн кампанит ажил нь СЕХ-ноос хараат бус байна. Гэсэн хэдий ч, намын штаб СЕХ-ны бүх шатлалын байгууллагатай, ялангуяа тойргийн хороотой ойр ажиллаж байв. Гуравдугаарт, нэр дэвшигчийн хувийн сонгуулийн штаб байх бөгөөд бараг л бүхэлд нь нэр дэвшигч өөрөө санхүүжүүлнэ. Түүнээс гадна нэр дэвшигчид намын нэгдсэн сонгуулийн кампанит ажилд хандив өгөх шаардлагатай болдог.

Монголчууд сонгуулийн үйл ажиллагааг удирдах ажлын албаа штаб гэх Орос үгээр нэрлэнэ. Чинээлэг нэр дэвшигчид нь олон штаб зэрэг ажиллуулна. Эдгээр нь зурагт хуудас болон бусад зүйлсийн үндсэн талбар тул энд дурдав. Штаб нь хэвлэл мэдээллийн ажил, уулзалт, хэлэлцүүлэг, хоол цай, зугаа цэнгэл гэх мэт динамик сурталчилгааны орон зай юм. Сонгуулийн штаб төрөл бүрийн хэлбэртэй. Зарим нь байшин барилгад, эсвэл орон сууцны хороолол дундах Монгол гэрт (дүрс 3.5) байрлана. Нэг удаа би ганцхан барилгын ойролцоо долоон өөр нэр дэвшигчийн долоон сонгуулийн штабыг олж тоолсон юм. Тэдгээрийн хоёр нь барилгын нэгдүгээр давхарт, гурав нь барилгын гадаа тусгайлан барьсан гэрт, үлдсэн хоёр нь тус барилгын хажууд орших жижиг мухлагт байрлаж байлаа.

Эсрэгээрээ Баянгол дүүргийн сонгуулийн тойрогт МАХН-ын нэг бүлгийн сонгуулийн олон штабыг ч олж тоолж үзэв. Тус бүлэг дөрвөн гишүүнтэй. Эдгээр штабыг найзынхаа амьдардаг байрнаас, ойролцоох худалдааны төвөөс, дүүргийн МАХН-ын хорооны барилгаас мөн дунд сургуулийн байрнаас олж харав. Тус бүлэг сонгуулийн тойргийнхоо 28 хороо тус бүрд өөрсдийн штабтай байсан байх. Эдгээр бүлэг штабаас гадна дөрвөн нэр дэвшигч тус бүр тойрог даяар өөр өөрсдийн сонгуулийн штабаа бас байгуулжээ. Эдгээрээс боловсролын сайд асан эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн штаб номын дэлгүүртэй залгаатай байсан нь албаар боловсролын орчинтой нийлүүлсэн мэт. Нэр дэвшигчид өөрсдийнхөө зурагт хуудас, далбаа, сурталчилгааны мессеж зэргээ сонгуулийн штабуудаасаа гадна тойргийн гол зам, гудамж, явган хүний зам, худалдаа, үйлчилгээний төвүүдэд ч байршуулжээ.



Дүрс 3.5. Орон сууцны цогцолбор дунд байрлах сонгуулийн штаб. 2008 он. Зохиогчийн дарсан зураг.



Дүрс 3.6. Энх тайвны өргөн чөлөө дагуух нэр дэвшигчдийн зурагт хуудаснууд. Улаанбаатар хот, 2012 он. Зохиогчийн дарсан зураг. 2012 оны сонгуулийн үеэр 2008 оны сонгуулийнхтай адил зурагт хуудаснууд хаа сайгүй байсан юм.

Сурталчилгааны эхэн үед тэрхүү бүлгийн зурагт хуудаснууд хаа сайгүй таарч байсныг сайн анзааралгүй явсаар гэнэт би өөрийгөө санамсаргүйгээр төөрч, нэг газраараа дахин эргэлдээд байна уу гэж эргэлзэж билээ. Хаана ч явсан нөгөө дөрвөн нэр дэвшигчийн нэгэн

ижил зурагт хуудастай тааралдана. Тухайн тойрог дахь худалдаа, үйлчилгээний төвүүд төвлөрснөөс болоод би тэр хавиар л ажлуудаа амжуулахаар эргэлдэж байсан аж. Би хэд хэдэн удаа зогсож, урдах, ардах хэсгээ ажиглан зөв замаараа явж байна уу гэдгээ шалгаж байлаа. Миний дурдсан МАХН-ын дөрвөн нэр дэвшигч Баянгол дүүрэгт өрсөлдөж буй нийт 31 нэр дэвшигчийн дөрөв нь байсан юм. Үлдсэн 27 нэр дэвшигч нь бусад намаас болон бие даан нэр дэвшигчид байсан бөгөөд мөн л өөр өөрсдийн багийн болон хувийн штабуудыг ажиллуулж, харагдах болон сонсогдох байдлаар сурталчилгаа хийж, төрөл бүрийн байршилд сонгогчидтой уулзалт хийж, ачааны машин, жижиг автобус ашиглан хөдөлгөөнт сурталчилгаа хийж, ухуулагчид нь ижил хувцсаар жигдэрч, далбаагаа барин сонгуулийн материал тараасаар байсан юм. Нэг нэр дэвшигч ижил зурагт хуудсаа хэт олон байршуулснаас болж төөрсөн мэт мэдрэмж маань өнгөрсөн 24 цагийн хугацаанд төрсөн гурав дахь этгээд жигтэй мэдрэмж байв. Дахин дахин тааралдах ижил зураг намайг төөрдөг байшинд оруулж урхидаж буй мэт. Хэт илүүдээд байсан эдгээр зурагт хуудсыг дараагийн хэсэгт илүү нарийвчлан тайлбарлана.

Тогтоож болох зай бүхнийг ашиглан (2008, 2012 оны сонгуулийн үеэр) тогтоосон зурагт хуудаснуудаас гадна, хоорондоо өрсөлдөх улс төрийн намын далбаа ч мөн адил хотыг дүүргэжээ (дүрс 3.6). Далбаа байрлуулах нь социализмын үед түгээмэл байсан туршлага хэдий ч, ингэглээ ихээр ашиглаж байсангүй. Сэтгүүлч Цэрэндоржийн Дашдондов (2003) “Баярын тухай гунигт бодол” хэмээх нийтлэлдээ төрийн далбааг хэт их үйлдвэрлэж, хурдан буулгаж байгааг шүүмжилсэн. Тэрээр, ингэглээ их далбаа үйлдвэрлэх нь угаас хязгаарлагдмал улсын төсвийн буруу зарцуулалт гэжээ. Төрийн ордны хажууд байрлах Улсын Гоёл Чимэглэлийн Үйлдвэрт баяр болгоноор далбаа үйлдвэрлэж гурав хоног мандуулаад дараа нь устгадаг байв. Харин ардчиллын үед улс төрийн намууд өөрсдийн далбаагаа гадаад, дотоодод үйлдвэрлэнэ. Тэдгээр далбааг гудамжинд, тагтанд, ачааны машин гээд төрөл бүрийн байршилд мандуулах бөгөөд сонгуулийн сурталчилгааны ухуулагчид хотын хаа сайгүй далбаа барьж явна.

Энэхүү сонгуулийн сурталчилгаа нь бүх орон зайгаар дэлбэрэх мэт гарч ирснээр УИХ-ын сонгууль хоорондын дөрвөн жилийн туршид аливаа арга хэмжээ, гадаад хэлний үнэгүй сургалтын дамжаа гэх мэт далдуур үргэлжилсэн сонгуулийн кампанит ажил албан ёсоор гадаад орон зайд ил гарч, илүү тод өрнөж дүүрэв. Сонгогчид өмнө нь зохион байгуулж байсан баярын арга хэмжээ, үнэгүй хэлний дамжааг тойрогт нь нэр дэвшигч санхүүжүүлж байсныг ойлгож эхэлнэ (үгүйдээ л таамаглаж байсан нь баталгаажна). Сонгууль гадна талдаа ихээхэн өргөн хүрээг эзэлжээ. Энэ хэсэгт сонгуулийн кампанит ажлын орчин ямар өргөн болох тухай, нэр дэвшигчийн зурагт хуудас хэрхэн хаа

сайгүй байршсан тухай танилцуулахыг хичээлээ. Үүнийг би гурван удаагийн жигтэй тохиолдлоор дүрсэлсэн. Эхний тохиолдол нь хоосон шахуу хоолны газрын эргэн тойронд өлгөгдсөн нэр дэвшигчдийн зурагт хуудасны талаар өгүүлсэн. Хоёр дахь нь шөнийн цагаар хүнгүй, харанхуй хотын гудамжинд аварга том зурагт хуудаснууд салхинд сэвэлзэх нь жигтэй. Гурав дахь тохиолдол нь Баянгол дүүрэгт төөрсөн мэт мэдрэмж төрүүлэм хаа сайгүй өлгөгдсөн ижил зурагт хуудаснууд тэр хавийг бүхэлд нь нөмөрсөн талаар дурдсан. Эдгээр мэдрэмж нь надад төрсөн хувийн мэдрэмж бөгөөд уншигчдадаа сонгуулийн кампанит ажил хэт өргөн, зурагт хуудаснууд хаа сайгүй байршсан байдгийг ойлгуулахын тулд энд хуваалцлаа.

Хэмжээ: Яагаад ийм их байдаг вэ?

Хаа сайгүй байрших нэр дэвшигчийн зурагт хуудаснууд нь улс орон даяар зонхилох сонгуулийн кампанит ажлын орчны ердөө нэг хэсэг билээ. Ардчиллыг дэмждэг институтүүдийн өнцгөөс харвал нэр дэвшигчийн зурагт хуудасны олон янз байдал нь чөлөөт, ардчилсан сонгуулийн шинж тэмдэг мөн. Сонгуулийн сурталчилгааны үеэр үнийн хөөрөгдөлд хүрсэн зурагт хуудаснууд нь Монгол Улс уул уурхайн лиценз, ирээдүйд орох орлого, гадаадын хөрөнгө оруулалтаас үүдэлтэй эдийн засгийн өсөлтийн үед байсны илрэл гэлтэй. Сонгуулийн самбар, ялангуяа нэр дэвшигчийн хөрөг бүхий зурагт хуудас нь Монголд ардчилсан сонгууль хийж эхэлснээс хойших сонгуулийн кампанит ажлын нэг хэсэг байсаар ирсэн хэдий ч, 2008 оны сонгуульд нэр дэвшигчид зурагт хуудаснуудад ихээхэн найдсан юм. 2008 оны сонгуулийн хуульд орсон гол өөрчлөлтүүд нь сонгуулийн кампанит ажил нүсэр болоход нөлөөлжээ. 2004 онд 76 тойрогтой байсан бол 2008 онд 26 тойрогтой болгосон нь нэг сонгуулийн тойргийн хэмжээг бараг гурав дахин томгосон. Сонгогчдын тоо ч мөн гурав дахин өсөхийн сацуу нэг мандаттай сонгуулийн тойргоос олон мандаттай сонгуулийн тойрог руу шилжив. Албан ёсны сонгуулийн сурталчилгааны хугацаа гурван долоо хоног болж богинослоо. Томгосон тойрогт, богиносгосон хугацаанд сурталчилгаагаа хийхийн тулд нэр дэвшигчид аль чадах чинээгээрээ хэвлэл мэдээлэл, технологийг ашиглахыг хичээх болсон юм². Зурагт хуудас хэт олон болоход сонгуулийн хуулийн өөрчлөлт чухал нөлөө үзүүлжээ. Гэсэн хэдий ч хуулийн өөрчлөлт нь зурагт хуудас хэт олшрохын цор ганц шалтгаан байсангүй. Өмнөх сонгуулиудаар ч зурагт хуудаснууд ашиглагдсаар байсан билээ.

Өргөн хүрээний кампанит ажил, зурагт хуудасны галзуурал нь Францын философич Клод Лэфортын (1988) “Ардчилал эрх мэдлийн

² 2004 онд 76 сонгуулийн тойрогтой байсан бол 2008 онд 26, 2016 онд буцаад 76 тойрогтой болжээ.

орон зайг хоосолдог” гэсэн үзэл санаатай сууриараа холбогддог. Европын хаант засаглалд төрийн бүрэн эрх мэдлийг ямар нэг бодит бие эзэлдэг, эрхшээдэг бол ардчилалд төлөөллөөр (парламент) дамжин төрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, “эрх мэдлийн орон зай хоосон газар болж хувирах бөгөөд . . . ямар ч хувь хүн, ямар ч бүлэг этгээд энэ хоосон орон зайг бүрэн төлөөлөх, бүрэн нэгдэх боломжгүй” (Lefort 1988, 17). Сонгогдсон төлөөлөгчид нийт нийгмээ бүтэн төлөөлж чадахгүй тул энэхүү хоосон байдлаас зугтах аргагүй болдог гэж Лэфорт (1988) үзжээ.

Лэфорт (1988) тоталитар дэглэм ард түмэн, эрх мэдэл хоорондын орон зайг устгаж, энэ хоёрыг нэгтгэх гэсэн оролдлого гэж үзжээ. Тус үзэл санаа нь коммунизмын хувьсгалч үзэл суртлын эхэн үед үндэслэн гарсан байж болох ч, тоталитар дэглэм бодит амьдралд ихээхэн өөр байсан юм. Алексей Юрчак (2015) Мэйфэйр Янг (2018) нар Лениний цогцсыг Зөвлөлт Холбоот Улсад, Маогийн цогцсыг Хятадад ариун эзэн хаан мэт авч үздэг байсан талаар өгүүлдэг. Ялангуяа Лениний цогцос шинжлэх ухааны хөгжлийн объект байсан бөгөөд түүний биеийн 77 хувийг өөр бодисоор нөхөж, Лениний бунханд зөвхөн түүний цогцсыг хадгалах зориулалттай биотехнологийн лаборатори ажилладаг байж (Yurchak 2015).³ Харин Монголын хувьсгалчид Дамдины Сүхбаатар, Маршал Чойбалсан нарын биеийг бунханд хадгалж, хэдийгээр занданшуулах боловсронгуй технологигүй ч гэсэн хүндэтгэлтэй ханддаг байлаа (Delaplache 2010). Мөн, Монголчууд төрийг хийсвэр, тэнгэрлэг зүйл гэж үзэх үзэл нь социализмын үед ч хадгалагдан үлдсэн. Төр бол ер бусын, тусгай орших зүйл бөгөөд төрийг институтүүдийн цогц гэдгээс тусад нь авч үзнэ. Өөрөөр хэлбэл, тоталитар дэглэм ард түмэн, бүрэн эрхт удирдагч хоёрын хоорондын орон зайг устгаагүй юм.

Ардчиллын үйл явцтай зэрэгцээд ард түмэн, эрх мэдэл хоорондын орон зай, ялангуяа чөлөөт сонгуулиар багассан боловч, Монголд “эрх мэдлийн орон зайн” хоосон байдал нэмэгдсэн. Монголчуудын үндсэрхэг үзлийн төвд байх Чингис хааныг шүтэх үзэл, түүнээс үүдэлтэй хүчтэй удирдагч хэрэгтэй гэх олон нийтийн дунд байх түгээмэл яриа зэрэг нь улс орон хүссэн хэмжээний бодит удирдагчийг үгүйлж буйн илрэл бололтой.⁴ Хуучны удирдагчдын биеийг бунхнаас гаргаж, оршуулсан нь (Delaplache 2010) эрх мэдлийн бодит бэлгэдлийг үгүй хийв. Дараа нь шинэ, тодорхойгүй ардчилсан удирдагчид иргэдийн урмыг хугалж, санааг зовоох боллоо. Дөрвөн жил тутамд болох

³ Алексей Юрчак (2015) тоталитар дэглэмийн удирдагчид бүрэн эрхт байдлаас үлдсэн орон зайг дүүргэх боловч, “ленинизмийн” дүр төрхийг хүлээн авч, өөрсдийнхөө биеэр биш, харин Ленинист намын, лениний биеэр дамжуулан дүүргэх хэрэгтэй байдаг тул Зөвлөлт Холбоот Улсыг үнэлсэн Лэфортын үнэлгээ алдаатай хэмээн үздэг.

⁴ Социализмын үед, 1962 онд Хэнтий аймагт Чингис Хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэснийг Зөвлөлүүд ихэд буруушаав (Bulag 1998).

сонгуулийн давтамж (УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн), олон талт байдал нь төрийн эрх мэдэлд бодит удирдагч байхгүй мэт мэдрэмжийг улам хурцална. Бүрэн эрхт удирдагч тогтвортой засагладаг байдал нь ардчилалд “төр, үндэстэн, иргэн, төлөөлөгч, хувь хүн гэсэн хийсвэр олон төрлийн ойлголтоор” солигддог (Scott 2018, 9).

Нийгэм соёлын үүднээс авч үзвэл удирдагчийн бие үгүй хоосон орон зайг нэр дэвшигчийн хөрөг бүхий зурагт хуудаснууд дүүргэхийг эрмэлзэж буй мэт. Ардчиллын эрх мэдлийн орон зай тодорхойгүй, хоосон байдаг гэх Лэфортын үзэл санаа, тэрхүү хоосон орон зайг дүүргэх оролдлого мэт хаа сайгүй тархан байрласан зурагт хуудасны урсгал хооронд нарийн холбоос бий. Зурагт хуудаснууд тодорхой техникээр тодорхой бус байдлаас зайлсхийхийг хичээдэг. Жишээлбэл, гэрэл зургийн хэв маяг хуучны авторитар дэглэмийн үеийн удирдагчдын хөргийг санагдуулам (зураг дээрх байдал, зургийн байршил гэх мэт) (Spyer and Steedly 2013) нүүр царайгаа тодруулж, зарлаж, эрх мэдэлд байршуулж буй мэт. Зурагт хуудас бүр олон нийтийн орон зайг нүүр царайгаараа дүүргэхийг эрмэлздэг тул зурагт хуудас бүрийн ард дүр төрхөө сонгогчдын оюун санаанд суулгах зорилго бий. Сонгуулийн үед ялангуяа эмэгтэй хүний хувьд биеийн харагдах байдлаас гадна, нүүр царай хамгийн чухал хэрэгсэл билээ.

Нийтийн орон зайд нэвтэрснээр зурагт хуудаснууд олны анхаарлыг татахын сацуу тэднийг улс төрийн орон зайд хүчээр татан оролцуулдаг. Нэр дэвшигчид телевиз, интернэт, сонин сэтгүүлийг сурталчилгаагаараа дүүргэх боловч, иргэд цахим хуудас, сувгаа сольж, тараасан сурталчилгааны материалтай танилцахгүй ч байж болно. Харин гудамжинд байрлуулсан зурагт хуудсыг харахгүй өнгөрөх аргагүй. Монголд, үгйдээ л 2008 оны сонгуулиар зурагт хуудас бүхий том самбаруудыг буулгах оролдлогууд гарсаар байсан ч, сонгогчид тэдгээр самбаруудыг харахгүй байх боломж бага. Бүр зурагт хуудсан дээр нэр дэвшигчийн зураг дээр давхарлаж зурах, танигдахгүй болгох оролдлогууд нь харин ч улам анхаарал татаж, илүү ашигтай болгож байлаа. Зурагт хуудаснууд хоорондоо “тэмцэлдэж” байв. Ихэнх тохиолдолд зурагт хуудаснууд нь “дүрс болон үйл явдлыг” хослон өгүүлсэн “нийгмийн янз бүрийн хүмүүстэй үр дүнтэй холбогдох” хэрэглэл (Strassler 2020, 9-10)⁵ бус, зөвхөн нэр дэвшиж буйг л мэдүүлэх төдий үүрэг гүйцэтгэв.

⁵ Социал медиаг ихээр ашиглах болсон саяхны сурталчилгааны зураг нь, өмнө нь ихээр ашиглагдаж байсан гудамжны зурагт хуудаснуудтай харьцуулахад үзэгч, сонгогчидтой харилцах илүү боломжийг олгодог. Учир нь сонгогчид олон нийтэд ямар нэг буруу үйлдлийг сэрэмжлүүлэх, тохуурхах зорилгоор зургийг өөрчлөх болжээ.

Танигдах нь: уйтгартай зураг ба, эрсдэл хүлээгчид

2008, 2012 болон 2016 оны сонгуулийн зурагт хуудсыг харвал эрэгтэй нэр дэвшигчдийн зураг нь паспортын зураг мэт цайвар өнгийн сорочкан цамц, хар хослол өмсөж, нэг тал руугаа самнасан спорт халимаг үстэй, байлаа.⁶ Нийтлэг ийм дүр төрх нь шүүмжлэл, доромжлол дагуулж болзошгүй ямар нэгэн хувийн онцлогийг зориудаар хассан эрсдэл багатай сонголт юм. Тэд эрх мэдэл, байр суурийг эрхэмлэнэ. Монголын болон бусад хэд хэдэн улсын сонгуульд ажиллаж байсан Орос зөвлөх улс төрийн зурагт хуудсанд баримтлах хэд хэдэн дүрэм буй талаар надад ярьж байсан юм. Үргэлж дэгжин, минимал байх ёстой бөгөөд буруу тайлбарлагдахааргүй, хүмүүсийн анхаарлыг сарниулах элдэв чимэглэлгүй байх ёстой. Социологич Маурицио Ладаратогийн бичсэнээр улс төрийн зурагт хуудас нь урлагийн бүтээл мэт “олон утга санаатай”, “олон дуу хоолойг агуулсан” бус, харин “нэг зорилго”, “нэг л дуу хоолой”-г илэрхийлэх ёстой аж (2014,72). Улс төрчийн зурагт хуудас нь Эрнст ван Алфены (2013) 1990 оноос хойших дүр төрх хэрхэн өөрчлөгдөж буйг “Дүр төрх нь гадагшаа, цаадах агуулга нь дотогшоо чиглэлтэй” хэмээн тайлбарласантай тохирох мэт. Сонгуулийн зурагт хуудаснууд В. Ж. Т Митчеллийн хэлснээр ямар нэг улс төрийн шаардлага тавигдахаас урьтаж байгаагаа санагдуулж, орон зайг эрхшээх мэт (2012, 10).

Нэгэн хэвийн сонгуулийн зурагт хуудаснууд нь Монголд л байдаг үзэгдэл биш. Эрдэмтэд, “хүмүүс албаны хэв маягийн дүр төрхийг л ахин дахин үйлдвэрлэх, гүйцэтгэх” явдал хаа сайгүй ихсэж буйг тэмдэглэв (Boyer and Yurchak 2010, 182). Инээд хөөртэй, багт наадмын маягийн дүр төрх (Klumbyte 2014) бүтээх, эсвэл элэглэл, чин сэтгэл хоорондын заагийг бүдгэрүүлэх гэх мэт үйлдэл нь (Boyer 2013) улс төрд оролцох арга хэрэгслүүдийн нэг мөн байсан ч, тун цөөн хэрэглэгддэг байна. Доминик Боер, Алексей Юрчак нар (2010) ЗХУ-ын социализмын сүүл үе 1970, 1980-аад оны болон либерал АНУ-ын 2000-аад оны сүүл үед улс төрийн зурагт хуудаснууд өөрийгөө өөртэйгөө харьцуулах, давтах, урьдчилан таамаглах, төлөөллийн давамгайл хэв маягийг хэт урлах зэрэг хандлагын хувьд төстэй байсан болохыг ажиглажээ. Юрчак (2007) иймэрхүү төстэй байдал 1950-аад оны сүүл үеэс эхэлсэн гэж үзэв. Энэ үед ЗХУ-д улс төрийн талаарх аливаа бичвэр хэл шинжлэлийн хуультай нийцдэг, хамгийн сайнд тооцогддог байсан төдийгүй, контекстээс үл хамааран шууд утга илэрхийлэх тул субъектив байдлаар тайлбарлах ч боломжгүй байжээ. Улс төрийн бичвэрт дүрслэлийн хэв маяг ч хэвийн үзэгдэл болж, тогтолцооны гол элемент болов (Yurchak 2007). 1980-аад онд энэ төрлийн хэв маяг (хошигнол, ёжлолын хэлбэрээр ч болтугай) газар авлаа. Боер (2013) ч мөн адил АНУ-д төдийгүй бусад

⁶ Хэдийгээр энэ номд судлаагүй ч гэлээ имижийн хэв маяг өмнөх сонгуулиудад ч мөн хамаарна.

олон газруудад улс төрийн яриа, сэдэв илүү албан ёсны илүү нэгэн төрлийн болж буйг ажиглажээ. Үүний зэрэгцээ, хэвлэл мэдээллийн дэд бүтцэд корпорацууд монополчилж, контентыг хэт хялбарчлах, тодорхой төлөөллийн хэлбэрүүд олшроход нөлөөлөв.

Монголд зурагт хуудас нэгэн хэлбэртэй байдаг нь зарим талаараа УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хязгаарлагдмал байдалтай холбоотой. Эрх мэдэлд хүрсэн, өмнө нь сонгогдож байсан туршлагатай удирдлагуудынхаа хэв маягийг эмэгтэйчүүд төдийгүй маш олон нэр дэвшигчид дуурайх хандлагатай байдаг. Нэр дэвшигчид бас сонгогчдоос ирж болох шүүмжлэлээс урьдчилан сэргийлэхийн тулд илүү дутуу онц гойд байдалтай гарахаас бүр ч их сэргийлнэ. Улс төрийн намын сонгуулийн төв штабаас цөөн тооны студитэй хамтарч ажилладаг нь тэндээс гарах зурагт хуудаснууд хоорондоо төстэй байдагт бас нөлөөлжээ. Мөн, өмнө нь дурдсанчлан, 2008 оны сонгууль олон мандаттай тойрогтой байсан тул сонгуулийн тойрог бүрд нэг намаас нэг нэр дэвшигч бус, нэг намаас олон нэр дэвшигч өрсөлдөх нь эсрэг намтай төдийгүй нам доторх өрсөлдөөнийг ч улам даамжруулна. Гэвч тус сонгуулийн үеэр улс төрийн намууд “багийн тоглолт”-ыг дэмжиж байсан нь нэг намаас багаар нэр дэвшигчид дүр төрхөө хоорондоо авцалдуулан тааруулж зурагт хуудсаа урлажээ.

Улс төрийн намууд социализмын эрин үеийн эв нэгдэл, тогтвортой байдлыг санагдуулахын тулд стандарт болсон, нэр хүндтэй гэгдэх дүр төрхийг бий болгохыг хичээж байв. Үүний адил Зүүн Европын постсоциалист улс орнууд ч (Gal and Kligman 2000; Creed 2011; Burawoy and Verdery 1999) ард түмний эв нэгдэл, залуу манлайлагчдын төлөөлөл (Greenberg 2006, 194) гэх мэт “социализмын үеийн бэлгэ тэмдэг”-ийг (2006, 197) ашиглан иргэдтэй холбогдохыг эрмэлзэж байсан юм. Сербид иймэрхүү социалист дүрс бэлгэдэл нь “засаглалын либерал ардчиллын хэлбэрээс үүдэлтэй талцан хуваагдал, хувийн ашиг сонирхолд суурилсан улс төрөөс сэргийлж улс төрийн шинэ талбарыг бий болгодог” (Greenberg 2006, 182). Сербчүүдтэй төстэй нь, Монголчууд ардчиллын туршлагыг улс төрийн тогтворгүй байдал, талцан хуваагдсан үндэстэн, чадваргүй удирдагчидтай холбон ойлгодог. Тиймээс, улс төрчдийн хөрөг зургийн нэгэн хэвийн байдал нь тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломж, дэг журам, хамгийн чухал нь социалист эрин үеийн хүчирхэг улс төрчдийг санагдуулах зорилго агуулна. Хэдийгээр социализмд буцах хүсэлтэй хүмүүс бараг байхгүй боловч улс төрчийн хөрөг зургууд социалист нийгэмд амьдарч үзсэн иргэдийн дурсамжийг сэргээнэ.

МАХН-ын төв байран дээрх 2008 оны сонгуулийн зурагт хуудсыг авч үзье. Тус зурагт хуудсанд МАХН-ын 20 нэр дэвшигчийн хөрөг байх бөгөөд эгнээний голд намын дарга байх аж. Самбарт “С.Баяр ба Түүний Нөхдийг Багаар нь Дэмжэе” гэсэн уриа үгс бичжээ. Социализмын үед амьдарч байсан Монголчууд тус уриаг хармагц Зөвлөлтийн зохиолч,

Дэлхийн Хоёрдугаар дайны баатар Аркадий Гайдарын Тимур ба Түүний Нөхөд (1940) гэх зохиол санаанд нь бууна. Тус зохиолд залуучууд төрийн албанд орж, дайны үед хамт олноо асарч буй тухай гардаг. Дэлхийн Хоёрдугаар дайны дараа үеийн Монголчуудын дийлэнх нь Тимур ба түүний нөхөд ёс суртахууны үлгэр жишээ хүмүүс болохыг гадарлана. Зурагт хуудсанд “багаар нь” хэмээн эв нэгдэл гэх агуулгыг онцлох мэт. МАХН “эв нэгдэл” гэх дүр төрхийг ашигладаг нь талцаан, хуваагдал бүхий АН-ын эсрэг өөрсдийгөө тодорхойлж буй улс төрийн намын онцлог шинж юм.

Зурагт хуудсыг байрлуулсан байршил, цаг хугацаа нь агуулгаасаа ч илүү ач холбогдолтой байсан төдийгүй нэр дэвшигчдийнхээ улс төр, эдийн засгийн хүчийг илэрхийлнэ. Патришиа Спайер, Мэри Стийдли (2013, 19) нар дүрс зургийг зохих үзэгчдэд нь хүргэхийн тулд байрлуулах, чимэглэх эргэн тойрных нь зүйлстэй холбон дүрс зургийг илүү тодруулах зэрэг төрөл бүрийн арга техникийг “хүрээлэх” гэх үгээр тайлбарлажээ. Сонгуулийн агуулгаар, зарын самбарууд хүрээлэх техникийн гол талбар болох бөгөөд үзэгчдэд хүргэх гол түлхүүр болж байдаг. Зурагт хуудсаа хэрхэн байршуулах нь зурагт хуудасны чанар, агуулгатай адил чухал ач холбогдолтой. Төв гудамж дахь зарын самбарын төлөө нэр дэвшигчид уралдах төдийгүй, үзэгчид нь харсан даруйдаа өөрийн хүрээлэл дотроо ам уралдан ярьцгаах тул тэдгээр самбарын түрээсийн үнэ сонгуулийн үеэр хэд дахин нэмэгдэнэ.

Тиймээс сурталчилгааны самбар өөрөө агуулгаасаа үл хамаараад улс төрийн мессежийг түгээнэ. Хамгийн сайн байршилд байх сурталчилгааны самбарыг дийлэнхдээ хамгийн хүчирхэг нэр дэвшигчид эзэлнэ. Нэр дэвшигчдийн дийлэнх нь нэр дэвших эсэх, аль тойрогт нэр дэвшихээ сонгуулийн өмнөх үе хүртэл мэдэхгүй тул тойргийн хуваарилалтыг хийх эрх мэдэл бүхий дарга нар л сурталчилгаагаа хаана байршуулахаа төлөвлөх боломжтой. 2008, 2012 онд сурталчилгааны самбарууд богино хугацаанд дүүрсэн тул маш олон нэр дэвшигчид зурагт хуудсаа байрлуулахад шинээр самбарууд суурилуулах шаардлагатай тулгарч, сонгуулийн сурталчилгааны гадаргууг үлэмж нэмлээ. Эдгээр сонгуулийн кампанит ажил богино хугацаанд болсон төдийгүй сонгуулийн сурталчилгаа эхлэхээс урьтаж сурталчилгааны самбаруудыг захиалж чадсан нэр дэвшигчидтэй харьцуулахад шинээр самбар суурилуулж буй нэр дэвшигчид зурагт хуудсаа байршуулах үнэт цагаа алдахын сацуу түүнийг дагаж их мөнгө зарцуулж байв. Хуучин сурталчилгааны самбарууд эрх мэдэл бүхий хүмүүсийн гол илэрхийлэл болжээ, заримдаа тэднийг бүр “од болгож” (Marwick 2015) эрх мэдлийг нь улам л бататгаж байлаа.

Уул шугамдаа нэр дэвшигчийн зурагт хуудас “эргэн тойрноосоо тусгаар тогтнож” үзэгчийн ой тоонд хоногшихоос гадна

өрсөлдөгчдийнхөө зурагт хуудсыг оршиж байгаа байдлаараа хязгаарлах ёстой (Spyer and Steedly 2013, 21). Гэсэн ч хэт шахцалдсан зурагт хуудасны цуглуулга нь сонгуулийн штабынхны найддаг шиг ямар нэг нэр дэвшигчийн талаарх дурсамжийг сонгогчдод үлдээх боломжгүй. Харин ч хаа сайгүй байршуулсан зурагт хуудас, түүний хэгийдсэн хэмжээ, нэгэн төрлийн агуулга, давтамж нь эсрэг нөлөө үзүүлнэ. Маш олон хүн надад “кампанит ажилд залхсан”, “дотор муухайрсан”, “залхуутай сонгуулиас хаашаа ч хамаагүй нүүх юм сан” гэж хэлж байлаа. Сонгогчдыг татах ёстой зурагт хуудас нь эсрэгээрээ сонгогчдоо үргээж байсан нь хоржоонтой.

Зурагт хуудсаа олон нийтийн анхаарал татахуйц байршилд байрлуулж чадсан эмэгтэй нэр дэвшигч цөөхөн байлаа. Эдгээр зурагт хуудас ерөнхий жишигт нийцэж, нийтлэг хэв маягийг хадгалах бөгөөд эмэгтэй нэр дэвшигчид гол төлөв хослол өмсөж, хүзүүний алчуур, болон бусад гоёл чимэглэл зүүжээ. Зурагт хуудсаа амжилттай байрлуулж чадсан эмэгтэй нэр дэвшигчид гол төлөв өмнө нь сонгогдсон УИХ-ын гишүүн, улс төрийн намд нөлөө бүхий албан тушаал хашдаг, үгүй бол томоохон бизнес эрхлэгчид байх аж. Эрэгтэй өрсөлдөгчдийнхөө адилаар тэд нийтийн шүүмжлэл, элдэв буруу тайлбарт автахаас сэргийлж эрсдэл багатай улс төрийн имиж бүтээхийг хичээжээ (жишээ нь дүрс 3.7).



Дүрс 3.7. Максима Консалтинг ХХК-ийн байрлуулсан Мөнхтуяагийн 2008 оны сонгуулийн зурагт хуудас. Зохиогчийн дарсан зураг.

Нөгөө талаар, улс төрд шинэ, бие даан нэр дэвших, шахагдсан, чинээлэг бус эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа хийх гэж үй олон бэрхшээлтэй тулгарч байв (жишээлбэл, нэр дэвшигч Жүрмэдийн Занаагийн талаар 5-р бүлэгт өгүүлнэ). Харин байршуулж чадсан тохиолдолд, тэдний зурагт хуудас нь бусад нэр дэвшигчийнх шиг нэгэн хэвийн, минимал, нэг утгатай буюу “зохист” зурагт хуудаснуудаас тэс өөр, харин ч хувийн үзэмжээрээ имижээ бүрдүүлсэн, олон талт байдлыг харуулсан зурагт хуудаснууд байлаа. Тэд шахагдсан хэдий ч, эрсдэл хүлээгчид байсан юм.

2008 онд АН-аас анх удаа нэр дэвшиж буй Раднаагийн Бурмаа сонгуулийн хөрөг зургаа цэцэглэж буй цагаан Моносын өмнө авхуулжээ. Бурмаа дийлэнх нэр дэвшигчдийн баримталдаг, дэгжин, цэвэр, сагааруулахааргүй гэх мэт ерөнхий жанжин шугамаас гадуур, ялгарахыг хичээж байлаа. Тэр цагаан өнгөөр цэвэр ариун, шударга, шинэ байдлыг илэрхийлэв. Монос мод зуны эхэн үеэр хэдхэн хоног цэцэглэдэг тул Бурмаа ч хамгийн тохиромжтой өдрийг хүлээлээ. Зарим нэг зөвлөх (өөр нэр дэвшигчийн сонгуульд ажиллаж байсан) Бурмаагийн зурагт хуудас цэцэг навч болсон “хэт зөөлөн” зэрэг байдлаараа “зохист улс төрийн” зурагт хуудас биш гэж хэлж байсан ч надад түүний онцлог шинжийг тодруулсан зурагт хуудас болсон санагддаг.

2008 оны сонгуулиар Иргэний Хөдөлгөөний Намаас нэр дэвшсэн өөр нэг эмэгтэй нэр дэвшигч Гантөмөрийн Уянга бодолд автсан зургаа кампанит ажилдаа ашиглажээ. Тэр даруйдаа шүүмжлэлд өртөв. Зарим нэг нь “хачин зураг вэ” гэж байсан бол зарим нь “нээх бодлогошроод л” гэгцгээж байлаа. Түүний зураг маш олон улс төрийн зөвлөхүүдийн илүү үздэг төвийг сахисан, энгийн, элдэв хэв маяггүй байх зэрэг нийтлэг хэв маягаас өөр байсан нь олон хүний анхаарлыг татсан бөгөөд хүмүүсийг юм бодогдуулснаараа онцлог байлаа (дүрс 3.8). 2012 оны сонгуулийн сурталчилгаанд Иргэний Хөдөлгөөний намын зурагт хуудаснууд хамгийн өвөрмөц байсан юм. Монгол Улсын газрын зурагт намаас нэр дэвших 38 нэр дэвшигчээ байрлуулжээ. Хамгийн сонин нь 38 нэр дэвшигчийн 36 нь эмэгтэйчүүд байв. Зурагт хуудас нь өвөрмөц, мэргэжлийн улс төрийн зөвлөхүүдийн хүлээлтэд нийцэхгүй, тийм ч зорилготой байсан биз (дүрс 3.9).



Дүрс 3.8. 2008 оны сонгуульд Иргэний Хөдөлгөөний намаас нэр дэвшигч Гантөмөрийн Уянга. Зохиогчийн дарсан зураг.



Дүрс 3.9. 2012 оны Иргэний Хөдөлгөөний намын сонгуулийн зурагт хуудас. Зохиогчийн дарсан зураг.

Хэрэв өрсөлдөөнт сонгуультай нөхцөлд зурагт хуудаснуудын нэгэн жигд агуулга нь сонгогчдод социалист төрийг санагуулдаг гэвэл тэдгээр зурагт хуудаснууд динамик солилцооны нэг хэсэг юм. Сонгуулийн

кампанит ажил харилцагчийнхаа дүр төрхийг өрсөлдөгчдийнх нь өмнө дахин үйлдвэрлэж, шинэчилж, дахин байрлуулсаар байна. Нэг талаар, тэдгээр зурагт хуудасны хэмжээ дамжаа, нэгэн хэвийн байдал нь өрсөлдөөний үр дүнд бий болсон туршлага бөгөөд томгосон тойрог бүхий сонгуулийн хэв загварт төдийгүй тодорхой түүхэн өөрчлөлтийн шилжилтээс үүдэлтэй үзэгдэл юм. Нөгөө талаар, эдгээр нь Кракауэрийн (1995) хэлснээр юмсын ухамсаргүй мөн чанарыг илэрхийлж буй гэлтэй. Зурагт хуудаснууд улс төрчдийн урагшаа алхах, эрсдэл хүлээхээс зайлсхийх эмгэгтэй зэрэгцээд эрсдэл бага, аюулгүй, танил арга барилаар ажиллах сонирхлоос үүдэлтэй. Өөрөөр хэлбэл, энэ нь улс төрд байнга эргэлдэх сонгуульжилтыг улам бүр хэлбэржүүлж байгааг илтгэнэ.

Гадаргын гүнд

Түүхч Жоун Скотт (2018) ардчилал бол эрх мэдлийн хоосон орон зай бий болгодог гэх Лэфортын үзэл санаанд үндэслэж, ардчилал эрх мэдлийн тогтворгүй байдлын талаарх зовнилыг бий болгох бөгөөд хүйсийн тухай ойлголтын биологийн шинжүүдийг лавшруулж ардчилсан удирдагчдын тодорхойгүй байдлыг тодорхой болгодог гэж үзсэн юм. Тэрээр улс төр бол жендэрийн [соёлд суурилсан] ойлголтыг үл ойшоож, хүйсийн [биологийн] ойлголтыг ашиглахыг эрмэлздэг гэжээ. Мөн, “Хүйсийн ялгаатай байдалд итгэх үнэмшил нь нийгмийн болон улс төрийн тэгш бус байдлыг бий болгох, эргээд улс төрөөс үүдэлтэй хүлээн зөвшөөрөгдөх байдал нь биологийн хөдөлшгүй мөн чанартай холбоотой” (Scott 2018,8) гэжээ. Скотт “чухамхүү ийм улс төрийн тогтворгүй байдлын үед л жендэрийн алслагдал бий болох тул . . . сэтгэлийн гүн хөрөнгө оруулалт хийх ёстой” (2018, 10) гэж үзсэн юм. Тэрээр, хүйсийн биологийн ялгааны талаар “хүйсийн ялгаатай байдал нь орчин үеийн улс төр оршихын нэг үндэс” бөгөөд улс төрд эмэгтэйчүүд бага оролцоотой, тэр хэрээр эрэгтэй шинж эрх мэдлийн илэрхийлэл болон биежсээр байна (10) гэжээ. Скотт дараах зүйлийг өгүүлэв.

Жендэр, улс төр хоёр нь хэдийнээ тогтсон ойлголтууд хоорондоо холбогдож, харилцан бие биедээ нөлөөлж буй хэрэг биш. Харин, тус бүрийнх нь тогтворгүй байдал нөгөөгөөсөө тодорхой байдлыг эрэлхийлдэг. Улс төрийн тогтолцоо эрх мэдлийн тэгш бус байдлыг илүү бэхжүүлэхийн тулд жендэрийн хувиршигүй байдлыг ашиглах хандлагатай. Ийм улс төрийн сэдэл нь хүйсийн ялгааг “засах”, улмаар улс төрд ч, хүйсэд ч саад учруулах тодорхойгүй байдлыг үгүйсгэж байдаг (2019,25).

Скоттын аргумент Монголын сонгуулийн кампанит ажлын улс төрд, ялангуяа эмэгтэй нэр дэвшигч хэрхэн сонгогдохуйц болдогтой холбоход маш нэмэртэй. Онолын хувьд, улс төрийн эрх мэдэл ирээдүйд ч хүлээн зөвшөөрөгдөхийн тулд жендэрийн хэм хэмжээг урьдчилан

таамаглагдахуйц болгохыг эрмэлздэг гэх Скоттын аргументтай би санал нэгдэж буй боловч, бодит амьдралд энэхүү үйл явц нь жендэрийн илүү динамик шилжилтийг бий болгодог гэдгийг олж мэдсэн. Энэ нь жендэрийн хэм хэмжээний тодорхойгүй байдалтай, ялангуяа Монголын нийгэм нэгэнт тогтсон, дээрээс доош удирдлагатай дэглэмээс, илүү олон ургалч, зах зээлд суурилсан нийгэм рүү шилжих үеийнхтэй илүү холбогддог. Түүнчлэн, эмэгтэй нэр дэвшигчид эмэгтэйлэг байдлын тохиромжтой хэлбэрийг эрэлхийлэхийн зэрэгцээ, тохиромжгүйг нь үгүйсгэж буй нь жендэрийн хэм хэмжээний шилжилтийн үйл явцыг үргэлжлүүлж байлаа. Дараах хэсэгт би, сонгуулийн сурталчилгааны зургууд жендэр, улс төр хоорондын холбоо хамаарлыг хэрхэн илэрхийлдгийг харуулна. Үүнд эмэгтэй нэр дэвшигчид нийгэмд хэвшсэн гэгддэг зарим эмэгтэйлэг шинжүүдийг сонгон тодотгодог нь ойлгомжтой. Хамгийн гол нь тэдний эрэлхийлж байгаа аль нэг жендэртэй холбогддоггүй соёлын болон ёс зүйн шинжүүд нь “эмэгтэйлэг” гэгдэх жендэрлэг болчихдогийг антропологийн үүднээс судлав. Мөн жендэрийн хэм хэмжээний өөрчлөлт нь Скоттын (2019) хэлснээр дандаа л хэвийн хэм хэмжээ болж нэвчдэггүй гэдгийг мөн харуулав. Харин нөгөө талаар эмэгтэй нэр дэвшигчид соёлын болон боловсролын хувьд жендэрийн бодит илэрхийлэл мөн боловч, УИХ-д сонгогдох магадлал нь бага. Хэдийгээр маш өндөр үнэ цэнтэй байлаа ч, хүн төрөлхтний бүтээсэн, олж авсан соёл “байгалийн жам ёс”-ноос үргэлж хоёрдугаарт тавигддаг, учир нь жам ёс хүний үйл ажиллагаанаас хол илүү хүчин чадалтай гэж үздэг билээ.



Дүрс 3.10. “Ардчиллын гурвыг сонгогчоо” зурагт хуудас. 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Кампанит ажлын зургуудаас улс төрд эмэгтэйчүүдийн нөлөө, жендэрийн талаарх ойлголт хэрхэн шинээр бий болж буйг харах боломжтой. Сонгуулийн кампанит ажилд жендэр хэрхэн ашиглагдаж, өөрчлөгдөж, илэрхийлэгдэж буйг харуулдаг тул эдгээр зургууд сонгууль нь жендэрийн шинж чанартай үйл явц гэдгийг бидэнд ойлгуулдаг. Эмэгтэйчүүд эрчүүдийн өрсөлдөгч бус, ихэнхдээ эрэгтэй нэр дэвшигчдийн хоорондын өрсөлдөөнд дагалдагч, дэмжигч, хүч нэмэгдүүлэгч мэт дүрслэгдэх нь түгээмэл. Тиймээс, маш олон эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийгөө илэрхийлэхдээ үүнийг санаж болгоомжтой хандана. Улс төрийн зурагт хуудас дээр эмэгтэй нэр дэвшигчийн харагдах байдлыг бүтээхэд гол төлөв олны танил хязгаарлагдам элементүүдийг ашиглаж нарийн нухацтай хандана. Зурагт хуудас нь эмэгтэйчүүдийн бэрхшээлүүдийг нуух боловч, зургийн ард өрнөж буй түүхүүд жендэр, улс төрийн хамаарлыг тод илэрхийлэх нь олон.

2008 оны сонгуулиар Бурмаа, хамтран нэр дэвшигч Элбэгдорж (АН-ын дарга), Баярсайхан (бизнес эрхлэгч бөгөөд анхлан нэр дэвшигч) нарын хамт “Ардчиллын гурвыг сонгоцгооё” гэх зурагт хуудас хийлгэжээ (дүрс 3.10). Тус зурагт хуудас цагаан дэвсгэр дээр паспортын маягийн гурван цээж зургийг цуглуулан зэрэгцүүлжээ. Гурван нэр дэвшигч гурвуул хар хөх өнгийн хослол өмссөн байв. Хослолын өнгө бие биедээ уусах тул Бурмаа нэр дэвшигч нөгөө хоёр (эрэгтэй) нэр дэвшигчийнхээ ард зогсож буйг хэн ч харсан даруйдаа анзаарахгүй. Зурагт хуудас гудамжинд байрласныг анх хараад “Хоёр залуу нь Бурмааг хоёр талаас нь шахан зогсоно”, “Ямар сонин зураг вэ” гэж бодсон талаараа миний судалгааны туслах Баасанхүү өөрийн тэмдэглэлдээ дурджээ. Сүүлд нь тэр зургийг сайтар ажиглаж байж хоёр эрэгтэй нэр дэвшигчийн мөр, Бурмаагийн мөрийг тагласан байсныг олж харсан юм.

Дараа нь Бурмаатай уулзахад, тэрээр: “Манай намын хоёр эрэгтэй нэр дэвшигч маань ганц эмэгтэйгээ ардаа зогсоочихсон. . . би тэр хоёрт МАХН-ын зурагт хуудсыг харуулж, жинхэнэ жентлмэнүүд ямар байдгийг сурч авцгаа” гэж хэлсэн талаараа надад ярилаа. Бурмаа нэмээд, эмэгтэй нэр дэвшигч нь хоёр эрэгтэй нэр дэвшигчийнхээ урд нь зогссон зурагт хуудасны (дүрс 3.11) талаар дурдаж, “МАХН-ын эрчүүд эмэгтэй хүнтэй хэрхэн харьцахыг мэддэг талаар намын нөхдөдөө сануулсан”⁷ гэв.

Зурагт хуудсанд өөрийнх нь арьсны өнгө илүү бараан гарсанд Бурмаа мөн сэтгэл дундуур байлаа. Эсрэгээрээ эрэгтэй нэр дэвшигчдийнх нь

⁷ Хоёр эрэгтэй нь ганц эмэгтэй нэр дэвшигчээ урдаа гаргасан зурагт хуудас нь ч мөн асуудалтай юм. Тус зурагт хуудсанд нэр дэвшигчдийн нэр байхгүй байгаа нь эмэгтэйнхээ сул талыг нь илүү тодотгож байгаа хэрэг. Хоёр эрэгтэй нэр дэвшигч нь 1990-ээд онд монголын ардчилал эхэлснээс хойших хамгийн алдартай улс төрчид билээ. Зүүн талын нэр дэвшигч Санжийн Баяр, 2008 онд Ерөнхий сайд МАН-ын дарга байв. Голын нэр дэвшигч Сүхбаатарын Батболд УИХ-ын гишүүн, Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан. Тэрээр 2009 онд Санжийн Баярын дараа намын дарга, Ерөнхий сайдын албан тушаалыг хаших болсон юм. Эсрэгээрээ олонд танигдсан хоёр эрэгтэй улс төртэй харьцуулахад, эмэгтэй нэр дэвшигч нь улс төрд бараг л цоо шинэ хүн байв.



Дүрс 3.11. Бүсгүйгээ урдаа гаргасан МАХН-ын “женгтлмэнуүдийн”-ийн постер. Тус постерт нэр дэвшигчдийн нэр бичигдээгүй байна. Хоёр эрэгтэй нэр дэвшигч нь Монголын олон нийтэд танигдсан улс төрчид бөгөөд эмэгтэй нэр дэвшигч нь улс төрд шинээр орж буй анагаахын ухааны доктор бүсгүй юм. Зохиогчийн дарсан зураг.

арьс арай цайвар гарчээ. Бурмаа, “Та яаж ингэж чадаж байна аа?” хэмээн Элбэгдоржтой уулзахдаа хэлж. “Өөрсдийгөө цайруулж, намайг пад хар гаргасан байна” гэж тэрээр эгдүүцэв. (Дараа нь тэдгээр зурагт хуудсыг арай сайжруулсан хувилбараар сольсон ч мөн л эрэгтэй нэр дэвшигчдийг илүү онцолсон хэвээр.) Ихэнх Монголчууд ялангуяа эмэгтэй хүний сэтгэл булаам байдлыг дүгнэхдээ бараан бус цайвар байхыг илүүд үзнэ. Арьсны өнгө зэрэг биеийн гадаад үзэмж нь хэр зэрэг орчин үеийн соёлтой, боловсрол, хувийн байр суурины үнэлэмж болдог. Зүүн болон Зүүн Хойд Азийн ихэнх улсад байдгийн адил, Монголд ч бас бараан арьс нь нийгмийн байр суурь доогуур, хөдөөгийн, бага боловсролтой гэх мэт шинжийг илэрхийлнэ. Бурмаагийн хувьд өөрийнхөө өндөр боловсрол, удирдагч, оюунлаг гэх мэт шинж чанараа онцолж нэр дэвшиж байсан учир тус зурагт хуудас түүний гол мөн чанаруудыг үгүйсгэсэн мэт. Бурмаагаас гадна олон хүн арьсны өнгийг бусад шинж чанартай холбож ойлгох нь хоцрогдсон, ялгаварласан шинжтэй гэж үзнэ. Гэвч, хүн амын олонх нь автоматаар цайвар арьсны өнгө хотын, илүү мэргэжлийн гэх шинжтэй холбож ойлгодог гэдгийг Бурмаа ч тэр бусад нь ч тэр мэдэж байсан юм. Бараан арьсыг ч гэсэн бас хотын, дээд зиндааны, мэргэжлийн хүмүүстэй холбохын тулд нийтийн сэтгэлгээ өөрчлөх ажил шаардах болно. Тэгэхлээр богинохон үргэлжлэх сонгуулийн кампанит ажлын хугацаанд нэр дэвшигчид нь сонгогчдын хувийн үзэмжийг засахыг оролдох нь бүтэшгүй ажил гэдгийг мэдэж байлаа.

Хэд хоногийн дараа, Элбэгдорж зураг дээрх байрлал, нүүрний өнгө зэрэг өмнө нь гаргасан алдаагаа засахыг хичээж ардчиллын гурав дахин

гэрэл зураг авхуулах боллоо. Нүүрний өнгийг засах амархан. Бурмаагийн арьс ч арай цайвар гарчээ. Гэвч Бурмаагийн өндрөөс болоод зураг дээрх байрлал нь болж өгөхгүй л байлаа. “Бурмааг урд гаргах боломж алга, тэмээ шиг л гозойж байна” гэж Элбэгдорж хэлэв. Элбэгдорж Бурмаагаас хоёр хуруу намхан, Баярсайхан Элбэгдоржтой ойролцоо өндөртэй аж. Элбэгдорж жижиг биетэйг (жижиг бие нь түүнийг хамгийн алдартай улс төрчдийн нэг болоход саад болсонгүйг тэмдэглэе) Монголчууд бүгд мэдэх боловч, эр хүн эмэгтэй хүнээс өндөр байх ёстой гэх жендэрийн хэвшмэл ойлголтод нийцэх зураг авхуулах гэж тэр гурав зүдэрчээ. Гэрэл зурагчны хамтаар дөрвүүлээ зураг хэрхэн авах талаар зөвлөлдөнө. Цувж алхаж буйгаар авхуулбал Бурмааг арай нам, эрчүүдийг арай өндөр харагдуулах өнцөг гарна. Гурван нэр дэвшигч гэрэл зурагчны өмнө оройжин алхсан амаргүй нэгэн оройг өнгөрүүлэв. Гэвч, тэр оройн гэрэл зургаас ашигласан сурталчилгааны самбар харагдсангүй.

Харин оронд нь хоёр нэмэлт зурагт хуудас хийгджээ. Нэг нь Элбэгдоржийг хамгийн өндөр, Баярсайханыг үл ялиг нам, Бурмааг хамгийн намхан харагдуулсан гурван нэр дэвшигчийн зургийн эвлүүлэг. Бодит амьдралд гурван нэр дэвшигчийн өндөр эсрэгээрээ тул эвлүүлэг хийсэн нь тодорхой. Эхний зурагт хуудастай харьцуулахад Бурмаагийн бодит төрхийг илүү харуулж, урд нь зогсоожээ. Хоёр дахь зурагт хуудсанд гурван нэр дэвшигч хотын гэр хорооллын урд хоорондоо ярилцаж буй мэт зогсоно. Энэ зураг хүрээлэн буй орчныг давуу тал болгон ашиглажээ. Эрчүүд чулуун дээр гишгэж үл ялиг өргөгдсөнөөр өндрийн асуудлыг шийдэв. Зураг дээр бүсэлхийнээс дээш хэсэг л харагдах тул чулуун дээр гишгэснийг харж чадахгүй (дүрс 3.12, 3.13). Тус зурагт хуудас эрчүүд өндөр, эмэгтэйчүүд цайвар байх ёстой гэх биологийн шинжид суурилсан жендэрийн хэвшмэл ойлголтод нийцүүлж тэрхүү хэвшмэл ойлголтыг улам даамжруулна. Нийгэм соёлын үүднээс, эмэгтэйгээ урдаа зогсоосноор тэднийг хүндэлж буй гэх давуу талыг ч шингээжээ. Эдгээр зурагт хуудасны ард орших түүх нь Жоан Скоттын жендэр улс төр хоёр нь харилцан бие биесээсээ өөрийгөө баталгаажуулахыг эрмэлзэх харилцан хамаарал бүхий ойлголтууд гэх санааг нотолно. Гэвч Бурмаагийн мэргэжлийн онцлог, иргэний нийгмийн удирдагч, болон түүний нэр хүнд энэ нөхцөлийг улам төвөгтэй болгож байв.

Бурмаагийн өндөр нь Элбэгдоржийг эр хүйсийнх нь дүр төрхөд заналхийлж байсан юм бол, АН-ын дарга хувьд яагаад Бурмааг хамтран нэр дэвшигчээр сонгов? Тэрээр эр хүйсийн хувьд өөрийнхөө эрэгтэйлэг дүрийг илүү тодруулж чадах жижиг биетэй маш олон эмэгтэйчүүдээс сонгож хамт нэр дэвших боломжтой байсан. Гэвч, Элбэгдорж хамтран нэр дэвшигчээрээ Бурмааг сонгосон. Бурмаагийн итгэмжит байдал Элбэгдоржийн хувьд бараг өөрөө төсөөлж байснаас ч үнэ цэнтэй байсан юм. Энэ талаар дараагийн хэсэгт өгүүлнэ.



Дүрс 3.12, 3.13. “Ардчиллын гурвыг сонгоцгооё” постерын шинэ хувилбарууд. Зохиогчийн дарсан зураг.

Шударга Жэндэр

Сурталчилгааны зурагт хуудаст нэр дэвшигчийн зургаас гадна нэр дэвшигчдийн нэр, уриа, улс төрийн намын нэр зэрэг бичвэрүүдийг агуулна. Бараан царайтай болголоо гэж Бурмаагийн дургүйцэж байсан мөнөөх постер дээр гурван нэр дэвшигчийн зурагтай хамт “Ардчиллын гурвыг сонгоцгооё” гэсэн бичиг оруулжээ. Нэр дэвшигчдийн овог нэрийг зурагт хуудасны дор бичив. Тус зурагт хуудсанд гурван нэр дэвшигчийн тодорхойлж буй мэт Шударга, Иргэнлэг, Эрч хүчтэй гэх гурван тэмдэг нэр харагдана. Гурван тэмдэг нэрийг хэрхэн сонгосон талаар авч үзье. Шударга, Иргэнлэг гэх хоёр үг намын дарга нь сонгуулийн үеэр Бурмааг тодорхойлон хэрэглэж байсан үгс юм. АН-ын дарга Элбэгдорж сонгогчидтой хийх нэгэн уулзалтын эхэнд хамтран нэр дэвшиж буй хоёр нэр дэвшигчээ танилцуулах үедээ, Бурмааг оюунлаг, шударга төдийгүй иргэний нийгэмд зүтгэж байсан талаар дурдаж байсан. Эрч хүчтэй

гэх гурав дахь үг нь тус уулзалтын үед нэр дэвшигч Баярсайханыг тодорхойлж буй талаар намын дарга дурдав. Элбэгдорж гучаад насны Баярсайханы залуу насны эрч хүчийг онцолж, залуусын энэ эрч хүч бол улс орны үнэт хөрөнгө хэмээн онцолж байлаа.

Эдгээр үгсийн ард ч мөн түүх бий. Бурмаа ард түмний дунд ялангуяа боловсролтой хэсгийнхний хувьд шударга зангаараа танигдсан хүн юм. Шударга гэх түүний нэр хүндийг иргэний нийгмийн байгууллагад ажиллаж байх үеийн түүх, түүний саяхан эхэлсэн улс төрийн замнал, болон түүний хүйс гэх гурван хүчин зүйл илэрхийлнэ. Сонгуулийн хууль болон хэд хэдэн өөр хуулийг УИХ-ын дарга Цэндийн Нямдорж засварласан нь үндсэн хууль зөрчсөн гэж тэмцэж байсан нь түүний нэр хүндийг өргөжээ. Бурмаа болон түүний нөхөд тэмцсэний үр дүнд Нямдорж буруутай нь тогтоогдож албан тушаалаас нь огцруулсан (Undarya 2009). Энэ үйл явцыг хэвлэлээр мэдээлж байсан тул Бурмаагийн нэр хүндийг шударга бустай тэмцэгч хэмээн онцолсон юм.

Бурмаагийн шударга нэр хүндийн хоёрдугаар шалтгаан нь улс төрд шинээр оролцох гэж буй хүн гэдэгт оршино. Удаан хугацаанд улс төрд байхдаа сенсацаас сенсацын хооронд сонгогчдын итгэлийг алдсаар байсан улс төрчидтэй харьцуулахад Бурмаагийн нэр хүнд ерөнхийдөө сэвгүй байсан юм. Тэрээр ямар нэг бизнесгүй, ашиг сонирхлын зөрчилгүй байсан тул авлигад болон улс төрчийн нэр хүндийг унагах ямар нэг зүйлтэй холбогдоогүй байв. Тиймээс Бурмаагийн өрсөлдөгчид түүний эсрэг хар пи-ар хийх зүйлс хайгаад олохгүй. Иймэрхүү “цэвэр” нэр дэвшигч улс төрд тун ховор.

Түүний шударга нэр хүндийн гурав дахь шалтгаан нь түүний хүйсийн онцлог шинжид оршино. Эмэгтэй улс төрчид эрэгтэй улс төрчидтэй харьцуулахад авлигад автаагүй байдаг гэх олон нийтийн яриа (гэхдээ маргаантай) түүний “шударга” нэр дэвшигчийн шинжийг улам тодруулжээ. 1990, 2000-аад онд УИХ-ын сонгуулийн хуульд нэр дэвшигчдийн 30 хувийн хүйсийн квотыг тусгах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлуулах, улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих кампанит ажлын хүрээнд ийм хэвшмэл ойлголт бий болжээ. Ерөнхийдөө улс төрийн агуулгаар, эмэгтэйчүүд нийтээрээ шударга гэгддэг билээ.

Эдгээр хүчин зүйлээс харахад Бурмаа улс төрчийн хувьд боломжит “хамгийн цэвэр” улс төрчид тооцогдоно. Түүнтэй харьцуулахад хамтран нэр дэвшиж буй хоёр эрэгтэй нэр дэвшигч “хар пи-ар”-ын шуурганд өртөж байлаа. 2008 оны сонгуульд нэр дэвших үедээ Элбэгдоржийг авлигад өртсөн, худал хэлсэн, биелэгдэшгүй амлалт өгсөн зэргээр шүүмжилж байв (Bodoo 2008; Erdene 2008; Suren 2008; Tsogtgerel 2008). Энэ зуур, Зууны мэдээ сонинд “Экологич Баярсайхан баригдав” гарчигтай нийтлэл гарчээ (Bat 2008). Тус нийтлэлд Баярсайханы

экологийн шинжлэх ухааны докторын зэрэг нь хуурамч, мөн тэр Иргэний Зориг намаасаа урваж АН-д элссэн зэргийг нь илчилжээ. Бурмаагийн шударга байдал Элбэгдоржид өгөх сонгогчдын саналыг нэмэгдүүлэхэд “эерэг нөлөө” үзүүлсэн гэж нотлох боломжгүй ч, Элбэгдоржийн хувьд хамтран нэр дэвшигчдийнх нь ядаж нэг нь түүн рүү чиглэх хэвлэл мэдээллийн довтолгоог эрчимжүүлэхгүй байх нь маш чухал байсан нь мэдээж. Бурмаагийн нэр хүнд сонгогдсон ч бай, үгүй ч бай нэр дэвших эрх олж авахад тусалсан. Бурмаагийн улс төрд цэвэр байдал, шударга хүн гэх нэр хүнд нь сонгуульд ороход АН-ын хувьд ч, АН-ын даргын хувьд ч маш чухал байсан юм. Энэ талаар дараагийн хэсэгт өгүүлнэ.

Иргэний хамгаалалт

“Ардчиллын гурвын” зурагт хуудсан дээрх Иргэнлэг гэх хоёр дахь үг нь Бурмаагийн өөр нэгэн давуу талыг харуулна. 1990-ээд оны ардчилагдах үйл явцын эхэн үед иргэний нийгмийг үүсгэн байгуулагчдын нэгд тооцогдох тул Бурмаа иргэний нийгэмд ихээхэн хүндэтгэл хүлээдэг. Тэрээр улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмждэг ТББ-ууд, иргэний нийгмийн байгууллагуудыг үүсгэн байгуулсан тул “Иргэний Бурмаа” гэж хүртэл хэлэгддэг байлаа. Сонгогчдын боловсролын төвийг үүсгэн байгуулсан учир Бурмаагийн найзуудын зарим нь “Сонгогчдын Бурмаа” нэрээр нэр дэвшихийг санал болгож байжээ.

2008 оны сонгуулиас урьтаад иргэний нийгмийн байгууллагууд авлигын эсрэг тэмцэж байлаа. Иргэний нийгмийн байгууллагаас төрсөн Иргэний Эвсэл сонгуульд өрсөлдөв⁸. Иргэний Эвслийн сонгуулийн кампанит ажил үндсэндээ үргэлж авлигад холбогдож, буруутгагдаж байдаг гол хоёр нам болох МАХН, АН-ын эсрэг чиглэжээ. Өөрөөр хэлбэл, өмнө нь Бурмаатай хамтарч ажиллаж явсан иргэний нийгмийн төлөөлөл одоо намынх нь эсрэг довтоллоо гэсэн үг. Иргэний Эвслээс нэр дэвшигч, эмэгтэй сэтгүүлч, Уянга ялангуяа АН-ын дарга Элбэгдоржийн эсрэг довтолж байлаа.

Улс төрийн хүрээнд Элбэгдорж иргэний нийгмээс ирэх довтолгооноос, ялангуяа авлигатай холбон буруутгахаас хамгаалах “бамбай” болгон ашиглахын тулд Бурмааг хамтран нэр дэвшигчээрээ сонгосон гэх цуу яриа түгжээ. Авлига гэх мэт тийм халуун сэдэвт “бамбай” болгон ашиглах боломжтой эсэхэд би эргэлзэж байлаа. Гэвч Бурмаа үнэн хэрэгтээ Элбэгдоржийг төдийгүй, АН-ыг бамбай мэт халхавчилсан нь үнэн билээ.

Бурмаа 2008 оны 6-р сарын 19-ний өдөр Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизэд уригдаж “Авлига” гэх сэдэвтэй мэтгэлцээнд

⁸ Бурмаа АН-аас нэр дэвшиж буйд иргэний нийгмийн байгууллагын гишүүд тийм ч таатай байсангүй. Бурмаа өөрөө ч АН-аас нэр дэвших эсэх дээрээ эргэлзэж байсан боловч нэр дэвшихэд нь намын сүлжээ, дэмжлэг маш чухал гэж үзсэн тул АН-аас нэр дэвшихээр шийджээ.

оролцохоор болжээ. Мэтгэлцээн орой 9 цаг хүртэл үргэлжлэхээр байлаа. Сонгуульд оролцож байсан 11 улс төрийн намын төлөөлөл бүгд уригджээ. Анхандаа Элбэгдорж (намын даргын хувиар) оролцохоор төлөвлөж байсан ч, тэрээр мэтгэлцээний өмнөхөн оролцохоос татгалзав.

Тус боломж нь Бурмаагийн хувьд хоёр иртэй чинжаал хутга мэт байлаа. Сонгуулийн үеэр дэлгэцийн цагийг голдуу өндөр тушаалын улс төрчид захиалдаг тул үнэгүй олдож буй тус мэтгэлцээн нь маш ховор, олзуурхууштай үйл явдал байв. Нөгөө талаар авлигын талаарх мэтгэлцээнд орох нь Бурмаагийн кампанит ажилд сөрөг нөлөөлж ч болзошгүй. АН-ын удирдлага авлигад буруутгагдах үед Бурмаа тулалдааны тэргүүн шугам руу шидэгдэнэ. “Жижиг намууд бидэн рүү, том намууд руу довтолох нь гарцаагүй” хэмээн Бурмаа ярих. Иргэний Эвслээс нэр дэвшигч Уянга ч мөн мэтгэлцээнд оролцож байна. Элбэгдоржийн авах саналтай дүйх саналыг Уянга авах магадлал бага боловч, Элбэгдоржийн саналыг хувааж, түүний ялах магадлалыг бууруулна гэлцэх хүмүүс бишгүй олон байлаа. Ингэхийн тулд л Уянга энэ боломжийг ашиглан Элбэгдоржийн эсрэг нүүр тулахаар хүлээж буй. Тэгвэл Элбэгдоржийн оронд Бурмаа мэтгэлцвэл юу болох вэ? “Уянга над руу довтолж чадахгүй (үгүйдээ л авлигатай холбож), гэвч тэрээр намын дарга (Элбэгдорж) руу довтолж эхэлбэл улайм цайм хамгаалах боломжгүй” хэмээн Бурмаа ярих.

Нэлээд эргэлзэж байгаад Бурмаа оролцохоор шийдэв. Халуухан мэтгэлцээний өмнө тэрээр хэрэг болж магадгүй хэмээн АН-ын санхүүгийн тайлан, сонгуулийн зарцуулалтын талаарх тайлан, товхимлууд цуглуулжээ. Тэрээр том, гэрэл сайтай дугуй өрөө хэлбэртэй студид хамгийн түрүүнд хүрэлцэн ирж, голын суудалд суув (дүрс 3.14). Бусад оролцогчид ирэх бүрд хоорондоо гар барин мэндэлнэ. Зарим нь Бурмааг хүндэлдгээ илэрхийлэх бөгөөд, зарим нь түүнээс сүрдэнэ. Бусад нь зүгээр л гайхаж байлаа: “АН Бурмаа эгчийг явуулдаг нь ямар ухаалаг шийдвэр вэ” хэмээн тэд хагас хошигнох байдлаар (учир нь АН-ыг хамгаалуулахаар Бурмааг явуулсныг тэд мэдэж буй) хэлэв. Уянга өрөөнд орж ирмэгцээ том харан гайхаж, улмаар Бурмаад хүрч очин хүндэтгэлтэйгээр гар барихын зэрэгцээ: “Сайн байна уу? Бурмаа эгч, Ардчилсан нам таныг л явуулж таарна л даа” гэж хэлэхдээ сэтгэл дундуур байгаа байдлаа ч нуусангүй.



Дүрс 3.14. Авлигын талаарх мэтгэлцээн. МҮОНРТ-ийн студи. 2008 оны 6-р сарын 19. Студийн зүүн төвд цагаан хүрэмтэй сууж байгаа нь Бурма. Уянга түүнтэй нэг ширээнд сууж байна. Зохиогчийн дарсан зураг.

Гол хоёр нам л тэдний гол бай гэдгийг Бурмаа гадарлаж байлаа. Танай нам авлигатай хэрхэн тэмцэх вэ? гэх хамгийн эхний асуултад оролцогч бүр хоёр минутад багтан хариулах ёстой. Бурмаа нэлээн эхэнд, авлигын тухай хууль бүрэн төгөлдөр бус байгаа бөгөөд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж, ашиг сонирхлын зөрчлийг ч мөн зохицуулах шаардлагатай талаар хариулав. Бурмаагийн араас хариулсан гурван оролцогч хууль хэт хийсвэр, ард түмэн ч хуулийг дагахгүй байна. Шинээр хууль хийхийн оронд төрийн албан хаагчдын цалинг нэмэх, засгийн газрыг хянах иргэний хяналтыг сайжруулах гэх мэт хуулийг хэрэгжүүлэхэд иргэдийг урамшуулсан тогтолцоо бидэнд хэрэгтэй гэх зэргээр Бурмаагийн дэвшүүлсэн аргументыг сөргүүлж байлаа.

Урьдчилан таамаглаж байсанчлан, Уянга АН, МАХН гол хоёр намын эсрэг довтолж эхлэв. “Хоёр том нам авлигатай тэмцэж чадахгүй. Хоёр том намыг улс төрөөс салгаж, засгийн газарт иргэдийн хяналтыг бий болгохгүйгээр авлигатай тэмцэх боломжгүй” гэж Уянга хэлэв. Тэрээр авлигын жишээ татахдаа, гол намуудын нэгийг нь дарга хамт нэр дэвшиж буй залуу бизнес эрхлэгчтэйгээ хэрхэн харилцан ашигтай тохиролцоо хийсэн талаар дурдав. (АН-ын даргыг шууд хэлж байна гэж ойлгож болно.) Дараагийн асуулт: Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэхэд ямар шинэлэг өөрчлөлт та бүхэн хийж чадах вэ? Уянга гол хоёр намыг үргэлжлүүлэн шүүмжилнэ. Тэрээр, “авлигын эсрэг хууль дунд түвшний албан хаагчдад л үйлчилж байна. Үүний оронд улс төрийн намын удирдлагууд, төрийн өндөр албан тушаалтнууд гэх мэт “аварга загаснуудыг” шалгах ёстой гэв.

Мэтгэлцээн тэр чигтээ биесээ харилцан буруутгасан талбар болж хувирсангүй. Уянгыг эс тооцвол бараг л хэн ч АН руу шууд довтолсонгүй. Бурмаа мэтгэлцээн болгонд түрэмгийлэн оролцолгүй харин оролцогчдыг авлигын шалтгаан (төрийн албан хаагчдын цалин маш бага гэх мэт) болон бодит шийдлүүдийг (төрийн албан хаагчдын цалинг нэмэх, хандлагыг өөрчлөх, иргэдийн сонор сэрэмжийг нэмэгдүүлэх гэх мэт) тойрон

ярилцахыг сонсон суув. Нэвтрүүлгийн хөтлөгч “Танай намд авлигатай тэмцэх чин хүсэл эрмэлзэл байна уу? гэх энгийн асуултыг тавихад жижиг улс төрийн намын нэг төлөөлөл АН-ыг авлигад буруутгаж гарлаа. Хариуд нь Бурмаа “АН-ын Санхүүгийн тайлан” гэсэн гарчигтай бэлдэж авчирсан хэд хэдэн материалаа гарган үзүүлэв. Тэрээр: “Бид санхүүгээ ил тайлагнахаас ажлаа эхлэх ёстой. Бүх улс төрийн намууд санхүүгийн тайлангаа хяналтын байгууллагад мэдүүлэх үүрэгтэй. Танай намын тайлан хаана байна? Танай нам санхүүгийн тайлангаа хүргүүлж байсан тохиолдлыг би л лав санахгүй байна. Манай тайлангууд энд байна” гэж хэллээ. Тэдгээр тайланг харсан бусад оролцогчид суудлынхаа араар нуугдах нь холгүй болжээ. Бурмаа намаа шууд өмгөөлсөнгүй. Гэсэн хэдий ч тэрээр өмнө нь авлигын эсрэг ажиллаж байхдаа Сонгогчдын Боловсрол Төвөөс зохион байгуулсан АН-ын санхүүд хийсэн хяналтын ажлаараа намаа аварсан юм. Бурмаа АН-ыг төлөөлж, өөрийн биеэрээ АН-ын даргыг орон мэтгэлцээнд оролцсон нь л хамгийн чухал байв. Бурмаа тэнд байснаараа бусад намын төлөөллүүд үндэсний олон нийтийн телевизийн эфирээр АН руу, АН-ын дарга руу дайрах бололцоог хааж байсан юм. АН аврагдаж, эмэгтэй нэр дэвшигчийн шударга, иргэнлэг чанар нь, үгүйдээ л АН-ын хүрээнд хүлээн зөвшөөрснөөр жендэр, улс төр хоёр хоорондоо харилцан нөлөөлдөг гэдэг нь олон нийтийн өмнө батлагдав.

Гадаргууг өргөжүүлэх нь

“Ардчиллын гурвыг сонгоцгооё” гэсэн зурагт хуудастай би хаа сайгүй тааралдаж байсан боловч, Улаанбаатар хотын гол гудамжаар Бурмаагийн хувийн зурагт хуудсыг олж харсангүй. АН-ын гурван нэр дэвшигчээс хамгийн олон зурагт хуудас байрлуулсан нь Баярсайхан байлаа. Цээж зурагтай түүний постерууд бүгд адил байх бөгөөд гагцхүү байрлуулсан газар, хэмжээгээрээ л ялгарна. Зарим нь өндөр шонд өлгөөтэй байсан бол, зарим нь замын хажуугийн зүлэг модтой хэсгийн дунд шинэхэн суурилуулсан зарын самбарт байрлана. Өөр хоорондоо 20 алхмын зайтай байрлах сурталчилгааны самбарууд дундаж хүний өндөртэй бөгөөд машинаар зорчих хүмүүс ч, явган алхах хүмүүст ч харагдах боломжтой. Гудамжны нэг өнцгөөс харвал тэдгээр самбарууд нэгэн жигд эгнэнэ. Гудамж дагуу алхвал хэд алхаад л самбартай тааралдана. Баярсайхан хамгийн ашигтай байрлалд самбаруудаа хэт олноор нь үйлдвэрлэсэн нь өөрийн гэсэн бяцхан ертөнцийг бүрдүүлсэн мэт. Өндөр барилгад өлгөгдсөн аварга зурагт хуудаснуудтай харьцуулахад жижиг орон зайд ихээр шавсан тэдгээр самбарууд өөр нэр дэвшигчийн сурталчилгаа байрлах боломжийг олгосонгүй. Барилгын хана, гудамжны гэрлийн шонд гээд хаа сайгүй өөрийн хөрөг зургийг байрлуулсан Баярсайхан тэр сонгуулийн хамгийн олон самбартай нэр дэвшигчдийн нэг байсан биз ээ. Кампанит ажлын сурталчилгаа энгийн үеийн арилжааны сурталчилгаанаас

хэд дахин давжээ. Олон тооны самбар байрлуулах нь танигдах байдлаа боломжит хамгийн өндөр түвшинд байлгах гэсэн сонгуулийн кампанит ажлын технологи юм.

Бурмаагийн оффис руу орвол, түүний сонгуулийн багийнхан жижиг дугуй ширээ тойрч суугаад шийдвэрлэгдээгүй асуудлуудын талаар ярилцаж байхтай таарав. Бурмаагийн сонгуулийн ажилд сайн дураараа тусалж буй түүний бага ангиас нөхөрлөсөн найз нь өмнөх шөнө сонгогчдод тараагдах ёстой Бурмаагийн тараах материал (захидлын хэмжээтэй) багцаараа хогийн саванд байхыг олжээ. Энэ нь нөгөө хоёр нэр дэвшигчгүй, Бурмаагийн өөрийнх нь материал байв. Найз нь дахин ашиглаж болох материалуудыг нь оффис дээрээ авчирсан аж. Доромжлогдсон мэдрэмж авахын зэрэгцээ санаа зовсон Бурмаагийн найз тэдгээр тараах материалыг хэн яагаад бөөнд нь хаясныг ойлгож ядна. Тэрээр Бурмаагийн нэр дэвшиж буйтай холбоотой боловч хувь хүнийх нь хувьд доромжилж буй ёс суртахуунгүй явдал гэж бодож буйгаа хэлэв. Бүгд санаа зовж байхад, Бурмаа л сонгуулийн кампанит ажлын хүрээнд хийгдэх ёстой бусад ажлууд руу ярианы сэдвийг чиглүүлэв.

Нэмэлтээр зурагт хуудас хийх нь хамгийн тулгамдсан асуудлуудын нэг байсан юм. Бурмаагийн штабт ажиллаж буй хүмүүс бүгдээрээ шахуу Чингэлтэй дүүрэгт нэр дэвшиж буй бүх нэр дэвшигчдийн дунд Бурмаагийн зурагт хуудас хамгийн цөөхөн байгаад санаа зовно. Өлгөөстэй нэгэн том зурагт хуудсанд Бурмаа намирч буй Монгол Улсын төрийн далбааны урд зогсож буйгаар дүрслэгджээ. Хэв маягийн хувьд хотыг бүхэлд нь хамарсан бусад нэр дэвшигчдийн нэгэн хэвийн зурагт хуудастай тун төстэй. Хоёр дахь зурагт хуудсанд Бурмаа цэцэглэж буй монос модын урд зогсож байна. Бурмаа гурав дахь зурагт хуудас нь түүнийг Сонгогчдын Боловсрол Төвийг (ТББ) үүсгэн байгуулсан, удирдсан гэдгийг онцолж, сонгогчдын өмнө үүрэг амлалт хүлээсэн хүн гэдгийг илэрхийлэх ёстой гэж үзэв. Түүний сонгуулийн уриа нь “Сонгогч Та Төрийн Эзэн” гэж байсан юм. Тэрээр сонгогчидтой хийж буй уулзалтын үеийн нэг зургийг сонголоо. Тус зурагт тэрээр өөрийнх нь хөрөг, далбаа, зурагт хуудсыг барьсан сонгуулийн ажилчид, хүүхдүүд, тойргийн сонгогчдын голд зогсоно. Энэ зураг нь түүний бүх өрсөлдөгчдийн сурталчилгааны зурагт хуудаснаас түүнийг нэр дэвшигчийн хувьд тодоос тод ялгаруулсан юм.



Дүрс 3.15. Ижил хувцсаар жигдэрсэн сонгуулийн ажилчид. 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Дараагийн хэдэн өдөр нэр дэвшигчдийн сурталчилгааны зурагт самбарын тоо үлэмж нэмэгдсээр байлаа. Нэр дэвшигчид хүмүүст өөрийнхөө хөргийг хэвлэсэн хувцас өмсүүлэх замаар кампанит ажлын гадаргууг нэмж эхэллээ. Сонгуулийн өрсөлдөөний ид үеэр кампанит ажилд оролцогчид, сайн дурынхнаас гадна хувь хүмүүст төлбөр төлж өөрийнхөө хөрөг бүхий футболк өмсгөж, хүнийг сурталчилгааны самбар болгон ашиглана. Эдгээр хүн-самбарууд далбаа барьж, олон нийтийн уулзалт, алхалтад оролцож, уулзалтын ирц бүрдүүлж, хэвлэмэл материал тараана. Иргэдийг хувь хүн гэхээс илүүтэй хөдөлгөөнт зурагт хуудас мэт авч үзэх болов. АН-ын цэнхэр өнгийн футболк, саравчтай малгай, МАХН-ын улаан өнгийн хувцаснууд гудамжаар нэг үзэгдэнэ. Цэнхэр, улаан өнгөний тухайд тус тусын кампанит ажлын брэнд өнгө бөгөөд үүнээс гадна маш олон залуус үзмэн ягаан, улбар шар, ногоон, алтан шар өнгийн зарим нь нэр дэвшигчийн зураг эсвэл нэрийг нь хэвлэсэн футболк, саравчтай малгай өмссөн байхтай таарна (дүрс 3.15).

Бурмаагийн штабын ажилчид түүний сурталчилгаа нь хэт даруухан, сурталчилгааны самбар нь хэт цөөн буйд санаа зовсон хэвээр, түүнийг сурталчилгаа байрлуулах томоохон зай олооч хэмээн ятгав. Бурмаа анхандаа 10x7 (3 давхар байшингийн дайтай) хэмжээтэй аварга том зурагт хуудсыг хаана, хэрхэн байрлуулах зэргээс өгсүүлээд логистикийн олон асуудал үүсгэх тул татгалзаж байлаа. Дараа нь тэрээр найзуудынхаа нэгтэй энэ талаар ярилцав. Жижиг барилгын кампани эзэмшдэг Бурмаагийн нэг найзынх нь 10 давхар барилгын ажил Бурмаагийн нэр дэвшиж буй Чингэлтэй дүүрэгт ид өрнөж буй ажээ. Тэрээр Бурмааг

барилгыг ашиглан хүссэнээрээ зурагт хуудсаа байрлуулахыг санал болгов. Гурван давхар барилгын хэмжээтэй аварга зурагт хуудас хэвлэх боломжгүй тул хэвлэлийн компани хэсэг хэсгээр нь хэвлэж, тээвэрлэж, нааж тогтоожээ. Бурмаагийн хажууд тус барилгыг харж зогсохдоо бид аварга зурагт хуудсыг хөдөлгөөнгүй байлгах ямар нэг хатуу хүрээ хийхгүй бол төд удалгүй салхинд хийснэ гэдгийг таамаглаж байсан. Хатуу жааз, хүрээ хийх мөнгө Бурмаад үлдсэнгүй. Бидний бодож байснаас ч илүү удаан хугацаанд тус зурагт хуудас тэссэн ч гэлээ нэг булан нь байнга л салхинд үлээгдэн нугаларсаар байсан юм (дүрс 3.16).



Дүрс 3.16. Бурмаагийн хамгийн том зурагт хуудас. 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Дүгнэлт: Зургийн гуравласан хэлхээ

Өрсөлдөөнт, ардчилсан сонгууль Монголд нэвтэрснээс хойш хэвлэмэл материал, зурагт хуудас сонгуулийн кампанит ажлын гол хэрэгсэл байсаар ирсэн боловч 2008 оны сонгуулиар нэр дэвшигчийн зурагт хуудас урьд хожид байгаагүй өндөр ач холбогдолтой болов. Тухайн жилд сонгуулийн тойргийг томсгосноос болоод нэр дэвшигчид сонгогчидтойгоо нүүр тулан уулзах боломж хязгаарлагдлаа. Сонгогчидтой хийх уулзалтыг тараах материалаар орлуулж, зурагт хуудсаа хаа сайгүй байрлуулжээ. Нэр дэвшигчид биечлэн уулзаж харизмаа харуулахыг бус зурагт хуудас байрлуулах байдлаар сонгогчидтойгоо холбогдохыг хичээж байлаа. Сонгуулийн сурталчилгаанд тараах материалын хуудасны тоог хязгаарласнаас, мөн иргэдийн шүүмжлэлд өртөхөөс эмээж “эрсдэлгүй” зураг үйлдвэрлэсэн нь хуучны социалист удирдагчдын энгийн хөрөг зургийг эрхгүй санагдуулна.⁹

Ихэнх зургийг олон давтан байршуулсан нь олон нийтэд бүрэн танигдсанаар зурган дээрх хувь хүний шинж чанарын ач холбогдол нь буурдаг гэсэн Майкл Уорнерын (1992) үзэл санааг бататгана. Олонд гүйцэд танигдсанаар тухайн зургийн чанар болон тухайн зурган дээр дүрслэгдсэн хүний шинж чанар болон хэн болохоос хамаарахгүйгээр, зөвхөн давтамжаасаа л нэмэлт үнэ цэн бий болдог. Учир нь сонгогч дангаараа нэр дэвшигчийн ач холбогдлыг тогтоох боломжгүй (Warner 1992). Сонгогч зургийг харах үед сонгогч, зураг, болон тэр зургийг бусад хүмүүс бас таньж байгаа гэсэн бусдыг мэдрэх мэдрэмж гэх гуравласан хэлхээ үүсдэг. Энэхүү гуравласан хэлхээ нь мэдрэмжид нэвчин орж, тэрхүү зургийг улам түгээн хөөсрөлт үүсгэхийн зэрэгцээ сонгуульжилтыг хэлбэржүүлнэ. Кажри Жайн (2007, 298) “Олон нийтийн соёлд зураг ус, агаар, биеийн шингэн адил халдвар тараагч болдог” гэснээс үзвэл зургаа олон нийтэд таниулах, олон нийтийн төсөөлөлд зургаа хоногшуулах нь ямар чухал болохыг харж болно. Тийм учраас зураг сонгуульжилтын гадаргууд чухал орон зайг эзлэх болжээ.

2008 онд Монголын сонгууль бараг л уулзалтад суурилсан сонгуулийн үйл явцаас зурагт хуудаснаас хамааралтай сонгууль руу шилжив. Тойргийн хэмжээг томсгосноос болж кампанит ажлын хамгийн чухал ардчилсан элемент болох сонгуулийн сурталчилгааны үеэр сонгогчидтой уулзалт зохион байгуулж мөрийн хөтөлбөрөө танилцуулах нь нэр дэвшигчдийн хувьд кампанит ажлын анхдагч арга хэрэгсэл байхаа больжээ. Нэр дэвшигч, сонгогчидтой холбогдохын

⁹ 2008 онд нэр дэвшигчид, улс төрийн намуудын сурталчилгааны тараах материал 4 хэвлэлийн хуудсаар хязгаарлагдав. Нэг хэвлэлийн хуудас нь найман захианы хэмжээтэй тэнцэх бөгөөд нэр дэвшигч, улс төрийн нам нийтдээ 32 нүүр материал (зурагт хуудсаа оруулаад) хэвлүүлж болохоор зохицуулжээ. 2012 онд энэ зохицуулалт өөрчлөгдөж, улс төрийн нам, нэр дэвшигчдийг ялгасан бөгөөд улс төрийн нам 40 хэвлэлийн хуудас буюу 320 захидлын хэмжээтэй тараах материал, нэр дэвшигч 2008 оны сонгуультай ижил 32 нүүр материал тарааж болохоор зохицуулав.

тулд уулзалт зохион байгуулах явдал багахан хүрээнд байсаар байв. Сонгогчдын асуулт, гомдол, шүүмжлэлийг хүчээр сонсох, рационал, шүүмжлэл харилцан яриа өрнөх боломж олгодог эдгээр уулзалтын үүрэг үлэмж багасжээ. Үүний оронд зурагт хуудасны кампанит ажил голлох болж, хоёр талын (нэр дэвшигч, сонгогч) хооронд харилцан яриа үүсгэхээс сэргийлж байв. Зурагт хуудасны кампанит ажилд сонгогчдод сайнаар ярихад үзэгч, хэрэглэгч мэт хандаж байсан бол, муугаар хэлэхэд “хүчээр ч хамаагүй зургаа тэдэнд заавал харуулах” ёстой гэж ханддаг (Jain 2007, 298) байна. Нэр дэвшигчид сонгогчдыг маш бага эсвэл бүр огт нөлөөгүй мэт авч үзнэ. Гэхдээ нэр дэвшигчид өөрсдийнх нь талаар элдэв шүүмжлэл сонгогчдын тарах вий гэдгээс эрх биш санаа зовнино. Ихэнх нэр дэвшигчид зургаа олон нийтийн хүртээл болгоход л анхаарч байв. Энэ нь нэр дэвшигчдэд өөртөө итгэх итгэлийг төрүүлэх боловч, сонгогчдод тэр бүр сонгох итгэлийг нь нэмэгдүүлэхгүй. Өмнө нь соёлын төв, сургуулийн байранд болдог байсан сонгогчидтой хийх уулзалтууд нь илүү дотно, бодит байдлаар өөрсдийнх нь талаарх сонгогчдын төсөөллийг мэдэх боломжийг нэр дэвшигчдэд олгодог байлаа. Эсрэгээрээ урьдчилан найруулсан, нүсэр том тайз зассан мянга мянган сонгогчидтой нэг дор хийх өргөн хэмжээний уулзалтууд нь нэр дэвшигчдэд өөрөөрөө бахархах, өөртөө хэт итгэх байдлыг нэмэгдүүлж, ялалтын хуурамч мэдрэмжийг төрүүлнэ. Эдгээр өргөн хэмжээний уулзалтын үеэр нэр дэвшигчид сонгогчид хоорондоо ярилцах, сонгогчид асуулт асуух, нэр дэвшигчдийн талаар санал, сэтгэгдлээ хуваалцах боломжгүй байдаг тул нэр дэвшигчид, сонгогчдын хоорондын харилцаа алдагддаг. Иймэрхүү өргөн хэмжээний уулзалтын үеэр нэр дэвшигчийн дүрсийг аварга том дэлгэцээр харуулах шаардлагатай бөгөөд үүнээс зураг ямар чухал объект болохыг харж болно. Зургийн кампанит ажлын адил иймэрхүү өргөн хэмжээний уулзалтууд зөвхөн нэг чиглэлтэй. Сонсох, алмайрах, агуулгыг нь хүлээн авах зэрэг нь зөвхөн нэр дэвшигчээс сонгогч руу л чиглэнэ.

Зурагт хуудасны кампанит ажил нь өвөрмөц, ойлгомжтой боловч гэнэтийн улс төрийн өөрчлөлт байлаа. Зурагт хуудасны кампанит ажил маш их хөрөнгө шаарддаг учраас, мөн сонгуулийн кампанит ажлын зардлын дийлэнхийг нэр дэвшигч өөрөө хариуцдаг учраас УИХ-д улиран сонгогдохоор нэр дэвшиж буй хүмүүст албан бусаар давуу байдал олгох “тусгай хамгаалалт” (Ahmed 2013) мэт бөгөөд УИХ-д анх удаа сонгогдохоор нэр дэвшиж буй хүмүүст саад учруулж байлаа. АНУ-д болон бусад олон улс оронд байдаг сонгуулийн кампанит ажлыг олон нийтээс хөрөнгө босгох замаар санхүүжүүлдэг туршлага Монголд байхгүй, байлаа гэхэд далд хэлбэртэй. Мөн капитализмын урт хугацааны түүхтэй АНУ-д нэр дэвшигч нь өөрөө санхүүгээ хариуцдаг байлаа гэхэд гайхах зүйл үгүй. Харин Монголын нөхцөл байдал өөр. Хувь хүн,

албан байгууллага их хэмжээний мөнгийг хянах, зарцуулах бололцоо социализмын дараа үеэс буюу ердөө саяхнаас л боломжит зүйл болсон. УИХ-д сонгогдсон гишүүдэд байнга, үнэгүй мэдээллийн хэрэгслээр гарах, олон нийтийн арга хэмжээнд оролцох, үг хэлэх гэх мэт танигдах боломжоос гадна улсын төсөв батлах эрх мэдлээ ашиглан тойрогтоо дэд бүтцийн, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн төсөв суулгаж, түүнийгээ тойргийнхоо сонгогчид өөрсдийнх нь хүчин чармайлтын үр дүн гэж ярих нь түгээмэл. Харин улс төрд шинэ хүмүүст ийм боломж байхгүй. Ийм хүч тэнцвэргүй тулаанд байрлалаа маш зөв эзэлсэн, эсвэл чинээлэг нэр дэвшигчид л ялалт байгуулах боломжтой. Баялаг дахь жендэрийн тэнцвэргүй байдал нь эмэгтэй нэр дэвшигчдийн нөхцөл байдлыг хоёр дахин хэцүү болгоно. Эмэгтэйчүүд мөнгөний эсрэг, эрчүүд зонхилсон улс төрийн соёлын эсрэг өрсөлдөх хэрэгтэй болдог. 2008 онд сонгуулийн зардал үлэмж өссөн бөгөөд энэ нь зарим талаар сонгуулийн тойргийг өргөтгөсөнтэй холбоотой байх. Өмнөх сонгуулиудад жижиг тойрогт кампанит ажил явуулахтай харьцуулахад том тойрогт илүү их нөөц шаардлагатай болсон нь мэдээж.¹⁰ Энэ нь нэр дэвшигчийн дүр төрх нь түүний чанараас ч илүү чухалд тавигдах байдал руу хөтөлсөн. Хэвлэл мэдээлэл, эрх мэдэл, сонгууль гурвын уялдаа холбоо урьдынхаас ч илүү нягт болов. Сонгуулийн ардчилсан шинж чанар буурч, эрх мэдэлд буй элитүүд, зурагт хуудасны кампанит ажлын хамт, эрх мэдлээ илүү баталгаажуулж чадсан юм.

Улс төрийн зурагт хуудсан дээр эмэгтэйчүүдийн дүр төрх маш ховор бөгөөд телевизийн, сонин сэтгүүлийн болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл дээрх арилжааны зурагт хуудаснууд дээрх эмэгтэйчүүдийн дүр төрхөөс ялгаатай. Эмэгтэйчүүдийн дүр төрхийг гадаад үзэмж, эд баялаг, хэрэглэж буй бүтээгдэхүүнийг нь л онцлон харуулах нь капиталист нийгэм, зах зээлийн эдийн засагтай холбоотой байдаг биз. Улс төрийн зурагт хуудаснууд энэ төрлийн жендэрийн дэглэмтэй нийцдэггүй. Өнгөрсөн 30 жилд улс төрийн дэглэм социалист, тоталитар дэглэмээс, зах зээлийн эдийн засагт шилжихтэй зэрэгцэн зурагт хуудасны дэглэм ч мөн адил ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд сууриараа өөрчлөгджээ. Социализмын үед үндэсний хэмжээнд өндөр албан тушаал хаших эмэгтэй удирдагч бараг байгаагүй тул улс төрийн удирдагч нарын зурагт хуудсанд ч мөн эмэгтэй хүн байсангүй (төв хорооны гишүүд бүгд эрчүүд байлаа). Зарим тохиолдолд олны танил эмэгтэй ард түмний ёс суртахууны үлгэр дуурайлал мэт дүрээр зурагт хуудсанд хааяа үзэгдэнэ. Эдгээр зурагт хуудас дээрх эмэгтэйчүүд нь урам зоригтой ажилчид, эсвэл бусдыг өөрөөсөө илүүд үздэг эхчүүд байсан юм.

Харин ардчиллын үед эмэгтэй нэр дэвшигчдийн улс төрийн зурагт хуудаснууд нь өвөрмөц боловч, одоогийн үйлчилж буй эрх мэдлийн

¹⁰ Эдийн засгийн байдал хэдий дордсон ч гэсэн сонгуулийн зардал өмнөх сонгуулийнхаас хэзээ ч буурч байсангүй.

дэглэм, дүр төрхийн дэглэмд огт нийцэхгүй байна. Зурагт хуудсанд жам ёсоор карьераа босгож буй эмэгтэйн оронд өнөө цагийн дүр төрхийн дэглэмд загвар өмсөгч, гоо бүсгүйчүүд, үзэсгэлэнт эхнэр гэх мэт залуу, дур булаам бүсгүйчүүдийн дүр төрх давамгайлж хэвшин тогтжээ. Энэ нь эмэгтэйчүүдийг нийгэд нь төлөөлөхгүй ч гэсэн, зургийн ертөнцөд болон нийтийн орон зай дахь сурталчилгааны самбарт ийм л эмэгтэйчүүдийн дүр төрх зонхилно. Энэ нь улс төрд орон зайгаа эзлэхийн төлөө зүдэрч яваа эмэгтэйчүүдийн дүр төрхөд сөрөг нөлөөтэй. Жоан Скоттын (2018) хэлснээр ардчилал дахь эрх мэдлийн хоосон орон зай нь улс орныг хэн хэрхэн удирдах талаар зовнилыг нэмэгдүүлдэг. Ийм айдас түгшүүртэй үед хүмүүс эмэгтэйлэг шинж, эрэгтэй чанарыг аль болох эрсдэлгүй жам ёсны, биологийн ойлголтыг эрхэмлэдэг бөгөөд, үүнээс үүдээд жендэрийн [соёлд тулгуурласан] ойлголтоос хүйсийг [биологид тулгуурласан] илүүд үзэх болов. Энэ талаар миний хийсэн угсаатны зүйн судалгаа цочирдом үр дүнг харуулдаг. Ардчилсан сонгуулийн хүрээнд Эрэгтэй хүний дүр төрх биологийн хувьд хүчтэй гарч ирсэн бөгөөд соёлын хувьд төвийг сахисан бол, эмэгтэй хүний дүр төрх соёлын онцлогоор чимэглэгдэх бөгөөд биологийн шинж чанараар хоёрдогч болж байв. [Жишээ нь, эрэгтэй нэр дэвшигч өндөр бас эрч хүчтэйгээр танигдах гэж эрмэлзэж байсан бол эмэгтэй нэр дэвшигчид боловсрол болон мэргэжлийн онцлогоо тодотгож байлаа]. Тиймээс, хэдийгээр “шударга ёс” гэдэг ойлголтод хүйс хамаарахгүй боловч, 2008, 2012 оны сонгуульд “шударга” гэдэг нь эмэгтэйчүүдэд илүү хамаарах эмэгтэй жендэрийг тодорхойлсон ойлголт болж хувирав. Энэ нь эмэгтэй нэр дэвшигчдийн сонгогдохуйц байдалд хэрхэн нөлөөлснийг тооцоолох аргагүй. Ямартай ч, олонд танигдсан нэр цуутай улс төрчид дахин сонгогдохын тулд өнгөрсөнд зарим талаар сэвтсэн нэр хүндээ “шударга” гэх дүр төрхөөр халхлахыг хичээж байсан билээ.

Тайзны ар тал: Кампанит ажлын өмнөх стратеги

Энэхүү бүлэгт гарч буй информантууд нэрээ болон бусад мэдээллээ нууцлахыг хүссэн учраас информантын хувийн мэдээллийг хадгалахын үүднээс тэдний нэр болон дурдаж буй газар ус, улс төрийн нам, хороо дүүрэгт зохиомол эсвэл өөр нэр өгөв.

Шинэ нэр дэвшигч: Жендэрийн нормоос гадуур

Сэржээгийн нэр дэвшиж буй сонгуулийн тойргийн нэг хэсэг Бумбат гэгдэх жижигхэн сууринд сонгуулийн сурталчилгааны зурагт хуудас хаа сайгүй байсан ч гэлээ түүний л зурагт хуудас огт харагдаагүй нь хачирхалтай.¹ Сонгуулийн сурталчилгаа байхгүй байх нь бас л нэг төрлийн судалгааны “материал” тул, энэ тохиолдол сонирхлыг маань ихээр татна. Бумбат руу очсон цагаасаа эхлээд бүтэн өдрийн турш “Сэржээ зурагт хуудсаа өлгөх орон зай олж чадаагүй юм байх даа? Гудамжинд нэг ч зурагт хуудас байрлуулж чадаагүйгээс үзэхэд кампанит ажлын ард юу өрнөсөн юм бол?” гэх асуултууд миний дотор эргэлдсээр байлаа. Гэр бүлээ аваад хэдэн долоо хоног ажиллахаар явж буй Сэржээгийн зөвлөхтэй хамт би Улаанбаатараас Бумбат руу явж очив. Сэржээ анх удаагаа нэр дэвшиж байгаа.

¹ Ярилцагчийнхаа хүсэлтийн дагуу нэрийг нь нууцалж, Сэржээ гэх зохиомол нэр ашиглалаа. Түүний хувийн нууцыг хамгаалах үүднээс, газрын нэр (хот, дүүрэг, сонгуулийн тойрог гэх мэт), улс төрийн нам, холбоотой хувь хүмүүсийн нэр гэх мэт мэдээллийг ч өөрчилсөн. Мөн, улс төрийн намыг нь нэрлэхээс зайлсхийж, Сэржээгийн нам, түүний нам гэх мэтээр төлөөлүүлэв.

Бид хүрч очсон даруйдаа тэнд байх гол зочид буудалд буудаллав. Сэржээгийн зөвлөхийн өрөөнд түүний сонгуулийн өрсөлдөгчдийн талаар шөнөжин ярьж хоноод, маргааш өглөө нь Сэржээ биднийг өөрийнхөө өрөөнд хүлээн авч уулзлаа. Уулзалтын том өрөө, унтлагын өрөө, бас түүний туслахад зориулсан илүү өрөө байх аж. Том толины өмнө, зочид буудлын үүдний бичгийн ширээ адил аварга том будаг шунхтай тавцангийн өмнө суугаа Сэржээ дөнгөж нүүрээ будаж дуусаж байна. Сэржээгийн өмссөн дэгжин даашинз, түүнтэй нь зохицох хүрэм зэргийг зөвлөх нь магтлаа.

Орон нутгийн эмэгтэйчүүдтэй уулзах Сэржээгийн анхны уулзалтад бид цагаасаа өмнө хүрч очлоо. Томоохон хурлын өрөөнд цугласан 10-аад эмэгтэйд хандан “Миний хайрт хүүхнүүд минь ээ” хэмээн Сэржээ мэндэллээ. Тэнд орон нутаг дахь улс төрийн намын хорооны дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын дарга тэргүүтэй хүмүүс цугласан бөгөөд зарим нь уулзалтад бэлдэхийн тулд мөн адил эрт иржээ. “Хэдүүлээ сандлуудаа тойрог хэлбэртэй засаж, сууцгаа” хэмээн Сэржээ эрч хүчтэй, итгэлтэйгээр хэлээд тавилгын байршил өөрчилж эхэллээ. “Миний хүүхнүүд ээ” гэж Сэржээгийн хэлэх нь дотно бөгөөд чанга сонсогдоно. Бусдыгаа таньж ч амжаагүй зарим хүний хувьд хэт дотносог санагдсан байж мэднэ. Гэвч, зарим эмэгтэйн гайхсан байдлыг үл тоомсорлон тавилга зөөхийн зэрэгцээ, Сэржээ тэдэнд зааварчилж эхлэв. Сэржээгийн хүмүүстэй харилцах арга барил нь ямар нэг байдлаар нийтлэг хэм хэмжээнээс өөр санагдав. Ялангуяа нэр дэвшигчид албан ёсны, ёсорхуу, бусдаас жаахан хөндий, соёлтой байхыг эрхэмлэх бөгөөд өөрийгөө орон нутгийнхны нэг адил байхаас зайлсхийнэ. Сэржээ хурдхан шиг тойрогтоо орж суулаа.

Нэмж цугласан 50 гаруй эмэгтэйтэй хийж буй энэ уулзалтад Сэржээ нэр дэвшигчийн хувиар тойрогтоо хэрхэн ажлын байр бий болгох, ядуу, эмзэг бүлгийнхнийг хэрхэн анхаарах, мөн үндэсний хэмжээнд авлигатай хэрхэн тэмцэх талаар танилцуулна. Түүнийг ярьж дуусмагц зөвлөх нь босоод анх удаа сонгуульд өрсөлдөж буй “шинэ нэр дэвшигчийг” эмэгтэйчүүд яагаад дэмжих ёстой талаар товч ярилаа. Тэрээр “намхан, туранхай энэ бүсгүйд улс төрд маш том боломж бий” хэмээн онцолно. Тэрээр, “Энэ бүсгүйд боломж олго, дараа нь энэ бүсгүй юу хийж чадах, ямар үр дүнг авчрахыг хараарай. Та бүхэн бүгдээрээ хижээл насны, эрэгтэй, бусад нэр дэвшигчдээс юу ч хүлээгээд хэрэггүй болохыг мэдэж байгаа шүү дээ” гэж нэмлээ. Цугласан эмэгтэйчүүдэд тэдний сонголт амин чухал учир нь “Монголын нийт сонгогчдын дийлэнх нь 20-30 насны эмэгтэйчүүд байдаг талаар ч дурдав. Сүүлд нь тэрээр, “Эмэгтэйчүүд та бүхэн эмэгтэй хүнээ дэмждэг гэдэгт би л лав итгэдэг” хэмээн дүгнэв.

Эргээд харахад, жендэрийн талаар зөвлөхийн ярьсан зүйлс, Сэржээ сонгуулийн кампанит ажлаа намынхаа эмэгтэйчүүдийн байгууллагад

түшиглэн, тэднийг дайчлах сонирхолтой байсныг илэрхийлэх мэт. Тийм ч учраас Сэржээ, уулзалтын өрөөнд ормогцоо, орон нутгийн эмэгтэйчүүдэд илэн далангүй хандаж, тайван, тухтай байсан байх. Гэвч Бумбат дахь кампанит ажил нь нэг нь сонин ер бусын байлаа. Яагаад иймэрхүү танилцах маягийн уулзалтыг ийм орой, бүр сонгуулийн яг өмнөхөн зохион байгуулав? Яагаад сурталчилгааны самбар, өөр сурталчилгааны материал нэг ч харагдсангүй вэ? Яагаад арай удаан хугацаагаар орон сууц түрээслэхийн оронд зочид буудалд байрлаж байв? Эдгээр асуултууд сонгуульд нөлөө үзүүлэх кампанит ажлын өмнөх үед буюу сонгууль болтол дөрвөн жилийн хугацаанд ямар зүйлс болдог вэ гэдгийг эрэлхийлэх сэдлийг надад өгөв. Сонгуулийн албан ёсны сурталчилгааны 21 хоногийн үеэр улс орон даяар хаа сайгүй өрнөх нүдэнд харагдаж, чихэнд сонсогдох кампанит ажил үргэлжилдэг талаар гуравдугаар бүлэгт өгүүлсэн боловч сонгуулиас өмнөх дөрвөн жилд буюу сонгуулийн кампанит ажлын өмнөх шатанд юу болдог талаар яриагүй билээ.

Энэ бүлэгт би Сэржээгийн сонгуулийн кампанит ажлын өмнөх үеийн туршлагад үндэслэн энэ үйл явц нь хувь хүний субьектив байдал, бүлгийн онцлог шинж, өдөр тутмын улс төржилтөд хэрхэн нөлөөлдөг талаар өгүүлнэ. УИХ-ын сонгуульд өрсөлдөх нэг л хүний хүчин чармайлт нь нийгмийн динамик шинж, субьектив шинж байдал зэрэгт өргөн утгаараа хэрхэн нөлөөлж, иргэдийг (эсвэл хүмүүсийг) төдийгүй нэр дэвшигчийн эргэн тойрныг хэрхэн сонгуульжуулж байдаг талаар харуулна. Сэржээгийн кампанит ажил, дэмжигчдээ хэрхэн сонгосон, түүний кампанит ажлын үр дүн зэрэг Сэржээгийн түүх нь сонгуульжилт бол жендэрт суурилсан жендэрийн үйл явц гэдгийг илчилдэг. Сонгуульжилт нь нийгэм, улс төрийн институтийг барьдаг, өргөжүүлдэг, нийгмийн бүлгүүдийг дайчилдаг төдийгүй феминизмийн тодорхой хэлбэрийг дахин бий болгож байдаг үйл явц юм. Сэржээгийн ярьснаас үзэхэд тэрээр бусад эмэгтэйчүүдтэй адилгүйгээр намынхаа эрэгтэй хамтрагчдын эдийн засгийн тусламж, дэмжлэгээс хараат бус байхыг эрмэлздэг. Тэрээр сонгуулийн кампанит ажлын зардлаа өөрөө хариуцаж, боломж гарах бүрд өөрийгөө бие даасан субьект гэдгийг харуулахыг хичээж байсан бөгөөд ингэснээр эрчүүд зонхилсон элитийн улс төрд ч эмэгтэйчүүдийн амьдрал эрэгтэйчүүдээс хараат, тэдний нөлөөнд байдаггүй гэдгийг харуулах эрмэлзэлтэй байсан юм.

Сэржээгийн кампанит ажил эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг нийтлэг нэг нөхцөл байдлыг мөн харуулдаг. Энэ нь хангалттай хүрэлцэхгүй санхүүгийн нөөцөө ухаалаг стратеги, сүлжээ үүсгэх үйл ажиллагаануудаар орлуулахын төлөө хичээж буй байдал юм. Сэржээгийн кампанит ажил ч тэр, кампанит ажлын өмнөх үе ч тэр, эмэгтэй нэр дэвшигчийн сурталчилгааны үйл ажиллагаа нь манлайлал, эрх мэдэл, итгэл үнэмшүүлэлд төвлөрдгийг харуулдаг. Гэхдээ энэ

ажиллагаа нь эрчүүдийн кампанит ажлаас арай өөрөөр явагддаг. Мөн, эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр сул дорой, хэл амтай гэж дүрсэлдгээс бодит байдал бол тэс өөр. Нийтлэг хандлагаас үзэхэд, тууштай байх, ятган үнэмшүүлэх чадвар зэрэг нь эрэгтэйчүүдэд эерэг дүр төрх бий болгодог бол эмэгтэйчүүдэд эсрэгээрээ түрэмгий, хэт шаардсан зэрэг сөрөг чанар болж хувирах нь бий (Togtohbayar 2008).

Сэржээгийн туршлагыг судлахад нэр дэвшигчийн нэр хүнд, эрх мэдэл, олны дэмжлэгт тулгуурласан кампанит ажил, туршлага нь нийгэмд ойлгомжтой, өргөн хүрээнд нөлөөлөл үзүүлдэг буюу Тереза Лауретийн (1987) томьёолсноор “жендэрийн технологи” болдог гэж би үзэв. Монгол дахь сонгуульжилт аль ч жендэрийн өгөгдөхүүнийг бүрэлдүүлэх нөхцөл байдлыг бий болгодог. Энэ нь нэр дэвшигчид өөрийгөө болон бусдыг төлөөлөх стратегиар жендэрийн ойлголтуудыг бүрэлдүүлэн тодотгодог. Сэржээ эрх мэдлийн улс төрийн технологийг (дайчлах, ятгах, удирдан чиглүүлэх гэх мэт) эмэгтэйчүүдийг дайчилж жендэрийн технологитой хослуулж чадсан юм. Тэр эмэгтэйчүүдийн дунд дэмжлэгийн шаталсан тогтолцоог бий болгож, илүү эрх мэдэл, хүч чадлыг бий болгоход түүнийгээ ашиглаж, солилцоо, хэлэлцээ (өрсөлдөгч нь түүний тойргийг булаах хүртэл) хийх замаар эрх мэдлээ хадгалжээ.

Сэржээгийн тохиолдол жендэрийн технологийн олон талт байдлыг маш тодоор харуулдаг. Тэрээр одоогийн жендэрийн тогтолцоог давж гарахын тулд эрх мэдэлд хүрэх стратеги баримталж байв. Одоогийн жендэрийн тогтолцоонд, ялангуяа улс төрд, дийлэнхдээ эмэгтэй хүний онцлог шинжийг эрчүүдтэй, ялангуяа хүчирхэг эрчүүдтэй харьцуулах хандлагатай байдаг. Мөн эмэгтэй шинжүүдийг эрэгтэй улс төрчдийн шинжүүдээс хамааралтайгаар харьцуулна. Эрчүүд зонхилсон эрх, мэдэл, жендэрийн орон зайгаас Сэржээ зугтах боломжгүй ч гэлээ, тэрээр бусад эмэгтэйчүүдтэй шаталсан зохион байгуулалтаар холбогдож, тэр хүрээлээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрэгтэй удирдагчид, хамтран зүтгэгчидтэйгээ харилцах харилцаанд эрх мэдэл олж авахыг эрмэлзэж байсан юм. Сэржээ өөрийнхөө улс төрийн эргэн тойронд эрэгтэй удирдагчдаас хамаарах хамаарлыг боломжит хамгийн бага түвшинд байлгахыг ихэд хичээсэн. Ингэхийн тулд Сэржээ өөрийнхөө гол дэмжлэгийг эрх мэдлийн бүх шатанд буй эмэгтэйчүүдээс эрэлхийлж, эрх мэдлийн шатыг өгсөж ч, уруудаж ч явсаар намын эмэгтэйчүүдийн байгууллагын албан ёсны удирдлагын албан тушаалд ч хүрлээ. Бусад эмэгтэйчүүдийг албан ёсны бүтцээр удирдан зохион байгуулснаар тэрээр эрэгтэй хамтрагчидтайгаа ижил түвшинд очиж, тэдний нөлөө, ивээн тэтгэлгийг хязгаарлаж байсан юм.

Энэ тохиолдол нь жендэрийн болон эрх мэдлийн технологийн үүднээс эмэгтэй хүнийг уламжлалт, ахуйн үүргээр, тэр тусмаа нийгэмд эмэгтэй хүнийг ойлгох бүдэг бадаг ойлголтоор хязгаарлагдахгүйг харуулж байна (Bowie 2008; Wolf 1960). Сэржээ болон бусад эмэгтэй

нэр дэвшигчид Лондонгийн (МакДауэлл[McDowell]) болон Уолл Стрийгийн хөрөнгийн бирж ([Фишер]Fisher 2012) адил эмэгтэйчүүд хэт цөөхөн, эрчүүд давамгайлсан албан ёсны улс төрийн орон зайд ажиллах шаардлагатай тулгардаг. Линда МакДауэлл, Мелисса Фишер нарын эмэгтэйчүүдийн стратегийг богино хугацааны үр дүнгээс илүүтэй, урт хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэл багатай стратегийг сонгодог гэж тодорхойлжээ. Гэвч Сэржээгийн стратеги иймэрхүү төрлийн эмэгтэй хүний талаарх хэвшмэл ойлголттой заавал нийцэх албагүй билээ.

Тэрээр нам дотроо тохироо хийх нөөцийг бий болгож, институтийн шатаар дээш гарахыг хичээсэн. Урам зориг өгөх уриалсан үг хэлэх, бэлгэдэл ашиглах, эв нэгдэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэх мэт түүний зарим стратеги нь социалист эриний үед олон нийтийг дайчлах, удирдах арга барилыг санагдуулдаг. Институтэд [нам дотроо] бүтцийн өөрчлөлт хийх санаачилга гаргах, удирдагчидтайгаа нүүр тулах, удирдах албан тушаалтнуудтай тохироо хийх гэх мэт бусад стратегиуд нь чөлөөт өрсөлдөөнт, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нийцнэ. Сэржээгийн илэн далангүй шаардлага тавьж, зарчмын асуудлаар эрэгтэй хамтрагчид, эмэгтэй удирдлагатайгаа ч нүүр тулдаг чанар нь Монгол уламжлалыг ч, социалист цаг үеийн арга барилыг ч үл санагдуулах, шинэ зан чанар юм. Тэрээр аливаа шалдар булдар зүйл хүсэх, наалинхай яриа өрнүүлэх, өөрийгөө аливаа нөхцөл байдал, уур амьсгалд тохируулан өөрчлөх, ажил бүтээхийн тулд ая тав олохоос татгалзана. Эмэгтэйлэгт тооцогдох эдгээр зан чанараас зайлсхийснээр Сэржээ жендэрийн хэвшмэл хандлагыг эвдэж, шинээр бий болгохыг хичээж байсан юм. Сэржээ эрэгтэй, эмэгтэй удирдлага, эмэгтэй дэмжигчид, штабын ажилчидтайгаа ч нэгэн ижил нээлттэй, илэн далангүй, шулуухан харьцдаг тул энэ зан чанар нь даруу, албархуу, биеэ барьсан харилцаанд дассан хүмүүст цоо шинэ, бүр “гадаадын” ч гэмээр зан чанар байлаа. “Даргын [намын эмэгтэйчүүдийн] өрөөний хаалгыг хэн савж гардаг вэ?” хэмээн Сэржээ надаас асуугаад, “Хэн ч тэгдэггүй юм, намайг ингэсний минь төлөө хүмүүс загнаж, элдвээр хэлдэг. Гэхдээ л хэсэг хугацааны дараа дарга ч миний зөв байсныг хүлээн зөвшөөрдөг юм” гэж үргэлжлүүлэн яриу. Сэржээгийн кампанит ажлын болон кампанит ажлын өмнөх үеийн стратеги, тактик, үйл ажиллагаануудыг харахад жендэрийн технологи, эрх мэдлийн технологи хоёр салшгүй ойлголт гэдэг нь нотлогддог.

Улс төрд оролцохын төлөө төрсөн хүн

Сэржээтэй хийсэн олон удаагийн ярилцлагын үеэр тэр УИХ-ын сонгуульд өрсөлдөх тактик, стратеги, өөрийнхөө улс төрийн замналын талаар надад дэлгэрэнгүй ярьж өгсөн юм. Эдгээр ярилцлагаас би Сэржээ сонгуульд нэр дэвших болсон нь түүний туулсан амьдралын замналын үр дүн бөгөөд нэр дэвших талаарх хүлээлт ч түүний эргэн тойронд

үүсээд байсан гэдгийг ойлгосон. Сэржээ насанд хүрснээс хойших амьдралынхаа дийлэнх хэсэгт улс төрд хэдийнээ орсон, дөнгөж орох гэж буй, эсвэл орохоор төлөвлөж буй хүмүүсээр хүрээлэгдсэн байлаа. Миний уулзсан бусад эмэгтэй нэр дэвшигчдийн нэгийн адил Сэржээ өөртөө итгэлтэй, уран яруу, ерөнхийдөө олон нийтийн өмнө чөлөөтэй биеэ авч явах чадварыг эзэмшсэн байсан. Нас залуу ч гэлээ, тэрээр гүйцэтгэх албан тушаал хашихад хэрэгтэй ур чадваруудыг эзэмшжээ. Тэрээр бусад хүмүүст хариуцах ажлыг нь даалгаж, чадварлаг хүмүүсээр өөрийгөө хүрээлүүлж, төлөвлөгөө боловсруулж, дарга, ажилчид, дэмжигчид, шүүмжлэгчид, болон огт танихгүй сонгогчдын өмнө хүртэл асуудал шийдвэрлэж чадаж байсан юм.

Сэржээ улс төрд орох шийдвэрээ гаргахад хувийн болон нийгмийн маш олон хүчин зүйл нөлөөлжээ. Түүний улс төрд оролцох сонирхолд нөлөөлсөн томоохон хүчин зүйлсийн нэг нь социализмын болон социализмын дараа бий болсон улс төрийн орчин юм. Социализмын үед улс төрд эмэгтэйчүүд эзлэх орон зайг баталгаажуулж, өдөр тутмын амьдралын нэг хэсэг болсон (1-р бүлэг үз), мөн 1990-ээд онд ардчилсан шилжилт хийснээр социализмын үед эрх мэдэл багатай, олны танил болоогүй хүмүүс ч улс төрд өрсөлдөх боломжтой болсон нь түүнийг зоригжуулжээ. Сэржээ 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд улс төрд татагдсан шинэ үеийн улс төрч гэх ангилалд багтана. Барууны феминизм нь өөрийгөө таних, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, хараат бус байдал зэргийг чухалчилдаг нь Сэржээ өөрийгөө боломжит манлайлагч гэдгийг ойлгоход тусалжээ. Тэрээр мөн социалист феминизмийн, ялангуяа бусад эмэгтэйчүүдийг уриалан дайчлахтай холбоотой асуудлыг өөр орчин үеийн дэг журамд нийцүүлэн ашиглав. Өөрөөр хэлбэл, Сэржээгийн хувьд улс төрч байх нь Монголын нийгэмд эзлэх байр суурийнхаа талаар нийгмийн, феминизмийн, түүхэн, болон онолын ойлголтын огтлолцолд суурилсан шийдвэр байлаа. Тэрээр улс төрөөр л амьсгалахаар ирсэн бүсгүй юм.

Сэржээ сонгуульд нэр дэвшсэнээр маш их сэтгэл нь догдолж түүнээсээ урам зориг, эрч хүч авч байлаа. Сонгуулийн өрсөлдөөний дараа ч тэрээр “сонгуульд нэр дэвшсэн нь” түүний хувьд амьдралынх нь хамгийн гоё мөч байсан гэж эргэлзэлгүй хэлдэг. Сонгуульд нэр дэвшсэнийгээ тэрээр бусдад танигдах, бусдаар хүндлүүлж хүлээн зөвшөөрүүлэх нь мартагдахааргүй амжилт байсан гэж үздэг юм. Стратеги, тактикаа алхам алхмаар нь төлөвлөснөөс нь үзвэл түүнийг үйлдэл, үр дүнг эрхэмлэдэг хүн хэмээн тодорхойлж болно. Түүний улс төрчийнх нь онцлог дүр төрх, тэрээр өөрийнхөө эргэн тойронд бүтээсэн зүйлс нь сонгуулийн агуулгаар Монгол хүний субьектив шинж байдалд хэрхэн нөлөөлдгийг харуулна. Сэржээ болон бусад зарим нэр дэвшигчид нэр дэвших шалтгаан, нэр дэвших хүртэл туулсан замнал нь чухамхүү улс орны л бодит байдлаас үүдэлтэй бөгөөд тэд өөр замналыг тухайн

нөхцөлд огтхон ч төсөөлөхгүй, харин ийм л улс төрийн замнал сонгох нь тэдний зайлшгүй жам ёсны л байсан юм гэсэн ойлголттой байснаас үзэхэд сонгуульжилт бол цаг хугацааны үйл явдал биш, тогтолцооны байнгын суурь хүч болсныг харуулдаг.

Сэржээ олон янзын бэрхшээлийг түүртэлгүй зохицуулж байгааг нь ажиглаад би бахархаж байлаа. Биднийг танилцуулсан дундын нэг найз маань Сэржээгийн тууштай байдлыг гайхан шагшиж дараах зүйлсийг ярьсан юм.

Нам нь түүнд тавьж байсан шаардлагуудыг хэрхэн биелүүлснийг мэдэхгүй юм. Нам нь түүнээс нэр дэвшихийн тулд их хэмжээний мөнгө “хандив” хэлбэрээр өгөхийг шаардсан, тэр ч өгсөн. Нам нь түүнээс “Элдэв арга хэмжээ зохион байгуул” гэхэд нь тэр мөн л зохион байгуулсан. Дараа нь нам нь “Хэрэв нэр дэвшигчдийн эгнээнд баймаар байвал 15 эмэгтэйд гадагшаа явуулж манлайллын сургалтад суулга” гэлээ. Сэржээ өөрөөсөө бүх зардлыг нь гарган намынхаа 15 эмэгтэйд АНУ-д сургасан. Хэрэв надаас энэ бүхнийг шаардсан бол би уурлаад аль хэдийнээ нэр дэвшихээс татгалзах байсан биз. Сэржээ баян айлаас гаралтай биш. Тэрээр ажлын гараагаа үйлчилгээний салбарт туслах ажилтнаас эхэлсэн бөгөөд хамаг хүнд хэцүү, бохир ажлыг хийдэг байсан. Тэрээр хүнд хэцүү амьдрал туулсан тулдаа энэ бүх бэрхшээлийг даван туулах хатуужилтай байдаг болов уу.

Сэржээгийн сонгуулийн зардал нь, үгүй ядахдаа надад мэдээлсэн зардлын хэмжээ нь бусад чинээлэг, эрх мэдэлтэй, эрэгтэй улс төрчдийнхтэй харьцуулахад цомхонд тооцогдохоор байлаа. Түүний сонгуулийн зардал телевиз, радиогоор цацах сурталчилгаа, зурагт хуудас, кампанит ажлын ухуулагчид, гарын бэлэг, хүүхдийн тоглоомын талбай, гүүр гэх мэт тойрогтоо хийх сонгогчдын хүлээж дассан зайлшгүй мэт зарим дэд бүтцийн ажлуудад зарцуулагджээ.² Сэржээгийн зохион байгуулсан үйл ажиллагаанууд тодорхой зорилтот бүлэгт чиглэх тул улс даяар сонгуульжилтын үйл явцад тохирох нэг жишээ мөн гэж үзэж болно. 2008 оны сонгуулиар нийт 340 нэр дэвшигч өрсөлдөв. Гэвч намаасаа нэр дэвших зөвшөөрөл авах, албан ёсны 21 хоногийн кампанит ажил эхлэхээс өмнө гурав дахин олон тооны нэр дэвшихээр гориллогчид нэр дэвшихийн төлөө бүтэн хоёр жил өрсөлдөнө. Гол улс төрийн намуудад албан бус, ихэнхдээ далд хэлбэрээр урьдчилан кампанит ажил ротацад орох гэх нэрийн дор явагдана. Энд ротац гэдэг нь нэр дэвших замдаа явж буй гэдэг илэрхийлэх зорилготой. Жишээлбэл, хоёр гол намын нэг нь УИХ-ын нийт 76 суудлаас бараг гурав дахин их буюу 200 гаруй гориллогчдыг ротацид оруулжээ. Өөрөөр хэлбэл, кампанит ажил эхлэх үеэр улс даяар төрөл бүрийн улс төрийн намын болон бие даан нэр дэвших сонирхолтой зуу зуун хүмүүс ямар нэг баталгаагүй ч, нэр

² Түүний намдаа өгсөн хандивыг энд дурдсангүй.

дэвших эрхээ баталгаажуулахаар улайран, өрсөлдөж байдаг гэсэн үг. Сэржээ бэлтгэл ажилдаа хичээнгүй хандаж байсан тул түүний жишээ нь хэд хэдэн улс төрчид сонгуулийн нэг тойрогт өөр хоорондоо төстэй олон нийгэд чиглэсэн үйл ажиллагаа зэрэг явуулах нь ямархуу байдгийг төсөөлөхөд бидэнд тусална.

Стратеги ба тактик

Сэржээгийн тохиолдол зарим талаар нэр дэвшигчдийг төлөөлөх боловч, зарим талаар маш онцгой тохиолдол юм. Миний ажигласнаар бусад нэр дэвшигчидтэй харьцуулахад тэрээр үйл ажиллагаагаа эмэгтэйчүүд рүү, эмэгтэйчүүдийн байгууллагууд руу чиглүүлснээр дэмжлэг бий болгох, санал баталгаажуулах зорилготой байлаа. Сэржээ хүчирхэг эрчүүдийн дэмжлэгт найдахаас илүүтэй эмэгтэйчүүдийн эв нэгдлийн хүч, эмэгтэйчүүд бие бие дэмжинэ гэдэгт итгэдэг феминист нэгэн юм. Тиймээс, Сэржээ эмэгтэйчүүдийг нэг талаар улс төрийн карьерыг нь дэмжих нөөц, нөгөө талаас улс төр, эдийн засгийн дэмжлэгийнх нь үр шимийг хүртэгч гэж харж байсан нь түүнийг бусад нэр дэвшигчдээс ялгаруулдаг. Сэржээ бусад эмэгтэйчүүдийг өөрийн манлайлал дор нэгтгэн зангидаж, дайчилж, өөрийгөө хүчирхэгжүүлэхийн зэрэгцээ эрчүүд давамгайлсан улс төрийн намын хатуу, албан ёсны бүтцэд эмэгтэйчүүдийн байр суурийг ч мөн нэмэгдүүлж чадсан.

Сэржээгийн сонгуулийн кампанит ажлын бэлтгэл Мишел Де Сертогийн тактик, стратеги хоёр нэг нэгнээ харилцан диалектик хэлбэрээр идэвхжүүлдэг гэсэн тодорхойлолттой нийцдэг. Серто стратегийг аливаа нэг хүчинтэй харилцах харилцааны хувьд “Аливаа субъект (бизнес, арми, хот, эрдэм шинжилгээний хүрээлэн гэх мэт) ямар нэг зүйл хийх хүсэл зориг, хүч чадал нь бүрдмэгц бий болох эрх мэдлийн тооцоолол (эсвэл манипуляц) юм” гэжээ (1984, 36). Өөрөөр хэлбэл, стратеги боловсруулахад өрсөлдөгчтэйгөө дүйцэх хүчтэй байх шаардлагатай. Стратеги “эхлээд ‘өөрийн’ байршлыг буюу өөрийн хүч чадал, хүсэл зоригийн байршлыг ‘орчноос’ ялгадаг” (1984, 36). Өөрийн байршил нь “олж авсан давуу талуудаа бэхжүүлэх, ирээдүйн үйл ажиллагаанд бэлдэх, улмаар хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдалд харьцангуй бие даасан байдлыг олгох” тул маш чухал (1984, 36). Амжилттай стратеги хэрэгжүүлэхийн тулд Сертогийн нэрлэснээр бүрэн зургаар нь харах буюу цаг хугацаа, орон зайг аль алиныг нь төгс тооцоолох шаардлагатай. Ингэснээр ирээдүй цагийг одоогийн орон зайгаар дамжуулан унших боломжтой болно. Орон зайг оновчтой уншсанаар цаг хугацааг овжин ашиглах боломжтой. Цаг хугацаа, орон зайг төгс тооцоолж чадвал мэдлэгээ тогтвортой хадгалж, урт хугацаанд өгөөжийг хүртэнэ (1984, 36).

Эсрэгээрээ тактик бол “өөрийн эрх мэдлийн байршил байхгүй үед хийх үйлдэл” (de Certeau 1984) бөгөөд аль нэг гадаад хүчний хүрээн дотор л хөдлөх боломж юм. Тактикч хүнд тус газар нутгийн гадна, дотно талд хурдан хариу үйлдэл үзүүлэх боломж бага тул гол шийдвэрлэх стратегийг хэрэгжүүлэх, төлөвлөх боломжгүй. Тактик “ялалтуудыг цуглуулж нөөцлөх” боломжгүй боловч гэнэт бий болох боломжуудыг болон тогтолцооны “хагарал”-ыг ашигладаг сул дорой хүмүүсийн урлаг юм (1984, 37). Сонгуулийн агуулгаар үзвэл нэр дэвшигчийн стратеги нь улс төрийн намууд, эрх зүйн зохицуулалтаар тодорхойлогдох нь мэдээж хэрэг. Гэсэн хэдий ч, хувь хүний үйлдэл тэдний танигдахуй, нөөц, эрх мэдлээс шалтгаалж харилцан адилгүй байдаг.

Монгол эмэгтэйчүүдийн сонгуулийн оролцоо, цаашлаад Монголын сонгуульжилтыг өргөн утгаар нь авч үзэхэд стратеги, тактикийн ялгааг ажиглах нь маш чухал. Стратегийн үүднээс эмэгтэй нэр дэвшигчид сонгуульд ялалт байгуулах төдий бус, харин эрэгтэйчүүд зонхилсон улс төрийн орон зайг сууриар нь өөрчлөх, эмэгтэй улс төрчийн субъектив шинж байдлыг дахин бий болгохыг эрмэлзэж байна. Тэд сонгуулийн улс төрд орж байгаа тул тактикийн давуу талуудаа хадгалахын тулд ажиллах, мөн эрчүүд давамгайлсан улс төрийн соёлын нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, улс төрийн давуу байдал олж авахын төлөө хурдан шаламгай хариу үйлдэл үзүүлж ажиллах хэрэгтэй болно. Энэ утгаар парадигмын өөрчлөлт авчрах стратеги, бүтцэд суурилан тодорхойлогдох тактик хоорондын диалектик харилцаа нь эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийнхөө эрхийн төлөө маш оновчтой шийдвэр гаргахыг үргэлж шаарддаг, төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэдэг. Арга зүйн талаас үзвэл, энэ динамикийг ажигласнаар эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай бусад нэр дэвшигчдэд хувь хүнийх нь амьдралд заавал тохиолддог нөхцөл байдлыг ойлгоход тусалдаг бөгөөд үүнийг бусад феминист угсаатан зүйчид аль хэдийнээ судлан гаргаад буй хандлагатай тохирдог (Жишээлбэл, Ginsburg 1989; Ahearn 2001; Mahmood 2004).

Сертогийн тодорхойлсон стратеги, тактикийн талаарх ойлголт нь эмэгтэй нэр дэвшигчдийн үйл ажиллагааг эргэцүүлэхэд туслах боловч, сонгуулийн кампанит ажлын үүднээс стратеги, тактикийг илүү нарийн авч үзэх хэрэгтэй. Учир нь сонгуулийн кампанит ажил бусдын төсөөлөл, үзэл бодол, субъектив шинж байдалд гол төлөв нүүр тулсан харилцаагаар, заримдаа ажлын орон зайгаар дамжуулж нөлөөлж байдаг. Өөрийнх нь тулааны орон зай нь өрсөлдөгчийнхөөс ялгарах зүйл үгүй. Ихэнхдээ гол тулалдаан бусдын субъектив шинж байдал, байр суурийг өөрчлөхийг оролдоно. Тиймээс, Сертогийн тодорхойлсон стратегийн ойлголтыг би нөлөөлөхүйц, ба бүтцийн гэж 2 хуваалаа. Сэржээ горилочг байхдаа ч, нэр дэвших үедээ ч өөрийнхөө тухай хүмүүсийн ойлголтыг эергээр эргүүлж, өөрийгөө чадварлаг улс төрч гэж таниулахын тулд нөлөөлөхүйц стратеги

хэрэгжүүлсэн гэж үзвэл зохино. Түүний ур чадварууд уулзалтын үеэр нэр хүндийг нь гутаан доромжлохоос өөрийгөө хамгаалах, хамтран нэр дэвшигчийнхээ сурталчилгааны зардлыг төлөхөөс татгалзах, уулзалтын үеэр бусад нэр дэвшигчдийн зохион байгуулалттай дайралтын эсрэг тайзан дээрээс өөрийгөө хамгаалах гэх мэтээр илэрч байсан. Заримдаа түүний нөлөөлөхүйц стратегиуд нь намын удирдлагуудтай хэлэлцээ хийх, багийнхнаа ятган үнэмшүүлэх чадвараар илэрнэ. Бусад үед тэрээр хүмүүстэй танилцах, харилцаа холбоогоо бэхжүүлэхэд тус болох үдэшлэгүүдэд оролцох, илүү өндөр албан тушаалтай хүмүүс нь түүний тэмцэж буй албан тушаалыг авах үед жөтөөрхөж хандахгүй байх гэх мэт сэтгэл хөдлөлөө удирдаж чадаж байсан нь ч нөлөөлөхүйц стратегийн нэг илрэл юм.

Тэрээр нөлөөлөхүйц стратегиас гадна миний бүтцийн гэж нэрлэсэн стратегийг мөн хэрэгжүүлсэн. Түүний бүтцийн стратегиуд нь, сонгогдохуйц нэр дэвшигч болгож өөрийгөө бэлдэх, нэр дэвшихэд нь учирч байсан хуулийн болон бүтцийн саад тогторыг давах (ялангуяа нэр дэвшигчийн хүйсийн квотыг 30 хувь болгоход тусалсан), орон зайгаа баталгаажуулах (сонгуулийн тойрог олох, тойргийн төлөө тэмцэх гэх мэт), нам доторх байр сууриа бэхжүүлэх, намын эмэгтэйчүүдийн байгууллагаар дамжуулан дэмжигчдийнхээ суурийг бүрдүүлэх, дайснаа дарах, үгүйдээ л дайсагналыг хамгийн бага түвшинд байлгах гэх мэтийг агуулах тул Сертогийн тодорхойлсон стратеги гэх ойлголттой давхацдаг. Эдгээр стратегиуд бүгд өргөн хүрээний стратегиуд бөгөөд орон зай, цаг хугацаа, хүний нөөц, нөлөөлөл, болон Сэржээгийн албан ёсны сонгуулийн сурталчилгааны үеэр ашиглах мэдлэгийн хуримтлалыг ч мөн адил бүтээлчээр зохион байгуулсан юм. Эдгээр өргөн хүрээний бүтцийн стратегиуд нь өдөр тутам нөлөөлөхүйц стратегиудыг шингээдэг.

Сэржээ сонгуулийн кампанит ажил албан ёсоор эхлэхэд урьд нь гаргасан бусад бүх удаан хугацаагаар хуримтлуулсан олон амжилтуудаа орхиж, цоо шинээр өөр зүйл рүү орох ёстой болсон талаар уншигчдад дараагийн хэсэгт тайлбарлана. Энэ өөрчлөлт нь түүний мэдлээс давсан зүйл байлаа. Тэрээр байдлыг бүрнээр нь харж хянах боломжийг олгож байсан өөрийн стратегиа өөрчилж, өрсөлдөгчөө харах боломжгүй бусдын мэдлийн орон зайд, хязгаарлагдмал хүрээнд, гол төлөв тактикаас бүрдэх байдал руу шилжихээс аргагүй болсон юм. Энд би тодорхой стратеги, тактикийн үр дүнгийн чанар, амжилтыг үнэлэхийг сонирхсонгүй. Харин эрчүүд давамгайлсан орон зайд эмэгтэйчүүдийн хэрэгжүүлсэн стратеги, тактик нь хэрхэн тэдний субъектив шинж байдлыг хэлбэржүүлж, сонгуульжилтын орон зай, цаг хугацаанд хэрхэн үйлчилснийг харуулахыг зорилоо.

Нөлөөлөхүйц стратегиуд: Мэдлэгийн Ажил, Шөнийн ажил, Уух ажил

Нөлөөлөхүйц стратегиудыг Сэржээ кампанит ажлынхаа туршид үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн юм. Бараг алхам тутамдаа кампанит ажлаа урагшлуулахын тулд нөлөөлөхүйц стратеги ашиглаж байв. Гэсэн хэдий ч би энэ хэсэгт эрчүүд зонхилсон улс төрд ажиллахад эмэгтэйчүүд эмэгтэй хүн байсныхаа төлөө ямар зүйлсийг даван туулдаг талаарх нөлөөлөхүйц стратегийн хамгийн өвөрмөц жишээнүүдийг дурдана. Сэржээ нэр дэвшихдээ бэлдэж, мэдлэг, гэр бүлийн дэмжлэг, шинэ хүрээлэл бий болгох гэх мэт олон зүйлийг урьдчилан тооцсон бөгөөд дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй өгүүлэх болно. Нэр дэвшихэд хамгийн анхдагч шаардлага буюу мэдлэгээ дээшлүүлэхийн тулд Сэржээ үндэсний болон НҮБХХ гэх мэт олон улсын байгууллагуудаас зохион байгуулах эмэгтэй нэр дэвшигчдийг бэлтгэх сургалт, семинаруудад оролцож эхлэв. Тэдгээр сургалт, семинаруудаас Сэржээ ардчиллын үйл явц, нэр дэвших, болон улс төрд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурийн талаар суралцжээ. Дараа нь тэдгээр байгууллагуудтай ажиллаж улс төрийн намын эмэгтэйчүүдэд чадавч бэхжүүлэх сургалт орж эхэллээ. Сургалт зааж багшилснаар тэр өөрийнхөө олны өмнө ярих, илтгэх, танилцуулга бэлдэх ур чадвараа сайжруулжээ. Түүнээс гадна тэрээр өөр өөр улс төрийн намын эмэгтэйчүүдтэй уулзаж, нам доторх эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, намын дотоод улс төрийн талаар суралцав.

Сайтар бодсоны дараагаар Сэржээ өөрийнхөө үнэт зүйл, зан чанарт тохирно гэж үзсэн улс төрийн намд элсэн оров. Намын гишүүн болсны дараа Сэржээ бусад гишүүдийн сонгуулийн кампанит ажилд оролцож, харилцааны техник, сурталчилгаанд хэвлэл мэдээлэл ашиглах, нөлөөллийн ажил гэх мэт кампанит ажлын ур чадваруудад суралцжээ. Ингэхдээ тэрээр хувь хүний хувьд ч, нэр дэвшигчийнхээ хувьд ч чиг баримжаа болгон тусгасан онол болон практикийн ойлголт хэллэгүүдийг эзэмшиж өдөр тутмынхаа яриа болон албан ёсны үг хэлэх бас илтгэл тавихдаа өргөн ашиглаж байлаа. Үүнд дараах зүйлс багтана.

Зөвшилцөл – negotiation

Асуудал шийдэх – problem-solving

Жендэрийн тэгш эрх – gender equality

Эмзэг бүлгийнхэн – vulnerable groups

Ядуурлыг бууруулах – poverty reduction

Эмэгтэйчүүдийг улс төрд чадваржуулах – political empowerment of women

Квот – quota

Сонгогчийн нэрийн жагсаалт – voter registration list

Хүлээн авалт – receptions

Арга хэмжээ – event

Багийн тоглолт – team work/performance

Хурал/форум – forum

Эдгээр нэр томьёо Сэржээгийн үеийнхэнд тохиолдсон, магадгүй өөрийгөө улс төрч болгон хөгжүүлэхэд хүргэсэн хурдацтай нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг илэрхийлэх мэт. Эдгээр нэр томьёо олон улсын байгууллагууд Монголд олширч, хүний эрх, эмэгтэйчүүдийн, болон тэдний эрхийн асуудлаарх яриа улам бүр нэмэгдсээр байсан 1990, 2000-аад оны үеийг илтгэнэ. Хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн үүрэгт өөрчлөлт орсны улмаас эмэгтэйчүүд ядуурч, нийгмийн давхаргажил үүсэж байсан тул эмэгтэйчүүдэд зориулсан бодлого боловсруулах, ядуурлыг бууруулах стратеги, улс төрд эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх талаарх яриа ихэд өрнөж байлаа. Энэ үе нь нэр дэвшигчдийн хүйсийн 30 хувийн квот бий болоогүй үе юм. Сэржээ шиг эмэгтэйчүүдийн хувьд 2000-аад оны үе (2008 оны сонгуулиас өмнө) бол ардчиллын үйл явцыг улам бэхжүүлж, улс төрд, бодлого боловсруулахад эмэгтэйчүүд илүү үр нөлөөтэй оролцох боломжийн талаарх мөрөөдлөөр дүүрэн, сэтгэл хөдөлгөм үе байсан юм.

Бусад эмэгтэйчүүдээс ялгаатай нь Сэржээгийн нөхөр түүний амбицыг дэмждэг, нэр дэвшихийг ч ятгаж байсан юм.

Миний нөхөр бол миний улаан шүтэн биширэгч. Тэрээр намайг хүсэл мөрөөдлөө дагахыг урамиуулахын зэрэгцээ надад УИХ-д нэр дэвшихдээ маш сайн бодох ёстойг хэлж байлаа. Тэр надад “энэ бол том үүрэг бас хариуцлага шүү” гэж хэлсэн. “Хүүхдээ харж ч чадахгүй, уртасгасан цагаар удаан ажиллаж чадах уу?” гэж асуух үед хүүхэд маань нярай байлаа. Тэрээр мөн, “үндсэн ажлаасаа гараад, бага орлогод сэтгэл хангалуун байж дасах хэрэгтэй” гэж хэлж байсан. Нэг өдөр нөхөр маань надаас “Хэрэв сонгуулийн кампани ид өрнөж байх үед би өвдөөд зурх маань зогсчихвол чи яах вэ?” гэж асуухад нь би, “мэдээж хэрэг, чам дээр очно шүү дээ” гэж хариулав. Тэрээр “Тэгвэл чи улс төрч биш байна. Чи өөрийнхөө хувийн амьдралыг биш ард түмнээ, улсаа бодох ёстой шүү дээ” гэж хэлсэн юм.

Мөн, Сэржээгийн гэр бүл түүнийг улс төрийн карьер хөөх, танилын хүрээ нэмэгдүүлэхийг дэмжиж ойлгож байсан нь бусад эмэгтэйчүүдээс ялгаатай байсан хэдий ч тэрээр ажил дээрээ ноцтой асуудалтай тулгарлаа. Хамгийн эхний бэрхшээл нь намынхаа эрчүүдтэй, ялангуяа удирдлагын түвшний эрчүүдтэй ажиллахад оройн цагаар, ажил тарсны дараа цугларч архи уунгаа улс төр ярилцах шаардлагатай болов.

Бараг бүх л уулзалтын үеэр манай (дүүргийн намын хорооны) дарга архи задалж, зочид болон ажилчидтайгаа тойруулдаг байв. Тэрээр танигдсан нэгэн бөгөөд маш олон дагагчтай. Төв (дүүргийн намын хороо) дээр үргэлж

л найр болно. “Ажил амжуулах ганц арга нь энэ шүү дээ” гэж тэр надад хэлэв. Би үүнтэй хэзээ ч санал нэгдэж байсангүй. Дээд удирдлагатай арай ойр ажиллах үедээ би эрчүүдтэй зэрэгцэн суугаад уудаг байлаа. Архи ууж чаддаггүй, хааяа шар айраг, вино л уудаг надад энэ нь том асуудал байсан юм. Түүнчлэн, бид баяр, арга хэмжээ, тэмдэглэлт ой бүрийг тэмдэглэж, хүлээн авалт зохион байгуулж, салхинд гарна. Би ийм төрлийн зардал гаргахын эсрэг байдаг. Би нэг удаа даргадаа хүлээн авалт, үдэшлэг зохион байгуулахын оронд сургалт, семинар хийж, хүмүүсийг сургаж, мэдлэг түгээмээр байгаагаа хэллээ. Тэр надад улс төр хэрхэн явагддаг талаар чамд ямар ч ойлголт алга гэсэн юм. Намайг албан тушаал ахихад дарга маань намайг эмэгтэйчүүдээ аваад амралтын өдрүүдээр амралтын газар очиж салхинд гарахыг зөвлөв. Гэвч би түүн рүү болон энэ талаар ярьж байсан бусад эмэгтэйчүүд рүү залхсан байдалтайгаар муухай хараад л өнгөрсөн юм.

Ажлын арга барил нь зөрчилдөж байсан ч гэлээ, Сэржээгийн дарга нь түүний улс төрийн карьерыг дэмжих сонирхолтой байлаа. Сэржээ сонгуулийн кампанит ажлын үеэр, ялангуяа сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой маргаан дэгдэх гэх мэт хамгийн эгзэгтэй үед ажиллах хүчээ бэлтгэж, намдаа эмэгтэйчүүдийг дайчлах онцгой чадвараа харуулсан юм. Түүнчлэн, нэр дэвшигчийн хүйсийн квот 30 хувь байх талаар яригдаж байх үед (2007 оноос өмнө) улс төрийн намын удирдлагууд эдгээр суудлыг бусад намд алдахгүйн тулд хамгийн сонгогдохуйц эмэгтэйчүүдээ нэр дэвшүүлэх сонирхолтой байлаа. Тиймээс Сэржээгийн дарга түүнийг ихэд дэмжиж байв. Гэвч түүний дэмжлэг нь эмэгтэй хүн, эх хүн, эхнэр хүний амьдралын болон ажлын хэв маягтай үл нийцэх төдийгүй бараг л хор нөлөөтэй байдал руу чиглэнэ.

Анхандаа би уулзалтын үеэр уудаггүй зүгээр л суудаг байлаа. Дараа нь тэдэн дунд эрүүл хүн байхаар эрчүүд хяналтын дор байгаа мэт санагдаж, хардах хандлагатай байгааг би анзаарсан. Тэд чөлөөтэй, нээлттэй ярихаа больж, улс төрд оролцоход надад хэрэгтэй нарийн ширийн зүйлсийг хуваалцахаа болив. Тиймээс би хатуу архи хэтрүүлэггүйхэн шиг хэрэглэж сурлаа. Тэгэхгүй бол тэд намайг хүрээллээсээ хасаж, би хэзээ ч шинэ мэдээлэл авч чадахгүй орхигдох байсан биз. Тэр тойрог, хүрээллээс мэдээлэл авалгүйгээр улс төрд байх ямар ч боломжгүй. Хамгийн хоржоонтой нь тэд хамгийн чухал зүйлсээ шөнийн 2 цагийн үед ярьж эхэлдэг. Эдгээр эрчүүд яг л өөрийн гэр бүлгүй, ганц бие хүмүүс мэт амьдарна.

Сэржээ бага насны хүүхэдтэй эх хүн тул оройн 7 цагт гэртээ харихыг хичээх боловч ихэнх өдөр арай гэж 10 цагт харьдаг байлаа. Өдөр нь үндсэн ажлаа хийгээд, үдээс хойш дүүргийн намын хороонд ажилласаар байтал орой болно. Гэвч тэрээр шөнийн уулзалтуудад оролцоогүй үедээ чухал үйл явдал, шийдвэрээс хоцорч байв. Сэржээ үргэлж л угсаар дуудагдах боловч заримдаа үнэхээр өөрөө биечлэн байх шаардлагагүй

байх тохиолдол олон таарна. Заримдаа архи, дарстай эдгээр шөнийн уулзалтын үеэр эцсийн мөчид шийдвэр гарах хүртэл юмс тодорхойгүй хэвээр байна. Уулзалтууд ямар нэг тодорхой үр дүнгүй дуусах нь элбэг тул, тэрээр зарим уулзалтуудыг алгасаж байв. Сэржээ ганцаараа эмэгтэй байх бөгөөд дан эрчүүдийн дунд байхаас эвгүй мэдрэмж төрж байлаа. Ихэнх эрчүүд гэрлэсэн, зарим нь салсан. “Ийм уулзалтуудын уур амьсгал таатай бишийн дээр надад зөв санагддаггүй” гэж надад хэлсэн юм.

Нэг удаа тэрээр долоо хоног гаруй шөнийн уулзалтуудад оролцоогүй аж. Тэр үед Сэржээ дүүргийн намын эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүнээр ажиллаж байлаа. Тэрээр төрөл бүрийн арга хэмжээг өөрөө санхүүжүүлэн зохион байгуулаад завгүй байсан бөгөөд мөн л гэртээ оройтож харьж байжээ. Төд удалгүй Сэржээ дүүргийн намын хороо өөрийг нь огцруулж өөр хүнийг томилох гэж буй талаар дуулав. Сэржээ хийж буй ажлынхаа талаар дарга нартаа цаг тухайд нь мэдээлэл өгөөгүй учраас бусдын цуу яриан дээр тулгуурлаад түүнийг огцруулах цочир шийдэл гаргасан байжээ.

Өөр нэгэн удаа Сэржээ Улаанбаатар хотын гадна томоохон форум зохион байгуулахад тусалж байсан тул шөнийн уулзалтад мөн л долоо хоног очиж чадсангүй. Тус форум нь эмэгтэйчүүд улс төрд оролцоход илүү таатай орчин бүрдүүлэх, нэр дэвшигчийн хүйсийн квотыг 30 хувиар батлуулахын төлөөх томоохон лоббины нэг хэсэг байсан юм. Тэр үед Сэржээ хөхүүл байсан тул нялх хүүхдээ аваад явдаг байв. Форум ч амжилттай болж, форумдаа дуусгаад тэрээр шөнө дунд гэртээ харьжээ. Шөнийн хоёр цагийн үед дарга нь түүн рүү залгаад “бидэнд чиний дуу хоолой хэрэгтэй байна ажил дээр хурдан хүрээд ир. Намын төв байгууллагад өөрчлөлт орж байна чиний санал хэрэгтэй байна” гэж гэнэ. Сэржээ шөнийн уулзалтуудад эргээд оролцох болжээ. Тэр гэртээ өглөөний 4, 5 цагийн үед ирдэг болов. “Нөхөр маань надад итгэж, дэмждэг бөгөөд гэртээ оройтож ирэхэд тэгтлээ бухимддаггүй. Харин нөхөр маань намайг ажлын хамтрагчидтайгаа архи уухыг огт хүлээн зөвшөөрөхгүй байлаа” гэж Сэржээ ярьсан юм. Сэржээ амжилттай нэр дэвшигч байхын тулд архи уух нь ажлынх нь нэг хэсэг болохыг тайлбарлахыг хичээвч нөхөр нь үүнтэй эвлэрсэнгүй.

Сэржээ шөнийн уулзалтуудад үргэлжлүүлэн оролцож, эрчүүдтэй байнга уулзаж, хамтран ажиллах шаардлагатай боловч, тэрээр ил тод, зохион байгуулалт сайтай, намын эмэгтэйчүүдийн байгууллагыг албан ёсоор удирдах ажлаа илүүд үздэг байлаа. Эмэгтэйчүүдийн байгууллагыг удирдах нь хэдий хүндрэлтэй, нөөц шавхсан, хөдөлмөр шаардсан ажил байсан ч гэлээ тэрээр өөртөө хамгийн тохиромжтой гэж үзэж байв. Учир нь тэнд таарч тохирох болов уу гэсэн айдас, ажлын байран дээрх тав тухгүй байдал, ичгүүр сонжуур гэх мэт бусад хүндрэл тулгардаггүй. Цаг хугацаа, орон зайн тодорхойгүй нөхцөлд цөөн тооны эрэгтэй улс төрчдийн хүрээлэл дунд ажиллах нь жендэрт суурилсан

үл нийцэлд үндэслэсэн тул түүний ур чадвар, мэдлэг, хичээл зүтгэлээс давсан асуудал байв. Өөрт тохиромжгүй, эвгүй байдалд ажиллах нь эмэгтэйчүүдийн байгууллагыг бэхжүүлэх хүлээн зөвшөөрөгдсөн орон зайд, ил тод ажиллахдаа бие, сэтгэлийн хувьд ядарч туйлдахаас ч хамаагүй хэцүү хэрэг байлаа. Эмэгтэйчүүдийн байгууллагад Сэржээ ур чадвар, мэдлэг, мөн чанараа ямар нэг эвгүй мэдрэмжгүйгээр гаргах боломжтой байсан юм.

Бүтцийн стратеги: Тойргийн төлөөх тэмцэл

Намынхаа нөлөө бүхий хүрээлэлд ороход ашигласан нөлөөлөхүйц стратегиас гадна, Сэржээ миний нэрлэснээр бүтцийн стратегийг ч мөн хэрэглэсэн юм. Эдгээр нь нэр дэвших эрх авахын тулд түүний хийсэн томоохон алхмаас бүрдэнэ. Үүнд, нэр дэвшигчийн хүйсийн квот 30 хувь байх гэх мэт эрх зүйн орчныг засахаас авхуулаад намаасаа нэр дэвших тойрог авахад Сэржээ намын удирдлагын схем дотор удирдах албан тушаал хүртэл өгсөх гэх мэт багтана.

2005 онд нэр дэвшигчийн хүйсийн квот 30 хувиар батлагдахад Сэржээ хамгийн идэвхтэй оролцсон хүмүүсийн нэг байсан юм. Хүйсийн квот батлагдсаны дараагаас тэрээр сонгуулийн хуулийг эмэгтэйчүүдэд илүү ээлтэй болгох талаар лобби хийж эхэлсэн. Гэвч, номын удиртгал хэсэгт дурдсанчлан УИХ 2007 онд квотыг цуцлав. Эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх гэсэн албан ёсны, хамтын стратеги үр дүнтэй байсан ч хууль тогтоогчид тус заалтыг унагав. Тиймээс эмэгтэйчүүд нэр дэвшихийн тулд зөвхөн өөрсдөдөө найдах, стратеги гэхээсээ илүү тактикийн үйлдлүүд хийх хэрэгтэй боллоо. 2007 онд нэр дэвшигчийн хүйсийн квотыг цуцалсан хэдий ч Сэржээ 2008 оны сонгуульд нэр дэвших төлөвлөгөөгөө орхисонгүй.

Нэр дэвшигчийн хүйсийн квотыг хуульчлах үйл явцад хувь нэмрээ оруулахын зэрэгцээ Сэржээ нам дотроо нэр дэвших эрхийн төлөө ажиллаж байсан юм. (Өмнөх хэсэгт дурдсанчлан намын удирдлагын хүрээлэлд орж ажиллах нь энэ зорилгын төлөөх хүчин чармайлтын нэг хэсэг байв.) Намаас нэр дэвшигчдийг тухайн нам нь Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-нд бүртгүүлдэг тул өрсөлдөөн байнга өрнөж байдаг бөгөөд үүнийг ротацад орох гэнэ. УИХ-ын сонгуульд нэр дэвшихийн төлөөх өрсөлдөөн албан ёсны сонгуулийн сурталчилгааны хугацаанаас хамаагүй өмнө (дунджаар хоёр жилийн өмнө) эхэлж, сонгуулийн албан ёсны сонгуулийн сурталчилгааны дараа ч (өмнө нь ч) удаан хугацаанд үргэлжилж сонгуульжилтыг бэхжүүлсээр байдаг. Нэр дэвших нь баталгаагүй ч горилогчид намдаа хандив өгөх, горилж буй тойргийнхоо сонгогчдод танигдах ажлууд зохион байгуулна. Нэр дэвшихээр горилогчид сонгуулиас өмнө намын бүтцэд захиргааны албан тушаал

эрхлэх, эсвэл намын төлөөллийн төв байгууллагад гишүүнээр элсэх нь маш чухал. Түүнчлэн, эмэгтэйчүүд өөр өөрсдийн улс төрийн намынхаа эмэгтэйчүүдийн байгууллагад удирдах албан тушаал эрэлхийлнэ.

Нэр дэвшихийн тулд Сэржээ тойрог олох ёстой боллоо. Ингэхийн тулд тэрээр намынхаа үндэсний хороонд, мөн эмэгтэйчүүдийн байгууллагад удирдах албан тушаал хаших ёстой. Яг л өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэдэг асуудал шиг. Тойрог, удирдах албан тушаал “нягт холбоотой” боловч аль нь түүрүүнд ирдэг талаар тодорхой дараалал үгүй. Намд удирдах албан тушаал хашихын тулд түүнд тойрог хэрэгтэй, тойрогтой байхын тулд албан тушаал хэрэгтэй. Тиймээс, тэрээр оргүй хоосноос эхлэхдээ зам дагуу таарах олон боломжийг ашиглах болсон юм. Нэр дэвшигчид тэр бүр тухайн тойрогт байнга оршин суудаггүй, эсвэл байнга суугаа тойрогтоо нэр дэвшдэггүй ч, эцэг эхийнхээ төрсөн нутагт бас нэр дэвшдэг туршлагатай.³ Сэржээ сонгуулийн кампанит ажлын өмнөх шатыг эхлүүлж (албан бус) өөрийгөө чадварлаг нэр дэвшигч байж чадна гэж харуулахын тулд хангалттай дэмжлэг цуглуулах хэрэгтэй байлаа.

Сэржээ анх Сэлэнгэ аймагт нэр дэвших сонирхолтой байв. Тэнд очиж ажиллахаар хөдлөхийн өмнөхөн нэгэн нэр хүндтэй эмэгтэйчүүдийн ТББ-ын ерөнхийлөгч Сараа түүнийг явахгүй байхаар ятгажээ. Тус ТББ нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олонд танигдсан байгууллага байлаа. Сараа өөрөө Сэржээд намынхаа үндэсний хороонд олон ажил ажилласан, 2008 оны сонгуульд Сэлэнгэд нэр дэвших төлөвлөгөөтэй байгаагаа хэлжээ. Сараа Сэржээг маш залуу учир түүнд өөр тойрог хайж олох цаг хугацаа байгаа, Сараа өөрөө эгчмэд тул удаан хугацаагаар ажиллаж танигдсан тойрогтоо нэр дэвших гэж байгаагаа учирлан тайлбарлажээ. Түүний туршлагыг ч, нэр хүндтэй ТББ-ын тэргүүн гэдгийг нь ч бодолцоод Сэржээ өөр тойрог хайхаар шийдэв.

Хоёр дахь удаагийн оролдлогоороо Сэржээ намынхаа даргатай зөвлөлдөөд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт нэр дэвшихийг санал болгов. Сүхбаатар дүүрэг бол сонгогдсон гишүүд нь ерөнхий сайд, намын дарга, хотын дарга гэх мэт албан тушаал хүртэл хашиж байсан “томчуулын” тойрог билээ. Сэржээ ялсан ялаагүй тэнд нэр дэвших нь нэр хүндтэй хэрэг тул зориг шулууджээ. Сүхбаатар дүүрэгт нэр дэвшихийн тулд тэрээр намын төлөөллийн төв байгууллагад Сүхбаатар дүүргээс сонгогдох ёстой.

³ Хүсэж буй тойрогтоо өрсөлдөхийн төлөөх намын дотоод өрсөлдөөн маш ширүүн өрнөх бөгөөд, хэр зэрэг тохироо хийж, өрсөлдөж чадахаас шалтгаалан нааш цааш маш олон өрсөлдөөн, тулаан өрнүүлж ч болзошгүй. Нэр дэвшигч тухайн тойргийнхоо оршин суугч байх ёстой боловч бодит байдалд нэр дэвшигчид огт өөр газар амьдрах туршлага түгээмэл байна. Мөн нэр дэвшигч эцэг, эхийнхээ төрсөн нутгийн тойрогт нэр дэвших туршлага мөн элбэг байдаг. Хэд хэдэн нэр дэвшигч (Тухайлбал, Монгол Ардын Намаас нэр дэвшигч Нацагийн Удвал) эцэг эхийнхээ дурсамжийг ашиглан орон нутгийнхны дунд сүлжээ үүсгэх, ахмадуудтай холбогдох гол цэг болгож сурталчилгаандаа ашигладаг.

Сэржээ намын төлөөллийн төв байгууллагын сонгуульд бэлдэж Сүхбаатар дүүргийн намын хорооны гишүүдэд зориулж маш олон сургалт, лекц, семинар, үдэшлэг болон бусад арга хэмжээ санхүүжүүлж, зохион байгууллаа. Тэрээр надад энэ талаараа доорх зүйлсийг ярьсан юм.

Тус албан тушаалд надаас гадна хоёр эмэгтэй өрсөлдөж буй аж. Тэд дүүргийн намын хороонд зориулж ямар нэг үйл ажиллагаа, уулзалт хурал хийж өөрсдийгөө сурталчлахгүй байгаа нь надад хачирхалтай санагдаж байв. Тэд бусад эмэгтэй гишүүдийн адилаар намын эрэгтэй гишүүдээр гишүүнчлэлийнхээ татварыг төлүүлсэн байх гэж би таалаа. Би эрчүүдийн тусламжид найддаггүй, тэднээс хараат бус байхыг хичээдэг. Тэгээд ч би ялна гэдэгтээ итгэлтэй байсан юм.

Намын төлөөллийн төв байгууллагын сонгууль болоход бид өөрсдийгөө танилцуулцаав. Асуулт хариултын үеэр нэг бүсгүй босож ирээд над руу довтолж гарах нь тэр. “Сэржээ, чи тойроггүй юм уу? Чи чинь Сэлэнгийнх биз дээ? Энд юугаа хийж яваа юм? Чиний гэрийн хаяг юу билээ? Утасны дугаар чинь хэд вэ?” Би түүнд унтууцаж, “Би ийм хувийн шинжтэй асуултад хариулахгүй. Хэрэв танд энэ мэдээлэл хэрэгтэй байгаа бол би танд төлөөллийн төв байгууллагын хурлын үеэр бус, хувиараа тусгайлан өгч болно. Манай нам иймэрхүү асуултуудаас татгалзах ёстой гэж би бодож байна” гэж хэллээ. Намайг ингэж хэлмэгц тэрээр байдлыг улам бүр хүндрүүлж, “Хүмүүсээ энийг хараарай, миний асуултад хариулахгүй гэнэ. Чи өөрийгөө хэн гэж бодсон юм?” гэх зэргээр уур амьсгалыг сөрөг болгож эхлэв. Санал хураалт эхлэх үед миний гар утсанд “чи ялагдах нь тодорхой”, “нэрээ тат”, “оройтохоос өмнө нэрээ тат” гэсэн зурвасууд ар араасаа ирэв. Би өөрийнхөө оноог харахыг хүсэж байсан тул нэрээ татсангүй. 90 саналаас би 40-ийг нь авсан юм. Миний хувьд маш өндөр санал байлаа.

Сэржээ эхний шатанд ялагдав. Гэвч хэдхэн сарын дараа Сүхбаатар дүүрэг (эхний шатанд ялагдсан) болон Сэлэнгэ аймагт (өмнө нь нэр дэвшихээр төлөвлөж байснаа татгалзсан) хоёр сул орон тоо гарч ирлээ. Сэлэнгэ аймагт Сэржээтэй өрсөлдөх хүн үгүй, харин Сүхбаатарт өрсөлдөгчид бий. Хүмүүс түүнийг Сүхбаатар дүүрэгт хоёр дахь удаагаа ялагдвал магад гурав дахь бололцоо гарахгүй шүү хэмээн анхааруулж байлаа. Сэржээ хүн ам төвлөрсөн хотын дүүрэг тул нөлөөлөлдөө байлгахад хялбар байж магад гэж бодсон тул Сүхбаатар дүүргийг сонгов.

Энэ удаа Сэржээ Сүхбаатар дүүргээс намын төлөөллийн төв байгууллагад сонгогдохын тулд дүүргийн намын хорооны эмэгтэйчүүдийн байгууллагын дэмжлэгийг авахаар шийджээ. Үүний тулд тэрээр сайн дураараа эмэгтэйчүүдийн байгууллагын үндэсний чуулганыг зохион байгуулав. Бүсийн эмэгтэй манлайлагчдаас өгсүүлээд 10 аймгийн 200 эмэгтэй цугларав. Сэржээ ч төлөвлөж байсны дагуу Сүхбаатар дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн боллоо. Түүнийг тэргүүн болох үед тус байгууллага “байгаа эсэх нь эргэлзээтэй”

байсан тул Сэржээ сэргээж, олон арга хэмжээ зохион байгуулж, олны анхаарлын төвд оруулж чадсан юм.

Гэсэн хэдий ч Сэржээтэй өрсөлдсөн хүмүүс бүгд түүний эсрэг зогсжээ. Түүнтэй өрсөлдсөн зарим хүмүүс түүний удирдлага дор гүйцэтгэх албан тушаал эрхлэх тул ямар нэг арга хэмжээ зохион байгуулах, ямар нэг төсөл амжилттай дуусгахад туйлын хүндрэлтэй байсан талаараа Сэржээ дурсав. Сүхбаатар дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын бүтцийн хувьд Сэржээ тэргүүн нь, түүний дор дэд тэргүүн, гүйцэтгэх хороо, гүйцэтгэх ажилтнууд болон бусад албан хаагч гэсэн шаталсан тогтолцоотой. Сэржээ өөрөө дэд тэргүүнтэйгээ л голдуу харилцах бөгөөд дэд тэргүүн маш их нөлөөтэй болж, байгууллагынхаа де факто эрх мэдлийг хэрэгжүүлж байгааг Сэржээ анзаарав. Дэд тэргүүн нь Сэржээг байгууллагын аливаа ажиллагаанд бараг оролцуулахгүй байлаа. Улс төрчид дүүргийн намын дэргэдэх төрийн бус байгууллагын даргын албан тушаалыг “бэлгэдлийн” төдий гэж үздэг бол, Сэржээ гишүүддээ нөлөөлөх, гүйцэтгэх хороо, бусад ажилчдаа хянах хэрэгтэй гэж үзэж байв.

Сэржээ удирдлагаа гартаа авахын тулд хотын намын хорооны дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагад (нийслэлийн 9 дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын салбарыг хянадаг) хандаж байгууллагадаа, үгүй ядахдаа өөрийнхөө дүүрэг дэх салбарт бүтцийн өөрчлөлт хийх хүсэлт гаргажээ. Мөн тэрээр байгууллагын тэргүүний хувьд гүйцэтгэх хороо, ажилтнуудтайгаа илүү ойр ажиллах хүсэлтэй байгаагаа ч тайлбарлажээ. Тэрээр гүйцэтгэх хороо, дэд тэргүүн, гүйцэтгэх ажилтнуудаа нэг шугамд байрлуулснаар босоо шатлалтай тогтолцоог хөндлөн болгов. Ингэснээр эдгээр гурван бүтэцтэй шууд холбогдох боломжтой боллоо. Бүтцийн өөрчлөлт хийснээр дэд тэргүүн нь түүнийг дэмжих эсэхээс үл хамааран гүйцэтгэх хороо, ажилтнуудтайгаа хамтдаа ажлаа төлөвлөх, тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлох боломжтой болжээ.

Бүтцийн өөрчлөлт хийсний дараа Сэржээ хэд хэдэн ажил эхлүүлээ. 2006 оны 6-р сарын 1-ний өдөр, Эх үрсийн баярыг тохиолдуулж намынхаа эмэгтэйчүүдтэй хамтран эмзэг бүлгийн 2000 айлд бэлэг тарааж, кино театрын өмнөх талбайн хүүхдүүдэд зориулсан нээлттэй концерт зохион байгуулж, үзэгчдэд зориулж 1000 зайрмаг тараажээ. Дараа нь Сэржээ Лэди төвтэй (имиж бүрдүүлэх, амьдралын хэв маягийн чиглэлээр сургалт зохион байгуулж, пи-ар үйлчилгээ, эрүүл мэндийн клуб, бүжгийн студи, моделийн агентлаг, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг төв) хамтран намынхаа эмэгтэй гишүүдэд зориулж имиж бүрдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, өөрийгөө халамжлах чиглэлийн сургалт зохион байгуулав. Сургалтад оролцогчдоооо сэтгэгдэл төрүүлэхийн тулд тансаг зэрэглэлийн хурлын танхим сонгож, хүлээн авалтын чамин хоол захиалж, цай кофены завсарлага дээр хүртэл сайтар анхаарчээ. Сэржээ, “Хэрэв би өдрийн хоолтой хоёр удаагийн кофе завсарлагатай сайхан

арга хэмжээ зохион байгуулбал хүмүүс маш талархалтайгаар оролцоно шүү дээ. Сургалтад оролцогчдын дийлэнх нь ийм тансаг сургалт, лекцэд сууж үзээгүй байж таарна” гэж хэлсэн юм. Сэржээ бүх зардлыг хувиасаа гаргажээ. Хэдхэн сарын дотор тэрээр өөрийнхөө байр суурийг дүүрэгтээ хүлээн зөвшөөрүүлж, намд болон намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагад ч эрх мэдлээ бэхжүүлж чадлаа.

Тиймээс, намын төлөөллийн төв байгууллагын дараагийн сонгуульд Сэржээ дүүрэгтээ ямар нэг томоохон өрсөлдөгчгүйгээр ялалт байгуулав. Энэ үед тэрээр Сүхбаатар дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн, намын төлөөллийн төв байгууллагын гишүүний албыг хашиж байлаа. Эмэгтэйчүүдийн нийгмийн сүлжээ (бусад эмэгтэйчүүдийн өрсөлдөөнөөс үл хамааран), эмэгтэй хүний нийтлэг дүр төрхийг дайчлан улс төрийн намд эрх мэдлээ бэхжүүлэх үйл явц нь эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн өмнө хэрхэн улс төр хийдэг, хүсэл зорилго, бүтцийн хоорондын ээдрээтэй байдлыг шийдэхийн төлөө гаргадаг хүчин чармайлтыг тод харуулдаг. Зарим талаар эмэгтэйчүүдэд суурилсан улс төрийн орон зайд явуулж буй Сэржээгийн тактик нь түүнийг аажим аажмаар эрчүүд зонхилсон сонгуулийн улс төрд шийдэмгий, нөлөө бүхий оролцоход дэмжлэг үзүүлэх хүчний суурийг бэлдэж буй урт хугацааны стратеги юм. Дараагийн хэсэгт, Сэржээ өөрийн байр суурь эрх мэдлээ бэхжүүлж, эмэгтэй дэмжигчдийг өөртөө татсан төдийгүй, ерөнхийдөө эмэгтэйчүүд сонгуулийн улс төрд маш чухал оролцогч болж буй талаар өгүүлнэ. Ингэхийн тулд шинэ нэр дэвшихийг зорьж буй ганц горилогч олон нийтэд улс төрийн нөлөөг бий болгож, субъектив шинж байдлыг хэлбэржүүлж, улс төрийн амьдралыг идэвхжүүлж буй талаар өгүүлнэ.

Том зургаар харах туршлага: Дэмжлэгийн суурь, үнэт зүйлээ бий болгох нь

Нэр дэвшихэд зайлшгүй хоёр чухал албан тушаалаа (Дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн, намын төлөөллийн төв байгууллагын гишүүн) авсны дараа Сэржээ Сүхбаатар дүүргийн намын хорооны дэд дарга боллоо. Бусад дүүргийн намын хорооны дэд дарга нар бүгд эрчүүд байв. Тус албан тушаалын төлөө өрсөлдөж, ялалт байгуулсан анхны эмэгтэй нь Сэржээ байсан юм. Хэрэв нөгөө хоёр албан тушаал нь түүнийг нэр дэвших боломжтой болгосон бол, гурав дахь албан тушаал түүнийг УИХ-ын сонгуульд нэр дэвшихээр горилогчдын тэргүүн эгнээнд байхад тусалсан юм.

Сэржээ элдэв үйл ажиллагаа тасралтгүй зохион байгуулах болсноор Сүхбаатар дүүрэг дэх салбар нь Улаанбаатар хотын намын хорооны дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын албан бус төв болон хувирав. Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн байгууллагын даргын сонгууль ойртох үед бусад дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн

нар Сэржээд тус албан тушаалыг авахыг санал болгожээ. Гэвч Сэржээ эргэлзэв. 2008 оны сонгуульд Сүхбаатар дүүрэгт өрсөлдөхөөр төлөвлөж байсан тул дүүрэгтээ нөлөөгөө хадгалах шаардлагатай байлаа. Эцэст нь Сэржээ Улаанбаатар хотын намын хорооны дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүний суудалд суух нь өөрт ногдсон үүрэг хариуцлага гэж үзсэн тул зориглохоор шийджээ. Ингэхийн тулд тэрээр Сүхбаатар дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүнээс огцрох ёстой. Сэржээ идэвхтэйгээр үйл ажиллагаануудаа үргэлжлүүлж, илүү өргөн хүрээнд, нийслэлийн 9 дүүргийн эмэгтэйчүүдийг өөрийн нөлөөнд авчирч чадлаа. Зохион байгуулсан үйл ажиллагаанаасаа гадна Сэржээ намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын гишүүдийг нэгэн дор, өөрийнхөө манлайлал дор нэгтгэж чадаж байгаадаа бахархаж байлаа.

Сэржээ намынхаа нийт гишүүд дунд танигдаж байлаа. Эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүний хувьд тэрээр гол төлөв ижил хувцас өмсөж, далбаа, шаар барьсан эмэгтэйчүүд дагуулж томоохон арга хэмжээнүүдэд оролцох болов. Ингэснээрээ Сэржээ өөрийгөө хүчирхэг, солилцох, хуваалцах үнэт зүйлтэй улс төрч гэдгийг намдаа улам нотолсоор байв. Ялангуяа, тэрээр сонгуулийн кампанит ажлын ухуулагчаар ажиллах, захиргааны ажилд дайчлагдах, арга хэмжээ зохион байгуулахад ар талд ажиллах маш олон дэмжигчдийг татаж чаджээ.

Сэржээ бусад хүмүүст ч хэрэг болохуйц нөөцийг бий болгож, бэхжүүлжээ. Намын нөхөд нь түүнээс Эмэгтэйчүүдийн байгууллагатай холбоотой тусламж асуудаг болов. Тухайлбал, 2000-аад оны дунд үед нэг тойрогт болсон нөхөн сонгуулийн үеэр намынх нь нэр дэвшигч Сэржээгээс тусламж хүслээ. “Тэд надаас тусламж хүсэж, «Сэржээ, сурталчилгаанд ажиллах 15 эмэгтэй гаргаж өгөөч» гэдэг байлаа. Эсвэл энэ ч арга хэмжээ, тэр ч арга хэмжээг зохион байгуулах бүсгүйчүүдээ явуулж туслаач” гэх болсон талаар ярих. Намынх нь гол сул талуудын нэг нь сонгогчдын нэрийн жагсаалтыг сайн бүрдүүлдэггүйг мэдэж байсан юм. Учир нь анхан шатны нэгжийн удирдлагууд нь эсрэг намын гарт байлаа. Сэржээгийн намд иргэний бүртгэлийн мэдээллийг шууд авах боломжгүй боловч сонгогчдын нэрийн жагсаалтыг жинхэнэ оршин суугчидтай тулгах шаардлагатай байж. Сэржээгээс тусламж хүсэхэд тэрээр хэдэн зуун эмэгтэйгээр хүмүүсийн мэдээллийн санг шүүлгэхээр илгээжээ. Тэдгээр эмэгтэйчүүд сонгогчдын нэрийн жагсаалтыг шалгаж үзэхэд тус жагсаалтад нас барсан, эзгүй сонгогчид болон зарим хүмүүсийг 2-3 хаяг дээр бүртгэсэн гэх мэт сонгуулийн луйвар гарч болзошгүй зөрчлийг илрүүлсэн байна. Эдгээр зөрчлүүдийг арилгаснаар Сэржээгийн илгээсэн бүсгүйчүүд намынхаа нэр дэвшигчид тус сонгуульд ялахад нь томоохон хувь нэмэр оруулсан нь мэдээж. Сэржээ ч эмэгтэйчүүдээ сургасандаа, тэдгээр эмэгтэйчүүд сонгуулийн кампанит ажилд чухал үүрэгтэй оролцож буйд сэтгэл хангалуун байсан

төдийгүй намдаа ч чухал хүн болжээ. “Эцэст нь эрэгтэй удирдагчид надаас тусламж хүсдэг болсон. Эцэст нь нэг юм тэдэнд хэрэгтэй үнэт зүйлсийг эзэмших болсон юм. Хүмүүст туслах боломжтой байх чинь сайхан шүү дээ”.

Хамгийн чухал нь, Сэржээ кампанит ажилдаа хэрэгцээтэй үндэс суурийг бэхжүүлэх гэсэн анхны зорилгодоо хүрсэн явдал юм. Сэржээ, “Би дүүрэг бүрд 100, нийт 900 эмэгтэйг бэлдэхээр төлөвлөж байлаа. Тэдгээр эмэгтэйчүүдэд ижил хувцас өмсгөж, Сүхбаатар дүүрэгт эмэгтэйчүүдийг дэмжсэн чимээгүй жагсаал зохион байгуулахаар төлөвлөсөн” гэв. Эдгээр эмэгтэйчүүд цэвэр засгийн газар хэрэгтэй байна гэх Сэржээгийн сурталчилгааны мессеж бүхий материалыг тараана. Мөн олон нийтийн гудамж талбайд зөрөх хүмүүсээс цэвэр засгийн газар гэх санааг дэмжиж буй эсэхийг асууж, хэрэв дэмжиж байвал Сэржээг болон түүний улс төрийн мессежийг дэмжиж буйн илэрхийлэл болгож ороолт зүүхийг гуйна. “Үүний зорилго нь Сүхбаатар дүүрэгт миний нэр дэвшихийг бүхэлдээ дэмжиж буй гэсэн мессежийг тараах байлаа” хэмээн Сэржээ ярих. Сэржээ сонгуулийн өмнө, хэрхэн сонгуулийн сурталчилгаагаар албан ёсоор эхлүүлэх талаар төсөөлж байсан олон хувилбарын нэг нь энэ байлаа. Өөрөөр хэлбэл, Сэржээ сонгуульд бэлдэхдээ гудамж талбайд гарах, олон нийтэд харагдахуйц, чихэнд сонсогдохуйц хамгийн гол нь олон нийтийг оролцуулж, дэмжлэгийг нь татах гэх мэт хүрээлэн буй орчныг ашиглан сурталчилгаа явуулахаар төлөвлөжээ. Түүний хүчин чармайлт нь эмэгтэйчүүдийг дайчлах, эмэгтэйчүүдийн нэгдлийг өргөжүүлж сонгуулийн үйл явцад татан оролцуулах гэх мэт эмэгтэйчүүдийг зөвхөн санал хураах үйл явцаар хязгаарлахгүй идэвхтэй оролцогч болгоход чиглэж байв.

Стратеги, тактикийн ялгааг тодорхойлсон Де Сертогийн (1984) өнцгөөс үзвэл Сэржээгийн үйлдлүүдийг үнсэндээ стратеги гэж үзэж болно. Сертогийнхоор, Сэржээ “өөрийн” газар нутагт хэрхэн тоглохоо мэддэг төдийгүй тооцоолох, төлөвлөх, урьдчилан харах чадвартай байсан. Өөрийн газар нутагтай байна гэдэг нь өөрийн ололт амжилтаа бататгах боломжтой байна гэсэн үг. Сэржээ алхам алхмаар Сүхбаатар дүүргийн намын хорооны дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүний суудлыг авсан, өөрийнхөө дэмжлэгийг үлэмж нэмэгдүүлсэн зэрэг нь яг л сурах бичигт дурдсан стратегийг санагдуулам (Сертогийн бичсэн). (Нэр дэвшигчийн хүйсийн квотыг 30 хувиар батлуулахад түүний оруулсан хувь нэмэр, хэдийгээр хожим нь УИХ хүчингүй болгосон ч гэлээ эмэгтэйчүүдийн улс төрд оролцох замыг засаж, урам зоригийг сэргээсэн нь ч мөн “стратегийн” нэг хэлбэр гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.) Сонгуулийн албан ёсны сурталчилгаанд бэлдэхэд цаг хугацаа, эрч хүч, нөөцөө итгэлтэй зарцуулж болох өөрийн гэсэн байрлалтай (сонгуулийн тойрог) байна гэдэг нь хүйсээс үл хамааран сонгуульд нэр дэвшихээр горилж буй хэн бүхний хамгийн чухал зорилго билээ. Шинээр нэр дэвшигчдэд ч, улиран сонгогдохоор зэхэж буй хүмүүст ч ялгаагүй. Де сертогийн стратеги, тактикийн тодорхойлолт

нь хэт зааварчилсан шинжтэй байж болох ч, эмэгтэй нэр дэвшигчдийн үйл ажиллагаа хэрхэн уян хатан, бүтээлч, шуурхай зохион байгуулалтад ордгийг ойлгоход тусалдаг. Нэмж хэлэхэд, өөрийн орон зай нь ирээдүйд хийх алхмуудаа том зургаар нь урьдчилан харах, төлөвлөхөд тусалдаг талаар де Серто тэмдэглэжээ. Түүнээс гадна ололт амжилт, нөөцийг хуримтлуулахад ч эерэг нөлөөтэй. Сэржээгийн жишээг авч үзэхэд, тэрээр нэр дэвших тойрогтой болмогцоо намын эмэгтэйчүүдийн байгууллагын даргын хувиар өөрийг нь дэмжих сонгогчдын суурийг бүрдүүлж, маш олон тооны эмэгтэйгээр өргөжүүлэх боломжтойг олж харжээ. Эдгээр нь бүтцийн стратегийн хэлбэрүүд байсан бөгөөд нөлөөлөхүйц стратегитай амжилттай хослуулсны тод илэрхийлэл билээ. Гэсэн хэдий ч Сэржээгийн бүх зүйл орвонгоороо эргэсэн юм.

Тактикаа өөрчлөх нь: Дотоод өрсөлдөөн, уналт

Намын дотоод өрсөлдөөнөөс болоод тойргийн хуваарилалт эцсийн мөч хүртэл албаждаггүй. Тиймээс аливаа нэр дэвшихээр горилогч урьдчилсан кампанит ажилд хэчнээн их цаг, хүч зарцуулсан ч гэлээ намдаа маш нөлөө бүхий, бусдаас илүү нөөцтэй хүн намын удирдлага, тойргийн сонгогчдыг өөртөө татах замаар тойргийг нь булаах аюул үргэлж байдаг. Энэ тохиолдолд горилогчийн зарцуулсан мөнгө, хүчин чармайлт, цаг хугацаа бүгд салхинд хийсэн замхарна.

2007 оны зун нэгэн шинэ эмэгтэй гишүүн намын төлөөллийн төв байгууллагад сонгогдон гарч ирэв. Тэрээр сонгуульд өрсөлдөхөөр төлөвлөж буй эсэхийг Сэржээ мэдэхийг хичээж, тэр бүү хэл намын даргаасаа шууд тулгаж асууж ч байлаа. Хүн бүхэн, шинэ эмэгтэй хүртэл өөрөө сонгуульд өрсөлдөхгүй гэгцгээж байв. Үнэн хэрэгтээ тэр бүсгүй сонгуульд өрсөлдөх санаатайг, тэр тусмаа Сэржээгийн тойрогт буюу Сүхбаатар дүүрэгт өрсөлдөхөөр зэхэж буйг мэдэх хүртлээ Сэржээ намаа дэмжсээр ирэв. Тэр эмэгтэй хувийн бизнестэй төдийгүй эрэгтэй бизнес эрхлэгчидтэй нөөцөөрөө өрсөлдөх боломжтой улс төрд буй цөөхөн эмэгтэйн нэг байж. Сэржээ өөрөө надад санхүүгийн нөөцийн хувьд түүнтэй өрсөлдөх боломжгүй талаараа дараах байдлаар дурдан өгүүлэв:

Миний тойрогт нэр дэвшихээр зэхэж буйг мэдмэгцээ би түүнийг дэмжихээ больсон. Эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүний хувьд би хурал, цуглааны үеэр түүнтэй таарахдаа харилцахаа болимогц, эмэгтэйчүүд ч (эмэгтэйчүүдийн байгууллагын) түүнийг үл ойшоож буйгаа нуугаагүй. Ингэж авирлах нь надад ч эвгүй байсан, тэр ч тэвчээр, хатуужилтай байлаа. Тэрээр их мөнгөнийхөө хүчээр намын эрэгтэй удирдлагыг бүгдийг нь өөрийнхөө талд эргүүлэх ч чадалтай. Гэсэн хэдий ч намын удирдлагууд дүүргээс нэр дэвшигчийг тодруулах хурлаар цэвэр санал хуваавал би ялж, тэр ялагдахыг ч гадарлаж байсан. Тийм ч учраас намын удирдлагууд, ялангуяа Сүхбаатар дүүргийн намын хорооны удирдлага надад Сүхбаатар дүүргийг орхиод өөр тойрог олж авахыг шаардсан юм.

Надад үнэхээр шударга бус санагдаж байсан тул би мэдээж эсэргүүцэв. Гэвч дараа нь би хурлаар санал хураалтад ялж, нэр дэвшихээр болсон ч гэлээ намын удирдлагууд Сүхбаатар дүүрэгт намайг дэмжихгүй гэдгийг ойлгосон юм. Ингээд би сонгууль болохоос гуравхан сарын өмнө өөр тойрог олох ёстой болох нь тэр.

Энэ зуур, Сэржээгийн хувийн амьдралд тохиолдсон эмгэнэлт, гэнэтийн үйл явдал улс төрийн орчинд ч таагүй зүйлтэй давхцаж буй нь тохиолдол гэлтэй. 2007 оны 1-р сард тэрээр намынхаа 15 эмэгтэйг АНУ-д манлайллын сургалтад хамруулахаар дагуулж явсан билээ. Сургалтын тав дахь өдөр Сэржээ нөхөр нь зуурдаар нас барсан талаар цочирдом мэдээг Монголоос авлаа. Сэржээ тэр дороо сургалтыг орхиж Монгол руу буцав. Хоёрдугаар сард уй гашуудалд автсан Сэржээ сонгуулийн кампанит ажил болон бусад ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байжээ. Намаас тойрогт нэр дэвшигчдийг сонгох ажиллагаа 3-р сард болох байсан бөгөөд Сэржээ нам доторх дэмжлэгээ бэхжүүлэхэд шаардлагатай үнэт цагаа алдсан юм. Тэрээр Улаанбаатар хотын намын эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн болохын тулд дүүргийн намын эмэгтэйчүүдийн байгууллагын даргын ажлаа өгсөндөө ч харамсаж байлаа. Сэржээгийн бодсоноор, тэрээр дүүргийн намын эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүн хэвээр байсан бол шинээр ирсэн хэн ч түүний тойргийг булааж зүрхлэхгүй байсан байж болох. Энэ зуур шинэ өрсөлдөгч намын удирдлагад илүү нөлөөтэй болжээ. Сэржээ “үнэхээр муухай байлаа” гэж “Нөхрөө алдсанаас хойш намын удирдлага намайг нэр дэвшиж чадах эсэхэд эргэлзэж эхэлсэн. Тэд намайг надаас илүү их мөнгөтэй өөр өрсөлдөгчтэй харьцуулах болсон” гэж Сэржээ ярьсан юм. Түүнчлэн, намын удирдлагууд хоёр эмэгтэй нэг намаас, нэг тойрогт өрсөлдөх нь зохимжгүй гэж үзэх болжээ. Тойргоо соль гэх дарамт зогсоо зайгүй ирэх болов. Нэлээд ширүүн ярилцсаны эцэст тэрээр Хэнтий аймгийг сонгожээ.⁴

Өөр нэгний нутаг дэвсгэрт: Кампанит ажил засаглах нь

Сонгосон тойрогтоо [Сүхбаатар дүүрэгт] жил гаруй хугацаанд ажиллаж, өөрийнхөө кампанит ажлын суурь, зохион байгуулалтын бүтэц, сонгогчдын дэмжлэг зэргийг бэхжүүлсний эцэст Сэржээ өөр нэгний нутаг дэвсгэрт өрсөлдөх болж таарав. Хэнтий аймагт буюу өөр хэн нэгний нутагт ажиллаж байгаа тул төлөвлөсөн стратегиасаа татгалзаж тактикийн хэмжээнд, бусдын дүрмээр ажиллахаас өөр аргагүй болжээ.

Тэрээр Хэнтий аймгийн намын хорооны гишүүдийг болон эмэгтэйчүүдийн байгууллагынхныг ч сайн таньж мэдэхгүй билээ. Аймгийн намын хороо сонгуулийн кампанит ажлын штабаа байгуулсан

⁴ Өмнө дурдсанчлан, газрын нэрийг мөн зориуд өөрчлөв.

хэдий ч Сэржээ өөр төлөвлөгөөтэй байлаа. Өөрийгөө сурталчлах зарим саналыг штаб нь дэмжсэнгүй. “Би аймгийн намын хорооны хүмүүсийг сайн танихгүй болоод ч тэр үү, өөрийнхөө төлөвлөгөөний талаар ярилцах болгонд тэд сайн дэмжиж өгөхгүй байсан” гэж Сэржээ хэлсэн юм.

Тус тойрог гурван суудалтай бөгөөд Сэржээгийн намын хороо Сэржээ, болон Самдан гэгч дахин сонгогдохоор өрсөлдөж буй эрэгтэй УИХ-ын гишүүн гэсэн хоёр нэр дэвшигчийг сонгожээ. Өөр өөрсдийн хувийн санхүүжилтээс гадна, өмнө нь сонгогдсон гишүүд төрийн санхүүжилтийг хувийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хуваарилах албан бус эрх мэдэлтэй. УИХ-ын гишүүн Самдангийн сонгуулийн сурталчилгааны зардлыг нарийн мөшгөх боломжгүй ч, сонгогчидтой хийх уулзалт тэр чигтээ сонгогчдынх нь хувь хүний эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байлаа. Аймгийн намын хорооны сонгуулийн штаб Самдангийн, болон Сэржээгийн сонгогчидтой хийх уулзалтуудыг зохион байгуулсан билээ. Сэржээ уулзалтын үеэр УИХ-ын гишүүнээр сонгогдвол хэрхэн ажиллах төлөвлөгөө, алсын хараагаа тайлбарлаж байсан бол, Самдан тэс өөр аргаар ажиллаж байв.

Бид сонгогчидтой уулзах өглөөний нэгэн уулзалтад хүрч очвол Самдан яг л тусламжийн байгууллагын адил хувь хүмүүсийн асуудлыг шийдэж өгч буйтай таарлаа. Өглөөний уулзалтад (8:00-11:00) зориулж гадаа талбайд оффисын ширээ сандлууд байрлуулсан байх бөгөөд туслахуудын хамт зэрэгцэн суужээ. Сонгогч нь хүрч ирээд түүнд асуудлаа танилцуулбал, тэрээр гол төлөв нэг туслахдаа даатган тус иргэнд өргөдөл, хүсэлт бичихэд нь тусална. Хэдийнээ өргөдөл гаргасан сонгогчид ч ирэх бөгөөд Самдан заримдаа яагаад тусалж чадаагүйгээ тайлбарлахаас гадна хаанаас тусламж олох талаар зөвлөнө. Уулзалт үндсэндээ сонгогчдын өргөдөл, хүсэлтүүдийг цуглуулж авахад л зориулагдсан гэлтэй. Дараа нь 16:00 – 19:00 цагийн хооронд тэрээр өргөдөл, хүсэлт гаргасан хүмүүст хариу өгөх бөгөөд асуудлыг нь шийдвэрлэнэ. Маш олон сонгогч гэр авах, хүүхдийн сургалтын төлбөр, эм тарианы мөнгө олгохыг хүсжээ. Сэржээ хажууд нь цөөн хүмүүст алсын хараагаа танилцуулж байх хооронд ихэнх сонгогчид Самдангийн эргэн тойронд шавж байлаа.

Хожим Сэржээ Самдантай хамт эхний зарим уулзалт хийсэн нь сонгогчдод түүнийг ч мөн адил хувийн асуудлыг нь шийдэх ёстой нэгэн гэсэн хүлээлт үүсгэсэн талаар ярьсан юм. Сонгуулийн сурталчилгааны ихэнх цагийг Самдан сонгогчидтой ганцаарчлан уулзахад зарцуулж байсан тул намаас зохион байгуулж буй сонгогчидтой хийх уулзалтуудад Сэржээд хангалттай хугацаа үлдэхгүй байв.

Сонгогчдын хувийн асуудлыг шийдвэрлэж буй Самданы сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны хэв маягийг харж, мөн хожим нь Сэржээгээс энэ талаар сонссон би Сэржээгийн гар утсанд яагаад

хувийнхаа асуудлыг шийдвэрлүүлэхийг хүссэн тэр олон зурвас сонгогчдоос ирж байсныг ойлгосон. Нэгэн удаа өдрийн хоол идэх үеэр Сэржээ өөртөө ирсэн гар утасны зарим зурвасуудыг харуулав. Заримыг нь уншиж үзвэл тэдгээр бүх зурвас ижил хэв маяг, ижил бүтэцтэй аж. Тулгарсан асуудлынхаа шалтгааныг дурдаж (тухайлбал, гэр бүлийн гишүүн нь удаан хугацаанд хүндээр өвдөөд байна, гэр нь шатсан, эсвэл үерт автсан, эсвэл хэн нэгэнд ажил, сургалтын төлбөр хэрэгтэй байна гэх мэт) эхлэх бөгөөд дараа нь тодорхой мөнгөн дүн, бусад тусламж хүссэн байна. Самданы кампанит ажилд оролцохоосоо өмнө Сэржээд ирсэн эдгээр зурвасыг үзсэн болохоор би сонгогчид яагаад нэр дэвшигчид рүү мөнгө хүсэж зурвас илгээдэг байна хэмээн гайхаж байлаа. Ялангуяа миний бодлоор огт танихгүй хүнээс хувийн чанартай тусламж байдаг л зүйл мэт хандаж хүсэж байгаа нь хачирхалтай санагдаж байв. Сэржээд асуудлыг нь шийдье гэхээр түүнд нөөц ч байсангүй, нэр дэвшигчийн хувиар нөөц тараах нь зарчимд нь ч нийцсэнгүй тул эдгээр зурвасууд Сэржээд бараг л дарамт учруулж байсан юм.

Харин Самданы кампанит ажлыг ажигласны дараагаар Сэржээд яагаад тэдгээр зурвас ирээд буйг ойлгов. Өргөдөл илгээж буй сонгогчид Сэржээг дарамтлах гэсэнгүй. Энгийнээр тэд ердөө л Сэржээг Самдантай л адил төсөөлсөн хэрэг. Эсрэгээрээ, Самдан бараг л дийлэнх УИХ-ын гишүүдийн адил тойргийнхоо сонгогчид, оршин суугчдын эрэлт хэрэгцээг мэддэг тул, сонгуулийн кампанит ажлынхаа хүрээнд тэдний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ. Монгол даяар энэ нь нийтлэг үзэгдэл бөгөөд сонгогчдын дийлэнх нь ядуу, төрийн үйлчилгээ хязгаарлагдмал. Зарим талаар, сонгууль нь төрийн халамжийн болон гамшгийн үеийн тусламжийн байгууллагын үүргийг гүйцэтгэж байлаа.

Нэр дэвшигчдээ хандан тавих сонгогчдын хүсэлт нь хүндрэлээ давах гэсэх арга төдийгүй, заримдаа төрийн үйлчилгээг авч болох цор ганц зам байх нь олон. Төрийн үүрэг гүйцэтгэх нь нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны арга хэрэгсэл болон хувирчээ. Судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хувийн байгууллагын нэгэн социологич, “Монголчууд ядуу биш, харин Монголчуудыг ядуу байлгаад байгаа юм” гэж хэлсэн. Тэрээр ингэж хэлэхдээ ард түмнийг ядуу байлгаж, зарим хэрэгцээг нь шийдэж сонгуулийн санал авах нь улс төрчдөд ашигтай байдаг гэсэн санааг агуулжээ. Харин улс төрчдөд ядуурал ч, өөрсдөөс нь тусламж хүсэх нь ч сонгогчид хараат бусаар сонголт хийх боломжийг хаахад чиглэнэ. Тиймээс, улс төрчид сонгогчдын саналыг авахын тулд ямар тусламж хүргэж болох талаар толгойгоо үргэлж ажиллуулна. Улсын төсвийн эрх мэдэлгүй шинэ нэр дэвшигч УИХ-ын сонгуульд өрсөлдөнө гэдэг нь сонгогчдын хэрэгцээг хувийнхаа нөөцөөр шийдвэрлэх болдог гэсэн үг.

Сэржээ анх удаа нэр дэвшиж байгаа тул, түүнд улсын төсвийн эрх мэдэл байхгүй төдийгүй, хэдийнээ сонгогчдоод дахин сонгогдохоор

өрсөлдөж буй хүмүүстэй өрсөлдөх хангалттай хувийн нөөц ч байсангүй. Сэржээ сонгогчидтой хийх уулзалтыг өөр тийш нь эргүүлж буйг, мөн сонгогчидтой хийх уулзалтын үеэр өөрсдийнхөө хөтөлбөр, амлалтыг танилцуулж, улс орны хөгжлийн төлөө том зургаараа хэрхэн ажиллах талаар сонгогчдодоо ярьж өгсөнгүй хэмээн Самданг шүүмжлэв. Сэржээ анх удаа өрсөлдөж буй тул Самданы адил сонгогчдынхоо асуудлыг шийдвэрлэх боломжгүйгээ ч тайлбарлажээ. Хариуд нь Самдан сонгогчидтой хийх албан ёсны уулзалтаа сонгодог агуулгаар нь зохион байгуулах талаар амлав. Ингээд анхны уулзалтын үеэр Самдан тайзан дээр гарч 20 гаруй минут ярьсны дараа Сэржээд асуулт, хариулт эхлэхээс өмнө 10 хүрэхгүй минут л ярих боломж олдсон юм.

Уулзалтын дараа Сэржээ бачуурч, шинэ нэр дэвшигч тул уулзалтын үеэр өөрт ноогдсон цагаа бүрэн ашиглаж өөрийгөө танилцуулах шаардлага буйгаа Самданд тайлбарлалаа. Самдан ч ичих шиг болж, уучлал гуйнгаа, “Чиний зөв, уулзалтын үеэр чи түлхүү ярь, би зүгээр зогсож байя. Чиний түмэн зөв, чамд илүү их цаг хэрэгтэй” гэлээ. Тэрээр Сэржээд урт хар ноосон хүрэм, цайвар ороолт чинь хэтэрхий ганган байна, арай аятайхан юм өмсвөл яасан юм хэмээн зөвлөжээ. Сэржээ хэдийгээр толгой дохисон ч, ямар ч эргэлзээгүйгээр өөрийнхөөрөө хувцаслан уулзалтуудаа үргэлжлүүлэв.

Сонгуулийн сурталчилгаа үргэлжлэх тусам, Сэржээ өөрийнхөө дүр төрхийг онцлохын зэрэгцээ, эсрэг намын нэр дэвшигчдийн сөрөг талыг илчлэх тактик ашиглаж байлаа. Тухайлбал, тэрээр өрсөлдөгч намын нэр дэвшигчдийг шүүмжилсэн телевизийн нэвтрүүлэг цацлаа. Ингэмэгц, хамтран нэр дэвшигч, намын өрсөлдөгч Самдан утасдаж, тус нэвтрүүлгийг зогсоохыг хүсэв. Самданы тайлбарлаж буйгаар өрсөлдөгч нам нь энэ төрлийн “хар” пи-арт өөрийг нь буруутгахгүй зөвхөн Самданг чиглэсэн сөрөг довтолгоонууд ирнэ, учир нь Сэржээ “цэвэр” гэжээ. Сэржээ ч санал хэрхэн өгөх, илүү нарийнаар дэмжиж буй нэр дэвшигчээ саналын хуудсанд хэрхэн дугуйлах гэх мэт сонгогчдын боловсролд чиглэсэн богино шторкуудыг бэлтгэн цацжээ. Тус сурталчилгаанд Сэржээгийн намыг дэмжиж буй нэгэн сонгогч гарах бөгөөд түүний дэргэд тайлбарлагч, “Саналаа өгөх маш амархан. Сэржээ, Самдан гэсэн хоёр С-ийн нэрийг дугуйлаарай, ингэснээр таны бүх хүсэл биелэх болно” хэмээн ярина. Дараа нь сурталчилгаа хоёр нэр дэвшигчийг танилцуулна. “Үнэхээр сайн болсон сурталчилгаа шүү” хэмээн Сэржээ хожим нь ярьж билээ. Тэрээр цааш нь, “Гэвч сурталчилгаа цацагдаж эхэлмэгц Самдан залгаад энийгээ одоохон зогсоо гэсэн. Яагаад гэвэл тэрээр, сонгогчдыг хэтэрхий шахсан, шаардсан маягтай байна гэжээ. Тиймээс би энэ сурталчилгааг ахин цацаагүй” гэж ярьсан юм.

Сонгогчдын боловсролын талаарх сонгуулийн зарчим, зохицуулалтын хүрээнд улс төрийн намууд сонгогчдод хэрхэн санал өгөхийг, ялангуяа Сэржээгийн сурталчилгааны тайлбарлагчийн

адил сонгогчдыг хэнд санал өгөхийг зааварласан сурталчилгаа хийж болохгүй. Сурталчилгаа нь хуульд нийцэхгүй байна гэсэн Самданы зөв байсан юм. Гэвч, энэ асуудлаар давхар стандарт мөрдөгдөж байсан гэж болох. Самдан тойрогтоо зориулсан нөөцийг ашиглан сурталчилгаагаа хийж “асуудлыг шийдэгч”, зуучлагч мэт аяглаж байлаа. Харин Сэржээ сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд өөрийнхөө сонгогдох өчүүхэн магадлалыг нэмэгдүүлж болохгүй. Өөр жишээ дурдахад төрийн нөөцийг буяны ажил мэт ашиглаж буй Самданы сурталчилгаа тойрогтоо хийж буй ажилд тооцогдоно. Сэтгүүлчид, ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүлчид Самданы санаархлыг илчлэвч Самданы үйл ажиллагаа нь хүмүүнлэгийн шинжтэй, түүний тойргийн хамгийн ядуу, орхигдсон сонгогчдынхны талархлыг хүлээдэг тул буруутгах боломжгүй мэт.

Самдан ялах магадлал өндөр тул түүний (болон түүний зөвлөхүүдийн) үзэж буйгаар Сэржээгийн сурталчилгаа, сонгогчдын боловсролын хөтөлбөрүүд нь сонгуулийн сурталчилгаанд тохиромжгүй аж. Сэржээгийн үйл ажиллагаа нэг бол Самданы нэр хүндэд сөрөг нөлөөлнө, эсвэл байр суурийг нь ганхуулах гэнэ. Бага түвшний, шинээр өрсөлдөж буй, ялангуяа хөрөнгө, мөнгөний нөөц багатай эмэгтэй нэр дэвшигч тул Сэржээ Самданы нөлөө, тусламжтайгаар түүний оронд биш, түүнийг дагаж сонгогдохыг хичээнэ. Энэ бол хэн нэгний ил тод хэлсэн үг биш бөгөөд аль аль нэр дэвшигчид зөвлөж байсан, энэ өрсөлдөөнд хэн нь ялах талаар санаа бодлоо хуваалцаж байсан зөвлөхүүдтэй ярилцах зуураа миний анзаарсан дүгнэлт юм.

Түүнээс гадна, сонгууль бол улс төрийн нам доторх хувь хүмүүсийн хоорондын өрсөлдөөн төдий зүйл биш билээ. Сонгууль нь мөн намын харьяаллаас үл хамааран улиран сонгогдох гэж буй нэр дэвшигчид болон шинээр өрсөлдөж буй хүмүүсийн эсрэг хийж буй өрсөлдөөн аж. Хэд хэдэн улс төрчдөд зөвлөдөг нэгэн зөвлөх, 2008 оны сонгуулиар УИХ-ын гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ сонгогдохын төлөө ихэд хичээсэн гэж ярьж билээ. Өөрөөр хэлбэл, дахин сонгогдохоор өрсөлдөж буй гишүүд, өрөөлийн намын дахин сонгогдохыг хүсэж буй нэр дэвшигчийг өөрийнхөө намын шинээр сонгогдохыг эрмэлзэж буй нэр дэвшигчээс илүүд үзэж байсан гэсэн үг. Учир нь эрх баригч гол намууд ашиг сонирхлоороо нэгдэж, илүү тохироонд хүрэхийн тулд яриа хийж байснаас болсон байх. Иймэрхүү улс төрийн үйл явдал Монгол Улсын засгийн газар, гадаадын компаниуд хоорондоо уул уурхайн томоохон хэлэлцээ өрнүүлж байсантай холбогдоно. 2006 оноос хойш уул уурхайг тойрсон олон нийтийн яриа хэлэлцүүлгийг үзвэл итгэл найдвар агуулсан, эерэг хандлагатай байснаас илүү шүүмжилсэн, болгоомжилсон болж өөрчлөгджээ. Эдгээр болгоомжлол нь олон нийт усны, бэлчээрийн, хөрсний бохирдлыг эсэргүүцэх хандлага, Канад/Америкийн уул уурхайн санхүүжүүлэгч Роберт Фридланд олон улсад Монгол бол бага татвартай, зохицуулалт султай, баялгийн нөөцөөс ашиг олж болохуйц

орон гэж ярьсан болон албан тушаалтай улс төрчид нь байнга л авлигад холбогдож байдаг зэргээс болжээ.⁵ Тиймээс, улс төрийн төрөл бүрийн мэдээлэлтэй хүмүүстэй ярилцсанаас дүгнэвэл намууд олон улсын томоохон уул уурхайн компаниудтай хийхээр төлөвлөж байсан яриа хэлэлцээнд нөлөөлж болзошгүй тул УИХ-д шинэ хүмүүс орж ирэхээс болгоомжилж байсан аж.

Өөр нэгэн эмэгтэй нэр дэвшигч, Цэдэвдамбын Оюунгэрэл (Удиртгал ба 5-р бүлэг үзнэ үү) өөрийн туршлагад үндэслэн эмэгтэйчүүд УИХ-ын суудлын төлөөх нам харгалзахгүй эрчүүд хоорондын тохиролцооны хэрэгсэл болдог гэдэгт баг итгэлтэй байлаа. Сэржээгийн тохиолдлыг оролцуулаад, ихэнх тохиолдолд иймэрхүү зүйлийг нотлох бараг л боломжгүй боловч эмэгтэйчүүд улс төрд, ялангуяа чухал шийдвэр гаргах үйл явцын гадуур үлддэг нь илэрхий. Телевизээр цацагдах УИХ-ын чуулганы үеэр эмэгтэйчүүд гадуурхагдаж буй нь харагдахгүй харин ч эмэгтэй улс төрчид маш чадвартай, мэргэжлийн байдалтай ярьж хэлж буй нь л олон нийтэд дамжуулагддаг. Гол асуудал нь хамгийн чухал шийдвэр, яриа хэлэлцээг УИХ-ын чуулганы танхимд биш, харин саун, биллиардын өрөө, ан хийх аялал, салхинд гарах, болон Сэржээ оролцох шаардлагатай байсан шөнийн архи, дарстай уулзалтуудын үеэр хийнэ. Сэржээ мэтийн эмэгтэй улс төрчид сонгогчдоос хангалттай санал авч, өөрсдийгөө улс төрд бий болгож, энэ төрлийн улс төрийн соёлыг өөрчилж чадна гэж найдаж байсан юм.

Эцэст нь сонгуулийн дүн гарахад тус тойрогт гурван суудлын төлөө дэвшсэн 11 хүнээс Сэржээ 10 гаруй мянган саналаар дөрөвдүгээр байранд оржээ. Тэрээр энэ талаар надад дараах байдлаар халагласан юм.

Хэрэв би өөрийнхөө хүссэнээр ажилласан бол илүү олон санал авч, гишүүнээр сонгогдох байлаа. Албан ёсны сонгуулийн сурталчилгааны сүүлийн долоо хоногт л надад сонгогчидтойгоо уулзах завшаан тохиолдсон юм. Гол нь би өөрийнхөө зөв гэж бодсоноор ажиллах боломжгүй байсанд л их харамсдаг. Өөрийнхөө нөөц, сонгуульд зориулан бэлтгэсэн материал зэргээ ашиглаж чадаагүй, олон нийтийн өмнө Самдантай ч муудалцахыг хүссэнгүй. Хэрвээ би хангалттай олон эмэгтэйтэй, нэн ядуу болон эмзэг бүлгийн хүмүүстэй өөрөө биечлэн уулзаж чадсан сан бол хангалттай санал цуглуулж чадах байсан. Харин оронд нь би Самданыг дагаж уулзалтууд хийж явсан минь намайг Самдантай эн тэнцүү биш, түүний дагуул мэт харагдуулсан байх. Өрсөлдөгч намын сонгуулийн менежер надаас “Чи Самданы дүр төрхийг л илүү тодруулах санаатай менежльд оролцож байгаа юм уу” гэж хүртэл асуусан удаа бий. Би ч хариуд нь үгүй, би өөр зорилготой гэвэл өнөөх менежер, “Гэвч чи Самданыг сонгогдоход нь л тусалж яваа хүн мэт харагдаж байна. Чи ганцаараа уулзалт хийвэл илүү хүчтэй харагдаж, илүү олон шүтэн бишрэгчидтэй болох чадалтай шүү дээ. . . Гэвч Самдантай хамт уулзалт хийвэл чи аравхан минут яриад, үлдсэн хугацаанд Самдан ярих гэх мэтээр чи түүнд дэмжигчдийг нь л бэлдэж өгч буй мэт ажиглагдлаа” гэв. Тэрээр үргэлжлүүлэн, “Хэрэв чи

⁵ Уул уурхайтай холбоотой яриа хэлэлцүүлгүүдийг Бонилла 2017-оос дэлгэрүүлж үзнэ үү.

сонгогчидтойгоо өөрөө ганцаараа уулзаад явбал манай намын хамгийн том өрсөлдөгч болох бөгөөд, бид ч маш их болгоомжилно. Бид чиний нэр хүндийг унагахаар чам руу довтолж чадахгүй. Учир нь чи маш “цэвэр” бөгөөд чамайг шүүмжлэх юу ч алга. Чи өөрөө алдаа гаргаж байна, чи ердөө л Самдан ялахад тусалж байна шүү дээ” гэсэн юм.

Дүгнэлт: Сонгуульжилтын хүч

Сэржээгийн түүх бидэнд Монголын сонгуульжилтын талаар юуг хэлэв? Нэгдүгээрт, сонгууль албан ёсны 21 хоногийн сурталчилгаанаас хамаагүй өмнө, болон дууссаны дараа ч үргэлжилж байдгийг харуулж байна. Нэр дэвшихийг гориллогчид сонгуулиас дор хаяж 2 жилийн өмнө албан болон албан бусаар кампанит ажлаа эхлүүлдэг. Намын дотоод сонгууль, уулзалтууд, ложистикийн өөрчлөлтүүд, дотоод өрсөлдөөн, сургалт семинар зэрэг нь албан ёсны бэлтгэл ажилд тооцогдоно. Нэр дэвшигчийн тойрогтоо зохион байгуулж буй баяр, тэмдэглэлт өдрийн үеэр концерт, фестивал зохион байгуулах, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй хэлний курст сургах, эрүүл мэндийн үзлэгт үнэгүй хамруулах, олон нийтийн лекц зохион байгуулах, бэлэг, хандив өгөх гэх мэт явуулж буй арга хэмжээнүүд нэр дэвшигч өөрийгөө таниулах, дэмжигчдийнхээ үндэс суурийг бүрэлдүүлэхэд чиглэгдэнэ. Эдгээр өдөр тутмын амьдралд тулгардаг сонгуулийн бус үйл ажиллагаа нь олон нийттэй харилцах албан бус суваг болох бөгөөд Монголын сонгуульжилтын маш чухал хэсэг билээ.

Хоёрдугаарт, Сэржээгийн түүхээс бид сонгууль бидний өдөр тутмын амьдралд хүмүүсийг жендэрийн болон насны хувьд хэрхэн ялгаж буйг харж болно. Төрийн болон орон нутгийн засаг захиргаанаас үзүүлэх олон төрлийн үйлчилгээ УИХ-ын гишүүдийн гарт очиж, сонгуульд ашиглагдах болсноор сонгогчдын хүлээлтийг бий болгожээ. Энэ төрлийн хүлээлт төрийн үйлчилгээ, эдийн засгийн нөөц илүү хүндрэлтэй газруудад төдий чинээ өндөр байна. Үүнд өнөөгийн неолиберал засаглалын үед төрийн үйлчилгээг хүртээх нөөц хязгаарлагдмал байдаг нь зарим талаар нөлөөлж буй биз. Дийлэнх УИХ-ын гишүүд төрийн үүргийг сонгуулийн арга хэрэгсэл болгож гарамгай ашиглах бөгөөд үр дүнд нь сурталчилгаа нь ихээхэн амжилттай болно. Боловсрол багатай сонгогчид саналаа худалдах магадлалтай гэх таамаглал элбэг боловч, саяхны антропологийн судалгаагаар хүмүүс бодит саналаа болон саналыг нь худалдаж авах гэж буй хүмүүст юу гэж хэлэхээ ялгаж салгадаг болжээ (Bjorkman 2014).

Гуравдугаарт, сонгууль социалист болон ардчиллын элементийг хослуулсан эмэгтэй улс төрчдийн танигдахуйг бий болгодог. Энд, эмэгтэйчүүдийн байгууллагыг өргөжүүлэх, сонгуулийн кампанит ажилд дэмжлэг үзүүлэх эмэгтэйчүүдийг сургаж бэлтгэх, цуглуулах

замаар сонгуулийн утгыг өөрчилж болохыг харуулдаг. Эмэгтэйчүүд нэг шалтгаанаар (тодорхой нэр дэвшигчийн төлөө), нэг бүлгийн нэг хэсэг байж, ижил хувцас өмсөж, ижил удирдагчийг дагах төдийгүй тэд сургалтын үеэрх тансаг цайны завсарлага, оройн зоог хүртэж сурчээ. Сэржээгийн зохион байгуулсан олон ажил, тэдгээрийн үр дагавар социалист үеийн залуучуудын байгууллагын бүтэц, арга замыг санагдуулдаг. Ороолт, хувцсаар ижилсэх нь хүртэл Залуу Пионерын Холбоо, Хувьсгалт Залуучуудын Холбоог санагдуулна. Гэвч гоо сайхан байх, өөртөө анхаарал тавьж биеэ тордох, хэрэглээ, амьдралын хэв маяг болон имиж бүрдүүлэх талаарх сургалтууд нь социализмын үетэй харьцуулшгүй орчин үед нийцүүлж, онцгой сайжруулсан байлаа. Ардчиллын үеийн улс төрийн намын гишүүд сонгуулийн ухуулагчид болон төлөвшиж, тэдний ур чадвар, сонирхол нь зах зээлийн тогтолцоог даган хөгжжээ. Сонгуулийн үйл ажиллагаагаар дамжин илүү дээд давхаргын шинж чанарыг тодотгом, хэрэглээнд суурилсан эмэгтэйлэг хэв маяг бий болов. Сонгууль нь эмэгтэйчүүдийн бүлэг, сонирхлын бүлгийн эмэгтэйчүүдийг дайчилж, бүлгийн зохион байгуулалтад оруулж, улс төрийн амжилтад хүрэхийг хүсэх байдлыг бий болгосноор феминист онцлогийг шинээр тодорхойлж байна. Сэржээгийн туршлагаас үзэхэд, сонгууль нь уламжлалт, зах зээлд суурилсан, эсвэл саяхны социалист үеийн жендэрийн ойлголтоос ялгаатай бөгөөд илүү мэргэжлийн, зиндаа дээгүүр эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх талбар болжээ. Сэржээ зорилгод нь хүрэхэд тохиромжгүй, таагүй санагдсан одоогийн жендэрийн ойлголтыг эвдэхийн төлөө ихэд хичээж, эмэгтэйлэг байдлын талаарх нийтийн төсөөлөлд нийцэхгүй, эрсдэлтэй ч гэмээр үйлдлүүдийг хийж байсан юм.

Сонгогчдын сонирхол ч мөн сонгуулиас сонгуулийн хооронд өөрчлөгдөж байна. Тэд сонгуулийг нэр дэвшигчээрээ дамжуулан төрийн нөөцийг хүртэх, давуу тал олох арга болгон ашиглаж сурчээ. Эцсийн эцэст, маш олон хүний хувьд сонгууль “асуудлаа шийдүүлэх” боломж болон хувирлаа. Сонгууль орон нутгийн засаг захиргааны, хамт олны дэмжлэгийн, төрийн үйлчилгээний, тэр бүү хэл гамшгийн үеийн тусламжийн байгууллагын үүргийг орлон гүйцэтгэнэ. Зарим сонгогчид мэдээж энэ төрлийн зохицуулалтад дургүйцлээ илэрхийлнэ. Тэд хэдийгээр ёс зүйн, ёс суртахууны хувьд энэ төрлийн үйл ажиллагааг шүүмжилж байсан ч, нэр дэвшигчдийн үйлдлээс залхаж буй хэдий ч гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад өчүүхэн ч атугай нэмэр болохын тулд сонгуулийн сурталчилгааг эсэргүүцэж чадахгүй.

Сонгууль бүх төрлийн дайчилгааг нэмэгдүүлж, капитал, үйл ажиллагаа, үр нөлөө, субъектив шинж байдлыг тасралтгүй үйлдвэрлэх мэдрэмжийг бий болгоно. Нефть импортлогчид сонгуулийн үеэр хамгийн их ашиг олно. Иргэд нэр дэвшигчид, сонгуулийн ажилчид,

сонгогчид – бүгд нэр дэвшигчийн уулзалт зэрэг бусад үйл ажиллагаанд хамрагдсанаар, бүх нийтээрээ цаг хугацааг өнгөрөөж, нийтийн нэгэн цаг үед хамрагдаж байгаага мэдэрч, цаг хугацааг хүртэл улс төрийн болгож буй мэдрэмжийг төрүүлэх болж. Хэн байгаагаасаа хамаарахгүйгээр нийтээрээ нэгэн цаг мөчийг эзэгнэж байна гэдэг нь социалист төрийн үед цаг хугацааг шаталж, ард түмнийг заримыг нь цаг үеэсээ “түрүүлж” бусдыг нь “хоцорч” яваагаар нь ялгадаг үе нэгэнт төгсгөл болжээ. Гэвч хамтын оршихуйн энэ мэдрэмж нь ихэвчлэн эмх замбараагүй байдал, үймээн самуунаар дүүрэн байх бөгөөд сэтгэл хөдлөл, хэрэглээний зардлын илүүдлийг бий болгож байдаг.

Ихээхэн хэмжээний хөрөнгө бас чармайлт талаар болж болохыг Сэржээ Хэнтий аймагт нэр дэвшихээс өмнө Сүхбаатар дүүргийн сонгуулийн тойрогт зарцуулсан хүчин чармайлтаас харж болно. Сонгуулийн нэр дэвших зорилттой ажил, уулзалт, сонгогчдод зориулсан баяр ёслолын арга хэмжээ, эмэгтэйчүүдийн байгууллагыг бэхжүүлэхэд зарцуулсан бүхий л хүчин чармайлт хий хоосон өнгөрчээ. Сонгууль болохоос хэдэн жилийн өмнө эдгээр нь нэг бол нийгмийн амьдралын хэвийн урсгал төдий, эсвэл тэдгээр үйл ажиллагаанд оролцогчдын дурсамж болон үлдэнэ. Үүний адил, жинхэнэ сонгуулийн кампанит ажлын үеэр Сэржээгийн бэлдсэн зар сурталчилгаа ч зорьсон зорилгодоо хүрэлгүй, хий хоосон ажил болсон билээ. Гэсэн хэдий ч телевизийн сурталчилгаа, тараах материал, мэдлэг, үзэл санааны болон мөнгөний шинэ хэлбэрүүд олширч, тараагдсаар байна.

Эцсийн эцэст, сонгууль шинэ төрлийн нийгмийн давхаргуудыг бий болгов. Нэр дэвшигчдийн дийлэнх нь шинэ төрлийн элит болохоос гадна, дагалдагчид нь шинээр бий болж буй шаталсан тогтолцоонд өөрсдийнхөө байр суурийг эрэлхийлж, баталгаажуулна. Ялангуяа сонгуулийн сурталчилгааны ажилчид, дэмжигчдийн (тойргийн сонгогчдыг хувиараа хөлслөн ажиллуулна) хувьд сонгуульд санал өгөх нь тун ярвигтай үйлдэл болжээ. Учир нь хэдэн сар, жил үргэлжилсэн албан, албан бус сонгуулийн кампанит ажилд оролцохдоо тэд өөрийн мэдэлгүй ажил олгогчдоо итгэгч, түүнийг сонгогч болон хувирдаг. Кампанит ажилд бэлтгэх өргөн хүрээг хамарсан, хүнийг ядраасан ажил бөгөөд ихэнх дарамт сурталчилгааны ажилчид буюу сонгогчдод нь очно. Хүмүүс цалин авсан, авахаар тохирсон, эсвэл хожим ямар нэг тус гуйх найдлагаар нэр дэвшигчийн төлөө ажиллаж буй учраас саналаа өгөх нь бараг гарцаагүй бөгөөд урт хугацааны хөрөнгө оруулалтын үр дүн гэж үзэж болно. Хэрэв кампанит ажил нь жинхэнэ сонгуулийн үр дүнгээс гадна тодорхой зорилго бүхий дагалдах бүтээгдэхүүн бий болгодог үйл явц гэж үзвэл сонгуульжилт нь өөртөө үйлчилдэг, өөрийгөө хангадаг үйл явц гэсэн үг юм.

Оюунлаг: Эмэгтэйчүүд мөнгөний кампанит ажлын эсрэг

“УИХ-д оюунлаг эмэгтэйчүүд сонгогдох хэрэгтэй байна. Цөөн ч атугай оюунлаг эмэгтэй сонгогдоосой гэж найдаж байна” гэж 40 эргэм насны эрэгтэй сонгогч хэллээ. Энэ бол 1996 онд, Монгол Улсын парламентын гурав дахь удаагийн сонгуулийн үеэр (би ч энэ судалгаагаа эхлүүлэхээс урт хугацааны өмнө) болсон явдал. Би судлаачийн хувиар биш, тойргийн сонгогчийн хувиар нэр дэвшигчдийн зохион байгуулж буй уулзалтын үеэр оюунлаг эмэгтэйчүүдийг дэмжиж буй эрийн сэтгэгдлийг сонсоод гайхах, бахдах зэрэгцэж байлаа. Сонгогч “оюунлаг” гэх үгээр нэр дэвшигчийн үнэ цэнийг тодорхойлсонд гайхах зүйлгүй. Харин Монголын болон дэлхийн үнэт зүйлсийг хослуулж, оюун санааг материаллаг зүйлээс илүүд үзэж, мэдлэгийн бие даасан байдал, амьдралын хэв маягтай нөхцөлддөг тул соёлын, ёс зүйн үнэ цэнийг илэрхийлэх тус сэтгэгдэл гайхам, бахдам санагдаж билээ. Оюунлаг гэх үг нь хувь хүний үйлдэл, ололт амжилтаар тодорхойлогдоно. Түүнчлэн, оюунлаг гэх үг нь сэхээтэн гэх ойлголтоос ялгаатай юм. Сэхээтэн гэдэг нь нийгмийн давхаргыг илэрхийлэх зан төлөв, мэдрэмж, нийгмийн хүрээлэл, гарал үүсэл, зарим талаар бусдаас илүү эрх дархтай гэх утгыг илэрхийлдэг өнгөрсөн үеийг санагдуулсан ойлголт. Мөн чанартаа, оюунлаг нь тухайн хүний нийгмийн гарлаас үл хамааран хувь хүний сонгосон үйлдэл ба амьдралын хэв маягт тулгуурласан ойлголт билээ.

Дээр дурдсан сонгогч оюунлаг гэх ойлголтыг дэвшүүлснээр тухайн үед сонгуульд өрсөлдөж байсан бизнес эрхлэгч нэр дэвшигчдийг ашиг хонжооны араас хөөцөлдсөн, социалист хандлагаар бол хувиа хичээсэн,

ёс суртахуунгүй гэж шүүмжилж буй мэт.¹ Мөн, оюунлаг гэж ерөнхий хэлэлгүй, оюунлаг эмэгтэйчүүд гэж тодотгосныг онцлон тэмдэглэе. Олон нийтийн итгэл үнэмшлийн дагуу, эмэгтэйчүүдийг эрчүүдээс илүү оюунлаг гэж үзэхээс гадна соёлын, болон боловсролын салбарт баялаг бүтээхэд илүү идэвхтэй оролцдог, хуулийг гажуудуулах магадлал бага учраас илүү ёс суртахуун өндөртөйд тооцогддог байна (3-р бүлэг “Шударга Жендэр” хэсгийг үзнэ үү).

Тойрогт өрсөлдөж буй нэр дэвшигч шар айраг худалдаалах бизнес эрхэлдэг хүн байсан нь сонгогчдын бухимдлыг юу юунаас илүү төрүүлж байв. Өнөөх сонгогч оюунлаг эмэгтэй сонгогдоосой гэж хүсэхэд шар айргийн эрүүл мэндийн ач тусын талаар ярих эрэгтэй нэр дэвшигчийн бүдүүлэг яриа ихээхэн нөлөөлөө биз. Нэр дэвшигч шар айраг импортлохыг дэмжсэн хууль санаачлах талаар ярьж, ингэснээр Монголчуудын дунд хамгийн ихээр хэрэглэгддэг согтууруулах ундаа буюу архиыг шар айраг орлох болж, түүнийхээр улс оронд нүүрлээд буй архидалтын асуудлыг шийдвэрлэх гэнэ.

Саналын хуудас дугуйлах үед сонгогчид хэнд санал өгөхөө хэрхэн шийддэгийг мэдэх боломжгүй. Үгүйдээ л хийсвэрлэн авч үзвэл, эрдэм ном хөөсөн мэргэжилдээ манлайлж буй оюунлаг эмэгтэйчүүдийг согтууруулах ундаа зарах хувийн ашиг сонирхлоо эрхэмлэж буй бизнес эрхлэгчдээс илүүд үзэх нь дамжиггүй. Өмнө дурдсан сонгогчийн үгнээс үзвэл тэрээр эмэгтэйчүүд парламентын шударга ёсыг хамгаалагчид мөн гэх санал дэвшүүлж байна. Учир нь хямралтай цаг үед эмэгтэйчүүдийг сонгож парламентыг аврах дуудлага, эсвэл тухайн үеийн парламентын бүтэлгүйтэл нь улс орныг доройтуулсан тул ийнхүү уриалах болсон гэж үзэж болох. 1992 оны сонгуульд 3 эмэгтэй, 1996 оны сонгуульд 8 эмэгтэй сонгогдож байсан бөгөөд мөнөөх сонгогч тодорхой нэгэн эмэгтэйг онцлон дэмжиж байсан байж магадгүй.

Ерөнхийдөө 1990-ээд онд улс төрч буюу, сонгогдсон албан тушаалтнууд ардчиллын үйл явцтай зэрэгцэн гарч ирсэн шинэ төрлийн дүр төрх байсан юм. Үүнээс өмнө социализмын үед улс төрийн албан тушаалыг дээрээс доош шууд томилдог эсвэл сэхээтнүүдэд нэмэлт удирдлагын сургалт орсны дараа сонгодог байжээ. Энэ агуулгаар оюунлаг, боловсролтой, мэргэжлийн ололт амжилт зэрэг нь албан тушаалд томилогдохын суурь нөхцөл болж байв. Гэсэн хэдий ч, социализмын дараагийн шилжилтийн үед тогтворгүй байдал үүсэж, сонгуулийн кампанит ажил ихээхэн арилжааны шинжтэй болж, сонгогдсон улс төрчид, улс төр бүхэлдээ биш юм гэхэд дийлэнх нь мөнгө, авлига, шударга бус байдалтай хугталдаж, ёс суртахууны болон мэргэжлийн ур чадварын доголдол ихээхэн газар авсан юм. Эдгээр болон бусад нөхцөл байдал эрчүүд давамгайлсан улс төрд эмэгтэй улс төрчийн шинж чанарыг оюунлаг хэмээн илэрхийлэхэд тус дөхөм болжээ.

¹ Социализмын дараа зах зээлийн эдийн засгийн талаар үзэл бодол хэрхэн өөрчлөгдсөн талаар Мандел, Хамфри (2002) нараас үзнэ үү.

Энэ бүлэгт зарим эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийнхөө оюунлаг дүр төрхийг онцлох замаар арилжааны шинжтэй болсон сонгуулийн кампанит ажлыг эсэргүүцэж буй талаар өгүүлнэ. Тэдгээр эмэгтэйчүүдийн зорилго нь өөрсдийгөө төгс төгөлдөр, сонгогдохуйц нэр дэвшигч болгож, арилжааны шинжтэй болсон сонгуулийн кампанит ажлыг өөрчлөх явдал байлаа. Тэнгэрт тулсан сонгуулийн зардлыг дагахын оронд тэдгээр бүсгүйчүүд соёлын үнэт зүйл бүтээх маягаар кампанит ажлаа хийж, өөрсдийгөө таниулахыг зорьж байв. Оюунлаг нь өөрийгөө төгс төгөлдөр болгон хөгжүүлэхэд чиглэсэн асар их хүч хөдөлмөрийн үр дүн бөгөөд, биеэ бэлдэх буюу нэр дэвшихэд шаардлагатай иж бүрэн бэлтгэл ажлын нэг хэсэг болжээ. Эдгээр эмэгтэйчүүд өөрсдийнхөө туршлага, мэргэжлийн амжилт, нэр хүнд болон бусад мөнгөн бус нөөц гэх мэт улс төрд дутагдаад буй шинж чанарыг ашиглан өөрсдийгөө оюунлаг нэр дэвшигч болгон илэрхийлнэ. Би дөрвөн эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын туршлагад үндэслэн оюунлаг байх олон арга замыг харуулахыг зорилоо. Эдгээр эмэгтэйчүүд өөрсдийгөө оюунлаг гэж ил тодоор тодорхойлоогүй ч тэд улс төрийн мессеж, хандлага, үйл ажиллагаагаараа өөрсдийнхөө оюунлаг чадварыг илэрхийлснийг тэмдэглэе. Харин олон нийт, дэмжигч, сонгогчид тэднийг олон талаар оюунлаг болохыг тодотгосон юм. Тэдний сонгуулийн кампанит ажил улс төрийг бүхэлд нь неолиберал капитализм эзэлчхээгүй, сонгуулийн арилжааны шинж чанар нь ч бага байх боломжтойг бидэнд харуулдаг.

Энэ бүлгийн эхэнд оюунлаг байдал социализмын болон ардчиллын үед тус тус хэрхэн хүндэтгэм ойлголтын хажуугаар бас эрх мэдлийн төлөөх шинж тэмдэг болсон талаар эхлүүлнэ. Мөн оюунлаг хүмүүсийг тодорхойлом шинж чанар нь социализмын үед сэхээтэн ангид орох, эрх мэдэлд хүрэх боломж байсан бол социализмын дараах, капиталист нийгмийн үед бусад шинж чанартай нэгдэн нийлж өөр үнэ цэнтэй болж буй талаар харуулна. Эмэгтэй нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын жишээнээс тэдгээр эмэгтэйчүүд хэрхэн шууд болон, шууд бусаар оюунлаг гэх ойлголтын үнэ цэнийг бий болгож, арилжааны шинжтэй болсон сонгуулийн хэв маягийн эсрэг нэр дэвшиж буйг тодорхой харуулдаг. Уншигч та бүхэн улс төрчийн хувьд өөрт нь халгаатай байсан хэдий ч сонгуулийн кампанит ажлын зардлын асуудлыг анх удаа олон нийтийн анхаарлын төвд гаргаж, сонгуулийн сурталчилгааг хязгаарлахын төлөө лобби хийж явсан Санжаасүрэнгийн Оюунтай танилцана. Жүрмэдийн Занаа маш өндөр өртөгтэй сонгуулийн кампанит ажлын эсрэг өөрийнхөө хязгаарлагдмал нөөцийг ухаалгаар удирдан кампанит ажлаа хийсэн. Цэдэвдамбын Оюунгэрэл олон нийтэд танигдсан зохиолчийн нэр цуугаа ашиглан улс төрийн өрсөлдөөнд орж байлаа. Мөн миний судалгааны ажлын гол төлөөлөгч Раднаагийн Бурмаа мөнгөний хүчин зүйл гэхээсээ илүү өөрийн нэр хүнд, чадвараар ихэнх кампанит ажлаа явуулж байлаа.

Торгон Ухаан

Оюунлаг гэх үг нь “оюун ухаантай” гэх утга бөгөөд өөрийгөө өндөр боловсролтой, оюун ухааныг эрхэмлэдэг гэж тодорхойлдог хүмүүсийг илэрхийлнэ. Дээд боловсролын түвшин, чанараас гадна шинжлэх ухааны салбарт, оюунлаг нь хэн нэгний ёс зүй, улс төрийн байр суурь, олон нийтийн дунд сэхээтний хувиар амьдралын хэв маягийн сонголт, материаллаг хөрөнгөөс илүүтэй мэргэжлийн хувьд өөрийгөө хөгжүүлэхийг эрхэмлэдэг байдал, үгүй ядахдаа л хуйвалдан хөлжихөөс татгалздаг зэрэг утгыг давхар агуулж байдаг. Оюунлаг нь тодорхой үйлдэл, мэргэжлээр шинэ нөхцөл байдалд хэрхэн хувирч, шинэ төрлийн танигдахуйг хэрхэн бий болгож буйг харуулахад нэмэртэй ухагдахуун юм. Монголын орчин үеийн бодит байдалд, оюунлаг гэх агуулга нь жендэрт суурилсан, контекстын онцлогтой ойлголт болсон төдийгүй, агуулга, хэрэглээ нь өөр өөр цаг үед өөрчлөгдсөөр ирсэн талаар энэ бүлгээс харж болно.

Сонгогдохуйц өөрийгөө бүтээх, сонгуульд нэр дэвшихээр зорьж буй дийлэнх эмэгтэй оюунлаг шинж чанараа тодруулах нь сонгуульд биеэ бэлдэх цогц үйл ажиллагааны хэсэг билээ. Олонх Монголчууд оюунлаг хүмүүсээр улсаа удирдуулахыг хүсдэг нь улс орны улс төрийн бие даасан, аюулгүй байдал, тусгаар тогтнол, хөгжил, цэцэглэлтэд хөтлөх чадвар зэрэг мэдрэмжтэй нь холбоотой биз. Эдгээр ойлголт нь 17-р зуунаас хойш Румын болон Зүүн Европын сэхээтний ангийг судалж, үндсэрхэг үзлийн болон үндэстнийг цогцлоох асуудлаар дүн шинжилгээ хийсэн Катерин Вэрдэригийн (1996) тодорхойлсон сэхээтний ангийн талаарх ойлголтыг санагдуулдаг.

Оюунлаг гэх үг нь давхар олон нийтийн өмнө хариуцлага хүлээх гэх утга агуулах боловч, сэхээтэн буюу социализмын үеийн Монголд байсан, илүү эрх ямба бүхий нийгмийн давхарга гэх ойлголтоос ялгаатай. Социализмаас өмнөх үеийн (1921 оноос өмнө) сэхээтэнд боловсролтой язгууртнууд, лам хуврагууд, худалдаа эрхлэгчид гэх нийгмийнхээ багахан хэсгийг эзлэх хүмүүс тооцогдож байсан нь өнгөрсөнтэй илүү холбоотой болов уу. Социалист төрийн үед гол төлөв нийгмийн дээд давхаргаас гаралтай, ирээдүйтэй залуучуудыг 1920, 1930-аад оноос эхлэн Баруун Европт боловсрол эзэмшүүлэхээр илгээх болжээ. Харамсалтай нь 1930-аад онд болсон Монголын улс төрийн их цэвэрлэгээний үед илүү боловсролтой хэсэг нь бараг бүхэлдээ өртөж, Зөвлөлтийн боловсролтой хүмүүс орыг нь эзэллээ.² Ийнхүү сэхээтэн гэх нэр томъёо Монголд социализмын үед шинээр бий болсон сэхээтний давхаргыг илэрхийлэх төдийгүй түүхэн ач холбогдолтой. Социалист үзэл суртлын үр нөлөөгөөр бий болсон сэхээтэн гэх үг нь социализмаас өмнөх үеийн сэхээтнүүдтэй адилгүй. Румыны сэхээтнүүд нь үндэсний яриа, хэлэлцээний гол найруулагчид байсан гэж Вэрдэри (1991)

² Илүүг Баабар 1999; Буяндэлгэр 2020, Дашпүрэв, Сони 1992, Саруул-Эрдэнэ 2000 үзнэ үү.

үздэг. Үүнтэй төстэйгөөр, шинэ социализмын үеийн Монголын сэхээтнүүд нийт ард иргэдэд тэгш байдал, хөгжил дэвшил, гэрэлт ирээдүйн тухай төрөөс дэвшүүлж буй хөтөлбөрийг итгүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж Саймон Викамсмит (2020) үзэв. Тиймээс, социалист Монголд сэхээтэн гэдэг нь үндэсний хүсэл тэмүүллийг бий болгох эрх мэдэлтэй, бусдаас амжилттай хүмүүсийг илэрхийлэх болжээ.³

Өөрсдөө эрх ямбатай байсан ч гэсэн олон сэхээтэн төрдөө шүүмжлэлтэй ханддаг байсан. Энэ нь тоталитаризм, 1930-аад оны улс төрийн цуст хүчирхийлэл, 1960-аад онд сэхээтний төөрөгдөл, Монголын удирдлагууд ихээхэн Зөвлөлтжиж буйг эсэргүүцсэнээс үүдэлтэй байв (Jamian 2017; Rupen 1979; Shinkarev 2006). Монголд Зөвлөлтийн эсрэг, илүү либерал социалист үзэл хандлага нэмэгдсэн нь (Zubok 2019) зарим сэхээтний байр суурьт нөлөөлжээ.⁴

1990 он гэхэд Монголын зарим сэхээтэн өөрсдийнхөө ажил үүргийг төрийн үзэл суртлыг үйлдвэрлэгчид төдий бус нийгмээ, улс орны удирдагчдыг илүү бүтээлч байдлаар шүүмжлэх хүч хэмээн харж байсан юм.⁵ Сэхээтний давхаргын хүмүүс л чухамдаа 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхэн үед өрнөсөн ардчилсан хөдөлгөөнийг удирдсан билээ. Сэхээтэн гэх ойлголт ч социализмын уналттай зэрэгцэн өөрчлөгдлөө.⁶ Өнгөрсөн үеийн Зөвлөлтийн ноёрхол, төрийн социализмтай холбогдож байсан тул үнэ цэнээ алдсан ойлголт болон хувирав. Шинэ төрийн тогтолцоо ч өмнөх үеийн социализмын адил ангийн давхаргыг хянах боломжгүй болсон тул нийгмийн давхаргын хувьд ч сэхээтэн гэх анги нь агшин жижгэрчээ.

Оюунлаг гэх ойлголт нь нийгмийн сэхээтний давхаргыг ч эсвэл улс төрийн эрх мэдэлд хүрэх урьдач нөхцөлийг ч илэрхийлэхээ больжээ. Харин тус ойлголт нь өөрийгөө хөгжүүлэхийн тулд мэдлэгийг эрхэмлэдэг, мэдлэг бүтээхийн тулд хувь нэмрээ оруулдаг хэнийг ч илэрхийлэх ойлголт болж хувирлаа. Нийгмийг удирдах хэсэг, хүсэл тэмүүлэл бүхий дундаас дээш давхаргынхан болон коллежийн суурь боловсролоос цаашид боловсролоо ахиулах боломжтой хэн бүхэн оюунлаг байдлыг эрхэмлэдэг гэж болно.⁷ Өөрөөр хэлбэл хэн нэгний өмнөх туршлагыг мэдэхгүй байсан

³ “Оюунлаг” гэх үгийн тодорхойлолтуудын талаар Зигмунт Бауман (1987) тэмдэглэснээр, дийлэнхдээ байр суурь бүхий бүлгүүд, нийгмийн орон зай, мэдлэгийн орон зайг бий болгох гэх мэтээр тодорхойлжээ (Bauman 1987). Бауманы онцолсон оюунлаг хүмүүсийн “шинж”-ийг үргэлжлүүлэн Катерин Вердери (1996, 17) “албан ёсны улс төрийн албан тушаалд хүрэх . . . хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд өөрсдийгөө илэрхийлэх үнэт зүйлсийн талаар мэдэж байдаг гэх мэт зүйлсээрээ ялгардаг” гэжээ.

⁴ Зөвлөлт Холбоот Улс төрдөө үйлчлэх шинэ сэхээтний ангийг үйлдвэрлэхийн зэрэгцээ, социализмаас өмнөх үеийн олон сэхээтнүүдээ хавчиж байлаа. Сэхээтний анги нь хавчлагад өртөж байсан тэрс үзэлтнүүдийг эсэргүүцэхээс өгсүүлээд улс төрийн удирдлагын талархлыг хүргэж, хавлагыг туулж гарсан гэх мэт олон янз байна (Elfmov 2003; Shlapentokh 2014).

⁵ Оросын сэхээтнүүд, социализмын дараа гэд хэрхэн өөрчлөгдсөн талаарх түүхийн дэлгэрэнгүйг Шалин 2012-оос үзнэ үү.

⁶ Хурдацтай өөрчлөгдөж байсан бусад бүх давхаргынхантай адил төстэй байдлаар (Gessen 1997; Humphrey 2002; Mandel and Humphrey 2002).

⁷ Зөвлөлтийн дараа үеийнхтэй төстэйгөөр, тухайлбал Мишел Ривкин-Фиш (2009, 81) маш олон Оросууд шинэ зах зээлд дундаж давхаргынхныг эдийн засгийн нөөц хүлээн авагч болгохын тулд тэдний танигдахуйг “соёлын үнэт зүйлсийн илэрхийлэл”, хэдийнээс сэхээтнүүдийг илэрхийлдэг байсан өндөр боловсрол хэмээн зөвшөөрт байсан гэж үздэг.

ч гэсэн өөрийгөө хөгжүүлэхэд гаргасан амжилтаар нь оюунлаг (сэхээтнээс ялгаатай) гэж тодорхойлох боломжтой юм.

Тус нэр томъёоны жендэрийн шинж ч мөн өөрчлөгдсөн. Социализмын үед өндөр албан тушаалтнуудын дийлэнхийг эрчүүд эзэлж байсны адил сэхээтний ангийн хамгийн амжилттай төлөөлөл нь мөн л эрчүүд голдуу байлаа. Уран зохиол, театр гэх мэт соёл урлагийн салбарыг төрөөс санхүүжүүлдэг байдал зогсож, зах зээлийн эдийн засаг, хувийн хэвшил сэргэхтэй зэрэгцэн нийгмийн давхаргын хувьд сэхээтэн ангийн байр суурь ч буурчээ. Оюунлаг гэх ойлголт эр хүйстэй шууд холбогдох шинж ч багаслаа. Бизнесийн үйл ажиллагаа (ялангуяа худалдааны) ч ихээхэн хөгжиж, хүмүүс дан ганц баяжих хүслээс гадна тэсэн үлдэхийн тулд бизнес эрхлэх болжээ. Хамгийн амжилттай харагдаж буй бизнесүүд ихэвчлэн эрэгтэй бизнес эрхлэгчдэд хамаарна. Ашгийн төлөөх шинэ, замбараагүй орчинд зарим боловсролтой бөгөөд чадвартай эмэгтэйчүүд материаллаг гэхээсээ илүү оюунлаг ажил эрхлэх замыг сонгосноор оюунлагийн шинэ бодит биелэл болсон юм.

Оюунлаг гэх ойлголт 1990-ээд оны эхэн үеэс ТББ бэхжүүлэх, улс төрийн оролцоо зэрэг эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагаатай холбоотой ойлголт болов. Энэ нь зарим талаар өндөр боловсролтой, улс төрийн идэвхтэй эмэгтэйчүүд шинэ, ардчилсан нөхцөлд улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцооны ач холбогдлыг таниулах оролдлоготой холбоотой. Ардчиллын үйл явцын эхэн үед шинэ улс төрийн орчин, мэдлэгийн орон зай эмэгтэйчүүдийг оюунлаг болгон хөгжүүлсэн гэхээс илүүтэй эмэгтэйчүүд өөрсдөө оюунлаг байхыг онцлог шинж чанар болгон бэхжүүлсэн гэвэл илүү зохино. Эдгээр эмэгтэйчүүд олон улсын хөгжлийн салбарын шинэ хэл яриа болон 1995 оны Бээжингийн Эмэгтэйчүүдийн Чуулга уулзалтад АНУ-ын Тэргүүн хатагтай Хилари Клинтон хэлсэн үг (жишээ нь, эмэгтэйчүүдийн эрх бол хүний эрх билээ гэх мэт) зэргийг ашиглахын зэрэгцээ өөрсдийнхөө олон улсад холбоо сүлжээтэй байдал, ур чадвартай, мэдлэг мэдээлэлтэй, оюунлаг манлайлагчийнхаа өнцгийг онцлон харуулах стратеги баримталсан юм. Олон улсын сүлжээг ашиглан өөрсдийнхөө нэр хүндийг эх орондоо өргөснөөр мессежээ ч олон нийтэд түгээх чадалтай болжээ. Тэдний мессеж нь жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайлал зэрэг болно.

The Liberal Women's Brain Pool⁸ гэх ТББ-ын нэрээс үзэхэд оюунлагийг танигдахуйгаа болгосныг харж болно. Монгол нэр нь Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан. Энд тархи (brain) гэж үгийг биш оюун (intellect) гэх үг ашигласан нь оюунлаг гэх үгний язгуур бөгөөд соёлын хувьд илүү нийцдэг. Зарим шүүмжлэгч улс төрийн идэвхтэй

⁸ Энэ ТББ-ын талаар Ундарьяа 2018-ыг үзнэ үү.

эдгээр эмэгтэйг оппортунист, амжилтдаа эрдэгсэд, эрх мэдлийн хөөцөлдөгч гэж шүүмжилдэг боловч, нөгөө талдаа тэднийг оюунлаг гэж үздэг хүмүүс ч цөөнгүй бий.

Монгол сонгогчид УИХ-ын эмэгтэй гишүүнийг сонгох шалтгааны нэгдүгээрт боловсролыг нэрлэжээ.⁹ Боловсрол бол оюунлаг байдлыг тодорхойлох үндсэн шинж билээ. Гэсэн хэдий ч, социализмаас хойш эмэгтэйчүүдийг хүйсээр нь дорд үзэх байдал илэрхий ихэссэн бөгөөд үүний эсрэг эмэгтэйлэг байдлын хүндэтгэл хүлээм, хүчирхэг шинжийг бий болгоход эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагаа, ялангуяа ТББ-д суурилсан үйл ажиллагаагаар илрэх эмэгтэйчүүдийн оюунлаг шинж чанар маш чухалд тавигдсан. Оюунлаг шинж чанарыг улс төрд нэр дэвшиж буй хүмүүсийн гол шинж болгох нь капитализмын үед материаллаг эд баялгийн араас хөөцөлдөх сонирхол, Монголын нийгэмд эрчимтэй хөгжиж буй улс төрийн кампанит ажлын арилжааны шинж байдлын эсрэг ерөндөг байсан юм. Мөн энэ нь эмэгтэй хүний талаар миссүүд, загвар өмсөгч гэх мэт хүйсэд суурилсан хэвшмэл ойлголтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэт их сурталчилдаг байдлын эсрэг ерөндөг байсан юм. Вотерс (2016) энэ талаар тачаангуй байдал зарим эмэгтэй хүний эдийн засгийн болон нийгмийн давхаргаар ахих нөөц болдог гэжээ. Оюунлаг гэх шинэ ангилал нь эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг өөрчлөхөд шаардлагатай хууль тогтоомж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарах дүр төрх, эмэгтэйчүүдийг ялгаатай, хүндэтгэлтэй хандах бүлэг гэдгийг ойлгуулахад чухал үүрэгтэй байсан юм. Өөрөөр хэлбэл, оюунлаг байдал нь эмэгтэйчүүд биологийн нөхөн үржих чадвар төдийгөөр хязгаарлагдах бус өөр бусад бүх талаар ч бүтээмжтэй байх чадвартай гэдгийг онцолсон.¹⁰

Ардчиллын үйл явц улс төр дэх эмэгтэйчүүдийг шинэ хэл яриа, шинэ сэдэв, үйл ажиллагааны шинэ хэлбэрээр хангасан юм. Ардчилал эхлэхээс өмнө ч эмэгтэйчүүд улс төрд оролцож, удирдах албан тушаал хашиж байсан туршлага бий. Оюунлаг гэх ойлголт эмэгтэйчүүдтэй холбогдохын хэрээр эмэгтэйчүүдийг торгон ухаантай, торгон мэдрэмжтэй гэж ярьдаг Монгол уламжлалтай нэгдэж тус нэр томьёо улам жендэрийн шинжтэй болсоор байна. Торгон мэдрэмж гэдэг нь бусдын бодол санаа, сэтгэл хөдлөлийг “унших” чадвар, ухамсар, ухаарлыг илэрхийлж буй ерөнхий нэр томьёо

⁹ Жендэрийн Үндэсний Хорооноос гаргасан “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо” тайланд судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 61.5 хувь нь эмэгтэй нэр дэвшигчийг сонгох 11 төрлийн шалгуураас хамгийн түрүүнд харах шалгуур нь “боловсрол” гэж хариулжээ. Тус судалгаанд эмэгтэй нэр дэвшигчдийн “үзэл бодол” хоёр дахь чухал шалгуур (56.4 хувь) гэсэн бол, гурав дахь чухал шалгуураар “туршлага”-ыг (59.6 хувь) нэрлэжээ. Хамгийн чухал бус шалгуураар эмэгтэй нэр дэвшигчдийн “имиж” (7.8 хувь), ба “хөрөнгө чинээ”-г (5.6 хувь) нэрлэв. 2007 онд хувийн судалгааны МЭЖ компаниас зохион байгуулсан “Сонгуулийн үйл явц дахь эмэгтэйчүүдийн оролцооны гарааны судалгаа”-нд мөн л “боловсрол” (27 хувь) хамгийн чухал шалгуур гэсэн бол “туршлага” (24 хувь) удаалж, “олон нийтэд танигдсан байдал” (19 хувь) гуравдугаар чухал шалгуур гэж хариулжээ.

¹⁰ Эргэн сануулахад, социализмын үед хууль тогтоох байгууллага, төрийн байгууллагын удирдлагын бүх түвшинд эмэгтэйчүүдийн квот 25-30 хувь байсан бөгөөд, 1990-ээд онд ардчилсан нийгэмд шилжихэд эдгээр квот алга болсон юм (1-р бүлэг үз). Үүний үр дүнд, УИХ дахь болон бусад удирдлагын албан тушаалын эмэгтэйчүүд багассан нь ялангуяа дундаж, болон дундаас дээгүүр давхаргад эзэмшсэн өндөр, дээд боловсролтой нь харьцуулахад маш бага байна.

юм. Торгон утас нарийн мөртөө хүчирхэг, уян хатан шинжийг илэрхийлнэ. Социализмын үед эмэгтэйчүүдийг сэтгэл хөдлөлийг мэдрэх чадвар, нарийн мэдрэмж гэх мэт эмэгтэй хүйсийн онцлог гэх хэвшмэл ойлголттой холбоотой ажил эрхлэхийг дэмждэг байлаа. Эрчүүд гол төлөв үйлдвэрлэл, инженерчлэл, хөдөө аж ахуйн ажил эрхэлдэг байхад эмэгтэйчүүд үзэл суртал, соёл боловсрол, нийгмийн халамж зэрэг илүү оюунлаг байдал, “торгон мэдрэмж” шаардсан ажил эрхэлдэг байсан юм.¹¹

Оюунлаг байх нь хүндэтгэлтэй шинж боловч, нэр дэвшихэд шаардлагатай мөнгө, эрх мэдэл, танилын хүрээ гэх мэт нөөцөд шууд хөглөхгүй. Ардчилал чөлөөт зах зээлийн эдийн засагтай зэрэгцэн эрэгтэйчүүд хамгийн ашиг орлоготой, томоохон бизнест нөөрхсон бол, эмэгтэйчүүд жижиг, дунд хэмжээний бизнест давамгайлах болжээ. Улсаас санхүүжиж байсан соёл боловсролын салбарын санхүүжилт багасаж, зах зээлийн хэсэг болж хувирав. Сонгууль арилжааны шинжтэй болсноор шинэ, эмэгтэй, бизнесийн ертөнцөөс гадна буй нэр дэвшигчдэд өрсөлдөөний илүү хүнд нөхцөлийг үүсгэлээ. Ихэнхдээ ихэнх эмэгтэй нэр дэвшигчид эрэгтэй нэр дэвшигчидтэй адил түвшинд кампанит ажлаа санхүүжүүлж чадахгүй тул санхүүгийн хүндрэлтэй байнга тулгарах болсон юм.

Оюунлаг байх нь чинээлэг түвшинд шууд хамаарагдахгүй бөгөөд оюунлаг байдалдаа хэт найдан, эрх мэдэл, баялгаа сонгогчдод мэдрүүлэхгүй байх нь сонгуулийн тойргоосоо хамаараад нэр дэвшигчийнхээ ирээдүйд ч сөрөг нөлөө үзүүлэх тал бий. Сонгосон төлөөлөгчдөдөө итгэл алдарсан Монгол сонгогчдын дийлэнх нь урт хугацааны амлалтаас илүүтэй, шууд ашиглаж болох бэлэг сэлт, үйлчилгээг илүүд үзэх хандлагатай (2-р бүлэг үз). Тиймээс, өндөр боловсролтой, ёс зүйн өндөр хариуцлагатай оюунлаг нэр дэвшигч мөнгө, бэлэг, бусад материаллаг нөөц тарааж буй хэн нэгэнд ялагдах тохиолдлууд бий. Оюунлаг байх нь санал авах баталгаа болохгүй боловч оюунлаг эмэгтэйчүүд өөрсдийнхөө ур чадвар, мэдлэг, нөөц цуглуулах чадвартай нэр хүнд зэргээ ашиглан танилын сүлжээгээ өргөжүүлж илүү танигдаж сонгогдохуйц болсон байдаг билээ.

Кампанит ажлыг сааруулсан нь

Үзвэр үйлчилгээ, бэлэг дурсгалын зүйл, баяр ёслол, цугларалт, жагсаал гэх мэтээр сонгуулийн кампанит ажил олон нийтийн баяр хөөр, догдлолыг төрүүлэх үйл явдлаар дүүрэн талбар болжээ. Телевизүүд нэр дэвшигчдийн өмнөөс концерт, улс төрийн мэтгэлцээн, сурталчилгааны видео, хөрөг нэвтрүүлэг зэргийг ихээр цацна. Сонгуулийн албан ёсны сурталчилгаа эхлэхтэй зэрэгцэн далдуур өрнөж байсан сурталчилгаа гэнэт ил болж хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гудамж талбай, бусад олон нийтийн болон хувийн орон зай тэр чигтээ сонгуулийн үйл явдлуудаар дүүрнэ. Бүх л сэдвийг

¹¹ Алексиа Блок (2003) Оросын алс дорнод дахь мэргэжилтнүүдийн жендэрийн онцлогийн төсөөтэй байдлын талаар өгүүлсэн.

хамрах мэтгэлцээн, өрсөлдөөн, цуу яриа зэрэг нь сонгогчдыг эцэс төгсгөлгүй үргэлжлэн үзэх, сонсох, бодох үйлдэл рүү урхидан оруулах гэлтэй.

2004 оны сонгуулийн кампанит ажил нь хүсэл биелүүлэгч бирд нэг хүслийн араас нөгөө хүслийг нь биелүүлэх мэт концерт, нэр дэвшигчдийн хоорондын ширүүхэн маргаан, донтуулам “хар пи-ар”-аар нэр дэвшигчдийн “муу муухайг” дэлгэх гэх мэтээр дүүрэн сонгууль байсан юм. Энэ сонгуулийн сурталчилгаа ид өрнөж байх үеийн нэгэн орой Иргэний Зориг Намын дарга Санжаасүрэнгийн Оюун (тухайн үеийн цор ганц эмэгтэй намын дарга) телевизээр гарахдаа сонгуулийн кампанит ажлыг орвонгоор нь эргүүлэв. Кампанит ажлын стрессээс болсон гэлтэй бага зэрэг чийхарсан дуугаар сонгуулийн сурталчилгаа хэт нүсэр, хэт сүржин өрнөж буйг зад шүүмжлэн, сонгуулийн санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг хянахыг олон нийтэд уриалав. Түүний үг нь кампанит ажлын залгуурыг цахилгаанаас салгах мэт. Тэрээр дараах зүйлийг хэлэв.

Зурагт хуудас, телевизийн нэвтрүүлэг, хувь хүний сурталчилгаа, хэвлэмэл, тараах материалд хэр их мөнгө зарцуулж буйг хар даа. Энэ бүх мөнгө хаанаас гарч ирээв? Эдгээр мөнгө улсын сангаас гарав уу? Хэрэв тийм бол тэдгээр сангийн мөнгийг хэн нь ашиглах эрхтэй, хэн нь эрхгүй байна? Үүнээс болж төсвийн алдагдал үүсвэл хариуцлагыг нь хэн хүлээх юм?



Дүрс 5.1. Оюун 2008 оны сонгуулийн кампанит ажлын үеэр ярилцлага өгч буй нь. Зохиогчийн дарсан зураг.

Оюун энэхүү шүүмжлэлээ олон нийтэд хүргэх үед сонгуулийн сурталчилгааны хүрээнд зохион байгуулах урлагийн тогтолт, шоу, бусад

хэлбэрийн зугаа, телевизээр дамжуулах нэвтрүүлэг, сурталчилгаа зэрэгт хязгаарлалт цөөн байсан юм. Тэдгээр хязгаарлалт хэрхэн хэрэгжиж буй хяналтын тогтолцоо ч бараг байсангүй. Мөн тэрээр сонгуулийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт байхдаа төлбөртэй улс төрийн сурталчилгаа нийт эфирийн цагийн 50 хувиас ихгүй байх тухай заалтыг 10 хувь хүртэл бууруулах ажлыг амжилттай лоббидож чадсан. Энэ нь бусад хязгаарлалтын адил сонгуулийн кампанит ажлын зардлыг бууруулж, нэр дэвшигчдэд тэнцвэртэй өрсөлдөх боломжийг бий болгоход чиглэсэн өөрчлөлт байсан юм. Гэвч хамгийн их ашигтай үеийнхээ орлогыг алдах болсон тул хэд хэдэн телевиз хуулийн тус заалтыг шүүмжлэв. Хуулийн гол санаачлагч нь Оюун гэдгийг мэдмэгцээ өнөөх телевизүүд түүнийг эфирээр гаргахаа зогсоолоо. Гэсэн ч Оюуны шүүмжлэл нь улс төрд нөлөөлж, урт хугацаандаа түүний нэр хүндийг ч өсгөсөн юм. Сонгуулийн сурталчилгааны хугацаа, хэвлэмэл материалын хэмжээ, өргөн нэвтрүүлгийн зөвшөөрсөн цаг зэргийг зохицуулсан хууль дараагийн сонгуулиудаас хэрэгжиж эхэллээ.¹² Хэдийгээр хуулийн эдгээр зохицуулалт янз бүрийн үр дагавар авчирсан ч сонгуулийн сурталчилгааны зохицуулалтыг тойрсон хэлэлцүүлэг сонгуулийн хамгийн чухал хэсэг болсон юм. Энэ номд өгүүлэх бусад бүх эмэгтэй нэр дэвшигчдээс ялгаатай нь Оюун УИХ-д сонгогдсон цор ганц эмэгтэй байв. Ардчилсан хөдөлгөөний удирдагч, олон түмэнд хүндлэгдсэн улс төрч, Санжаасүрэнгийн Зориг агсны дүү болохоор, Оюун өргөн нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, ихэд нэр хүндтэй болсон байлаа (дүрс 5.1). Шударга, авлигад автагдаагүй улс төрч гэх Оюуны дүр төрх нь улам бэхжиж, нэр хүнд нь ч улам баталгаажсан. Дараагийн сонгуулиудаар зарим нэр дэвшигчид Оюуны адил олон нийтийн нөөцийг улс төрийн намууд тэгш бус хүртэж буйг ард иргэдэд анхааруулж эхлэв. Үгүйдээ л сонгуулийн санхүүжилтийн асуудал цээртэй мэт байсан бол сонгуулийн кампанит ажлыг тойрсон яриа хэлэлцүүлгийн гол хэсэг болон хувирлаа. Гэсэн ч одоог хүртэл энэ асуудал маш бүрхэг хэвээрээ байгаа билээ.

Оюунлаг харизм

Жүрмэдийн Занаа бие даан нэр дэвшсэн бөгөөд “Иргэдийн Альяанс төв” хүний эрхийн төлөө ажилладаг ТББ-ын тэргүүн, иргэний нийгмийн

¹² Тухайлбал, 2008 оны сонгуулийн хууль нэр дэвшигчийн (болон улс төрийн нам, эвслийн) сурталчилгааны тараах материалыг (хоёр сонин, нэг зурагт хуудас, нэг сэтгүүл) нийтдээ 64 захидлын хэмжээнээс (Монголын сонин стандарт хэмжээгээр нийтдээ 4 хэвлэлийн хуудас) хэтрэхгүй байхаар хязгаарлав (Вигмаа, Оуунтуяа, Munkhnaran 2008). Хэдийгээр зурагт хуудас зарим талаар хязгаарлагдсан боловч, эдгээр хязгаарлалт нь бүгдийг хангалттай зохицуулж чадсангүй. 2012 онд хэвлэл тараах материалын хэмжээ нэмэгдсэн боловч, зурагт хуудас болон бусад харагдахуйц материалыг тухайн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал илүү хатуу зохицуулав (Вигмаа, Оуунтуяа, Munkhnaran 2012). Хэдийгээр эдгээр хууль, журмаар нэр дэвшигчийн сурталчилгааны хугацааг зохицуулж байсан боловч медиа мониторингийн бүлгүүд далд сурталчилгаа төрөл бүрийн телевизийн сувгаар дараа дараагийн сонгуулиар үргэлжилсээр байсан төдийгүй төлбөрт сурталчилгаа нь илүү чинээлэг нэр дэвшигчдийн эрх мэдлийн тусгал байсан талаар тэмдэглэжээ. Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг хянахаар хүчин чармайлт гаргасаар байсан ч санхүүжилтийн асуудал тодорхойгүй хэвээр байна (Оуунтуяа 2013c).

лидерүүдийн нэг юм. 1950-аад онд төрсөн энэ эмэгтэй нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, хүндлэгдсэн нэгэн билээ. Занаа 1990-ээд оны ардчилсан хөдөлгөөнд оролцсон боловч тэрээр Ардчилсан намтай (АН) холбогдолгүй иргэний нийгмийн идэвхтэн гэдгээр олон нийтэд танигдсан юм. Сонгуулийн кампанит ажилд нь туслах сайн дурынхантай уулзах үедээ тэрээр “АН нэгэнт ардчилсан зарчмуудыг дагахаа больсон тул АН-аас бус, бие даан нэр дэвшихээр эргэлт буцалтгүй шийдсэн” гэж ярьж байлаа.

2000-аад оны хамгийн олонд танигдсан нийгмийн зүтгэлтнүүдийн нэг тэрээр хурц үгээ шулуухан хэлдэг төдийгүй үргэлжид гоё хувцас, дэгжин зүүлт сэлтийг хэрэглэх бөгөөд хаана ч үзэгдсэн хүчтэй сэтгэгдэл төрүүлэх нь үргэлжид төгсийн төлөө тэмүүлдгийг нь илэрхийлнэ. Бусад эмэгтэйчүүд харагдах байдлаараа олон нийтийн шүүмжлэлд өртдөг нь түгээмэл байсан бол Занаа өөрийн нас эгчмэд байдлыг ашиглан өөрийгөө хүчирхэг, харизмтай байдлаар илүү тодруулж чаддаг байлаа. Түүнийг эмэгтэй нэр дэвшигчийн зарим нь биширдэг бол, зарим нь сүрдэж, олон нийтийн арга хэмжээ, ялангуяа цөөн хүнтэй уулзалтад түүнтэй хамт оролцож нүүр тулахаас дөлдөг байв. Занаагийн олон нийтэд танигдсан байдал, гадаад төрх, итгэмжит байдал нэр дэвшихэд маш нэмэртэй байсан боловч тэрээр рейтингээ өсгөх улс төрийн намын суваг үгүй, мөн найдаж болохуйц намын төв байгууллагын сурталчилгаа ч үгүй, бас мөнгө санхүүгийн нөөц нь ч хязгаарлагдмал байлаа.¹³ Өөрөөр хэлбэл, Занаад өөрөөсөө өөр найдах зүйл тун бага байв.

Гэвч Занаа хүнд нөхцөлийг өөртөө ашигтайгаар эргүүлж чадаж байлаа. Тэрээр бусад нэр дэвшигчийн сурталчилгааг ур чадвартай, халгаа багатайгаар ашиглах арга олж чадаж байв. Занаа оролцсоноор өрсөлдөгчийнх нь пи-ар ч сайжирч, тэлэх тохиолдол ч байлаа. Тухайлбал, сонгуулийн том тойргийн янз бүрийн хэсэгт сонгогчидтой хийх уулзалт зохион байгуулах нь асар их хөдөлмөр, хөрөнгө шаардсан ажил тул Занаа уулзалт зохион байгуулахгүйгээр шийдэв. Харин оронд нь Занаа чинээлэг нэр дэвшигчийн сурталчилгааны уулзалтын яг дараа нь тэрээр цугларсан сонгогчидтой уулзаж байлаа. Судалгааны ажлын маань туслах Намсрайжавын Ариун-Ундрах (Ундрах) Занаагийн сонгогчидтой хийх уулзалтуудад оролцож явсан бөгөөд дараах яриаг надад хуваалцсан юм.

Занаа эгч АН-ын нэр дэвшигчийн сонгогчидтой хийх уулзалт болж буй танхимд орох гэж байлаа. “Та орж болох юм уу?” гэж Занаагийн сонгуулийн ажилтан санаа зовонгуй асууна. “Мэдээж хэрэг болж л таарна шүү дээ. Тэд (АН-ын нэр дэвшигч, ажилчдыг хэлж байна) намайг хөөж гаргах эсэхийг нь харъя” гэж хэллээ. Ингээд АН-ын уулзалт бараг дуусахын алдад Занаа танхимд орж индэр дээрээс ярьж буй нэр дэвшигчийг чиглэн хөндлөн гулд алхав. Хар хослол өмссөн шкаф шиг шкаф шиг бие хамгаалагчаар хүрээлүүлэн зогсох нэр дэвшигч залуухан эр Занаа

¹³ Нэр дэвшигчийн хэлж буйгаар, нийт сонгогчдын 20-30 хувь нь улс төрийн намын хатуу дэмжигчид байдаг аж.

дөхөж буйг хараад зогтосав. Тэр Занааг таниад нүүр нь улайв. Тэд бүгд Занаатай мэндчилж, хүндэтгэлтэйгээр гар бариад шалавхан шиг гарч одлоо. Энэ мөчид Занаагийн сонгуулийн ажилчид танхим даяар “Уулзалт бие даан нэр дэвшигч Жүрмэдийн Занаагаар үргэлжилж байна. Та бүхэн суудалдаа суугаарай” гэж чанга дуугаар зарлав. Гэвч мэдээж хэрэг хүмүүсийн гуравны нэг нь гарч орхив. Тэд нэр дэвшигчээ дагадаг АН-ын зохиомол “дэмжигчид” байсан юм. Жинхэнэ сонгогчид танхимд үлдмэгц Занаа эелдэг байдлаар “Та бүхэнд маш чухал зүйл хэлэхээр ирлээ” гэх нь тэр. Үзэгчид нам гүм боллоо. Занаа байгалийн баягийн эрэл хайгуул ихэссэн талаар, Засгийн газар батлахыг найддаж байгаа томоохон уул уурхайн хэлэлцээрийн сул талуудын талаар ярьж эхлэв.

Ундрах цааш нь үргэлжлүүлэн:

Занаагийн сонгуулийн явуулын штаб нь фургон машин байх тул (учир нь тэрээр оффис түрээслэх мөнгө байхгүй) тэрээр үргэлж л ийш тийш явж байдаг. Тийм учраас 30 гаруй хүнтэй уулзалт хийх (ихэнх хорооны уулзалтад, намын “хуурамч” дэмжигчдийг хасаж тоолбол дунджаар 30 орчим хүн л ирдэг аж) гэж хүлээж суухын оронд Занаа ихэнх өдөр гудамжаар алхаж хүмүүстэй ярилцана. Тэр хооронд сайн дурынхны ажилчид нь сурталчилгааны материалыг тараана. Автобусны буудлуудын дэргэд хүмүүс их цугларсан үед уулзалт их хийнэ. Би Занаа эгчийн уулзсан хүмүүсийг тоолж үзлээ. Тэрээр хоёрхон өдөрт хамгийн багадаа 200 гаруй хүнтэй иймэрхүү байдлаар уулзсан. Энэ нь томоохон хурлын танхимд уулзалт зохион байгуулахад ирдгээс ч олон хүн бөгөөд ямар нэг зардалгүй билээ.

Занаагийн сонгуулийн сурталчилгаа зарим чинээлэг нэр дэвшигчийнхтэй адил олны анхаарлыг ихээр татсангүй. Гэсэн хэдий ч, тэрээр ихэнх нэр дэвшигчийн сонгуульд ашигладаг нөөцтэй харьцуулахад бага нөөцөөр олон нийтэд өөрийгөө харуулж чадсан юм. Тэрээр ямар нэг улс төрийн намын мөрийн хөтөлбөргүй буюу бие даан нэр дэвшиж байсан, улс төрд анх удаа өрсөлдөж буй, ашгийн төлөө бус байгууллагын удирдагч (жишээлбэл, тэрээр төрийн мөнгийг ч ашиглах боломжгүй, хувийн хөрөнгө ч маш хязгаарлагдмал), бэл бэнчинтэй өрсөлдөгчтэй байсан зэрэг хүчин зүйлийг тооцвол түүний кампанит ажил амжилттай гэж үзэж болно. Иймэрхүү байдлаар тэрээр ихэнх нэр дэвшигчид маш их мөнгө зарцуулдаг, сонгогдсоныхоо дараа зарцуулснаасаа илүү мөнгө олохын төлөө зүтгэдэг байдалтай харьцуулахад улс төрийг өөр аргаар хийж болно гэдгийг харуулсан юм.

Занаа маш олон талаар оюунлаг нэгэн юм. Түүний намтар, нэр хүнд, амьдралын хэв маяг нь оюунлаг шинжийг агуулна. Занаа 2005 онд докторын зэрэг хамгаалсан бөгөөд жендэр судлалын чиглэлээр диссертациа хамгаалжээ. Мөн Занаа жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн гол авторуудын нэг билээ. Түүний дотнын найзууд нь дипломат, профессор болон хуульчид байлаа. Занаа Монгол Улсын Боловсролын Их Сургуульд Орос (социализмын үед), Англи хэл (социализм унаснаас

хойш) заадаг байсан. Улс төр, нийгмийн оролцооноос ангид байдаг бусад оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүстэй адилгүй, тэрээр нийгмийн идэвхтэн, шүтэл үлээгч, шаардлагатай үед тэмцэгч байж чаддаг нэгэн билээ. Энгийн тэмцэгчдээс түүнийг ялгаж, оюунлаг болгодог шинж нь түүний улс төр, нийгмийн амьдралыг ул суурьтай, гүн гүнзгий, нухацгайгаар задлан шинжилж, шүүмжлэх чадвар юм. Тэрээр ганц чухал асуудлыг (жишээлбэл, газар хувьчлал хууль гэх мэт) шийдвэрлэхийн төлөө биш, харин нийгэм, улс төрийн цогц асуудлыг сууриар нь шинжилж, шийдвэрлэхийн төлөө улс төрд оролцож байлаа.

Хүмүүнлэгийн салбарт ажиллах, Англи хэлтэй бусад сэхээтний адил, Занаа ч ардчилсан эрин үед иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Тэрээр хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, болон ардчиллын бусад үнэт зүйл, хөтөлбөрийг сурталчлахын төлөө Барууны хэв маягийн ТББ байгуулж олон улсын байгууллагуудад хүсэлт гаргаж, санхүүжилт авч чадсан анхны (Бурмаа, Ойдовын Энхтуяа, болон бусад эмэгтэйчүүдийн хамт) эмэгтэйчүүдийн нэг байлаа. Намайг судалгааны ажлынхаа мэдээлэл цуглуулж байх үеэр (2006-2017 оны хооронд) Занаа эмэгтэйчүүдийн эрхийн талаар нийгмийн ойлголтыг дээшлүүлэх, боловсролын хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг Иргэдийн Альянс төв гэх ТББ-ыг удирдаж байв.

1990-ээд оны сүүл, 2000-аад оны эхэн үед тэрээр “жендэр” гэх нэр томъёог (дагалдах ойлголт, жендэрийн асуудлын хамт) Монголын улс төр, нийгмийн амьдралд нэвтрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Тус ойлголт нь жендэртэй холбоотой асуудлыг нийгмийн идэвхтнүүд болон нийт нийгэмд ойлгуулахад чухал ач холбогдолтой байлаа. Ингэснээр социализмаас хойш орхигдоод байсан жендэрийн болон эмэгтэйчүүдийн асуудлыг ярилцах, лоббидох суурийг бүрдүүлэхэд тусалсан юм. Занаа шинэ үеийн феминистүүдэд ихээхэн урам зориг өгч тэднийг хүчирхэгжүүлж байлаа. “Жендэр” гэх ойлголт тухайн үедээ ихээхэн маргаан дагуулж байлаа. Эерэг үр дүнгээс (эерэг үр дүнгүүд нь нүдэнд харагдахгүй, зарим хүнд үнэ цэнтэй санагдахгүй) үл хамааран Занаагийн оруулсан хувь нэмэрт олон хүн шүүмжлэлтэй хандаж байв. Зарим хүмүүс жендэр, эмэгтэйчүүдийн эрхийн талаарх хэл яриаг, мөн Занааг хувь хүнийх нь хувьд шүүмжилнэ. Маш олон хүн “жендэр” гэх ойлголтыг “эмэгтэйчүүдийн эрх”-тэй холбож, тиймээс “жендэр”-ийг “феминизм”-тэй хольж, харин “феминизм”-ийг “эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх” гэж хольж ойлгоно. “Жендэр” гэх ойлголт “эмэгтэйчүүд улс төрд” гэх ойлголттой холбогдож, ерөнхийдөө карьер хөөх хүүхнүүд гэж явцуу ташаа ойлгодог болсон. Тэр бүү хэл өөрсдийгөө дэвшилтэт, орчин үеийн гэж тодорхойлох маш олон эрчүүд надад, “Жендэр ярих эдгээр хүүхнүүд бүгд л дарга болох сонирхолтой. Тиймээс, тэднээс хол байсан нь дээр гэж хүртэл ярьж байлаа. Иймэрхүү үзэл бодол Занаагийн танилцуулсан “жендэр” гэх ойлголт, жендэрийн тэгш

байдлын үзэл санаатай огт холбоогүй билээ.

Занааг зарим хүмүүс эсэргүүцдэг нь түүний хатуу, шүүмжлэлт байр суурьтай бас холбоотой. 1990-ээд оноос, 2010-аад оны сүүл хүртэл Занаа улс төр, нийгэмд нүүрлэсэн буруу зүйлс, улс төр дэх авлига, төрийн үйлчилгээг неолиберал арга барилаар багасгаж хумьсныг болон уул уурхай дахь гадаадын хөрөнгө оруулалтыг тууштай, хурцаар шүүмжилж байсан юм. Тэрээр ерөнхий зүйл л яриад байлгүй маш тодорхой шулуун ярина, түс тас асууж, шүүмжилнэ. Зарим нь түүнийг ухуулагч, үймүүлэгч гэж харах бол, зарим нь хүчирхэг удирдагч, зоригтой манлайлагч гэж үзнэ. Түүний хурц яриа, хатуу зан байдал нь “төмөр хатагтай”-н дүр төрхийг бий болгох бөгөөд жендэр, насны талаарх Монголчуудын хэвшмэл ойлголтыг эвдэж байсан юм. Занаагийн хурц хэл яриа түүний гол зэвсэг нь байлаа. Эрх мэдэлтэй хүмүүс ерөнхийлсөн, албан ёсны байдлаар харьцдаг бөгөөд Юрчакын (2007) тодорхойлсноор «төлөөллийн давамгайл хэв маягийг» ашиглаж бусадтай харьцахдаа зайлсхийсэн, бөөрөнхийлсөн, тойруулсан байдлаар ханддаг. Мөн Францын социологич Пьер Бурдьё (1991) эрх баригч анги өөрсдийн үзэл бодлыг ард түмэнд тулгаж, тэднийг захирахад хэл яриаг хэрхэн ашигладаг талаар судалжээ. Монгол удирдагчдын албан яриа нь хэт бөөрөнхий, нарийн тодорхой мэдээлэл, утга санаа бүрэнхий байдаг. Тиймээс Занаагийн хурц хэл яриа нь дарга нарын уйтгартай, залхаам, зайлсхийсэн ярианы эсрэг туйл байлаа. Улс төрд ялалт байгуулах зорилго нь түүний оюунлаг шинжид нийцэх ч түүний дүр төрх нь эмэгтэйчүүд ухаалаг “соёлтой” [бас эелдэг гэсэн утгаар], байх ёстой гэх олон нийтийн хэвшмэл хүлээлтэй зөрчилддөг.

2008 оны сонгуулийн өмнө, телевизийн шоуны алдартай хөтлөгч Шагдарсүрэнгийн Гүрбазар, уул уурхайд гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхайн хэлэлцээрүүдийг (2-р бүлэг үз) эсэргүүцдэгийн ард ямар хүсэл, бодол байдаг талаар Занаатай ярилцаж байлаа. Занаа улс төрийн орчны талаар маш сайн мэдээлэлтэй байсан нь ахимагдуу насны эмэгтэйчүүд гэртээ л суудаг, үеэ өнгөрөөсөн, улс төрийг үл ойшоодог гэх хэвшмэл ойлголтыг няцаасан юм. Хууль, улс төрийн талаарх гүн мэдлэгээ хуваалцаж, бас одоогийн хэлэлцэж буй хуулийн хүрээнд уул уурхайн өөрчлөлтийн талаарх санаа бодлоо солилцсоноор Занаа оюунлаг гэдгээ олон нийтэд тод томруун харуулав. Нэвтрүүлгийн төгсгөлд Гүрбазар Занаад талархал илэрхийлээд, түүнийг удирдагч, дайчин, оюунлаг талыг харсандаа баяртай байна гэв. Тэрээр Занааг онцгой бөгөөд бусад хормойгоо чирсэн эмэгтэйчүүдээс өөр байна гэж хэлсэн нь нас ахисан эмэгтэйчүүдийг голдуу хоцрогдсон, мэдээллээс тасархай гэж үзэх эмэгтэйчүүдийг доромжилсон хэвшмэл ойлголтыг бас илэрхийлээд амжсан билээ.

Жендэрийн үзэл баримтлалын гол төлөөлөгчийн хувьд Занаа хуульчид, судлаачид, идэвхтнүүд, улс төрчдөөс бүрдсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орсон юм. Тэрхүү хуулийн төсөл нь удаан хугацаанд яригдсан ярвигтай байсан тул түүнийг батлуулахын тулд Занаа урьд өмнөхөөсөө ч илүү стратегич байх

шаардлагатай байлаа. Энэ нь олон нийтийн дунд “жендэр”-ийн тухай ойлголт нь “карьерист эмэгтэйчүүд”-тэй холбогдож байсан тул, олон нийтийг “намжаах хэрэгтэй” байсан юм. Хуулийн төсөл батлуулах үйл явцыг хянаж байсан Жендэрийн Үндэсний Хорооны нарийн бичгийн дарга, Баасанхүүгийн Энхсайхан надад дараах зүйлийг ярьж билээ.

Хуулийг боловсруулах, лоббидох, батлуулах олон жилийн хугацаанд Занаа эгч ноён нуруу байсаар ирсэн. Бид бүгдийн нэгэн адил тэрээр хуулийн төсөл УИХ-ын чуулганы танхимд очоод унах вий гэдэг болзошгүй эрсдэлд санаа зовж байсан юм. Тэр хуулийг батлуулахын төлөө Занаа эгч яаж ч тэмцэхэд бэлэн байсныг бид мэднэ. Бид лоббидож байхдаа Занаа эгчийг ишрүүлчих вий гэж болгоомжилж байлаа. “Занаа эгч ээ, бид зохирууля, та түр хүлээнээд байж бай” гэж гуйсан. Учир нь бид хүмүүсийн дургүйг хүргэхгүй, уур бухимдлыг нь төрүүлэхгүй, найрсаг байх ёстой байлаа. Өнгөрсөн үеийн жендэрийн талаарх маргааныг дахин сэдэрэхгүй байх хэрэгтэй байлаа (Тэрээр феминизмтэй хольж ойлгож жендэрийг эсэргүүцсэн, болон Занаатай холбоотой маргааныг хэлж байна).

Жендэрийн тэгш байдлын хуулийн гол авторуудын нэг байсан нь Занаагийн гаргасан оюунлаг амжилтуудын нэг юм. Би 2007, 2008 онд Занаа болон бусад хуульчид, идэвхтнүүд, ТББ-ын удирдлагууд, феминистүүдтэй хамт жендэрийн тэгш байдлын хуулийн төсөл боловсруулах, бичих, төлөвлөх хэд хэдэн өдрийн уулзалтад оролцож байлаа. Тэд олон улс орны жендэрийн тэгш байдлын хуулийг судалж, олон улсын экспертүүдтэй зөвлөж, хуулийн заалтууд, нэр томъёоны тодорхойлолт, хуулийн хамрах хүрээг (жишээлбэл, төрийн алба, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөрийн харилцаанд тэгш эрхийг хангах гэх мэт) хамгийн оновчтойгоор тусгахын тулд өөрсдийн мэдлэгийг Монголын хөрсөнд буулгахаар хичээн ажиллаж байв. Занаа хуулийн заалтуудыг тайлбарлахад шаардлагатай жендэрийн онол, бүтцийн болон институцийн талаар хамгийн их мэдлэгтэй байлаа.

Эрэгтэй гишүүд зонхилсон УИХ-д жендэртэй холбоотой асуудлыг хэлэлцэх сонирхол өчүүхэн байх нөхцөлд жендэрийн тэгш байдлын тухай хууль төгс боловсрогдсон бас итгэн үнэмшүүлэх ёстой байв. Учир нь УИХ-ын үнэмлэхүй олонх нь эрчүүд бөгөөд энэ хуулийг батлах ямар ч сонирхол байхгүйн дээрээс төслийг унагах өндөр эрсдэл байлаа. Утга бүрхэг эсвэл өчүүхэн алдаа гаргах л юм бол хуулийг бүхэлд нь унагах эрсдэл үргэлж дагана. Тийм болохоор хууль боловсруулах ажлын хэсэг Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн хэлний мэргэжилтнүүдэд хандан “жендэр” гэх үгийг Монгол хэлэнд хэрхэн орчуулах, тайлбарлах талаар албан захидал хүртэл илгээжээ. Захидлыг Энхсайхан ажлын хэсэгт танилцуулах үеэр би байж таарсан юм. Захидалд “жендэр” гэх утгыг тайлбарласан (жендэр нь эрэгтэй, эмэгтэй шинж чанарын талаарх нийгмийн, соёлын тодорхой ойлголт) бөгөөд Монгол хэлэнд бүрэн утгаар нь нэг үгээр хөрвүүлэх боломжгүй тул жендэр хэмээн галиглан хэрэглэж дадах нь зүйтэй (нийгэмд хэдийнээ жендэр гэх гадаад

үгээр хэрэглэж хэвшсэн байв) гэжээ. (Хуульд жендэр гэх үгийн албан ёсны тайлбар мөн орсон).¹⁴ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг УИХ-аар хэлэлцэх үеэр, удаан хугацаанд хууль тогтоогчоор ажиллаж буй улс төрч Эрдэнийн Бат-Үүл, 10 гаруй жил УИХ-ын гишүүнээр ажиллахдаа хэзээ ч ийм төгс боловсруулсан хууль үзээгүй бөгөөд, хууль тогтоох туршлагын тод жишээ тул тус хуулийг хүн бүхэн уншвал зохино гэж хэлсэн юм.¹⁵

Дараагийн 2012 оны сонгуулийн үеэр Занаа шинээр байгуулагдсан Иргэний Хөдөлгөөний Намын гишүүн болжээ. Тус намаас нийт 38 нэр дэвшигч сонгуульд өрсөлдсөнөөс 36 нь эмэгтэй нэр дэвшигч байлаа. Түүний нэг нь Занаа. Гол хоёр нам сонгуулийн сурталчилгааны орон зайг эзлэхтэй харьцуулахад, шинэхэн улс төрийн намын сонгуулийн сурталчилгаа тун даруухан байв. Бараг л бүхэлдээ эмэгтэй нэр дэвшигчдээс бүрдсэн тус нам хөл хөдөлгөөн ихтэй улс төрийн талбарт “үсрэн орох нь” дан ганц сонгуульд төдийгүй, нийгэмд өргөн утгаараа феминист үзэл санааг дэлгэрүүлэхийг зорьсон мэт.

Оюунлаг алдартан: Уран зохиолоороо санхүүжилт босгосон нь

Ардчилсан нам нэр дэвшигчдээсээ “хандив” (50 сая төгрөгийн) нэхсэнийг улс төрд шинэ хүмүүсийг хязгаарлах арга гэж үзсэн Цэдэвдамбын Оюунгэрэл хандив өгөхөөс татгалзжээ.¹⁶ Хандив өгөхгүй бол АН нэр дэвшигчийн мандат олгохгүй. Гэвч Оюунгэрэл ч байр сууриа өөрчилсөнгүй. Эцэст нь нэрээ нууцалсан хэд хэдэн дэмжигчид тус хандивыг түүний өмнөөс өгчээ. Тэрээр хэн хандивласныг хэзээ ч мэдэж чадаагүй юм. Би 2008 оны сонгуулийн дараахан Хөвсгөл аймгийн тойрогт сонгуульд өрсөлдөж хэдхэн саналаар ялагдсан Оюунгэрэлтэй холбогдлоо. Тэрээр ярилцлага өгөхийг зөвшөөрч, уриалгахнаар намайг гэртээ урилаа. Хөвсгөл аймагт сонгуулийн кампанит ажлынхаа үеэр тэрээр мориноос унаад нуруугаа гэмтээсэн тул гадагшаа гарах боломжгүй байсан юм. Тэрээр нэг их өвдөөгүй боловч, удаан хугацаанд сууж чадахгүй эсвэл өвдөглөж суух, эсвэл хэвтэх шаардлагатай байв.

Оюунгэрэл бид хоёр цай уусны дараа том буйдан, кофены ширээ, номын тавиур, хоёр хүн бүтэн ажиллаж болохуйц компьютер бусад технологи бүхий ажлын хоёр ширээ бүхий саруулхан зочны өрөөнд нь оров. Оюунгэрэл 1990-ээд онд ардчилал өрнөх үеэс улс төрд оролцох болжээ. Тэрээр АН-ын урт хугацааны бодлого боловсруулахад, өдөр тутмын ажлыг хянах, 70 жилийн түүхтэй МАХН-ын сөрөг хүчин болгон бэхжүүлэхэд

¹⁴ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль: https://www.legislationline.org/download/id/4518/file/Mongolia_law_gender_equality_2011_en.pdf. 2020 оны 1-р сарын 12-нд үзсэн.

¹⁵ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг батлуулах лобби, нөлөөллийн ажиллагааны давлагаа нь 2012 оны сонгуульд эмэгтэйчүүдийг дэмжихэд нөлөө үзүүлжээ. Жендэрийн тэгш байдлын талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлсэн нь, бусад олон үр дүнг авчирсан боловч эмэгтэй хүн нэр дэвшихэд зайлшгүй чухал алхам байсан юм. (2012 оны сонгуульд 11 эмэгтэй сонгогдож хууль тогтоогч болсон.)

¹⁶ 2008 оны 12-р сарын 31-ний байдлаар 1 ам.доллар 1267.51 төгрөгтэй тэнцэж байв. 50 сая төгрөг нь ойролцоогоор 39000 ам.доллар байв.

хувь нэмэр оруулсан юм. Оюунгэрэлийн улс төрийн замнал нь нам дотроо ихээхэн амжилттай байсан хэдий ч УИХ-д нэр дэвшихэд хангалтгүй байлаа. Тэр, “Эмэгтэйчүүд дийлэнх ажлыг нь хийж гүйцэтгэдэг ч гэлээ, эрэгтэй улс төрчдийн шатны гишгүүр болох нь түгээмэл” гэв. Гиймээс, тэрээр өөрийгөө өндөр ур чадвартай, өндөр амжилттай хүн гэдгийг олон нийтэд харуулах замаар сонгуульд нэр дэвших боломжоо бүрдүүлж эхлэв.

2002 онд Оюунгэрэл Монголын хэвлэл мэдээллээр гарч, олонд танигдаж байлаа. Тэрээр Стэнфордын их сургуулийн Олон Улсын Бодлого судлалын магистрын хөтөлбөрт тэнцсэн ч сургалтын төлбөр төлөх боломжгүй байжээ. Сургалтын төлбөрөө босгохоор үндэсний хэмжээнд аян өрнүүлэв. Энэ аяныг зарим нь амжилтынхаа төлөө тууштай байна гэж сайшаасан бол, зарим нь улс төрийн пи-ар хийж байна гэж буруутгаж байлаа. Гэвч түүний мессеж нь маш тодорхой байсан юм: “Би мөнгө олох гэж улс төрд ороогүй, харин улс төрд байгаа учраас надад ур чадвараа дээшлүүлэх нэмэлт сургалт шаардлагатай байна” (тэрээр 2004 онд сургуулиа төгсөж, зэргээ хамгаалсан билээ).

2006 онд Оюунгэрэл төрийн болон бизнесийн удирдагчдыг бэлтгэдэг Иелийн Их Сургуулийн Дэлхийн Манлайлагч хөтөлбөрт (Yale University's World Fellow Program) тэнцэн суралцахаар иржээ. Хөтөлбөрийн хүрээнд тэрээр олон нийтэд танигдах стратеги маягаар өөрийнхөө дурсамж, өөрийнхөө сонгосон замналыг хослуулан ном бичих тухай зөвлөмж авчээ. Америкт суралцсан тэмдэглэл (2007a) хэмээн Оюунгэрэлийн анхны ном нь АНУ-ын их сургуулиудад тэнцсэн өөрийнхөө туршлагыг болон тэтгэлэг олох талаар зөвлөгөөг агуулсан ном юм. Номын уншигчид нь гол төлөв Улаанбаатар хотод амьдрах оюутан, сурагчид бөгөөд нэр дэвшихээр төлөвлөж буй Хөвсгөл аймгийн сонгогчдыг татахад төдийлөн тус болсонгүй.

Хөвсгөлийн сонгогчдыг татахын тулд Оюунгэрэл Нүүдэлчний яриа (2007b) гэх хоёр дахь номоо бичжээ. Энэ нь Англи хэлтэн жуулчдад зориулсан ном бөгөөд, өрхийн хэмжээнд үйлдвэрлэсэн бяслаг, цагаан идээ, нэхмэл жижиг бэлэг сэлтийг борлуулах хүсэлтэй Монгол айл өрхүүдэд ч хэрэгтэй ном юм (тус номд жишээлбэл, хөдөө орон нутгийн ялаа нь хотод байдаг шиг бохир биш, хоол хүнсийг бохирдуулдаггүйг тайлбарласан хэсэг хүртэл багтжээ). Тус ном Монголын зах зээлд хамгийн их борлуулагдсан ном болов. Гэвч Оюунгэрэлийн хэлж буйгаар, түүнийг нэр дэвшихэд хангалттай нэр алдар авчирч чадсангүй.

Дараа жил нь Оюунгэрэл Ногоон нүдэн лам (2008) гэх өөрийн гурав дахь номоо нөхөр Жеффри Фолтын хамт 10 гаруй жил бичиж дуусгажээ. Тус ном Оюунгэрэлд улс даяар алдар нэр авчирсан төдийгүй, сонгуулийн кампанит ажлаа эрчимжүүлэх мөнгийг ч авчирлаа.¹⁷ Тус роман 1930-аад онд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт, тэр үед Оюунгэрэлийн гэр бүлд болон

¹⁷ Хэдийгээр номыг хамтран бичсэн боловч, Оюунгэрэл номоо олон нийтэд илүү сурталчилжээ.

Хөвсгөл аймагт орших Даян Дээрхийн сүм орчмын айлуудад тохиолдсон түүхэн баримт дээр суурилсан роман юм. Тус романы гол дүрүүд болох Сэндмаа нь Оюунгэрэлийн төрсөн эмээ (Дэнсмаа гэх жинхэнэ нэрийг бага зэрэг өөрчилсөн), мөн Баасан гэх ногоон нүдэт, бурхан бүтээгч, Даян Дээрхийн сүмийн унзад ламын дүрийг өөрийн элэнц авга ах Баасангийн амьдралаас тус тус сэдэвлэн бүтээжээ.

Оюунгэрэлийн номоо танилцуулах аялал нь албан ёсны сонгуулийн кампанит ажил эхлээгүй үед кампанит ажлын өмнөх бэлтгэл хийх чухал боломжийг олгожээ. Тэрээр Хөвсгөл аймагт аялангаа Ногоон нүдэн ламын талаар ярьж явлаа. Эхний хэвлэл гармагцаа зарагдаж дуусжээ. Тэрээр дараах зүйлийг надад ярьж өгсөн юм.

Тайгад амьдрах хүмүүс мөнгө багатай ч ингэглээ ном авна гэж огт төсөөлөөгүй. Хүмүүс номыг минь худалдан авч буйд баярлаж, “тайгын таван мянга” (тайгад 5000 төгрөгийн хямдрал) гэх хямдрал зарласан юм. Хүмүүс номыг минь авахаар дугаарлан, дуусахаар нь рекламны хувиа хүртэл бүгдийг нь зарав. Залуучууд ихэд шимтэн, шөнөжингөө салахгүй уншаар дуусгасан тухай ярьж хэлж байлаа. Дараагийн ботийг хурдан хэвлээрэй гэсэн цахим шуудан ч байнга ирэх боллоо.

Өмнө нь дурдсанчлан, Ногоон нүдэн лам номын борлуулалтын орлого Оюунгэрэлийн сонгуулийн кампанит ажлын дийлэнхийг санхүүжүүлэв. Ихэнх нэр дэвшигчид эрх мэдэл, эсвэл мөнгө ашиглан олон нийтийн анхаарлыг татдаг байхад, Оюунгэрэл олон нийтийн сэтгэлийг догдлоож сонгогчидтойгоо холбоо тогтоож чаджээ. Ер нь анхнаасаа яагаад роман бичих болсон талаар түүнээс асуувал, тэрээр, социализмаас хойш хэн ч энэ талаар бичээгүй тул би бичихээр шийдсэн гэж хариулсан юм. “Социализмын үед зохиолчдыг төр санхүүжүүлнэ. Харин социализмын дараа хэн ч зохиолчдод мөнгө төлж зохиол бичүүлэхгүй тул бичих хүн ч байхгүй болсон. Ингээд энд орон зай үүсэв” гэж тэрээр нэмж хэллээ. Гэвч энэ нь миний асуултад хариулсан хариултын ердөө зах зух нь байсан юм.

Илүү дэлгэрэнгүй хариулт бид түүний сонгуулийн кампанит ажлын талаар ярилцаж байхад санамсаргүй байдлаар гарч ирлээ. Оюунгэрэл бид хоёр түүний бусад нэр дэвшигчдийн хамт морь унаж, нисдэг тэрэгнээс бууж ирж, машины ачаан дээр зогсонгоо Хөвсгөлийн сонгогчид руу даллаж буй гэх мэт сонгуулийн кампанит ажлынх нь зургуудыг үзэх зуураа түүний өөр зургуудыг бас үзэв. Хар цагаан нэг зурган дээр томоохон цуглааны голд Оюунгэрэл уйлж байна. Тус зургийг 1996 оны оны 9-р сарын 10-ны өдөр буюу Монголд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг анх удаа дурсаж буй өдөр аж. Оюунгэрэл, “сэтгүүлч энэ зургийг дараад сонинд хэвлүүлсэн байсан” гэлээ.

Тэрээр хэлмэгдэгсдийг дурсах үеэр уй гашуудаа автаж байгаа гэх хариулт нь тодорхой байсан хэдий ч “Та яагаад уйлав?” гэж би асууж орхив.

Оюунгэрэл, “Би өвөг дээдсээ өрөвдөөд уйлж байгаа юм” гэлээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг анх удаа тэмдэглэхэд олон нийтийн уй гашуу жинхэнэ тэсэрсэн юм. Хүмүүс өвөг дээдсийнхээ зургийг авчирчихсан, бас тэднийхээ тухай маш их мэддэг юм байна лээ. Тэгсэн манай өвөг дээдсийн араас хэн ч гашуудаагүй. Яагаад гэвэл бид чинь өвөг дээдэс маань ямар хүмүүс байсан гэдгийг ч мэдэхгүй байгаа юм чинь. Би тэгэхэд л ёстой их харамсаж билээ. “Хөөрхий миний өвөг дээдэс. Тэднийхээ тухай мэдэх юм ч байхгүй” гэж бодохоор ёстой ичгүүртэй ч юм шиг.

Түүнээс хойш, Оюунгэрэл өвөг дээдсийнхээ өлгий нутаг Хөвсгөл аймагт байн байн очиж, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэр бүл, удам агсаагаа лавлаж, тодруулах болжээ. Ингээд тэд түүний зохиолын гол дүрүүд болж мөнхлөгдсөн хэрэг.

Оюунгэрэл санамсаргүйгээр өөрийнхөө өвөг дээдсийг ил болгосноор тэрээр өөрийгөө хар цагаан хэл амнаас, ялангуяа “хар пи-ар”-аас хамгаалжээ. “Хүмүүс надад танайх чадалтай ламын удамтай юм байна гэж хэлж байсан, тэр бүү хэл өрсөлдөгчид маань хүртэл надад тэгж хэлж байсан” гэж Оюунгэрэл ярьсан юм. Гэсэн ч Оюунгэрэлийн хүчирхэг өвөг дээдсийн талаарх мэдлэг нь түүний өрсөлдөгчид сөрөг мэдээлэл цацаж сонгогчдын санаа бодолд нөлөөлөх буюу “хар пи-ар” гэгчээс татгалзахад хүргэсэн эсэхийг батлах аргагүй. Өмнөх сонгуулиар түүнийг өөрөөсөө ахмад Америк эртэй гэрлэснийг нь шүүмжилж, буруутгасан зохион байгуулалттай хар пи-арын үр дүнд түүний нэр хүндийг ихээр унагасан билээ. Уламжлалт сэтгэлгээ илүү бат бөх орон нутагт гадаад хүнтэй гэрлэсэн эмэгтэй хүн ард түмнээсээ урвасанд тооцогдоно. Оюунгэрэлээс үргэлж “та яагаад нүүрэндээ галтай нүдэндээ цогтой Халхын сайхан залуу эрчүүдээсээ шилж гэрлэхгүй, хөгшин Америк эртэй суусан юм бэ гэж байнга асуудаг байлаа” хэмээн надад тэр ярьсан юм. Харин 2012 онд Оюунгэрэл хотын тойрогт өрсөлдөхөд байнга л тулгарч байдаг гэрлэлтийнх нь талаарх асуулт бараг ирсэнгүй. Түүнээс хар пи-арыг хэрхэн хааж чадав хэмээн асуухад тэрээр зөвхөн өөрийнхөө материалыг тараах гэх мэт “ганцаарчилсан тоглолт” хийлгүй АН-аас хамт нэр дэвших нөгөө хоёртойгоо “турвал” (түүний тойрог 3 мандаттай байлаа) болж, үргэлжид багаараа сурталчилгаа хийснээр хар пи-араас зайлсхийж чадсан болов уу гэж хариулсан юм. Багаар дагнаснаар ганц Оюунгэрэлийг сугалан авч дайралт хийх аргагүй болжээ. Хамт дэвшиж буй хоёр нь гэр бүлийн байдал нь тогтвортой эрэгтэй хүмүүс байсан тул өрсөлдөгчид нь Оюунгэрэлийн Америк эртэй гэрлэсэн гэх эмзэг цэгт нь хүрч довтлох аргагүй байж. Оюунгэрэл хар пи-арт өртөөгүй нь чухам түүний хүчирхэг өвөг дээдсийнх нь сүнс хамгаалав уу, эсвэл нөлөө бүхий эрэгтэй хамтран нэр дэвшигчид нь хамгаалав уу гэдгийг мэдэх аргагүй билээ.

Бичсэн номынхоо ачаар Оюунгэрэл өөрийгөө улсын хэмжээнд

таниулахад мөнгө зарцуулсангүй (сэтгүүлч, продюсерт мөнгө төлж танигдах туршлага түгээмэл), харин ч мөнгө олжээ. Тэрээр Миссийн тэмцээний бүсгүйчүүд, загвар өмсөгч, эсвэл үзэсгэлэнт эхнэрийн дүрээр бус оюунлаг дүрээр олны танил хүн болж чадсан. Сэхээтэн гэж нийгмийн давхаргыг илэрхийлдэг бол, оюунлаг нь нийгмийн давхаргаас үл хамааран хувь хүний ёс зүйн үнэ цэн, ур чадварыг онцлох ойлголт юм. Оюунгэрэл социализмын үед дарагдуулж байсан эмгэнэлт түүхийг илчлэн роман бичсэнээрээ өөрийгөө ардчилсан үеийн оюунлаг улс төрч болгон харуулсан төдийгүй, социалист төрийн үеийн уламжлал, үзэл суртлын дарамт түүний сонголтод нөлөөлж чадахгүй хэмээн харуулж чадсан. Оюунгэрэлийн уран бүтээлч, зохиолчийн дуу хоолой нь түүний улс төрчийн дуу хоолойноос илүү нөлөөтэй гэдэг нь батлагдаж байлаа (жишээлбэл, жендэрийн квотыг унагахыг эсэргүүцсэн Оюунгэрэлийн тэмцэл нь төдийлөн үр дүнтэй байгаагүй). Тэрээр зохиолчийнхоо нэрээр олсон алдар хүндээ ашиглан намынхаа удирдлагуудыг үнэмшүүлж, нэр дэвших эрхээ авч чадлаа. Тэрээр зорьж төлөвлөсөн эсэхийг хэлж мэдэхгүй ч бусад энгийн сонгогчдоос чанарын хувьд “илүү”-гээс гадна “соёлтой” хүн байх шалгуурыг өөрийнхөө хувьд бүрэн хангаж чадсан юм.

Улс төрчдөөс өгүүлэл болон өөр зүйл бичиж хэвлэх нь элбэг боловч Оюунгэрэл мэргэжлийн уран зохиолын роман бичиж алдаршсанаараа ялгаатай. Улс төрчид (эрэгтэй голдуу) улс төрийн үзэл санаагаа дурсамж маягаар тайлбарлах, улс төр, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар эссе бичих, эсвэл өөрсдийнхөө манлайллын ур чадварыг хувийн болон мэргэжлийн үүднээс тайлбарласан ном голдуу бичдэг. Харин Оюунгэрэлийн роман нь 1990-ээд онд оноос эхэлсэн ардчилсан хувьсгалын эрэл хайгуулыг гүйцэлдүүлэхийн зэрэгцээ болж өнгөрсөн хэлмэгдүүлэлтийн дарагдмал түүхийг илчлэхийг шаардах мэт. Мөн МАХН-ын эсрэг шууд улс төрийн довтолгоо хийхийн оронд, тэрээр уран бүтээлийн нарийн арга ашиглажээ. Ийнхүү Оюунгэрэл уран зохиолын ажлаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдөхөөс (сонгогчдодоо хүлээн зөвшөөрөх, танигдах) гадна сонгогчдын хүсэн хүлээж байдаг оюунлаг шинж чанарыг агуулж чадсан юм.

Бэлгэдлийн капитал ашиглан кампанит ажил явуулах нь: Улс төр дэх шинэ Оюунлаг

Математикт гойд сайн Раднаагийн Бурмаа 1980-аад онд Болгарт Софигийн Технологийн Их сургуулийг электроникийн инженер мэргэжлээр төгсжээ. Монголд буцаж ирмэгцээ тэрээр МОНЭЛ гэх Монголын хамгийн анхны электроникийн компанид ажиллаж эхлэв. Тэнд анх улс орныхоо ирээдүйн талаар нухацтай боддог, чөлөөт, нээлтэй, чинээлэг нийгмийг бүтээх хүсэлтэй инженерүүдтэй танилцжээ. Софид суралцаж байхдаа кофе ууж сурсан Бурмаа, үргэлжид

Монголын дэлгүүрт яагаад кофе байдаггүй юм бол, кофены үр зардаг Зөвлөлтийн дэлгүүрт би яагаад үйлчлүүлэх эрхгүй байна? гэх мэтээр тэр үеийн нийгмээ шүүмжилнэ. “Монголчууд бид эх орондоо байгаа мөртөө манайд үйл ажиллагаа явуулж буй Зөвлөлтийн дэлгүүрээр яагаад орж болдоггүй байна? гэж үргэлж гайхдаг байлаа” хэмээн тэрээр хэлэв. 1980-аад оны сүүл үеэс МОНЭЛ-ын оффис ардчилсан хөдөлгөөний далд оффис болох үед тэрээр ардчилсан хөдөлгөөнд оролцох болжээ. “МОНЭЛ тэр үед Ксерокс машинтай цөөхөн газрын нэг байсан бөгөөд бид Баабарын (1990) өгүүллүүдийг (шүүмжлэлт голдуу) тараахын тулд шөнөжингөө хувилан олшруулдаг байлаа.¹⁸ Бид манай оффистоо л ардчилсан хувьсгалынхаа бэлтгэлийг хийдэг байв” гэж тэрээр надад ярьсан юм.

1990 онд болсон ардчилсан хувьсгалын дараа Бурмаа ТББ байгуулжээ. Түүнийхээр энэ нь яагаад ч юм АН-ын гишүүний хувьд өөрийнх нь улс төрийн ажиллагаанаас үүдэлтэй органикаар бий болсон ажил гэнэ. Тэрээр дараах яриаг хуваалцав.

АН-ыг байгуулсны дараа бид 1990-ээд оны эхээр намын эмэгтэйчүүдийн байгууллага (Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоо) байгуулсан юм. Учир нь бид болон улс төрд болон ардчиллын үйл явцад эмэгтэйчүүдийг олноор нь оруулахыг хичээж байлаа. Бид ямар ч мэдлэг мэдээлэл үгүй тул эмэгтэйчүүдийн байгууллагадаа МАХН-ын эмэгтэйчүүдийн байгууллагын загвараар хийв. АНУ болон Европын орнууд руу аялсныхаа дараа би “иргэний нийгэм” гэх улс төрийн намуудаас хамааралгүй, иргэдийн оролцоонд суурилсан байгууллага ардчилсан нийгэмд хэр чухал байдгийг олж мэдэв. Ингээд буцаж ирмэгцээ “Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд” ТББ байгууллаа. Дахиад олон газраар аялж, сонгууль ажиглах үеэрээ ардчилсан сонгуульд сонгогчид мэдээлэлтэй, мэдлэгтэй байх ёстой гэдгийг ойлгосон. Ингээд буцаж ирмэгцээ, “Сонгогчдын Боловсролын Төв” гэх бас нэг ТББ байгуулсан юм.

Бурмаагийн болон бусад эмэгтэйчүүдийн бүрэлдүүлж байсан иргэний нийгэм нь эмэгтэйчүүдэд ээлтэйгээс гадна тэднийг чадваржуулж байлаа.¹⁹ ТББ-ын удирдагч эдгээр эмэгтэйчүүд шинэ нийгмийг бэхжүүлэх алхмуудыг төрөөс ч урьтаж (Бурмаагийн хувьд улс төрийнхөө намаас урьтаж) харж чадсан байсан.²⁰ ТББ бэхжүүлэх нь өөрсдийгөө өөрчилнө гэсэн үг. Бурмаа ч өөрийнхөө огт мэдэхгүй цоо шинэ салбарт туршлага

¹⁸ Баабар номоо ойролцоогоор 1988 онд Москвад бичсэн боловч, 1990 он хүртэл хэвлэгдээгүй юм (Karplonski 2004).

¹⁹ Социализмын дараах Монголд иргэний нийгмийн хөгжлийн түүхийн талаар нарийн задлан шинжилснийг Төмөрсүхийн Ундарьяа 2018-аас үзээрэй. Ундарьяа эдгээр ТББ-уудын ихэнх нь элитийн үзлийн орон зай, үгүйдээ л нийгмийн хамгийн боловсролтой хэсгийн орон зай болж байна гэж үзсэн. Ундарьяа идэвхтний хувиар илүү том зорилго, хүлээлттэй байв. Нийгэмдээ үйлчлэх шинэ бүлгүүдийг бий болгох, бэхжүүлэхийн тулд өөрийгөө илэрхийлэх шинэ хэлбэр, шинэ нийгэм, соёлын үзэгдэл гэж би үзсэн.

²⁰ Ардчиллын шинэ нийгэмд шаардлагатай институцийг бий болгоход Бурмаагийн цуцалтгүй санаачилга болон нэгдгээр бүлэгт өгүүлсэн социализмын үед МЭХ-ны эмэгтэй удирдагчдын хэрэгжүүлсэн стратеги хооронд ер бусын давхцал байдаг.

хуримтлуулж чадсан. Электроникийн инженерээр ажиллаж байсан тэрээр одоо Англи хэл, хууль тогтоох үйл ажиллагаа, нөлөөллийн ажил, олон нийтэд хүрэх, тэтгэлгийн төсөл бичих, олон улсын байгууллагуудын шинэ орчин зэрэгт хурдан шаламгай суралцаж эхлэв. Эдгээр үйл ажиллагаанууд Бурмаад өөрийгөө улс төрд шинэ оюунлаг төлөөлөгч болгоход тусалсан юм.

Ардчиллын үйл явцын талаарх Бурмаагийн туршлага, мэдлэг нь ялангуяа АН-д маш үнэ цэнтэй байлаа. 1990-ээд оны эрч хүчтэй, хүсэл тэмүүлэлээр дүүрэн намын удирдлагууд АН-д байсан ч гэсэн өдөр тутам засаглах, төрийн бэхжүүлэх тал дээр илүү том, арвин туршлагатай, улс орныг долоон аравны турш удирдаж ирсэн, удирдлагуудаа социализмын үед Зөвлөлт Холбоот Улсад болон Монголдоо бэлдэж байсан МАХН-тай харьцуулахад мэдээж туршлага дутна. 1990 онд МАХН-ын улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, олон намын тогтолцоо Монголд хүлээн зөвшөөрөгдсөн ч гэсэн парламентын анхны хоёр сонгуульд (1990, 1992 онуудад) МАХН ялалт байгуулсан юм. Энэ нөхцөл байдалд, Бурмаагийн бэхжүүлэхээр ажиллаж иргэний нийгэм ардчиллын үйл явцад том зургаараа олон намын өрсөлдөөнөөс ч илүү ач тустай байв. Олон нийтийн дунд ардчиллыг ойлгож эхэлсэн нь АН-ыг хүчирхэгжүүлж, 2004 оны сонгуульд ялалт байгуулахад тусалсан юм.

Иргэний нийгмийг бэхжүүлэх үйл ажиллагаа Бурмааг оюунлаг болгосон. Түүний оюунлаг дүр төрх нь түүний улс төрийн агуулгаар шинэ зам мөр хөөж, шинэ туршлагад суралцсаны үр дүн байлаа. Тэрээр өөрийгөө хөгжүүлэх, өөрийгөө илэрхийлэх, эсвэл тодорхой амьдралын хэв маягийн төлөө л оюунлаг байхыг хичээж байсангүй. Харин түүний зорилго нь ардчиллын институтийг бэхжүүлэх байсан бөгөөд энэ нь түүнийг шинэ мэдлэг, ур чадварт суралцуулж байсан хэрэг.

Бурмаа АН-ын маш үнэ цэнтэй боловсон хүчин байсан хэдий ч, олон улсын донор байгууллагаас ТББ-таа санхүүжилт татахын тулд улс төрийн намаас ангид байх тэдний шаардлагын дагуу намын гишүүнээсээ татгалзжээ. Мөн иргэний нийгмийг бэхжүүлэхэд өөрийнхөө намаас, намынхаа шаардлагаас бас л ангид байх ёстой гэдгийг Бурмаа бас нэмж ойлгосон юм. Учир нь гэвэл 1990-ээд оны эхэн үед, Бурмаа НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Азийн Хөгжлийн Банк болон бусад олон улсын байгууллагуудаас томоохон санхүүжилт авч чадсан юм. Тэгсэн чинь АН-ын санхүүгийн албан хаагчид Бурмаа байгуулж, даргаар нь ажиллаж байсан иргэний нийгмийн байгууллагууд нь АН-ын хүрээнд байгуулагдсан учир Бурмаагийн ТББ-т авсан санхүүжилтийг шууд авч зарцуулах эрхтэй гэж үзлээ. Тиймээс Бурмаа өөрийнхөө байгуулсан байгууллагууд улс төрийн намаас тусдаа байх ёстой төдийгүй, өөрөө ч улс төрийн намаа орхих нь зүйтэй гэж үзэх болжээ.

Бурмаа улс төрөөс явсан нь олон улсын байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдсөн ч улс төрийн намдаа гадуурхагдсан (Иргэний Зориг Намын

дарга Хатагтай Оюуны жишээ үүнд хамаарахгүй) бусад эмэгтэйчүүдийн туршлагыг давтдаг. Улс төрд идэвхтэй байсан эмэгтэйчүүд 90-ээд оноос иргэний нийгмийг сонгожээ. 1990-ээд онд тохиосон Монголын эдийн засгийн хямралын үед ТББ-ууд тасралтгүй санхүүжилт татаж байсан, мөн өөрийнхөө ТББ-ыг харьцангуй эрх чөлөөтэйгөөр удирдаж болдог байсан зэрэг нь улс төрийн идэвхтэй олон эмэгтэйд улс төрийн намаа орхиж, иргэний нийгэмд нэгдэн орох сэдэл боллоо. Энэхүү иргэний нийгмийг чиглэсэн хөдөлгөөн тэдгээр эмэгтэйчүүд улс төрөөс шахагдсан, мөн улс төрд эрчүүд зонхилох болсны нэг шалтгаан болов уу. ТББ-ыг бэхжүүлсэн бусад эмэгтэйчүүдийн адилаар Бурмаа ч танилын сүлжээгээ өргөтгөж, хүлээн зөвшөөрөгдөж, нэр хүндтэй боллоо. Үүнтэй зэрэгцээд тэрээр улс төрийн нам доторх байр суурь, намын нөхдийн ойр харилцаагаа ч алдсан юм.

Нийгмийн тойрог, ба нийгмийн сүлжээ

УИХ-ын сонгуульд нэр дэвшихээр шийдсэнээр Бурмаа АН-ын харьяалал, болон иргэний нийгмийн удирдагчийн аль алиных нь давуу талыг зэрэг биш ч гэлээ хүртэх боломжтой болжээ. Тэрээр 2008 оны сонгуулийн өмнө АН-д дахин элсэж орлоо (иргэний нийгмийн байгууллагын зарим гишүүд таагүй хандаж байсан нь гарцаагүй). АН Бурмаад сонгуульд өрсөлдөх мандат олгожээ. Бурмаа оюунлаг, иргэний нийгмийн удирдагч, энгийн иргэдийн дуу хоолойг хүргэгчийн имиштэйгээр өрсөлдөв. Бурмаа 1990-ээд оны сүүлээр ТББ-аа бэхжүүлэх зорилгоор АН-ыг орхиж, 2008 онд намдаа буцан орох зуураа өөрийн танилын сүлжээг алдаж, улс төрийн намын дотоод орон зайд харийн хүн болсон мэт мэдрэмж төржээ.

Бурмаад өрсөлдөгчөөсөө давах, эсвэл улс төрийн ойрын холбоотнууд бий болгохын тулд сонгуулийн кампанит ажилд хангалттай мөнгө цацах санхүүгийн нөөц байгаагүй тул, тэрээр иргэний нийгэмд зүтгэсэн туршлага, түүний өөрийн бий болгосон үнэт зүйлд найдахаас өөр арга байсангүй. Пьер Бурдьегийн (1993, 7) тодорхойлсон шинж чанарын дагуу, Бурмааг илэрхийлэх үнэт зүйлс нь хуримтлагдсан нэр хүнд, алдар цуу, шударга байдал, бас түүний гүйлгээ ухаанд суурилсан мэдлэг мэдрэмж, хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэрэгт төвлөрдөг. Нэр хүнд, хүндэтгэл, бахдал зэрэг нь ихэнх улс төрчдийн, ялангуяа сонгуульд нэр дэвшигчдийн хүслэн болсон үнэт зүйлс билээ. Эдгээрийг мөнгөөр худалдаж авч, эсвэл кампанит ажил өрнүүлснээр олж авах боломжгүй тул Бурмааг нэр дэвшигчийн хувьд илэрхийлэх үнэт зүйлс нь түүнийг бусад өрсөлдөгчөөс ялгаруулж байлаа.

Төрийн бус байгууллага байгуулсан, танилын сүлжээтэй, өндөр боловсрол эзэмшсэн бусад нэр дэвшигчдээс ялгаатай нь Бурмааг илэрхийлэх үнэт зүйлс нь түүнийг УИХ-ын сонгуульд өрсөлдөхөөр шийдсэнээс өмнө нь ч байсан юм. Дараагийн хэсэгт би Бурмааг илэрхийлэх үнэт зүйлсийг гурван хэсэгт хуваав, үүнд: түүнд нийгмийн сүлжээ гэхээс илүүтэй нийгмийн тойрог, ирээдүйн амлалтаас илүүтэй өнгөрсөн нийтийн дурсамж, зөвхөн

цалин орлогоос илүүтэй, алдар хүндийг эрхэмлэдэг гэх мэт. Ихэнх нэр дэвшигчид сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр ч тэр, бусад үед ч тэр өөрсдийгөө дэмжигчдийн суурь, нийгмийн сүлжээг бэхжүүлэхийн төлөө ихэд чармайдаг билээ. Эдгээр нийгмийн сүлжээнүүд гол төлөв нутгийн зөвлөл, ангийн хамт олон, хамаатан садан гэх мэт аль хэдийнээ байдаг сүлжээнд суурилах (Sneath 2018) боловч, сонгуулийн кампанит ажлын агуулгаар идэвхжих шаардлагатай болдог. Анхан шатанд ажиллах төрийн албан хаагчид төрийн үйлчилгээ, тусламжийн багц, ажлын байр зэргийг хянадаг тул хороо, баг гэх мэт засаг захиргааны нэгжид суурилсан нийгмийн сүлжээ нь нэр дэвшигчдэд илүү ашигтай. Эдгээр бүлэгт хамаарах гишүүд нь аль нэг улс төрийн нам, улс төрчид үнэнчээ харуулахын тулд кампанит ажлын үеэр зохицуулагч мэт ажиллана. Маш олон нэр дэвшигчид, нэр дэвшихээр горилогчид эдгээр хүмүүст илүү сайхан ирээдүйг амлах, тодорхой үйлчилгээнд хамруулах, эсвэл цалин олгох гэх мэтээр өөртөө үнэнч байлгахыг хичээнэ. Тиймээс энэ нь нэр дэвшигч, эсвэл нэр дэвшихээр горилогч талаас санаачилсан, шаталсан, харилцан болзол бүхий харилцаа юм. Өөрөөр хэлбэл, эдгээр нь Монгол Улсын эдийн засаг, төрийн үйлчилгээг төрөл бүрийн шүүлтүүр, сувгаар ашиглах сонирхлын хүрээнд сонгуулийн агуулгаар бий болсон албан бус сувгууд билээ (2-р бүлэг үзнэ үү).

Бурмаа сонгуулийн зорилгоор иймэрхүү төрлийн нийгмийн сүлжээ үүсгэсэн ч гүй, ашигласан ч гүй. Харин түүнд инженерээр ажиллаж байхдаа, ТББ бэхжүүлж явахдаа, мөн улс төрчийн хувиар бий болгосон хэд хэдэн нийгмийн тойргууд байсан юм. Нийгмийн сүлжээнд нэр дэвшигч нь шаталсан харилцааны хамгийн дээр байдаг бол Бурмаа янз бүрийн нийгмийн тойргуудынхаа эгэл гишүүн нь байсан юм. Нийгмийн сүлжээ сонгууль угтан бий болдог бол, Бурмаагийн нийгмийн тойргууд сонгууль, нэр дэвшигчээс үл хамааран, туршлага, нөхөрлөл дээр тулгуурлан байгуулагдсан бөгөөд оршин тогтнох сэдэл нь ч өөр билээ.

Хэн ч нэр дэвшигчид туслах, хандив өгөх зэрэг тодорхой үүрэг хүлээхгүй. Эдгээр тойргийн гишүүдийн хоорондын холбоо нь сонгуультай эсвэл Бурмаатай ашиг сонирхлын холбоогүй байсан ч Бурмаагийн сонгуулийн сурталчилгааны зорилгоор цугларчээ. Мэдээж хэрэг, нийгмийн тойрог нь тойргийнхоо гишүүнийг нэр дэвшиж буйг дэмжих зорилгоор нийгмийн сүлжээ болон өөрчлөгдөж болно. Гэвч Бурмаагийн хамрагддаг аль ч тойрог нь шууд ашиг сонирхол дээр суурилсан, харилцан нөхцөл бүхий нийгмийн сүлжээ болон хувирсангүй. Бурмаагийн хамрагдах тойргууд түүнийг нэр дэвшигчийн хувиар хэрхэн дэмжиж байсныг Бурмаагийн сонгуулийн сурталчилгааны нээлтийн жишээн дээр тайлбарлая.

Бурмаагийн анхны кампанит ажил 2008 оны 6-р сарын 2-ны өдөр эхэлсэн юм.²¹ Тус нээлтийн ажиллагаа Улаанбаатар хотоос гадна байх хүүхдийн сувилалд боллоо. Бурмаагийн сонгуулийн тойргийн 1000 орчим сонгогч тус

²¹ 2008 оны сонгуулиас гадна, 2012, 2016 оны УИХ-ын сонгуулиудад ч Бурмаа өрсөлдсөн юм.



Дүрс 5.2. Бурмаа сонгуулийн кампанит ажлын үеэр. Улаанбаатар хот, 2008 он. Зохиогчийн дарсан зураг

сувилал руу автобусаар хүргэгдсэн юм. Түүнээс гадна поп дуучид, хошин урлагийнхан, яруу найрагчид гэх мэт олны танил хүмүүс, шагнал хүртсэн багш, соён гэгээрүүлэгч болон Бурмаагийннайз нөхөд, ажлын хамт олон гэх мэт түүний ойрын дэмжигч 300 орчим хүн цуглажээ. Тэдгээр хүмүүс Бурмаагийн өөрийн бий болгосон нэр хүнд, хүлээн зөвшөөрөгдөх, хүндлэл хүлээх байдлыг сонгогчдод таниулах, тэдний саналыг татах зорилгоор тэнд очсон хэрэг (дүрс 5.2).

Бурмаагийн олон салбарыг хамарсан, мэргэжлийн карьерынх нь төрөл бүрийн үед таарсан, танилцсан хүмүүс тайзан дээр гарч, түүнийг магтах төдийгүй заримдаа мөнгөн хандив өгч байх аж. Тэд Бурмааг янз бүрийн мэргэжлийн салбарын өнцгөөс тайлбарлах нь түүнийг оюунлаг, бүтээлч нэр дэвшигч болохыг сонгогчдод таниулахад тусалж байв. Өөр өөр бүлгийн эдгээр хүмүүс тайзан дээр нэг нэгнийхээ араас гарч, өөрсдийгөө танилцуулж, Бурмаатай ямар харилцаатай болохоо тайлбарлаж, ажлын түүхээсээ хуваалцах нь Бурмаатай хувь хүнийх нь хувьд ч, нэр дэвшигчийнх нь хувьд ч шинээр танилцах боломж олгож байлаа. Энэ нь түүний хамт олны үнэлэмж, дурсамж дээр суурилсан юм.

Ихэнх нэр дэвшигчид, өөрийн нэр дэвшиж буйг сурталчлахын тулд өөрсдийн багш, ментор зэрэг олны танил хүмүүсийг авчирч сурталчилгаандаа оролцуулах эрмэлзэлтэй байдаг. Харин Бурмаагийн кампанит ажил арай өвөрмөц, ялгаатай нь бүлэг бүр Бурмаагийн онцлогийг өөр өөр байдлаар илэрхийлэх замаар түүнийг сонгогдохуйц болгон харуулж байв. Бүлэг бүр өмнөх бүлгийнхээ Бурмаагийн талаар ярьсан зүйлсийг улам баяжуулсаар

Бурмаагийн онцлог шинжийг улам илүү тодруулна. Энэ нь ч урьдаас төлөвлөсөн зүйл биш байсан төдийгүй олон хүний ярианаас хамгийн дурсамжтай зүйлсийг өөрсдийн үзэмжээр сонгон сонсох сонгогч олонд маш сайн ажилласан гэж болно.

Хамгийн эхний дэмжигчдийн бүлэг нь иргэний нийгмийн төлөөлөл байлаа. Тэд “Ихэнх хүмүүс манай Бурмааг Иргэний Бурмаа (Иргэний Нийгмийн Бурмаа гэдгийн товч хувилбар) гэдгээр нь таних байх аа” гэнэ. Энэ бүлэг нь хэвлэл мэдээллийнхэн, хотын оршин суугчид, АН гэх мэт бусад бүлэгтэй харьцуулахад янз бүрийн хүмүүсээс бүрдсэн бүлэг билээ. 2008 онд Монголд иргэний нийгмийн дуу хоолой маш хүчтэй байсан. Хамгийн боловсролтой, хүсэл тэмүүлэлтэй хувь хүмүүсээс бүрдсэн, хурц бодол, хүчтэй дуу хоолой бүхий иргэний нийгэм том агуулгаараа гол улс төрийн намуудаас ч илүү нөлөөтэй байсан гэвэл худал хэлсэн болохгүй.²²

Тайзан дээр гарсан дараагийн бүлэг нь залуу мэргэжилтнүүдээс бүрдсэн бөгөөд Хүүхдийн Бурмаагийн талаар ярилаа. Тэд ЮНЕСКО-гийн Нэг Ертөнц чуулга уулзалт (UNESCO's One World Forum), Дэлхийн Залуучуудад Зориулсан Мини Парламент (Mini Parliament Global Citizenship for Youth) зэрэг Бурмаа 1990, 2000-аад онд зохион байгуулж байсан залуучууд, хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрт оролцсон туршлагаасаа хуваалцана. Цугласан олон дунд зарим хүмүүс “Түүнийг Боловсролын Бурмаа гэдгээр нь ч олон хүн мэднэ шүү дээ” гэх зэргээр ярих нь түүний үнэ цэнийг улам онцолж буй хэрэг юм.

Болгарт их сургууль төгссөн гэдгээр нь Бурмааг Болгарын Бурмаа гэх бөгөөд Монголын Болгарт суралцагсдын дэмжлэгийг татахад нөлөөлөв. Энэ бүлэг нь дунд эргэм насны, эмэгтэйчүүд голдуу мэргэжилтнүүдийн бүлэг байх бөгөөд олны өмнө Бурмаагийн сонгуульд хандивын мөнгө гардуулжээ. Энэхүү анхны уулзалтын дараа сайн дурынхан гарч ирж, сонгуулийн сурталчилгааны үеэр байнга уулзалдаж байсан бөгөөд тараах материалыг шалгах гэх мэт хамгийн хариуцлагатай бөгөөд хүнд хэцүү ажлыг гардан гүйцэтгэсэн юм. Сонгогчдын хувьд Бурмаа гадаад улсад дээд боловсрол эзэмшсэн нь, ялангуяа Хүйтэн дайны үеийн хамгийн өндөр хөгжиж, орчин үежсэн, социалист холбоотон болох Зүүн Европт төгссөн нь чухал байсан төдийгүй, сонгогчдын хүлээлтэд ихэд нийцэж байв.

“Бидний хувьд түүнийг МОНЕЛ-ын Бурмаагаар нь илүү танина” гэж 40, 50-аад насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэн дараагийн бүлэг хэллээ. Бурмаа Болгарт төгсөж ирээд МОНЕЛ-д анх ажилласнаар МОНЕЛ-ын Бурмаа болжээ. Эндээс эхэлсэн нөхөрлөл нь түүний хувьд онцгой, дурсамжтай, удаан хугацаанд хадгалагдаж байгаа аж. 1980-аад онд, Монгол Улс социалист дэглэмтэй байх үед байгуулагдсан анхны электроник үйлдвэрлэлийн компани, МОНЕЛ тухайн үед голдуу гадаадад төгссөн,

²² Идэвхтний хувьд Ундаръяа (2018) санхүүгийн хүнд байдал, засгийн газрын дэмжлэг сул зэргээс болж Монгол дахь иргэний нийгмийг хүчгүй хэмээн үздэг. ТББ-ын ертөнцөөс гадуур байдаг хүний хувьд би, хэдийгээр ийм бэрхшээлүүд бий боловч иргэний нийгмийн ололт амжилт нь баялаг бөгөөд удаан хугацааны үр дүнг авчирсан гэж дүгнэж байна.

хамгийн ухаалаг инженерүүдийг ажилд авч байлаа. “1980-аад оны сүүл үед манай компани дөнгөж эхэлж байсан ардчилсан хөдөлгөөний нууц “цэг” болсон бөгөөд дарга маань шөнө дунд бид юу хийдгийг огт мэдээгүй дүр эсгэж байсан, ухаалаг хүн байлаа. Бид түүнд нь талархахын зэрэгцээ, өдрийн ажлыг хэзээ ч алдагдуулж байгаагүй” гэж Бурмаа цугласан олонд яриу. “Бурмаа ардчилсан хөдөлгөөнийг тодорхойлоход бидний журмын нөхөр байсан тул түүнийг Ардчиллын Бурмаа гэж болмоор” гэж дэмжигчдийн нэг хэллээ.

Иргэний, хүүхдийн, боловсролын, Болгарын, МОНЕЛ-ийн, ардчиллын Бурмаа гэх тодотгол дээр нэмээд “52-ын” (түүний төгссөн ерөнхий боловсролын сургуулийг хэлж байна), дарга, сэхээтэн, шударга гэх мэт тодотгол ч шинээр гарч ирэв. Кампанит ажлын эхэнд, Бурмаагийн хувь хүний намтар, түүний эзэмшсэн ур чадвар, гаргасан амжилтыг нэг талбар дээр харуулж чадсан. Монгол хэлэнд нэр дэвших гэдэг үг нь хэн нэг хүн нэрээ өргөх гэсэн утгатай бөгөөд чухам энэ арга хэмжээ нэр дэвших гэдэг утгатайгаа гойд нийцсэн арга хэмжээ болсон юм. Энэ арга хэмжээ нь Бурмаагийн өнгөрсөнд болон одоо хийж буй ажил, түүний танигдахуй, нийгэмд эзлэх байр суурийг нь онцолсон үйл явдал болсон тул түүний нэрийг өргөсөн өргөн хүрээний арга хэмжээ болсон гэлтэй.

Цуглуулагчид, бие халаагчид, болон дагалдагчид

Сонгуулийн кампанит ажлын хамгийн ачаалалтай ажлын нэг нь сонгогчидтой хийх уулзалт билээ. Эдгээр уулзалт нь нэр дэвшигч энгийнээр тойргийнхоо зах худалдааны төвөөр алхаж, сонгогчидтой яриа өрнүүлэхээс өгсүүлээд асар том тайз засаж, мөнгөөр авч болох зугаа цэнгэлийн хамгийн өндөр түвшинд хүртэл янз бүрийн хэлбэртэй байна. Сонгуулийн кампанит ажил сонгогчдыг татахын тулд чадварлаг яруу найрагчид, рок попын одод, кино жүжигчид гэх мэт олны танил хүмүүсийг хамруулахыг хичээнэ. Нэр дэвшигчид аварга том тоглолтын танхим түрээсэлж, салют буудуулах, тайзны утаа ашиглах, хийн бөмбөлөг нисгэх, жигд хувцас бүхий хөгжөөн дэмжигчид хөлслөхөөс гадна олон тооны өнгөт дэлгэц ашиглан өөрсдийгөө харуулна. Сонгуулийн кампанит ажилд нэр дэвшигчийн танилцуулга материал тараах, гудамж талбайгаар явж нэр дэвшигчээ сурталчлах сурталчилгааны ажилчдаас гадна сонгогчидтой хийх уулзалтад оролцож, олон хүн цугласан мэт харагдуулах замаар бусад сонгогчдын анхаарлыг татах “хуурамч” сонгогчдыг ч мөн ажиллуулдаг.

Дүүргийн АН-ын хорооноос Бурмаа болон түүнтэй хамт нэр дэвшигч буй хоёр нэр дэвшигчдийн (Элбэгдорж, Баярсайхан) сонгогчидтой хийх уулзалтад залуу, эмэгтэй хөтлөгч ажиллуулжээ. Нарийн цагаан хослолын өмд, зузаан ултай өсгийг өмсөж, нүүрээ цэвэрхэн будсан урт үстэй бүсгүй сэтгэл татам байдлаар ярихдаа зарим талаар нэг нэр дэвшигчдийг нөгөөдүүлээс нь онцолно. Сонгуулийн сурталчилгааны дунд үеэс хөтлөгч

бүсгүй харагдахаа больсон нь тэрээр өөр хаа нэгтээ илүү өндөр цалинтайгаар хөтлөгчийн ажил хийхээр болсон ажээ. Дүүргийн АН-ын хороо хөтлөгч бүсгүйг орлох хүн хайсан оролдлого нь бүтэлгүйтэж, нэр дэвшигчид уулзалтаа хөтлөгчгүйгээр хийх хэрэгтэй боллоо. Үүнээс хойш, нэр дэвшигч бүр уулзалтын үеэр хувийн тоглолт хийхийг эрмэлзэх болсноор багийн ажиллагаа бага зэрэг бүдгэрч эхэлсэн юм.

Нэр дэвшигч бүр өөрийн хувийн сонгуулийн штаб, сурталчилгааны багтай байв. Сурталчилгааны ажилчид гол төлөв их, дээд сургуулийн оюутнууд болон бусад залуус байх бөгөөд сонгогчидтой хийх уулзалтын үеэр сурталчилгааны ажил хийх боломжоо олж авна. Тэд ойр хавийн оршин суугчдыг цуглуулж, нийтийн алхалт зохион байгуулж, нэр дэвшигчийн танилцуулга материалыг тараахын сацуу нэр дэвшигчдийнхээ талаар эерэг үг, сэтгэгдэл түгээнэ. Сурталчилгааны ажилчдын хийх ажил нь урт хугацааны туршид үүрэг амлалт, сахилга бат, хичээл зүтгэл шаардах тул хангалттай олон ажиллах хүч олох нь маш хэцүү. Мөн, сонгуулийн сурталчилгааны дийлэнх хугацаа нь их дээд сургуулийн шалгалтын үетэй давхцана.

Бурмаагийн сурталчилгааны ажилчдын дийлэнхийг түүний 1990-ээд онд зохион байгуулж байсан ЮНЕСКО-гийн Нэг ертөнц чуулга уулзалтад болон Мини Парламент зэрэг хөтөлбөрт хамрагдсан суралцагчид, тэдний танилууд бүрдүүлж байлаа. Одоо бүгд амжилттай мэргэжилтэн болсон эдгээр залуусын хэд хэд нь оролцсон хөтөлбөрийнхөө талаарх дурсамжаа надад бахдалтайгаар хуваалцсан бөгөөд зарим нь тэдний амьдралын хамгийн сайхан мөчүүдийн нэг гэж хүртэл ярьж билээ. Тэд Бурмаад талархсандаа, найз нөхдийн хувиар, болон гоё дурсамжаараа дахин аялахын тулд туслахаар иржээ. Эдгээр хүмүүсийн адилаар, Бурмааг шууд дэмжигчид түүний кампанит ажилд ямар нэг санхүүгийн болон бусад хувийн ашиг хонжоо хайж ажиллаагүй юм. Миний мэдэх ихэнх нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажилд ажиллаж буй хүмүүс нэг бол нэр дэвшигч нь сонгогдсоны дараа өөрт нь ирэх ашиг тус эсвэл нэмэлт орлого олох боломж гэж харж байсан бол Бурмаагийн дэмжигчдэд иймэрхүү төрлийн сонирхол бараг л байгаагүй юм. Нэмэлт орлого олох сэдлээр ажиллаж буй хүмүүс ихэнхдээ төрөл бүрийн нэр дэвшигчдийн сурталчилгааны ажлыг хооронд нь харьцуулж уулзалт, хурал, өдрийн хоолны үеэр алдаг оног ярина. Тэд бусад нэр дэвшигчдийн сурталчилгааны ажилд ажиллаж буй найз нөхөдтэйгөө утсаар ярьж иймэрхүү мэдээлэл цуглуулна. Тэд мөн бусад нэр дэвшигчид ямар үйл ажиллагаа зохион байгуулж, юу амлаж, ямар материал тарааж буйг Бурмаагийн сурталчилгааны ажилчдад (болон надад) нуулгүйгээр ярьж өгчээ. Бурмаагийн сурталчилгаанаас ашиг хүртэх гэж ирсэн хүмүүс төд удалгүй бусад нэр дэвшигчдийн сурталчилгааны ажил илүү өндөр төлж буйг мэдмэгцээ алга болно. Гэсэн хэдий ч Бурмааг дэмжигчид түүнийг ур чадвар, оюун ухаан, ёс зүйн үнэт зүйлсээрээ гарцаагүй УИХ-д сонгогдох ёстой гэж үзэх тул чин сэтгэлээсээ дэмжихийн сацуу, түүнийг сонгуулахын төлөө сайн дураараа ажиллах нь нэр төрийн хэрэг гэдгээ

хэнээс ч нуудаггүй билээ.

Бурмаа энэ зуур сурталчилгааны ажилчдадаа эелдэг, хүндэтгэлтэйгээр хандаж байлаа. Тэрээр сурталчилгааны багийнхандаа илүү сайн өдрийн хоол, өдөр тутмын хэрэгсэл, нэмэлт цэвэр ус, шоколад, борооны цув хүртэл авахад сонгуулийн санхүүжилтээсээ илүүчлэх бөгөөд, түүний сурталчилгааны багийнхан нь аль хэдийнээ хэтрээд буй сонгуулийн зардалд нэрмээс болж байна хэмээн санаа зовно. Бурмаа тэдэндээ зууш бэлдэх, машины зогсоол дээр яриа өрнүүлж саатаад гэх мэтээр хэд хэдэн удаа төлөвлөсөн уулзалтаасаа хоцорсон юм. Бурмаагийн багийн зарим хүмүүс түүнийг ажилчдадаа хэт их анхаараад, өөртөө болон нэр дэвшигчийн хувиар гүйцэтгэх үүрэгтээ төдийлөн анхаарал тавихгүй байна уу даа хэмээн санаа зовж байлаа. Гэвч Бурмаа сурталчилгааны ажилчдадаа хамгийн сайн туршлага, дурсамжийг үлдээхийн тулд ихэд хичээж ажиллаж байсан юм.

Нөгөө талаар, сурталчилгааны баг өөрсдийнхөө хариуцах үүргийг илүү сайн ухамсарлаж, кампанит ажилд нь хувь нэмрээ оруулахаар чин сэтгэлээсээ хичээж байлаа. Тэд өөрсдийн санаачилга, уран сэтгэмжээр “цуглуулагчид”, “бие халаагчид”, “дагалдагчид” гэх мэт бүлгүүдэд хуваагджээ. 2008 оны сонгуулиар нэг тойргийн нийт сонгогчид өмнөх 2004 оны сонгуулиас бараг гурав дахин ихсэж, тойрог нь томорсон. Энэ нөхцөлд нэр дэвшигчид сонгогчидтойгоо биечлэн уулзах нь тун хэцүү болж, өдөрт 5 хүртэл хорооны иргэдтэй л уулзаж чадаж байлаа (энэ сонгуульд кампанит ажилд хэвлэл мэдээллийн хэрэгсэл урьж хожид байгаагүйгээр ихээр ашиглагдсан талаар 3-р бүлэгт өгүүлсэн). Хамгийн хэцүү сорилт нь уулзалтад оролцох хангалттай олон тооны сонгогч авчрах. Сонгогчдыг авчрах нь кампанит ажлын багийнхны үүрэг бөгөөд хотын захын хүний төвлөрөл багатай, зуслан голдуу хэсэгт сонгогчид аврах нь үнэхээр хэцүү даалгавар байлаа. Ихэнх цуглааны талаарх мэдээлэл нэг хөршөөс нөгөөд, амаас ам дамжин хүрэх бөгөөд уулзалтын зарыг машинтай, явган сурталчилгааны ажилчид чанга яригчаар зарлан гудамжаар алхана. Нэр дэвшигчид сонгогчдыг татахын тулд алдартай жүжигчдийг уулзалтдаа байлцуулах боловч мөнгөний дутагдалтай Бурмаа сурталчилгааныхаа ажилчдад л найдахаар өөр аргагүй билээ.

Энэ тохиолдолд, “цуглуулагчид” зах, гудамж, худаг гэх мэт газруудад голдуу болох сонгогчидтой хийх уулзалтын товыг зарлан, иргэд, сонгогчдыг ирж оролцохыг хүснэ. Сонгогчид уулзалт болох газарт цуглаарх зуур “бие халаагчид” гэх хоёрдугаар бүлгийнхэн сонгогчдыг уйдаахгүйн тулд зугаацуулна. Энэ нь Бурмаа өөр газарт уулзалт хийх, эсвэл уулзалт болох газар ирж байх зуур ирсэн сонгогчид буцаж явахаас нь сэргийлж буй хэрэг юм. Ингээд “бие халаагчид” тайзан дээр буй жүжигчдээс дутахгүй ур чадвартай болжээ. Тэд Бурмаагийн сонгуулийн кампанит ажлын хөтөлбөрийг харилцан яриа хэлбэрээр олонд хүргэхдээ хошин, хөгжилтэй үг яриа нэмэх нь сонгогчдын сэтгэлийг хөдөлгөнө.²³

Дараа нь “цуглуулагчид” дараагийн гудамж, айлууд руу очиж уулзалтын зарыг үргэлжлүүлэн түгээх зуур, “бие халаагчид” сонгогчдыг уйдаахгүйхэн шиг уулзалтад бэлдэнэ. Харин гуравдугаар бүлэг буюу “дагалдагчид” Бурмаагийн хамт уулзалтад хүрэлцэн ирнэ. Бурмаа “дагалдагчдын” хамт өмнөх уулзалтаас ирэхэд дараагийн сонгогчдын “бие халж” Бурмааг сонсох, гүн гүнзгий асуулт хариулт өрнүүлэхэд бэлэн болжээ. Хамтын ажиллагаа, уран сэтгэмж, ижил зорилгоор нөхөрлөсөн сурталчилгааны ажилчид зохион байгуулалтын болон олны өмнө ярих ур чадвараа хөгжүүлэхийн зэрэгцээ өөрсдийн оюунлаг байдлаа харуулсан юм. Сурталчилгааныхаа багийн ажилтнуудтай “яриа өрнүүлж зогсох нь” ямар ч утгагүй мэт санагдах боловч, түүнийг дэмжигчдийн заримынх нь хувьд, ялангуяа шинэ үеийн оюутан залууст дурсамжтай, урам хайрласан, сэтгэл хөдлөм дурсамж бий болгожээ. Эргээд харахад Бурмаа 1990-ээд онд ЮНЕСКО-гийн Нэг Ертөнц чуулга уулзалт, Дэлхийн Залуучуудад Зориулсан Мини Парламентын төгсөгчдөд тухайн үед төрүүлж байсантай ижил төстэй дурсамжийг сонгуулийнхаа сурталчилгаанд оролцож буй залуучуудад бас төрүүлж чадсан байх.

Санхүүжилт: Эмх замбараагүй байдлын эсрэг гарын авлага

Бурмааг илэрхийлэх үнэт зүйлсээс гадна түүнд хувь нэр дэвшигчийн сурталчилгаа, болон Бурмаа, Баярсайхан, Элбэгдорж гурав хамтдаа нэр дэвшиж буй сонгуулийн тойргийн АН-ын хорооны багийн сурталчилгааны ажилд зарцуулах мөнгө хэрэгтэй байлаа. Тараах материал, зурагт хуудас, түүний зурагтай футболк, сайн дурынхны өдрийн хоол, гадаа болох хотын захын хорооллын сонгогчидтой хийх уулзалтад зориулж хуванцар сандал гээд нэхэмжлэх ар араасаа цувран ирсээр байв. Гэрэл зурагчид, зурагт хуудас, самбар, хүлээн авалт, эфирийн цаг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа цацахад мөн ихээхэн зардал хэрэгтэй.

Бурмаагийн хувийн сурталчилгааны зардал маш тодорхой бөгөөд ойлгомжтой байлаа. Гэвч АН-ын штабаас (АН-ын сонгуулийн төв штаб болон дүүргийн намын хороо) ирж буй нэхэмжлэх нарийн задаргаагүй тул маш ойлгомжгүй байх аж. Хамгийн гол нь, Бурмаа хэдийгээр тэдгээр төлбөрийг төлж байсан ч, дүүргийн намын хорооноос авсан ажилчдын цалинг Бурмаа төлөцхөггүй байна гэдэг цуу яриа түгэх нь тэр. Бурмаа дүүргийн сонгуульд ажиллаж буй ухуулагчид, ажилчдын цалинд өгсөн мөнгө нь холбогдох эзэндээ хүрээгүй байх гэж таамаглав. Ингээд Бурмаа дүүргийн сонгуулийн штабаас санхүүгийн тайлангийн талаар асуухад түүнд хариу ирсэнгүй. Сонгууль болж өнгөрснөөс нэлээд хугацааны дараа дүүргийн сонгуулийн штаб үйл ажиллагаагаа зогсоосон тул түүний өөрөөсөө төлсөн санхүүгийн талаар тодорхой хариу өгөх боломжгүй гэсэн хариу иржээ.

²³ Бурмаагийн сонгуулийн хөтөлбөр нь ерөнхийдөө дээд боловсролыг сайжруулах, уул уурхайн орлогоос иргэдэд хуваарилах, ураг төрлөө дэвшүүлэх, авлига, үр бүтээмж багатай байдалтай тэмцэж, эрх зүйт ёсонд суурилсан үр бүтээлтэй парламентын тогтолцоог хөгжүүлэх зэрэгт төвлөрч байлаа.

Энэ нь ялангуяа Бурмаад маш хэцүү байлаа. Сонгуулийн экспертийн хувьд тэрээр иймэрхүү сонгуулийн тодорхойгүй байдлыг бууруулах, сонгуулийн санхүүжилтийг ил тод байлгах эрх зүйн орчныг бий болгохын төлөө шаргуу ажилласан билээ. Энэ төрлийн бүрхэг зүйлээс сэргийлэхийн тулд тэрээр, сонгуулийн кампанит ажил зохион байгуулагчдад зориулсан гарын авлага хүртэл бүтээж байхад, түүний төлсөн мөнгө ухуулагчдадаа очоогүй нь хувь тавилангийн шоглоом гэлтэй. Тэрээр Сонгогчдын Боловсролын Төвийн дарга байсныхаа хувьд системийг нь засах гэж хүмүүсийг нь ёс зүйтэй сургах гэж байсан ч эдгээр систем, хүмүүс нь түүнийг сүйрүүлжээ.

Энэхүү зүй бус байдалтай холбоотой байдал нь сонгууль бүрийн цаана илүү өргөн хүрээний, өөр төрлийн өрсөлдөөн байдгийг харуулдаг. 2008 оны сонгуулийн дараа хүчирхийлэл, эмгэнэлт үйл явдал тохиов. Бурмаа сонгууль зохион байгуулах гарын авлагадаа ялангуяа сонгуулийн эргэлзээ, луйвраас урьдчилан сэргийлэх талаар тодорхой оруулсан нь түүний бусадтай зүйрлэшгүй сонгуулийн туршлагыг харуулдаг. Тиймээс 2008 оны 7-р сарын 1-ний өдрийн сонгуулийн дараах бослогын үеэр таван иргэний амь насаа алдсан нь сонгуульд хөндлөнгөөс оролцсон хамгийн эмгэнэлтэй тохиолдол байсан тул хуулийн тэмцлийг үр дүнтэй хийснээр цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх төдийгүй хүний алтан амийг ч хамгаалах боломжтой байсныг илэрхийлдэг.

1990-ээд оны сүүл үеэс хойш сонгууль бүрээр Бурмаа болон түүний багийнхан хэд хэдэн гарын авлага, тараах материал боловсруулсаар ирсэн. УИХ-ын сонгуультай холбоотой хамгийн онцлом хоёр гарын авлага нь Сонгууль Зохион Байгуулахад Зориулсан Гарын авлага, болон Сонгууль Ажиглагчийн Гарын Авлага зэрэг болно (Вигмаа 2008, 2012). Ялангуяа 2008 оны гарын авлага онцгой ач холбогдолтой. Тус гарын авлага ерөнхийдөө сонгуулийн кампанит ажилд, ялангуяа менежерийн түвшнийхэнд зориулагджээ.

2008 оны УИХ-ын сонгууль: Сонгууль Зохион Байгуулахад зориулсан гарын авлага (Вигмаа 2008) жишээлбэл, нэр дэвшигчид, кампанит ажлын ухуулагчид, менежерүүд, сонгууль зохион байгуулагчид, улс төрийн намууд болон бусад сонгууль зохион байгуулахтай холбоотой бүхий л оролцогч талуудыг зураглажээ. 18 бүлэг бүхий тус гарын авлагад, сонгууль зохион байгуулах захиргааны байгууллагууд, нэр дэвшигчийн болон улс төрийн намын кампанит ажил, медиа мониторингийн болон сонгууль ажиглагчдын үүрэг, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн өдөр, санал тоолох гэх мэт сонгуультай холбоотой бараг бүх л ойлголтыг хамарчээ. Гарын авлагад нарийн зөвлөмж зааварчилгаа туссан нь сонгуулийн луйвар, зохион байгуулалтын алдаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэгджээ. Тус гарын авлага хууль, дагалдах журмуудыг ил тод болгож, өдөр тутам тохиолддог аливаа үйл явдлуудыг хуулийн агуулгаар хэрхэн өөр өөрөөр тайлбарлагчийг харуулсан юм. Тус гарын авлага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхээс

эхлээд, сонгуулийн санал тоолох хүртэлх сонгуулийн бүх үе шатанд сонгуулийн луйвраас урьдчилан сэргийлэх стратегийг тусгажээ. Тухайлбал, тус гарын авлагад сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх шатанд гарч болох 19 төрлийн зөрчлийг дурджээ. Эдгээрээс дурдвал сонгогчдыг хэд хэдэн дүүрэгт давхар бүртгэх, зарим хорооллыг бүртгэлээс хасах гэх мэт.

Энэ болон бусад гарын авлагууд нь кампанит ажлын ажилчдад сонгуулийн хууль, сонгуулийн сурталчилгааны зохицуулалт, тойргийн хэмжээ, хэвлэл мэдээллийн зохицуулалт, болон УИХ-ын сонгууль бүрээр өөрчлөгддөг байсан хуулийг таниулахад чухал үүрэгтэй байсаар ирсэн. Сонгууль бүрд бий болдог хэт их стресс, кампанит ажлын эмх замбараагүй байдал зэргийг мэдэх тул Бурмаа гарын авлагаа хуулийн чухал хугацаануудыг тодруулсан хуанли маягаар, мөн хийх ёстой ажлын жагсаалтын хамт хэрэглэхэд хялбар байдлаар боловсруулжээ. Бурмаагийн намын маш олон хүмүүс түүний гарын авлагыг аль эрт захиалсан байлаа. АН-ын хувьд сонгуулийн луйвраас болж олон саналаа алдаж байсан түүхтэй тул өндөр сонор сэрэмжтэй байх нь маш чухал гэж Бурмаа ярьж байв. “Хэн ч сонгуулийн луйврын хохирогч болох боломжтой. Санал хураалтаас өмнө л нэр дэвшигчид луйвар бол урьдчилан таамаглах аргагүй бөгөөд сонгуулийн аль ч үе шатанд нуугдаж байж болно гэдгийг ойлгох ёстой” гэж Бурмаа тэмдэглэжээ. Бурмаагийн гарын авлагаас хамгийн анх авсан хүмүүс нь ихэнхдээ өмнөх сонгуулиудаар сонгуулийн луйврын улмаас хохирч байсан намынх нь нөхөд байлаа. Дараа нь бусад улс төрийн намууд, ялангуяа МАХН гарын авлагаас нь олон ширхэг авчээ. Бурмаа гарын авлагынхаа ач холбогдлыг тайлбарласаар байсан тул АН ч гэсэн олон ширхэг худалдан авч улс орон даяар сонгуулийн штабуудаар тараав. Тус гарын авлага нийтдээ 10000 хувь борлогджээ. Номын борлуулалтаас олсон мөнгө нь Бурмаагийн сонгуулийн санхүүжилтийн гол эх үүсвэр болж, тэрээр эрхэлдэг томоохон бизнесгүй, эсвэл томоохон бизнес эрхлэгчид өр тавилгүйгээр сонгуулийнхаа санхүүжилтийг босгож чадсандаа баяртай байлаа.

Луйврыг нь илчилсэн 2008 оны сонгуулиас 2012 оны сонгууль хүртэл

2008 оны сонгууль бусад сонгуулиас өөр байлаа. 6-р сарын 30-ны өдөр МАХН-ын сонгуулийн ялалтыг эсэргүүцсэн жагсагчид Улаанбаатар хотын төв Сүхбаатарын талбайн дэргэд байх намын байрны гадаа цугларчээ. Жагсагчид МАХН-ыг сонгууль луйвардсан хэмээн буруутгаж байлаа. Бурмаа сонгуульд ялаагүй бөгөөд тэрээр өөрийнхөө саналыг хулгайлагдсан гэж (тэрээр хожим нь шууд бусаар ч болтугай үүнийгээ нотолж байсан) итгэж байв. Жагсаал болж буйг мэдмэгцээ Бурмаа сонгуулийн багийнхантайгаа хамт өөрийн аргументыг дэмжиж буй сонгогчдын гарын үсэг цуглуулахаар хүрч очив. Бараг л сонгууль бүрийн дараа сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн жагсаал, цуглаан болж байдаг тул Сүхбаатарын талбайд

цугласан олон гойд сонин үзэгдэл байсангүй. Бурмаа Иргэний Хөдөлгөөний хэд хэдэн удирдагчтай жагсаалын үеэр уулзсаны дараа, тэрээр багийнхнаа гэрт нь яаралтай хариулав. Жагсаал ч өргөжсөөр байлаа.

Маргааш нь гэхэд жагсаал цуглаан нь үймээн самуун, дээрэм тонуул болж хувирав. 7-р сарын нэгний шөнө дунд цагдаа нар цугласан олныг тарааж чадаагүй тул, Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр дөрвөн өдрийн турш онц байдал зарласнаас олон нийтийн арга хэмжээнд хорио тавигдаж, гудамжаар цэргийнхэн холхилдож эхлэв (дүрс 5.3). Тэр шөнө Засгийн газар зэвсэгт хүчин авчирч, жагсагчдыг хүчээр тарааж эхлэх үеэр таван хүн амиа алджээ. 800 гаруй хүн саатуулагдаж, тэдний хагас нь хожим 7 хүртэлх жил хоригдох ял шийтгүүлсэн юм (Delaplache, Kaplonski, and Sneath 2008). Харамсалтай нь дийлэнхэд нь улс төрийн сэдэлтэй хэргээр бус, хулгай, дээрэм гэх үндэслэлээр хэрэг үүсгэжээ. Хожим нь Ерөнхийлөгч Энхбаяр, Элбэгдорж нар саатуулагдсан хүмүүсийн дийлэнхэд нь өршөөл үзүүлсэн. Гэвч, улс төрийн хэрэгт цагаатгах тохиромжтой зохицуулалт хомс байсан аж. Хүний эрхийн зөрчил, цагдаа нарын мөргөлдөөний мөрийг баллахын тулд засгийн газар хүч хэрэглэн жагсаал тараах үедээ өргөн нэвтрүүлгийн томоохон сувгуудыг хаажээ. Үймээний шалтгаан, мөн чанарын талаарх яриа, үймээнийг дарахад засгийн газар, цагдаагийн байгууллага түргэн шуурхай хариу үзүүлж чадаагүй байдал үймээний үеэрх болон дараа нь гарсан хүний эрхийн зөрчлүүд сонгуулийн дараа анхаарч авч үзэх хамгийн чухал асуудал болсон юм (Oleinik 2012; Undarya 2009). Үймээний дараа саатуулагдсан хүмүүсийг хавчиж, мөрдөж байсан нь олныг айдастай, шуугиан гаргахгүй байхад хүргэв.



Дүрс 5.3. Хол хорионы үед цэргийн техник гудамжаар явж буй нь. 2008 оны 7-р сарын 2-ны өдөр. Улаанбаатар хот. Зохиогчийн дарсан зураг.

Долоодугаар сарын эхний хэдэн өдрийн үймээний үеэр Бурмаа АН-ын төв байранд очжээ. Элбэгдорж болон АН-ын удирдлагууд телевизэд яриа өгөөд завгүй байлаа. Бурмаа өөрийнх нь санал хулгайлагдсан талаар (Баярсайхан, Элбэгдорж нар сонгуульд ялж, Бурмаа ялагдсан юм) Элбэгдоржид хэлжээ. Хариуд нь Элбэгдорж сонгуульд ялагдсандаа гомдоллохын оронд гудамжинд гарч саатуулагдсан, хилсээр буруутгагдсан хохирогчдод тусалбал яасан юм, иргэний нийгмийн удирдагч, хүний эрхийн мэргэжилтэн, эмэгтэй хүний хувьд энэ чиний хийх ёстой ажил биш үү гэжээ. Бурмаа хулгайлагдсан саналынхаа талаар хууль, шүүхэд хандахаар төлөвлөж буйгаа хэлбэл, Элбэгдорж ингээд нэг их олигтой үр дүнд хүрэхгүй болов уу хэмээн анхааруулжээ.

Хулгайлагдсан саналаа эргүүлэн авахад нь ямар нэг байдлаар туслахыг хичээгээгүй АН-ын удирдлагад Бурмаа бухимдав. Ингээд тэрээр сонгуулийн луйврыг батлахаар ажиллаж эхэллээ. Эцэст нь Бурмаа олон нийтэд сонгуулийн луйврыг анхааруулахыг эрмэлзсэн, хилс хэрэгт буруутгагдаж буй жагсагчдын гэм буруугүйг нотлох нь хамгийн зөв зам байсан гэж надад ярьсан юм.

Луйврыг илчлэх гэхээр өрсөлдөгч улс төрийн хүчин (МАХН) төдийгүй Бурмаагийн өөрийн намаас (АН) ч саад тотгор ирж байсан тул маш хэцүү байжээ. Олон мандаттай том тойрогт, нэр дэвшигчид эсрэг намынхантайгаа өрсөлдөхөөс гадна өөрийн намаас нэр дэвшиж буй хамтрагчидтайгаа ч өрсөлдөх шаардлага тулгардаг. Бурмаагийн хувьд хамтран нэр дэвшигч Элбэгдорж, Баярсайхан нар сонгуульд ялсан нь түүний нөхцөлийг улам хүнд болгож байв. Хэрэв түүний гомдол, шалгалтын хүрээнд өөрийнх нь намын гишүүдтэй холбоотой зөрчил (МАХН-аас гадна) илрэх аваас түүнд хэд хэдэн түвшинд улам халгаатай болох байлаа. Хэрэв ингэвэл АН-ын нэр хүнд унаж, Бурмаа АН-аас гарч, тэр бүү хэл түүний намын зарим гишүүн түүний эсрэг хөдөлж ч болзошгүй байв.

Сонгуулийн дараа МАХН, АН эвслийн засгийн газар байгуулахаар хэлэлцээрт хүрлээ. Энэ нь АН, ялангуяа АН-ын дарга Элбэгдоржийн хувьд сонгуулийн саналыг дахин тоолох Бурмаагийн оролдлогыг дэмжих ямар нэг сонирхол байхгүй болохыг илэрхийлнэ. АН ямар нэг булхайгүй, шударгаар өрсөлдсөн, МАХН луйвар хийсэн гэж үзсэн ч гэлээ түүнийг нь илчлэх сонирхолгүй болсон гэсэн үг. Хоёр нам өрсөлдөгчид биш холбоотнууд боллоо. Хожим нь Бурмаа холбогдох албаны хүмүүст хандан архивд хадгалагдаж буй өөрийнхөө тойргийн сонгогчдын саналыг дахин тоолохыг хүссэн ч архивд түүний хүссэн материалууд байхгүй гэсэн хариу авчээ.

Бурмаа санал зөөсөн (өөрийнх нь саналыг өөр нэр дэвшигч дээр тоолох) гэдгийг нотолж чадаагүй боловч сонгууль ерөнхийдөө луйвартай болсон гэдгийг нотлох боломжтой байлаа. Бурмаагаас гадна түүний

тойрогт нэр дэвшсэн өөр улс төрийн намын хэд хэдэн нэр дэвшигчид иргэдийн саналын хуудсыг дахин тоолох хүсэлт гаргасан ч ямар нэг хариу авсангүй.²⁴ Бурмаа ч сонгуулийн луйврын эрлээ үргэлжлүүлж, нотлох баримтуудыг хэсэг хэсгээр нь цуглуулсаар байв.

Нягт нямбай мөшгөсний эцэст Бурмаа өрсөлдсөн сонгуулийн тойргийнх нь 8 хэсгийн хороонд 1114 саналыг буруу тоолсон, санал тоолох нэгдсэн хүснэгтэд цагааруулсан, харандаа ашигласан, баллуурдсан, мөн саналын нийлбэрийг баталгаажуулахын өмнө хамгийн багадаа 2 хэсгийн хорооны санал нэг өдрийн турш “алга болсон” гэх мэт санал тоолохтой холбоотой олон зөрчил илрүүлжээ. Ерөнхийдөө тус сонгуулийн тойрогт өрсөлдсөн таван нэр дэвшигчийн 152-10597 саналын хооронд буруу тоолсон байна.²⁵ Түүнчлэн, Бурмаа СЕХ-ны дарга Батаагийн Баттулга 2008 оны 6-р сарын 29 буюу сонгуулийн өдөр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгогч Иргэний үнэмлэхээ ашиглан санал өгч болох тухай хууль бус зарыг түгээснээс болж энэ бүх санал буруу тоолох нөхцөл үүссэн гэж үзэж байв. Бурмаа СЕХ-ны даргад сонгуулийн үеэр иймэрхүү өөрчлөлт гаргах эрх байхгүй тул тус зарлал нь хууль зөрчсөн гэж түүнийг буруутгаж байлаа. Мөн, бүртгэлгүй сонгогчдын тоо эрс нэмэгдсэн нь “хот, суурин газруудад сонгуулийн үр дүнд мэдэгдэхүйц нөлөөлсөн” гэж үзсэн юм.²⁶

Бурмаа эдгээр болон бусад материалыг хавсарган нэхэмжлэх үүсгэхэд аль ч шүүх хэрэг үүсгэн хэлэлцэхээс татгалзаж байсан тул Бурмаа захиргааны өөр өөр түвшний, өөр өөр шүүхээс бүрдэх хуулийн тогтолцоотой бүхэлд нь тэмцэхээр шийджээ. 2008 оны намаржингаа, Бурмаагийн хандсан хуулийн байгууллага бүр нэг бол түүний нэхэмжлэхэд зарга үүсгэхээс татгалзаж, нэг бол түүнийг өөр шүүх рүү хандуулж байлаа. Бурмаа анх захиргааны хэргийн хэд хэдэн шүүхэд ханджээ. Ямар ч үр дүн гарахгүй байсан тул, Үндсэн Хуулийн Цэцэд хандсан байна. Үндсэн Хуулийн Цэц Бурмааг Улсын Дээд Шүүх рүү явахыг зөвлөжээ. Бурмаа Улсын Дээд Шүүх рүү очвол, Үндсэн Хуулийн Цэц рүү хандахыг зөвлөв. Бурмааг ийш тийш нь, гол төлөв Үндсэн Хуулийн Цэц, Улсын Дээд Шүүх хоорондоо нааш, цааш явуулсаар хэдэн сар өнгөрсний дараа Улсын Дээд Шүүх Бурмаагийн нэхэмжлэхийг аль ч шүүх авч хэлэлцэхгүй тул нэхэмжлэхээ зогсоохыг хүсжээ. Энэ үед Бурмаа иргэний хувьд хуулийн этгээдээр хамгаалуулах үндсэн хуулиар хамгаалуулсан эрхтэй тул хэрэв аль ч шүүх түүний нэхэмжлэхийг хэлэлцэхгүй аваас, хуулийн тогтолцоо түүнийг хэргийг нь хэлэлцэх

²⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл. Л.Одончимэд, Ц.Ганхуяг, Р.Бурмаа, 2008 оны 7-р сарын 18 (Раднаагийн Бурмаагийн хувийн архив).

²⁵ Сонгуулийн Ерөнхий Хороонд гаргасан өргөдөл. Раднаагийн Бурмаа. 2008 оны 7-р сарын 21 (Раднаагийн Бурмаагийн хувийн архив).

²⁶ Улсын Дээд Шүүхийн иргэний шүүхийн 188-р хэргийн хяналтын сонголт. 2009 оны 4-р сарын 14 (Раднаагийн Бурмаагийн хувийн архив).

²⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт: Иргэн Бурмаагийн нэхэмжлэхийг бүх шатны шүүхээс хэрэгсэхгүй гэж үзсэн хэргийн зүйлчлэлийн талаарх сонголт (Раднаагийн Бурмаагийн хувийн архив).

ямар нэг шүүхээр хангах ёстой гэж мэдэгдэв.²⁷ Түүний нэхэмжлэхийг хэлэлцэж болох ганц газар үлдсэн нь иргэний хэргийн шүүх байлаа. Хоёр сар орчим хугацаа өнгөрсний дараа Бурмаа ялжээ. Иргэний хэргийн шүүхээс Баттулга хууль зөрчсөн нь (сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй иргэд санал өгөхийг зөвшөөрсөн) сонгуулийн үр дүнд нөлөөлсөн тухай тогтоол гаргажээ.²⁸ Маргааш өглөө нь (2009 оны 1-р сарын 5-ны өдөр) Баттулга хэвлэлийн хурал зарлаж Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын албан тушаалаас огцорч буйгаа мэдэгджээ.

Энэ ялалтаар Бурмаа 2008 оны сонгуульд луйвар орсон гэдгийг нотолсон боловч, өөрт нь өгсөн санал хулгайлагдсан гэдгийг нотолж чадсангүй. Тэрээр сонгууль луйвартай байсан гэдгийг эсэргүүцсэн тэмцэгчид, 2008 оны сонгуулийн дараах 7-р сарын 1-ний өдрийн жагсаал үндэслэлгүй зүйл байгаагүй гэдгийг харуулахыг хүсэж байсан тул энэ ялалт түүнийх хувьд чухал байлаа. Засгийн газар үймээнийг хүчээр тарааж, маш олон гэм зэмгүй хүмүүс баривчлагдаж, шүүн таслагдсан. Бурмаа шүүхтэй амжилттай тулалдсан нь тэдгээр яллагдагчаар татагдсан жагсагчдын ялыг хөнгөлөхөд тусалсан гэж итгэж байсан юм.

Бурмаа 2008 оны сонгууль луйвартай болсныг шалгасан явдал нь хоёр том намд бас сонин байдлаар ашиг тусаа өгчээ. АН-ын дарга Элбэгдоржийн хувьд үймээн самуунд уруу татсан гэх улс төрийн ялаас чөлөөлөгдсөн гэж болно. Хуулийн дагуу УИХ-ын гишүүд нэгэнт тангараг өргөсөн бол сонгуулийн үр дүнг хүчингүй болгох аргагүй. Элбэгдорж эвслийн засгийн газрын нэг хэсэг болсон тул сонгуулийн үр дүнг үнэнд ойртуулахын тулд саналыг дахин тоолох, хуулийн зохицуулалттай тэмцэх сонирхол тун бага байсан гэж болно.

Үймээнийг дарахдаа хүч хэрэглэсэн, хүний эрхийг зөрчсөн, зэвсэгт хүчин ашигласнаас таван хүн амиа алдсан эмгэнэлт явдал болсноос шалтгаалан МАХН-ын нэр хүнд ихээхэн унав. Гэвч АН-тай хамтран ажилласнаар МАХН жагсагчдын эсрэг үйлдсэн хүчирхийллийн хариуцлагыг тэднээс нэхэх бодит хүчийг өөрийнхөө талд оруулсан билээ. “Дараагийн сонгуульд АН ногоон гэрлээр ялна” гэж хүмүүс ярилцацгааж байлаа. Бурмаа 2008 оны сонгуулийн луйврыг баталгаажуулж чадсанаар 2009 оны ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Элбэгдорж ялахад тусалсан юм. Улс төрийн ялаас чөлөөлөгдсөн Элбэгдорж бусад өрсөлдөгчөөс ялангуяа МАХН-ын нэр дэвшигчээс илүү давуу талтай байлаа. Шинэ ерөнхийлөгчийн хувиар Элбэгдорж өршөөл үзүүлэх тухай хууль санаачилж, жагсаалын үеэр баривчлагдсан ихэнх хүмүүсийг өршөөлд хамруулж, шоронгоос сулласан юм (Oleinik 2012).

Иргэний нийгэмд ажиллах үүрэг амлалтынхаа мөрөөр намын гишүүнчлэлээс татгалзаж, намын нөлөө маш бага болсон байсан Бурмаагийн хувьд, сонгуулийн луйврыг илчилсэн нь нь түүний нэр

²⁸ Улсын Дээд Шүүхийн иргэний шүүхийн 188-р хэргийн хяналтын сонстол. 2009 оны 4-р сарын 14 (Раднаагийн Бурмаагийн хувийн архив).

хүндийг нам дотор ихээхэн өсгөжээ. 2012 оны сонгуулийн өмнө тэрээр сонгуулийн хуулийг шинэ улс төрчид, эмэгтэйчүүд, бизнесгүй хүмүүст ээлтэй болгон өөрчлөхөд АН талаас манлайлан оролцож, төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан юм. 2012 онд тус хууль өөрчлөгдөж сонгуулийн тогтолцоог холимог болгосон бөгөөд иргэд тойргийнхоо нэр дэвшигчид болон намын жагсаалтад тус тус санал өгөх боломжтой болсон юм. Бурмаа намын жагсаалтын дээгүүр хамгийн эхэнд бичигдсэн эмэгтэй болсон (Элбэгдоржийн зааварчилснаар). 2012 оны сонгуульд 11 эмэгтэй гишүүн УИХ-д сонгогдсон нь 2008 онд 3-хан эмэгтэй сонгогдсонтой харьцуулахад огцом өсөлт бөгөөд тус сонгуулийн хууль эмэгтэйчүүдэд илүү ээлтэй байсныг харуулдаг.

Дүгнэлт: Оюунлаг байдал сүйрүүлэх хүч болох нь

Энэ бүлэгт ардчилсан улс төр, арилжааны шинжтэй болсон сонгуулийн кампанит ажил бүхий шинэ орчин нөхцөлд оюунлаг нь хэрхэн идэвхижиж, жендэртэй холбоотой ойлголт болсныг харууллаа. Сэхээтэн гэх нийгмийн давхаргыг илэрхийлэх ойлголттой зарим талаар сууриараа холбогдсон боловч, оюунлаг нь ардчилагдах үйл явц, хувь хүн, жендэрт суурилсан нөхцөлд сэхээтнээс ялгаатай ойлголт билээ. Хэдийгээр яруу найрагчид, зохиолчид, эрдэмтэд, урлагийнхан гэх мэт маш олон төрлийн хүмүүсийг оюунлаг гэж тодорхойлж болох боловч Монгол Улс неолибералчлагдахын хэрээр энэ нь нийгмийн давхаргад тооцогдох боломжгүй болсон юм. Социализмын үед сэхээтнүүд тусдаа хангамж эдэлдэг, ааш байдал, амьдралын хэв маяг нь онцлогтой байсан нь нийгмийн давхаргад тооцогдож байсан бол ардчиллын үед энэ байдал алга болжээ. Гэвч оюунлаг байдал төрөл бүрийн хэлбэрээр үргэлжлэх болсон нь Монголд болсон шилжилтийн үеийн олон янзын нюансыг илэрхийлдэг.

Сэхээтнүүд, социалист төр хоёр МАХН-ын үзэл суртлын агуулгыг бүтээж, ард түмэнд нөлөөлөхөөр бие бие харилцан бэхжүүлж байлаа. Сэхээтнүүд нам-төр болон ард иргэдийн хоорондын нягт харилцааг хадгалахад тусалдаг байв. Викамситын (2020) үзэж буйгаар, сэхээтнүүд төрийн үзэл суртлын агуулгыг үйлдвэрлэх үүрэгтэй байсан тул социализмын үед хамгийн гол байр суурь эзэлдэг. Тэдний ажил нь үзэл санааны уран яруу үг хэллэг, бодит байдал хоорондын зөрүүг харагдахгүй байлгаснаар нийгмийн болзошгүй дургүйцлийг хянахад тусалдаг.

Тиймээс, 1980-аад оны сүүлээр сэхээтнүүд энэхүү зөрүүг ойлгож эхэлснээр Монголд ардчиллын үйл явц эхэлсэн нь хоржоонтой хэдий ч гэнэтийн зүйл байсангүй. Зөвлөлтийн дэлгүүрээс кофе авах нь бүү хэл орох ч эрхгүй Бурмаа мэтийн хүмүүс, хөгжил, цэцэглэлтийн тухай хий хоосон уран зөгнөл мэт ярианд эргэлзэх болсон хүмүүс 1980-аад оны үеэс нам-төрд шүүмжлэлтэй хандаж эхэлжээ. Үнэхээр илүү эрх ямба, давуу байдал эзэлж байсан нийгмийн давхарга гэнэт алга болбол юу болох вэ? Миний судалгаанд

хамрагдаж буй эмэгтэй нэр дэвшигчид Монголын төрд бий болсон нарийн ширийн шинж ихтэй, олон талт өөрчлөлтүүдийн тод жишээ юм гэдгийг номынхоо энэ бүлэгт өгүүллээ. Эдгээр эмэгтэйчүүдийн туршлагаас харахад сонгуульжилт бол зөвхөн өөрсдийнхөө эрхийн төлөө өргөжүүлж, мөнхжүүлж буй төдийгөөр хязгаарлагдахгүй. Харин сонгуульжилт нь түүний үндсэн институц, үнэт зүйл, холбоо, эдийн засаг зэргийг агуулах улс орны үндэс суурийг дахин бүрдүүлэх тухай асуудал билээ.

2008 оны сонгуулийн луйврыг баталснаар, Бурмаа өөрийнхөө хосгүй туршлагыг хуулийн хүрээнд нотолж чадсан юм. Тэрээр тууштай хөдөлмөрийн үр дүнд рентгений аппарат мэт ажиллаж үндэсний хууль, шүүхийн тогтолцооны гажгийг илрүүлэв. Тэрээр 7-р сарын 1-ний жагсаал нь жагсагчдын улс төрийн хүсэл эрмэлзэлд суурилсан жагсаал байсан гэдгийг харуулж чадсан. Түүнчлэн, Бурмаа жагсагчдыг хожим нь зөвтгөж болох улс төрийн үндэслэлээр яллаж болох байтал дээрэм, хулгайн гэмт хэргээр ялласан нь шүүх хэргийг буруу ангилсан болохыг харуулж чадсан юм.

Занаа чинээлэг нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны уулзалт дээр дөрөөлж, тогтсон албаны үг яриагаар улс төрийн эрсдэлийг зайлуулах гэж оролддог уйтгартай кампанит ажлын хэв маягийг өөрийн хурц яриа хэлээр эвдэж, өөрийн гайхалтай дүр төрхийг онцолж чадсанаараа улс төр, бизнесийн бүлгүүдэд л үйлчилдэг шахуу кампанит ажлын хэвшмэл тогтолцоонд шинэ өнгө авчирсан юм. Бусад нэр дэвшигчдийн бараг л очдоггүй шахуу автобусны зогсоол, явган хүний гудамж зэрэг цэгүүдэд ажиллаж сурталчилгаа хийх нь “цөхөрсөн сонгогчидтой холбоо тогтоож, ёс суртахууны төлөвшилийг сурталчилж” (Klumbyte 2014, 474) буй мэт.

Тэрээр кампанит ажлынхаа үеэр улс төрийн дотоод асуудлыг илчилж байснаараа чанга яригч, шүгэл үлээгчийн үүрэг гүйцэтгэж байлаа. Тэрээр өөрийн уур цухал гэх мэт сэтгэл хөдлөлөө ашиглан нийгэмд буруугаар өрнөж буй гэж бодсон асуудлуудаа бусдад анхааруулах улс төрийн мессеж болгон ашиглахын зэрэгцээ, бусдын цөхрөлийг ч ухамсарлаж байгаагаа илэрхийлж чаддаг.²⁹ Тэрээр тойргийнхоо орхигдсон болон, хүнд өвчтэй олон айлаар зочилсон. Тэдэнтэй уулзах үеэрээ орон нутгийн засаг захиргааг хатуухан донгодож, үг яриа, хүсэлт нь холбогдох хүндээ хүрдэггүй, хүрсэн ч анхаардаггүй тэдгээр эмзэг бүлгийнхний сулхан дуу хоолойг чангаар хүргэж чадаж байлаа. Ингэхдээ елдэг байдал, зан чанар дээд давхаргынханд л буй гэж үздэг байсан гэх мэт хэвшмэл ойлголтыг хурц үг хэл, сэтгэл хөдлөлөө удирдах замаар эвдэж байв. Түүний үсээ үзүүр гарган зассан байдал, дэгжин хувцаслалт нь түүнийг өөрийгөө хянаж чаддаг бөгөөд хаа нэгтээ, магадгүй улс төрд үүсээд буй олон асуудлыг цэгцлэхэд бэлэн гэх улс төрийн мэдэгдэл мэт илэрхийлэгддэг гэлтэй. Хэдийгээр харизм гэх үгийг бүгдэд ашиглаж болох цор ганц тодорхойлолт үгүй, олон хэлбэрээр илрэх боловч (Scale-Collazo 2012), Занаагийн харизм нь бусдад нөлөөлж, бусдыг хөдөлгөх

²⁹ Орос, Зүүн Европт гадуурхагдсан хүмүүсийн дунд олон талаар цөхөрсөн туршлага бишгүй бий. Хамфри 2002, Клумбит 2014, Райс 1997.

чадвараар тодорхойлогддог. Тэрээр өөрийнхөө биеэ авч яваа байдал, дохио зангаа, харагдах байдлаа хянаж чаддагаа харуулахын зэрэгцээ өөрийн мэдрэмж, байдлыг чөлөөтэй илэрхийлж чаддаг.

Шинэ оюунлагууд нь эрх мэдэлд хүрэхийн тулд өгөгдсөн орон зайд шилжилт хийж чаддаг төдийгүй, Монголын нийгмийг илүү шударга, хүмүүнлэг, ардчилсан нийгэм болгохын тулд өөрсдийн итгэл үнэмшлийн дагуу шинэ орон зайг бий болгож чаддаг бие даасан, хувь хүмүүс билээ. Бурмаа шүүх тогтолцооны гажуудлыг ил болгож, өөрийнхөө нэхэмжлэхийг шүүх байгууллагаар хангахыг шаардаж байсан нь сонгууль бидний бодож буйгаас хамаагүй том үзэгдэл байж болохыг ойлгоход тусалсан юм. Эдгээр эмэгтэйчүүд неолиберализмын түрэмгий шаардлагуудыг даван туулахад өөрсдийн ур чадвар, үнэт зүйлсээ ашиглаж, арилжааны шинжтэй болсон сонгуулийн кампанит ажлын эсрэг тэмцэхдээ эрх мэдэл, танигдахуй, үнэт зүйлсээ ашиглах орон зайг шаардаж чадсан эмэгтэйчүүд билээ. Эдгээр эмэгтэйчүүдийн хувь сонгогдохуйц байхын тулд тогтолцоогоо дагаж мөрдөх бус, харин тогтолцоог өөрчлөх, нураах хэрэгцээ үүсдэг. Зарим талаар эдгээр эмэгтэйчүүд бүтээхийг хүсдэг, зорьдог тогтолцоондоо сонгогдохуйц эмэгтэйчүүд билээ.

6

Биеэ бэлдэх нь: Нэр дэвшигчийн дотоод болон гадаад дүр төрх

Хувиргалт

Энэхүү номын удиртгал хэсэгт би УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хүйсийн квотыг 30 хувь болгох чин хүсэлтэй байсан Лэгцэгийн Ариунаатай ярилцах үеэр УИХ-ын суудлын төлөө өрсөлдсөн эмэгтэй нэр дэвшигчдийн туршлагыг үргэлжлүүлэн судлах хүсэл төрсөн талаараа дурдсан билээ. Номынхоо төгсгөлийн энэхүү бүлэгт би Ариунаагийн төлөвшлийг өөр өнцгөөс харуулна. Энэ нь эмэгтэйчүүдэд ерөнхийдөө, ялангуяа нэр дэвшигч эмэгтэйчүүд гоо сайхны болон бие бялдрын өөрчлөлтийн ач холбогдлыг үзүүлнэ. Улс төрийн ертөнцөд гоо үзэсгэлэнгийн талаарх ойлголт, хамгийн зохистой эмэгтэй шинж гэж юу болохыг ойлгох талаар маш олон төрлийн үзэл бодол бий бөгөөд үүнийг тойрон мөнхийн мэтгэлцээн өрнөх боловч, Ариунаагийн жишээ түүний сонгосон эмэгтэйлэг шинжийн нөлөөллийг тод харуулдаг.

Ариунаатай ярилцахдаа хэдий үеийн хүн болохыг сайн тогтоож чадахгүй, насыг нь таамагласан ч, бүрэн итгэлгүй байлаа. Социализмаас өмнө эсвэл дараа нь нас биед хүрсэн эсэхийг хэлэх аргагүй байв. Гэртээ халат, таавчигтай байхыг нь харвал 50 нас шахаж буй гэмээр. Харин гадаа, үсээ засуулж, хар өнгийн нарийн банзал, загварлаг өндөр өсгийт өмссөн байхыг харвал дөнгөж 30 гарч буй гэж бодмоор. Үнэнээ хэлэхэд, би олон нийтийн газар түүнтэй 15 минутын турш байгаад таниагүй байсан юм. Хамт алхаж явсан найз маань түүнийг хараад яриа өрнүүлж, зогсов. Би Ариунааг таниагүй тул, “сайн байна уу” гэж мэндлээд хоёр бүсгүйд ярилцах орон зайг нь олгох зуураа, эргэн тойрондоо буй сонгуулийн

сурталчилгааг ажиглан зогсов. Харин найз маань “Баяртай, Ариунаа эгч ээ” гэж хэлэхэд нь, би хэдхэн долоо хоногийн өмнө гэрт нь очиж ярилцсан Ариунаа байсныг мэдээд цочирдож билээ.

Ариунаа АН-ын тэргүүлэгчдийн нэг, намын эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүнээр ажиллаж байв. Тэрээр надад эмэгтэй нэр дэвшигчдийн квотын ач холбогдлын талаар (удиртгал хэсэг үзнэ үү) төдийгүй, яагаад сонгуульд өрсөлдөхөөр шийдсэнээ ярьсан юм. Ариунаагийн улс төрийн карьер үнэхээр сэтгэл хөдөлгөм хэдий ч, түүний олон нийтийн өмнө гарахдаа өөрийнхөө дүр төрхийг хувирган өөрчлөх чадвар нь онцгой билээ. Амжилттай нэр дэвшихэд, ялангуяа нэр дэвшигчид байх ёстой гэмээр шинж чанарууд буюу гоо сайхан байдал, эмэгтэйлэг хэв маягийг Ариунаа өөртөө хэрхэн бий болгож буйгаар жишээ авч эмэгтэйчүүд өөрийгөө сонгогдохуйц болгохын тулд юу туулдгийг өгүүлэх болно.

Неолиберализмын нугачаанууд

“Тэр ч ёстой ажлын төлөө төрсөн хүн. Хэдийд нь унтаж амждаг юм бүү мэд” гэж саяхан байгуулагдсан өргөн нэвтрүүлгийн телевизийн захирал Дууяагийн (нууц нэр) талаар танил маань надад хэлэв. Дууяаг бусад өргөн нэвтрүүлгийн телевизүүд бүгд л авахыг хүсэж байлаа. Улаанбаатар хотын төвийн Итали ресторанд байцаа, өргөст хэмх, манжин голдуу орсон салат идэн суух зуураа “Надтай хамт ажиллаж байсан чадварлаг хүмүүс намайг дагаж шинэ телевизэд ажиллах болсон тул телевизийн маань ажил амжилттай сайхан л байна” гэж даруухан ярив. Дууяагийн сэтгүүлчид салбарынхаа хамгийн шилдгүүд байсан биз. Гэвч түүний удирдлагын ур чадвар ч мөн адил төрөлхийн онцгой байлаа. Хамт олон нь түүнийг чанга, мундаг, сүрхийгээс гадна хэрийн хүний зүрхэлж хийдэг ч гүй ажлыг барьж аваад үр дүн гаргадаг хүн хэмээн тодорхойлсон юм.

Дууяа телевизийн захирлаар цаашид ажиллахын оронд УИХ-д өрсөлдөхөөр шийджээ. Гэвч телевизийн ажил удирдах нь амжилттай нэр дэвшигч байхад хангалттай хэмжээний ур чадвар биш гэж тэрээр үзэв. “Нэр дэвшихийн тулд би биеэ бэлдэх хэрэгтэй. Би тархиа цэнэглэж, Англи хэлээ эрс сайжруулах хэрэгтэй. Дандаа л орчуулагчаас хамааралтай байгаад байвал гадаад харилцаагаа тэлж чадахгүй. Мөн би өөрийгөө хөгжүүлэх хэрэгтэй тул гадаадад докторын зэрэг хамгаалах нь зүйтэй юм байна” гэж тэрээр надад ярилаа. Надтай уулзах үеэр Дууяа өөрийгөө оюунлаг хүн болгон хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаа нь илэрхий байв.

Дууяа оюунлаг байхыг сонгохын зэрэгцээ, гадаад төрхөө өөрчлөн бүтээх эрмэлзэлтэй байлаа. “Дууяа их турж, имиж ээ ч өөрчилж, үнэхээр сайхан харагдаж байна. Цаадах чинь их гоё болчихжээ” гэж нэг танил маань дурдав. Итали ресторанд өдрийн хоол идэнгээ ярилцаж байх үеэ эргэн санавал Дууяа тухайн үед Япон маягийн хоолны дэглэм барьж буйгаа

хэлсэн бөгөөд түүнд нь нийцэх ганц хоол нь салат байсныг санаж байна. Дууяа өөрийнхөө бие, тархи, гадаад төрхийг цогцоор нь сайжруулахыг хичээж байсан ч, ийм эрмэлзэлтэй цор ганц бүсгүй байгаагүй нь мэдээж. Маш олон эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийгөө сонгогдохуйц болгох стратегийн хүрээнд эмэгтэйд байдлыг шинээр бий болгохын тулд сэтгэл хөдөлгөм, шинэлэг байдлаар өөрсдийгөө хөгжүүлэхийг ихэд эрмэлзэж байсан юм.

Ариунаа, Дууяа хоёрын талаарх дээр өгүүлсэн дүрслэл нь тодорхой анги давхарга, байр суурь, хүйс, амьдралын хэв маягт хамаарах хүн байна гэдэг нь юу гэсэн үг болох талаарх Монголчуудын ойлголттой холбоотой саяхны өөрчлөлтийг илэрхийлдэг гэлтэй. Нэгдүгээрт, өөрийгөө олон нийтийн өмнө илэрхийлэхдээ хамгийн хөөрхөн дээрээ тавьж, сэтгэл татам байх хүлээлтийн тухай. Нөгөөтээгүүр, өөрийнхөө бие, гадаад төрх, хувцаслалтын хэв маяг, гоо сайхан байх арга техник, эрүүл мэнддээ анхаарах гэх мэтээс гадна өөрийнхөө тархи, мэдлэг, ур чадварыг ялангуяа гадаадад сурах байдлаар иж бүрэн, байнга хөгжүүлж буй туршлага зэрэг болно. Хэдийгээр энэ хоёр нь бүхэлдээ шинэ зүйл биш боловч, даяаршил, аялал жуулчлал, хэрэглээний бүтээгдэхүүний импорт, тодорхой бүлгүүдийн эдийн засгийн хөгжил дэвшил, амьдралын хэв маягт гарч буй шинэ өөрчлөлт зэргээс хамааран хэвийн зүйл болжээ. 1990-ээд оноос Монголд зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бэхжиж эхэлсэнтэй зэрэгцээд сургалтын хөтөлбөрийг дахин боловсруулах, гэр орноо, гал тогоогоо засах гэх зэрэг материаллаг орчин сайжирч буйтай холбоотойгоор өөрийгөө дахин боловсруулах, хөгжүүлэх үзэгдэл өрнөх болсон гэж болно. Эдгээр өөрчлөлт нь бие махбод, оюун санаа төдийгүй хүрээлэн буй орчиндоо ч нөлөөлдөг.

Оюунлагийн талаар өгүүлэх тавдугаар бүлэгтээ нэр дэвшигчид өөрсдийгөө сонгогдохуйц болгохын тулд, хэт арилжааны шинжтэй сонгуулийн кампанит ажлыг оюунлаг байдлаараа даван туулж буй талаар өгүүлсэн. Харин энэ бүлэгт сонгогдохуйц өөрийгөө бий болгох талаар үргэлжлүүлэн судлахдаа нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлын үеэр болон өмнөх нь гадна талдаа харагдах байдал, дотор талдаа өөрсдийгөө хөгжүүлэх стратегид төвлөрнө. Эмэгтэй нэр дэвшигчдийн зорилго боловсролтой, үзэсгэлэнтэй, харизмтай буюу нэг үгээр сонгогдохуйц болох, тэр байдлаа сонгогчдод танилцуулахад оршино. Эдгээр эмэгтэйчүүд өөрсдийгөө хөгжүүлэх, сайжруулах, өнгөлөх замаар сонгогдохуйц болгож буй иж бүрэн үйл ажиллагааг би биеэ бэлдэх гэж нэрлэлээ. Монгол хэлэнд биеэ бэлдэх гэх үг нь өөрийнхөө хамгийн төгс хувилбарыг бүтээх гэх утга илэрхийлнэ. Бие гэх үг нь бие махбодоос гадна хүн гэх утга илэрхийлэх бөгөөд би, тэр гэхээс гадна миний бие, түүний бие гэж ярьдаг билээ.

Монгол дахь ардчилсан сонгуулийн байнга үргэлжлэх, өндөр зардалтай шинж чанар нь хэрэглээнд суурилсан, нийгмийн дээд давхаргад

хамрагдахуйц мэргэжлийн, жендэрийн онцлогтой үнэ цэний биелэл болсон пост социалист улс төрийн субъектив шинж байдлыг бий болгоход нөлөөлсөн гэж үзэж байна. Эмэгтэй нэр дэвшигчид болон биеэ бэлдэхэд чиглэсэн тэдний үйл ажиллагаа нь сонгуульжилтын нөлөөллийг тод харуулах жишээ болдог. Эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийгөө сонгогдохуйц болгохын тулд биеэ бэлдэх, эмэгтэй улс төрчдийн дүр төрхийг дахин бүтээх хэрэгцээ нь ангийн танигдахуйц өргөн хүрээнд дахин тодруулж, дэлхийн түвшний манлайлагч ангийг бий болгох оролдлого болж байдаг. Сонгууль дундаас дээш давхаргын эмэгтэйчүүдийг дахин бүтээх талбар байх бөгөөд, тиймээс жендэрийн онцлогийг ч мөн адил өргөн агуулгаар дахин боловсруулдаг билээ. Монгол эмэгтэй хүн гэж хэнийг ойлгох вэ гэдэг нь Монголын ардчилсан сонгуульд мөнхийн өөрчлөгдөж байдаг ойлголт юм.

Эдгээр нэр дэвшигч эмэгтэйчүүд неолиберализмын нөлөөнд бүрэн автаагүй, санал нийлдэггүй неолиберализмын ойлголтуудыг няцаахын тулд неолиберализмын зарим хэрэгтэй гэсэн чиг хандлагыг ашигладаг. Айва Онг (2006) зэрэг эрдэмтэд неолиберализм нь олон талтай, бас хүмүүс өөр өөр байдаг болохоор хүн амын зарим хэсэгт неолиберализм ашиг тустай, зарим хэсэгт хор хөнөөл учруулдаг харилцан адилгүй байдалд анхаарлаа хандуулахыг уриалжээ. Кристина Швенкел, Энн Мариз Лешкович (2006) нар неолиберализм олон янзын хэлбэр, агуулгаар хэрэгжиж буйг онцлон тэмдэглэсэн. Судлаачдын эдгээр үзэл санаа Монгол эмэгтэй нэр дэвшигчид неолиберализмтай холбоотой сорилт бэрхшээлүүдийг хэрхэн даван туулж буйг олж мэдэхэд тус болдог. Сонгуул ийн кампанит ажил явуулна гэдэг нь одоо цагт тасралтгүй үргэлжлэх удирдлагын механизмыг санхүүжүүлэх гэсэн утгатай болсон бөгөөд улс төрд эмэгтэй нэр дэвшигчид гадуурхагдах үйл явцыг бэхжүүлж байна.¹ Нөгөө талаар эмэгтэй нэр дэвшигчид энэхүү арилжааны шинжтэй сонгуулийн кампанит ажлыг өөрчлөхийн тулд өөрсдийнхөө бие махбод, харагдах байдал, оюун санаагаа төгөлдөржүүлж, татгалзахын аргагүй нэр дэвшигч болохын тулд биеэ бэлдэж байна. Ингэхдээ тэд гоо сайхан, эрүүл мэнд, хувцас загварын салбарын давуу талыг ашигладаг.

Эмэгтэй нэр дэвшигчид өөрсдийгөө сонгогдохуйц болгох гэсэн оролдлого нь тогтворгүй зах зээлийн хэрэгцээнд нийцэхийн тулд үргэлж дахин бүтээн байгуулалт хийхийг шаарддаг неолиберализмын шинжтэй нийцдэг (Freeman 2014; Rose 1999). Гэсэн хэдий ч сонгогдохуйц өөрсдийгөө бүтээх нь зөвхөн тухайн тогтолцоонд амжилт гаргахыг эрмэлзэх неолиберал шинжээс илүү өргөн хүрээтэй. Сонгогдохуйц болж яваа эдгээр эмэгтэйчүүд том зургаараа эрчүүд зонхилсон улс төр, арилжааны шинжтэй болсон сонгуулийн кампанит ажлыг өөрчлөхийн төлөө хүчин чармайлт гаргаж яваа билээ. Чадах чинээгээрээ биеэ бэлдэж

¹ Төрийн бус тоглогчдыг удирдах үзэгдэл бусад газруудад ч мөн адил өргөжсөөр байна (Dunn 2008; Ong and Collier 2004).

буй эдгээр эмэгтэй нэр дэвшигчид неолиберализмын давуу талаар сул талыг нь нөхөхийн тулд хичээж буй юм.

Эдгээр эмэгтэйчүүд үзэсгэлэнтэй, харизмтай дүрийг бий болгохын тулд хувцас загвар, гоо сайхан, эрүүл мэндийн бүтээгдэхүүн, амьдралын хэв маягтай оюун санаа, бие махбодоороо холбогддог (Edmonds 2010; Miller 2006). Эмэгтэй сонгогчдын хувьд гоо сайхан гэдэг нь юу гэсэн утга вэ гэдгийг авч үзвэл, нэр дэвшигчид биеэ бэлдэх нь маш чухал болохыг ойлгоно. Хэдваг Уотерс (2016, 8) янз бүрийн салбарын түүх, туршлагатай эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн байр сууриа хамгаалахын тулд орчин үеийн, дундаас дээш давхаргынхны гоо сайхны стандартад нийцэхийг эрмэлздэг гэжээ. Хөдөөгийн, нүүдэлчин эмэгтэйчүүдийн дунд хийсэн Уотерсын (2016) судалгаа нь ялангуяа сонгуулийн кампанит ажлын агуулгын талаар өгүүлэхэд ихээхэн ач холбогдолтой судалгаа юм.

Эмэгтэй сонгогчид, ялангуяа эдийн засгийн үзүүлэлт багатай бүс нутгийн эмэгтэй сонгогчид эмэгтэй нэр дэвшигчдийг харагдах байдал, гоо үзэсгэлэн, гадаад төрхөөр нь шүүх хандлагатай байдаг аж. Уг нь сонгогчид нэр дэвшигчдийн амлалтын биеллийг нь харах учиртай. Эндээс эмэгтэй нэр дэвшигчид бусад нэр дэвшигчдийн адил мөрийн хөтөлбөрөө танилцуулахын өмнө нэн тэргүүнд өөрийнхөө гоо сайхан, эрх мэдэлтэй дүр төрхийг харуулах хэрэгтэй гэх логик харагдана. Мөн эмэгтэй нэр дэвшигчид сонгогчидтой харилцах, анхны сэтгэгдэл төрүүлэх тул имиж ээ хэрхэн бүрдүүлэх нь маш чухал. Эмэгтэй нэр дэвшигчдэд сонгогчдодоо байнга бэлэг өгөх, ажил олгох, тойрогтоо дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгээд байх хангалттай санхүүгийн бололцоо байхгүй тул уулзалтынхаа үеэр сэтгэгдэл төрүүлэх, имиждээ анхаарахыг хичээнэ. Харин сонгогчид нь нэр дэвшигчдийн төрүүлэхийг хичээж буй сэтгэгдлийг харилцан адилгүй хүлээн авч, шүүмжилж, үнэлэх нь мэдээж.

Дараагийн хэсэгт би эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг, өөхшүүлж боломгүй зарим асуудлыг тоймлон өгүүлнэ. Улмаар, эмэгтэйчүүд биеэ бэлдэж буй туршлагыг түүхэн талаас нь авч үзэхийн зэрэгцээ, Оюунгэрэл, Занаа, Одонтуяа гэх гурван эмэгтэй нэр дэвшигчид 2008, 2012 оны сонгуульд хэрхэн биеэ бэлдэж буй туршлагыг задлан шинжилнэ.² эмэгтэйчүүдийн хувийн түүх өөр өөрийн онцлогтой боловч, өргөн утгаараа хүн ам зүйн төлөөлөл билээ. Маш олон эмэгтэйчүүдийн хувьд “кампанит ажлын” болон кампанит ажлын өмнөх шатны талаарх үзэл санаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн харагдах, сонгогчидтой хийх уулзалтын хуваарь, албан ёсны илтгэл яриа зэргээр хязгаарлагддаггүй. Харин кампанит ажлын талаарх үзэл санаа нь гадна болон дотор талаасаа өөрийгөө өнгөлөх, биеэ бэлдэх, “тархиа” цэнэглэх үйл явц билээ.

² Би эдгээр стратегийн үр нөлөөг хэмжээгүй бөгөөд эдгээр стратеги болон эмэгтэйчүүд сонгуульд хэрхэн оролцсон талаар учир шалтгааны холбоосыг ч мөн эрэлхийлээгүй болно.

Супер нарийн бичгийн дарга ба нэр дэвшигч

Эмэгтэйчүүд боловсрол, мэргэжлийн амжилт, өөрийгөө сэтгэл татам, харизмтай дүрээр танилцуулах гэх мэтээр өөрийгөө төгс төгөлдөр болгохын эрэлд гарна. Гэвч сонгогдохуйц гэж юу болох, сонгогдохуйц байдлыг хэрхэн хэмжих талаарх ойлголт маш бүдэг байдгаас сайн, муу аль аль тал нь нэмэгджээ. Хэдийгээр сонгогдохуйц гэдэг нь юу болох талаар хэн ч надад оновчтой тайлбар өгч чадаагүй ч, цаг хугацаа өнгөрөхийн хэрээр би сонгогдохуйц байдал гэдэг нь сонгогчдыг татахын тулд өөрийнхөө сэтгэл татам байдлыг тод харуулах, намаа болон намын гишүүдээ дэмжих бэлгэдлийн (нэр төр, алдар хүнд гэх мэт) болон соёлын (мэдлэг, туршлага) капиталыг өөрийнхөө имиж дээр нэмж бий болгох зэрэг цогц үйл явдал болохыг ойлгосон юм.³

Томоохон улс төрийн намууд эцгийн эрхт ёсны “нийтийн”, болон “хувийн” гэх хуваагдлын хамт өрхийн уламжлалт хөдөлмөрийн хуваарьт суурилсан жендэрийн үнэт зүйлсийг нийгэмд зохион байгуулалттай түгээн дэлгэрүүлж байдаг гэлтэй. Эрчүүд гол төлөв тайзан дээр, эсвэл олон нийтийн өмнө ил гарах бөгөөд эмэгтэйчүүд сонгуулийн кампанит ажлын бэлтгэл гэх мэт арын албыг хариуцах хандлагатай байдаг. УИХ-ын сонгуулиар эрэгтэй нэр дэвшигчдийн кампанит ажлын ард удирдлага, зохион байгуулалтын албыг ихэнхдээ эмэгтэйчүүд хариуцна. Улс төрийн намд (үгүйдээ л Ардчилсан Намд 2000-аад оноос хойш) эрэгтэйчүүд илүү эрх мэдэл, нэр хүндтэйгээс гадна эмэгтэйчүүдээс илүү амжилттай байх хандлагатай гэх үзэл санаа нь 2008 оны сонгуульд нэр дэвшигч Оюунгэрэл 2007 онд нэр дэвшигчдийн хүйсийн квотыг цуцалсны дараа нь телевизэд өгсөн ярилцлагаас харагддаг.⁴ Тэрээр надад “Квотыг цуцалсан УИХ-ын шийдвэрийг сонсоод 17 жилийн турш улс төрийн гал тогоонд тэр бүх хүнд хүчир ажлыг хийснийхээ дараа алгадуулах шиг болсон” гэж ярьсан юм. Намын улс төр жендэрийн улс төрийн нэг хэсэг бөгөөд эрчүүд нь удирдан манлайлж, амжилт гаргаж, эмэгтэйчүүд нь тэднийг дэмжих ёстой мэт хандлага байдаг. Энэ талаар Оюунгэрэл “Эрчүүд биднийг (улс төрд буй эмэгтэйчүүдийг хэлж байна) шатны гишгүүр л гэж хардаг даа” хэмээн ярьсан юм.

Миний найз, феминист зохиолч Баатарсүрэнгийн Шүүдэрцэцэг улс төрийн намын “эцгийн эрхт” шинж чанарыг байнга шүүмжилдэг бөгөөд

³ Сонгогчдод сэтгэл төрүүлж, намынхаа эрх мэдэлтэй гишүүдийн тойрогт орохын тулд сонгуульд нэр дэвшигчид бэлгэдлийн үнэ цэн гэх ойлголт хамаатай. Торстейн Вэблен (2007) шинэ баячууд хэрэглээгээ харагдуулах нь маш чухал бөгөөд, өмнө нь хаалттай байсан зүйлээ хийхийг эрмэлздэг нь зарим тохиолдолд улс төр, манлайлал байдаг гэжээ. Үүнтэй адилаар, Марсел Маусс (2006) дээш тэмүүлэх хөдөлгөөнд хэрэглээний ач холбогдлыг тэмдэглэсэн байдаг. Пьер Бурдьё (1984) мөн бэлгэдлийн капиталтай хүн түүнийгээ ашиглаж нийгмийн капитал болгох боломжтой гээд нийгмийн капиталын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн. Гэсэн хэдий ч, сонгуулийн агуулгаар үзвэл, нийгмийн капитал нь сонгогчдод итгэл төрүүлэм мэдрэмжийг тэр бүр бий болгодоггүй.

⁴ Оюунгэрэл надад хэлсэнээр, тэрээр 10 гаруй телевизүүд рүү залгаж, багахан эфирийн цаг хүссэний эцэст шахаж шаардаж байж ярилцлага өгч чадсан цор ганц улс төрч аж. Учир нь УИХ квот цуцалсан мэдээг 12-р сарын 25-нд зарласан бөгөөд, шинэ жилийн баярын хөтөлбөр, концертуудаар телевизүүдийн цаг дүүрсэн байжээ.

“Эмэгтэй улс төрч улс төрд амжилт гаргах боломж маш бага” болохыг хэлдэг билээ. Тэрээр, “хамгийн өндөр боловсролтой эмэгтэй хүн супер туслах л болно, магадгүй үнэхээр царайлаг, үзэсгэлэнтэй бол романтик хань л болно” хэмээн тайлбарлав. АН анхнаасаа улс төрийн ашиг сонирхолтой хүмүүсээр хязгаарлагдаж байсангүй. Харин АН де факто олон нийтийн байгууллага байсан бөгөөд хүмүүс нийгмийн харилцаанд орох, танилцах, сүлжилдэх, хамт ажиллаж болох чадварлаг хүмүүсийг хайх, нарийн бичгийн дарга, менежерүүдийг хайж олох “цэвэр”, сайхан орчин байсан юм. (Эсрэгээрээ МАХН 2000-аад оныг хүртэл хаалттай, шинээр элсэх хүмүүсээс шалгалт авдаг, намтрыг нь шалгадаг хатуу гишүүнчлэлийн бодлоготой байгууллага байв.) Маш олон залуучууд, түүний дотор ганц бие эмэгтэйчүүд 1990-ээд оноос АН-ын уулзалтад идэвхтэй оролцож байсан нь дан ганц улс төрийн шалтгаантай бус, зүгээр л ижил санаа бодолтой хүмүүстэй нийгмийн харилцаанд оролцох сонирхолтой байснаас тэр юм. Тийм учраас эрэгтэй, эмэгтэй намын гишүүд хоорондын өдөр тутмын харилцаа нь (тухайлбал, эмэгтэй хүн ажлаасаа гарах, албан ёсоор ч бай, түр зуур ч бай өөр ажилд орох, болон найз нөхдийн эсвэл гэм хоргүй сээтэгнэл гэх мэт харилцаанууд) яван явсаар улс төрийн намд эрэгтэй, эмэгтэй байх нь ямар утгатай болох гэх мэт жендэрт суурилсан хөдөлмөрийн хуваарийг улам бататгасан талаар Шүүдэрцэцэг тайлбарлав. Эмэгтэй хүн нэр дэвшихэд эрчүүдээс илүү тохиромжтой биш гэх үзэл санаа улам бүр лавширч, жендэрт суурилсан энэхүү таамаглал нь өдөр тутмын харилцан үйлчлэлд улам бүр бэхжэсээр иржээ.⁵ Тиймээс, улс төрийн намд эцгийн эрхт бүтцээс шалтгаалан эмэгтэйчүүд илүү бага түвшний, илүү хөнгөн үүрэг гүйцэтгэх болсон байна.

Ингээд, маш олон эмэгтэй нэр дэвшигч эмэгтэйчүүдийн улс төрийн үүрэг, амлалтын талаарх нэгэнт тогтсон өрөөсгөл ойлголтыг таслах шаардлагатай болсон юм. Тэдгээр бүсгүйчүүд өөрсдийгөө эрчүүдтэй харьцуулахад эн тэнцүү ур чадвартай гэдгээ, мөн өөрсдийнхөөс нь өөр зорилгоор намд элсэж буй эмэгтэйчүүдээс ялгаатай гэдгээ аль алиныг нь харуулахыг ухамсарлаж байлаа. Ингэхийн тулд тэд боломжит хамгийн сайн боловсрол эзэмшиж, хамгийн дур булаам харагдаж, сонгогчдооо чиглэсэн хамгийн зөв мессежийг хүргэх гэх мэтээр өөрсдийнхөө хамгийн төгс хувилбарыг дахин бүтээхийг хичээсэн. Сонгогдохуец нэр дэвшигч байхыг хичээж буй эмэгтэйчүүд эргэн тойрныхондоо хүлээн зөвшөөрөгдөх, сонгуульд нэр дэвших шийдвэр нь хөнгөн хуумгай бус гэдгийг мэдрүүлэхийн тулд эмэгтэй хүнийг авч үзэх хэвшмэл ойлголтыг эвдэх шаардлага өдөр тутам тулгарна. Эдгээр эмэгтэйчүүд хамгийн оновчтой баланс барих шаардлагатай ч мөн тулгарч байлаа. Тухайлбал,

⁵ АН-ын уур амьсгал илүү нээлттэй, илүү чөлөөтэй байдаг бол эсрэгээрээ Монгол Ардын Хувьсгалт Намын уур амьсгал илүү хаалттай, албархуу, шатлан захирах ёсны шинжтэй байдаг.

хэт хол, ихэмсэг байх нь тэдний сүлжээг эвдэж, өрсөлдөгчдөд давуу байдал үүсгэх бол, хэтэрхий найзархаг байх нь хүлээх ёстой хүндэтгэлийг алсруулна.

Хэдийгээр маш олон эмэгтэйчүүд сонгуулийн кампанит ажил хэрхэн удирддагийг мэдэх боловч, нам нь тэднийг өөрсдөө сонгогдохын төлөө кампанит ажил хийнэ гэхэд төдийлөн итгэж өгөхгүй. Эмэгтэй нэр дэвшигчдийн замнал нь хязгаарлагдмал, биеэ авч явахад тодорхой дүрэмтэй гэх мэт хэвшмэл ойлголт түгээмэл байх тул, тэд өөрсдийнхөө зам мөрийг өөрсдөө л тодорхойлох хэрэгтэй болно. Энэхүү үйл явцад тэд намын удирдлага, сонгогчид, сонгуулийн менежерүүд болон, хэвлэл мэдээлэл, хов жив, найз нөхдийн зөвлөгөө болон өөрсдийн төсөөлөл гэх мэт маш олон талын хоорондоо зөрчилтэй олон талын хэрэгцээ, шаардлагын дундуур алхах хэрэгтэй болдог.

Сонгогдохуйц гэдэг барьцгүй байдал

Шударга, зарчимч, чадвартай гэх мэт шинж чанарыг УИХ-ын гишүүнд заавал байх ёстой гэж олон нийт үзэх боловч эдгээр нь улс төрийн намын дарга, улс төрийн намын дотоод сонгууль зохион байгуулах хүмүүст тэр болгон байхгүй төдийгүй, бүр эсрэг шинжтэй байх нь түгээмэл. Хэрэв эдгээр чадварууд давхцаж байвал, нэг шинж чанарын талаар өөр өөр тоглогчдын санаа бодол ялгаатай байж болно.

Тухайлбал, хэд хэдэн улс төрийн намд зөвлөхөөр ажиллаж байсан нэгэн: “Хувь нэр дэвшигчийн оюуны чадавх, бие даасан бодолтой эсэх, илэн далангүй байх эсэх нь улс төрийн намын удирдлагуудад (гол хоёр намын удирдлагыг хэлж байна) огт падгүй. Харин нэр дэвшигч нь багийн тоглогч байж чадах эсэх, намдаа үнэнч байж, шаардлагатай тоглоомд намын даргын төлөө байж чадах эсэх нь хамгийн чухал. Үнэн хэрэгтээ, бие даан бодож сэтгэх, үзэл бодлоо нээлттэй илэрхийлэх ур чадвар нь харин ч эсрэг үйлчилж, хүндрэл учруулж болзошгүйд тооцогдоно” гэж ярьсан юм. Намын хамаг эрх мэдлийг атгаж буй хаалттай, нягт холбоотой ажиллаж буй цөөн дарга нарын хувьд илэн далангүй хүн тийм ч таатай санагддаггүй. Өөрийгөө нухацтай нэр дэвшигч гэдгийг харуулахын тулд намын тактикийг ягштал баримталж, намын төлөвлөгөөний л дагуу ажиллах ёстой бөгөөд өөрийн санаа бодлоор ажиллах гэвэл нэр дэвшигч байж чадахгүй гэдгийг туршлагатай зөвлөх надад сайтар хэлж өгсөн. Тэрээр, “Ямар ч намын дарга өөрийг нь сорьж буй мэт, хувийн бодолтой, түүнийгээ ил тод ярьдаг эмэгтэй хүнийг тэсвэрлэдэггүй” гэв.

Гэвч, намын улс төрөөс зайлсхийх шинж чанар нь сонгогчдын анхаарлыг татах хандлагатай байдаг. Нэгэн эмэгтэй сонгогч шинээр нэр дэвшиж буй эмэгтэйн сонгогчидтой хийх уулзалтад явж ирээд нэлээн урам нь хугарсан байдалтай дараах зүйлийг яриу.

Тэрээр нэг их ярьсангүй, яриа нь ч тийм гал цогтой байсангүй, бидэнд ч итгэл үнэмшил төрсөнгүй. Эрэгтэй хамтрагчийнхаа дэргэд сул дорой харагдав. Бидэнд биднийг төлөөлөх, ажиллах хүчирхэг эмэгтэй хэрэгтэй шүү дээ. Тиймээс эмэгтэй нэр дэвшигчид байр суурьтаа бат зогсож, эрчүүдтэй ижил тэнцүү, чанга дуугарах ёстой. Тэгж чадахгүй бол бид яагаад сонгох гэж? Нэмэх нь түүний өмссөн хувцас хэтэрхий энгийн, цүнх нь мөрнөөс нь унжсан нь түүнийг хааш яаш харагдуулж байв. Түүний уйтгартай байдал намайг тавгүйтүүлсэн. Үгүйдээ л тэр цэвэрхэн, өнгөлөг харагдаж болох шүү дээ.

Түүнчлэн, эмэгтэй нэр дэвшигчид олон нийтийн хүлээлтийг давсан, амжилтын бэлгэ тэмдэг байх ёстой гэж өндөр хүлээлт тавьдаг байна. Эмэгтэй улс төрчид “хөөх” гэмээр санагдах ёстой гэж сонгогчид үзнэ. Улс орны өнцөг булан бүрийн төлөөлөлтэй олон удаагийн фокус бүлгийн ярилцлага хийж явахдаа би нэг тойргийн бараг 20 гаруй сонгогчдоос эмэгтэй УИХ-ын гишүүнд тавигдах шаардлагыг өөр өөрсдийнхөө бодлоор үнэлэхийг хүсэв. Хариулт нь янз бүр байсан ч, ерөнхийдөө “сайн бэлтгэгдсэн”, “өндөр боловсролтой”, “ажлаа эхлэхэд бэлэн” зэрэг зүйлсийг нэрлэсэн юм. Хэд хэдэн эмэгтэй нэр дэвшигч бүхий сонгуулийн тойрогт ядахдаа нэг эмэгтэй нэр дэвшигч сонгогдох боломжтой байжээ. Тухайлбал, хүний эрхийн хуульч Манжаагийн Ичинноров (Нора) нэг нэр дэвшигч нь байлаа. Би сонгогчдын бүлгээс түүнд санал өгсөн, эсвэл өгөх талаар бодож байсан эсэхийг асуувал 20 сонгогч дуу нэгтэй “үгүй” гэв. Яагаад гэж лавшруулбал, ихэнх нь дуугүй л бодолхийлнэ. Зарим эрчүүд сонгогчидтой уулзалт хийж, сурталчилгааны алхалт хийх нь тэдний сэтгэгдлийг хангалттай татаж чадахгүй бөгөөд илүү их зүйл хүлээж байснаа тайлбарлав.

Норагийн туршлагын талаар мэддэг бололтой нэгэн эр, “хүний эрхийн хуульч байж, хангалттай сайн ажиллаагүй” гэв. Та бүхний саналыг авахын тулд Нора яг юу хийх ёстой байсан гэж бодож буйг би асуулаа. Хэсэг зуур чимээгүй байсны эцэст нэгэн эр, “Тэр Малайз руу нисэж, Алтантуяагийн хэргийг хамгаалах ёстой байсан юм” гэв. Ингэмэгц, хэд хэдэн хүн дуу дуугаа авалцан, яг тийм, тэр яг л үүнийг хийх ёстой байсан юм гэгцгээв. Үнэн хэрэгтээ, тэдгээр сонгогчид маань хүний эрхийн хуульчийн хувьд Нора сонгуульд өрсөлдөхийн талаар бодох нь бүү хэл, хүний эрх хаана хамгийн хэрэгтэй байна, тэнд л тэднийг хамгаалж, үйлчлэх ёстой гэж итгэж байсан нь надад анзаарагдсан.

Тухайн ярилцагчийн дурдсан хэрэг нь 10 гаруй жил сунжирсан, үндэсний, болон олон улсын шүүх, хүний эрхийн байгууллагуудыг хамарсан, маш төвөгтэй хэрэг байсан юм (Ellis-Peterson 2018). Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэл, Монголын Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийнхний хэлж буйгаар Алтантуяа нь 2006 онд Малайз улсад амь насаа алдсан залуу Монгол эмэгтэй юм. Тэрээр

Францаас Скорпин шумбагч онгоц худалдан авах яриа хэлэлцээнд Малайзын Засгийн газрыг төлөөлж оролцсон Малайзын Стратегийн Судалгааны төвийн батлан хамгаалахын шинжээч Абдул Разак Багиндад орчуулагчаар ажиллаж байжээ. Францаас шумбагч онгоцоо хүлээн авсны дараа төлөх ёстой ажлын хөлсийг нь төлөөгүй тул Алтангуяа Багиндагийн гэрийн гадаа эсэргүүцлээ илэрхийлэн суулт хийсэн байна. Төд удалгүй, Алтангуяагийн цогцос Куала Лумпур хотын ойролцоо олдov. Маш олон Монголчууд энэ хэргийг цаг тухайд нь шийдвэрлэж чадаагүй, хангалттай хүчин чармайлт гаргаагүйд Малайзын шүүхэд, Монголын албан тушаалтнуудад ч ихээр бухимдаж байлаа (Lhagva 2015). Тиймээс хохирогчийн ар гэрийнхэнд туслахыг хүсэж байсан Монголчуудын сэтгэлийг ойлгож болох. Гэсэн хэдий ч Монголын Засгийн газар бүү хэл, олон улсын байгууллагууд хүртэл хэтэрхий төвөгтэй гэж тооцож байсан хэргийг шийдвэрлэхийг эмэгтэй нэр дэвшигч Норагаас хүлээж байсан нь сонгуульжилт, түүний цар хүрээ, эмэгтэй нэр дэвшигчдээс хүлээх хүлээлт хэмжээ дамжаагүй болсныг харуулдаг.

Эмэгтэй нэр дэвшигчид тойрогтоо өрсөлдөж буй эрэгтэй нэр дэвшигчидтэй ижил тэгш байх, үгүйдээ л ижил тэгш харагдах ёстой гэж зарим сонгогчид үздэг. Үүний зэрэгцээ, маш олон сонгогчид, ялангуяа эрэгтэй сонгогчид илэн далангүй, илүү зүтгэлтэй эмэгтэй нэр дэвшигчдэд дургүйлхэнэ. Нэгэн удаа нэр дэвшигчдийн телевизийн ярилцлагын дараа эмэгтэй нэр дэвшигчийн насанд хүрсэн хүү нь утас руу нь залгажээ. Учир нь ердийн үедээ энгийн, намуухан ярьдаг эмэгтэй телевизийн үеэр ердийнхөөсөө бага зэрэг түрэмгий ярилцлага өгсөн аж. Хүү нь түүнд битгий эрчүүд шиг авирлаж, дуу хоолойгоо түрэмгий болго харин энгийн үеийнх шигээ намуун зөөлөн ярихыг зааварчлав. Энэ мэтчилэн эмэгтэй нэр дэвшигчид орон нутгийн сонгуулиас УИХ-ын сонгууль хүртэл аливаа сонгуулийн кампанит ажлын үеэр алхам тутамдаа төрөл бүрийн сонгогчид, шүүмжлэгчдийн хоорондоо зөрчилтэй, маш олон төрлийн хүсэлт, шаардлагад нийцэх хэрэгцээтэй тулгарч байдаг.

Ихэнх эмэгтэй нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөхөөр төлөвлөж байх үедээ өөрсдийн сонгогдохуйц байдлыг сайжруулахын тулд юу хийвэл зохих, сонгуулийн кампанит ажлын үеэр юу хийх талаар өөрсдийн ойлголттой болсон байдаг. Сонгуульд биеэ бэлдэх туршлага нь эмэгтэй нэр дэвшигчдийн хувийн танигдахуй, сонирхол, удирдаж болохуйц нийгэм, соёлын нөөцөөсөө хамааран харилцан адилгүй байна. Хэвлэл мэдээллийн технологи, хэрэглэгчдийн шинэ дадал суусан цаг үед Монгол УИХ-ын суудлын төлөө өрсөлдөж буй эмэгтэй нэр дэвшигчид өөрийнхөө хэв маягийг тодорхойлох, эрүүл, гоо сайхан байх арга барилыг ашиглаж өөрсдийгөө бие мах бод, оюун санааны хувьд төгс төгөлдөр байх буюу оюунлаг, дур булаам, харизмтай байхыг хичээж байна. Дийлэнх эмэгтэйчүүд эдгээрээс гадна, бусад онцлог талаа

сонгогчдод төдийгүй намын даргадаа харуулж УИХ-ын суудлын төлөө өрсөлдөхөд бэлэн гэдгээ илэрхийлэхийн тулд байнга хичээсээр ирсэн юм.

Биеэ бэлдэх нь: Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас

Нэр дэвшигчид өөрсдийгөө сонгогдохуйц болгохын тулд жендэрийн үүднээс өөрийгөө боломжит хамгийн өндөр түвшинд боловсруулах, сайжруулах туршлагыг тодорхойлохын тулд биеэ бэлдэх гэх нэр томъёог ашиглав. Энэ туршлага нь өөрийгөө удирдах, өөрийн хариуцлагыг ухамсарлах неолиберал үзэл санааны цуурай юм. Чөлөөт зах зээлийн тогтолцооны ёс суртахуун, хувцас загвар, гоо сайхны бүтээгдэхүүн, амьдралын хэв маягийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй илэрхийлэмж, дэлгүүр хэсэх, худалдан авах өргөн боломжууд хамтдаа хүмүүст биеэ анхаарах хэрэглэгчийн дадал зуршилд суулгаж байна (Edmonds 2010). Гэсэн хэдий ч, 20-р зууны эхэн үеийн Оросоос эхэлж, гүн гүнзгий нэвчсэн хувь хүний хөгжлийн стратегийн ул мөр нь орчин үеийн сонгуульд нэр дэвшигчдийн улс төрийн амбицад ч нөлөөсөөр байна. Үнэн хэрэгтээ өөрийгөө боловсруулах, өөрийгөө хөгжүүлэх тухай үзэл санаа нь социализмын бүтээн байгуулалтын гол цөм болсон шинэ социалист хүнийг бүтээхийг эрмэлзсэн аварга том социалист төслийн нэг хэсэг юм (Shirendev 1969). Төр нь төвлөрсөн хяналт бүхий сургууль, цагдаа, дотоод хэрэг хариуцсан байгууллагууд, төрийн болон нэгдлийн аж ахуйгаар дамжуулан иргэдээ “дуулгавартай” болгон төлөвшүүлдэг гэсэн Фукогийн (1977) тодорхойлолтоос хамаагүй төвөгтэй. Анхан үеийн Зөвлөлтүүд зохист хувь хүний хөгжлөөр дамжуулан шинэ нийгмийг цогцлоох (өөрсдийгөө бус нийгмээ) хувь хүнийг бий болгож чадна гэж итгэж байсан юм.

Энэхүү үзэл санаа 1917 оны Октябрын Хувьсгалын дараа, хуучин институцийг устгаж, ард түмний өдөр тутмын амьдралыг шинэ чиглэлд загварчлах үйл явц эхэлсэн боловч хараахан хэрэгжиж эхлээгүй үе буюу Зөвлөлт Холбоот Улсын завсрын 1920-1930 оны үед гарч ирсэн үзэл санаа юм (Fitzpatrick 1978, 1979). Сергей Оушакины (2004) үзсэнээр тус завсрын үед үзэл суртал, засаглалын битүүмжилсэн орон зайд, нэр хүндтэй зохиолчид, сурган хүмүүжүүлэгчид, сэхээтнүүд хүний үйл ажиллагаа жам ёсыг удирдаж чадна гэж итгэж эхэлжээ. Тэд соёлыг “хоёр дахь жам ёс” хэмээн үзэж, Зөвлөлт маягаар орчин үежих төслийн хүрээнд социалист хүн бүтээхийг оролдов. Цар хүрээ байхгүй үед, эсвэл өмнөх тогтолцооноос улбаатай өдөр тутмын эмх замбараагүй, дэг журмын эсрэг зохион байгуулалтад орлоо. Эвдрэл, хагарал ямар нэг шинэ зүйл хурдан бүтээх, тэр шинэ зүйл нь хараахан тодорхойлогдоогүй ч зайлшгүй хүрэх ёстой зорилго бүхий нөхцөлийг үүсгэдэг бөгөөд үүнээс улбаатай “оршин буй бүхнийг шинэчлэх” (Maxim Gorky), эсвэл

бүхнийг шинээр бүтээн байгуулах хэрэгтэй болдог (Oushakine 2004, 399). “Шинэ хүмүүс өөрсдийн амьдралын мөн чанарыг бий болгохын тулд бүгдэд зориулсан ертөнцийг дахин бүтээдэг” (396).

Фукогийн (1977, 1988) харж чадаагүй зүйлийг онцолсон тул өөрийгөө хөгжүүлэх мөн чанарыг ойлгоход Оушакины судалгаа илүү тусалдаг. Монголын түүхийн турш, зонхилох институц, тогтолцоо өөрчлөгдөж, өмнөх нэг нь шинээр солигдож ирсэн тул эвдрэл, хагарал байнга үүсэхийн зэрэгцээ (Hojer and Peterson 2019) нийгэм солигдох бүрд дэг журам нь тодорхойгүй завсрын үеүд бий болж, ард түмэн шинэ нийгмийн талаар сайн, муу бүхий л төгсгөлийг төсөөлсөөр ирэв. Гэсэн хэдий ч, өөрийгөө хөгжүүлэх гэдэг нь эцсийн зорилго бус, харин нийгмийн философийн болон ёс зүйн цар хүрээг тодорхойлох замаар нийгмээ цогцлоон бүтээхийг зорьж буй хэрэг юм. Энэ шалтгаанаар өөрийгөө хамгийн өнгөтэй, нягт, ганган хээнцэр, эрүүл мэнд, эрч хүчний ундарга мэт (хийморьлог) дүрслэн харуулах нь зөв эрч хүч, засаглах чадварыг нь тодорхойлж буй. Ёс суртахууны энэхүү төлөвшил нь хувиал боддог неолиберал онцлогийг саармагжуулж, капиталист тогтолцоонд өөрийгөө шинээр бий болгоход тусална. Өөрийгөө хөгжүүлэх гэдгийн цаад агуулга нь “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэх Монгол зүйр үгийн философитой нийцдэг. Тус зүйр үг өөрийгөө хөгжүүлж чадаагүй хүн УИХ-д тохирохгүй гэж, ур чадваргүй нэр дэвшигчийг шүүмжлэхэд өргөн ашиглагддаг билээ.⁶

Хэв маягаа тодорхойлох нь: Хослол ба дээл

Монгол эмэгтэйн дүр төрх социалист нийгэмд ээжүүд, ажилчин эмэгтэйчүүдээр илэрч байсан бол орчин цагт загвар өмсөгч, үзэсгэлэнт эхнэр гэх дүр төрх рүү шилжиж байна.⁷ Дэлхий дахинд хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй хүнийг эм хүйсийнх нь хувьд, илүү эротик байдлаар онцолж буй нь соёлын хувьд эмэгтэй хүний зохист дүр төрхөд ихээхэн нөлөөлжээ. Ингээд эмэгтэй хүнийг эзэмшсэн боловсролоор нь, эрхэлж буй албан тушаалаар нь төдийгүй, тэдгээр зар сурталчилгаанд гарах эмэгтэйчүүдтэй харьцуулан хэрхэн орчин үеийн эмэгтэйн дүр бүтээж буй

⁶ Өөрийгөө төгөлдөржүүлэх, болон Күнзийн өөрийгөө хөгжүүлэх талаарх үзэл санаа хооронд олон давхцал ажиглагддаг. 18-19-р зууны Чин улсын ноёрхлын үеэс Монголчууд Күнзээс улбаатай олон үзэл санаа, үнэт зүйлсийг авч хэрэглэжээ. Кол Гаррити (2019) Монголын философийн уламжлалд Чин улсын үзүүлсэн нөлөөний талаар өгүүлсэн. Монголчуудын Хятадыг үзэн ядах үзэл, соёлын зааг ялгаа хооронд шууд холбоотой гэж дүгнэхэд өргөтгөсөн судалгаа хэрэгтэй. Монголд, Хятад хэлний нөлөө хязгаарлагдмал, Монголд Буддизмаас өөр Хятадын (болон Азийн бусад улсын) философийн нөлөө бараг л байхгүй, соёлын холбоо ч зөвхөн хэрэглээ төдийгөөр л хязгаарлагддаг билээ.

⁷ Ийм хандлага нь Монголын сонин, сэтгүүл төрөөс санхүүждэг байснаас хувийн хэвшилд шилжиж, хараат бус хэвлэл мэдээлэл олширсонтой зарим талаараа холбоотой юм. Уншигчдынхаа тоог нэмэгдүүлэхийн төлөөх өрсөлдөөний үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл “сенсацитай” мэдээ, ялангуяа олны танил хүмүүсийн амьдралын талаар мэдээлэл бэлдэх нь ихэссэн. Өрсөлдөөнт хэвлэл мэдээллийн хэрэгсэл эмэгтэйчүүдийг хүйсийн онцлогтой мэдээлэл түгээх соёлыг бий болгож буй төдийгүй, өдөр тутмын амьдралд хэвшүүлж байна. 1990-ээд оноос хойш, гоо сайхны тэмцээнүүд (тухайлбал, гоо сайхны тэмцээн, загварын шоу, бодибилдингийн тэмцээн гэх мэт) ихээхэн алдартай болсон.

гэдгээр нь хүртэл шүүмжлэх болов (Collier 2009). Тиймээс, оршин буй болон шинээр бий болж буй дундар давхаргын хүлээлт нь *Вог* (Vogue), *Космополитан* (Cosmopolitan) зэрэг Барууны загварын сэтгүүлүүдийн тодорхойлсны адил хувцаслах сонирхол, хэрэгцээг төрүүлж байна. Нүүр будалт, үнэт эдлэл, өндөр өсгийг зэрэг нь заавал хэрэглэх ёстой зүйлс болжээ.

Олон нийт эмэгтэй хүний эмэгтэйлэг талыг хэт хүйсээр онцолсон байдлаар, арилжааны шинжтэй сурталчилгаанд харуулдаг дүрийг тойрон ярилцаар, эмэгтэй хүнийг харагдах байдлаар дүгнэх болжээ. Үүнд дундаж давхаргын эмэгтэйчүүд гэлтгүй, УИХ-ын гишүүд ч хамаарна. Сонгуулийн кампанит ажлын үеэр хүмүүс, “Эмэгтэй улс төрч ямархуу харагдах ёстой вэ? УИХ-д сонгогдсон эмэгтэйд ямар имиж хамгийн тохиромжтой вэ? Тэр эмэгтэйлэг үү? Аль зэрэг эмэгтэйлэг вэ? гэх мэтээр ярилцахыг би зөндөө сонссон. Энэ мэтээр эмэгтэй хүнийг онцлон авч үзэх нь эмэгтэйчүүдийг эмзэг болгодог гэвэл, тэд УИХ-д сонгогдлоо гэхэд энэ эмзэг байдал алга болохгүй. Эмэгтэйчүүдэд нийгмийн болон ёс суртахууны хувьд эгэл жирийн этгээд байх ёстой атал тэд үзэсгэлэнт хатад, кино од, поп одод, загвар өмсөгч, гэртээ л гоёод суудаг эхнэр байх ёстой мэт хүлээлт бий болжээ.

Нэг талаар эмэгтэй хүнийг гүтгэх, бүр гутаан доромжлох, нөгөө талаас олон нийт эмэгтэй хүний бие, харагдах байдлыг хэт онцолдог зэргээс үзвэл эмэгтэй нэр дэвшигчид яагаад аль болоох албан ёсны, “аюулгүй” хувцас, имижийг сонгодгийг ойлгож болно. Эдгээр эмэгтэйчүүд хувцаслах хэв маягаа тодорхойлохдоо ердөө л ирж болзошгүй гүтгэлэг, дарамтаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ, хүндлүүлэхийг л эрмэлздэг. Хятадын урлагийн сургуулийн оюутнуудын дунд “бүтээлч зан чанарын” талаар судалсан Лили Чумли (2016) хэрэглэсэн “хэв маягаа тодорхойлох” гэх үгийг энд ашиглалаа. Чумлигийн судалгаанд хамрагдсан оюутнууд шинэ либерал орчин, түүнийг дагалдах гоо зүйн мэдрэмж, мэдээлэл бүхий урлаг хурдан өөрчлөгдөж буй цаг үед бэлтгэгдэж байгаа боловч реализмын хатуу ширүүн байдал, урлагт үзүүлэх социализмын нөлөө зэрэг сорилтуудыг шууд бусаар ч атугай даван туулах шаардлагатай байдаг аж. Монголын эмэгтэй улс төрчид гэдэг нь өмнөх нийгэмд байгаагүй, эмэгтэйлэг байдлын шинэ хэлбэр бөгөөд тэд эрэгтэй улс төрчдийн эмэгтэйчүүдийг хүйсээр нь ялгаварладаг орчин, түрэмгий хэвлэл мэдээлэл, шүүмжлэлт сонгогчид гэх мэт сорилтуудыг давах ёстой болж байна. Хятадын урлагийн сургуулийн оюутнууд ч тэр, Монголын эмэгтэй улс төрчид ч хэт их хяналт шалгалттай, тэр хэмжээгээрээ дарамттай орчинд ажиллаж байна. Чумли “хэв маягаа тодорхойлох” гэх үгийг хувь хүний оршин буй байдал, сорилтоо хэрхэн давж буйг тодорхойлоход ашигласан бол, би тус үгийг нэр дэвшигчид ялангуяа хувцаслалт, нүүр будалт гэх мэтийг ашиглан харагдах байдлаа хэрхэн тодорхойлж буй, улмаар

өөрийнхөө гадаад төрхийг бусдаас ялгаруулахын зэрэгцээ, хэмжээг нь хэрхэн барьж “аюулгүй” байлгаж буйг онцлоход ашиглалаа. Өөрөөр хэлбэл, эдгээр эмэгтэйчүүд хэрэглээгээ зохицуулах неолибералист хандлагыг ашиглан, неолиберализмын өөр нэг үр дүн, сонгуульжилтыг даван туулахыг хичээж байна.

Нэр дэвшигчид өөрийнхөө хэв маягийг тодорхойлж буй нь тэд хувцаслалтаараа бусдаас өөрийгөө илүү тодруулж, онцолж буй боловч, сонгуулийн амлалтыг бий болгож болзошгүй сэтгэл хөдөлгөм дүр төрхийг сонгогчдод төрүүлэх зорилготой. Нэр дэвшигчид хээнцэр хэв маяг, байр суурийг нь илэрхийлэх зүүлт чимэглэл зүүх нь энгийн эмэгтэйчүүдээс яаж ийгээд илүү харагдана. Өөрсдийгөө улс төрийн субъект болгон төлөвшүүлэхдээ нэр дэвшигчид голдуу ажил хэрэгч хослол, даашинз өмсөнө. Ихэнх нь Шанел маягийн, өөрийн биед яг таарсан, товчтой хослол өмсөх бөгөөд заримдаа энгэрийн тэмдэг, өндөр өсгийттэй хослуулна. Эдгээр нь зөвхөн эд баялаг, байр суурийг илэрхийлдэг зүйлс биш. Харин эмэгтэйчүүд эдгээр зүйлсийг хэрэглэснээр өөрт ирж болзошгүй доромжлолыг аль болох хол байлгах, эрэгтэйчүүдтэй ижил түвшинд бий гэдгээ илэрхийлэх, өөрсдийнхөө байгалийн хүйсийнхээ онцлогийг хэт илэрхийлэхгүйгээр дур булаам байдлыг бий болгохыг хичээдэг. Роланд Бартэс энэ талаар дараах зүйлийг бичжээ.

Шанелийн эрэгтэй, эмэгтэй хослолын аль аль нь “ялгарах” зорилгоороо нийтлэг. 19-р зуунд “ялгарах” гэдэг нь нийгмийн үнэт зүйл байлаа. Учир нь нийгэм нь дөнгөж ардчлагдсаны дараа дээд давхаргад хамаарах эрчүүд эд баялгаа сурталчлах эрхгүй байсан бөгөөд, эхнэртээ үнэт эдлэл мэтийг авч өгөх замаар бусдаас “ялгардаг” байсан аж. Шанелийн хэв маяг энэхүү түүхэн өвийг авахдаа илүү феминист байдлаар, илүү сайжруулж, боловсруулжээ (1995, 107).

Бартэсийн үзэл санаа нь эмэгтэй улс төрчдийн төдийгүй нийгмийн давхарга дахин тодорхойлогдож буй цаг үед өөрийгөө нийт массаас онцлох гэсэн эмэгтэй хүн бүрийн хувцаслах хэв маягийг тайлбарласан мэт. Сэхээтнүүд, профессорууд, улс төрийн намын албан хаагчид өөрсдийгөө ажилчид, малчдаас ялгах гэсэндээ хослол өмсдөг байсан социализмын үеийн хэв маяг тийм ч их өөрчлөгдсөнгүй. Гэсэн хэдий ч Бартэс (1995, 107-18) цааш нь эмэгтэй нэр дэвшигчид хүлээн авалтад илүү тохиромжтой ганган даашинз, үнэт эдлэлийг хэрэглээ болгосон орчин цагийн шинэ баячуудаас оюунлаг, улс төрийн элит гэх дүр төрхөө ялган харуулахыг хичээдэг талаар тайлбарлажээ. Тэрээр:

“Бүх загварын дотроос Шанел юуны төлөө тэмцдэг . . . жижиг хөрөнгөтний бүдүүлэг хэв загварыг зөвшөөрдөггүй . . . гэдгээрээ нийгэмд хамгийн тохирохуй, тийм ч учраас өөрийгөө гоо зүйн хувьд илэрхийлэх хэрэгцээ үүсэж буй шинэ нийгэмд, жишээлбэл, Москвад Шанел өмсөх нь хамгийн амжилттай яваа хүнийг тодоор илэрхийлэх магадлалтай байдаг (Barthes 1995, 107)” гэгжээ.

Дараагийн хэсэгт би Оюунгэрэлийн өмссөн барууны загварын ажил хэрэгч хослол, Занаагийн өмссөн үндэсний дээл гэсэн хоёр төрлийн хувцаслалтад шинжилгээ хийж үзлээ. Аль аль хувцаслалт нь онцлог агуулгатай. Үндэсний дээл нь үндэсний үзэл, өв соёлоо эрхэмлэн дээдлэх байдлыг илэрхийлэх бол, эмэгтэй загвар зохион бүтээгчид эрэгтэй хослолтой дүйцүүлж, эмэгтэйчүүдийн карьерыг дэмжих, нийтийн дунд эмэгтэйчүүдийн орон зайг бий болгох зорилгоор барууны маягийн ажил хэрэгч хослолыг бүтээжээ. Занаа, Оюунгэрэл хоёрын хэн хэн нь эдгээр хувцсыг ашиглан хувийнхаа улс төрийн мессежийг тун оновчтой илэрхийлсэн. Эдгээр хувцаслалт нь жендэрийн улс төр өөрчлөгдөж буй цаг үед өөрсдийгөө тодорхой төрлийн эмэгтэйчүүд гэдгийг илэрхийлэхэд улс төрийн болон, соёлын давхар утга санааг агуулдаг. Хувцаслалтаараа дамжуулж эдгээр эмэгтэйчүүд олон төрлийн сонгогчидтой зэрэг харилцахын зэрэгцээ өөрсдийн илэрхийлэх гэж оролдож буй танигдахуйг дахин бүтээж, шинэчилж, хүлээн зөвшөөрүүлжээ. Түүнчлэн, социализмын дараах Монголын нийгэмд жендэрийн талаарх төсөөлөл хэрхэн тодорхой бус, хоёрдмол агуулгатай буйг илэрхийлнэ.

Байгалийн төрх, барууны ажил хэрэгч хослол

Оюунгэрэлтэй биечлэн уулзаж, танилцахаас өмнө би Хөвсгөл (Оюунгэрэлийн төрсөн нутаг бөгөөд 2008 оны сонгуульд нэр дэвшсэн тойрог) аймгийн залуухан бүсгүйтэй уулзсан юм. Жагаа гэх тэр залуу бүсгүй Оюунгэрэлийг маш сайн мэдэх бөгөөд хэдийгээр умайн хүзүүний хорт хавдартай гэж оношлогдсон ч гэлээ ирэх сонгуульд Оюунгэрэлийн кампанит ажилд ажиллана хэмээн төлөвлөж байсан аж. “Оюунгэрэл сонгуулийнхаа тойрогт өнгөрсөн жилүүдэд их ч хүч хөдөлмөр зарцуулсан, их ч зүйл зольсон учир би Оюунгэрэлийн сонгуульд ажиллахаас үнэхээр татгалзаж чадахгүй. Оюунгэрэл урт сайхан үсээ хүртэл тайрсан шүү дээ. Тэрээр хосгүй сайхан урт үстэй, жинхэнэ мисс бүсгүй байв шүү дээ” гэж надад ярьсан юм.

Мисс гэх үг Монголд сайхан бүсгүй шалгаруулах “Монголын Мисс”, “Дэлхийн Мисс” зэрэг тэмцээнээс үүдэлтэйгээр үзэсгэлэнт эмэгтэй гэх утга илэрхийлнэ. Монголчууд гадаад төрхийн хувьд үзэсгэлэнтэй эмэгтэйг “мисс” гэж товчоор ярьж заншжээ. Монголчууд тэрний эхнэр нь ёстой мисс гэх зэргээр өдөр тутмын амьдралд хэрэглэж хэвшсэн. Гэвч Оюунгэрэл мисс гэх дүрээсээ зугтахыг хүсэж байв. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн өмнө тэрээр хүмүүст мисс гэж харагдаж болзошгүй харц булаам үнэт эдлэл, хэт дэгжин үсний засалт, биеийнхээ онцлогийг харуулах ил хувцас зэргээс зайлсхийнэ. Шулуун, тайрмал үсний засалт, бараан өнгийн ажил хэрэгч хослол, бараг мэдэгдэхээргүй бага зэрэг нүүрээ будсан Оюунгэрэл гадаад төрхөөрөө олны дэмжлэгийг

татахыг хичээх дэгжин, залуу бүсгүйчүүдээс эрс ялгарна. Өөрийнхөө дүр төрхийг өөрчилснөөр, тэрээр гадаад дур булаам байдлаараа бус, өөрийн эрх мэдэл, эзэмшсэн боловсрол, мэргэжлээрээ хүлээн зөвшөөрөгдөхийг хүсэж буй нь тодорхой харагддаг. Улс төрч болоход шаардлагатай бусад давуу талаа илүү олон нийгэд таниулахын тулд өөрийн гоо сайхныг нууж буй мэт. Олон хүн Оюунгэрэлийг угаасаа сайхан төрсөн бүсгүй гэж ярьдаг. Гэвч тэрээр өөрийнхөө эмэгтэйлэг байдлыг гоо сайхны бүтээгдэхүүний хэт хэрэглээний нөлөөнд зонхилох болсон, хэвшмэл хэв маягаар илэрхийлэхийг хүсээгүй юм.⁸

Оюунгэрэл нийтлэг байх урт үс, хэтэрсэн нүүрний будаг, хээнцэр даашинз, гоёл чимэглэлийн хэрэгсэл зэргээс эрс тагталзаж, харин эрх мэдэлд хүрэх, олны анхаарлыг татахдаа өөрийн онцлог эмэгтэйлэг байдлаа ашигласан юм. Улаанбаатарт болон бусад хот суурин газруудад ажиллахдаа Оюунгэрэл голдуу том товчтой цагаан цамц, бараан өнгийн хослол, түүнтэй өнгө дагуу гутал сонгож өмсөнө. Мөн, ажлын цүнх үргэлж барих нь Оюунгэрэлийг эршүүд биш юм аа гэхэд жендэрийн хувьд эмэгтэйлэг ч биш, эршүүд ч биш нийтлэг дүр төрхтэй харагдуулна (дүрс 6.1).⁹ Оюунгэрэл өөрөө хотод, болон хөдөөд имижээ хэрхэн бүрдүүлэх нь түүний улс төрийн замналд нь адилхан чухал нөлөөтэй гэж үздэг. Тэр бүү хэл тэрээр чангаар, удаанаар гар барих дадалд хүртэл суралцжээ. Энэ нь түүнийг эрэгтэй хамтран зүтгэгчдээс нь ялгаруулахгүй бөгөөд, улс төрийнх нь мессежинд нь ч эргэлзээ төрүүлэхгүй аж.

Иелийн их сургуулийн Дэлхийн манлайлагч хөтөлбөрийн хүрээнд АНУ-д суралцаж байхдаа Оюунгэрэл улс төрд нэр дэвшиж буй хүн имижээ хэрхэн зохистой бүрдүүлэх талаар зөвлөгөө авчээ. Зөвлөгөөний дагуу тэрээр тухайн үед урт, сүлжсэн үсээ тайрч, орчин үеийн тайрмал маягаар үсээ засуулсан бөгөөд байгалийн төрхийг нь илүү тодруулахын тулд нүүр будгийг аль болох бага (Монгол хүний мэдрэмжид нийцүүлж тод уруулын будаг хэрэглэдэг боловч) хэмжээтэй хэрэглэх болжээ. Мөн түүнд сонгогчдод амархан хоногшихын тулд ижил загварын хувцас сонгохыг зөвлөсөн байна. Ингээд Оюунгэрэл АНУ-ын телевизийн шоууудад гардаг хуульчийн энгийн мөртөө өөгүй имижийг бүрдүүлэв. Мөн тэрээр сурталчилгааныхаа зургийг Хилари Клинтон гэх мэт томоохон улс төрчдөд үйлчилдэг мэргэжлийн гэрэл зургийн студиэр даруулжээ. Оюунгэрэл мөн инээмсэглэх, зургийн үеэр ямар байрлал, өрөлт авах талаар ч сургалт авсан байна.

Гэсэн хэдий ч, энэ бүх өөрчлөлт, шилжилтээс үл хамааран Оюунгэрэл эмэгтэйлэг хувцас, чимэглэл нь Монгол сонгогчдын анхаарлыг татахад чухал

⁸ 2016 оны дараа, Оюунгэрэл биеэ бэлдэх тактикаа өөрчилсөн. Тэрээр даашинз, болон тод өнгийн хувцаснууд өмсөж, гоо сайхны техникүүд ашиглаж, илүү эмэгтэйлэг дүр төрх гаргах болов. Түүнчлэн, тэрээр гоо сайхны бүтээгдэхүүний болон хувцасны модел болж, өөрийнхөө засаж янзалсан зургуудыг социал медиагаар түгээжээ. Энэхүү өөрчлөлт нь гоо сайхан бол дээшээ тэмүүлэх хөдөлгөөнд хүч нэмэх арга зам гэдгийг харуулна.

⁹ Монгол үндэсний дээл нь жендэрийн онцлогийг илтгэдэггүй, уламжлалт хувцас юм. Материалын өнгө, товч, эмжээр, ханцуйны хэлбэр зэрэг элементээр жендэрийн онцлогийг гаргаж болох хэдий ч, зайлшгүй шаардлага биш. Дээлийг хүн хүссэнээрээ энгийн байлгаж болно.

хэрэглэгдэхүүн болохыг тэмдэглэсэн юм. 2008 оны 6-р сарын маш халуун нэгэн өдөр сонгуулийн сурталчилгааны ажлаар явж байхдаа тэрээр дээл, гутлаа тайлж, нимгэн дашинз, сандал өмсжээ. Хувцсаа солиод гудамжаар алхаж явбал зөрж өнгөрөх хүмүүс Оюунгэрэлийг хэрхэн сонирхож, онцгой анхаарч буйг анзаарахгүй байж чадсангүй. Тэрээр, “Дээл, хослол өмссөнөөс дашинз өмссөн бол намайг илүү найрсаг хүлээн авах байж” хэмээн ярьсан юм. Сурталчилгааныхаа ажлын дундаас дашинз өмсөж эхлэх тухай бодол орж ирсэн боловч тэрээр эхэлсэн имиждээ үнэнч байж, сурталчилгаагаа дуусгахаар шийджээ.



Дүрс 6.1. Оюунгэрэл, түүний ард талд сурталчилгаанд ашигласан нисдэг тэрэг харагдаж байна. Хөвсгөл аймаг. Зургийн эрхийг Оюунгэрэл



Дүрс 6.2. Оюунгэрэл дээл, гутал өмссөн бусад гурван нэр дэвшигчийн хамт Хөвсгөл аймагт, сонгогчидтой уулзаж буй нь. Зургийн эрхийг Оюунгэрэл



Дүрс 6.3. Ажил хэрэгч хослолоос үндэсний дээл, Оюунгэрэл моринд мордсон байдалтай Хөвсгөл аймгийн орон нутгийн телевизэд ярилцлага өгч буй нь. Зургийн эрхийг Оюунгэрэл

Надтай уулзсан ихэнх эмэгтэй нэр дэвшигчид, улс төрчид эмэгтэйлэг байдлын илүү зоримог шинжээс, үгүйдээ л барууны зонхилогч загварын стандартаас татгалзаж байсан мэт санагддаг. Тухайлбал, эмэгтэйчүүд энгэрээ их задгайлж, үсээ задгай тавилгүй, урт үс, хэт тод нүүр будалтаас татгалзаж, хослол, даашинз л өмсөх бөгөөд даашинз нь дэрвэгэр хормой, торон эмжээргүй энгийн л загвартай байх нь түгээмэл. Гэвч эдгээр гоёл, чимэглэлийг жирийн Монгол эмэгтэйчүүд элдэв арга хэмжээний үеэр чөлөөтэй өмсдөг билээ. Цөөн улс төрч эмэгтэйчүүд гоёл чимэглэл хэрэглэх боловч энгийн сувдан зүүлт, хослолын энгэрийн чимэглэл, ээмэгнээс хэтэрдэггүй нь илүү мэргэжлийн, амжилттай байдлыг илэрхийлнэ. Монголчуудын олон нийтийн төсөөлөл, хэвлэл мэдээлэл, улс төрийн орчинд түгээгдэж байдаг яриа, хэлэлцүүлэг зэргийг тооцвол Оюунгэрэл сандаал, зуны даашинзнаас татгалзаж, бараан өнгийн дээл, өвдгөө шүргэсэн түрийтэй гутал, ажил хэрэгч хослолыг сонгосон нь стратегийн шинжтэй имиж бүрдүүлэлт гэдгийг ойлгож болох. Тэр бүү хэл арай тод өнгийн хослол, гоёл чимэглэл зоригтой хэрэглэдэг бусад эмэгтэй нэр дэвшигчдийн дунд ч Оюунгэрэл бараан өнгийн хослолоо өмссөөр байв. Хослолынх нь өнгө, загвар нь түүнийг бусад бүх эмэгтэй нэр дэвшигчдээс ялгана. Ерөнхийдөө Оюунгэрэлийн хувцаслалт бусдаас ялгарах давхар онцлогтой байв. Нэгдүгээрт, хэт ганган, эмэгтэйлэг, хүйсийнхээ онцлогийг тодруулсан хувцаслалтын хэв маягаас эрс ялгардаг, харин хоёрдугаарт, ихэнх эмэгтэй нэр дэвшигчид өмсдөг арай өнгөлөг хослол, даашинзнаас ч мөн адил ялгарч байв.

Оюунгэрэл өөрийгөө гаднаасаа болон дотроосоо ч өөрчилсөн. Оюунгэрэлийн дуу хоолойг (улс төрч хүний хамгийн чухал хэрэгслүүдийн нэг) хэт “нарийн”, дээгүүр өнгөөр ярьдаг тул сонгогчид түүний яриаг тайвнаар, удаан сонсоход зохимжгүй гэжээ. Ингээд тэрээр илүү хүчирхэг, харизмтай байдлыг илэрхийлэх “бүдүүн” хоолойгоор ярьж сурахын тулд мэргэжлийн дуучдаас зөвлөгөө, хичээл авч илүү доод өнгөөр ярих дадлага хийжээ. Улс төрч хүнд тохиромжтой гэж үзсэн хоолойгоор ярьж сурахын тулд тэрээр хоёр жил хичээллэсэн байна. Намайг Оюунгэрэлийн ажил дээр нь очиж уулзах үед тэрээр өөр өөр гэмээр хоолойгоор ярьж үзүүлсэн юм. Туслахуудтайгаа ярихдаа тэрээр нэгэн хэмийн, бүдүүндүү хоолойгоор ярих бөгөөд, надтай арай нарийн, дээд өнгөөр, динамик байдлаар ярьж байлаа. Хоолойных нь өнгө өөрчлөгдөж буйг би бага зэрэг анзаарч байсан боловч, тэрээр надад энэ талаараа ярьж өгөөгүй бол би үл ялиг гайхаад л өнгөрөх байсан биз ээ.

Харизм ба орчин цагийн Дээл

Загварын салбарынхан Монгол үндэсний дээлийг зоримог, бүтээлч байдлаар шинэчилж, олон нийтэд танилцуулавч улс төрчид дээлийг

уламжлалт байдлаар нь өмсөхийг эрхэмлэнэ. Харин энд өгүүлэх нэг эмэгтэй нэр дэвшигчийн жишээгээр дамжуулан эмэгтэйлэг байдлын талаарх олон нийтийн үзэл санаанд нийцэхийн тулд уламжлалт дээлийг ашиглаж буйг үзүүлье.

Өнөө цагийн улс төрийн идэвхтэн, анхны феминистүүдийн нэг Занаа 2008 оны сонгуульд бие даан нэр дэвшлээ. Тэрээр цэнхэр өнгийн үйтэн хуаран урт торгон дээл өмсөж, мөрөн дээгүүрээ зүүсэн ороолтоо хөлийнхөө шагай хүртэл унжуулжээ (дүрс 6.4). Монголын хөдөөд дээлийг өдөр тутам өмсөх боловч, хот суурин газарт тийм ч элбэг өмсдөггүй. Хотын ихэнх эмэгтэйчүүд, ялангуяа боловсролтой, дундаж давхаргын эмэгтэйчүүд өдөр тутамдаа Барууны хэв маягийн хувцас өмснө. Тэд дээлийг шагнал гардуулах ёслол, үндэсний баярын өдрүүд, эсвэл олон нийтийн арга хэмжээнд үг хэлэхдээ л хааяа өмсдөг. Урт нимгэн ороолт Монгол үндэсний хувцас ч биш, дээлтэй ч тэр болгон хэрэглэгддэггүй билээ. Тиймээс, Занаа дээлийг барууны хэв маягийн хувцас буюу урт нимгэн ороолттой хослуулж өмссөн нь шинэлэг бөгөөд олны анхаарлыг татахуйц байлаа. Барууны хувцас өмсвөл Занаа хотын олноос ялгарахааргүй байв. Харин урт торгон ороолт унжуулж зүүсэн Занаагийн алхаа түүний харизмыг илтгэх төдийгүй 2008 оны сонгуулийн үеэр тус имижийг бүрдүүлсэн Занааг Улаанбаатар хотын янз бүрийн хэсэгт харж болох байлаа.



Дүрс 6.4. Занаа сонгуулийнхаа санхүүжилт босгох уулзалтын үеэр. Улаанбаатар хот, 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Нэгэн удаа би өөр нэг эмэгтэй нэр дэвшигчийн хамт машинтай гэрлэн дохио солигдохыг хүлээж байв. Энэ үед тод цэнхэр дээл, өргөн хүрээтэй бүрх малгай өмссөн Занаа гудамжаар алхаж буйг харвал бараг л тунгалаг даавуун ороолт нь хэдэн алхмын ард намирч яваа мэт. Надтай хамт явсан нэр дэвшигч Занааг сайн таних бөгөөд надад нэгэн үзмэрч Занаад ийнхүү хувцаслахыг нь зааж өгсөн талаар ярив. (Үзмэрч Занаад цэнхэр дээл, урт ороолт санал болгосон бөгөөд өөр нэгэн эмэгтэйд хурц ажил хэрэгч хослол өмсөхийг зөвлөсөн гэнэ.) Үзмэрч яагаад ингэсэн юм бол гэж би лавлавал тус үзмэрч эмэгтэй улс төрчдөд хүлээн зөвшөөрөгдөхүйц олон нийтийн анхаарлыг татах, имиж бүрдүүлэхэд тусалж байсан гэх. Үзмэрч бараан өнгийн ажил хэрэгч хослол өмсөхийг санал болгосон нөгөө нэр дэвшигч нь зөөлөн яриатай, даруухан, эелдэг хүн байжээ. Тиймээс барууны хэв маягийн бараан өнгийн хослолыг санал болгосноор тэр нэр дэвшигчийг илүү хүчирхэг харагдуулахыг оролджээ. Хожим нь ийм хослол өмсөх зөвлөгөө авсан “дөлгөөн” эмэгтэй нь Бүдээгийн Мөнхтуяа байсныг би мэдсэн юм (дүрс 3.2, 3.7).

Дээл өмсөж, урт ороолт зүүсэн Занаагийн хувьд байдал өөр байлаа. Занаа бол феминист, идэвхтэн, иргэний нийгмийн манлайлагч эмэгтэй юм. Тэрээр аливаад буулт хийдэггүй, итгэл үнэмшилдээ бат зогсохын дээр эрчүүдийн дээрэнгүй үзэл, авлига, бусад болж бүтэхгүй үйлдлүүдийг нь шүүмжлэхдээ огтхон ч эргэлздэггүй. Зарим хүмүүс түүнийг сүрдмээр гэж бодох бол, зарим нь түүнийг хэтэрхий шулуун зантай тул хамт байхад тухгүй гэж дүгнэнэ. Юутай ч бүгд Занаагийн харизмыг хүлээн зөвшөөрнө. Би өөр өөр улс төрийн намын эмэгтэйчүүдийн хэд хэдэн уулзалтад оролцож байсан. Эмэгтэйчүүд нэр дэвших тухай яриа өрнөж эхлэх бүрд Занаа мэт иргэний нийгмийн өндөр харизмтай эмэгтэйчүүд хүчтэй өрсөлдөгч бөгөөд түүнтэй өрсөлдвөл ялах магадлал нь багасах тухай яриа өрнөж байлаа.

Занаагийн дээл, ороолт нь барууны хэв маягийн бусад ямар ч хувцас онцолж чадахааргүй түүний харизм, болон бусад онцлог шинжийг улам тодруулж өгчээ. Занаа иргэний нийгэм дэх ажлын гараагаа феминизм, жендэрийн тэгш байдлын төлөөх идэвхтний хувьд иргэний нийгмийн эвсэл байгуулах ажлаар эхэлжээ. 1990-ээд оны эхэнд тэрээр жендэрийн тэгш байдлыг талаарх үзэл санааг танилцуулах үед эмэгтэйчүүд дарга болохын төлөөх тэмцэл гэж буруугаар хүлээн авдаг байлаа. Учир нь жендэрийн тэгш байдал ч тэр, феминизм ч тэр Америк, Европоос гаралтай ойлголт бөгөөд Занаа барууны үнэт зүйлийг Монголд түгээх гэж байна гэж хүмүүс үзэж байжээ. Хөдөөгийн нэгэн залуу охин надад баруунд боловсрол эзэмшсэн нэр дэвшигчид “Монголынхоо хөрсийг мэдэрдэггүй”, тэд хэт “хөндийрсөн” байдаг талаар ярьж байсан билээ. Занаад зөвлөсөн өнөөх үзмэрч түүнийг Монголын хөрсөнд тохирохгүй гэж үзсэн эсэхийг би сайн мэдэхгүй юм. Ямартай ч Занаа сонгуулийн кампанит ажлынхаа турш Монгол дээл өмсөж байсан нь олон нийтэд

түүнийг Монголын хөрсөнд нийцсэн, уламжлалаа эрхэмлэдэг гэдгийг сануулахад тус болсон нь дамжиггүй. Түүнчлэн, урт нимгэн ороолт гэх мэт эмэгтэйлэг гоёл чимэглэлийг (дээл нь бүх жендэрийн онцлоггүй хувцас билээ) ашигласнаар түүний дүр төрхийг зөөлрүүлж, хатуу ширүүн харагдуулахгүйг зорьжээ. Урт нимгэн алчуур нь Занааг эмэгтэйлэг харагдуулахын зэрэгцээ дээлтэй хослуульж зүүх тул биеэ ил гаргах шаардлагагүй. Мөн урт нимгэн ороолт нь Занаагийн оршихуйг илэрхийлэхээс түүний биеийг онцлоогүй билээ. Дээл, ороолт нь мэдээж хэрэг Занаа гэж хүнийг шинээр урлаагүй. Тэдгээрийг өмссөн ч гэлээ Занаа феминист, баруунжсан, хотын эмэгтэй хэвээр. Ерөнхийдөө, хувь хүмүүс өөрсдийн онцлог шинжийг илэрхийлэхийн тулд намирсан алчуур, ой тоонд хоногшсон гоёл чимэглэл, ажил хэрэгч хослол, ажлын цүнх, дээл зэргийг өмсөж буй ч гэлээ хүйсээр ялгаварладаг байдал, эмэгтэйчүүдийг хүйсийн онцлогт тулгуурлан хэвлэл мэдээлэл, олон нийт увайгүй шүүмжилдэг байдлын эсрэг хүчирхэг, харизмтай гэдгээ харуулж, өөрийнхөө хэв маягийг тодорхойлж буй үйлдэл юм.

Дотоод хүнээ хөгжүүлэх нь: Нэр дэвшигч байхын төлөө

Нэр дэвшигч сонгуульд биеэ бэлдэх нь хувцаслах хэв маягаас хамаагүй гүнзгий, нарийн үйл билээ. Биедээ тохиромжтой хувцас хэрэгсэл сонгож өөрийгөө харуулах нь хангалттай биш бөгөөд өөрийнхөө дотоод ертөнцийг, цаашлаад биеийн болон сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарах нь ч амин чухал ач холбогдолтой. Би Улаанбаатар хотод нэр дэвшигч Одонтуятай 2008 оны хавар анх танилцах үед тэрээр өөрийн өөгүй, сэтгэл татам гадаад төрхөөсөө гадна дотоод ертөнцөө хөгжүүлэхийг хичээж байсан юм. Одонтуяа Сингапур болон Азийн зарим улсаас албан тасалгааны тавилга импортолдог Сентоза хэмээх тавилгын сүлжээ эзэмшдэг. “Тэрээр өөрөө мөнгөтэй, нөхөр нь нөлөөтэй учраас АН түүнийг чухалчлан авч үздэг” гэж нэгэн ярилцагч маань надад ярьж билээ.

Би Одонтуяаг өдрийн хоолонд урьж, бид Улаанбаатар хотод элбэг байх стейк, жигнэсэн махаар үйлчилдэг барууны маягийн ресторануудын нэгний үүдэнд уулзахаар тохиров. Би болзсон цагаасаа нэлээд өмнө ирвэл тэрээр аль хэдийн ирчихсэн байлаа. Бид орж ширээнд суухад, Одонтуяа сурталчилгааныхаа бэлтгэл ажлын талаар надад танилцуулж цаг алдсангүй, харин өөрөө барьж ирсэн сурталчилгааныхаа тараах материалыг гаргаж ирээд надад тайлбарлаж эхлэв. Бидний уулзалт бол Одонтуяагийн ажлын (сонгуулийн кампанит ажлын бэлтгэл) нэг хэсэг бөгөөд, тэрээр өөрийгөө чадварлаг, зохион байгуулалттай, хичээнгүй нэр дэвшигч гэдгээ харуулж буйг уулзалтын туршид би анзаарч суулаа. Тэрээр сонгогчдодоо хүрч ажиллахын тулд Иргэн Та Баялаг гэх ТББ-аа

өргөжүүлж буй талаараа надад ярьж өгөв.¹⁰ Тэрээр тойргийнхоо иргэдэд мэндчилгээ, төрсөн өдрийн ил захидал илгээж, хүүхдүүдэд зориулсан урлан бүтээх чиглэлийн арга хэмжээ зохион байгуулж, өөрөө хүүхэд байхаасаа цуглуулсан 400 гаруй хүүхэлдэйн тоглоом бүхий үзэсгэлэн гаргах гэх мэт олон ажил хийж байжээ. Би түүний өдөр тутмын ажилтай танилцахын тулд ТББ руу нь очихоор тохироод бид саллаа.

Бидний дараагийн уулзалт Улаанбаатар хотын төв зам дагуу дөрвөн давхар барилгад байрлах Одонтуяагийн ТББ-ын байранд болов. Бид оффистой нь танилцаж явах зуур Одонтуяа надад ажилчдаа, хийдэг үүрэг хариуцлагынх нь хамт танилцуулна. Хамгийн захын өрөөнд орвол харанхуйд хоёр залуу хуучны проектороор хар цагаан кино тоглуулж байлаа. 1960, 1970-аад оны үед Одонтуяагийн аав нь бичиж авсан тэдний гэр бүлийн бичлэг аж. Хөдөө, ойн дэргэд, голын захад авсан дүрс бололтой. “Манай гэр бүлийн амралтын бичлэг байх” гэж Одонтуяа хэллээ. Бичлэг дээр 5-6 орчим насны жаахан охин жижигхэн ванны өмнө явган суугаад, овоолсон хувцас ширүүн үрж угааж байгаа дүрс гарна. Өрөөнд байгаа бүх хүн дэлгэц рүү нүд цавчилгүй ширтэнэ. Одонтуяа, “Ммм. . . би одоо юу угааж суугаа юм бол доо, миний л хувцас байх даа. Би ч үргэлж л ажлын хэнхэг байсан дөө” гэв. Бид өрөөнөөс гарахад Одонтуяа тус бичлэгүүдийг ашиглан өөрийнхөө талаар баримтат кино хийж, сонгуулийн кампанидаа ашиглахаар төлөвлөж буйгаа хэлсэн юм.

Шаргуу байдал, ажлын ёс зүй зэрэг нь Одонтуяагийн олон нийтэд өөрийгөө таниулсан имижийнх нь гол шинжүүд билээ. Тухайлбал, түүний сонгогчдод тараах материалд ч, түүний хувийн цахим хуудсанд ч Одонтуяа төгөлдөр хуур тоглодгийг дурджээ. Төгөлдөр хуур нь социализмын үед, гагцхүү мэргэжлийн хөгжмийн сургуулиудад л байсан ховор хөгжмийн зэмсэг билээ. 1978 оны тэрээр төгөлдөр хуурын тэмцээнд Моцартын “Турк марш” тоглож түрүүлээд, Болгар явж амрах эрхийн бичгээр шагнуулжээ¹¹. Хэдийгээр өдөрт хэдэн цаг ажилладгаа надад илэрхийлж ярьж байгаагүй ч гэлээ, түүнтэй харилцах харилцаа, ярилцлагынхаа туршид ажлыг бүхний тэргүүнд тавьдаг хүн юм байна гэдгийг би анзаарсан. Түүний ажлын ёс зүй түүний бахархлын үндэс юм.

Одонтуяа хийж, хэрэгжүүлж байсан олон төсөл, арга хэмжээнүүдийнхээ талаар танилцуулсан ч “Эрүүл иргэд нийгмийн баялаг” нь материаллаг өмчтэй холбогддог баялаг гэх ойлголтыг иргэд рүүгээ эргүүлж, иргэд өөрсдөө эх орны баялаг гэдгийг ойлгуулах гэсэн түүний оролдлогыг шууд илэрхийлдэг. Одонтуяа өөрөө өөртөө туслах гэх тухайн үеийн чиг хандлага болж байсан неолиберал, барууны үзэл санааг сурталчилсан. Тэрээр тойргийнхоо сонгогчдод өөрөө өөрийгөө

¹⁰ТББ-ын нэр нь социализмын дараа маш олон хүний санааг зовоосон гол зүйл болсон материаллаг баялгийн араас хөөцөлдөх үзэгдлийн хариу үйлдэл байсан гэлтэй. Иргэд ч мөн адил улс орны баялаг гэдгийг тунхагласнаар, Одонтуяа хүн ч гэсэн хэмжигдэхүйц, сайжруулж болох баялаг бүтээгч мөн гэх неолиберал үнэт зүйлсийг ойлгуулсан юм.

¹¹“Намтарчилсан хөпөр” <http://odontuya.com/content.php?id=99&rid=39>

халамжлах, эрүүл хооллолт, эрүүл амьдралын хэв маяг, дасгал хөдөлгөөн хийж хэвшихийг уриалав. Тэрээр надад өөрийнхөө мацаг барих дадал, мацгаар дамжуулж хэрхэн амьдралаа өөрчилснөө, хэрхэн дуусашгүй эрч хүчтэй болсноо, улмаар ажиллах арвин цагтай болсноо, гялалзсан царай, гоолиг биетэй болсноо хүртэл надад ярилаа. Үндэсний төмөр зам түүний сонгуулийн тойрогт хамаарах бөгөөд тэрээр төмөр замчдад өгөх лекцэдээ ч намайг урив.

Лекцэд нь хүрч очвол Одонтуяа туслахуудын хамт байх бөгөөд төмөр замын депогийн үүдэнд тэдэнтэй таарав. Зуны сайхан өглөө байлаа. Бид ч төмөр замын барилгын гадаа жаал алхав. Одонтуяа хувцсаа өдөр бүр сольдог байсан ч дунд зэргийн өсгийтэй, оломтой сандаалуудаа байнга өмсөнө. Тэр гоёмсог сандалтайгаа хайрга, тоос шороотой гудамжаар алхахад дэндүү хайран гэмээр. Бид лекцийн цагаас эрт ирсэн бөгөөд хаалга нь хараахан онгойгоогүй байсан юм. Биднийг хүлээх зуур Одонтуяа надад яагаад мацаг барихаар шийдсэнээ ярьж өгсөн юм.

Хэдэн жилийн өмнө хуучны танилтайгаа Бээжингийн онгоцны буудал дээр таарлаа. Өвөл байсан тул би гадуур хүрмийнхээ дотуур ноосон цамц давхарлан өмссөн байж. Би ч ажилдаа анхаараад өөртөө анхаарах цаг зав ч гүй байсан үе. Найз маань надтай мэндлээд ярилцаж байх зуураа тэрээр гэнэт, “Ммм. . . эмэгтэйчүүд биеэ хаядаг насандаа ирээ юу даа. Маш олон бүсгүйчүүд нас, жин нэмэхийн зэрэгцээ, нүүр будалт, хувцаслалтдаа ч анхаарахаа больдог үе байдаг даа, тэр үе” гэж хэллээ. Яг энэ үед л би өөрийгөө хаяж болохгүй юм байна гэж ойлгосон. Тиймээс өөрийгөө хэзээ ч хаяхгүй, гартаа бүрэн авахаар шийдсэн юм.



Дүрс 6.5. Одонтуяа төмөр замчдад лекц уншиж байна. Улаанбаатар хот 2008 он. Зохиогчийн дарсан зураг.

Одонтуяа надад мацаг, дасгал, хоолны дэглэмийнхээ талаар ярьсны дараа бид лекцийн танхим руу явж оров. Ойролцоогоор 150 гаруй эмэгтэй төмөр замчид Одонтуяагийн яриаг сонсохоор хүрэлцэн иржээ (дүрс 6.5). Тэрээр эд материалд авталгүй, бусдын санаа бодлоос хараат бус хэрхэн аз жаргалтай амьдрах талаар нэлээн урт танилцуулсны эцэст дараах байдлаар үргэлжлүүлэв.

Монгол эмэгтэйчүүд хүчирхэг, тийм учраас ямар ч ажил мэргэжил эзэмисэн амжилтад хүрэх чадвартай. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд бидэнд, хамгийн амжилттай яваа нэгэнд ч хүртэл нийтлэг сул тал байна. Бид эрүүл амьдралын хэв маягийн талаар, гоо сайхан байхын үндэс суурь нь эрүүл мэнд гэдэг талаар мэддэггүй юм байна. Ихэнх бүсгүйчүүд алмаазан эдлэл, үнэтэй хувцас худалдаж авахыг боддог ч, эрүүл хооллох соёл, эрүүл мэндийн талаар мэддэггүй, сонирхдоггүй юм байна.

Би ч гэсэн таван жилийн өмнө өөхтэй бууз тааваараа идчихээд жин нэмэхдээ бусдыг л буруутгадаг байлаа. Тэр үед Орос найз маань надад эрүүл амьдралын хэв маяг, эрүүл хүнс, зөв хооллох дадал зуршлын талаар ном бэлэглэсэн юм. Би амьдралынхаа хэв маягийг 100 хувь өөрчилсөн. Гоо сайхан гэдэг эрүүл бие, саруул ухаанд оршдог гэдгийг ч би ойлгосон. Тиймээс, үнэтэй нүүр будаг, арьс арчилгааны хэрэгсэл, загварлаг хувцас зэрэг нь гоо сайханд хүрэх хангалттай хэрэгсэл биш ээ. Би тэвчээртэй, сахилга баттай, хувийн зохион байгуулалттай, магадгүй дасгал хийж, биеэ анхаарч, хорт дадлаас татгалзаж байж эрүүл биетэй, залуу харагдах юм байна гэдгийг ойлгосон. Жишээ нь, богино хугацаанд тураана гэж сурталчилж буй бэлдмэл, тураах тос зэрэг нь хөгширөлтийг зогсоож чадахгүй, харин тэдгээр нь зөвхөн өөрөөсөө ичиж санаа зовоход, өөрийгөө голоход л нэмэрлэх юм.

Үүний эсрэгээр, Одонтуяа мацаг барьснаар хүссэн жингээ хасаж, дотор эрхтнүүдээ цэвэрлэж, эрч хүч, олж авдаг талаар зөвлөв. 24 цагийн мацаг буюу өдөрт нэг л удаа хооллох аргыг санал болгов. Тэрээр эмэгтэй төмөр замчдад лекц уншиж буй бөгөөд, дийлэнх нь дотоодын аялал болон Транс Сибирийн төмөр замаар Улаанбаатараас Москва, Бээжингийн чиглэлд аялах галт тэрэгний бүхээгийн ажилчид аж. Тэд аяллын хуваариасаа болж тогтмол цагт хооллож чадахгүй бэрхшээл буйг дурдахад, Одонтуяа энэ сул талыг давуу тал болгон ашиглаж мацаг барихыг уриалж байсан юм.

Дараа нь тэрээр нийтлэг хоол хүнсний талаар ярьж эхлэв. Цагаан будаа Азийн олон хүнийг өлсгөлөнд нэрвэгдэхээс аварсан боловч шим тэжээл сайтай хүнс биш. Цагаан будаа түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Тиймээс цагаан будааны хэрэглээг багасгаж, жимс, хүнсний ногоо, байгалийн зэрлэг жимс зэрэг шим тэжээлтэй хүнсний хэрэглээгээ нэмэгдүүлэх цаг нь болсон гэх мэтээр яриу. Татгалзах ёстой хүнсний

талаар ярихдаа Одонтуяа пүнтүүсийг онцлов. Харин оронд нь лууван хэрэглэж болно гэв. “Охин маань тухтай суугаад хоолоо ч иддэггүй. Үргэлж л гадаа тоглоно. Тиймээс бид жимсний шүүс шахагч авсан юм. Тиймээс луувангаа буталж шүүс болгоход тэр дор нь уучхаад гадаа гарч тоглоно. Бид суугаад луувангаа ид гэж шаардах ч хэрэггүй болсон юм” гэлээ. Тэрээр цааш нь “орой бүр гэртээ хариад нэг цаг гүйлгийн зам дээр алхдаг. Хөлс гарах тусмаа бие дэх бохирдол гадагшилж байдаг” гэв.



Дүрс 6.6. Одонтуяагийн сурталчилгааны постер. Улаанбаатар, 2012 он. Зохиогчийн дарсан зураг.

Хоол, шим тэжээл, хүнснээс авах илчлэгийн хэмжээг өөрчилж, дасгал хөдөлгөөн хийснээр гоо сайхан байх тухай санаа нь шинэ зүйл биш байлаа. Харин Монголын өнөөгийн зах зээл, амьдралын хэв маягт тохируулан мэдээлэл олгож буй тул Одонтуяагийн лекц амьдралд хэрэгтэй зөвлөгөөгөөр дүүрэн байсан юм. Зах зээлийн эдийн засаг өргөжин хөгжсөнөөр Монголчууд өмнө нь бараг л мэддэггүй байсан хүнсний олон бүтээгдэхүүн орж ирж, хүмүүс хэрэглэх бололцоотой болсон юм. Өмнө нь Монголын хот суурин газарт хоол хүнсний хэрэглээ нь үндсэндээ мах, улаан буудай, цагаан идээ, хүйтэн нөхцөлд ургадаг цөөн төрлийн хүнсний ногоо төдийгөөр л хязгаарлагддаг байлаа. Одонтуяа төмөр замчдаас эрүүл мэнд, гоо сайхан байх талаар юу мэдэхийг хүсэж байгааг нь асуувал, зарим эмэгтэйчүүд төрөл бүрийн хүнсэнд агуулагдах шим тэжээлийн талаар мэдэхийг үнэхээр хүсэж байгаагаа илэрхийлж байсан юм.

Одонтуяагийн лекц нийгэмд гоо сайхан байх талаарх хэвшмэл ойлголтыг илүү задалж, эрүүл мэнд, амьдралын хэв маяг, хоолны шим тэжээл зэрэгтэй холбож өгсөн. Одонтуяа гоо сайхан бол өөрчилж болдог зүйл бөгөөд, үр дүн нь хувь хүний тууштай байдлаас хамааралтай болохыг эмэгтэйчүүдэд ойлгуулсан юм (Тэрээр гоо сайхныг өөрчилж болно гэдэгтээ гоо сайхны мэс засал, Ботокс зэргийг хэлээгүй бөгөөд

тухайн үед амар хялбараар гоо сайхан болох эдгээр аргууд ихээхэн түгээмэл байсныг өөрчлөхийг зорьж байв). Хүний бие өөрийн хүсэл эрмэлзэл, мэдлэг, үйлдлээр цэгцэрч, сайжирч, өөрчлөгдөж байдаг гэдэг санааг Оюунтуяа хүргэхийг хичээж байлаа. Энэ нь бие бол зөвхөн байгальд бус, соёлд ч мөн хамаарна гэх үзэл санааг санагдуулна. Тэрээр цааш нь эрүүл биетэй байж чадвал гоо сайхан, эрч хүч зэрэг бусад капиталыг бий болгож болно гэх санааг мөн илэрхийлсэн юм.

2008, 2012, 2016, 2020 оны сонгуулиар Одонтуяагийн биедээ таарсан хослол, хувцас нь биеийнх нь галбирыг тодотгож байлаа. Тэрээр нэг бол ажил хэрэгч, бараан өнгийн хослол үгүй бол алтлаг, эсвэл мөнгөлөг өнгөтэй хослол сонгож өмсөх нь түүнийг илүү цэмцгэр, эрхэмсэг харагдуулна (дүрс 6.6). Гоёл чимэглэл, энгэрийн зүүлт зэрэг гангарааг маш бага хэрэглэснээр хувцаслалт нь түүний бие, зан чанарыг илүү төгс, илүү цэмцгэр болгожээ. Хувцаслалт нь түүний өөрийгөө хянадаг, ялгардаг гэх нийтийн хүлээлтэд бүрэн нийцжээ. Мацаг барих, дасгал хийх, зөв хооллох зэрэг нь түүний эрх чөлөө, баялаг, нэр хүнд, мэдлэг, өөрийгөө хянах чадварын илэрхийлэл юм. Одонтуяа эрүүл мэнд, гоо сайхнаа бүтээж буй нь түүний хувийн орон зай боловч нууц биш билээ. Энэ талаар түүний эрэгтэй хамтран ажиллагсад нь ч, сэтгүүл, хэвлэлээр гарах бөгөөд учир нь Одонтуяа өөрийнхөө “жор”-ыг нууц байлгахыг хүсээгүй, харин ч түүний өөртөө анхаарал тавьж буй хөрөнгө оруулалт нь бусад ихэнх хүмүүсийн чаддаггүй зүйл учраас тэр юм.

Дүгнэлт: Гоо сайхан Улс төрийн төсөл болох нь

Энэ бүлэгт УИХ-ын сонгуульд өрсөлдсөн эмэгтэйчүүд хэрхэн биеэ бэлддэг талаар ярилцлаа. Хувцаслах хэв маяг, нүүр будаг, эрүүл амьдрах зэргээр өөрсдийнхөө имижийг болон бусад зүйлсээ ч сайжруулснаас үзэхэд эдгээр эмэгтэйчүүд бие, оюун санаагаа цэгцэлж, хязгааргүй тэлэх чадвартай гэж үзэж болно. Сонгуульд биеэ бэлдэхэд чиглэсэн тэдний хүчин чармайлт нь нэр дэвших, улмаар ялалт байгуулах гэх анхдагч зорилгоосоо хол илүү давж, тэдний үнэт зүйлс, амьдралын хэв маяг, мэдрэмж, сонголт, амьдралын салшгүй хэсэг болон тэлжээ.

Монголд өрнөсөн неолиберал шилжилтийн үр дүнд сонгууль арилжааны шинжтэй болсон, улмаар эмэгтэйчүүд улс төрд гадуурхагдах болсон нөхцөлд эмэгтэй улс төрчдийн баримталсан стратегиудыг шинжилж үзлээ. Сонгуулийн кампанит ажил нь эдийн засгийн үйлдвэрлэл, сонгуулийн бус үед ч шинэ туршлагуудыг тасралтгүй үйлдвэрлэх мөнхийн хөдөлгүүр болжээ. Ёс суртахуун, мэргэжилтэн, манлайлагчийн хувьд эдгээр бүсгүйчүүд өөрсдийгөө сайжруулах төрөл бүрийн тактик ашиглан, жинхэнэ улс төрд эмэгтэйчүүд супер нарийн бичгийн дарга, эсвэл секс объект болдог гэх хэвшмэл ойлголтыг (эрэгтэй улс төрчид болон, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зугаа болгон ярьдаг)

эвдэж чадсан. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эмэгтэйлэг байдлыг гоо сайхны тэмцээнд оролцогч, үзэсгэлэнт эхнэр төдийгөөр дүрсэлдэг бол, эдгээр эмэгтэйчүүд мэргэжлийн, оюунлаг дүр төрхийг бий болгосон юм. Тиймээс, эмэгтэй улс төрийн субьектив шинж байдал нь гадаад ертөнц бол удаан хугацаанд төлөвшсөн дотоод дадал юм гэх Пиер Бурдбегийн үзэл санааг, субьектүүд үргэлж тактикийн шинжтэй байдаг, үүнийгээ ч мэддэг гэх Шерри Ортнерын (2001) үзэл санааг нэгтгэсэн мэт. Ортнер субьектив шинж байдал бол хүрэх зорилгын үндэс гэж үзсэн. Тиймээс, эрчүүд зонхилсон улс төрд эмэгтэйчүүд ихэнхдээ дагалдагч маягтай, дор байр суурь эзлэх ба улс төрийн эрх мэдэлд шууд хүрэх боломжгүй нөхцөлд соёлын хувьд өөрчлөлт авчрахын төлөө эрмэлздэг (Ortner 2001).

Түүнчлэн, эмэгтэй нэр дэвшигчид жендэрээс улбаатай хүлээлт өөрчлөгдөж буйг давуу тал болгон ашиглаж, тактикийн төдийгүй өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй улс төрийн болон соёлын орчныг шинээр бий болгож байна. Эдгээр эмэгтэйчүүдийн баримталж буй сонгуулийн кампанит ажлын стратеги нь өнөөгийн улс төрийн нөхцөлд нийцэхээс гадна, өөрсдөд нь үгүйдээ л зарим талаараа тус болох шинэ нөөц, имиж, мэдлэгийг бүтээж, өөрсдийн улс төрийн орон зайг шинээр бий болгож, өөрсдийгөө тоглогч болгон байршуулж буйг онцолъё. Тиймээс би, эрчүүд ноёлсон өнөөгийн улс төрийн орон зайд эдгээр эмэгтэйчүүд багтахын тулд өөрсдийгөө бэлдэхээс гадна, өөрсдийн нөлөө бүхий, шинэ орон зайг бүтээж байна гэж үзлээ.

Өмнө нь дурдсанчлан, 2006-2007 оны зун буюу сонгуулиас хамаагүй өмнө нэр дэвшихээр зэхэж буй эмэгтэйчүүдтэй танилцсанаар би төрөл бүрийн аргаар сонгуулийн кампанит ажилд эртнээс биеэ бэлддэг болох талаар анх мэдэж авсан бөгөөд хожим 2008, 2012 оны сонгуулийн кампанит ажлын үеэр тэднийг дагалдаж явахдаа илүү ойлгосон юм. Би эдгээр эмэгтэйчүүдтэй сонгууль гэлтгүй байнга холбогдсоор байсан тул (2006-2019) тэд урт хугацаанд өөрсдөдөө хөрөнгө оруулж, сонгуульд бэлдэж байсан нь тэднийг улс төрч, мөн чанартаа улс төрийн субьект болгож буйг ойлгосон. Монголд ардчилсан сонгууль Монгол эмэгтэй хүн гэж хэн болохыг байнга өөрчилж, шинэчилж, дахин бүтээж байдаг гэж би үзлээ. Сонгууль бол дундаас дээш давхаргын эмэгтэйчүүд өөрсдийгөө дахин бүтээх талбар учраас жендэрийн асуудлыг өргөн хүрээнд өөрчлөх боломжтой газар юм.

Эдгээр эмэгтэйчүүдийн дийлэнх нь өөрсдийгөө биеэ даасан, өөрийгөө удирдах чадвартай гэж үздэг бөгөөд зорилготой, хүчирхэг, амьдралаа хүссэнээрээ бүтээж чадна гэх мэдрэмж тэдэнд байдаг (Ortner 2006, 143). Гэсэн ч, эрэгтэйчүүд ноёлсон, шаталсан ёс бүхий улс төрийн тогтолцоонд дээшээ тэмүүлж буй эмэгтэйчүүд хууль журам, соёлын хүлээлт, эдийн засгийн бүтэц зэрэг шалтгаанаар ил болон далд амжилт ололгүй төгссөн маш олон тохиолдол бий. Сонгуульд бэлтгэгдсэн нэр дэвшигч болох буюу өөрсдийгөө сонгогдохуйц нэр дэвшигч болгон

бүтээх үйл явцад шинэ технологи, туршлага, мэдлэг, нөөцийг ашиглан эдгээр эмэгтэйчүүд өөрсдийнхөө бие махбод, оюун санаагаа өөрчлөхийн зэрэгцээ, жендэрийн шатлалыг өөрчилж, шинэчилж байна. Эдгээр эмэгтэйчүүд эрх мэдэлд хүрэхээр зорьж буй боловч, тэд өөрсдийнхөө удирдлага, улс төрийн нам, сонгуулийн улс төр зэрэгтэй давхар тэмцэж байна.

Эдгээр эмэгтэйчүүдийн зарим нь ашигласан стратегиуд амьдралын хэв маяг, бие, дүр төрхийг нь эрс өөрчилжээ. Тэд бие махбод, оюун санааны хувьд сахилга баттай байж хоолны дэглэм барьж, дасгал хийж, дуу хоолойгоо өөрчилж, олны өмнө ярих дадлага хийж, танилын хүрээгээ нэмж, шилдэг борлуулалттай ном бичиж, дэлхийн шилдэг сургуульд өндөр боловсрол эзэмшсэн. Эдгээр стратеги нь феминизмийн талаар олон улсын болон үндэстэн дамнасан хэлхээ, социалист үзэл суртлын туршлага болон НҮБХХ, Америк, Европт төвтэй олон улсын ТББ-ууд, засгийн газар, хувийн хэвшил, улс төрийн байгууллагуудын хэрэгжүүлж, дэмжиж ирсэн эмэгтэйчүүдийн чадавх бэхжүүлэх чиглэлийн хөтөлбөр, сургалт, семинар зэрэг өнөөгийн болон түүхэн төрөл бүрийн үйл явдлаас урган гарсан юм. Дээд давхаргын Монгол эмэгтэй хүнийг илэрхийлэх байдал улс төр, эдийн засгийн харилцан холбоонд шингэсэн бөгөөд, илүү сайжрах, дэлхийн түвшинд ч тоглох боломжтой болж байна.

Дүгнэлт: Шилэн тааз томруулдаг шил болох нь

“Дэлхий ертөнц үндэсний парламентууд дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд “шилэн таазанд” хүрсэн үү? Тус асуултыг улс үндэстний парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх үйл явц юутай ч зүйрлэшгүй удаашралтай буйг ажигласан Олон Улсын Парламентын холбоо нэгэн тайландаа тавьжээ (Sengupta 2015). Парламентад хүрэх мянган алхам ном маань тус асуултад зарим талаар хариулав. Тус асуултад хариулахдаа би, эмэгтэй нэр дэвшигчдийн парламентад хүрэх зам мөр нь хэрхэн неолиберал капиталист нийгмийн улс төр, жендэр, орон нутгийн болон дэлхий дахины феминист улс төртэй хэрхэн уялдаж буйг харуулахыг зорив. Улс төрд орохоор тэмцэлдэхдээ эдгээр эмэгтэйчүүд төр, улс төр, сонгуульд нөлөөлөхийн зэрэгцээ өөрсдийгөө ч төлөвшүүлжээ. Өөрсдийгөө албажуулах хуулийн тэмцэл, мөн хувь хүний жижиг хүрээний стратеги, тактикууд нь “шилэн тааз” хэрхэн баригддагийг харуулав. Мөн, эдгээр эмэгтэйчүүд хурдацтай неолибералчлагдаж буйн зэрэгцээ ардчиллыг бүтээх, бэхжүүлэхийн төлөө чармайж буй нийгэмд сонгуулийн үүргийг гэрэлтүүлэх “толь” болжээ.

Энэхүү ном нь неолиберализмын эрин үеийн сонгуулийн

өөрчлөлтийг, ялангуяа сонгуулиас сонгуульжилт болон хувирч буй өөрчлөлтийн талаар эргэцүүлж, бид үзэл санаа, ойлголт, хэл яриагаа хэрсүү өнцгөөс дахин үнэлэхэд тусална гэж итгэж байна. Неолиберализмын талаарх одоогийн академик судалгаа ихэнхдээ эдийн засгийн амьдралд төвлөрч буйг тэнцвэржүүлэх үүднээс энэ номд улс төрд, улс төрийн амьдралд үзүүлэх неолиберализмын нөлөөг онцлон авч үзлээ. Энэ номд өгүүлсэнчлэн, эмэгтэй улс төрчид, улс төрийн субъект, субъектив шинж байдал дан ганц неолиберализмын нөлөөгөөр гэлтгүй, улс төрийн нэмэлт шүүлтүүрүүдийн нөлөөгөөр өөрчлөгдөж буй бөгөөд неолиберал өөрчлөлтүүдийг хүлээн авч, тэдгээрт дасан зохицож байна. Монголд 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн неолиберал өөрчлөлт нь худалдааг чөлөөлж, төрийн өмчийг хувьчилж, нийгмийн халамжийг багасгах зорилготой байлаа. Зорьж байсан эдгээр өөрчлөлт хэрэгжиж, давтагдаж байсан ч (эдгээр өөрчлөлт ихэнхдээ тэгш бус байдлыг ихэсгэсэн), урьдчилан таамаглаж байсан, таамаглаж чадаагүй олон зүйл өнгөрсөн 30 жилд болжээ. Төрийн гүйцэтгэх үүрэг багасаж, санхүү, худалдааны салбарын либералчлал өргөжсөнтэй холбоотой шинээр үүссэн орон зайг ардчилсан сонгууль нөхөн авсан юм.

Монгол Улс либерализм, рационал сонголт, чөлөөт зах зээлийн тогтолцооноос бий болоогүй газар нутагт барууны институт, үзэл санаа хэрхэн бий болж буйг харуулах маш сонирхолтой жишээ билээ. Монгол Улс ардчиллын үйл явцыг тууштай дэмжсээр ирсэн ч, улс төрчид нь неолиберализмыг улайран дэмжиж, өөрсдөдөө ашигласаар ирсэн. Үзэл баримтлалын энэхүү хуваагдал нь улс оронд өрсөлдөөн, хурцадмал байдал, эдийн засгийн хөөсрөлтийг бий болгож Монгол Улсыг дампуурлын ирмэг рүү түлхэв. Монголд буй жендэрийн улс төр энэ бүхний үр дүнгээр тодорхойлогдож, жендэр, улс төр хоёр тогтворгүй боловч харилцан бие биеэ бүрдүүлдэг болохыг харуулж байна.

Номынхоо туршид өгүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгууль хэдийгээр Европ, Америкийн ардчилсан сонгуультай төстэй мэт боловч, ихээхэн ялгаатай. Монголын албан ёсны сонгуулийн институцүүд, тогтолцооны загвар, саналын хуудас, кампанит ажил зэрэг нь үндсэндээ барууныхтай төстэй. Гэсэн хэдий ч, сонгуулийн албан ёсны зохион байгуулалт, хуулийн хугацаанаас гадуур албан бусаар кампанит ажил өдөр бүр өрнөж, Монголчууд ч үүнийг неолиберализмаас бий болсон тодорхойгүй байдлыг даван туулах хэрэгсэл болгон ашиглаж сурчээ. Өөрөөр хэлбэл, Монголд сонгууль нь зохист хэм хэмжээнээс хэт нүсэр өрнөх болсон юм. Ийм учир оршин буй зарим үзэл баримтлал өөр газарт нутагшихдаа ижил үр дүнд хүрэх баталгаагүй аж.

Иймээс, рационал сонголтын онолын үүднээс Монголын нийгэмд хувь хүний хийж буй сонголт нь барууны либерал нийгэмд буй иргэдийн адил бие даасан байдаг гэх, эсвэл Монгол иргэд танилын сүлжээ, нутгархаг харилцаанд суурилсан амьжиргааны эх үүсвэрээ үл ойшоож,

эрх зүйт ёсыг ягштал дагах ёстой гэж хүлээх нь утгагүй. Гэсэн хэдий ч сонгуулийн кампанит ажлыг өдөр тутмын амьдралд гүн нэвчихэд, ураг төрлийн холбоо, нутгийн зөвлөлийг бэхжүүлэхэд хүргэсэн зарим урьдач нөхцөлийг неолиберализм бий болгосон. Хүн амын томоохон хэсэг нь гэнэт хумигдсан төрийн үйлчилгээ, зах зээлийн өсөлт бууралт, хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал зэргээс үүдэлтэй тодорхойгүй нөхцөл байдлыг давахын тулд сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеийг ч, сонгуулийн бус үеийг ч чадамгай ашиглаж сурав. Сонгуулийн кампанит ажил ч тэр, сонгогчид ч тэр аль аль нь өөр өөр сэдэлтэй төрөл бүрийн нийгмийн сүлжээ, ураг төрлийн харилцааг бэхжүүлжээ. Неолиберализм хэрхэн Монголд иймэрхүү сүлжээг бэхжүүлж буйтай төстэй жишээ Колумбид байсныг антропологич Мариа Видарт-Делгадо (2017) илрүүлж, орчин үеийн улс төрийн кампанит ажил “хандивлагч-хандив хүртэгчийн” харилцааг устгах ёстой байтал, улам бэхжүүлж байна гэжээ. Сонгууль бол албан ёсны институц төдийгөөр хязгаарлагддаг үйл явдал биш билээ.

Энэ номд дурдсанчлан сонгуулийн кампанит ажил амжилттай байхын тулд халамжийн үйлчилгээ гэх мэт төрийн үүргийг, тэр бүү хэл нийгмийн амьдралыг зохион байгуулах, гамшгаас хамгаалах санхүүжилт олгох гэх мэт хувийн хэвшлийн үүргийг ч гүйцэтгэх болсныг сонгуульжилт гэдэг үгээр илэрхийлэв. Нэр дэвшигчид нь буяны сан мэт сонгогчдод мөнгө тарааж, эрүүл мэндийн үйлчилгээ олгож, орон нутгийн засаг захиргаа мэт сургууль, зам барьж, хувийн хэвшил мэт үдэшлэг зохион байгуулж, баярын арга хэмжээг нүсэр тэмдэглэдэг болов. Элизабет Дунн (2008) болон бусад антропологичдын үзсэнээр неолиберал нийгэмд төр шинэ тоглогчид, институцүүдийг ашиглаж улам өргөжив. Монголд сонгуулийн кампанит ажил ийм маягийн шинэ институц болжээ. Сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаанаас хальсан сонгуулийн кампанит ажил цаг хугацааг зохион байгуулах, хүмүүсийн амьжиргааг шийдэх, эдийн засаг, нийгмийн нөөцийг дахин хуваарилах гэх мэтээр олон нийтийн орон зай, хувийн орон зайн хоорондын заагийг улам бүдгэрүүлэв.

Түүнчлэн, албан ёсны сонгуулийн сурталчилгааны хугацаанд үргэлжлэх нүсэр кампанит ажлаас гадна бүтэн дөрвөн жилийн турш, далд хэлбэрээр сонгуулийн кампанит ажил үргэлжилсээр байдгийг сонгуульжилт гэх үгээр илэрхийллээ. Энэ байдал нь улс төрд, ялангуяа УИХ-д байр суурь эзлэхийн төлөө зүдэрч буй эмэгтэй нэр дэвшигчид, нэр дэвшихээр горилогчдод өөр нэг саад тогтор л болж байна. Сонгуулийн кампанит ажлын хүрээнд сонгогчдоо халамжлах элдэв төрлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх нь ихэнх эмэгтэйчүүдийн хувьд асар хүнд санхүүгийн дарамт болдог. Үргэлжид нэр дэвшигч хувиасаа шийддэг, маш хаалттай байсаар ирсэн сонгуулийн санхүүжилтийг хуулиар ил тод болгох олон удаагийн оролдлого хангалттай амжилт олоогүй л байна.

Гэвч, сонгууль нь нэр дэвшигчдийн хувьд ч, сонгогчдын хувьд ч хүсэн хүлээдэг үйл явдал хэвээр байгаа юм. Энэ номд сонгууль хэрхэн улам нүсэр болсоор байгааг, сонгогчид яагаад сонгуульд татагддаг болохыг хэд хэдэн арга замаар тайлбарлалаа.

Эргээд бодоход Монголд гудамжаар дүүрэн, хаа сайгүй өлгөгдсөн нэр дэвшигчийн хөрөг зурагтай самбар нь 2016, 2020 оны сонгуулиас эхлэн зонхилох болсон цахим сүлжээгээр цацагдах нэр дэвшигчдийн зураг, мэдээний биет хувилбарууд байсан аж. Сонгууль улам нэр дэвшигчээс шалтгаалсан, улам арилжааны шинжтэй болсны дээр 2016, 2020 оны сонгуулиар Фейсбүүк, Твиттер зэрэг цахим сүлжээгээр сурталчилгаагаа явуулах болсноор улс төрийн орон зай виртуал ертөнцийг дүүргэж, сонгуулийн сурталчилгаа хаа сайгүй харагдах болов. Энэ байдлыг технологийн хувьд орчин үежих Монголчуудын эрмэлзэл (Buyandelger 2014), Хятадын хямд электрон төхөөрөмжүүд улам дэвэргэлээ. АНУ, болон бусад газарт нэр дэвшигчид, улс төрийн намууд, хандивлагчид, намын идэвхтнүүд л ирэх сонгуульд эртнээс санаа зовдог билээ. Харин Монголд хэт улс төржсөн өдөр тутмын амьдрал нь улс орон даяар сонгуулийн цаг цохилж, дөрвөн жил тутамд засгийн газрын ихэнх албан тушаал солигдож, сонгуульд ялсан намын гишүүд эзэлнэ. Сонгуулийн үеийн шуугиан, сонгогчдын өндөр ирц, төрөл бүрийн нийгмийн сүлжээ улам бэхжиж буй байдал зэргийг сонгуулийн богино хугацааны үр дагавартай холбон ойлгож болох.

Бараг л дааж давшгүй санхүүгийн саад бэрхшээлээс гадна #MeToo хөдөлгөөнөөс хойш өргөн дэлгэрсэн эмэгтэйчүүдийг хүйсээр нь доромжлох үзэл, эцгийн эрхт ёс, авторитарианизмын шинэ хэлбэр эмэгтэй нэр дэвшигчдэд нэмэлт дарамт учруулж байна. Нэр дэвшигчийн хүйсийн квотыг 2007 онд цуцалж, 2012 онд дахин сэргээсэн ч (квот 30 хувиас 20 болж буурав), энэ нь эмэгтэйчүүдийн урмыг мохоосон төдийгүй, нэр дэвших хүртэлх албан ёсны замаар өгсөх бүсгүйчүүдийн тоог хязгаарласан юм. Түүнчлэн, өдөр тутам тулгарах жижиг хэмжээний саад бэрхшээлүүдээс болж эмэгтэйчүүд нөхцөл байдлыг дээрээс нь харах, өрсөлдөгчдийнхөө үйл хөдлөлийг мэдэх, урьдчилан таамаглах боломжгүй, харин нөхцөл байдлыг доороос нь харж, ойрын жижиг тактикууд л ашиглахаас (de Certaeu 1984) өөр аргагүй болжээ. Төрөл бүрийн улс төрийн үйл явдлууд өөрсдийгөө сонгогдохуйц болгохын тулд хичээж, өөрийгөө хөгжүүлсээр байгаа эмэгтэй улс төрчдөд янз бүрийн боломж, хязгаарлалтыг бий болгож байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн амбиц, зохион байгуулалтын ур чадвар, жендэрийн тэгш байдлын зарчмыг хийсвэрлэх эрх мэдэл, социалист төрөөс уламжлагдан ирсэн өв зэрэг нь нийгэм илүү төвлөрсөн, хамтын шинжээсээ сарнисан, хувийн нөөцөд тулгуурласан шинжтэй болж хувирахын хэрээр эмэгтэйчүүдэд дэм болж байна. Социализмын үед нас биед хүрсэн маш олон эмэгтэйчүүд өөрсдийгөө чухал үүрэг гүйцэтгэх талаар төсөөлж

чадаж байсан төдийгүй, өөрсдийн эрмэлзэл, дадал, ёс суртахуунаа дараа үедээ шилжүүлсэн юм. Тэд мөн ардчиллын институтүүдийг босгох, эрх зүйн шинэчлэлд лоббидох, шинэ боломжуудыг ашиглахад дараа үеийнхэндээ тусалсан.

Эмэгтэй нэр дэвшигчид эдийн засгийн хязгаарлагдмал нөөц, улс төрийн хувьд гадуурхагдсан байдлаасаа үл шалтгаалан ухаалгаар сонгуулийн кампанит ажлаа өрнүүлсэн нь улс төрийг хэрхэн өөрөөр хийж болохыг тод харуулав. Сонгогдохуйц нэр дэвшигч болохын тулд эмэгтэй нэр дэвшигчид өөрийгөө хөгжүүлэх, толгойгоо цэнэглэх, биеэ бэлдэхэд анхаарч чадсан. Ном бичиж сонгуулийн санхүүжилтээ босгож чаддаг, академик болон улс төрийн туршлагаа ашиглан хуулийн ажилд хөндлөнгөөс оролцож батлуулж ч чаддаг эмэгтэйчүүд ямар оюунлаг болохыг би энэ номдоо онцоллоо. Тэд боловсрол, ур чадвараа тасралтгүй хөгжүүлж, эрдмийн зэрэг хамгаалж, хувцаслалт, нүүр будалт, биеэ урлах зэргээр оюун санаа, бие махбодоо тасралтгүй хөгжүүлж чадсан. Эдгээр эмэгтэй нэр дэвшигчид хэт арилжааны шинжтэй сонгуулийн кампанит ажлыг давахын тулд өөрсдийгөө төгс, татгалзахын аргагүй нэр дэвшигч болгон бэлдэхийг хичээж байлаа. Тэд өөрсдийнхөө хамгийн сайн хувилбарыг бүтээж, сонгогдохуйц болгож буй нь зарим талаар неолиберализмын бүтээгдэхүүн гэж хэлж болох бөгөөд тэд үүгээрээ неолиберализмын өөр нэг үр дагавар, арилжааны шинжтэй улс төрийн кампанит ажлыг даван туулахыг эрмэлзсэн.

Тиймээс, сонгуулийн кампанит ажил нь жендэрийн болон ангийн танигдахуйг дахин загварчилж болох талбар юм. Жоун Скотт (2019) ардчилалд, хэн засаглах нь ойлгомжгүй нөхцөлд байгалийн шинжээрээ хүч чадалтай холбогдох тул эрэгтэй удирдагчид гарч ирж, улмаар эмэгтэйчүүд тэгш байдлыг бий болгоход гаргаж буй хүчин чармайлтаас үл хамааран улс төр эрчүүдээр дүүрэх хандлагатай байдаг гэжээ. Скоттын энэ үзэл санааг гуравдугаар бүлэгт Монголд сонгуулийн үеэр хаашаа л харна нэр дэвшигчийн зурагт хуудас, самбар тааралдаж байсан ба, технологийн дэвшил, соёлын онцлогтой хэрхэн холбогдож буй талаар дэлгэрэнгүй өгүүлсэн билээ. Сонгуулийн кампанит ажил, нэр дэвшигчийн зураг зэрэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь хувьд сонгогдохуйц нэр дэвшигч гэж ямар утгатай болохыг харуулдаг. Учир нь эмэгтэйчүүдийн хувьд сонгогдохуйц байхыг хэрхэн ойлгох нь маргаантай бөгөөд, байнга хувьсан өөрчлөгдөхийн зэрэгцээ эмэгтэйчүүд өөрсдийгөө төлөөлөхдөө маш нухац, болгоомжтой ханддаг билээ. Ардчилал жендэрийн онцлогийг багасгах хандлагатай гэх Скоттын аргумент (2019) нь Монголын жишээн дээр эр хүйсэд ихээхэн нийцэж буй ч сонгогдохуйц нэр дэвшигч болох тухай агуулгаар эмэгтэйчүүдийн хувьд нийцэхгүй байна.

Жендэр, улс төр хоёр нийгмийн институц болохын хувьд үргэлжийн өөрчлөгдөж, харилцан бие биеэс хамааралтай байдаг ойлголтууд

юм. Тереза де Лауретисын (1987) томъёоллыг ашиглан өгүүлэхэд, сонгуулийн кампаниг ажил зохион байгуулах болон, эрх мэдэл олж авах туршлагад “жендэрийн технологи” ашиглах нь нөлөө ихтэй болох нь ойлгомжтой болжээ. Гэсэн хэдий ч, эмэгтэйчүүдийг сонгох хүлээлтээ нэмж, эмэгтэйчүүд өөрсдийгөө сонгогдохуйц болгохын тулд эмэгтэйлэг байдлаа илүү харагдуулахыг хүсэж, буй туршлагаас үзэхэд жендэр хоорондын эрх мэдлийн тэнцвэргүй байдал улам нэмэгдэж буйг харуулна.

Номын эхэнд дурдсан хэд хэдэн феминист үзэл санааг дахин үзэхэд, неолиберализм өнөөгийнх шиг эрчимжиж эхлээгүй 20-р зууны сүүл үед феминист олон улсын байгууллагуудын хоорондын эв санааны нэгдлийн хүчийг энд онцлох нь зүйтэй. Үндэсний парламентад эмэгтэй гишүүд хөл давахад эмэгтэйчүүдийн элдэв хөдөлгөөн ихээхэн тус болсон. Үндэсний хууль тогтоох байгууллагууд неолиберализмын нөлөөгөөр хэлбэржиж байгаа хэдий ч Европын Холбоо, Нэгдсэн Үндэсний Байгууллага болон бусад олон улсын байгууллага үндэсний парламентад нөлөө үзүүлэх илүү дэвшилтэт, үндэстэн дамнасан талбар болж чадна. Монгол эмэгтэйн хэрэглэсэн албан болон албан бус олон стратеги, тэдний давж гарсан зовлон бэрхшээл, хуримтлуулсан ололт амжилт бүхэн нь шилэн таазны хийцийг, магадгүй шилэн таазыг хагалах замыг ойлгож мэдэхэд тусалж чадна гэдэгт эргэлздэггүй.

Талархал

Энэхүү төсөлд бүх талаар надад тусалсан Монголд, АНУ-д болон дэлхий дахинд байгаа найз нөхөд, гэр бүл, хамтран ажиллагсдадаа баярлалаа. Багшлах, хүүхдээ ганцаараа шахуу өсгөхийн зэрэгцээ хоёр ном бичих ёстой Массачуссетсийн Технологийн Их сургуулийн ажлын шаардлагыг биелүүлэх ажил бараг л боломжгүй мэт санагдаж байлаа. Ялангуяа хоёр дахь ном нь эхний номоос тэс өөр судалгааны сэдэвтэй байсан нь бүр ч хэцүү болгов. УИХ-ын сонгууль дөрвөн жилд нэг л удаа болдог учраас Массачуссетсийн Технологийн Их сургуулийн ажлаа нэг жилээр хойшлуулж өөрийн анхны ном Эмгэнэлт онгодууд (2013) номын судалгааныхаа ажлыг үргэлжлүүлсэн юм. Энэ номын судалгааны ажил 2008, 2012, 2016 оны гурван удаагийн УИХ-ын сонгуулийг хамарсан бөгөөд, энэ хугацаанд энэхүү номыг бичихэд, хүүхдийг минь харж, сэтгэл санаагаар тусалж, ажлаа тайван хийх бололцоогоор тусалсан бүх хүнд чин сэтгэлээсээ талархлаа.

Монголд буй дотнын найзууд, судалгааны ярилцлагад оролцогчид, Ядамсүрэнгийн Хишигсүрэн, Момолын Отгонбаяр болон тэдний гэр бүл, найз нөхөд намайг бүх талаар дэмжиж, урам хайрласан. Хишигсүрэн найз маань Судалгаа, зөвлөх үйлчилгээний Максима Консалтинг компанийнхаа нөөцийг надад хуваалцаж, судалгааны аялал, ярилцлага, медиа судалгаа, болон ярилцлагын транскрипт буулгах зэргээр маш их тусалсан. Миний найз, ажлын хамтрагч, Монголын нэр хүндтэй

феминист зохиолч Баатарсүрэнгийн Шүүдэрцэцэг маш олон судалгааны гол ярилцагчид, эмэгтэй нэр дэвшигчидтэй танилцуулснаар, судалгааны маань ажилд үнэлж барамгүй хувь нэмэр оруулсан билээ. Мөн сүүлийн хэдэн жилийн туршид номд минь үнэт хувь нэмэр оруулсан Нэргүйн Баасанхүү, Намсрайжавын Ариун-Ундрах, Болдын Гэрэл, Болормаа, Охидойн Отгонжаргал зэрэг судалгааны туслахууддаа баярлалаа.

Сонгогчдын Боловсрол Төвийн захирал Сумьяагийн Оюунтуяад, болон чин сэтгэлээсээ тусалж дэмжсэн төвийн хамт олон талархаж байна. Монфемнет үндэсний сүлжээний зөвлөх Төмөрсүхийн Ундарьяа, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төвийн захирал Даваасүрэнгийн Энхжаргал, Жендэрийн Үндэсний Хорооны нарийн бичгийн дарга асан Баасанхүүгийн Энхсайхан, МОНЭС-ийн дарга Найдангийн Чулуун зэрэг иргэний нийгмийн, феминист хөдөлгөөний хамтран зүтгэгчдэдээ баярлалаа. Судалгааны ажилд үнэтэй ярилцлага, мэдээлэл өгч бусад зүйлсээр тусалсан Баасанжавын Оюунбилэг, Загасбалдангийн Энхжаргал, Жамсрангийн Булган, Андрей Вагаев, Төвсанаагийн Бэхцэцэг, Цэдэвдамбын Оюунчимэг нарт талархлаа. Эдгээр хүмүүсийн тусламж байгаагүй бол энэхүү ном маань бичигдэх боломжгүй байсан биз ээ. Профессор Сэдэнжавын Дуламд баярлалаа. Сонгуулийг угсаатан зүйн үүднээс судлах гэсэн миний сонирхолд түүний УИХ-д нэр дэвшиж өрсөлдсөн туршлага гарцаагүй нөлөөлсөн юм. Нэрээ нууцлахыг хүссэн Монголын анхны пи-арын зөвлөхөд мөн баярлалаа.

Надад өөрийнхөө туршлага, мэдлэг, санаа бодлоо харамгүй хуваалцсан бүх хүнд ялангуяа эмэгтэй нэр дэвшигчид, горилогчид, сэтгүүлчид, олон нийтийн харилцааны мэргэжилтнүүд, сонгуулийн кампанит ажлын ухуулагчид, менежерүүд, төрөл бүрийн сонгуулийн штабын ажилчид зэрэг нийт судалгааны ярилцлагад оролцсон хүмүүстээ баярлалаа. Тусгайлан, Раднаагийн Бурмаа, Цэдэвдамбын Оюунгэрэл, Даваасамбуугийн Оюунцэцэг, Санжаасүрэнгийн Оюун, Чимэдийн Базар, Жүрмэдийн Занаа, Салдангийн Одонтуяа, Манжаагийн Ичинноров, Лэгцэгийн Ариунаа, Шагдарын Батцэцэг, Төгсжаргалын Ганди, Нацагийн Удвал, Нацагийн Дуламсүрэн, Дүгэрсүрэнгийн Сүхжаргалмаа болон нэрээ нууцлахыг хүссэн бусад эрэгтэй, эмэгтэй улс төрчдөд баярлалаа.

Санаа бодлоо солилцож, нөөцөө хуваалцах гэх мэт үнэт туслалцаа үзүүлсэн Дэлхий дахины Монгол судлаачид, Монголын антропологичдод баярлалаа. Кристофер Этвүүд, Лорен Бонилла, Никола Ди Космо, Ребекка Эмпсон, Ларс Хөөр, Кристофер Каплонский, Жессика Мэдисон, Мягмарын Саруул-Эрдэнэ, Марисса Смит, Уртнасангийн Эрдэнэтуяа, Жаргалсайханы Санчир, Гантулгын Түвшинзаяа, Уянгын Дарьбум, Лхамсүрэнгийн Мөнх-Эрдэнэ, Цүлтэмийн Уранчимэг нарт баярлалаа.

Номынхоо өөр өөр бүлгийн талаар төрөл бүрийн институтүүдэд

очиж яриа хийсэн маань дүн шинжилгээгээ илүү гүнзгийрүүлэхэд томоохон тусламж болсон билээ. Тиймээс, илтгэлийг маань хүлээн авч, эрдэм шинжилгээний хуралд урьж оролцуулсан Бритиш Колумбиагийн Их Сургуулийн Ази Судлалын хүрээлэн, Антропологийн тэнхим, Монголын талаарх семинарыг зохион байгуулсан Жулиан Дьеркес, Калифорни Берклигийн Их сургуулийн Зүүн Ази судлалын хүрээлэн, Монгол Санаачилгын Доктор Фрэнк Биллэ, Кэмбрижийн их сургуулийн Антропологийн тэнхимийн Кристофер Каплонски, мөн үнэтэй харилцан яриа өрнүүлж, санал бодлоо хуваалцсан Хилдегард, Диембэргэр, Кэролин Хамфри, Николай Ссорин-Чайков, Канад, Онтарио дахь Хэмилтоны МакМастерийн Их сургуулийн Нэтина Тан, Колумбын Их сургуулийн Харриманы хүрээлэнгийн Жанара Наурезбаева, Харвардын Их сургуулийн Орос, Евроази судлалын Дэвисийн төвд илтгэл тавихыг урьсан Элизабет Вүүдс, Блүүмингтон дэх Индианагийн Их сургуулийн Төв Ази судлаачлын холбооны Жэими Бью, Массачусетс дэх Брандэйс Антропологийн тэнхим, Данийн Аархус Их сургуулийн Мортен Педерсон, Германы Хайделбургийн их сургуулийн Иван Саблин, Жаргал Бадагараг, Пенсилвани дахь Питтсбургийн Их сургуулийн Союз Постсоциалист Соёл судлалын төвийн Томас Матца, Өвөр Монголын Их сургуулийн Монгол Судлалын Сургуулийн Тангудайн Бүрэнжаргал, Баярын Насан, Чимэддорж болон бусад хамт олонд баярлалаа. Номынхоо эхний нооргийг би Нью Жерсид Принстоны Ахисан Түвшний Сургалтын хүрээлэнгийн хөтөлбөрт хамрагдах үедээ бичсэн юм. Тиймээс, Сергей Оушакине, Диде Фассин, Хью Гастерсон, Жилл Лок, Жон Холмвуд, Шарун М. Муканд, Жоун Скотт нарт ажлыг маань үнэлж, ул суурьтай санал зөвлөмж өгсөнд талархаж байна.

Чикагогийн Их сургуулийн хэвлэлийн газрын гайхамшигтай редакторуудад гүнээ талархъя. Төслийн эхэн үеэс онцгой анхаарч, тусалж байсан Дэвид Брэтт, хэвлэлийн газрын шаардлагад нийцэхэд тусалсан Прияа Нелсон нарт баярлалаа. Ковид-19 цар тахлын үлэмж хэцүү, бухимдалтай мөн Хэвлэлийн газар бүтцийн өөрчлөлт хийж байсан амаргүй цаг үед номыг маань хэвлүүлэхэд чин сэтгэлээс тусалсан Алан Г. Томаст баярлалаа. Мэри Аль-Сасейдын тусламж, дэмжлэгт, мөн төслийн турш тасралтгүй дэмжиж байсан Тристан Бейтет баярлалаа. Мөн номын гар бичмэлийг хянан уншиж, санал сэтгэгдлээ өгсөн нэр нь үл мэдэгдэх гурван хүний хувь нэмэр номыг маань сайжруулахад бүх талаар амин чухал дэмжлэг болсон.

Стефан Хэлмрич, Хэдер Паксон зэрэг номын маань хэд хэдэн нооргийг уншиж, унших бүрдээ үнэт санал, зөвлөгөө өгсөн Массачуссетсийн Технологийн Институтын Антропологийн тэнхимийнхээ хамт олонд гүнээ талархъя. Ялангуяа Хэдерт номд маань төдийгүй, номоо бичих хүнд хэцүү цаг үеийн турш надад тусалж, дэмжиж байсныг нь энд

Ном зүй

- Abélès, Marc. 1988. "Modern Political Ritual." *Current Anthropology* 29 (3): 391–405.
- Abrahms-Kavunenko, Saskia. 2018. *Enlightenment and the Gasping City: Mongolian Buddhism at a Time of Environmental Disarray*. Ithaca, NY: Cornell University Press.
- Ahearn, Laura. 2001. *Invitations to Love: Literacy, Love Letters, and Social Change in Nepal*. Ann Arbor, MI: University of Michigan Press.
- Ahmed, Amel. 2013. *Democracy and the Politics of Electoral System Choice: Engineering Electoral Dominance*. Cambridge: Cambridge University Press.
- Alphen, E. J. van. 2013. "Explosions of Information, Implosions of Meaning, and the Release of Affects." In *Images on the Move*, edited by P. Spyer and M. Steedly, 219–36. Santa Fe, NM: School for Advanced Research Press.
- Anderson, Benedict. 1998. *The Spectre of Comparisons: Nationalism, Southeast Asia and the World*. New York: Verso.
- Andors, Phyllis. 1983. *The Unfinished Liberation of Chinese Women*. Bloomington, IN: Indiana University Press.
- Appel, Hillary and Mitchell A. Orenstein. 2018. *From Triumph to Crisis: Neoliberal Economic Reform in Postcommunist Countries*. Cambridge: Cambridge University Press.
- Appiah, Kwame Anthony. 1991. "Is the Post- in Postmodernism the Post- in Postcolonial?" *Critical Inquiry* 17 (2): 336–57.
- Ardener, Edwin. 1975. "Belief and the Problem of Women and The 'Problem' Revisited." In *Perceiving Women*, edited by Shirley Ardener, 1–27. London: Malaby.
- Atwood, Christopher. 2004. *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*. New York: Facts on File.
- Baabar. [Bat-Erdene Batbayar]. 1990. *Buu Mart! Horin Nedgügeer Zuuny Bosgon Deer [Don't Forget! On the Threshold of the Twenty-First Century]*. Ulaanbaatar, Mongolia: Social Democratic Movement [Ardchilsan Sotsialist Höддölgөөн].
- . 1999. *Twentieth Century Mongolia*. Cambridge: White Horse Press.
- Ballis, William B., and Robert A. Rupen. 1956. *Mongolian People's Republic (Outer Mongolia)*. New Haven, CT: Human Relations Area Files.
- Banerjee, Mukulika. 2007. "Sacred Elections." *Economic and Political Weekly* 42 (17): 1556–62.

- . 2011. “Elections as Communitas.” *Social Research* 78 (1): 75–98.
- . 2014. *Why India Votes?* New Delhi: Routledge.
- Barthes, Roland. 1995. *The Language of Fashion*. London: Bloomsbury.
- Bat, Ö. 2008. “The Ecologist Bayarsaikhan Is Caught.” *Century News* [Zuunii Medee], June 20.
- Batchuluun, Ch. 1982. *Monkhiin aldar* [Eternal glory]. Ulaanbaatar, Mongolia: Ulsyn Kheveleiin Gazar [State Publishing Agency].
- Batmunkh, Batsukh, Gereltuya Altanhuyag, and Idshinrenjin Osorjav. 2013. “Achieving the Millennium Development Goals, Fifth National Progress Report.” Ulaanbatar: Ministry of Economic Development of Mongolia.
- Bauman, Zygmunt. 1987. *Legislators and Interpreters: On Modernity, Post-Modernity, and Intellectuals*. Ithaca, NY: Cornell University Press.
- Bawden, Charles. 1968. *The Modern History of Mongolia*. New York: Praeger.
- Bayantur, Gerelt-Od. 2008. “Democratic Transition and The Electoral Process in Mongolia.” PhD diss. University of Saskatchewan, Canada.
- Begzsuren, Tsolomon, and Dolgion Aldar. 2014. “Gender Overview in Mongolia—A Desk Study.” Ulaanbaatar, Mongolia: Swiss Agency for Development and Cooperation and IRIM.
- Bille, Franck. 2014. *Sinophobia: Anxiety, Violence, and the Making of Mongolian Identity*. Honolulu: University of Hawaii Press.
- Bira, Sh., ed. 1984. *The History of the Mongolian People’s Republic* [Bugd Nairamdah Mongol Ard Ulsiin Tuuh]. Ulaanbaatar, Mongolia: State Publishing House. [In Mongolian.]
- Bjorkman, Lisa. 2014. “‘You Can’t Buy a Vote’: Meanings of Money in a Mumbai Election.” *American Ethnologist* 41 (4): 617–34.
- Bloch, Alexia. 2003. “Longing for the Kollektiv: Gender, Power, and Residential Schools in Central Siberia.” *Cultural Anthropology* 20 (4): 534–69.
- Bonilla, Lauren. 2017. “Extractive Infrastructures: Social, Environmental and Institutional. Transformations in Mongolia’s Emergent Extraction-Based Economy.” PhD diss. Clark University, Worcester, MA.
- Bonilla, Lauren, and Tuya Shagdar. 2018. “Electoral Gifting and Personal Politics in Mongolia’s Parliamentary Election Season.” *Central Asian Survey* 37 (3): 457–74. <https://doi.org/10.1080/02634937.2018.1442319>.
- Bodoo, D. 2008. “The Movie Narrated by Elbegdorj.” *Century News* [Zuunii Medee], March 26. Borneman, John. 2011. *Political Crime and the Memory of Loss*. Bloomington, IN: Indiana University Press.
- Bourdieu, Pierre. 1977. *Outline of a Theory of Practice*. Cambridge: Cambridge University Press.
- . 1984. *Distinction: A Social Critique of the Judgment of Taste*. Cambridge, MA: Harvard University Press.
- . 1991. *Language and Symbolic Power*. Cambridge, MA: Harvard University Press.
- . 1993. *The Field of Cultural Production: Essays on Art and Literature*. New York, NY: Columbia University Press.
- Bowie, Katherine A. 2008. “Vote Buying and Village Outrage in an Election in Northern Thailand: Recent Legal Reforms in Historical Context.” *Journal of Asian Studies* 67 (2): 469–511.
- Boyer, Dominic. 2013. “Simply the Best: Parody and Political Sincerity in Iceland.” *American Ethnologist* 40 (2): 276–87.
- Boyer, Dominic, and Yurchak Alexei. 2010. “American Stioab: Or, What Late-Socialist Aesthetics of Parody Reveal about Contemporary Political Culture in the West.” *Cultural Anthropology* 25 (2): 179–221.

Branigan, Tania. 2008. "State of Emergency in Mongolia after Post Election Violence." *The Guardian*, July 2. <http://www.guardian.co.uk/world/2008/jul/03/1>.

Brenner, Susan. 1998. *The Domestication of Desire: Women, Wealth, and Modernity in Java*. Princeton, NJ: Princeton University Press.

Brink-Danan, Marcy. 2009. "'I Vote, Therefore I Am': Rituals of Democracy and the Turkish Chief Rabbi." *PoLAR: Political and Legal Anthropology Review* 32 (1): 5–27.

Bulag, Uradyn. 1998. *Nationalism and Hybridity in Mongolia*. Oxford, UK: Oxford University Press.

———. 2009. "Mongolia in 2008: From Mongolia to Mine-golia." *Asian Survey* 49 (1): 129–34.

Bum-Ochir, Dulam. 2020. *The State, Popular Mobilisation and Gold Mining in Mongolia: Shaping 'Neoliberal' Policies*. London: UCL Press. <https://doi.org/10.14324/111.9781787351837>.

———. 2019. "Nationalist Sentiments Obscured by 'Pejorative Labels' Birthplace, Homeland and Mobilisation against Mining in Mongolia." *Inner Asia* 21 (2019): 162–79.

———. 2018. "Mongolia in Democracy, Civil Society and Movement." In *Routledge Handbook of Civil Society in Asia*, edited by Akihiro Ogawa, 95–109. New York: Routledge.

Burawoy, Michael, and Katherine Verdery. 1999. *Uncertain Transition: Ethnographies of Change in the Postsocialist World*. Lanham, MD: Rowman and Littlefield.

Burcher, Catalina, and Fernando Bértoa. 2018. "Political Finance in Mongolia." <https://www.idea.int/sites/default/files/publications/political-finance-in-mongolia.pdf>. Accessed February 26, 2021.

Burmaa, Radnaagiin. Personal Archive Documents.

———. 2008a. *A Petition to the Constitutional Court of Mongolia*. Odonchimed L., Ganhuyag Ts., Burmaa R., July 18, 2008.

———. 2008b. *A Petition to the General Election Commission*. July 21, 2008, by Burmaa Radnaa.

———. 2008c. *Declaration of the Constitutional Court of Mongolia: A Hearing Concerning a Classification of Citizen Burmaa's Legal Case, which Has Been Rejected by All Courts*. December 29, 2008.

———. 2009. *Supreme Court of Mongolia Final Hearing for a Civil Case #188, April 14, 2009*. Burmaa, Radnaagiin (with Sumyagiin Oyuntuya and Avirmed Mönkhnanan). 2008. *The Parliamentary Election of 2008: Manual for Organizing Elections*. Booklet prepared by the Center. Ulaanbaatar, Mongolia: Voter Education Center.

———. 2012. *The Parliamentary Election of 2012: Manual for Organizing Elections*. Booklet prepared by the Center. Ulaanbaatar, Mongolia: Voter Education Center.

Burn, Nalini, and Oidoviin Oyuntsetseg. 2001. *Women in Mongolia: Mapping Progress under Transition*. Ulaanbaatar, Mongolia: United Nations Development Fund for Women.

Buyandelger, Manduhai. 2013. *Tragic Spirits: Shamanism, Memory, and Gender in Contemporary Mongolia*. Chicago: University of Chicago Press.

———. 2014. "Engineers and Shamans as Heralds of the New Mongolia." *Vital Topics Forum Anthropology in and of MOOCs*, guest editor Graham Jones. *American Anthropologist* 116, no. 4 (Dec. 2014): 829–38.

———. 2018. "Asocial Memories, 'Poisonous Knowledge,' and Haunting in Mongolia: Asocial Memories." *Journal of the Royal Anthropological Institute* 25, no.

1. <https://doi.org/10.1111/14679655.12963>.
- . 2020. “Writing Oneself Out of the Oppression: Biographies of Reconciliation and Re-Collection.” *New Literary Observer* [in Russian]. No. 161 (January 20): 199–218.
- Buyandelgeriyn, Manduhai. 2008. “Post-post Transition Theories: Walking on Multiple Paths.” *Annual Review of Anthropology* 37:235–50.
- Cerwonka, Allaine. 2008. “Traveling Feminist Thought: Difference and Transculturation in Central and Eastern European Feminism.” *Signs: Journal of Women in Culture and Society* 33 (4): 809–32.
- Chaney, Joseph, and David Stanway. 2010. “Special Report—Mongolia’s Fabled Mine Stirs Asian Frontier.” *Reuters*, October 12, 2010. <https://www.reuters.com/article/uk-special-report-mongolia-mine/special-report-mongolias-fabled-mine-stirs-asian-frontier-idUKLNE69B05T20101012>. Accessed October 29, 2019.
- Chari, Sharad, and Katherine Verdery. 2009. “Thinking between the Posts: Postcolonialism, Post-socialism, and Ethnography after the Cold War.” *Comparative Studies in Society and History* 51 (1): 6–34.
- Chimid, B. 2008. *Election Study Guide: System, Process, and Rights* [In Mongolian: Songuulid Suraltsahui: Tогтoлтsoo, Уил Yавтs, Эрhзui]. Ulaanbaatar, Mongolia: Admon Publishing.
- Choi, Dale. 2010. “HDF to Receive \$94 M from Royalties and Erdenet, \$150 M from OT, to Spend \$235 M on Human Development in 2010.” *Independent Mongolian Metals & Mining Research*. November 23. <http://uclalum.blogspot.co.uk/2009/11/hdf-to-receive-94-m-from-royalties-and.html>.
- Chumley, Lily Hope. 2016. *Creativity Class: Art School and Culture Work in Postsocialist China*. Princeton, NJ: Princeton University Press.
- Coles, Kimberly. 2004. “Election Day: The Construction of Democracy through Technique.” *Cultural Anthropology* 19 (4): 551–80.
- . 2007. *Democratic Designs: International Intervention and Electoral Practices in Post-War Bosnia-Herzegovina*. Ann Arbor, MI: University of Michigan Press.
- Collier, Jane. 2009. “From Mary to Modern Woman: The Material Basis of Marianismo and Its Transformation in a Spanish Village.” *American Ethnologist* 13 (1): 100–107.
- The Constitutions of Mongolia. 2009. Ulaanbaatar, Mongolia. Compiled by J. Amarsanaa. Creed, Gerald W. 2011. *Masquerade and Postsocialism: Rituals and Cultural Dispossession in Bulgaria*. Bloomington, IN: Indiana University Press.
- Dashdondov, Tserendorjiin. 2003. “Gloomy Thoughts on Festivities.” In *This Is a Chronicle Executed with a Stylus in Hand with a Cluster of Words Urged and Their Meaning Nurtured*, 6–18. Ulaanbaatar, Mongolia. The Union of Mongolian Journalists.
- Dashpurev, Danzankhorloo, and S. K. Soni. 1992. *Reign of Terror in Mongolia, 1920–1990*. New Delhi: South Asian Publishers.
- De Certeau, Michel. 1984. *The Practice of Everyday Life*. Berkeley: University of California Press.
- De Haan, Francisca. 2012. “The Women’s International Democratic Federation (WIDF): History, Main Agenda, and Contributions, 1945–1991.” In *Women and Social Movements (WASI)*, edited by Thomas Dublin and Kathryn Kish Sklar. <http://alexanderstreet.com/products/women-and-social-movements-international> Online Archive. Accessed November 7, 2021.
- Delaplache, Grégory. 2010. “Marshal Choibalsan’s Second Funeral.” In *Representing Power in Modern Inner Asia: Conventions, Alternatives and Oppositions*, edited by Isabelle Charleux, Grégory Delaplace, and Roberte Hamayon, 97–116. Bellingham, WA: Western Washington University, Center for East Asian Studies.
- Delaplache, Grégory, Christopher Kaplonski, and David Sneath. 2008. “The End

of Post-socialism? An Account of the 1st of July Riots in Ulaanbaatar, Mongolia.” *Inner Asia* 10: 323–65.

De Lauretis, Teresa. 1987. *Technologies of Gender: Essays on Theory, Film, and Fiction*. Bloomington, IN: Indiana University Press.

Diaz, Holly D. 2019. “Centuries of Navigating Resistance and Change: Exploring the Persistence of Mongolian Women Leaders.” PhD diss. Antioch University, Yellow Springs, OH.

Dunn, Elizabeth. 2008. “Postsocialist Spores: Disease, Bodies, and the State in the Republic of Georgia.” *American Ethnologist* 35: 243–58. <https://doi.org/10.1111/j.1548-1425.2008.00032.x>.

Durkheim, Émile. 1995. *The Elementary Forms of Religious Life*. Translated and with an Introduction by Karen E. Fields. New York: The Free Press. First published in 1912.

Edmonds, Alexander. 2010. *Pretty Modern: Beauty, Sex, and Plastic Surgery in Brazil*. Durham, NC: Duke University Press.

Elfimov, Alexei. 2003. *Russian Intellectual Culture in Transition: The Future in the Past*. Münster, Germany: Lit Verlag.

Ellis-Petersen, Hanna. 2018. “Malaysia to Reopen Inquiry into Murder of Mongolian Model.” *The Guardian*. June 22. <https://www.theguardian.com/world/2018/jun/22/malaysia-altantuya-re-open-investigation-mongolian-model-murder>. Accessed November 7, 2021.

Empson, Rebecca. 2020. *Subjective Lives and Economic Transformations in Mongolia: Life in the Gap*. London: UCL Press.

Empson, Rebecca, and Lauren Bonilla. 2019. “Introduction: Temporary Possession.” *Theorizing the Contemporary*, *Fieldsights*, March 29. Editors’ Forum. *Cultural Anthropology*. <https://culanth.org/fieldsights/introduction-temporary-possession>.

Erdene, L. 2008. “The Weakening of the Democratic Party.” In *Mongolyn Ünen [Mongolian Truth]*. April 11, no. 70 (21044).

Eudin, Xenia Joukoff, and Harold H. Fisher. 1957. *Soviet Russia and the West, 1920–1927: A Documentary Survey*. Stanford, CA: Stanford University Press.

Fisher, Melissa S. 2012. *Wall Street Women*. Durham, NC: Duke University Press.

Fitzpatrick, Sheila, ed. 1978. *Cultural Revolution in Russia, 1928–1931*. Bloomington, IN: Indiana University Press.

———. 1979. *Education and Social Mobility in the Soviet Union, 1921–1932*. Cambridge: Cambridge University Press.

Foucault, Michel. 1977. *Discipline and Punish*. New York: Vintage Books.

———. 1988. “Technologies of the Self.” In *Technologies of the Self: A Seminar with Michel Foucault*, edited by Luther H. Martin, Huck Gutman, and Patrick H. Hutton, 16–49. Amherst, MA: University of Massachusetts Press.

Fox, Elizabeth. 2017. “The Price of an Election: Split Hopes and Political Ambivalence in the Ger District of Ulaanbaatar.” *Emerging Subjects* (blog), July 13. <https://blogs.ucl.ac.uk/mongolian-economy/2017/07/13/the-price-an-election-split-hopes-and-political-ambivalence-in-the-ger-districts-of-ulaanbaatar/>. Accessed October 30, 2019.

———. 2016. “The Road to Power.” *Emerging Subjects* (blog), August 24. <https://blogs.ucl.ac.uk/mongolian-economy/2016/08/24/the-road-to-power/>. Accessed March 15, 2021.

Freeman, Carla. 2014. *Entrepreneurial Selves: Neoliberal Respectability and the Making of a Caribbean Middle Class*. Durham, NC: Duke University Press.

Friedland, Robert. 2005. “Nothing Like It on Planet Earth: Robert Friedland’s

Tour d' Tolgoi." Keynote Address presented at the BMO Nesbitt Burns Global Resources Conferences, Tampa, Florida. <http://www.resourceinvestor.com/pebble.asp?relid=9010>.

Friedman, Milton. 2001. Free to Choose. In Mongolian [Khuv, zaïaagan songokh n']. Ulaan- baatar, Mongolia: "Monsudar" Kheвлеliin: "Altan Taria" khuv'aat Kompani.

Funk, Nanette, and Magda Mueller. 1993. *Gender Politics and Post-Communism: Reflections from Eastern Europe and the Former Soviet Union*. London: Routledge.

Gal, Susan, and Gail Kligman. 2000. *The Politics of Gender after Socialism: A Comparative- Historical Essay*. Princeton NJ: Princeton University Press.

Gaidar, Arkady. 1973 [original publication, 1940]. *Timur and His Squad* [Timur i yego komanda]. Moscow: Progress Publishers.

Ganhuyag, Dashtsevegiin. 2019. "Mongolians Have Not Participated in the Global Division of Labor for 30 Years." *Sudlaach Ganaa* (blog). May 29. <https://ganaa.mn/2019/05/29/nbnby wywitisghs/>. Accessed March 14, 2021.

Gerelsuren, N., and D. Altai. 2008. *Mongolian Women's Organization: Chronicles 1924–2008*. Ulaan- baatar, Mongolia: Uralah Erdem Publishing Company.

Gerelsuren, N., and J. Erdenechimeg. 2014. *On Tsagin Dursamj* [Reminiscence of the Years]. Vols. 1–3. Ulaanbaatar, Mongolia: Mönkhiin Үсег.

Gessen, Masha. 1997. *Dead Again: The Russian Intelligentsia after Communism*. New York: Verso.

Ghodsee, Kristen. 2012. "Rethinking State Socialist Mass Women's Organizations: The Committee of the Bulgarian Women's Movement and the United Nations Decade for Women, 1975–1985." *Journal of Women's History* (24) 4: 49–73.

———. 2014. "Pressuring the Politburo: The Committee of the Bulgarian Women's Movement and State Socialist Feminism." *Slavic Review* 73 (3): 538–62.

———. 2019. *Second World, Second Sex: Socialist Women's Activism and Global Solidarity During the Cold War*. Durham, NC: Duke University Press.

Ginsburg, Faye. 1989. *Contested Lives: The Abortion Debate in an American Community*. Berkeley: University of California Press.

Good, Mary-Jo Del Vecchio. 1999. "Foreword." In *Hermeneutics and Honor: Negotiating Female "Public" Space in Islamic/ate Societies*, edited by Asma Afsaruddin. Cambridge, MA: Harvard University Press.

Government of Mongolia, National Committee for Gender Equality. 2011. "Women's Participation in Decision-Making: Research on the Populace's Opinion." [Part One of the Research]. Document can be requested from the National Committee on Gender Equality, Government Bldg. 11, Room 611, 612. Desk Study Brochure.

———. 2012. "Women's Participation in Political Leadership: Research on the Populace's Opinion." [Part Two of the Research]. Ulaanbaatar, Mongolia: Soyombo Printing [In Mongolian].

Greenberg, Jessica. 2006. "Noć Reklamoždera: Democracy, Consumption, and the Contradictions of Representation in Post-Socialist Serbia." *PoLAR: Political and Legal Anthropology Review* 29 (2): 181–207.

Greenhouse, Carol. J. 1996. *A Moment's Notice*. Ithaca, NY: Cornell University Press.

Gruska, Ulriker, Christoph Dreyer, and Anne Renzenbrink. 2016. "Who Owns Media in Mongolia?" *Press Institute of Mongolia and Reporters without Borders*. <https://rsf.org/en/news/who-owns-media-mongolia>. Accessed April 4, 2021.

Hann, Chris. 2006. *Not the Horse We Wanted! Postsocialism, Neoliberalism and Eurasia*. Münster: LIT.

Hatcher, Pascale. 2014. *Regimes of Risk: The World Bank and the Transformation*

of Mining in Asia. London: Palgrave Macmillan.

Heller, Nathan. 2017. "Is the Gig Economy Working?" *New Yorker*. May 15, 2017. <https://www.newyorker.com/magazine/2017/05/15/is-the-gig-economy-working>.

Herzfeld, Michael. 2000. "Uncanny Success: Some Closing Remarks." In *Elites: Choice, Leadership, and Succession*, edited by João de Pina-Cabral and Antónia Pedroso de Lima, 227–36. Oxford: Berg.

———. 2005. *Cultural Intimacy: Social Poetics in the Nation-State*. New York: Routledge.

———. 2015. "Heritage and Corruption: The Two Faces of the Nation-State." *International Journal of Heritage Studies* 21:531–44. Online 2014, <https://doi.org/10.1080/13527258.2014.948486>.

———. 2018. "Corruption as Political Incest: Temporalities of Sin and Redemption." In *Reconnecting State and Kinship*, edited by Tatjana Thelen and Erdmute Alber, 39–60. Philadelphia: University of Pennsylvania Press.

Hladik, Radim. 2011. "A Theory's Travelogue: Post-Colonial Theory in Post-Socialist Space." *Theory of Science* 33 (4): 561–90.

Højer, Lars. 2019. *The Anti-Social Contract: Injurious Talk and Dangerous Exchanges in Northern Mongolia*. New York: Berghahn.

Højer, Lars, and Morten Pedersen. 2019. *Urban Hunters: Dealing and Dreaming in Times of Transition*. New Haven, CT: Yale University Press.

Huat, Chua Beng. 2007. *Elections as Popular Culture in Asia*. London: Routledge.

Humphrey, Caroline. 1993. "Women and Ideology in Hierarchical Societies in East Asia." In *Persons and Powers of Women in Diverse Cultures*, edited by S. Ardener, 173–92. New York: Berg.

———. 2002. *The Unmaking of Soviet Life: Everyday Economies after Socialism*. Ithaca, NY: Cornell University Press.

———. 2008. "Reassembling Individual Subjects: Events and Decisions in Troubled Times." *Anthropological Theory* 8 (4): 357–80.

Interparliamentary Union. 1973. *Mongolia*. http://www.ipu.org/parlinee/reports/arc/MONGOLIA_1973_E.PDF.

———. 1977. *Mongolia*. http://www.ipu.org/parlinee/reports/arc/MONGOLIA_1977_E.PDF.

Ismailbekova, Aksana. 2017. *Blood Ties and the Native Son: Poetics of Patronage in Kyrgyzstan*. Bloomington, IN: Indiana University Press.

Jacob, Pearly. 2012. "Mongolia: Can New Electoral Law Help Women Enter Parliament?" In *Eurasianet* (online news outlet), June 27, 2012. <https://eurasianet.org/>. <https://www.eurasiareview.com/29062012-mongolia-new-electoral-law-aims-to-help-women-enter-parliament/>. Accessed October 31, 2019.

Jaggar, Alison. 1994. *Living with Contradictions: Controversies in Feminist Social Ethics*. Boulder, CO: Westview Press.

Jain, Kajri. 2007. *Gods in the Bazaar: The Economies of Indian Calendar Art*. Durham, NC: Duke University Press.

Jamian, G. 2017. *The Life of Resisting and Succumbing*. [In Mongolian.] Ulaanbaatar, Mongolia: Impresscolor Press.

Kanaaneh, Rhoda Ann. 2002. *Birthing the Nation: Strategies of Palestinian Women in Israel*. Berkeley. University of California Press.

Kaplonski, Chris. 2004. *Truth, History and Politics in Mongolia: Memory of Heroes*. New York: Routledge.

———. 2014. *The Lama Question: Violence, Sovereignty and Exception in Early Socialism in Mongolia*. Honolulu, HI: University of Hawaii Press.

Kligman, Gail. 1998. *The Politics of Duplicity: Controlling Reproduction in*

Ceausescu's Romania. Berkeley: University of California Press.

Klima, Michal. 2019. *Informal Politics in Post-Communist Europe: Political Parties, Clientelism and State Capture*. London: Routledge.

Klumbyte, Neringa. 2014. "Of Power and Laughter: Carnavalesque Politics and Moral Citizen-ship in Lithuania." *American Ethnologist* 41 (3): 473–90.

Knapp, Michael, Anja Flach, and Ercan Ayboğa. 2016. *Revolution in Rojava: Democratic Autonomy and Women's Liberation in the Syrian Kurdistan*. London: Pluto Press.

Kohl-Garrity, Elisa. 2019. "The Weight of Respect: Khündlekh Yos—Frames of Reference, Governmental Agendas and Ethical Formations in Modern Mongolia." PhD diss. University of Halle-Wittenberg, Halle, Germany.

Kohn, Michael. 2013. "Mongolia Loan May Help Tavan Tolgoi Exit Chalco Deal, CEO Says." *Bloomberg.com*. January 24. <http://www.bloomberg.com/news/articles/2013-01-24/mongolia-loan-may-help-tavan-tolgoi-exit-chalco-deal-ceo-says>.

Kohn, Michael, and Yuriy Humber. 2013. "Mongolia Plans to Charge Rio's Oyu Tolgoi Interest on Tax." *Bloomberg.com*. February 28. <https://www.bloomberg.com/news/articles/2013-02-28/mongolia-plans-to-charge-rio-s-oyu-tolgoi-interest-on-unpaid-tax>. Accessed November 7, 2021.

Kracauer, Siegfried. 1995. *The Mass Ornament: Weimar Essays*. Cambridge, MA: Harvard University Press. First published 1963.

Krook, Mona Lena. 2009. *Quotas for Women in Politics: Gender and Candidate Selection Reform Worldwide*. New York: Oxford University Press.

Krook, Mona Lena, and Jacqui True. 2012. "Rethinking the Life Cycles of International Norms: The United Nations and the Global Promotion of Gender Equality." *European Journal of International Relations* 18 (1): 103–27.

Lawless, Jennifer, and Richard L. Fox. 2010. *It Still Takes a Candidate: Why Women Don't Run for Office*. Cambridge: Cambridge University Press.

Lazzarato, Maurizio. 2014. *Signs and Machines: Capitalism and the Production of Subjectivity*. New York: Semiotext(e).

Ledeneva, Alena V. 2006. *How Russia Really Works: The Informal Practices That Shaped Post-Soviet Politics and Business*. Ithaca, NY: Cornell University Press.

Lefort, Claude. 1988. *Democracy and Political Theory*. Cambridge, UK: Polity Press. Leshkovich, Ann Marie. 2014. "Standardized Forms of Vietnamese Selfhood: An Ethnographic

Genealogy of Documentation." *American Ethnologist* 41 (1): 143–62.

Leyenaar, Monique. 2004. *The Political Empowerment of Women: The Netherlands and Other Countries*. Boston/Leiden: Martinus Nijhoff Publishers.

Lhagva, G. 2015. "Neither Here Nor There." *Unuudur*, January 14, 2015. http://www.new.mn/News/Detail?news_code=29667.

Lhamsuren, B., ed. 1985. *Short History of the Mongolian People's Revolutionary Party* [Mongol

Ardyn Khuvsгалт Намын Товч Туух]. Ulaanbaatar, Mongolia: State Publishing House. [In Mongolian.]

Lomnitz, L. A., Claudio Lomnitz Adler, and Ilya Adler. 1993. "The Function of the Form: Power Play and Ritual in the 1988 Mexican Presidential Campaign." In *Constructing Culture and Power in Latin America*, edited by Daniel H. Levine, 357–401. Ann Arbor, MI: University of Michigan Press.

Mahmood, Saba. 2005. *The Politics of Piety: The Islamic Revival and the Feminist Subject*. Princeton, NJ: Princeton University Press.

Mandel, Ruth, and Caroline Humphrey. 2002. *Markets and Moralities:*

Ethnographies of Postso- cialism. London: Bloomsbury Academic.

Manning, Paul. 2007. "Rose Colored Glasses? Color Revolutions and Cartoon Chaos in Postso- cialist Georgia." *Cultural Anthropology* 22:171–213.

Marwick, Alice E. 2015. "Instafame: Luxury Selfies in the Attention Economy." *Public Culture* 27, no. 1 (Jan. 2015): 137–60.

Mauss, Marcel. 2006. *Techniques, Technology and Civilization*. New York: Berghahn Books.

MCC (Millennium Challenge Compact). 2008. "Making a Difference: 2008 Annual Report." https://pdf.usaid.gov/pdf_docs/PCAAB908.pdf. Accessed November 5, 2021.

McDowell, Linda. 1997. *Capital Culture: Gender at the Work in the City*. Malden, MA: Wiley- Blackwell Publishers.

McLeod, James R. 1999. "The Sociodrama of Presidential Politics: Rhetorics, Ritual and Power in the Era of Teledemocracy." *American Anthropologist* 101 (2): 359–73.

MEC LLC Research and Advisory. 2007. "Baseline Survey Women Participation in Electoral Pro- cess." As part of the "Support to Electoral Processes in Mongolia" Project of UNDP Mongolia, 2007. <http://www.mec.mn/> or contact infor@mex.com. to request a copy of the report.

Miles, William. 1988. *Elections in Nigeria: A Grassroots Perspective*. Boulder, CO: Lynne Rienner.

Miller, Laura. 2006. *Beauty Up: Exploring Contemporary Japanese Body Aesthetics*. Berkeley: University of California Press.

Mitchell, W. J. T. 1984. "What Is an Image?" *New Literary History* 15, no. 3: 503–37. <https://doi.org/10.2307/468718>.

———. 2012. "Image, Space, Revolution: The Arts of Occupation." *Critical Inquiry* 39, no. 1: 8–32.

Mongolian People's Revolutionary Party (MPRP). Politburo Central Plenum Decree #338. December 22, 1966. "On the Promotion of Women to the Leadership Positions in Party, State, and Public Establishments." National Archives [МУҮТА], Ulaanbaatar, Mongolia, UTNONBBA, Kh-4, D-30, KhN-7, Kh., pages 337–42.

The Mongolian Women. 1964. Periodical, 1964, issue no. 3. Ulaanbaatar, Mongolia. Mönkhchimeg, Davaasharav. 2018. "Mongolians Protest against Corruption as Temperature Plunges." Reuters (online newspaper). <https://www.reuters.com/article/us-mongolia-politics /mongolians-protest-against-corruption-as-temperature-plunges-idUSKCN1OQ0RG>. Accessed March 15, 2021.

Moore, Sally F., and Barbara Meyerhoff. 1977. *Secular Ritual*. Assen, Netherlands: VanGorcum.

Munkh-Erdene, Lhamsuren. 2012. "Mongolia's Post-Socialist Transition: A Great Neoliberal Transformation." In *Mongolians after Socialism: Politics, Economy, Religion*, edited by Bruce M. Knauff and Richard Taupier, 61–66. Ulaanbaatar, Mongolia: Admon Publishing.

Namuun, A. 2019. "'Gifts of the Politicians' Exhibition Opens." *Ikon.mn* (online newspaper). May 14. In Mongolian. https://ikon.mn/n/1kob?fbclid=IwAR1P1KaQfaCsaDokA5QbUfGd_kRJsgelTZ_ywyw5-o6YCCQuXhHhGKqzchH2Q. Accessed November 5, 2021.

Naughton, Tracey, and Ondine Ullman. 2008. "Blue Sky Mining: Community and Mining in Omnogovi Aimag, Mongolia." Scoping Report. Ulaanbaatar, Mongolia: Pact Mongolia.

Nima, Dolgoryn. 2009. *The Life and Work of Pagamdulam, the Wife of Great Poet Natsagdorj*. Ulaanbaatar, Mongolia: Bembi San, LLC.

Nordby, Judith. 1988. "The Mongolian People's Republic, 1924–1928, and the Right Deviation." PhD diss., University of Leeds, Department of Chinese Studies.

Nugent, David, and Joan Vincent, eds. 2009. *A Companion to the Anthropology of Politics*. Oxford, UK, and Cambridge, MA: Blackwell Reference Online Collection. <https://onlinelibrary.wiley.com/doi/book/10.1002/9780470693681>.

Obeid, Michelle. 2011. "The 'Trials and Errors' of Politics: Municipal Elections at the Lebanese Border." *PoLAR: Political and Legal Anthropology Review* 34 (2): 251–67.

Odontuya, Turmunkh. 2016. "On Encouraging Mothers of Multiple Children through the Order of the Mother Glorious in Mongolia." In *Rethinking Representations of Asian Women*, edited by N. Iguchi, 35–49. New York: Palgrave Macmillan.

Oleinik, Anton. 2012. "Institutional Exclusion as a Destabilizing Factor: The Mass Unrest of 1 July 2008 in Mongolia." *Central Asian Survey* 31, no. 2: 153–74. <https://doi.org/10.1080/02634937.2012.671994>. Accessed March 12, 2021.

Ong, Aihwa. 2006. *Neoliberalism as Exception: Mutations in Citizenship and Sovereignty: Mutations in Citizenship and Sovereignty*. Durham, NC: Duke University Press.

Ong, Aihwa, and Stephen J. Collier, eds. 2004. *Global Assemblages: Technology, Politics, and Ethics as Anthropological Problems*. Malden, MA: Wiley-Blackwell.

Ong, Aihwa, and Michael G. Peletz, eds. 1995. *Bewitching Women, Pious Men: Gender and Body Politics in Southeast Asia*. Berkeley: University of California Press.

Ortner, Sherry B. 1974. "Is Female to Male as Nature Is to Culture?" In *Woman, Culture and Society*, edited by M. Rosaldo and L. Lamphere, 67–88. Stanford, CA: Stanford University Press.

———. 2001. "Specifying Agency: The Comaroffs and Their Critics." *Interventions* 3 (1): 76–84.

———. 2005. "Subjectivity and Cultural Critique." *Anthropological Theory* 5 (1): 31–52.

———. 2006. "Power and Projects: Reflections on Agency." In *Anthropology and Social Theory: Culture, Power, and the Acting Subject*, edited by Sherry Ortner, 129–53. Durham, NC: Duke University Press.

Oushakine, Serguei. 2004. "The Flexible and the Pliant: Disturbed Organisms of Soviet Modernity." *Cultural Anthropology* 19 (3): 392–428.

Oyungerel, Tseveddamba. 2007a. *Notes on my Study in America*. Ulaanbaatar, Mongolia: Interpress.

———. 2007b. *Nomadic Dialogues*. Ulaanbaatar, Mongolia: Admon Publishing.

———. 2008. *The Green-Eyed Lama*. Ulaanbaatar, Mongolia: Admon Publishing.

Oyuntuya, Sumyagiin. 2013a. "Political Financing: Studies from 2008–2013." Powerpoint presentation. The Voter Education Center, Ulaanbaatar Mongolia. Personal communication with the author.

———. 2013b. "Women's Participation in Politics: Experiences and Lessons Gained." Powerpoint presentation. The Voter Education Center, Ulaanbaatar Mongolia. Personal communication with the author.

———. 2013c. "Some Issues on the Management of Electoral Financing: Mongolia." Report. The Voter Education Center, Ulaanbaatar, Mongolia. Personal communication with the author.

Paley, Julia. 2002. "Toward an Anthropology of Democracy." *Annual Review of Anthropology* 31: 469–96.

———. 2008. *Democracy: Anthropological Approaches*. Santa Fe, NM: SAR

Press.

Parliament Archive. 2008. “2007 Fall Plenary Session Minutes.” January 10, 2008, 10:30 a.m. Parliament Building, Parliament Library, Archive collections. Ulaanbaatar, Mongolia.

Paxson, Heather. 2004. *Making Modern Mothers: Ethics and Family Planning in Urban Greece*. Berkeley: University of California Press.

Pedersen, Morten A. 2011. *Not Quite Shamans: Spirit Worlds and Political Lives in Northern Mongolia*. Ithaca, NY: Cornell University Press.

Perlez, Jane. 2012. “From Mongolia, Clinton Takes a Jab at China.” *New York Times*, July 9. http://www.nytimes.com/2012/07/10/world/asia/in-mongolia-clinton-offersmessage-to-china.html?_r=0.

Phillips, Sarah D. 2014. “The Women’s Squad in Ukraine’s Protests: Feminism, Nationalism, and Militarism on the Maidan.” *American Ethnologist* 41:414–26.

Piliavsky, Anastasia, ed. 2014. *Patronage as Politics in South Asia*. Cambridge: Cambridge University Press.

Plueckhahn, Rebekah. 2020. *Shaping Urban Futures in Mongolia: Ulaanbaatar, Dynamic Ownership and Economic Flux*. London: University College London.

Prashad, Vijay. 2007. *The Darker Nations: A People’s History of the Third World*. New York: The New Press.

Radchenko, Sergey, and Mendee Jargalsaikhan. 2017. “Mongolia in the 2016–17 Electoral Cycle: The Blessings of Patronage.” *Asian Survey* 57, no. 6 (December 1): 1032–57. <https://doi.org/10.1525/as.2017.57.6.1032>.

Results of Parliamentary Elections in Mongolia. 2017. In the website of the General Election Commission of Mongolia, <https://www.gec.gov.mn/>. Accessed March 15, 2021.

Reuschmeyer, Marilyn, and Sharon L. Wolchik. 2009. *Women in Power in Post Communist Parliaments*. Bloomington, IN: Indiana University Press.

Ries, Nancy. 1997. *Russian Talk: Culture and Conversation during Perestroika*. Ithaca, NY: Cornell University Press.

Riles, Annelise. 2000. *The Network Inside Out*. Ann Arbor, MI: University of Michigan Press.

Rivkin-Fish, Michele. 2009. “Tracing Landscapes of the Past in Class Subjectivity: Practices of Memory and Distinction in Marketizing Russia.” *American Ethnologist* 36 (1): 79–95.

Robinson, Bernadette, and A. Solongo. 2000. “The Gender Dimension of Economic Transition in Mongolia.” In *The Mongolian Economy: A Manual of Applied Economics for a Country in Transition*, edited by F. Nixon, B. Suvd, P. Luvsandorj, and B. Walters, 231–55. Cheltenham, UK: Edward Elgar Publishing.

Rose, Nikolas. 1999. *Powers of Freedom: Reframing Political Thought*. Cambridge: Cambridge University Press.

Rossabi, Morris. 2005. *Modern Mongolia: From Khans to Commissars to Capitalists*. Berkeley: University of California Press.

Rupen, Robert A. 1956. “Cyben Žamcaranovič Žamcarano (1880?–1940).” *Harvard Journal of Asiatic Studies* 19 (June): 126–45.

———. 1979. *How Mongolia Is Really Ruled: A Political History of the Mongolian People’s Republic, 1900–1978*. Stanford, CA: Hoover Institution Press.

Sablin, Ivan, Jargal Badagarov, and Irina Sodnomova. 2021. “Khural Democracy: Imperial Transformations and the Making of the First Mongolian Constitution, 1911–1924.” In *Socialist and Post-Socialist Mongolia Nation, Identity, and Culture*, edited by Simon Wickhamsmith and Phillip P. Marzluf, chap. 2, 12–42. New York: Routledge.

Sabloff, Paula. 2013. *Does Everyone Want Democracy? Insights from Mongolia*. Walnut Creek, CA: Left Coast Press.

Sarantuya, Bjambaagijn. 2012. Sorhugtani. Ulaanbaatar, Mongolia: Admon.

Saruul-Erdene, Myagmariin. 2000. "An Internal Affairs' Chairman's Attempt to Connect with the USA or the Image of Khayankhivva Namjiliin." *The Best Columnists of Mongolia* (website), April 6, 2000. <http://www.baabar.mn>. April 6. Accessed March 27, 2021.

Schmillen, Achim, and Nina Weimann-Sandig. 2018. "Perceptions of Precariousness: A Qualitative Study of Constraints Underlying Gender Disparities in Mongolia's Labor Market." Washington: World Bank Group. A Study Report. <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/29539/124451.pdf?sequence=4&isAllowed=y>. Accessed November 7, 2021.

Schwenkel, Christina, and Ann Marie Leshkovich. 2012. "Guest Editors' Introduction: How Is Neoliberalism Good to Think Vietnam? How Is Vietnam Good to Think Neoliberalism?" *Positions: Asia Critique* 20 (2): 379–401.

Scott, Joan W. 2009. "Finding Critical History." In *Becoming Historians*, edited by James Banner and John Gillis, 26–53. Chicago: University of Chicago Press.

———. 2019. *Sex and Secularism*. Princeton, NJ: Princeton University Press.

———. 2018. "The Persistence of Gender Inequality: How Politics Construct Gender, and Gender Constructs Politics." *The Institute Letter* (Fall 2018): 8–10. Institute for Advanced Study. <https://www.ias.edu/ideas/scott-gender-inequality>. Accessed November 7, 2021.

———. 1981. "Politics and Professionalism: Women Historians in the 1980s." *Women's Studies Quarterly* 9 (3): 23–32.

———. 1991. "The Evidence of Experience." *Critical Inquiry* 17 (4): 773–97.

———. 1996. "Academic Freedom as an Ethical Practice." In *The Future of Academic Freedom*, edited by Louis Menand, 163–87. Chicago: University of Chicago Press.

Seale-Collazo, James. 2012. "Charisma, Liminality, and Freedom: Toward a Theory of the Everyday Extraordinary." *Anthropology of Consciousness* 23:175–91. <https://doi.org/10.1111/j.15563537.2012.01060.x>. Accessed March 21, 2021.

Sengupta, Somini. 2015. "Most Nations Miss a Goal for Women in Leadership." *New York Times*, August 31. <http://www.nytimes.com/2015/09/01/world/most-nations-miss-a-goal-for-women-in-leadership.html>.

Shalin, Dmitri. 2012. "Intellectual Culture: The End of Russian Intelligentsia." http://digitalscholarship.unlv.edu/cgi/viewcontent.cgi?article=1005&context=russian_culture.

Shinkarev, L. 2006. *Tsedenbal and His Time: The Chronicles* [In Mongolian: Tsedenbal, Tuunii Tsag Uye: Barimtat Ögüülemj]. 2 vols. Vol. 2: 213–26. Ulaanbaatar, Mongolia: Monsudar.

Shirendev, Bazarin. 1969. *The History of Mongolian People's Republic*. Ulaanbaatar, Mongolia: State Publishing House.

Shlapentokh, Vladimir. 2014. *Soviet Intellectuals and Political Power: The Post-Stalin Era*. Princeton, NJ: Princeton University Press.

Shuudertsetseg, B. Chanrav. 2011. *Legendary Queen Anu*. Ulaanbaatar, Mongolia: Admon.

Siilegmaa, Tserenpiliin. 2004. *Siilegmaa of the Women's Committee*. Ulaanbaatar, Mongolia: Sogoo Khuur Publishing LLC.

Simon, Scott. 2010. "Negotiating Power: Elections and the Constitution of Indigenous Taiwan." *American Ethnologist* 37:726–40.

Smith, Marissa. 2020. "Power of the People's Parties and a Post-Soviet Parliament:

Regional Infrastructural, Economic, and Ethnic Networks of Power in Contemporary Mongolia.” Special Issue: Parliamentary Formations and Diversities in (Post-)Imperial Eurasia, edited by Ivan Sablin. *Journal of Eurasian Studies* 11(1–2): 1–10. <https://doi.org/10.1177/1879366520916743>.

———. 2018. “Mungu Idekh” [Eating Money]. In *Global Informality Project* (online encyclopedia). [https://www.informality.com/wiki/index.php?title=Mungu_idekh_\(Mongolia\)](https://www.informality.com/wiki/index.php?title=Mungu_idekh_(Mongolia)). Accessed November 5, 2021.

Sneath, David. 2006. “Transacting and Enacting: Corruption, Obligation and the Use of Monies in Mongolia.” *Ethnos* 71 (no. 1): 89–112. <https://doi.org/10.1080/00141840600603228>.

———. 2010. “Political Mobilization and the Construction of Collective Identity in Mongolia.” *Central Asian Survey* 29 (3): 251–67.

———. 2018. *Mongolia Remade: Post-socialist National Culture, Political Economy, and Cosmo-politics*. Amsterdam: Amsterdam University Press.

Sperling, Valerie. 1999. *Organizing Women in Contemporary Russia: Engendering Transition*. Cambridge: Cambridge University Press.

Spyer, Patricia, and Mary Margaret Steedly. 2013. “Introduction: Images That Move.” In *Images That Move*, edited by Patricia Spyer and Mary Steedly, 3–41. Santa Fe, NM: SAR Press.

Stack, Carol. 1983. *All Our Kin*. New York: Basic Books.

Stacey, Judith. 1983. *Patriarch and Socialist Revolution in China*. Berkeley: University of California Press.

Steedly, Mary Margaret. 2000. “Modernity and the Memory Artist: The Work of Imagination in Highland Sumatra, 1947–1995.” *Comparative Studies in Society and History* 42 (4): 811–46.

Stoler, Ann. 2009. *Along the Archival Grain: Epistemic Anxieties and Colonial Common Sense*. Princeton, NJ: Princeton University Press.

Strassler, Karen. 2020. *Demanding Images: Democracy, Mediation, and the Image-Event in Indonesia*. Durham, NC: Duke University Press.

Suren, N. 2008. “The Election Promises or Two Sides of a Coin.” In *Mongolyn Үнэн [Mongolian Truth]*. April 25, no. 080 (21054).

Tan, Netina. 2016. “Gender Reforms, Quotas and Women’s Political Representation in Taiwan, South Korea, and Singapore.” *Pacific Affairs* 89 (2): 84.

Tsenddoo, Byambajavyn. 2008. “Mongol Wife: Know Your Husband before Knowing the State” / “Mongol Gergii: Toroo Medie Gevel Eree Medeh.” In *Olloo.mn*. <http://archive.olloo.mn/News/91110.html>. Accessed April 12, 2015.

Tsedengiin, Tsetsegjargal, Zhigzhidiin Boldbaatar, and D. Tumen. 2009. *Mongolyn emegteichuud XX zuund: Khuvisal, oorchlolt [Mongolian Women in the Twentieth Century: Transformation and Changes]*. Ulaanbaatar, Mongolia: Soembo Printing.

Tsogtgerel, B. 2008. “The Laments of Stolen Billboards.” *Century News [Zuunii Medee]*, June 20.

Tsolmon, Davaagyn. 1995. “An Historical Outline of Mongol-American Relations and American Studies in Mongolia.” *American Studies International* 33, no. 2: 71–74. <http://www.jstor.org/stable/41279346>.

Tuya, Nyamosor. 2005. “Mongolia in 2004: Testing Politics and Economics.” *Asian Survey* 45, no. 1: 67–70.

———. 2012. “What Is at Stake in Mongolia’s Election.” *Brookings Institution*. June 26. <https://www.brookings.edu/opinions/what-is-at-stake-in-mongolias-election/>.

Undarya, Tumursukh. 2009. “Arrested Democratization and Glimpses of Hope:

Mongolia's Political Culture as Seen through the 2008 and 2009 Elections." In *Election and Democracy: Reflections on the Asian Experiences*, edited by the Korea Democracy Foundation, 137–65. Seoul: Korea Democracy Foundation.

———. 2018. "Interrogating Women's Activism in the Age of Neoliberal Democratization in Mongolia." PhD diss. Auckland University of Technology, Auckland, New Zealand.

United Nations. 1966. "1965 Seminar on the Participation of Women in Public Sphere." Ulan Bator, Mongolia, and United Nations, New York.

———. 1980. "Report of the World Conference of the United Nations Decade for Women: Equality, Development and Peace," Copenhagen, July 14–30. <https://undocs.org/en/A/CONF.94/35>. Accessed November 2, 2021.

———. 1986. "Report of the World Conference to Review and Appraise the Achievements of the United Nations Decade for Women: Equality, Development and Peace," Nairobi, July 15–26, 1985. <https://www.un.org/en/conferences/women/nairobi1985>. Accessed November 2, 2021.

———. 1996. "Report of the Fourth World Conference on Women," Beijing, September 4–15, 1995. <https://www.un.org/womenwatch/daw/beijing/fwcwn.html>. Accessed November 2, 2021.

———. 2020. "Report of the Commission on the Status of Women: Report on the Sixty Fourth Session." Economic and Social Council, United Nations. <https://undocs.org/en/E/CN.6/2020/L.1>. Accessed November 2, 2021.

Uranguya, Zhamsrangiin, and Batsukhiin Bayarsaihan, eds. 2004. *Jinhene dagaj yavah huuli' durem 1913–1918: Eh bichgiin sudalгаа [The Essential Laws and Regulations to Follow]*. Ulaanbaatar, Mongolia: Interpress.

Uyanga, Gantömöriin. 2017. "About MANAN." In *Toim Medee mn*. http://toimmedee.mn/index.php?view=article&type=item&val=5537&fbclid=IwAR0wVWlirHrUP1DolX8wNeeJb-S6RfBaqt3NQNQ6hSgnRrA_AKohI0VPe0. Accessed March 14, 2021.

Valdur, Mari. 2020. "Life and Abortion: The Post-Biopolitics of Reproductive Health in Ulaanbaatar, Mongolia." PhD diss. University of Helsinki, Finland.

Veblen, Thorstein. 2007. *The Theory of the Leisure Class*. Oxford: Oxford University Press. Verdery, Katherine. 1991. *National Ideology under Socialism: Identity and Cultural Politics in Ceasescu's Romania*. Berkeley: University of California Press.

———. 1996. *What Was Socialism, and What Comes Next?* Princeton, NJ: Princeton University Press.

Vidart-Delgado, Maria L. 2017. "Cyborg Political Machines: Political Brokering and Modern Political Campaigning in Colombia." *Hau: Journal of Ethnographic Theory* 7 (2): 255–77. <http://dx.doi.org/10.14318/hau7.2.027>.

Waters, Hedwig Amelia. 2016. "Erotic Capital as Societal Elevator: Pursuing Feminine Attractiveness in the Contemporary Mongolian Global(ising) Economy." *Sociologus* 66, no. 1 (2016): 25–51. <http://www.jstor.org/stable/24755104>.

Warner, Michael. 1992. "The Mass Public and the Mass Subject." In *Habermas and the Public Sphere*, edited by Craig Calhoun, 388. Cambridge, MA: MIT Press.

Weatherford, Jack. 2011. *The Secret History of the Mongol Queens: How the Daughters of Genghis Khan Rescued His Empire*. New York: Crown.

Werner, Cynthia. 2002. "Gifts, Bribes and Development in Post-Soviet Kazakhstan." In *Economic Development: An Anthropological Approach*, edited by Jeffrey Cohen and Norbert Dannhaeuser, 183–208. Walnut Creek, CA: Altamira.

Weston, Kath. 2002. *Gender in Real Time: Power and Transience in a Visual Age*. New York: Routledge. Wickhamsmith, Simon. 2020. *Literature and Politics in Mongolia (1921–1948)*. Amsterdam: Amsterdam University Press.

Wolf, Margery. 1960. *The House of Lim: A Study of a Chinese Farm Family*. Englewood Cliffs, NJ: Pearson.

Wood, Elizabeth. 1997. *The Baba and the Comrade: Gender and Politics in Revolutionary Russia*. Bloomington: Indiana University Press.

Woolf, Virginia. 2019. *A Room of One's Own*. London: Lector House. First published 1929.

Yang, Mayfair. 2018. "Millenarianism in the Soviet Union and Maoist China." In *Immanent Frame: Secularism, Religion, and the Public Sphere* (blog). November 23. <https://tif.ssrc.org/2018/11/23/millenarianism-in-the-soviet-union-and-maoist-china/> Accessed March 15, 2021.

Yurchak, Alexei. 2007. *Everything Was Forever until It Was No More*. Princeton, NJ: Princeton University Press.

———. 2015. "Bodies of Lenin: The Hidden Science of Communist Sovereignty." *Representations* 129 (Winter 2015): 116–57.

Zanaa, Jurmed. 2005. "The Concepts of Gender Equality and Their Application in Human Development." PhD diss., Mongolian National University, Ulaanbaatar, Mongolia.

Zubok, Vladislav. 2019. "Intelligentsia as a Liberal Concept in Soviet History, 1945–1991." In *Dimensions and Challenges of Russian Liberalism*, edited by R. Cucciolla, 45–62. Cham: Springer. https://doi.org/10.1007/978-3-030-05784-8_4.

Нэрийн хэлхээс

- Авлига, 3, 10, 13, 89, 95, 144-148,
157, 183, 188, 196, 200, 216, 246
- Антропологийн судалгаа, 17, 22, 27,
32, 35, 52, 184, 265
- Ардчилсан нам, 4, 10, 13, 16, 35, 37,
146, 197, 202, 231
- Ардын их хурал, 69, 72
- Ариунаа, 9-10, 226-228, 262
- Баасанхүү, 35, 94, 124, 141, 262
- Базар, 35-36, 117, 262
- Батцэцэг, 36, 262
- Батчулуун, 59
- Бие даан нэр дэвших/дэвшигч, 30,
35, 100, 123-124, 129, 137, 162,
196-198, 245,
- Биеэ бэлдэх, 17, 20-21, 42-43, 189-
190, 226-230, 232, 234-238, 240-
242, 244, 246-248, 250, 252, 254,
259
- Буддизм, 45, 54, 237
- Бүтцийн өөрчлөлт, 26, 76, 160, 173,
263
- Бэлгэдлийн капитал, 206, 231
- Бэлэг, 88, 95-99, 103, 107, 115, 125,
162, 173, 184, 194, 203, 230
- Ганди, 36, 77, 262
- Геополитик, 3, 11, 85, 87, 90
- Гэрэлсүрэн, 38, 58, 61, 66
- Жендэр, 1-5, 7-8, 15-18, 21-24, 28-29,
31-34, 41-44, 47-51, 54-55, 63, 72-
73, 75, 77, 87, 108, 119, 122-123,
139-144, 148, 154-160, 170, 184-
185, 188, 190-194, 198-202, 206,
223, 229-231, 240-241, 246-247,
252-260
- Занаа, 35, 137, 189, 196-202, 224,
230, 240, 245-247, 262
- Зөвлөлт Холбоот Улс/ЗХУ, 3, 28,
56-57, 60, 63-65, 67, 73, 86, 131,
191, 208, 236
- Иргэний нийгэм, 3, 13, 31, 33, 52,
107, 143-146, 196-199, 207-212,
220, 246, 262
- Төрийн бус байгууллага, 28-30, 209
- Иргэний нийгмийн идэвхтэн, 71, 77,
197, 199, 246
- Ичинноров, 36, 234, 262
- Кампанит ажил, 1-2, 5, 7, 9-12, 14-
15, 18, 20-27, 32-36, 39-47, 59,
77-85, 89-123, 125-130, 135-137,
139, 141-142, 145-146, 149-154,
156-168, 171, 175-180, 184, 186-
189, 193-198, 202-206, 209-218,
223-225, 228-235, 238, 240, 246-

- 247, 252-253, 256-259, 262
- Капитализм, 3-4, 21, 47, 53, 61-62, 87, 97, 103, 153, 189, 193
- Клинтон, Хилари, 1-2, 4-8, 17, 46, 78, 192, 241
- Коминтерн, 45, 56
- Лобби, 10-13, 16-17, 30-31, 77, 169-170, 189, 196, 199, 201-202, 258
- Мажоритар систем, 39-40
- Манлайлал, 16, 28-30, 158, 163, 175, 192, 231
- Монгол Ардын Нам/МАН, 4, 37, 58, 171
- Монгол Ардын Хувьсгалт Нам/МАХН, 3, 13, 37, 56
- Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, 58-59, 76-77
- Монголын Эмэгтэйчүүдийн Хороо 7, 18-19, 28, 47, 49
- Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоо, 10, 207
- Эмэгтэйчүүдийн хэлтэс/тасаг, 44-45, 49, 58-63, 65-66, 76
- Мянганы Сорилтын Сан/Компакт гэрээ, 13, 112
- Неолиберал/Неолиберализм, 2-5, 13-14, 18, 20-22, 25-27, 41, 43, 47-48, 78, 82, 85-88, 97, 100-102, 112-113, 115-117, 184, 189, 200, 223, 225, 227, 229-230, 236-237, 239, 248, 252, 255-260
- Нийгмийн сүлжээ, 8, 25, 81, 93, 97, 118, 125, 174, 209-210, 257-258
- Нэгдсэн Үндэстний Байгууллага/НҮБ, 29, 260
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, 208
- Нэр дэвшигч/дэвших, 1-28, 31-43, 45-49, 69-70, 79-82, 85, 87, 89-94, 96-108, 112, 115-118, 120, 122-130, 132-146, 148-150, 152-171, 174-189, 193-198, 202, 204-205, 209-211, 213-218, 220-239, 243-247, 252-253, 255, 257-259, 261-262, 264
- Одонтуяа, 35, 71, 230, 247-252, 262
- Олны танил, 9, 141, 154, 161, 206, 211, 213, 237
- Олон улсын байгууллага, 28, 30, 49-50, 78, 208, 260
- Чадавхжуулах сургалт, 28-32, 45, 62, 166, 253
- Орос/оросын, 34, 55-57, 71, 86, 127, 133, 191, 194, 198, 224, 236, 250
- Оюу толгой, 13, 111, 113
- Оюун, 15, 35, 195-196
- Оюунгэрэл, 8, 14, 16, 23, 36, 92, 183, 203, 205, 231, 240-244, 262
- Оюунлаг, 6, 20-21, 25-26, 34, 42-43, 48, 142-143, 187-214, 216, 218, 220, 222-233, 235, 239, 259
- Пагмадулам, 57, 63
- Сийлэгмаа, 66
- Сонгогдохуйц, 1, 9-10, 12, 14, 16-26, 28, 30, 32, 34, 36, 40, 43, 78, 139, 155, 165, 168, 189-190, 194, 211, 225, 227-233, 235-236, 253, 258-260
- Сонгууль
- Сонгуулийн амлалт, 13, 82, 88, 98, 108-109, 112-115, 239
- Сонгуулийн зардал/санхүүжилт, 4, 5, 25, 81, 146, 154, 162, 189, 195-196, 215, 217, 245, 259
- Сонгуулийн луйвар, 10, 175, 218, 220-222, 224
- Сонгуулийн мэргэжилтэн, 85
- Сонгуулийн сурталчилгаа, 20, 42, 80, 83, 90, 96, 98-99, 103-104, 110-111, 117, 122-127, 129-130, 135, 137, 140, 170, 176, 179-182, 185-186, 195-196, 198, 202, 210, 214, 242
- Сонгуулийн тойрог, 39, 89, 105,

- 127, 134, 152, 156, 165, 194, 234, 249, 257-258
Намын жагсаалт, 40, 223
- Сонгуульжилт, 2, 20, 23-27, 34, 37, 41-43, 79-86, 88-92, 94, 96, 98-106, 108, 110, 112, 114-126, 128, 130, 132, 134, 136, 138-140, 142, 144, 146, 148, 150, 152, 154, 158-159, 162, 164-165, 170, 184, 186, 224, 229, 235, 239, 255, 257
- Сосор, 58-59, 78
- Стратеги, 1, 12, 14-15, 17, 20, 23, 32-33, 37, 42, 46, 60, 68, 72, 125, 156, 158-167, 170, 174, 176-178, 192, 200, 203, 207, 218, 228, 230, 235-236, 244, 252-255, 260
- Субъектив шинж байдал, 19, 27, 48-49, 60, 73, 77-78, 83, 89, 105, 107-108, 114, 117, 133, 158, 161, 164-165, 229, 252, 256
- Тактик, 20-21, 33, 42, 160-161, 163-165, 170, 174, 176-178, 181, 233, 241, 252, 255, 258
- Танигдах/Танигдахуй, 3, 6, 28, 43, 74, 81, 118-119, 164, 184, 190-192, 213, 225, 229, 235, 240, 259
- Торгон ухаан/торгон мэдрэмж, 190, 193-194
- Удвал, Нацагийн, 36, 171, 262
- Удвал, Сономын, 68-69, 72,
- Ураг төрөл, 56, 88, 98, 257
- Феминизм, 27-28, 30-31, 60, 65, 69, 158, 161, 199, 201, 246, 253
- Либерал феминизм, 18, 38, 41, 49-50, 52, 63, 76
- Социалист феминизм, 28, 38, 50, 53, 161
- Филатова, 71-72
- Халтуурчид, 25, 99
- Харизм, 6, 12, 25, 46, 152, 196-197, 224, 228, 230-231, 235, 244-247
- Хувьчлал, 5, 199
- Хүйтэн дайн, 27, 53, 67, 212
- Хүчирхийлэл, 8, 31, 39, 62-63, 90, 93, 191, 217
- Шүүдэрцэцэг, 231-232, 261
- Эрдэнэчимэг, 7, 38, 58, 61, 66
- Эсэргүүцэл, 50, 86, 98, 112
- Янжмаа, 44-45, 58-59, 78

Монгол Улс тоталитар социализмын төгсгөлд чөлөөт сонгуулийг түргэн хугацаанд нутагшуулсныхаа төлөө “ардчиллын арал” хэмээн үнэлэгдэх болов. Гэсэн хэдий ч ардчиллын үйл явцтай зэрэгцэн энгийн сонгуулийн үеэс ч давж гарсан монголчуудын өдөр тутмын амьдралыг удирдах неолиберал хүч бий болсныг Буяндэлгэрийн Мандухай “сонгуульжилт” гэж томъёолжээ. Ийнхүү, сонгуулийн кампанит ажил нийгмийн халамжаас өгсүүлээд төрийн зарим үүргийг орлон гүйцэтгэх болсон нь ихэнх эмэгтэй нэр дэвшигчдийн хүрэх боломжгүй хэмжээний эрх мэдэл, эд баялгийн хуримтлалыг шаардах болов. Зохиогч Б.Мандухай ПАРЛАМЕНТАД ХҮРЭХ МЯНГАН АЛХАМ номдоо эмэгтэй нэр дэвшигчид хэрхэн харизмтай, нэр хүндтэй, оюунлаг байж, сонгуульд биеэ бэлдэх стратеги ашиглаж буй тухай өгүүлжээ. Үүнийг “сонгогдохуйц байх” хэмээн нэрлэж болох бөгөөд неолиберализмын үр дүнд хэт арилжааны шинжтэй болсон сонгуулийн үеэр эмэгтэй нэр дэвшигчид бие махбод, оюун санаагаа шинэлэг, уян хатан байлгаж өөрсдийгөө дахин урлах хэрэгтэй болно. Парламентад хүрэхийн тулд Монгол эмэгтэйчүүдийн туулдаг бартаатай, бэрхшээлтэй Мянган Алхмыг мөшгөн үзвээс дэлхий даяарх ардчиллын толин тусгал мэт төдийгүй дэлхийн улс төрийн тогтолцоонд үзүүлж буй неолиберализмын түрэмгий нөлөөтэй тэмцэх шаардлагатайг сануулдаг.

“Парламентад хүрэх мянган алхам ном нь улс төрийн антропологиин үлгэр жишээ бүтээл юм. Нарийн шинжилсэн угсаатны зүйн шинжилгээ, дэлгэрэнгүй өгүүлэх түүх бичлэг, сэтгэл хөдөлгөм уран сайхныг хослуулснаар Б.Мандухай сонгууль бол техникийн төдий үйл явцаас илүү ээдрээтэй, нарийн зүйл болохыг харуулав. Үр дүнд нь сонгуулийн улс төр, эмэгтэйчүүд сонгогдохуйц нэр дэвшигч байхын тулд өөрсдийгөө дахин урлаж буй талаарх задлан шинжилгээ бүхэлдээ маш үндэслэлтэй болжээ. Б.Мандухай постсоциалист улс орнуудын ардчиллыг ойлгох арга зүй, үзэл санааг хамгийн зөв цаг үед цогцоор нь дэвшүүлсэн гэж үзэж байна.”

ЖЕССИКА ГРИЙНБЭРГ, Урбана-Шампэйн дэх Иллинойсийн Их Сургууль
(Jessica Greenberg, University of Illinois Urbana-Champaign)

“Б.Мандухайн энэхүү гайхалтай ном нь Монголын талаар Англи хэл дээр бичигдсэн судалгааны ертөнцөд олон сэдвийг хамарсан, цоо шинэ агуулга нэмж байна. Монголын улс төрийн бодит үйл явдлын талаар шинэ мэдлэг хүргэхийн зэрэгцээ өнөөг хүртэл анхаарлын гадна байж, онцлон судлагдаж байгаагүй жендэрийн улс төрийн бодит төрхийг ил гаргаж иржээ.”

КЭРОЛИН ХАМФРИ, Кэмбрижийн Их Сургууль
(Caroline Humphrey, University of Cambridge)

Массачусетсийн Технологийн Институтын антропологиин профессор Буяндэлгэрийн Мандухай нь Чикагогийн Их Сургуулийн Хэвлэлийн газрын гаргасан Эмгэнэлт Онгодууд номын зохиогч юм.



9789919905927